Чөлөөт бүсийн тухай хуулийн төсөл (Шинэчилсэн найруулга)²²

ЧБ-ийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, худалдааны урсгалыг бий болгох, ЧБ-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хил орчмын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үүднээс олон улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд гарч буй өөрчлөлт, шинэчлэлт, ЧБ-ийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага болон манай улсын онцлог, эрх ашигт нийцүүлэн ЧБ-ийн хууль, эрх зүйн орчныг дахин өөрчлөх шаардлага гарч байгааг хуулийн төслийн танилцуулгад дурьдсан байна.²³

Дээр дурдсан хууль эрх зүйн орчны шинэчлэлт, ЧБ-ийн хөгжлийг түргэтгэх үндсэн шаардлагуудын дагуу Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 9 бүлэг, 26 зүйлтэй байхаар боловсруулжээ. Үүнд:

²¹ЗГ-ын 1995 оны 87-р тушаалын хавсралтаар баталсан.

²²Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (2014.06.12-ны өдөр ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн).

²³Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга (2014.06.12-ны өдөр ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн).

1-р бүлэг.	Нийтлэг үндэслэл
1-р зүйл.	Хуулийн зорилт
2-р зүйл.	ЧБ-ийн тухай хууль тогтоомж
3-р зүйл.	Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
2-р бүлэг.	ЧБ байгуулах, татан буулгах, өөрчлөх
4-р зүйл.	ЧБ байгуулах зорилго
5-р зүйл.	ЧБ-ийг байгуулахад баримтлах угтвар нөхцөлүүд
6-р зүйл.	ЧБ байгуулах, татан буулгах, өөрчлөх, түүний хилийн цэс, байршлыг тогтоох
3-р бүлэг.	ЧБ-ийн удирдлага
7-р зүйл.	ЧБ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
8-р зүйл.	ЧБ-ийн захирагч, түүний бүрэн эрх
4-р бүлэг.	ЧБ дэх үйл ажиллагааны тусгай дэглэм
9-р зүйл.	Тусгай дэглэмийн зохицуулалт
10-р зүйл.	ЧБ-д үйлчлэх гаалийн тусгай дэглэм
11-р зүйл.	ЧБ-д үйлчлэх визийн тусгай дэглэм
12-р зүйл.	ЧБ дэх аж ахуйн нэгжийн бүртгэлийн зохицуулалт
13-р зүйл.	ЧБ-д төлбөр тооцоог гүйцэтгэх зохицуулалт
14-р зүйл.	ЧБ дэх мэргэжлийн хяналтын зохицуулалт
15-р зүйл.	ЧБ-д үйлчлэх хөдөлмөр эрхлэлтийн дэглэм
16-р зүйл.	ЧБ-д үйлчлэх татварын дэглэм
17-р зүйл.	ЧБ дэх тусгай дэглэмийн болон бусад үйлчилгээний зохицуулалтыг хэрэгжүүлэх
5-р бүлэг.	ЧБ-д аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх
18-р зүйл.	ЧБ-д эрхлэх үйл ажиллагааны төрөл
19-р зүйл.	ЧБ-ийн аж ахуйн үйл ажиллагааны орлого
20-р зүйл.	ЧБ-ийн захирагчаас орон нутгийн ИТХ, ЗД-тай харилцах
21-р зүйл.	Хөрөнгө оруулагчдын зөвлөл
6-р бүлэг.	ЧБ дэх газрын харилцаа
22-р зүйл.	Газрын зохицуулалт
23-р зүйл.	Газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт
7-р бүлэг.	ЧБ-ийн дэд бүтэц
24-р зүйл.	ЧБ-ийн дэд бүтэц, барилга байгууламж
8-р бүлэг.	ЧБ-ийн харуул хамгаалалт
25-р зүйл.	ЧБ-ийн хамгаалалт
9-р бүлэг.	Бусад зүйл
26-р зүйл.	Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Төсөлд зааснаар хуулийн зорилт нь ЧБ байгуулах, түүний хэлбэр, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, ЧБ-д мөрдөх татвар, гаалийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү Чөлөөт бүсийн тухай хуулийн төслөөр дараах томоохон зарчмын өөрчлөлтүүдийг зохицуулахыг төслийн үзэл баримтлалд дурьдсан байна.²⁴ Үүнд:

1. ЧБ-ийг хэлбэрээр нь ангилсан заалтыг өөрчилж, ЧБ-ийг хилийн боомт болон ЗГ-ын санал болгосон тусгай бүс нутагт байгуулж хөгжүүлэх, хил дамнасан ЧБ-ийн эрх зүйн орчинг бүрдүүлэв.
2. ЧБ-д Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд үл харшлах, олон улсын гэрээний тулгуур зарчим, шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, аялал жуулчлал, үйлчилгээ, худалдаа, олон улсын банк санхүү, даатгал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, нийгэм, зах зээл, дэд бүтцийн бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болохоор тусгав.

²⁴Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал (2014.06.12-ны өдөр ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн).

3. ЧБ-ийн удирдлага, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, ЧБ-ийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүргийг хуульчилж, ЧБ-ийн Захирагчийн эрх хэмжээг нэмэгдүүлэв.
4. Татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах зэрэг үйл ажиллагааны тусгай дэглэмийг хуульчилж өгөв.
5. Концессын гэрээний үндсэн дээр хувийн хэвшлийн хөрөнгөөр ЧБ-ийг бүхэлд нь буюу хэсэгчлэн байгуулж, хөгжүүлэх боломжтойгоор шинэчлэн тусгав.
6. ЧБ-д гадаад болон дотоодын иргэн, ААН-д газар эзэмших, ашиглах зохицуулалтыг тодорхой болгов.

Хуулийн төсөл нь Монгол Улсын хилийн боомтын бүсэд ЧБ-ийг түлхүү байгуулж хөгжүүлэх, ЧБ-д иргэний бараа солилцоо, худалдааг дэмжих, ЧБ-ийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний шинэ салбарыг хөгжүүлэх, татвар, гааль зэрэг тусгай дэглэмийн зохицуулалтыг хуульчлах замаар хөрөнгө оруулагчдад ээлтэй орчин бүрдүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, ЧБ-ийн дэд бүтэц, барилга байгууламжийг төр хувийн хэвшлийн түншлэлийн замаар байгуулах, улмаар төрийн хүнд суртлыг бууруулж, бизнесийн орчныг сайжруулахад чухал ач холбогдол өгнө гэж төсөл санаачлагчид үзэж байна.

Чөлөөт бүсийн тухай хууль (2002 он)

2002 онд батлагдсан Чөлөөт бүсийн тухай хуулийн зорилт нь ЧБ байгуулах, түүний хэлбэр, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, ЧБ-д мөрдөх татвар, гаалийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад орших ба уг хууль нь 3 бүлэг, 18 зүйлтэй. Үүнд:

1-р бүлэг. Нийтлэг үндэслэл

- 1-р зүйл. Хуулийн зорилт
- 2-р зүйл. ЧБ-ийн тухай хууль тогтоомж
- 3-р зүйл. ЧБ, түүний хэлбэр
- 4-р зүйл. ЧБ дэх үйл ажиллагааны тусгай дэглэм
- 5-р зүйл. ЧБ байгуулах, өөрчлөх, татан буулгах

2-р бүлэг. ЧБ-ийн удирдлага

- 6-р зүйл. ЧБ-ийн захирагч
- 7-р зүйл. ЧБ-ийн захирагчийн бүрэн эрх
- 8-р зүйл. ЧБ-ийн ерөнхий менежер
- 9-р зүйл. ЧБ дэх мэргэжлийн хяналтын алба
- 10-р зүйл. ЧБ дэх хөрөнгө оруулагчдын зөвлөл
- 11-р зүйл. ЧБ-ийн төсөв
- 12-р зүйл. ЧБ-ийн захирагчаас орон нутгийн ИТХ, ЗД-тай харилцах

3-р бүлэг. ЧБ-д аж ахуй эрхлэх

- 13-р зүйл. ЧБ-д үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг бүртгэх
- 14-р зүйл. ААН-ийг бүртгэх асуудлаар бүсийн захирагчийн бүрэн эрх
- 15-р зүйл. ЧБ-д эрхлэх аж ахуйн үйл ажиллагаа
- 16-р зүйл. Газрын харилцаа
- 17-р зүйл. ЧБ-д татвар ногдуулах, татвараас чөлөөлөх
- 18-р зүйл. ЧБ-ийн хамгаалалт, шалган нэвтрүүлэх

1.2. ОХУ

1980-аад оны сүүлээр хуучин Зөвлөлт Холбоот Улсад ЭЗЧБ байгуулах тухай идэвхтэй яригдаж, тухайн үеийн засаг Приморийн хязгаар болон Ленинград мужийн удирдлагын “Находка”, “Выборг” ЭЗЧБ-үүдийг байгуулах тухай саналыг дэмжин баталжээ.

1991 оны 9 дүгээр сард ЗСБНХУ-ын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон ба уг хуулийн нэг бүлэг нь ЭЗЧБ-тэй холбоотой харилцааг зохицуулах болсон. Хуулиар гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, гадаадын тэргүүлэх техник, технологи, удирдах туршлага зэргийг нэвтрүүлэх, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор ЭЗЧБ-ийг байгуулахыг заасан. Гадаадын хөрөнгө оруулагч, оролцогчдод зориулж хөнгөлөлтүүдийг санал болгож, бүртгэлтэй холбоотой процессыг хялбаршуулсан.

Тус улсад 1992-1994 оны хооронд ЧБ-ийг олон тоогоор байгуулсан боловч амжилттай хэрэгжиж чадаагүй. Эдийн засгийн хямрал, улс төрийн тогтворгүй байдал, ЭЗЧБ-ийг байгуулах хөрөнгө оруулалт байхгүй зэрэг асуудлуудаас төлөвлөсөн олон төслийг хэрэгжүүлж чадаагүй. Тус улсад ЭЗЧБ-ийн тухай бие даасан хуулийг боловсруулах, хэрэгжиж байсан эрх зүйн актуудыг боловсронгуй болгох, байгуулагдсан бүсүүдээс газар зүйн байршил сайтай, дэд бүтцийн зардал бага гаргах бүсийг сонгон, төрөлжүүлэх зэрэг ажлуудыг хийж эхэлсэн. Тухайлбал, Холбооны ач холбогдол бүхий дотоод худалдааны бүс, гаалийн ЧБ, шинжлэх ухаан-техникийн бүс, аялал жуучлалын бүс, мөн эдийн засгийн тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бүс гэж төрөлжүүлсэн.

2005 онд ОХУ-ын ЭЗОБ-ийн тухай хууль²⁵ 9 бүлэг, 41 зүйлтэйгээр батлагдсан. Үүнд:

- 1-р бүлэг - Нийтлэг үндэслэл: ЭЗОБ-тэй холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, хуульд хэрэглэгдэж буй үндсэн нэр томъёонуудын тодорхойлолт, ЭЗОБ байгуулах зорилго, төрлүүд, байгуулах нөхцөл, татварын харилцаа;
 - 2-р бүлэг - ЭЗОБ байгуулах, татан буулгах: ЭЗОБ байгуулах, татан буулгах, төсвийн хөрөнгөөр дэд бүтэц барихад хөрөнгө оруулах;
 - 3-р бүлэг - ЭЗОБ-ийн захиргаа: ЭЗОБ-ийн захиргааны байгууллагыг байгуулах, түүний эрх, үйл ажиллагаа, ЭЗОБ-ийг удирдах тухай гэрээ;
 - 4-р бүлэг - ЭЗОБ-ийн оршин суугчийн эрх зүйн байдал: Оршин суугч, ЭЗОБ-д аж үйлдвэр байгуулах журам, төрийн хяналт;
 - 5-р бүлэг - Боомтын ЭЗОБ-д аж үйлдвэрлэл, техник, аялал жуучлалын үйл ажиллагаа явуулах тухай гэрээ: Боомтын ЭЗОБ-д аж үйлдвэрлэл, техник, аялал жуучлалын үйл ажиллагаа явуулах тухай гэрээний зүйл, нөхцөл, бусад шаардлагатай бичиг баримт, гэрээ байгуулах дэг, хэлбэр, хугацаа, гэрээний нөхцөл өөрчлөх, гэрээ хүчингүй болох, эсхүл цуцлах, түүнээс үүссэн үр дагавар, газрын түрээсийн гэрээ, түүний төлбөр;
- Хуулийн 6, 6.1, 6.2 зэрэг бүлгүүд 2012 оны 1-р сарын 1-ээс хүчингүй болсон.*
- 7-р бүлэг - ЭЗОБ-ийн хилд байрлах газрыг олгох, заасан газрыг ашиглах журам: ЭЗОБ-д газар ашиглах, ЭЗОБ-ийн хил дээр дэд бүтэц, барилга барихад сервитут тогтоох, газрын түрээсийн гэрээ, төлбөр;
 - 8-р бүлэг - ЭЗОБ-ийн гаалийн ЧБ-д гаалийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх: гаалийн ЧБ-д гаалийн үйл ажиллагаа, гаалиар бараа дамжин өнгөрөх үйл ажиллагаа, барааны тайлан, тооцоо, гаалийн хяналт, аж үйлдвэрлэл, эсхүл техникийн эдийн засгийн тусгай бүсэд бараа хадгалах, боомтын ЭЗОБ-д бараа оруулах;
 - 9-р бүлэг - ЭЗОБ-ийн оршин суучдын баталгаа: ОХУ-д татвар, төлбөрийн хууль тогтоомжид таагүй нөхцөл өөрчлөлтийн баталгаа, маргаан шийдвэрлэх;
 - 10-р бүлэг - Төгсгөлийн хэсэг.

Эдийн засгийн онцгой бүсийн тухай хуулиар ЭЗОБ байгуулах зорилгыг эдийн засгийн өндөр технологийн болон боловсруулах салбарыг хөгжүүлэх, аялал жуучлал, сувилалын газрууд, боомт болон тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, технологи, коммерциализацийг боловсруулах, шинэ төрлийг бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал хэмээн тодорхойлсон байна.

²⁵ФЗ от 22.07.2005 N 116-ФЗ (ред. от 23.07.2013) "Об особых экономических зонах в Российской Федерации".

1.3. БНХАУ

Хятад улс нь Гуандун мужийн ЧБ-ийг 1980 онд батлагдсан Гуандун мужийн Эдийн засгийн онцгой бүсийн тухай тогтоол²⁶ (Regulations on Special Economic Zones in Guangdong Province)-оор зохицуулж байна. Тогтоол нь бүртгэл болон үйл ажиллагаа, татварын хөнгөлөлт, хөдөлмөрийн харилцаа, захиргаа зэрэг асуудлыг тусгасан 6 бүлэг, 26 зүйлээс бүрдэх бөгөөд Гуандун дахь Шинжан, Чжухай, Шаньюу гэсэн гурван хотод ЭЗОБ байгуулахтай холбоотой харилцааг зохицуулж байна.

1.4. БНТурк улс

Турк улсад 1985 онд Худалдааны чөлөөт бүсүүдийн тухай хууль №3218 (Free Trade Zones Act)-ийг, 1993 онд Худалдааны чөлөөт бүсүүдийн тухай хуулийг дагаж мөрдөх журмыг тус тус баталсан. Худалдааны чөлөөт бүсүүдийн тухай хууль нь 4 бүлэг 15 зүйлтэй бөгөөд ЧБ-ийг үүсгэн байгуулах, хамрах хүрээ, Худалдааны Чөлөөт Бүс (ХЧБ)-ийн сан, ЧБ дахь худалдаа, үйлчилгээ, гадаад валют арилжаа, хөдөлмөр, нийгмийн хамгаалал зэрэг асуудлыг тусгасан байна.

Энэ хуулийн зорилт нь ХЧБ байгуулах, түүний байршил, хил хязгаарыг тогтоох, үйл ажиллагаа, Турк улсад экспортод чиглэсэн хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, гадаад хөрөнгө оруулалт, техник технологийг нэвтрүүлэхэд чиглэсэн ЧБ-д барилга, байгууламж барьж байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Чөлөөт бүсийн тухай хуулийг дагаж мөрдөх тухай журам нь ЧБ-ийн удирдлага, засаг захиргаа, ЧБ-ийн төрөл хэлбэр, хил хязгаарын тодорхойлолт, үйл ажиллагааны чиглэл, ЧБ-д үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, ЧБ-д оршин суух, зорчих, ЧБ-д аюулгүй байдал болон ажиллах орчин бүрдүүлэх, гаалийн татвар, татвар хураамжаас чөлөөлөх нөхцөл, тусгай данс болон ЧБ-ийн орлого, банк, даатгал зэрэг асуудлыг тусгасан байна.

1.5. БНСерби улс

Серби улсад ЧБ-тэй холбоотой харилцааг 2006 онд батлагдсан Чөлөөт бүсийн тухай хуулиар²⁷ зохицуулах ба энэхүү хууль нь ЧБ байгуулах, ЧБ-т үйл ажиллагаа эрхлэх, ЧБ-ийг татан буулгах болон ЧБ-ийн удирдлагын бүрэн эрхийг тодорхойлно.

Бүсийг үүсгэн байгуулагч, Бүсийн менежментийн компани болон Бүсийн хэрэглэгчийн хуулиар тогтоосон эрх нь бусад ямар ч хууль, эсхүл зохицуулалтаар хязгаарлагдахгүй байх баталгаат эрхийг Чөлөөт бүсийн тухай хуулиар баталгаажуулсан байна.

Чөлөөт бүсийн тухай хууль нь бүтцийн хувьд 9 бүлэг, 39 зүйлтэй:

- I. Нийтлэг үндэслэл: Хуулийн агуулга, Нэр томъёоны ойлголт, Баталгаат эрх;
- II. Орон зайн тодорхойлолт: Бүсийн орон зайн тодорхойлолт, Өргөдлийн шаардлага, Өргөдлийн агуулга;
- III. Бүсийн журам болон менежмент: Бүсийн менежмент, Бүсийн хэрэглэгчид, Бүсийн журам, Үйл ажиллагааны эхлэл;
- IV. Бүсийн бизнесийн үйл ажиллагаа: Бүсэд үйл ажиллагаа явуулах;
- V. Бүсийн үйл ажиллагааг зогсоох: Бүсийн орон зайг тодорхойлох зөвшөөрлийг хүчингүй болгох, Бүсийн үйл ажиллагааг зогсоох;
- VI. ЧБ-ийн захиргаа: ЧБ-ийн захиргааны бүрэн эрх;

²⁶Resolution of the Standing Committee of the National People's Congress on Approving the Regulations on Special Economic Zones in Guangdong Province (Adopted on August 26, 1980). www.asianlii.org/cn/

²⁷Law on free zone, "RS Official Gazette", No 62/2006.

- VII. Хуулийн хэрэгжилтийн хяналт;
- VIII. Хуулиар шийтгэх нөхцөл;
- IX. Шилжилтийн болон төгсгөлийн нөхцөл.

1.6. Малайзын Холбооны улс

Малайз улс анх 1971 онд Чөлөөт худалдааны бүсийн хуулийг батласан бөгөөд энэ нь цаг хугацааны шалгуураар эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг дэмжих чадваргүй болох нь тодорхой болж, дахин хуулийг шинэчлэх хэрэгтэй болсон байна. Тиймээс 1990 онд Чөлөөт бүсийн хуулийн төслийг боловсруулж, худалдаа болон аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор улс орондоо ЧБ-үүдийг байгуулах шинэ чиг хандлагыг дэвшүүлсэн. Хуулийн төсөл дэмжигдэж Чөлөөт бүсийн хууль (Free Zones Act 1990)-ийг батлан 1991 оны 9-р сарын 5-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөхөөр хуульчилжээ. Хуулийн хэрэгжилтийг хангуулах 1991 оны Чөлөөт бүсийн журам (Free Zones Regulations)-ыг мөн батласан байна. Энэ хууль нь Малайзын усан боомт ба нисэх буудлуудын уламжлалт үүрэг ролийг өөрчилж, татваргүй ЧБ болох аливаа алхам бүрийг дэмжих боломжийг бүрдүүлсэн.

1.7. БНСолонгос улс

Солонгос улсад ЧБ-тэй холбоотой аливаа харилцааг Эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментийн тухай тусгай хуулиар голлон зохицуулах бөгөөд түүнд нийцүүлэн гаргасан холбогдох журам, түүнчлэн бусад салбарын хуулиудаар зохицуулдаг байна. Тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хууль, Төрийн өмчийн менежментийн тухай орон нутгийн журам, Газрын тухай хууль гэх мэтчилэн салбарын хуулиудад шаардлагатай зохицуулалтыг тусгасан байна.

БНСУ-ын ЭЗЧБ-ийн гол хууль нь бүтцийн хувьд 8 бүлэг, 35 зүйлтэй байна. Тус хуулийн зорилго нь ЭЗЧБ-ийн төлөвлөлт болон менежментээр дамжуулан Гадаадын хөрөнгө оруулалт (ГХО)-тай бизнес эрхлэгчдийн бизнесийн орчин, гадаад иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулах замаар ГХО-ыг дэмжих, үндэсний өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, бүс нутаг хоорондын тогтвортой хөгжлийг хангахад оршино гэж заажээ.

1.8. БНАрмен улс

Армен улсын Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хууль нь 2011 оны 5-р сарын 25-ны өдөр батлагдсан ба хуулийн 1-р зүйлд зааснаар энэхүү хууль нь ЭЗЧБ байгуулах, түүнийг зохион байгуулах болон татан буулгах явцад бий болсон эрх зүйн харилцааг зохицуулна. Уг хууль нь дараах бүтэцтэй. Үүнд:

- 1-р зүйл. Хуулийн агуулга
- 2-р зүйл. ЧБ-ийн тухай хууль тогтоомж
- 3-р зүйл. Хуулийн зарчмууд
- 4-р зүйл. Операторт зөвшөөрөл олгох болон Байгуулагчийг сонгох
- 5-р зүйл. ЭЗЧБ байгуулах
- 6-р зүйл. ЭЗЧБ-ийн шаардлагууд
- 7-р зүйл. ЭЗЧБ-ийг зохион байгуулах гэрээ байгуулах
- 8-р зүйл. Эрх бүхий этгээдийн бүрэн эрх
- 9-р зүйл. Байгуулагчийн эрх үүрэг
- 10-р зүйл. Операторын эрх үүрэг
- 11-р зүйл. ЭЗЧБ дэх хязгаарлалт
- 12-р зүйл. ЭЗЧБ-ийн үйл ажиллагаа
- 13-р зүйл. ЭЗЧБ дэх татвар, гааль, болон валютын зохицуулалт

- 14-р зүйл. ЭЗЧБ-д улсаас хяналт тавих болон тусламжийн үйлчилгээ үзүүлэх
- 15-р зүйл. ЭЗЧБ-ийг татан буулгах
- 16-р зүйл. ЭЗЧБ-д маргааныг шийдвэрлэх
- 17-р зүйл. Хуулийг хүчин төгөлдөр болгох

1.9. БНБеларусь улс

Беларусь улсад Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хууль²⁸ 1998 онд батлагдсан. Уг хуулийн 3-р зүйлд ЭЗЧБ байгуулах зорилгыг БНБУ-ын нийгэм эдийн засгийн хөгжил, бие даасан удирдлага, нутаг дэвсгэрийн нэгжүүдэд нөлөөлөх, шинэ өндөр технологид суурилсан экспортод чиглэсэн импортыг орлох хөрөнгө оруулалтыг татах болон ЭЗЧБ байгуулахад тодорхойлсон бусад зорилгыг харгалзан үзэж байгуулна хэмээн тодорхойлсон байна. Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хууль нь бүтцийн хувьд 6 бүлэг, 26 зүйлтэй. Үүнд:

- 1-р бүлэг - Нийтлэг үндэслэл: Хуульд хэрэглэгдэх гол нэр томьёонууд болон тэдгээрийн тодорхойлолт, ЭЗЧБ-ийн хууль тогтоомж, ЭЗЧБ байгуулах зорилго, төрөл, хориотой үйл ажиллагаа;
- 2-р бүлэг - ЭЗЧБ дэх төрийн зохицуулалт болон хяналт: ЭЗЧБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах хүрээнд төрийн зохицуулалт хийж буй төрийн байгууллагууд, тэдгээрийн бүрэн эрх, ЭЗЧБ-ийн үйл ажиллагаа болон түүний үр ашгийн ерөнхий хяналт;
- 3-р бүлэг - ЭЗЧБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах, түүний хилийн заагийг өөрчлөх: ЭЗЧБ байгуулах, хилийн заагийг өөрчлөх, үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах, татан буулгах;
- 4-р бүлэг - ЭЗЧБ-ийн менежмент болон санхүүжилт: ЭЗЧБ-ийн захиргаа, түүний бүрэн эрх, Хяналтын зөвлөл, Хөгжлийн сангийн санхүүжилт;
- 5-р бүлэг - ЭЗЧБ-ийн оршин суугч: ЭЗЧБ-ийн оршин суугчаар бүртгүүлэх, ЭЗЧБ-ийн үйл ажиллагааны нөхцлийн гэрээн дэх тухайн бүсийн оршин суугчийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөл, Бүсийн оршин суугчаар бүртгүүлсэн хуулийн этгээдийг өөрчлөх, оршин суугчийн статусаа алдах, эсхүл хасуулах;
- 6-р бүлэг - ЭЗЧБ-ийн тусгай эрх зүйн зохицуулалт. ЭЗЧБ-ийн оршин суугчдын улсын баталгаа: ЭЗЧБ-ийн татвар, Гаалийн ЧБ, ЭЗЧБ дэх Газрын харилцааны зохицуулалт, хөдөлмөрийн болон холбогдох харилцааны зохицуулалт, Бүсийн оршин суугчдын улсын баталгаа.

1.10. БНКазахстан улс

Казахстан улсад анх 1990 онд Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хууль²⁹ батлагдаж, ЭЗЧБ-д хуульд заасан бүх төрлийн үйл ажиллагааг явуулахыг зөвшөөрсөн байжээ. ЭЗЧБ-ийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй эрхлэгчид буюу оролцогчдод гаалийн болон бусад албан татварын хөнгөлөлт үзүүлж байсан.

1991-1996 оны хооронд тус улсад 9 ЭЗЧБ байгуулагдсан. Томоохон нутаг дэвсгэрийг ЭЗЧБ гэж зарласан боловч судалгаа шинжилгээ хийгдээгүй, хууль эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын механизмыг нарийн тогтоогоогүй, санхүү, татвар зэрэг олон асуудлуудыг бие даан шийдэх хангалттай эрх мэдэл байгаагүй зэрэг асуудлуудаас болж тэдгээр ЭЗЧБ-үүдийн үйл ажиллагаа нь хүссэн үр дүндээ хүрч чадаагүй аж.

²⁸Закон Республики Беларусь 7 декабря 1998 г. № 213-З. О свободных экономических зонах.

²⁹Закон Казахской ССР от 30 ноября 1990 г. "О свободных экономических зонах в Казахской ССР".

ЭЗЧБ-ийг байгуулах гэсэн анхны оролдлого амжилтгүй болсноор амжилттай үйл ажиллагаа явуулж байсан эсэхээс үл хамааран бүх ЭЗЧБ-үүдийг 1996 онд татан буулгаж, 1996 онд шинэ Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийг³⁰ баталжээ. 2002 оноос шинэ үеийн ЭЗТБ-үүдийг байгуулж эхэлсэн ба одоо ажиллаж байгаа ЭЗТБ-үүд нь өөрийн зорилго, түүнд нийцсэн үйл ажиллагааны төслийг хэрэгжүүлж байна.

Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2007 онд баталсан хэдий ч одоо ЭЗТБ-тэй холбоотой харилцааг 2011 онд батлагдсан Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулиар зохицуулж байна. Энэхүү хуулиар ЭЗЧБ-ийн удирдлага, үйл ажиллагааны системийг сайжруулахад чиглэсэн байна.

ЭЗТБ-ийн хөгжлийг удаашруулж байсан асуудлуудын нэг бол олон улсын зах зээлтэй хангалттай харилцаа байгаагүй явдал ба үүнээс болж томоохон ГХО-ыг татах боломжгүй хэмээн үзэж, энэ асуудал дээр түлхүү анхаарах болсон. Иймд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах үүднээс зөвшөөрөл авах процессыг “нэг цонх”-ны зарчмаар хуулиар тогтоосон нь төрийн үйлчилгээг боломжийн хэмжээнд хялбаршуулсан гэж үзэж байгаа аж.

Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль нь БНКаЗУ-ын нутаг дэвсгэр дээр ЭЗТБ үүсгэн байгуулах, зохион байгуулах, татан буулгахад олон нийттэй холбоотой харилцааг зохицуулна. Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль нь бүтцийн хувьд 6 бүлэг, 26 зүйлтэй. Үүнд:

- 1-р бүлэг - Нийтлэг үндэслэл: Хуульд хэрэглэгдэх гол нэр томъёонуудын тодорхойлолт, ЭЗЧБ-ийн хууль тогтоомж, ЭЗТБ байгуулах зорилго;
- 2-р бүлэг - ЭЗТБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах хүрээнд дэх төрийн зохицуулалт: ЭЗТБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах хүрээнд төрийн зохицуулалт хийж буй төрийн байгууллагуудын эрх, үүрэг;
- 3-р бүлэг - ЭЗТБ байгуулах, үйл ажиллагаа явуулах, татан буулгах: ЭЗТБ байгуулах, үйл ажиллагаа явуулах нөхцөл, өргөдөл гаргагчид тавигдах шаардлага, түүнийг хянаж үзэх, туслах үйл ажиллагаа явуулахыг хүсэгчид тавигдах шаардлага, бүрдүүлэх бичиг баримт, татан буулгах;
- 4-р бүлэг - ЭЗТБ-ийн захиргаа: ЭЗТБ-ийн захиргааны байгууллагыг байгуулах, түүний үйл ажиллагаа, удирдах компанийн удирдлагын бүрэлдэхүүнийг сонгох, түүний эрх, үүрэг, Үйл ажиллагааны хэрэгжилтийн гэрээний нөхцөлийн биелэлтийг хянах, Захиргааны үйл ажиллагааг санхүүжүүлэх, татан буулгах;
- 5-р бүлэг - ЭЗТБ-ийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, нөхцөл: ЭЗТБ-ийн эрх зүйн тусгай зохицуулалт, татвар, гаалийн харилцаа, Гаалийн ЧБ-ээр өнгөрөх бараа, Гадаадаас ажиллах хүч оруулах, Бүсийн оролцогчдын эрх зүйн баталгаа;
- 6-р бүлэг - Шилжилтийн нөхцөл.

2. ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТ

ЭЗЧБ-ийн ерөнхий шинж чанар нь эдийн засаг ба улс төрийн зорилтуудыг эдийн засаг хийгээд засаг захиргааны элдэв дарамтгүй “эрх чөлөө”-тэй, таатай нөхцөлд хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгох явдал юм. “Эрх чөлөө” гэдэг нь тухайн “бүс”-д санхүүгийн таатай нөхцөл, эдийн засгийн болон захиргааны онцгой эрх олгохыг хэлнэ. Тухайн бүсэд улсын татварын систем, бусад гадаад худалдааны хориг хязгаарлалтууд, зарим төрлийн улс төр эдийн засгийн бодлогууд үйлчлэхгүй гэсэн үг болно.

³⁰Закон РК от 26 января 1996 г. “О специальных экономических зонах в Республике Казахстан”.

Эдийн засгийн онцгой таатай бодлого бүхий эдийн засгийн бүсүүд нь харилцан адилгүй өөр өөр хэмжээтэй байхаас гадна нэг улс орны нутаг дэвсгэр дотор ч байна, бас хэд хэдэн орны хилийн бүс нутгийг хамран орших нь ч бий. Ийм бүсийг гагц чөлөөт худалдааг эрхлэн явуулахад бус, бас тухайн улсын эдийн засгийг дэлхийн эдийн засгийн сөрөг муу үр нөлөөнөөс хамгаалан удирдах зорилгоор хэрэглэдэг.

ЭЗЧБ бүрт тэргүүлэх сектор, салбар байдаг, тухайлбал, худалдаа ба усан тээвэр, тээвэр ба агуулах, зарим энгийн боловсруулах үйлдвэрлэл нь Чөлөөт усан боомт, Чөлөөт худалдааны бүс ба Гаалийн агуулахын тэргүүлэх сектор; үйлдвэр, шинэ болон өндөр технологийн үйлдвэр ба худалдаа нь Экспортын чиглэлийн ЧБ, Чөлөөт арилжааны бүс болон ШУ-д суурилсан аж үйлдвэрийн паркийн тэргүүлэх салбар; санхүү, даатгал, мөрийтэй тоглоом ба аялал жуулчлал бол Чөлөөт үйлчилгээний бүсийн тэргүүлэх сектор; харин Чөлөөт эдийн засгийн бүсийн тэргүүлэх секторууд нь дээрх бүгд байдаг байна.

Судалгаанд хамрагдсан орнуудын ЧБ-ийн тухай хуулиудад ЧБ-ийг тодорхойлсон байдлыг харьцуулан үзэхэд ЧБ гэдгийг ихэнх улс орнуудад үйл ажиллагааны тусгай дэглэмтэй, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, бизнесийн таатай орчныг бүрдүүлсэн, ЗГ-аас тогтоосон хил зааг бүхий бүс нутгийг хэлж байна.

Монгол Улсын хувьд Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ЧБ-ийг тодорхойлохдоо дээрх ерөнхий зарчмуудыг тусгасан байна. Харин 2002 оны Чөлөөт бүсийн тухай хуультай харьцуулахад хяналтын болон хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмтэй байхаар нэмж зохицуулсан байна. (Дэлгэрэнгүйг Хүснэгт 1-ээс үзнэ үү.)

3. ЧӨЛӨӨТ БҮСИЙГ БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

Судалгаанаас үзэхэд ЧБ-ийг байгуулах саналыг ихэнх улс орнуудад орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь Засгийн газар болон холбогдох Эрх бүхий газарт гаргаж байгаа бол зарим улс оронд тухайлбал, Монгол, Малайз, Казахстанд Засгийн газар нь УИХ-д хүсэлт гаргадаг, харин Казахстан, Турк улсуудад төрийн байгууллагаас гадна хуулийн этгээд ЧБ байгуулах тухай хүсэлтийг гаргах эрхтэй байдаг байна. Үүнээс харахад ихэнх улс орнуудад ЧБ байгуулах хүсэлтийг төрийн байгууллага гаргаж байна.

Ингэхдээ бусад улс орнуудад ЧБ байгуулах төлөвлөлт, төлөвлөгөөг юун түрүүнд харгалзан үзэж зөвшөөрөл олгож байна. Тухайлбал, Солонгос улсын Эдийн засгийн чөлөөт бүсийн төлөвлөлт болон менежментийн тухай тусгай хуульд ЭЗЧБ байгуулах төлөвлөлт, төлөвлөгөөний талаар нарийн зохицуулсан байна. ЭЗЧБ-ийг хөгжүүлэх төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгасан байна. (6.1). Үүнд:

1. ЭЗЧБ-ийн нэр, байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ;
2. ЭЗЧБ-ээр төлөвлөгдсөн байх;
3. ЭЗЧБ-д хэрэгжүүлж буй хөгжлийн төслийн оператор;
4. хөгжлийн төслийг хэрэгжүүлэх үе шат;
5. санхүүгийн нөөцийг бэхжүүлэх арга зам;
6. газар ашиглалт болон үндсэн дэд бүтцийн хөтөлбөр;
7. хүн амын байр сууц, оршин суух газрыг барьж байгуулах хөтөлбөр;
8. замын хөдөлгөөний зохицуулалтын хөтөлбөр;
9. аж үйлдвэр хөгжүүлэх хөтөлбөр;
10. эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ, боловсрол, нийгмийн хангамжийн газар байгуулах хөтөлбөр;
11. байгаль орчин хамгаалах хөтөлбөр;
12. ГХО-ыг татах, гадаад иргэд оршин суух орчинг бүрдүүлэх хөтөлбөр;
13. бусад зүйлс.

Эрх бүхий байгууллага нь ЭЗЧБ-ийн төлөвлөлтийн талаар эцсийн шийдвэрийг гаргах ба дараах зүйлсийг судалж үзнэ (5.1):

- ГХО-ыг татах, гадаад иргэдийг суурьшуулах боломж;
- орон нутгийн эдийн засаг болон бүс нутгийн тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөөлөл;
- шаардлагатай газрыг хамгаалах боломж, хөгжлийн үнэ цэнэ;
- хотын замын сүлжээ, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, ус, цахилгааны хангамж зэрэг дэд бүтэц;
- байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг хангах боломж;
- орон нутгийн захиргааг дэмжих тогтолцоо, нарийвчилсан төлөвлөгөө;
- бусад зүйлс гэх мэт.

ОХУ-д ЭЗОБ-ийг байгуулахдаа байрлал, алслагдмал байдал, цаг уурын эрс тэс нөхцөл зэрэг хүндрэлүүд нь барилгын ажлыг удаашруулах, зардлыг нэмэгдүүлэх зэрэг нөлөөллийг тооцолгүйгээр төлөвлөлт хийдэг нь бодит байдалд нийцдэггүй, төлөвлөгөө, тооцоонд хийдэл гарахад нөлөөлдөг. Мөн ЭЗОБ-ийг хөгжүүлэхэд томоохон саад учруулсан өөр нэгэн хүчин зүйл бол авилгын асуудал гэж мэргэжилтнүүд онцолсон байна.

Шанхай хотын ЗГ нь “Хятадын (Шанхай) ХЧБ-д ГХО-ад тавих захиргааны онцгой шаардлага бүхий “Хасалтын жагсаалт”³¹-ыг баталсан ба үүнд үйлдвэрлэл, тээвэр, мэдээллийн технологи, санхүү, үл хөдлөх хөрөнгө, бизнесийн үйлчилгээ, үзвэр үйлчилгээ зэрэг үндэсний эдийн засгийн 18 салбарыг багтаажээ. Эдгээр салбарт хамаарах үйл ажиллагааг ЧБ-д эрхлэхийг хязгаарласан журам гаргасан нь бүсээс гадуурх дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хамгаалсан байна.

Харин Монгол Улсын ЧБ-ийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 5.1-д ЧБ-ийг байгуулахад баримтлах угтвар нөхцлүүдийг оруулсан ч төдий л тодорхой бус асуудлууд нэлээд байна.

Хүсэлтийг хүлээн авч ЧБ байгуулах тухай шийдвэрийг судалгаанд хамрагдсан орнуудын дийлэнх нь буюу Орос, Хятад, Турк, Серби, Армен, Беларусь (Ерөнхийлөгчийн БН засаглалтай улс), Казахстан (Ерөнхийлөгчийн БН засаглалтай улс) зэрэг улсуудад ЗГ-ын тэргүүн гаргаж байна. Солонгос улсад Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний сайд шийдвэрлэдэг бол Малайз улсад Сангийн болон Олон улсын худалдаа, аж үйлдвэрийн сайд нар хэлэлцэн шийдвэрийг гаргадаг байна. Харин Монгол Улсын хувьд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд ЧБ-ийг байгуулах тухай саналыг ЗГ өргөн мэдүүлснээр УИХ шийдвэрлэхээр тогтоосон ба шинэчилсэн хуулийн төсөлд ч энэ хувилбараараа боловсруулагдсан байна.

ЧБ-ийг байгуулах хугацааг хуулинд тусгасан байдлыг авч үзвэл судалгаанд хамрагдсан нийт 10 орноос 2 нь буюу Орос, Казахстан улсууд тодорхой хугацааг хуульчилсан бол Армен улс ЧБ-ийг байгуулах тодорхой хугацааг заагаагүй боловч ЗГ нь ЭЗЧБ-ийг байгуулах тухай шийдвэр гаргахдаа үйл ажиллагааны хугацааг тогтоодог, Беларусь улс ЭЗЧБ-ийг байгуулах тухай хүсэлт гаргахдаа хугацаагаа өөрсдөө тодорхойлж батлуулдаг, харин үлдсэн 6 улсын (Монгол, Солонгос, Турк, Хятад, Серби, Малайз) хуулинд ЧБ-ийг байгуулах хугацааны талаар ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй байна.


³¹Negative List, Special Administrative Measures on the entry of Foreign Investment into China (Shanghai) Free Trade Zone, 2013.09.30.

ЧБ-ийг байгуулах үйл ажиллагааны төрөл, хэлбэрийг дийлэнх улс орнуудад хуульчилсан байх хэдий ч хэлбэрийн хувьд ямар байх талаар хуульчилсан зүйл нийтлэг байхгүй байна. Судалгаанд хамрагдсан орнуудын хууль эрх зүйн зохицуулалтаас харахад үйл ажиллагааны төрлийн хувьд худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн ЧБ байгуулах нь нийтлэг байгаа бол Армэнд ЭЗЧБ-ийг үйл ажиллагааны бүх төрөл хэлбэрээр байгуулж болно гэж хуульчилжээ. (Хүснэгт 2)

Монголд ЧБ-ийн байршлыг ЗГ-аас тогтоосон хил зааг бүхий газар нутагт байгуулахаар тусгасан бол Сербийн ЧБ-ийн хуулиар Бүс нь хашаагаар хүрээлэгдсэн, орох гарах хаалган дээрээ болон голын эрэг дагуу “Чөлөөт бүс” гэсэн таних тэмдэгтэй байна. Хэрэв бүс хэд хэдэн хэсгээс бүрдэж байвал бүс, эсхүл түүний хэсэг нь тусгаарлах хашаатай, таних тэмдэгтэй, бараа бүтээгдэхүүн болон иргэдийн орох гарах тусгай хаалгыг байрлуулах зэргээр зохицуулах ба хашлага, орох гарах хаалга нь чөлөөтэй, аюулгүй байдал хангасан гэрэлтүүлэгтэй байна гэхчилэн заажээ.

ЭЗЧБ-ийн түүхээс үзэхэд ЧБ нь хөгжлийн үе шат, байршил, дэглэм, үйл ажиллагааны төрөл, зорилгоос шалтгаалан өөр өөр хэлбэрүүдтэй байна. Зураг 1-д ЭЗЧБ-үүдийн ерөнхий төрлүүдийг үзүүлсэн байна.

Зураг 1. ЭЗЧБ-үүдийн ерөнхий хэлбэр, хувьсалуд



ЭЗЧБ-үүдийг байршил болон үйл ажиллагааны төрөл, хэлбэрээр нь ангилсан байгаагаас үзвэл байршлын **хэлбэрээр** нь улс доторх, хил дамнасан, үндэстэн дамнасан гэж ерөнхийд нь хуваах бөгөөд эрэг орчмын, нутгийн гүн дэх, боомт, хотын, тусгаарлагдсан зэргээр төрөлжүүлдэг байна. Харин үйл ажиллагааны **төрлөөр** нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, санхүүгийн, шинжлэх ухааны, бүрэн гэж ангилдаг байна.

ЧБ-ийг **татан буулгах** харилцааг хуульчилсан байдлыг харьцуулахад гадаадын орнуудын ЧБ-ийн тухай хуульд хугацаа дууссан тохиолдолд хугацаа сунгах шийдвэр гараагүй бол, хугацаанаас нь өмнө татан буулгах зэрэг нийтлэг зохицуулалт байна. Хугацаанаас өмнө татан буулгахдаа янз бүрийн шалтгааны улмаас татан буулгах ба ихэнхдээ үйл ажиллагааны зөвшөөрөл авснаас хойш тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй бол, улс орны үндэсний аюулгүй байдалд шаардлага гарсан тохиолдолд, мөн бүсийн зорилго хэрэгжээгүйд тооцогдох ноцтой түвшинд хүрсэн зэрэг тохиолдлуудад Засгийн газрын болон Ерөнхийлөгчийн зарлигаар шийдвэрлэж байна.

Монгол Улсын Чөлөөт бүсийн хууль болон Чөлөөт бүсийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ЧБ-ийг татан буулгах асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ шийдвэрлэнэ гэснээс өөр ямар нэгэн зохицуулалт байхгүй байна. Өөрөөр хэлбэл ямар тохиолдолд дээрх шийдвэрийг гаргах нь тодорхойгүй байна. (*Дэлгэрэнгүйг Хүснэгт 2-өөс үзнэ үү.*)

4. ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ТУСГАЙ ДЭГЛЭМ

ЧБ-ийн тухай хуулийн төсөлд ЧБ-ийн үйл ажиллагааны тусгай дэглэмийг бие даасан бүлэг болгон боловсруулсан байна. Төслийн хуулийн нэр томъёоны тодорхойлолтын дагуу **“ЧБ дэх үйл ажиллагааны тусгай дэглэм”-д хөрөнгө оруулалтыг татах, шинэ технологийг нэвтрүүлэх, экспортыг дэмжих, аялал жуулчлал, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор ЧБ-д үйл ажиллагаа эрхэлж буй ААН, иргэнийг гаалийн болон бусад татвараас хөнгөлж чөлөөлөх болон шалган нэвтрүүлэх, бүртгэх, гаалийн хяналт тавих, ЧБ-д зорчих, оршин суух, хөдөлмөр эрхлэх хөнгөөчилсөн нөхцөлийн талаар энэ хуульд заасан тусгай зохицуулалт**” гэсэн утгаар ойлгож хэрэглэнэ (3.1.2) гэж заажээ.

Цаашлаад *“ЧБ-д гаалийн, визийн, Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, оршин суух, ААН-ийн бүртгэлийн, валют зохицуулалтын, мэргэжлийн хяналтын, хөдөлмөр эрхлэлтийн, татварын болон бусад дэглэмүүд үйлчилнэ”* хэмээн тусгай дэглэмээр зохицуулахаар боловсруулсан байна. (9.1)

Хуулийн төсөлд ЧБ-ийн үйл ажиллагааны дараах тусгай дэглэмүүдийг тусгасан ба эдгээр зохицуулалтыг Хүснэгт 3, 4-т дэлгэрэнгүй оруулсан. Үүнд:

- гаалийн тусгай дэглэм,
- визийн тусгай дэглэм,
- ААН-ийн бүртгэлийн зохицуулалт,
- төлбөр тооцоог гүйцэтгэх зохицуулалт,
- мэргэжлийн хяналтын зохицуулалт,
- хөдөлмөрийн эрхлэлтийн дэглэм,
- татварын дэглэм.

Монгол Улсын хууль болон хуулийн төслийн ЧБ-ийн талаарх тодорхойлолтыг эргэн харвал *“ЧБ нь гаалийн хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох”* хэмээн тодорхойлсон ба Армен улсын хуулинд мөн *“ЭЗЧБ нь тус улсын гаалийн бүс нутгийн хүрэнээс гадна тооцогдох тусгай бүс нутаг байх”*-ыг заасан байна.

Судалгаанд хамрагдсан орнуудын ЧБ-ийн хуулиудыг үзэхэд ЧБ дэх **гаалийн дэглэмийг** ОХУ-ын Эдийн засгийн онцгой бүсийн тухай хуулийн “ЭЗОБ-ийн Гаалийн ЧБ-д гаалийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай” 8-р бүлэгт гаалийн үйл ажиллагаа, гаалиар бараа дамжин өнгөрөх үйл ажиллагаа, барааны тайлан, тооцоо, гаалийн хяналт, аж үйлдвэрлэл, эсвэл техникийн эдийн засгийн тусгай бүсэд бараа хадгалах, боомтын ЭЗОБ-д бараа оруулах зэргээр нарийн зохицуулсан бол хуучин Зөвлөлт улсын бүрэлдэхүүнд байсан Армен, Беларусь, Казахстан зэрэг улсуудад ЧБ дэх гаалийн дэглэмийг салбарын хуулиар нь зохицуулахаар тусгасан байна.

Серби улсын туршлагаас үзэхэд ЧБ-д орж, гарч байгаа бараанаас гадна ЧБ-ийн дотор хадгалагдах бараа бүтээгдэхүүнд хяналт тавьдаг байна. Түүнчлэн ЧБ дотор үйлдвэрлэсэн болохыг баталсан гэрчилгээ олгодог.

Монгол Улсын хувьд ЧБ-ийн тухай хуулийн төсөлд гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийх, ЧБ-д орсон, гарсан барааны бүртгэлийг цахим хэлбэрээр хөтлөх зэрэг зохицуулалтыг тодорхой болгосон бол ЧБ-д орох, гарах бараанд ямар нэгэн хориглолт хязгаарлалт тавиагүй байна.

Визийн дэглэмийн талаар зохицуулалтыг Монгол Улсын Чөлөөт бүсийн тухай хуулийн төсөлд тусгасан байна. Харин Турк болон Хятадад ЧБ-д нэвтрэх тухай асуудлыг заасан байдаг бол судалгаанд хамрагдсан бусад орнуудын Чөлөөт бүсийн тухай хуулиудад тусгагдаагүй байна.

ААН-ийн бүртгэлийг Казахстаны хуулиар хөрөнгийн чадварыг харгалзан хийх ба оролцогчдод хязгаарлалт тавьсан бол Монгол Улсын хуулийн төсөлд ЧБ-д үйл ажиллагаа явуулах дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай, хамтарсан ААН, байгууллагууд бүртгүүлж гэрчилгээ авахад ямар нэг хязгаарлалт тавиагүй байна. Манайтай адил зохицуулалтыг Сербийн туршлагаас үзэж болно. Харин бусад гадаадын орнуудын хувьд энэхүү харилцааг хуулиндаа тусгаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн талаар Монгол Улсын ЧБ-ийн тухай хуулийн төсөлд хөдөлмөр эрхлэлтэй холбоотой харилцаанд татвар, төлбөрийн хөнгөлөлтийг үзүүлсэн байна. Солонгос улсад энэ асуудал дээр илүү хатуу байр суурьтай хандсан байх ба Казахстанд гадаадын ажиллах хүчинд хамгийн таатай нөхцлийг тогтоосон байна. Серб, Беларусьт салбарын хуулиар зохицуулахаар заасан байна. (Дэлгэрэнгүйг Хүснэгт 3-ас үзнэ үү.)

5. ЧӨЛӨӨТ БҮСИЙН САНХҮҮЖИЛТ, ТАТВАР, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Судалгаанд хамрагдсан орнуудын ЧБ-ийн тухай хуульд ЧБ дэх татварын тусгай дэглэмийн талаар ямар нэгэн байдлаар тусгасан бөгөөд тус бүрдээ өөрийн онцлогтой байна. Тухайлбал, дэлхийн улс орнуудад татварын хөнгөлөлтийг экспортын бараанд түлхүү үзүүлдэг бол Турк улс нь дотоодын зах зээл дээр худалдаанд татварын хөнгөлөлтийг үзүүлдэг байна. Харин БНСУ-ын хувьд ЭЗЧБ-д үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд тухайн улсад хөрөнгө оруулснаар дараах 5 төрлийн урамшуулал, дэмжлэгийг үзүүлдэг байна. Үүнд:

- татварын үр ашиг,
- бизнесийн дэмжлэг,
- төрийн оролцоог багасгах,
- амьдрах нөхцөл,
- захиргааны дэмжлэг.

Хятад улс “5 сая ам.доллараас дээш хөрөнгө оруулалт бүхий, эсхүл өндөр технологи нэвтрүүлж буй ААН-д тусгай хөнгөлөлт олгодог” байхад Монгол улсын Чөлөөт бүсийн хуулийн төсөлд ЧБ-д дэд бүтцийн хөгжилд хандуулан “500.0 мянган ам. доллар буюу түүнээс дээш хөрөнгө оруулсан ААН-д оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх орлогын албан татварын хөнгөлөлтийг үзүүлэхээр” (16.2.1) зохицуулалттай байна.

Түүнчлэн Монгол улсын Чөлөөт бүсийн тухай хуулийн төслийн 16.1.4-т заасан “зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг гаалийн болон бусад татвараас чөлөөлнө” гэсэн зохицуулалт бусад оронд байхгүй байна.

ЧБ-ын санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэрийн талаар Монгол, Орос, Турк, Беларусь, Казахстан зэрэг орнуудын хуульд тодорхой тусгасан байна. Тухайлбал, Турк, Беларусь улсуудад ЧБ-ийн хөгжлийн сан байгуулах хэлбэрээр санхүүжилтийг төвлөрүүлж, эх үүсвэрээ бүрдүүлж байна.

ЧБ-ын газрын харилцааг Монгол, Орос, Хятад, Беларусь, Казахстан зэрэг орны хуулиудад ямар нэгэн байдлаар зохицуулсан бол Серби, Малайз, Арменд энэ асуудлыг тусгаагүй байна. Газрын харилцааг зохицуулсан байдлыг харьцуулан үзвэл ОХУ-ын хуулинд ЧБ-д газрыг давхар түрээслэх болон эрхээ бусдад шилжүүлэх, барьцаалах зэргийг хориглосон байдаг бол манай улсын хуулинд газрын харилцааны асуудлыг нэлээд тодорхой заасан хэдий ч эдгээр хориглох заалтууд тодорхой бус байна. Мөн газар эзэмших, ашиглах хугацааг ихэнх улс орнууд хуульчлаагүй байгаа бол Монгол (50 жил), Казахстан (10 жил), Турк (49 жил)-д хуульчилсан байна.

Турк улсын хувьд ЧБ-ийн төрийн мэдлийн газарт операторын барьж байгуулсан байгууламж нь үйл ажиллагаан зөвшөөрөл хүчингүй болох, хүчинтэй хугацаа дуусгавар болоход төрийн мэдэлд шилжинэ. ЧБ-ийн төрийн мэдлийн газарт түрээсийн үндсэн дээр барилга байгууламж барьсан нөхцөлд газар болон байгууламжийг Хэрэглэгчпэд худалдаж болно. *(Дэлгэрэнгүйг Хүснэгт 4-ээс үзнэ үү.)*

6. ЧӨЛӨӨТ БҮСИЙН УДИРДЛАГА БОЛОН ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

ЧБ-ийн талуудын эрх үүргийг хуульд тусгасан байдлыг авч үзвэл Монгол Улсын одоо мөрдөгдөж буй ЧБ-ийн хуульд ЧБ-ийн төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн төлөөлөгч-ЧБ-ийн захирагчтай байхаар заасан ба захирагч нь ажлын албаараа дамжуулан ЧБ-ийн үйл ажиллагааг удирдахаар хуульчилсан бол, ЧБ-ийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ЧБ-ийн **удирдлагын** эрх үүрэг, гүйцэтгэх үйл ажиллагаа зэрэг нэлээд тодорхойгоос гадна ЧБ-ийн асуудлыг төрийн захиргааны төв байгууллага нь хэрэгжүүлэхээр нэмж тусгажээ.

Харин **оролцогч** буюу **ЧБ-д үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн** эрх үүргийг аль алинд нь огт тусгаагүй байна.

Бусад орнуудын хувьд ЧБ-ийн удирдлага болон оролцогчийн эрх үүргийг аль алиныг орхигдуулалгүй хуульд тодорхойлон тусгасан байна. Тухайлбал, Казахстаны хуульд бүсийн үйл ажиллагааг **ЭЗЧБ-ийн удирдах компани хариуцах** бөгөөд түүнийг ЗГ, орон нутгийн засаг захиргаа болон гадаад дотоодын хуулийн этгээд байгуулж болохоор тусгасан байна.

Мөн тэдгээрийн эрх, үүрэг, гүйцэтгэх үйл ажиллагаа зэргийг тодорхой оруулснаас гадна оролцогч нь ЭЗЧБ-д үйл ажиллагаа эрхлэгч байх бөгөөд оролцогчид зориулсан татварын хөнгөлөлтүүдийг эдэлж, эрхээ хамгаалуулах зэрэг эрхүүдийг эдлэх ба гэрээнд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй байхаар хуульчилжээ. *(Дэлгэрэнгүйг Хүснэгт 5-аас үзнэ үү.)*

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНАУ	Бүгд Найрамдах Армен улс
БНБУ	Бүгд Найрамдах Беларусь улс
БНКаэУ	Бүгд Найрамдах Казахстан улс
БНСерби улс	Бүгд Найрамдах Серби улс
БНСолонгос улс	Бүгд Найрамдах Солонгос улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк улс
БНУ	Бүгд найрамдах улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалт
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗСБНХУ	Зөвлөлт социалист бүгд найрамдах холбоот улс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХУ	Малайзын Холбооны улс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОАТ	Онцгой албан татвар
ОХУ	Оросын Холбооны улс
СнЗ	Сайд нарын Зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ХАА	Хөдөө аж ахуй
ХЧБ	Худалдааны чөлөөт бүс
ЧБ	Чөлөөт бүс
ЭЗОБ	Эдийн засгийн онцгой бүс
ЭЗТБ	Эдийн засгийн тусгай бүс
ЭЗЧБ	Эдийн засгийн чөлөөт бүс

* * *

АШИГЛАСАН МАТЕРИЛ

Монгол улс

- Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал (ЗГ-ын 1995 оны 87-р тушаалын хавсралт),
- Чөлөөт бүсийн тухай хууль (2002),
- Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (2014.06.12-ны өдөр ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн),
- Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга (2014.06.12-ны өдөр ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн),
- Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал (2014.06.12-ны өдөр ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн),

Армен улс

- Закон Республики Армения О Свободных экономических зонах. Принят 25.05.2011.
- www.parliament.am/

Беларусь улс

- Закон Республики Беларусь 7 декабря 1998 г. № 213-З О свободных экономических зонах.

Казахстан улс

- Закон Республики Казахстан «О специальных экономических зонах» от 21 июля 2011 года.

Малайз Улс

- www.portsworld.com/customs/proc_freezone.htm
- Act Free zone in Malaiz, 1990. www.lexadin.com

Орос улс

- Министерство экономического развития Российской Федерации, Особые Экономические Зоны в РФ. <http://economy.gov.ru/>
- Постановление Правительства Российской Федерации N 398 «Об утверждении критериев создания особой экономической зоны»). 26 Апрель 2012. www.rg.ru/
- ФЗ об Особых Экономических Зонах Российской Федерации (в ред. Федерального «закона» от 06.12.2011 N 409-ФЗ). 8 Июль 2005. www.consultant.ru/

Серби улс

- Law on free zone, "RS Official Gazette", No 62/2006.

Солонгос улс

- Korean Special Act on Designation and Management of FEZ.
- Korean Foreign Investment Promotion Act.
- Korean Local Regulation on Managing Public Properties⁶

Турк улс

- Чөлөөт бүсийн тухай хууль №3218. 1985 оны 6-р сарын 15-ны №18785 дугаар Албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн.
- Чөлөөт бүсийн тухай журам №21520. 1993 оны 3-р сарын 10-ны Албан ёсны хэвлэлд нийтлэгдсэн.
- Special Investment Zones. www.hvac-turkey.com/

Хятад улс

- Fenwick, Ann. Evaluating China's Special Economic Zones. 1984. <http://scholarship.law.berkeley.edu/>
- Free Trade Zones Act №3218. 6 June 1985. www.ilo.org/
- Negative List, Special Administrative Measures on the entry of Foreign Investment into China (Shanghai) Free Trade Zone. 29 9 2013.
- Regulations on Special Economic Zones in Guangdong Province. 1980. www.asianlii.org/cn/
- World Bank (2009) World Development Report 2009: Reshaping Economic Geography. <http://people.hofstra.edu/geotrans/eng/>

ХАВСРАЛТ 1.

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТ

Монгол	<p>Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл:</p> <p>Чөлөөт бүс – гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, шалган нэвтрүүлэх, гаалийн болон хорио цээрийн хяналт тавих, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг ойлгож хэрэглэнэ.</p>
	<p>Чөлөөт бүсийн тухай хууль /2002 он/:</p> <p>Чөлөөт бүс - гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ.</p>
Орос	Эдийн засгийн онцгой бүс - ОХУ-ын ЗГ-аас тодорхойлсон, аж ахуйн тусгай дэглэм үйлчлэх ОХУ-ын газар нутгийн нэг хэсэг бөгөөд гаалийн чөлөөт бүсийн дэглэм үйлчилж болох газар нутаг юм.
Хятад	Тусгагдаагүй.
Турк	Тусгагдаагүй.
Серби	Чөлөөт бүс - БНСУ-ын нутаг дэвсгэрийн нэг хэсэг бөгөөд тусгайлан хашигдсан байх ба бүс доторх үйл ажиллагаа нь Чөлөөт бүсийн тухай хуулийн дагуу явагдана.
Малайз	Чөлөөт бүс - чөлөөт боомтын худалдааг дэмжих ба аж үйлдвэрүүд экспортын бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа бүхий Малайзын Сангийн сайдын шийдвэрээр тогтоосон татваргүй бүс нутгийг хэлнэ.
Солонгос	Эдийн засгийн чөлөөт бүс - ГХО-тай бизнес эрхлэгчдийн бизнесийн орчин болон гадаад иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор хөгжүүлж буй ЭЗЧБ-ийн төлөвлөлт болон менежментийн тухай тусгай хуульд заасны дагуу төлөвлөсөн, нэрлэсэн бүсийг хэлнэ.
Армен	Эдийн засгийн чөлөөт бүс - ЭЗЧБ-ийн тухай хуулийн дагуу БНАУ-ын ЗГ-аас тогтоосон, тус улсын гаалийн бүс нутгийн хүрээнээс гадна тооцогдох тусгай бүс нутаг байх ба үйл ажиллагаа нь уг хуулиар тогтоосон онцгой зохион байгуулалттай хэрэгжинэ. БНАУ-ын газар нутаг дээр ЭЗЧБ-ийг үйл ажиллагааны бүх төрөл хэлбэрээр байгуулж болно.
Беларусь	Эдийн засгийн чөлөөт бүс - тогтоосон хил хязгаартай, дотроо тухайн ЭЗЧБ-ийн оршин суугчдад хамаарах тусгай хуулийн зохицуулалттай мөн хөрөнгө оруулалтын болон хувиараа бизнес эрхлэх үйл ажиллагаа явуулахад үр ашигтай БНБУ-ын нутаг дэвсгэрийн нэг хэсэг юм.
Казахстан	Эдийн засгийн тусгай бүс - тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулахаар тодорхой хилийн хязгаарт эрх зүйн тусгайлсан зохицуулалт бүхий БНКУ-ын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ.

ХАВСРАЛТ 2.

ЧӨЛӨӨТ БУС БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

	ЧБ байгуулах хүсэлт гаргах эрх бүхий субъект	ЧБ байгуулахад тавигдах шаардлага	Хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх эрх бүхий байгууллага / Хугацаа	ЧБ-ийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр	Татан буулаах
Монгол Чөлөөт бүсийн тухай хуулийн төсөл	Засгийн газар өргөн мэдүүлнэ. (6.1)	ЧБ-ийг байгуулахад төрөөс дараах нөхцөлүүдийг баримтална (5.1): 1. ЧБ байрлах бус нутагт авто зам, төмөр зам, онгоцны буудал зэрэг шаардлагатай дэд бүтэцтэй байх буюу эдгээр дэд бүтцийн ажлуудыг хийх боломжтой байх; 2. ЧБ-д ашиглах усны нөөц, цахилгаан хангамжтай байх; 3. хот байгуулалтын норм, дүрэм, стандарт, орон зайн нөхцөлүүдийг хангасан байх; 4. ЧБ байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, хөрөнгө оруулагчид, ААН, байгууллагууд итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин нөхцөл бий болгох; 5. байгаль орчинд ээлтэй байх; 6. бус нутгийн тогтвортой хөгжил, орон нутгийн эдийн засгийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, мэргэжлийн ажилчдыг бэлтгэх нарийвчилсан төлөвлөгөөтэй байх.	УИХ шийдвэрлэнэ. (6.1) Хугацаа: Тодорхой хугацаа заагаагүй.	Хил дамнасан чөлөөт бүс (3.1.12) 18-р зүйл. ЧБ-д эрхлэх үйл ажиллагааны төрөл ЧБ-д Монгол Улсын үндэсний асуулгүй байдалд үл харшлах, олон улсын гэрээний тулгуур зарчим, шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, аялал жуулчлал үйлчилгээ, худалдаа, олон улсын банк санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом, нийгэм, зах зээл, дэд бүтэц зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болно.	Монгол Улсад ЧБ байгуулах, түүний байршил, ЧБ-д олгох газар нутгийн хэмжээ, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх, татан буулгах асуудлыг ЗГ-ын өргөн мэдүүлснээр УИХ шийдвэрлэнэ. (6.1)
Монгол Чөлөөт бүсийн тухай хууль, 2002 он	Засгийн газар өргөн мэдүүлнэ. (5.1)	Тусгагдаагүй.	УИХ шийдвэрлэнэ. (5.1) Хугацаа: Тодорхой хугацаа заагаагүй.	<ul style="list-style-type: none"> • Худалдааны • үйлдвэрлэлийн • ХАА-н • аялал жуулчлал-үйлчилгээний • эдийн засгийн 	Монгол Улсад ЧБ байгуулах, түүний байршил, ЧБ-д олгох газар нутгийн хэмжээ, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх, татан буулгах асуудлыг ЗГ-ын өргөн мэдүүлснээр УИХ шийдвэрлэнэ. (5.1)

Орос	ОХУ-ын субъектуудийн гүйцэтгэх засаглалын эрх бүхий байгууллага нь ЭЗОБ-ийг байгуулах тухай саналаа гаргана.	Аялал жуулчлалын бүсээс бусад бүсэд орон сууц байрлуулахыг хориглоно. Түүнчлэн, ЭЗОБ-д рашаан ус болон байгалийн эмчилгээний нөөцөөс бусад ашигт малтмалын олборлолт явуулахыг хориглоно.	Саналаа ОХУ-ын ЗГ-ын эрх бүхий байгууллагад хүргүүлж, ЭЗОБ-ийг ОХУ-ын ЗГ-ын шийдвэрээр байгуулна. ЗГ шийдвэрлэхдээ бүсийн явуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг санхүүжүүлэх журам болон хуульд заасан бусад асуудлуудыг хамтад нь тогтооно. Хугацаа: ЭЗОБ-ийг 49 жилийн хугацаатай байгуулна, хугацааг сунгахгүй.	<ul style="list-style-type: none">• үйлдвэрлэлийн техникийн• аялал жуулчлалын• боомтын	ЭЗОБ-ийг хугацаанаас нь өмнө татан буулгах нөхцөл: хүн амын эрүүл мэнд, амь насыг хамгаалах, байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах болон улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах шаардлага гарсан бол. ЭЗОБ байгуулснаас хойш гурван жилийн дотор үйл ажиллагаа явагдаагүй, эсхүл үйл ажиллагааны гэрээ цуцлагдсан, эсхүл гурван жил дараалан ЭЗОБ-д дэд бүтэц баригдаагүй бол. Татан буулгах асуудлыг ОХУ-ын ЗГ шийдвэрлэнэ.
Хятад	Орон нутгийн засаг захиргаанаас Хятадын Үндэсний ардын хуралд хүсэлт гаргана.	Мэдээлэл олдоогүй.	ЧБ байгуулах шийдвэрийг Хятадын Үндэсний ардын хурлаас тогтоолоор гаргана. БНХАУ нь анх 1980 онд батлагдсан Гуандун мужийн ЭЗОБ-ийн тухай тогтоолоор Гуандун дахь Шинжан, Чжухай, Шаньтоу гэсэн 3 хотод ЭЗОБ байгуулсан. Хугацаа: Мэдээлэл олдоогүй. СнЗ нь хэлэлцэж шийдвэрлэнэ.	<ul style="list-style-type: none">• аж ахуй, ХАА, мал аж ахуй, загасны аж ахуй, аялал жуулчлал, барилга, өндөр технологи бүхий аж үйлдвэрлэл	ЭЗОБ-д үйл ажиллагаа явуулж буй ААН төлөвлөсөн хугацаанаасаа өмнө үйл ажиллагаагаа зогсоохыг хүсвэл ЭЗОБ-ын удирдлага хариуцсан Гуандун мужийн хороонд татан буулгах болсон шалтгаанаа мэдүүлж, өр төлбөр, тооцоогоо барагдуулна. (Журам 11-р зүйл)
Турк	Хувь хүн болон хуулийн этгээд аль аль ЧБ байгуулах хүсэлтийг СнЗ-д гаргах эрхтэй.	ХЧБ-д Төлөвлөлтийн дээд зэвлэлөөс зөвшөөрсөн үйлдвэрлэлийн, худалдаа болон үйлчилгээний бүхий л үйл ажиллагаа явуулж болно.	Хугацаа: Мэдээлэл олдоогүй.	<ul style="list-style-type: none">• үйлдвэрлэл• худалдаа• үйлчилгээ	Тусгагдаагүй.
Серби	Нутгийн өөрөө удирдах байгууллага нь бүсийг үүсгэн байгуулах ба ингэснээр мөн	Өргөдлийн шаардлага (5): 1. бүсийг үүсгэн байгуулагч нь зөвхөн нэг бүсийн менежментийн компанийн үүсгэн байгуулагч байна; эдийн засгийн операторуудын бүртгэлд орно;	Сангийн ямаар дамжуулан ЗГ-т өргөдлөө ирүүлнэ. (4) Хугацаа: Тодорхой хугацаа заагаагүй.	Тусгагдаагүй.	Бүсийн орон зайг тогтоох шийдвэр гарснаас хойш 2 жилийн дотор бүсийн үйл ажиллагаа эхлүүлэхгүй бол хүчингүй болно. Бүсийн орон зайн

	Бүсийн менежментийн компанийн үүсгэн байгуулагч байна. (2.2)	3. бүсийг үүсгэн байгуулагч нь эдийн засаг, эд хөрөнгө, хууль бус худалдаа, болон албан үүргийнхээ эсрэг гэмт хэрэг үйлдэн шийтгэгдээгүй байх; 4. бүсийн менежментийн компанийн хариуцлагатай этгээд нь өмнөх 3 жилд удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүн байгаагүй, үйл ажиллагаа нь татан буусан эсвэл дампуурсан хуулийн этгээдтэй хамааралгүй байх;		3. бүсийг үүсгэн байгуулагч нь эдийн засаг, эд хөрөнгө, хууль бус худалдаа, болон албан үүргийнхээ эсрэг гэмт хэрэг үйлдэн шийтгэгдээгүй байх; 4. бүсийн менежментийн компанийн хариуцлагатай этгээд нь өмнөх 3 жилд удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүн байгаагүй, үйл ажиллагаа нь татан буусан эсвэл дампуурсан хуулийн этгээдтэй хамааралгүй байх;		зөвшөөрөлийг ЗГ-ын актаар хүчингүй болно.
Малайз	Засгийн газар	Мэдээлэл олдоогүй.		ЧБ байгуулах асуудлыг Сангийн яам, Олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яам хэлэлцэн шийдвэрлэнэ. Хугацаа: Мэдээлэл олдоогүй.	<ul style="list-style-type: none">• чөлөөт худалдаа арилжааны бүс• чөлөөт аж үйлдвэрийн бүс	Мэдээлэл олдоогүй.
Солонгос	Тусгай хот/хотын ЗД нь ЭЗЧБ төлөвлөх талаар хүсэлт гаргана. Хэрэв тухайн төлөвлөсөн бүс нь 2, түүнээс дээш тооны тусгай хот, хот, мужийг хамарч байгаа тохиолдолд холбогдох ЗД нар хамтран тухайн ЭЗЧБ-ийг төлөвлөх талаар хүсэлт гаргана.	ЗД нь ЭЗЧБ-ийн хөгжлийн төлөвлөгөөг гаргана. ЭЗЧБ-ийн хөгжлийн төлөвлөгөөнд заасан нутаг дэвсгэрт бусад ямар нэгэн Хуулийн дагуу хөгжлийн ажил хийх зөвшөөрөл авахыг хүссэн этгээд Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний сайдтай зөвшилцөнө. Энэ тохиолдолд Ерөнхийлөгчийн зарлигт заасны дагуу Сайд эрх бүхий ЗД-ай энэ талаар зөвшилцөнө.	ЗД нь ЭЗЧБ-ийн хөгжлийн төлөвлөгөөг хүч (ХАҮЭХ)-ний сайдад хүсэлт гаргана. Сайд ЭЗЧБ-ийн хөгжлийн төлөвлөгөөний талаар эцсийн шийдвэрийг гаргана. Хугацаа: Тодорхой хугацаа заагаагүй.	Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүч (ХАҮЭХ)-ний сайдад хүсэлт гаргана. Сайд ЭЗЧБ-ийн хөгжлийн төлөвлөгөөний талаар эцсийн шийдвэрийг гаргана.	Тусгагдаагүй.	Тусгагдаагүй.
Армен	Тусгагдаагүй	ЭЗЧБ нь дараах шаардлагуудыг хангаж байх ёстой (6.1): 1. тээврийн хэрэгсэлийн орох, гарах гарц, зогсоол болон ачаа тээвэрлэх, тэр дундаа төмөр замын ачаа тээвэрлэх зориулалтын зогсоолыг байгуулсан байх;	ЭЗЧБ-ийг ЗГ-ын шийдвэрээр байгуулна. (5.1) Хугацаа: ЗГ-ын шийдвэрээр хугацааг тогтооно. (5.2.5)	ЭЗЧБ-ийг ЗГ-ын шийдвэрээр байгуулна. (5.1) Хугацаа: ЗГ-ын шийдвэрээр хугацааг тогтооно. (5.2.5)	ЭЗЧБ-ийг үйл ажиллагааны бүх төрөл хэлбэрээр байгуулж болно. (3.1)	ЭЗЧБ-ийг дараах байдлаар татан буулгана (15.1): 1. ЗГ хугацааг нь сунгах шийдвэр гаргаагүй тохиолдолд тогтоосон хугацаа дуусгавар

		<p>2. хилийн шугамыг ЗГ-аас тогтоосон техникийн шаардлагад нийцүүлэн хилийг тогтоох;</p> <p>3. гаалийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөлөөр хангах;</p> <p>4. ЭЗЧБ-ийн дотор бараа бүтээгдэхүүнийг чөлөөтэй шилжүүлэх нөхцөлөөр хангах;</p> <p>5. аюулгүй байдлын систем, эмнэлгийн анхны тусламж болон галын аюулгүйн системээр хангагдсан байх;</p> <p>6. байнгын цэвэр ус болон бохир ус ариутгах татуурга, эрчим хүч, хийн түлш, хог хаягдал зайлуулагч, хамгийн багадаа харилцах угас болон интернет зэрэг харилцаа холбооны хэрэгсэлтэй байх;</p> <p>7. ариун цэврийн болон эрүүл ахуйн стандартыг мөрдөх;</p> <p>8. хорио цээрийн хэсэгтэй байх;</p> <p>9. бараа бүтээгдэхүүн хадгалах ложистик хэрэгсэл, түүнчлэн харилцаа холбоо, ачаа ачих буулгах, тээвэрлэх болон агуулах хэрэгсэлээр хангагдсан байх;</p>			<p>болоход;</p> <p>2. ЗГ-ын шийдвэрээр - татан буулгах болсноос болж Байгуулагч болон Операторын гаргасан хохирлыг урьдчилан нөхөн төлүүлэх ба урьдчилан татан буулгах процесс нь тухайн шийдвэр гарсны дараа нэг жилээс илүүгүй хугацаанд хэрэгжиж эхлэхгүй.</p>
Беларусь	<p>СнЗ, тухайн бүс нутгийн /Минск хот/ гүйцэтгэх хороо нь ЭЗЧБ байгуулах санаачлага гаргаж болно. (11)</p>	<p>ЭЗЧБ байгуулах асуудлын талаар хүргүүлсэн баримт бичигт дараах зүйлс багтана (11):</p> <ul style="list-style-type: none"> ЭЗЧБ байгуулах Ерөнхийлөгчийн зарлигийн төсөл, зарлигийн төсөлд ЭЗЧБ-ийн нэр, байгуулагдах хугацаа, ЭЗЧБ байгуулах зорилго болон түүний төрөл, тусгай эрх зүйн зохицуулалтын нарийвчилсан төсөөлөл, ЭЗЧБ-ийн нийт орон зай болон хилийн заагийн тодорхойлолт, ЭЗЧБ байгуулах болон түүний хөгжлийг хангах арга хэмжээ зэргийг тодорхойлно; 	<p>Тухайн бүс нутгийн /Минск хот/ гүйцэтгэх хороо ЭЗЧБ байгуулах саналаа хуульд заасан бичиг баримтыг СнЗ-д хүргүүлж, Ерөнхийлөгчийн шийдвэрээр ЭЗЧБ-ийг байгуулна. (11)</p> <p>Хугацаа: ЭЗЧБ байгуулах асуудлын талаар хүргүүлсэн баримт бичигт ЭЗЧБ байгуулах Ерөнхийлөгчийн зарлигийн төсөлд ЭЗЧБ-ийн байгуулагдах хугацааг тодорхойлно.</p>	<p>ЭЗЧБ-ийн үйл ажиллагааны төрлүүдийг ямар ЭЗЧБ байгуулах гэж байгаа, тухайн бүсэд явуулах үйл ажиллагааны мөн чанарыг харгалзан үзэн тодорхойлно. Түүнчлэн эдийн засгийн цогцолбор ЧБ-ийн үйл ажиллагааг явуулах болон зорилтыг хэрэгжүүлэхдээ ЭЗЧБ-ийн янз бүрийн чиг үүргийн төрлүүдтэй тус тус нийцүүлнэ. (4)</p>	<p>ЭЗЧБ-ийг дараах 2 тохиолдолд татан буулгана.</p> <p>1. ЭЗЧБ-ийг Ерөнхийлөгчийн шийдвэрээр хугацааг нь сунгаагүй л бол анх байгуулахад заасан хугацаа дууссанаар татан буулгана.</p> <p>2. Тухайн хугацаа дуусахаас өмнө ЭЗЧБ-ийг зөвхөн дараах тохиолдолд Ерөнхийлөгчийн</p>

Казахстан	Гүйцэтгэх засаглалын төв болон орон нутгийн байгууллага, хуулийн этгээд, эсхүл хэд хэдэн хуулийн этгээд хамтран ЭЗТБ-ийг байгуулах хүсэлтээ гаргана.	<ul style="list-style-type: none"> • ЭЗЧБ-ийн зохицуулалтын төсөл; • ЭЗЧБ-ийн захиргааны хуулийн төсөл; • тодорхой арга хэмжээ, ЭЗЧБ-ийг хөгжүүлэх ажлын санхүүгийн эх үүсвэрийн хариуцлагатай этгээд, байгууллагыг тодорхойлсон ЭЗЧБ хөгжлийн хөтөлбөрийн төсөл; • ЭЗЧБ-ийн хилийн заагийг урьдчилсан байдлаар тодорхойлсон кадастрын зураг төслийн хуулбар; • урьдчилсан байдлаар тодорхойлсон ЭЗЧБ-ийн хил доторх газрын зохион байгуулалт, эзэмшигчид, өмчлөгчид, хэрэглэгчид болон түрээслэгчдийн жагсаалт; • урьдчилсан байдлаар тодорхойлсон ЭЗЧБ-ийн хил доторх нутаг дэвсгэрт ажиллаж буй хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгч нарын жагсаалт; • ЭЗЧБ байгуулах шаардлага болон хэтийн төлөв, түүний төрөл, тухайн нутаг дэвсгэрийн нийгэм эдийн засаг болон экологийн нөхцөл байдлын судалгаа, боловсон хүчин, ажиллах хүчний нөөц бололцоо, харилцаа холбооны хангамжид үндэслэсэн ТЗЗУ, түүнчлэн ЭЗЧБ-ийн тусгай эрх зүйн зохицуулалтын ТЗЗУ. 	<p>СНЗ, тухайн бүс нутгийн Минск хот/ гүйцэтгэх хороо, ЭЗЧБ-ийн захиргаа нь ЭЗЧБ-ийн үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах санаачлага гаргаж болох ба хуульд заасан холбогдох баримт бичгийг СНЗ-д хүргүүлнэ.</p> <p>ЭЗЧБ-ийн үйл ажиллагаа явуулах хугацааг БНБУ-ын Ерөнхийлөгчийн шийдвэрээр сунгана. (11)</p>	<p>ЭЗЧБ-ийн бүс нутгийн шийдвэрээр татан буулгана. Үүнд: Хүний амь болон эрүүл мэнд, байгаль орчин, соёлын үнэт зүйлсийг хамгаалах, үндэсний аюулгүй байдал болон улсын байтлан хамгаалах хүчийг хангах шаардлагын улмаас, ЭЗЧБ-ийн оршин суугчийн статусаа алдсанаас болж тухайн бүс нэг ч оршин суугчгүй болсон, бүсийн хамгийн суугчийн оршин суугч статусаа алдсан өдрөөс эхлэн нэг жилийн дотор нэг ч хуулийн этгээд болон хувиараа бизнес эрхлэгч оршин суугчаар бүртгүүлээгүй, ЭЗЧБ байгуулах Ерөнхийлөгчийн зарлигт тодорхойлсон бүс бүс байгуулах зорилгыг бусад шалтгааны улмаас биелүүлэх боломжгүй болсон.</p>	<p>ЭЗТБ-ийг дараах 2 тохиолдолд татан буулгана.</p> <p>1. Ерөнхийлөгчийн ЭЗТБ байгуулах тухай шийдвэрт заасан хугацаа дуусгавар болсон бол татан буулгана.</p> <p>2. Ерөнхийлөгчийн тогтоосон тухайн бүсийн</p>
			Уг хүсэлтийг экспертын баг хянаж үзээд дүгнэлтээ гаргана. Экспертын алба нь ЭЗТБ-ийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэх зорилгоор БНКУ-ын Ерөнхий сайдын байгуулсан байгууллага дундын зөвлөх байгууллага юм.	Тусгагддаггүй.	ЭЗТБ байгуулах тухай шийдвэрийг 3Г-ын санал

	(7.1)	<p>болгосноор Ерөнхийлөгч шийдвэргэнэ. Ингэхдээ</p> <p>Ерөнхийлөгч нь тус бүсийн журам, үйл ажиллагааны зорилго, зорилго хэрэгжээгүйд тооцох ноцтой түвшин, тэдгээрийн шалгуурыг тогтооно.</p> <p>Хугацаа: 25 хүртэлх жилийн хугацаатай байгуулна. (8.1)</p>	<p>зорилго хэрэгжээгүйд тооцох ноцтой түвшинд хүрсэн гэж үзвэл Ерөнхийлөгчийн шийдвэрээр хугацаанаас нь өмнө татан буулгана.</p>
--	-------	---	--

ХАВСРАЛТ 3.

ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ТУСГАЙ ДЭГЛЭМ

	Гаалийн тусгай дэглэм	Визийн тусгай дэглэм	ААН-ийн бүртгэл	Хөдөлмөр эрхлэлтийн дэглэм	Мэргэжлийн хяналтын зохицуулалт
Монгол Чөлөөт бүсийн тухай хуулийн төсөл	<p>Барааг ЧБ-д оруулахад хуульд заасан баримтыг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийнэ. 3.0 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй барааг ЧБ-ээс Гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн бүрдүүлэлт шаардахгүй. Барааг ЧБ-ээс хилийн чанадад гаргахад зөвхөн бүртгэл хийнэ.</p> <p>Хилийн чанадаас ЧБ-д оруулах, ЧБ-ээс хилийн чанадад гаргах бараанд тарифын бус хязгаарлалт тогтоохгүй ба гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.</p> <p>ЧБ-д нэвтэрч буй барааг</p>	<p>Хилийн боомтод байрлалтай ЧБ-д хил залгаа орны иргэд визгүй, гуравдагч орны иргэд зохих ангиллын визээр зорчино.</p> <p>Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй, "орох-гарах" визтэй гадаадын иргэн оршин суух болон визийн зөвшөөрлийн хугацаанд аль ч ЧБ-д визгүй зорчино.</p> <p>Хилийн боомтод байрлалтай ЧБ-д зорчиж буй гуравдагч орны иргэдийн визийн хүчинтэй байх хугацааг нэг удаад 30 хүртэлх хоногоор сунгаж болно. (11.1-3)</p>	<p>ЧБ-дх ААН нь ЧБ-ийн захирагчийн ажлын алба (ЗАА)-нд бүртгүүлэх (12.1) ба ЧБ-ийн ЗАА нь баримт бичгийг хянан үзээд хуульд заасан шаардлага хангасан гэж үзвэл бүртгэн, гэрчилгээ олгоно.</p> <ul style="list-style-type: none">ГХО-тай ААН-ийг мөн адил бүртгэнэ. (12.3)ЧБ-ийн ЗАА-нд бүртгэгдсэн ААН, хуулийн этгээд нь бусад ААН, байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болно. ЧБ-д гэрээгээр хамтран ажиллах ААН хуульд заасны дагуу бүртгүүлж, бүртгэлийн гэрчилгээ	<p>ЧБ-д үйл ажиллагаа эрхэлж буй ААН-д ажиллах гадаад ажилчдын тоо нийт ажилчдын 50%-иас хэтрэхгүй байна.</p> <p>ЧБ дэх ААН, байгууллага, иргэн нь гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхэлсэн бол ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөнө.</p> <p>ЧБ-д ажиллаж буй хуулийн этгээд өөрсдийн ажилчдыг чадваржуулах, мэргэшүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн тохиолдолд зардлыг тухайн жилийн татвар ногдох орлогоос хасаж тооцно. (15.1-3)</p>	<p>ЧБ дэх мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг Мэргэжлийн хяналтын төв байгууллага дараах тохиолдолд хяналт, шалгалт хийнэ (14.1):</p> <ol style="list-style-type: none">1. гаалийн хяналтын явцад мал амьтан, ургамал, хорио цээртэй холбоотой зайлшгүй шалгах шаардлага гарсан;2. ЧБ доторх бараа бүтээгдэхүүн, хүнсний эрүүл ахуй, барилга байгууламжийн чанар, байгаль орчны бохирдолтой холбоотой гомдол ирсэн.

Монгол Чөлөөт бүсийн тухай хууль /2002 он/	сэжигтэй гэж үзвэл хуулийн дагуу үзлэг, шалгалт хийнэ. ЧБ-д дэх ААН, байгууллага нь ЧБ-д орсон, гарсан барааны бүртгэлийг цахим хэлбэрээр хөтөлнө. (10.1-7)	Тусгагдаагүй.	авна. (12.5) ЧБ-д үйл ажиллагаа эрхэлж буй ААН, хуулийн этгээдийг хуульд заасан үндэслэлээр бүртгэлээс хасна. (12.6) ЧБ дэх үйл ажиллагааны тусгай дэглэм (4) ЧБ-д ААН-ийн бүртгэлийн журмын хялбарчилсан горим үйлчлэх (4.1) ба бүртгүүлэхдээ дараах шаардлагыг хангасан байна (13.1): 1. ЧБ-д эрхлэх, татварын хөнгөлөлтөд хамаарах үйлдвэрлэл, үйлчилгээ нь тухайн ЧБ-ийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэлд нийцэх; 2. ЧБ-д эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээ нь стандартад нийцсэн дэвшилтэт арга, технологи эзэмших; 3. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж дүгнэлт гаргуулах. ЧБ-ийн захирагч өргөдлийг хянан үзээд хуульд заасан шаардлага хангасан гэж үзвэл улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоно. (13.4)	ЧБ-ийн ажиллах хүчний болон хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх асуудал ЧБ-ийн захирагчийн бүрэн эрхэд хамаарна. (7.1.5)	ЧБ дэх мэргэжлийн хяналтын алба ЧБ-д мэргэжлийн хяналтын бие даасан алба ажиллана. Мэргэжлийн хяналтын албаны орон тооны хязгаар зохион байгуулалтыг ЧБ-ийн хэлбэр, байршил, үйл ажиллагааны онцлогоос хамааруулан 3Г тогтооно. (9.1)
Орос	Хилийн чанадаас ЧБ-д оруулж буй бараанд гаалийн татвар, хураамж, тарифын бус хязгаарлалт тогтоохгүй. Гаалийн холбооны бараанд гаалийн татвар, хураамж, тарифын бус хязгаарлалт тогтоохгүй.	Тусгагдаагүй.	Үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулах өргөдөлд дараах мэдээллийг тусгана: - ЭЗӨБ-д явуулах үйл ажиллагааны чиглэл шаардагдах улсын, эсхүл хотын хөрөнгө газрын хэмжээ - шаардагдах дэд бүтэц	Тусгагдаагүй.	Тусгагдаагүй.

Хятад	ЭЗОБ-д үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээл дээр арилжаалах бөгөөд Хятадад худалдаалах нөхцөлд ЭЗОБ-ийн захиргаа хариуцсан Гуандун мужийн хорооноос тусгай зөвшөөрөл авч, холбогдох гаалийн татвар төлнө.	Гадаадын албан хаагч, ажилчдын орох, гарах нэвтрэх асуудлыг хялбарчилсан журмын дагуу явуулна.	Үүнээс гадна: - гэрчилгээ, - бизнес төлөвлөгөө, - татварын байгууллагад бүртгүүлсэн баримт	Өөрийн хөрөнгөөр ЭЗОБ-д үйл ажиллагаа явуулах сонирхол бүхий этгээд нь ЭЗОБ хариуцсан Гуандун мужийн хороонд холбогдох баримт бичиг бүрдүүлснээр үйл ажиллагааны болон газрын тусгай зөвшөөрөл авах эрх бүрдэнэ.	ЭЗОБ бүхэн хөдөлмөр үйлчилгээ хариуцсан байгууллагатай байна. ЧБ-ийн газар нутаг дээр үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд нь ажилчидтайгаа гэрээ байгуулах үүрэг хүлээнэ. ЭЗОБ-д үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн хятад ажилчдын цалин хөлс, шагнал урамшуулал, хөдөлмөрийн даатгалтай холбоотой асуудлыг ажил олгогч болон ажилчны хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна. ЭЗОБ-д үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд нь шаардлагатай эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах зохих арга хэмжээ авна.	Мэдээлэл олдоогүй.
Турк	ХЧБ, Туркийн бусад бүс хоорондын худалдаа, гадаад худалдааны дэглэмд хамаарна. Туркээс гаралтай 500 ам.доллараас доош өртөгтэй барааг, өргөдөл гаргасны үндсэн дээр экспортын татвараас чөлөөлж болно. Гадаад худалдааны дэглэм нь ХЧБ болон бусад гадаад улс, ХЧБ хоорондын худалдаанд үйлчлэхгүй.	ЧБ-д зөвшөөрөл, тусгай зөвшөөрлөөр нэвтэрнэ.	Журамд заасан баримт бичиг, үйл ажиллагааны хураамжийг Тусгай дансанд тушааснаар үйл ажиллагааны зөвшөөрөл авах эрх бүрдэнэ. ЧБ-ийн Удирдлага өргөдлийн хүлээн авч, олгохоор шийдвэрлэвэл 30 хоногийн дотор гэрээ байгуулж, баталгаажуулна. Өргөдлийг буцаасан тохиолдолд үйл ажиллагааны хураамжийг буцаан олгоно.	Гадаадын иргэнийг удирдах албан тушаал болон ажиллуулах нөхцөлд ЧБ-ийн Удирдлагаас тусгай зөвшөөрөл авна.	Мэдээлэл олдоогүй.	

Серби	Сангийн яамны тодорхойлсон комисс нь гаалийн мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны шаардлага, гаалийн хяналтын ажлыг гүйцэтгэх шаардлагуудыг тодорхойлно. (14.) Бүс доторх гадаадын худалдаа наймаа нь гэрээний дагуу хязгаарлалтгүй байна. Бүсийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт, импорт нь хязгаарлалтгүй ба худалдааны бодлогын хэмжүүр байх ёсгүй. Хориотой барааг экспортлох, импортлохыг хориглоно. Хэрэглэгч нь шаардлагатай тохиолдолд барааг түр хугацаагаар бүсээс гаргах ба бүсэд бараа оруулж ирэхэд хуулийн дагуу бараа бүтээгдэхүүний гаалийн зөвшөөрсөн үйлчилгээг үзүүлнэ. Бүсийн гаалийн мэргэжилтэн тухайн бараа нь бүс дотор үйлдвэрлэгдсэн болохыг баталсан гэрчилгээ олгоно. (16-18.)	Тусгагдаагүй.	Тусгагдаагүй.	Бүс доторх ажил олгогч болон ажилчдын хоорондын хөдөлмөрийн харилцааг хөдөлмөрийн харилцааны зохицуулдаг журмын дагуу хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна. (25.)	Тусгагдаагүй.
Солонгос	Тусгагдаагүй.	Тусгагдаагүй.	Тусгагдаагүй.	ЭЗЧБ дэх ГХО-тай байгууллагууд хамаарахгүй ба амралтын мөнгө, эмэгтэйчүүдэд жирэмсний тэтгэмж олгохгүй ажлын байрыг зөвшөөрч болно. (17.4) Хөдөлмөрийн яамнаас ЭЗЧБ дэх ГХО-тай байгууллагын ЧБ-ийн зөвлөлөөр хэлэлцэгдэж	Тусгагдаагүй.

					шийдэгдсэн мэргэжлийн гэрээт ажилчдын ажил, ажиллах хугацааг нэмэгдүүлж болно. (17.5)	
Армен	ЭЗЧБ-ын Оператор нь ЭЗЧБ дэх гаалийн харилцаа нь БНАУ-ын гаалийн хуулиар зохицуулагдана. (13.1.)	Тусгагдаагүй.	Тусгагдаагүй.	Тусгагдаагүй.	Тусгагдаагүй.	
Беларусь	Гаалийн хороотой зөвшилцсөний үндсэн дээр ЭЗЧБ-ийн оршин суугчдад гаалийн ЧБ-ийн хязгаарыг тогтоох шийдвэр гаргана. (16.) ЭЗЧБ-ийн нутаг дэвсгэрт оршин суугчдад зориулж гаалийн ЧБ-ийг байгуулна. Гаалийн ЧБ-ийг байгуулах болон үйл ажиллагааг дуусгаар болгох журам, түүний тоног төхөөрөмжийн шаардлага, ЭЗЧБ-ийн түрээслэгчдийн эрх үүргийг хууль эрх зүйн актын дагуу тодорхойлно. (24.)	Тусгагдаагүй.	Зөвхөн ЭЗЧБ-ийн хилийн зааг дотор байрлах газартай, ЭЗЧБ-ийн үйл ажиллагааны нөхцөлийн гэрээ байгуулсан БНБУ-ын хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгч нар бүртгүүлнэ. Оршин суугчаар бүртгүүлэхэд татвар төлнө. (19.)	ЭЗЧБ дэх хөдөлмөрийн болон холбогдох харилцааг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна. ЭЗЧБ-ийн хөдөлмөрийн нөөцийн нөхцлийн хувьд юуны өмнө орон нутгаас, мөн ажил олгогчийн хүсэлтээр БНБУ-ын бусад нутаг дэвсгэрээс, хуулийн дагуу гадаадын иргэд, харъяалалгүй иргэдийг оролцуулах замаар бүрдүүлнэ. (26.)	СнЗ, Төрийн Хяналтын Комисс, бус нутгийн /Минск хот/ гүйцэтгэх хороо нь ЭЗЧБ-ийн үйл ажиллагаа, үр ашгийн ерөнхий хяналтыг хэрэгжүүлнэ. (10.) СнЗ нь ЭЗЧБ-ийн дарга, СнЗ-ийн төлөөлөгчид, тухайн бус нутгийн /Минск хот/ гүйцэтгэх хороо, бусад байгууллага, хувиараа бизнес эрхлэгч нарыг оруулсан ЭЗЧБ-ийн Хяналтын зөвлөлийг байгуулж болох ба ЭЗЧБ-ийн Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, зохицуулалтыг СнЗ батална. (17.)	
Казахстан	ЭЗТБ-д гаалийн ЧБ-ийн процедур хэрэгжинэ. (26.1) ЭЗТБ-ийн нутаг дэвсгэр нь гаалийн холбооны гаалийн газар ³² нутаг дэвсгэрт хамаарах ба (26.3) үйл явцыг Гаалийн холбоо	Тусгагдаагүй.	Оролцогч нь техник-эдийн засгийн үндэслэлд тохирох хөрөнгийн чадавартай байх ёстой. Дараах субъектүүд ЭЗТБ-ийн оролцогчид хамаарахгүй (9.1):	ЭЗТБ-ийн оролцогчдоод үзүүлж буй хөнгөлөлт нь гадаадаас ажиллах хүч оруулахад дотоодын хөдөлмөрийн зах зээлээс нэр дэвшигч	ЧБ дэх төрийн хяналтыг БНКУ-ын төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн дагуу хэрэгжүүлнэ. (30.)	

³² Гаалийн холбооны гаалийн нутаг дэвсгэрт болон гаалийн ЧБ-ийн гаалийн үйл явц дахь эдийн засгийн чөлөөт /тусгай, онцгой/ бүсийн асуудалтай холбоотой гэрээ (Соглашение по вопросам свободных (специальных, особых) экономических зон на таможенной территории таможенного союза и таможенной процедуры свободной таможенной зоны) – ЭЗТБ-д гаальтай холбоотой харилцааг зохицуулна. (2017.01.01-ний өдөр хүртэл түр хугацаагаар хэрэгжүүлнэ.)

³³ Гаалийн холбоо нь хоёр ба түүнээс олон орнууд хоорондоо байгуулсан гэрээний дагуу өөр хоорондоо худалдааны татвараас чөлөөлөх, хамтран гуравдагч орноос гаалийн тарифаар дамжуулан хамгаалах зорилготой. Одоогийн байдлаар хэд хэдэн гаалийн холбоо байх ба түүний нэг нь Евроазийн эдийн засгийн нийгэмлэгийн хүрээнд буюу Беларусь, Казахстан, Оросын хооронд байгуулагдсан гаалийн холбоо (Таможенный союз ЕврАзЭС) юм.

	Болон БНКУ-ын гаалийн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ. (26.4)		<ul style="list-style-type: none">газрын хэвлийг ашиглагч,онцгой албан татвар ногдуулдаг барааны худалдааг эрхэлдэг байгууллага /татварын тухай хуулийн дагуу/,татварын тусгай зохицуулалттай байгууллага,хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт эдэлдэг байгууллага,тоглоомын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага.	оролцуулахгүйгээр шийдвэрлэх явдал юм. (28.)	
--	---	--	---	--	--

ХАВСРАЛТ 4.

ЧӨЛӨӨТ БҮСИЙН САНХҮҮЖИЛТ, ТАТВАР, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

	Татварын дэглэм	Төсөө, санхүүжилт	Газрын харилцаа
Монгол Чөлөөт бүсийн тухай хуулийн төсөл	Экспорт, импортын татвар ногдуулах, татвараас чөлөөлөх (16.1): 1. хилийн чанадаас барааг ЧБ-д импортлоход импортын, гаалийн, НӨАТ, онцгой албан татвар ногдуулахгүй; 2. импортын гаалийн, онцгой албан татвар, НӨАТ төлж гаалийн нутаг дэвсгэрт оруулсан барааг ЧБ-д оруулахад татвар ногдуулахгүй ба татвар төлсөн баримтыг үндэслэн бусад татвараас хасалт хийж буцаан олгоно; 3. Монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс ЧБ-д оруулахад экспортын гаалийн албан татвартай бол түүнийг ногдуулж, НӨАТ-ыг буцаан олгоно; 4. зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг гаалийн болон бусад татвараас чөлөөлнө;	19-р зүйл. ЧБ-ийн аж ахуйн үйл ажиллагааны орлого ЧБ-ийн ЗАА нь дараах орлогыг холбогдох байгууллагуудтай байгуулсан гэрээний үндсэн дээр төвлөрүүлж, орлогын 80 хувийг улсын төсөвт оруулна: 1. ЧБ дэх ААН, байгууллага, иргэний орлогын албан татвар, тэдгээрээс авах хураамж; 2. ЧБ-ийн төрийн өмчийн барилга, байгууламжийг эзэмшиж, ашигласны болон үйлчилгээ үзүүлсний төлбөр; 3. газрын төлбөр; 4. бусад аж ахуйн ажил, үйлчилгээний орлого.	22-р зүйл. Газрын зохицуулалт ЧБ-д олгох газрын хэмжээ, хилийн цэсийг тогтоох асуудлыг ЗГ-ын өргөн мэдүүлснээр УИХ шийдвэрлэнэ. ЧБ-ийн газар нь боомтын газар нутагт хамаарахгүй. ЧБ доторх газрыг иргэн, ААН, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэрийг ЧБ-ийн захирагч гаргаж, түүний ажлын алба газар эзэмшигч буюу ашиглагчтай гэрээ байгуулна. Шийдвэрт эзэмших, ашиглах газрын хэмжээ, хугацааг тусгасан байна. ЧБ-д иргэн, ААН, байгууллагад газар эзэмшүүлж, ашиглуулах, газрын суурь үнэлгээ болон газрын төлбөрийн хэмжээг ЗГ тогтооно. ЧБ-д газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг 50 жилийн хугацаатай олгоно. Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг нэг удаад 40 жилээр сунгаж болно.

	<div>5. ЧБ-д үйлдвэрлэсэн барааг Гаалийн нутаг дэвсгэрт оруулахад НӨАТ ногдуулахгүй; 6. бусад бараанд бусад татварыг холбогдох хуулийн дагуу ногдуулна; 7. барааг ЧБ-ээс хилийн чанадад гаргахад татвар ногдуулахгүй.</div> <div>ЧБ-д ААН-ийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт (16.2): 1. ЧБ-д дэд бүтцэд 500.0 мянган ам. доллар буюу түүнээс дээш хөрөнгө оруулсан ААН-д оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх орлогын албан татварын хөнгөлөлтийг үзүүлнэ; 2. ЧБ-д зориулсан үйлчилгээний байгууламж байгуулахад 300.0 мянган ам. доллар буюу түүнээс дээш хөрөнгө оруулсан ААН-д оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх орлогын албан татварын хөнгөлөлтийг үзүүлнэ; 3. ЧБ-д хөрөнгө оруулсан ААН-ийн татварын тайлангаар үйл ажиллагаагаа эхлүүлсний дараагийн 5 жилд албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцно: Бусад зохицуулалт (16.3): 1. үйлдвэрлэл эрхэлж буй ААН-ийг ашигт үйл ажиллагаагаа эхлүүлсний дараагийн татварын 5 жилд ногдох орлогын албан татварыг бүрэн чөлөөлнө; 2. 16.3.2. Инновацийн төсөл хэрэгжүүлсэн иргэнд тухайн жилийн хүн амын орлогын албан татварын 50 хувийг буцаан олгоно; 3. 16.3.3. ЧБ-д баригдаж бүртгэгдсэн барилга, байгууламжийг үл хөдлөх хөрөнгийн албан татвараас бүрэн чөлөөлнө.</div>	<div>Газрын суурь үнийг бүрэн төлж барагдуулсны дараа газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг олгоно. Газар эзэмших, ашиглах эрхийг гэрээ хэлэлцээр, төсөл сонгон шалгаруулах, дуудлага худалдааны аль нэг хэлбэрийг ашиглан олгоно. Энэ хуулийн 12.6.1, 12.6.2-т заасан нөхцөл байдал үүссэн ААН-ийн газар эзэмших, ашиглах эрхийг мөн адил хүчингүй болгоно. Газар эзэмших, ашиглах эрх нь хүчингүй болсон ААН-ийн оруулсан хөрөнгө оруулалт, өмч хөрөнгө ЧБ-ийн захирагчийн ажлын албаны өмчлөлд шилжинэ. 23-р зүйл. Газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт Худалдаа, аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ эрхэлж байгаа ААН-ийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 5 жилд ЧБ-д эзэмшиж, ашиглаж буй газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө. ЧБ-д эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтэц болон экспортын үйлдвэрлэл эрхэлж байгаа ААН, түүний салбарыг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 10 жилд ЧБ-д эзэмшиж, ашиглаж буй газрын төлбөрөөс бүрэн чөлөөлнө. ЧБ-д үндэсний бренд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулж буй ААН-ийг борлуулалтын үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс тооцож газрын төлбөрөөс бүрэн чөлөөлнө. ЧБ-д газар ашиглах, эзэмших гэрээ байгуулсан дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн газрын үр өгөөжийг ашиглах, эзэмших, хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа байдлыг нь харгалзан тэдгээрийг газрын төлбөрөөс тодорхой хугацаагаар хөнгөлж болно.</div>
--	--	--

Монгол Чөлөөт бүсийн тухай хууль /2002 он/	<p>Бараа оруулахад дараах албан татварыг ногдуулахгүй:</p> <ul style="list-style-type: none">ЧБ-д барааг хилийн чанадаас оруулахад импортын гаалийн, НӨАТ, онцгой албан татвар ногдуулахгүйИмпортын гаалийн, онцгой албан татвар, НӨАТ төлж гаалийн нутаг дэвсгэрт оруулсан барааг ЧБ-д оруулахад экспортын гаалийн албан татвар ногдуулахгүй. <p>Татвар ногдуулах, буцаан олгох:</p> <p>Монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс ЧБ-д оруулахад экспортын гаалийн албан татвартай бол түүнийг ногдуулж, НӨАТ-ыг буцаан олгоно.</p> <p>Бараа гаргахад дараах албан татварыг ногдуулах болон албан татвараас чөлөөлнө:</p> <ul style="list-style-type: none">барааг ЧБ-ээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад импортын гаалийн, НӨАТ, онцгой албан татвар ногдуулна; <p>Барааг ЧБ-ээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад дараах татвар ногдуулахгүй:</p> <ul style="list-style-type: none">Импортын гаалийн, НӨАТ, онцгой албан татвар ногдуулахгүй.Монголын барааг буцаан оруулахад импортын гаалийн болон онцгой албан татвар ногдуулахгүй. Энэ тохиолдолд экспортын гаалийн татварыг буцаан олгож, НӨАТ-ыг ногдуулна.Барааг хилийн чанадад гаргахад экспортын гаалийн, НӨАТ, онцгой албан татвар ногдуулахгүй. Хуулиар тусгайлан ногдуулсан бол экспортын албан татвар ногдуулна.Бусад албан татварын хөнгөлөлт, чөлөөлт үзүүлэх асуудлыг ЧБ-ийн байршил, хэлбэрийг харгалзан хуулиар тогтооно.ЧБ-д газар ашиглах, эзэмших гэрээ байгуулсан дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн газрын үр өгөөжийг ашиглах, эзэмших, хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа байдлыг нь харгалзан тэдгээрийг газрын төлбөрөөс тодорхой хугацаагаар хөнгөлөх буюу чөлөөлж болно.	<p>ЧБ-ийн төсөв (11)</p> <p>ЧБ бие даасан төсөвтэй байна.</p> <p>ЧБ-ийн төсвийг 31-аас өргөн мэдүүлсний дагуу улсын төсвийн тусгай зүйл болгон УИХ батална.</p> <p>ЧБ-ийн төсвийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:</p> <ol style="list-style-type: none">ЧБ дэх ААН, байгууллага, иргэний орлогын албан татвар, тэдгээрээс авах хураамж;ЧБ-ийн эзэмшлийн газар, байгалийн баялаг, төрийн өмчийн барилга, байгууламжийг эзэмшиж, ашигласны болон үйлчилгээ үзүүлсний төлбөр;ЧБ байгуулахад зориулж улсын болон орон нутгийн төсвөөс ЧБ-ийн төсөвт хуваарилсан төсвийн санхүүжилт;ААН, байгууллага, иргэний тусламж, хандив;бусад орлого. <p>ЧБ-ийн төсвөөс дараах зардлыг санхүүжүүлнэ.</p> <ol style="list-style-type: none">урсгал зардал;бусдад үзүүлэх үйлчилгээний зардал;ЧБ-ийн харуул хамгаалалтын зардал;мэргэжлийн хяналтын албаны зардал. <p>ЧБ-ийн төсвийн ерөнхийлөн захирагч нь ЧБ-ийн захирагч байна.</p> <p>ЧБ-д төлбөр тооцоог үндэсний болон гадаадын валютаар гүйцэтгэнэ. (13.1)</p> <p>ЧБ-д арилжааны банк, түүний салбар нэгж байгуулах болон валют зохицуулалтын журмыг ЧБ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол банктай хамтран боловсруулж батална. (13.2)</p> <p>ЧБ дэх үйл ажиллагааны тусгай дэглэм (4)</p> <p>ЧБ-д төлбөр тооцоог үндэсний болон гадаад валютаар хийнэ. ЧБ-д валютын зохицуулалтын тусгай журам үйлчилнэ. Валютын зохицуулалтын журмыг Монголбанк тогтооно. (4.5)</p>	<p>Газрын харилцаа (16)</p> <p>ЧБ-д олгох газрын хэмжээ, хилийн заагийг тогтоох асуудлыг 3Г тухайн аймгийн ИТХ-тай зөвшилцөж, холбогдох төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.</p> <p>Газрыг иргэн, ААН, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэрийг ЧБ-ийн захирагч гаргаж түүний ажлын алба газар эзэмшигч буюу ашиглагчтай гэрээ байгуулна. Шийдвэрт эзэмших, ашиглах газрын хэмжээ, хугацааг тогтооно.</p> <p>Иргэн, ААН, байгууллагад газар эзэмшүүлж, ашиглуулсны төлбөрийг Газрын төлбөрийн тухай Монгол Улсын хуульд заасан суурь үнэлгээг үндэслэн, ЧБ тус бүрт түүний байршил, үйл ажиллагааны төрлөөс хамааруулан 3Г тогтоож болно.</p>
---	--	---	---

	<ul style="list-style-type: none"> Газрын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх хугацаа, хувь хэмжээ тогтоох асуудлыг ЗГ-ын санал болгосноор УИХ шийдвэрлэнэ. 			
Орос	Татварын хөнгөлөлтийг холбооны болон бүс нутгийн хэмжээнд үзүүлнэ. Хөнгөлөлтийн хувь хэмжээ нь ЭЗОБ-ын хэлбэр, байрлаж буй субъектын эрх зүйн орчноос хамаарна.	ЭЗОБ-д инженерийн, тээврийн, нийгмийн болон бусад дэд бүтцийн барилга, байгууламжийг барихад хууль тогтоомжийн дагуу холбооны, түүний субъектүүдийн, орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулна. ЭЗОБ дахь газрын түрээсийн болон бусад төлбөр нь холбогдох шатлалын төсөвт орно.	ЭЗОБ-д газар олгох асуудлыг ЭЗОБ-ийн удирдах байгууллага ЭЗОБ байгуулах гэрээний үндсэн дээр эрхэлнэ. ЭЗОБ доторх газрыг гагцхүү түрээсийн гэрээний үндсэн дээр түр эзэмшүүлж, ашиглуулна. ЭЗОБ дахь газар түрээслэгч нь өөрсдийн өмчлөлд буй үл хөдлөх хөрөнгийн доорх газрыг худалдан авах эрхтэй. ЭЗОБ дахь газрыг төрийн, эсхүл орон нутгийн хэрэгцээнд, тус хуульд заасан үндэслэлийн дагуу дэд бүтэц байгуулах зорилгоор хураан авч болно. Эдийн засгийн хөгжлийн яам ЭЗОБ-д дахь газрын төлбөрийн дээд хэмжээг тогтооно. ЭЗОБ дахь газрын түрээсийн болон бусад төлбөр нь холбогдох шатлалын төсөвт орно. ЭЗОБ дахь газрыг давхар түрээслэх, ашиглах, эзэмших эрхээ бусдад шилжүүлэх, барьцаалах, нөхөрлөл, нийгэмлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгүүлэхийг тус тус хориглоно.	ЭЗОБ дахь газар нь төрийн мэдэлд байна. Хөрөнгө оруулагчдад газрын ашиглах хэрэгцээнд тохируулан олгоно. Үйл ажиллагааны хэлбэр, хугацаанаас хамааран ашиглалтын төлбөр, хураамжийн хэмжээ болон төлбөрийн нөхцөлийг ялгаатай тогтооно.
Хятад	<p>ЭЗОБ дахь газар нь БНХАУ-ын өмч бөгөөд ХД дэх газрыг ашиглах хугацаа, зориулалт, төлбөрийн хэлбэр зэргээс хамааран ашиглалтын эрх олгоно.</p> <ul style="list-style-type: none"> ЭЗОБ-д үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулахад шааргдах машин техник, тоног төхөөрөмж, түүхий болон хагас боловсруулсан түүхий эд болон бусад эд зүйлсийг импортын татвараас чөлөөлнө. ЭЗОБ дахь ААН-ийн орлогын албан татвар 15 хувь байна. Ингэхдээ ЭЗОБ байгуулагдсанаас 2 жилийн дотор байгуулагдсан, эсхүл 5 сая ам.доллараас дээш хөрөнгө оруулалт бүхий, эсхүл өндөр технологи нэвтрүүлж буй ААН-д тусгай хөнгөлөлт олгоно. Хөрөнгө оруулагч нь олсон ашгаараа таван жилийн турш дахин хөрөнгө оруулалт хийсэн нөхцөлд дахин хөрөнгө оруулалтын хэмжээгээр ААНОАТ-аас чөлөөлөгдөнө. 	ААН нь орлогын албан татвар, гадаад болон дотоод ажилчдын цалин хөлсийг хувь хүний орлогын албан татварыг төлсний дараагаар үлдэх ашгийг Хятадын Банк (Bank of China), эсхүл ЭЗОБ-д үйл ажиллагаа явуулах эрх бүхий Банкаар дамжуулан валют арилжааны хуульд заасан журмын дагуу гадаадад шилжүүлж болно.	ААН нь орлогын албан татвар, гадаад болон дотоод ажилчдын цалин хөлсийг хувь хүний орлогын албан татварыг төлсний дараагаар үлдэх ашгийг Хятадын Банк (Bank of China), эсхүл ЭЗОБ-д үйл ажиллагаа явуулах эрх бүхий Банкаар дамжуулан валют арилжааны хуульд заасан журмын дагуу гадаадад шилжүүлж болно.	ЭЗОБ дахь газар нь төрийн мэдэлд байна. Хөрөнгө оруулагчдад газрын ашиглах хэрэгцээнд тохируулан олгоно. Үйл ажиллагааны хэлбэр, хугацаанаас хамааран ашиглалтын төлбөр, хураамжийн хэмжээ болон төлбөрийн нөхцөлийг ялгаатай тогтооно.

Турк	<p>ХЧБ-д татвар, хураамж, шимтгэл, гаалийн болон валют арилжаатай холбоотой эрх зүйн зохицуулалт үйлчлэхгүй.</p> <p>БНТУ-ын ХЧБ-д хувь хүн болон хуулийн этгээдийн хуримтлуулсан ашиг орлогыг валют арилжааны хуулийн дагуу БНТУ-ын нутаг дэвсгэрт шилжүүлэхэд орлогын болон ААН-ийн татвараас чөлөөлнө.</p>	<p>ХЧБ байгуулах, хөгжүүлэх, сургалт, судалгааны үйл ажиллагаа дэмжих, нийтийн барилга байгууламж байгуулах, БНТУ-ын үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор БНТУ-ын Төв Банк-д "ХЧБ байгуулах, хөгжүүлэх сан" байгуулна.</p> <p>Турк улс өөрийн ЧБ-үүдийн үйл ажиллагаанаас олсон бүх орлогыг Туркийн Төв Банкнд байрлах "ЧБ-ийн орлогын тусгай данс" (Special Account for FTZ Revenue)-д татан төвлөрүүлдэг байна. Тус дансанд хуримтлагдсан орлогын 10 хувийг буцаагаад ЧБ-үүдийн хөгжил, бүтээн байгуулалт, үйлчилгээ, үйл ажиллагаанд зориулдаг. Санд дараах эх үүсвэрээс орлого хуримтлуулна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • үйл ажиллагааны лицензийн төлбөр • бүсэд нэвтэрсэн болон орхин гарсан бараа бүтээгдэхүүний CIF, FOB үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хураамж • ЧБ-ийг удирдаж байгаа хувь хүн, хуулийн этгээдтэй хийсэн гэрээний дагуу төлөгдөж буй тусгай төлбөр • бусад орлого <p>Үйл ажиллагааны мэдүүлгийн энгийн хураамж 5000 ам доллар, 49-99 жилийн хугацаатай онцгой чухал төслүүдийн мэдүүлгийн хураамж 100000-250000 ам доллар байна.</p> <p>ЧБ дахь төлбөр, тооцоо гүйлгээг гадаад валюттаар гүйцэтгэнэ. Төлбөр тооцоог Туркийн лирээр гүйцэтгэхэд 1985 онд батлагдсан СнЗ-ийн № 85/9801 шийдвэрийг дагаж мөрдөнө.</p>	<p>ЧБ-ийн төрийн мэдлийн газарт операторын барьж байгуулсан байгууламж нь үйл ажиллагаан зөвшөөрөл хүчингүй болох, хүчинтэй хугацаа дуусгавар болоход төрийн мэдэлд шилжинэ. ЧБ-ийн төрийн мэдлийн газарт төрийн мэдлийн газар, барилгын талбай, байгууламжийн хураамжийг дээд тал нь 49 жилээр чөлөөлж болно.</p> <p>ЧБ-ийн төрийн мэдлийн газарт түрээсийн үндсэн дээр барилга байгууламж барьсан нөхцөлд газар болон байгууламжийг Хэрэглэгчдэд худалдаж болно.</p>
Серби	<p>Бүсэд үйл ажиллагаа явуулах болон барилга барихад зориулагдсан бараа бүтээгдэхүүний импортод гаалийн татвар болон бусад импортын татвар ногдуулахгүй. (19.)</p> <p>Хэрэглэгчид, тухайлбал бүсийн менежментийн компанид, корпорацийн ашгийн татвар, хөдлөх хөрөнгийн татвар болон хувийн ашгийн татварыг зохицуулдаг журмын дагуу татварын хөнгөлөлт үзүүлж болно. (26.)</p>	<p>Төлбөр, төлбөрийн бүрдүүлэлт, шилжүүлэг, худалдан авах болон худалдах гадаадын эрх зүйн төндөр нь гадаадын хөрөнгийн биржийн үйл ажиллагааны зохицуулалтын дагуу явагдана. (23.) Бүсийн банк байгуулах болон банкны үйл ажиллагаа нь банкны зохицуулалтын дагуу явагдана. (24.)</p>	Тусгагдаагүй.

Малайз	ЧБ-ийн дотор оруулж ирсэн, бүтээсэн, үйлдвэрлэсэн, ханган нийлүүлсэн хуулиар тусгайлан зааж, бүрэн хориглосноос бусад аливаа бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд гааль, дотоод зах зээлийн барааны, худалдаа, үйлчилгээний зэрэг татвар, хураамжийг төлөхгүй. Тусгайлан зарлагдсан бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээнээс ЧБ нь гаалийн, дотоод зах зээлийн барааны, худалдааны, үйлчилгээний гм татвар хураамжуудыг авна.	Мэдээлэл олдоогүй.	Мэдээлэл олдоогүй.
Солонгос	Хөрөнгө оруулалтын урамшуулал БНСУ-ын хувьд ЭЗЧБ-д үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд тухайн улсад хөрөнгө оруулсаных нь төлөө дараах 5 төрлийн урамшуулал эдлүүлдэг байна. Үүнд: Татварын үр ашиг <ul style="list-style-type: none">• Бизнесийн дэмжлэг• Төрийн зохицуулалтыг халах• Амьдрах нөхцөл• Захиргааны дэмжлэг. ЭЗЧБ-ын оператор нь ашгийн татвар, нэмүү өртөгийн татвар, хөдлөх хөрөнгийн татвар болон гаалийн татвар төлөхөд онцгой эрх эдлэх ба ЭЗЧБ дэх татвар, гаалийн харилцаа нь БНАУ-ын татвар, гаалийн хуулиар зохицуулагдана. (13.1.)	Тусгагдаагүй.	Ерөнхийлөгчийн зарлигт заасны дагуу ЭЗЧБ-д газар ашиглах, эзэмшүүлэх харилцааг Үндэсний газар төлөвлөлт болон ашиглалтын тухай хуулиар зохицуулна. (9.2)
Армен	ЭЗЧБ-ын оператор нь ашгийн татвар, нэмүү өртөгийн татвар, хөдлөх хөрөнгийн татвар болон гаалийн татвар төлөхөд онцгой эрх эдлэх ба ЭЗЧБ дэх татвар, гаалийн харилцаа нь БНАУ-ын татвар, гаалийн хуулиар зохицуулагдана. (13.1.)	ЭЗЧБ дотор үйл ажиллагаа явуулах түүнчлэн оператор болон бусад ААН-үүдийн хооронд явуулсан үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой онцгой эрх нь БНАУ-ын "Валютын зохицуулалт болон хяналт"-ын тухай хуулиар тодорхойлогдоно. (13.2.)	Тусгагдаагүй
Беларусь	ЭЗЧБ-ийн татвар (23) ЭЗЧБ-ийн татварын онцгой нөхцөлүүдийг БНБУ-ын Татварын Хууль, бусад хууль, БНБУ-ын Ерөнхийлөгчийн акт, БНБУ-ын гэрээний дагуу тогтооно.	ЭЗЧБ-ийн хөгжлийн сангийн санхүүжилт (18) ЭЗЧБ-ийг байгуулах, аж үйлдвэрийн, технологийн, тээвэр, бусад дэд бүтэц зэргийг хөгжүүлэх, ЭЗЧБ-ийн захиргаанд шилжүүлсэн өмчийг БНБУ-ын өмч хэвээр байхад нь туслах, ЭЗЧБ-ийн захиргаа зэрэг ЭЗЧБ-ийн үйл ажиллагаатай холбоотой бусад зардлын санхүүжилтийг хуулийн дагуу БНБУ-ын төсөв, бусад эх үүсвэрээс гаргана. ЭЗЧБ-ийн дэд бүтэц, зар сурталчилгаа, хэвлэлийн ажил, ЭЗЧБ-ийн захиргааны ажилчидын мөнгөн урамшуулал болон бусад хэлбэрийн санхүүжилтийг ЭЗЧБ-ийн хөгжлийн сан гаргана. ЭЗЧБ-ийн хөгжлийн сангийн хөрөнгийг ЭЗЧБ-ийн захиргаа хуваарилах эрхтэй ба хүлээн авсан хөрөнгөө зүй зохистой хэрэглэх	ЭЗЧБ дэх газрын харилцааны зохицуулалт (25) ЭЗЧБ дэх газрын харилцааг газар ашиглах болон хамгаалах талаарх хууль тогтоогоор зохицуулна. ЭЗЧБ-д түрээсийн газрыг зохихон байгуулах, ашиглах, төлбөр төлөх талаарх харилцааг ЭЗЧБ-ийн хууль тогтоомжид заасан нөхцөлийн дагуу эрх зүйн актаар зохицуулна.

		зорилгоор сангийн зөвлөл байгуулна. ЭЗЧБ-ийн хөгжлийн санг байгуулах тусгай эх үүсвэр, түүний хөрөнгийг зарцуулах чиглэл, сангийн зөвлөлийн бие бүрэлдэхүүн болон бүрэн эрхийг ЭЗЧБ-ийн захиргааны саналаар БНБУ-ын СнЗ баталсан ЭЗЧБ-ийн хөгжлийн сангийн зохицуулалтаар тодорхойлно.	ЭЗТБ-ийн оролцогчдод үзүүлж хөнгөлөлт нь 10 жилийн хугацаатайгаар газар үнэ төлбөргүй эзэмшүүлнэ.
Казахстан	ЭЗТБ-ийн оролцогчдод үзүүлж буй татварын хөнгөлөлтийг Казахстаны Татварын тухай хуулиар зохицуулсан ба дараах албан татварын хөнгөлөлт үзүүлнэ (25.). Үүнд: <ul style="list-style-type: none">Аж ахуйн албан татвараас чөлөөлөх,Газрын албан татвараас чөлөөлөх,Хөрөнгийн татвараас чөлөөлөх,ЭЗТБ-ийн зорилгод нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай барааны татварыг тэлэх /барааны жагсаалтыг ЗГ тогтооно/. "Астана – шинэ хот", "Мэдээллийн технологийн парк" ЭЗТБ-ийн оролцогчид татварын нэмэлт хөнгөлөлтийг үзүүлнэ ³⁴ .	Удирдах компанийн үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ: <ul style="list-style-type: none">Удирдах компанийн ЭЗТБ-д оролцогчдод үзүүлж буй үйлчилгээний урамшуулал,Төлбөрийн орлого,Дэд бүтцийн объект, газар болон бусад хөрөнгийн түрээсийн орлого,Бусад орлого.	

ХАВСРАЛТ 5.

ЧӨЛӨӨТ БҮСИЙН УДИРДЛАГА БОЛОН ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

ЧБ-ийн удирдлагын эрх, үүрэг		ЧБ-ийн оролцогчийн эрх, үүрэг
Монгол Чөлөөт бүсийн тухай хуулийн төсөл	ЧБ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ (7.1): <ol style="list-style-type: none">ЧБ-ийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг боловсруулж, батлуулах;ЧБ-үүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах;ЧБ-ийн үйл ажиллагааг жил бүр ЗГ-т тайлагнах;ЧБ-ийн талаарх төрийн зохицуулалт, үйл ажиллагаатай холбоотой төсвийг боловсруулах;ЧБ дэх төрийн байгууллага болон ААН-үүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;ЧБ-д зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих;	Тусгагдаагүй.

³⁴ Дэлгэрэнгүйг “Чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалт, онцлог, түүхэн хөгжлийн талаарх гадаадын зарим орны туршлага” харьцуулсан судалгаанаас үзнэ үү. УИХ-ын Тамгын газрын СШХ. Код: СТ-13/238. 2013 он.

Монгол Чөлөөт бүсийн тухай хууль /2002 он/	<p>7. ЧБ-ийн хөгжлийн төсөл болон ЧБ-ийн талаар УИХ, ЗГ-аас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>8. ЧБ дэх үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг боловсруулж, батлуулах.</p> <p>ЧБ-ийн захирагч нь ЧБ-д төрийн захирагааны удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төлөөлөгч мөн. ЧБ-ийн захирагч ажлаа ЧБ-ийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүний өмнө хариуцна. ЧБ-ийн захирагч ажлын албатай байна. Ажлын албаны орон тоог ЗГ тогтооно. (8.)</p> <p>ЧБ-ийн захирагч нь ЧБ-д төрийн захирагааны удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн. Захирагчийг эдийн засгийн хөгжлийн сайд томилж, чөлөөлөх ба ажлаа эдийн засгийн хөгжлийн сайдын өмнө хариуцна. Захирагч ажлын албатай байна. Ажлын албаны орон тооны болон зардлын хязгаарыг ЗГ тогтооно.</p> <p>ЧБ-ийн ерөнхий менежер нь ЧБ-д аж ахуйн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтан ба ЧБ-ийн нийгэм, соёл, ахуйн үйлчилгээ, хот тохижилт, газар зохион байгуулалтын асуудлыг хариуцах бөгөөд эдгээр арга хэмжээг хөрөнгө оруулагчдын зөвлөл, нутгийн захирагааны байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ. Ерөнхий менежер нь ажлаа Захирагчид тайлагнаж, ЧБ дэх хөрөнгө оруулагчдын Зөвлөлд хуульд заасан 3 чиглэлээр танилцуулна.</p> <p>Хөрөнгө оруулагчдын Зөвлөл: Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалтыг татах, ЧБ-ийн хөгжлийг дэмжих, сурталчлах зорилго бүхий хөрөнгө оруулагчдын төлөөлөгчдөөс бүрдсэн хөрөнгө оруулагчдын зөвлөлтэй байж болно. Зөвлөлийн хурлаар баталсан дүрмээр үйл ажиллагаагаа зохицуулна.</p>	Тусгагдаагүй.
Орос	<p>ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2009.10.05-ны өдрийн №1105 тушаалаар ЭЗӨБ-ийг удирдах Холбооны агентлагийг татан буулгасан ЭЗӨБ байгуулах үйл ажиллагааг зохицуулах асуудлаар нэгдсэн бодлого боловсруулах, ЭЗӨБ-ийн удирдлага зэргийг Эдийн засгийн хөгжлийн яаманд шилжүүлсэн. Яамны бүтцэд ЭЗӨБ, бүс болон хотын хөгжил хариуцсан Департаментыг байгуулсан. Яам нь ЭЗӨБ-ийн удирдлагатай холбоотой зарим эрх үүргийг гэрээний үндсэн дээр ОХУ-ын субъектын гүйцэтгэх засаглалын байгууллагад, эсхүл удирдах компанид шилжүүлж болдог. Эрх бүхий байгууллагууд:</p> <ul style="list-style-type: none"> • ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗӨБ, бүс, хотын хөгжил хариуцсан Департамент) • ЭЗӨБ Нээлттэй хувь нийлүүлсэн хувьцаат нийгэмлэг • ОХУ-ын субъект (ЭЗӨБ-ын байршлаас хамаарна) <p>Удирдлага, удирдах байгууллага: ЭЗӨБ байгуулах, үйл ажиллагааг зохицуулах асуудлаар нэгдсэн бодлого боловсруулах, ЭЗӨБ-ийн удирдлага зэргийг ОХУ-ын ЗГ-аас эрх олгосон гүйцэтгэх засаглалын холбооны эрх бүхий байгууллага хариуцна. ЗГ-аас эрх олгосон гүйцэтгэх</p>	<p>ЭЗӨБ-ийн тухай хуулиар ЭЗӨБ-ийн оршин суугчийг төрөл тус бүрээр нарийн тодорхойлж өгсөн байна. Тухайлбал,</p> <ol style="list-style-type: none"> 1. <i>Үйлдвэрлэлийн ЭЗӨБ-ийн оршин суугч</i> – үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, эсхүл логистикийн үйл ажиллагаа эрхлэх ашгийн байгууллага, 2. <i>Техникийн ЭЗӨБ-ийн оршин суугч</i> – техниктэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх хувиараа аж ахуй эрхлэгч, эсхүл ашгийн байгууллага, 3. <i>Аялал жуулчлалын ЭЗӨБ-ийн оршин суугч</i> – аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх хувиараа аж ахуй эрхлэгч, эсхүл ашгийн байгууллага, 4. <i>Боомтын ЭЗӨБ-ийн оршин суугч</i> – боомтын үйл ажиллагаа эрхлэх ашгийн байгууллага. <p>ЭЗӨБ-ийн оршин суугч нь ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн, тухайн бүсийн удирдлагатай холбогдох үйл ажиллагааны гэрээг байгуулсан байна. Оршин суугчийг ЭЗӨБ-ийн тухай хуулийн дагуу зөвхөн шүүхийн шийдвэрээр бүртгэлээс хасна.</p>

	<p>засаглалын эрх бүхий байгууллага нь ЭЗОБ-ийн удирдлагатай холбоотой зарим эрх үүргийг гэрээний үндсэн дээр ОХУ-ын субъектын гүйцэтгэх засаглалын байгууллагад, эсхүл удирдах компанид шилжүүлж болно. Тус гэрээний үлгэрчилсэн загварыг ЗГ-аас эрх олгосон гүйцэтгэх засаглалын холбооны эрх бүхий байгууллага батална.</p> <p>Удирдах байгууллагын эрх, үүрэг: ЗГ-аас эрх олгосон гүйцэтгэх засаглалын холбооны эрх бүхий байгууллага нь ЧБ-ийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагаа, удирдлагын асуудлаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого боловсруулах ажлыг хэрэгжүүлнэ. ЗГ-аас эрх олгосон гүйцэтгэх засаглалын холбооны эрх бүхий байгууллага дараах эрх, үүрэгтэй. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчдийг ЭЗОБ-ийн оршин суугчаар бүртгэх, • бүртгэлийг хөтлөх, • ЗГ-ын тогтоосон журмын дагуу жил бүр ЭЗОБ-ийн үйл ажиллагааны үр дүнг дүгнэж, ЗГ-т танилцуулах, • бүсийн оршин суугчдын үйл ажиллагааг хянах, • сар бүр олон нийтийн хэвлэл мэдээллээр мэдээлэл гаргах, • ЭЗОБ-ийн нутаг дэвсгэрт гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, • бүсийн газрыг хуваарилах, удирдах, • газар болон бусад хөрөнгийг түрээслэх, • бусад. <p>Удирдах компани нь дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • ЭЗОБ байгуулах тухай гэрээний дагуу бүсийн дэд бүтэц болон бүсийн үйл ажиллагааг, • хангах бусад объектыг байгуулах, • оршин суугчид, хөрөнгө оруулагчдыг татах /ялангуяа бүсийн дэд бүтцийн объектуудыг байгуулахад/, • бүсийн төлөвлөгөөний төслийг боловсруулах, • хуулиар тогтоосон бусад үйл ажиллагаа. • ЭЗОБ-д инженерийн, тээврийн, нийгмийн болон бусад дэд бүтцийн барилга, байгууламжийг барихад хууль тогтоомжийн дагуу холбооны, түүний субъектуудын, орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулна. 	<p>ГХО-чид ЭЗОБ-д бие даан үйл ажиллагаа явуулах эрхтэй бөгөөд техниктэй холбоотой болон удирдах албан тушаалд гадаадын иргэнийг ажиллуулж болно.</p>
Хятад	<p>ЭЗОБ-ийн захиргаа хариуцсан Гуандун мужийн хороо нь дараах эрх үүрэгтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • ЧБ-ийн хөгжлийн төлөвлөлөө боловсруулж, хэрэгжилтийг хариуцна. • ЧБ-д оруулах хөрөнгө оруулалтын төслүүдийг хянаж, зөвшөөрөл олгоно. • ЧБ дэх аж ахуй болон худалдаа эрхлэх байгууллагуудын бүртгэл, газар олголтыг хариуцна. 	
Турк	<p>ЧБ-ийн Захирлуудын Зөвлөл: ЧБ-ийн Ерөнхий Захирал, Сангийн яам, Гааль, Далайн газар, Цагдаа, Туркийн Хөрөнгө оруулалтын дэмжих,</p>	<p>ХЧБ дахь ажилт, тээвэрлэлт болон боомтын үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг оператор, эсхүл эрх бүхий төрийн</p>

	<p>хөгжүүлэх агентлаг, Туркийн экспортологчдын холбоо, Туркийн чөлөөт бүсийн холбоо зэргийн холбогдох эрх бүхий албан тушаалтнуудаас бүрдэнэ. ЧБ-ийн Ерөнхий захирал ЧБЗЗ-ийн нарийн бичгийн дарга байна. ЧЦЗЗ нь ЧБ-ийн үйл ажиллагаанд хяналт тавих, ЧБ-ийн үйл ажиллагааг сайжруулах асуудлаар бодлого, санал, зөвлөмж боловсруулна.</p> <p>ЧБ-ийн удирдлага нь Гадаад худалдаа, Чөлөөт бүсийн газар /Undersecretariat of Foreign Trade and Free Zones/-т шууд захирагдана. ЧБ-ийн Удирдлагын эрх, үүрэг:</p> <ul style="list-style-type: none">• ЧБ-д төлөвлөлт, барилга байгууламж барих, ашиглах зөвшөөрөл олгох,• ЧБ-ийн орлогыг тусгай дансанд төвлөрүүлэх,• гааль, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, боомтын үйл ажиллагаа, харилцаа холбоо, эрүүл мэнд зэрэг үйлчилгээний хэвийн ажиллагаа, хоорондын уялдаа холбоог хангуулах,• гадаад худалдаа, ЧБ-ийн газар болон оператор, операторын хэрэглэгчтэй байгуулсан "үйл ажиллагаа" болон "үүсгэн байгуулах, үйл ажиллагааны" гэрээний нөхцөлийг хангуулах, хяналт тавих,• ЧБ-д нэвтрэх зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох,• үйл ажиллагааны зөвшөөрөл бүхий хувь хүн болон хуулийн этгээдэд түрээс болон худалдан авах гэрээг батлах,• бусад• ЧБ-ийн удирдлага нь өөрийн зөвшөөрөл, хяналттай холбоотой зарим эрх, үүргээ оператор, үүсгэн байгуулагч операторт шилжүүлэх эрхтэй. <p>Бүсийн менежментэд бүртгэгдсэн бүсийн менежментийн компани нь бүсийг удирдана. Бүсийг зөвхөн нэг бүсийн менежментийн компани удирдаж болно. Бүсийн менежментийн компани нь бүс дотор үйл ажиллагаа явуулахад зохион байгуулалтын болон техникийн шаардлагуудыг тусгайлан заана.</p> <p>Бүсийн менежментийн компани нь ЧБ-ийн Захиргааны зөвшөөрлийг авахаа хуульд заасан баримтыг хүргүүлэх үүрэгтэй. Бүсийн менежментийн компани нь бүсийн хэрэглэгчтэй өөрсдийн харилцан эрх үүрэг болон хуульд заасан баримтын элементүүдийг багтаасан гэрээ байгуулна.</p> <p>Бүсийн менежментийн компани нь бүсийн бизнесийн үйл ажиллагааны тайланг хуанлийн жил дууссанаас 90 өдрийн дотор ЧБ-ийн захиргаанд өгөх үүрэгтэй.</p>	<p>байгууллага, агентлаг, эсхүл хувь хүн, хуулийн этгээд гүйцэтгэж болно.ХЧБ-д үйл ажиллагаа явуулж буй ААН нь гадаадын менежер, мэргэшсэн боловсон хүчин ажиллуулж болно.</p> <p>Тус хуулиар зохицуулаагүй асуудлыг холбогдох журмуудаар зохицуулна.</p> <p>Энэхүү хууль нь ХЧБ үйл ажиллагаагаа явуулж эхэлмэгц хүчин төгөлдөр үйлчилнэ.</p> <p>ЧБ-ийн үйл ажиллагааг ЧБ-ийн гадна хашаа, хаалга баригдаж гүйцэж, орон нутгийн удирдлага, цагдаа болон гаалийн байгууллагууд үүргээ хүлээж авснаар эхэлсэнд тооцно.</p> <p>ЧБ-д үйл ажиллагаа явуулах оператор нь үйл ажиллагааны гэрээнд заасан нөхцөлийн дагуу үйл ажиллагаа явуулна. Гэрээнд дэд бүтцээр хангахгүй гэж заасан нөхцөлд гэрээнд заасан үүргийн дагуу дэд бүтэц барьж, байгуулж барилгын талбайг хэрэглэгчдэд түрээслэх, худалдах үүрэгтэй.</p>
Серби	<p>Бүсийн хэрэглэгч нь бүс дотор үйл ажиллагаа явуулах хувь хүн буюу хуулийн этгээд. (2.5)</p> <p>Бүсийн хэрэглэгч нь бүсийг үүсгэн байгуулагч, бүсийн менежментийн компани болон бусад дотоод гадаадын хуулийн этгээд болон хувь хүн байна (цаашид "хэрэглэгчид" гэх). Хэрэглэгчид нь журмын дагуу бүсийн менежментийн компанитай хамтын эрх үүргээ зохицуулах гэрээг үндэслэн бүсэд эдийн засгийн үйл ажиллагаа явуулна. Хэрэглэгчид бүсийн үйл ажиллагааны орлого зарлага бүртгэх эсвэл бүсэд явагдаж буй тэдний бизнесийн үйл ажиллагааны хэсэгт тусад нь орлого зарлага бүртгэх үүрэгтэй. Хэрэглэгчид нь Чөлөөт Бүсийн Захиргааны хэсэлтээр бизнесийн үйл ажиллагааныхаа мэдээллийг Захиргаанд өгөх үүрэгтэй. (12.)</p> <p>Энэ Хууль болон бүсийн менежментийн компанитай хийсэн гэрээний дагуу хэрэглэгч бүс доторх үйлдвэрлэл болон үйлчилгээний нөхцөлийг мөрдөнө. Бүс дотор үйл ажиллагаа явуулах болон үйлчилгээ үзүүлэхэд ямар нэгэн зүйл байгаль орчин, хүний эрүүл мэнд, бараа бүтээгдэхүүн болон улсын аюулгүй байдалд аюул учруулахгүй байх ёстой. (15.)</p> <p>ЧБ-ийн дотор үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн өргөдлийг ЧБ-ийн дотор үйл ажиллагаа явуулахыг хүссэн хэн боловч түүний захиргаанд FZ</p>	
Малайз		

	<p>Үүрэг хариуцлагыг хүлээнэ.</p> <ol style="list-style-type: none">1. ЧБ-ийн хил хязгаарын дагуу хоёр паралель хүрээ хашаа эсвэл ханыг орох ба гарах үүдтэйгээр босгож, засвар үйлчилгээг нь хийх2. Үүд дээрээ Гаалийн алба ба Шалгалтын байрыг байршуулах3. оператор ААН-үүд ЧБ-ийн хууль, дүрмийг баримтлан ажиллаж буй эсэхэд хяналт тавих4. өөрийн үйл ажиллагаа ба бодлогын тайланг жил бүр Сангийн Яаманд өгнө.5. ЧБ-д нэвтрэн, гарч буй хүмүүс ба бараа бүтээгдэхүүний хөдөлгөөнийг хянах.6. гаалийн үүргийг хамгаалж, гаалийн татвар хураамжинд хамааралтай бараа ЧБ-ийн дотор хадгалуулахгүй байхыг хариуцах.7. Гаалийн ерөнхий захиралын өгсөн аливаа бусад бүх чиглэлийг сахин биелүүлэх зэрэг болно.	<p>No 4 маягтыг бөглөн өргөдөл өгнө. Зөвшөөрлийг FZ No. 6 маягтаар олгох бөгөөд зөвшөөрлийн нөхцөл нь Бүсийн Захиргааны шийдвэрээс хамаарна. Мөн зөвшөөрлийн хуулбарыг Гаалийн Ерөнхий Захиралд өгсөн байх шаардлагатай байдаг байна.</p> <p>Харин ЧБ-ийн дотор барилга барих, түрээслэх, байр зээмших зөвшөөрлийг авахдаа FZ No.5 маягтаар өргөдөл үйлдэх ёстой. Үүний дагуу Бүсийн захиргаа хянан үзээд зөвшөөрлийг FZ No.6 маягтаар олгох ба түүний хуулбарыг мөн Гаалийн Ерөнхий Захиралд өгсөн байх ёстой. Бүсийн захиргааны зөвшөөрөлгүйгээр барилга ба түүний бүтцэд ямар ч нэмэлт өөрчлөлт хийж болохгүй.</p> <p>ЧБ-д үйл ажиллагаа явуулагчид болон операторууд нь дараах үүрэг хариуцлагыг хүлээхээр хуульчилсан байна. Тухайлбал,</p> <ol style="list-style-type: none">1. Улсын татвар болон ЧБ-ийн зохистой үйл ажиллагааг хамгаалах, хадгалах зорилгоор Бүсийн захиргаанаас оператороос операторын бүх үйл ажиллагааны бүрэн тэмдэглэл хөтлөхийг шаардаж болно.2. Тэмдэглэлийг гагцхүү Бүсийн захиргаа, Гаалийн байгууллагатай зөвлөлдсөний дараа өгсөн зөвшөөрөлөөр устгаж болно.3. Оператор нь Бүсийн Захиргаанд өмнөх сарын тайланг сар бүрийн 10-наас өмнө мөдүүлэх ёстой.4. Ямар ч оператор Захиргааны зөвшөөрөлгүйгээр ямар ч эд зүйлийг устгах ёгүй. <p>Тусгагдаагүй.</p>
Солонгос	<p>ЭЗЧБ-ийн хороо нь Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яаманд байгуулагдах ба ЭЗЧБ-ийн асуудлыг эрхэлнэ. ЭЗЧБ-ийн хороо дараах асуудлуудыг хариуцан ажиллана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• ЭЗЧБ-ийн нэгдсэн бодлого болон нэгдсэн системийн асуудлууд;• ЭЗЧБ-ийн төлөвлөлт, төлөвлөлтийн цуцлалт болон өөрчлөлттэй холбоотой асуудлууд;• ЭЗЧБ-ийн хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой асуудлууд;• ЭЗЧБ-д үйл ажиллагаа явуулах ГХО-тай үйлдвэрүүдэд шаардлагатай засаг захиргааны үйлчилгээг хангахтай холбоотой асуудлууд;• ЭЗЧБ-үүдийн хөгжилтэй холбоотой асуудлууд;• Төвийн захиргааны агентлагуудын дарга, хотын ЗД, захирагчтай ЭЗЧБ-тэй холбоотой асуудлаар санал нэгдэх асуудлууд;• Ерөнхийлөгчийн зарлигт заасан ЭЗЧБ-ийн үйл ажиллагааны төрөл болон менежменттэй холбоотой бусад чухал суудлууд. <p>ЭЗЧБ-ийн зөвлөл нь нэг дарга, нэг дэд дарга, орон тооны бус болон арваас дээшгүй орон тооны гишүүнтэй байна. ЭЗЧБ-ийн зөвлөлийн удирдлага, бүтэцтэй холбоотой асуудлуудыг Ерөнхийлөгчийн зарлигт тусгана.</p>	
Армен	<p>“Эрх бүхий этгээд” нь ЗГ-аас олгосон эрхийн дагуу ЭЗЧБ-д төрийн бодлогыг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага байх (3.4.) ба дараах бүрэн эрхийг эдэлнэ (8.1.):</p> <ol style="list-style-type: none">1. ЭЗЧБ байгуулах эсвэл татан буулгах гэрээнд нэмэлт өөрчлөлт	<p>ЭЗЧБ-ын үйл ажиллагаа нь Байгуулагчийн гаргасан үйл ажиллагааны процедурын дагуу Байгуулагч, Операторын хооронд хийсэн гэрээний үндсэн дээр явагдана (12.1)</p> <p>ЭЗЧБ байгуулах ЗГ-ын шийдвэрт тодорхойлогдсоноос бусад ЭЗЧБ дэх</p>

	<p>оруулахад 3Г-т санал хүргүүлэх;</p> <p>2. 3ЗЧБ байгуулах ажлыг гэрээгээр хүлэсэн үүргийн дагуу хянах;</p> <p>3. 3ЗЧБ-ийн Операторын зөвшөөрөлд тавигдсан шаардлагын дагуу судалгаа явуулах, шаардлагатай бол 3Г-т тусгай санал хүргүүлэх;</p> <p>4. 3Г-аас тогтоосон журмын дагуу 3ЗЧБ-ийн үйл ажиллагааны талаар Зохион байгуулагчаас мэдээлэл шаардах;</p> <p>5. БНАУ-ын хууль тогтоомжийн дагуу бусад үйл ажиллагааг явуулах;</p> <p>6. Операторт өгсөн зөвшөөрлийг цуцлахад 3Г-т санал хүргүүлэх;</p> <p>“3ЗЧБ-ийн Зохион байгуулагч” нь 3ЗЧБ-д үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дэд бүтцээр хангах 3ЗЧБ-ийг байгуулах үндсэн зорилготойгоор 3Г-аас томилсон буюу 3Г-ын шийдвэрээр сонгогдсон хуулийн этгээд байна. (3.2.)</p> <p>Зохион байгуулагчийг сонгох журам, шалгуурыг 3Г тодорхойлно. (4.6.)</p> <p>Зохион байгуулагчийн хэрэгжүүлэх эрх үүргийг хуулийн 9.1-аар тогтоосон байна.</p>	<p>бусад өөр төрлийн үйл ажиллагааг Оператор биш зөвхөн хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгч явуулна. Оператор биш хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгчийн явуулсан үйл ажиллагаа нь БНАУ-ын гаалийн нутаг дэвсгэрээс гадна явуулсан үйл ажиллагаад тооцогдохгүй. (12.2)</p> <p>“3ЗЧБ-ийн Оператор” хуулийн дагуу 3ЗЧБ-д зохион байгуулах үйл ажиллагааг дангаараа явуулах БНАУ-д бүртгэлтэй худалдааны хуулийн этгээд, хувиараа бизнес эрхлэгч эсвэл салбар нэгж, мөн 3Г-аас зөвшөөрөл олгосон, Зохион байгуулагчтай байгуулсан холбогдох гэрээ байгуулсан зөвхөн 3ЗЧБ-д энэхүү хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах гадаадын байгууллагын төлөөлөгч байна. (3.3.)</p> <p>Операторын зөвшөөрлийг 3Г-аас гаргасан журмын дагуу олгох ба цуцлана. (4.1.) Оператор нь зөвшөөрөлд заагаагүй үйл ажиллагаа эрхлэх бол нэмэлт зөвшөөрөл авна. (4.4.) Олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцад эерчил гарсан тохиолдолд тухайн зөвшөөрлийг цуцлана. (4.5.)</p> <p>3ЗЧБ-ийн оршин суугчид дараах үйл ажиллагааг 3ЗЧБ-д явуулахыг хориглоно (5.):</p> <ul style="list-style-type: none">• буу, тэсрэх сум, тэсэлгээний бодис, тэсэлгээний багаж төхөөрөмжийг үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, худалдаалах;• цацраг идэвхт болон бусад аюултай бодисыг үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, цэвэрлэх, худалдаалах;• мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх бодис болон тэдгээрийн бэлдмэлийг үйлдвэрлэх, боловсруулах, хадгалах, худалдаалах, устгах;• мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх болон хордуулагч бодис агуулсан үржүүлэгчийг тариалах, ургуулах, боловсруулах, хадгалах, худалдаалах;• оргилуун дарс, вино, шар айргаас бусад согтууруулах ундааны үйлдвэрлэл,• тамхины үйлдвэрлэл;• үнэт цаас, банкны мөнгөн тэмдэгт, зоосон мөнгө, шуудангийн марк үйлдвэрлэх;• хонжворт сугалааны үйл ажиллагаа;• радио телевизийн техникийн үйлчилгээгээс бусад дуу бичлэгийн болон телевизийн хөтөлбөр бэлтгэх, нэвтрүүлэх;• хүн амын эрүүл мэндэд аюул учруулж буй өвчтэй хүмүүсийн эмчилгээ;• онц аюултай өвчин туссан амьтадын эмчилгээ;• БНБУ-ын иргэд, гадаадын иргэд, харьяалалгүй иргэд болон БНБУ-д түр хугацаагаар суугаа иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үйл ажиллагаа. <p>3ЗТБ-д татвар төлөгчөөр бүртгэгдсэн, тус бусад тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулах төлөвлөгөөтэй байгаа дотоод, гадаадын хуулийн этгээд 3ЗТБ-д аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч буюу оролцогч байна.</p>
Беларусь	<p>СнЗ, Төрийн Хяналтын Комисс, бүс нутгийн /Минск хот/ гүйцэтгэх хороо 3ЗЧБ-ийн үйл ажиллагаа болон түүний үр ашгийн ерөнхий хяналтыг хэрэгжүүлнэ. (10.)</p> <p>3ЗЧБ-ийн захиргаа нь СнЗ-ийн институт хэлбэрээр байгуулсан БНУ-ын хуулийн этгээд юм. 3ЗЧБ-ийн захиргаа нь хуулийн дагуу СнЗ-ийн баталсан тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах; СнЗ-д үйл ажиллагаагаа тайлагнах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. 3ЗЧБ-ийн захиргааны ажилчид болон даргын цалингийн түвшинг Сайд нарын Зөвлөл тодорхойлно. (15.)</p>	
Казахстан	<p>3ЗТБ-ийн удирдах компани нь Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийн дагуу бүсийн үйл ажиллагааг хангахын тулд байгуулагдсан хуулийн этгээд юм. Удирдах компанийг Казахстаны 3Г, орон нутгийн</p>	

	<p>засаг захиргаа болон дотоод, гадаадын хуулийн этгээд байгуулж болно.</p> <p>ЭЗТБ-ийг төрийн байгууллагын саналаар байгуулж байгаа тохиолдолд удирдах компанийн саналын 50-аас багагүй хувийг, хувийн хөрнөгө оруулагчийн саналаар байгуулж байгаа тохиолдолд саналын 26-аас багагүй хувийг төр эзэмшинэ.</p> <p>Үйл ажиллагааны хэрэгжилтийн гэрээний биелэлтийн хяналтыг ЭЗТБ-ийн захиргааны тайланд үндэслэж эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.</p>	<p>ЭЗТБ-д оролцогчид дараах эрхтэй:</p> <ul style="list-style-type: none">• оролцогчид зориулсан хууль тогтоомжоор тогтоосон татварын болон бусад хөнөгөлтүүдийг эдэлж, эрхээ хамгаалуулах,• газар авч, тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулагдсан дэд бүтцийн объект барих,• тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад туслах үйл ажиллагаа эрхлэгчдийг татан оролцуулах,• бусад эрх. <p>ЭЗТБ-д аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч букуу оролцогчид дараах үүрэгтэй:</p> <ul style="list-style-type: none">• үйл ажиллагааны жилийн тайланг ЭЗТБ-ийн удирдах компанид өгөх,• хууль тогтоомж болон гэрээнд заасан үүргээ биелүүлэх.
--	--	---



МОНГОЛ УЛС, БНХАУ ХООРОНДЫН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ТОДОРХОЙ БАРААГААР БАЙГУУЛАХ БОЛОМЖ

*Р.Хатанбаатар, Н.Золтуяа /ЭЗХЯ/,
Н.Отгонсайхан /МУИС, БС/, И.Болд /УХААЯ/,
Б.Алтанцэцэг /УХААЯ/, Л.Ганхуяг /ГЕГ/,
Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа*

АГУУЛГА

1. Ерөнхий зүйл
2. БНХАУ-ын бусад улстай ЧХХ байгуулсан туршлага
3. БНХАУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах барааны талаарх судалгаа
 - 3.1 Хоёр орны хоорондын худалдаа
 - 3.2 Нүүрс, химийн бүтээгдэхүүн (синтетик газ)
 - 3.3 Төмөр болон ган
 - 3.4 Хонины мах
 - 3.5 Бусад
4. Дүгнэлт, санал

Ашигласан материал

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Орчин үед чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ) нь олон талт худалдааны тогтолцооны дараа орох худалдааны бодлогын гол арга хэрэгсэл болж, 2000 оноос ийм хэлэлцээрийг эрчимтэй байгуулж эхэлсэн. Дэлхийн хэмжээнд 500 орчим байгуулагдаад байна. Харин Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудаас чөлөөт худалдааны хэлэлцээр огт байгуулаагүй цорын ганц улс юм. 2010 оноос түнш орнуудтай ЧХХ байгуулахад анхаарч, Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэх, Япон Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах хэлэлцээг эхлүүлж үндсэнд нь дуусгаад байна.

Түнш орнуудтай ЧХХ байгуулах асуудлаар цөөнгүй судалгаа хийгдсэн. Үүний дотор БНХАУ-тай ийм хэлэлцээр байгуулах асуудал хамрагдсан.³⁵ Өмнө нь хийгдсэн судалгаагаар БНХАУ-тай ЧХХ байгуулахад болгоомжтой хандах талаар санал, дүгнэлт гаргасан байдаг.

БНХАУ нь эдийн засгийн хэмжээгээр дэлхийд нэгдүгээрт ордог, хамгийн хурдацтай өсөж буй гол эдийн засаг, сүүлийн 30 жилийн дундаж өсөлт нь 10 хувиас дээш, хамгийн том экспортлогч, 2 дахь том импортлогч улс болоод байна. БНХАУ манай худалдааны 52 хувь (2013), гадаадын шууд хөрөнгө оруулалтын 26 хувь (2013)-ийг эзэлдэг гол түнш.

Олон улсын худалдааны хөгжлийн чиг хандлага, манай улсын экспортын барааны нэр төрлийг олшруулах, зах зээлийг тэлэх шаардлага, БНХАУ-ын хөгжил, зах зээл болон манай улсын хэрэгцээг харгалзан Монгол Улс БНХАУ-тай ЧХХ байгуулах асуудлыг нарийвчлан, цөөн нэр төрлийн бараагаар хэлэлцээр байгуулах боломжит хувилбарыг судлах нь чухал юм.

³⁵"Худалдааны гол түнш орнуудтай ЧХХ байгуулах боломж болон эрсдэл", 2012 (захиалагч ҮХШХ, гүйцэтгэгч МУИС); "Монгол Улс, БНХАУ хоорондын ЧХХ-ийн төслийн үндэслэл", 2013 (захиалагч ГХЯ, гүйцэтгэгч ШУА); "БНХАУ, ОХУ-тай ЧХХ байгуулах боломж, ач холбогдол", 2014 (захиалагч ЭЗХЯ, гүйцэтгэгч ОУСХ).

Энэхүү ажлын гол зорилго нь БНХАУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээрийг цөөн нэр төрлийн бараагаар байгуулах боломжтой эсэхийг судлахад оршино. Эдгээр бараанд захиалгын дагуу нүүрс, синтетик газ, төмөр болон ган, тэдгээрээр хийсэн зүйлс, хонины махыг оруулсан болно.

Дээрх зорилгын хүрээнд БНХАУ-ын бусад улстай ЧХХ байгуулж байгаа туршлагад үндэслэн эдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ, экспорт, тарифын болон тарифын бүс зохицуулалт зэргийг онцлон судлана.

2. БНХАУ-ЫН БУСАД УЛСТАЙ ЧХХ БАЙГУУЛСАН ТУРШЛАГА

Сүүлийн жилүүдэд улс орнууд олон улсын (ДХБ), бүс нутгийн хэмжээнд болон хоёр талын худалдааны хэлэлцээрүүдийг олноор байгуулж байна. Худалдааны саад хоригийг багасган илүү нээлттэй, чөлөөтэй болгох зорилгоор чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ) байгуулдаг бөгөөд ЧХХ-ийн зарчим нь “хоорондын худалдааны дийлэнхийг”³⁶ чөлөөлөх юм. Энэхүү шаардлагын дагуу олон улсын туршлагад хоёр орны хоорондын худалдааны 90 орчим хувьд хамаарах барааны тарифыг 10 жилийн туршид бууруулж, улмаар тэглэх зарчмыг баримталж байна. Монгол Улсын Япон улстай байгуулж байгаа Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрт мөн адил зарчим үйлчилж байна. Гэсэн хэдий ч хөгжиж байгаа орнуудын онцгой хэрэгцээ шаардлага, хөгжлийн түвшинг харгалзан тэдгээрийн хоорондын ЧХХ-ийг Enabling clause буюу хөнгөлөлттэй нөхцлөөр байгуулах боломжийг олгодог.³⁷

ЧХХ-ийг худалдаа, эдийн засгаас гадна улс төр, гадаад бодлогын зорилгоор, эсвэл эдгээрийг хослуулан байгуулдаг. Тухайлбал, Тайвань өөрийн улс төрийн түншүүд болох Никарагуа, Гватемала зэрэг улстай ЧХХ байгуулсан нь илүү улс төрийн агуулгатай. Зарим улс ЧХХ-ийг туршлага хуримтлуулах зорилгоор ч хийдэг. Сингапур Шинэ Зеланд улстай, БНСУ Чили улстай, Монгол Улс Япон улстай байгуулж буй хэлэлцээрийг дурдаж болно.

Дээрхийн хүрээнд болон энэхүү ажлын зорилгоор БНХАУ-ын байгуулж буй ЧХХ-үүд, тэдгээрийн шинж чанар, онцлогийг авч үзье.

БНХАУ-ын хувьд ЧХХ-ийг ДХБ-д нэгдэж орсноос хойш буюу 2001 оноос эхлэн байгуулсан. Өнөөгийн байдлаар 12 улстай ЧХХ-ийг байгуулан хэрэгжүүлж байна. Үүнд: Хонгконг, Макао, АСЕАН, Чили, Пакистан, Шинэ Зеланд, Сингапур, Перу, Коста Рика, Исланд, Швейцар болон Австрали. Норвеги, БНСУ, Шри Ланка, Персийн булангийн орнуудтай хоёр талын хэлэлцээр байгуулж, Япон, БНСУ-тай 3 талт хэлэлцээр байгуулах шатанд байна.

БНХАУ-ын бусад улстай байгуулсан болон байгуулах шатанд байгаа хэлэлцээрүүдийг 4 хэсэгт хувааж болно: (i) Хятадын үйлдвэрлэлийн сүлжээг бэхжүүлэх (Хонгконг, Макао); (ii) хөрш зэргэлдээ орнуудтай дипломат харилцаанд ач холбогдол өгөх, мөн эдийн засгийн зорилгоор (АСЕАН, Энэтхэг, Япон, БНСУ зэрэг); (iii) байгалийн нөөц ихтэй улс орнуудтай түүхий эдийн хангамжийг бэхжүүлэх (Бразил, Булангийн орнууд, Өмнөд Африкийн гаалийн холбоо зэрэг); (iv) Австрали, Шинэ Зеланд зэрэг жижгэвтэр боловч байгалийн нөөц ихтэй орнуудтай хэлэлцээр байгуулах саналыг Хятад Улс хүлээж авсан байна.³⁸

³⁶ДХБ-ын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 24 дүгээр зүйл. Энэхүү зүйлийн тайлбар байхгүй боловч олон улсын туршлагад мөрдөж байгаа практик тогтоод байна.

³⁷Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн гишүүн орнуудын 1979 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн шийдвэр. 2008 онд ДХБ-ын хийсэн судалгаагаар энэхүү нөхцлийг ашиглан байгуулсан хэлэлцээр 30 орчим байсан байна: Энэтхэг-Бутан, Энэтхэг-Малайз, Египет-Турк, АСЕАН-БНХАУ, АПТА (Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр), АПТА-БНХАУ зэрэг. www.wto.org

³⁸John Ravenhill, Yang Jiang “China's Move to Preferential Trading: An Extension of Chinese Network Power?”, www.dur.ac.uk

Дээрх хэлэлцээрүүдээс үзэхэд БНХАУ-ын ЧХХ байгуулах туршлага АНУ, Европын Холбооны туршлагаас ялгаатай, тогтсон загвар байхгүй. Ийм хэлэлцээр байгуулахад илүү прагматик байдлаар ханддаг гэж үзэж болно. Тухайлбал, зарим ЧХХ-ийг зөвхөн барааны худалдаагаар хийсэн бол зарим нь үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалтыг мөн хамруулсан байна. АСЕАН, Пакистан, Чили Улстай ЧХХ-ийг эхлээд дан бараагаар хийж, үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалтыг хожим нэмсэн. Түүнчлэн, АСЕАН-ы орнуудтай байгуулсан ЧХХ-ийг нарийвчилсан бус, ерөнхий байдлаар, мөн АСЕАН, Пакистантай “тэгш бус” (asymmetric) зарчмаар хэлэлцээр байгуулсан. Өөрөөр хэлбэл, тариф бууруулах болон бусад үүрэг амлалтын хувьд ижил түвшинд бус, харин ялгаатай түвшинд авсан байна.

Хятад улс Азийн бүс нутгийн улс орнуудтай ЧХХ байгуулахыг илүүтэй зорьж байгаа нь Япон Улсын энэ бүс дэх нөлөөтэй өрсөлдөх, түүнчлэн, олон улсын тавцанд хөгжиж байгаа орнуудын тэргүүлэгч болохтой холбоотой.³⁹

БНХАУ-ын ЧХХ байгуулах эдийн засгийн зорилгод худалдааны түнш орнуудаар зах зээлийн эдийн засагтай улс гэж хүлээн зөвшөөрүүлэх, түүхий эдийн хангамжийг бэхжүүлэн сайжруулах, Хятадын компаниудын үйл ажиллагаанд илүү хөнгөлөлттэй нөхцөл авах зэрэг орж байна. Харин Хятадын экспортын бүтээгдэхүүнд шинэ зах зээл нээх, зах зээлийг тэлэх нь ЧХХ байгуулах гол зорилго биш гэж судалгаанд дурджээ.⁴⁰

Үйлчилгээний худалдааны хувьд БНХАУ-ын үйлчилгээний салбарын хөгжил бусад хөгжингүй улстай өрсөлдөх түвшинд хүрч чадаагүй байгаа тул ЧХХ байгуулахад үйлчилгээний худалдаанд болгоомжтой ханддаг. Тухайлбал, зарим ЧХХ-т үйлчилгээний худалдааны хэлэлцээрийг сүүлд нэмж байгуулсан байдаг. Тухайлбал, Чили, Пакистан, АСЕАН-ы орнуудтай байгуулсан ЧХХ-ийг нэрлэж болно. Хятад улс ЧХХ-ийг үе шаттай байгуулах хандлагатай нь харагдаж байна.

Түүнчлэн, ДХБ-ын гишүүн орнуудын дунд хэсэгчилсэн хэлэлцээр байгуулсан туршлага ч байна. Тухайлбал, АСЕАН-БНХАУ, САПТА буюу Өмнөд Азийн Худалдааны хөнгөлөлттэй хэлэлцээр, Лаос-Тайланд, СПАРТЕКА буюу Өмнөд Номхон далайн бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр зэрэг орж байна.

Дээрхээс дүгнэхэд, Монгол Улс БНХАУ-тай хэсэгчилсэн (дан бараагаар), эсвэл хөнгөлөлттэй нөхцлөөр цөөн бараагаар ЧХХ байгуулах боломжтой. Ийм хэлэлцээр байгуулах боломжийг эхлээд БНХАУ-аар зөвшөөрүүлэх нь эхний ээлжинд авах арга хэмжээ юм. Энэхүү судалгаанд нүүрс, нүүрсний хий (синтетик газ), төмөр болон ган, хонины махыг онцлон судлав.

3. БНХАУ-ТАЙ ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛАХ БАРААНЫ ТАЛААРХ СУДАЛГАА

3.1. Хоёр орны хоорондын худалдаа

Дээр дурдсан тодорхой бараа судлахаас өмнө Монгол Улс, БНХАУ-ын хоорондын худалдааг авч үзье.


Монгол Улсаас БНХАУ-тай хийж байсан худалдаа 1990 онд 34 сая ам.доллар, үүнээс экспорт 11.3 сая ам.доллар, импорт 22.3 сая ам.доллар, худалдааны алдагдал 11 сая ам.доллар байсан. 2013 оны байдлаар Монгол Улсын худалдааны нийт эргэлтэд Хятад

³⁹Мөн тэнд.

⁴⁰Мөн тэнд.

улс 52.1 хувь (5.5 тэрбум ам.доллар), экспортод 86.8 хувь (3.7 тэрбум ам.доллар), импортод 28.7 хувь (1.8 тэрбум ам.доллар)-ийг эзэлжээ. Хоёр орны хоорондын худалдааны оргил үе 2011 онд байсан бөгөөд нийт 6.5 тэрбум ам.долларт хүрчээ (Зураг 1).

Зураг 1. Монгол Улсын БНХАУ-тай хийж буй худалдаа, сая ам.долл. (1990-2014.10)



2014 оны эхний 10 сарын байдлаар нийт худалдаа 5.5 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үетэй харьцуулбал 23 хувиар өссөн. Мөн үед экспорт 4.0 тэрбум ам.доллар болж 35 хувиар өссөн, импорт 1.5 тэрбум ам.доллар болж, 1 хувиар өссөн. Худалдааны эргэлт нэмэгдэхэд экспортын өсөлт нөлөөлөв.

Монгол Улсаас БНХАУ-д экспортолж буй барааны бүтцийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Монгол Улсаас БНХАУ-д хийсэн экспортын барааны бүтэц
(сүүлийн 3 жил, хувиар)

HS code	Бүлгийн нэр	БНХАУ-д хийсэн нийт экспортод тухайн барааны эзлэх хувийн жин			Монгол Улсын нийт экспортод тухайн барааны эзлэх хувийн жин			БНХАУ-ын тухайн барааны импортод Монгол Улсын экспортын эзлэх хувийн жин			БНХАУ-ын нийт импортод тухайн барааны эзлэх хувийн жин		
		2011	2012	2013	2011	2012	2013	2011	2012	2013	2011	2012	2013
27	Эрдэс түлш, нефть ба тэдгээрийн бүтээгдэхүүн	49.8	53.9	47.5	43.5	48.6	38.7	0.7	0.7	0.5	15.8	17.2	16.1
26	Хүдэр, баяжмал	47	42.3	47.9	41.1	38.4	41.3	1.2	1.2	1.1	8.6	7.4	7.6
25	Давс; хүхэр; шороон эрдэс, чулуу; шаварлаг эрдэс	0.3	0.4	0.6	2.4	2.2	2	0.2	0.3	0.3	0.3	0.3	0.4
Нийт, %		97.1	96.6	96	87	89.2	82	2.1	2.2	1.9	24.7	24.9	24.1
51	Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, хялгас	1.7	2.4	2.9	2.7	3.1	6	1.7	2.6	2.7	0.2	0.2	0.2

41	Арьс, ширэн түүхий эд (ангийн үснээс бусад), боловсруулсан арьс, шир	0.4	0.4	0.5	0.5	0.4	0.8	0.2	0.2	0.2	0.4	0.4	0.4
Нийт, %		2.1	2.8	3.4	3.2	3.5	6.8	1.9	2.8	2.9	0.6	0.6	0.6
Бүгд, %		99.2	99.4	99.4	90.2	92.7	88.8	4	5.0	4.8	25.3	25.5	24.7

Дээрх хүснэгтээс үзэхэд, Монгол Улсаас БНХАУ-д хийсэн экспортын барааны бүтэц маш хязгаарлагдмал, эрдэс (96%) болон малын гаралтай ноос, ноолуур, арьс шир (3%) гэсэн нэмүү өртөг шингээгүй түүхий эд нийт экспортын 99 хувийг бүрдүүлж байна.

Монгол Улсын нийт экспортын 80-90 орчим хувь, БНХАУ-д хийж буй экспортын 97 орчим хувийг зөвхөн эрдэс бүтээгдэхүүн эзэлж байхад БНХАУ-ын тухайн барааны нийт импортод Монгол Улсын экспортын эзлэх хувь дөнгөж 2 хувийг эзэлж байгаа нь манай улсын хамаарал маш өндөр, харин хятадын тал манай экспортоос хамаарал султай байгааг харуулж байна. Эрдэс бүтээгдэхүүн нь БНХАУ-ын нийт импортод 24 орчим хувийг эзэлдэг аж.

Хоёр орны хоорондын худалдаа, манай экспортод голлох бараа болон цаашид өөрсдийн нөөцөд тулгуурлан экспортлох боломжтой гэж үзэж нүүрс, нүүрсний хий, төмөр болон ган, хонины мах зэрэг бараанд доорх судалгааг хийв. Эдгээр бараагаар ЧХХ байгуулах нөхцөлийг илүүтэй судлах нь зүйтэй гэж үзэв.

3.2 Нүүрс, нүүрсний хий (синтетик газ)

Нүүрс

Монгол Улс нүүрсний нөөцөөр дэлхийн эхний 15 орны тоонд багтдаг бөгөөд геологийн таамаг нөөц 175,5 тэрбум тонн, нарийвчилсан хайгуулын үр дүнгээр тогтоосон нь 26,5 тэрбум тонн байна.⁴¹ Энэ их нөөцийг үр ашигтай ашиглахад шинэ технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн эргэлтэд оруулах, коксжих болон чулуун нүүрсийг баяжуулах, коксжуулан экспортлох бодлого барьж байна.

2014 оны эхний улирлын байдлаар нүүрсний олборлолт өмнөх оны мөн үетэй харьцуулбал 25 хувиар буурч 4.5 сая тонн болсон⁴². Энэ нь манай нүүрсний экспорт багассантай холбоотой.


Экспорт

Монгол Улсын хувьд нүүрс нь эрчим хүчний эх үүсвэр төдийгүй манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болсон. 2004 онд 1.6 сая тонн экспортолж байсан бол 2011 он буюу оргил үедээ 21.3 сая, 2012 онд 20.9 сая, 2013 онд 18.4 сая, 2014 оны эхний 10 сарын байдлаар 14.8 сая тонн (төлөвлөснөөр 31.4 сая тонн) болжээ.

2010 оноос хойш БНХАУ-д гаргаж байгаа нийт экспортын 40 орчим хувийг нүүрс дангаараа эзэлж байсан бол 2014 оны эхний 10 сарын байдлаар 17 хувь болж огцом буурсан. Монгол Улсаас БНХАУ-д чулуун нүүрс (антрацит, коксжих, эрчим хүчний), хүрэн нүүрсийг экспортолдог (Зураг 2).

⁴¹Ашигт малтмалын газар.

⁴²2013 оны эхний улиралд 6 сая тонн байсан.

Зураг 2. Монгол Улсаас БНХАУ-д экспортолж буй нүүрс, мянган тонн

Тайлбар: 2009 оноос өмнө нүүрсийг ангилдаггүй байсан бөгөөд экспортод гарч байсан бүх нүүрсийг нэг ангиллаар бүртгэж байсан.

Нийт нүүрсний экспорт 2011 оноос хойш буурсан үзүүлэлттэй байна. Коксжих нүүрсний экспорт 2013 онд 7.7 сая тонн буюу 377 сая ам.доллар болсон. 2013 оны байдлаар БНХАУ-д гаргаж байгаа коксжих нүүрсний экспорт нийт нүүрсний экспортод 34 хувийг эзэлжээ. 2014 оны эхний 10 сарын байдлаар нийт нүүрсний экспорт 14.8 сая тонн, үүнээс коксжих нүүрс 5.0 сая тонн болов.⁴³ Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 онд БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалаар ирэх 20 жилд 1 тэрбум тонн нүүрс нийлүүлэх талаар санамж бичиг байгуулсан.

Хэрэгцээ

Олон улсын эрчим хүчний агентлаг (ОУЭХА, IEA)-ийн мэдээллээр сүүлийн 10 гаруй жилд нүүрсний үйлдвэрлэл жигд өсч байна. 2013 оны байдлаар дэлхийн нүүрсний үйлдвэрлэл 7.8 тэрбум тоннд хүрч өмнөх оноос 0.4 хувиар өссөн. 2000 оноос БНХАУ нүүрсний үйлдвэрлэлээрээ тэргүүлж, 2013 оны байдлаар 3.56 тэрбум тонн (эрчим хүчний нүүрс-3.0, коксжих нүүрс-0.5) болжээ. Монгол Улс 2013 онд 20 орчим сая тонн коксжих нүүрс үйлдвэрлэж, дэлхийд 7 дугаар байранд орсон.⁴⁴

БНХАУ дэлхийн эрчим хүчний хамгийн том хэрэглэгч бөгөөд нүүрсний хэрэгцээ жилээс жилд өсч, 2013 онд нийт эрчим хүчний хэрэглээний 81 хувийг нүүрсээр хангажээ.⁴⁵ Түүнчлэн нүүрсний импортоор дэлхийд нэгдүгээрт ордог.

БНХАУ 2013 онд 267.5 сая тонн нүүрс импортлосноос Австрали 33 хувь, Индонези 25 хувь, ОХУ 10 хувь, Монгол Улс 6 хувийг нийлүүлжээ.⁴⁶ Коксжих нүүрсний импортын хувьд, 75.4 сая тонн байсан ба Австралид 40 хувь, Монгол Улсад 20.4 хувь оногдож байна.

ОУЭХА-ийн тооцоогоор 5 жилийн хугацаанд дэлхийн нүүрсний хэрэгцээ жилд дундажаар 2.3 хувиар өсч, Хятадын хэрэгцээ дэлхийн хэрэгцээний 60 орчим хувьд хүрнэ гэж тооцоолжээ.⁴⁷

БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын хөгжлийн хурд, зах зээлийн багтаамжийг харгалзахад манай улсын хувьд ойрын 10 жилийн хугацаанд БНХАУ-д экспортолж байгаа хэмжээг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

⁴³Статистикийн мэдээллээр 2013 оноос өмнө коксжих нүүрсийг тусад нь ангилдаггүй байсан тул дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.

⁴⁴Дэлхийн нүүрсний ассоциаци. www.worldcoal.org

⁴⁵www.worldcoal.org

⁴⁶Олон улсын худалдааны төв. www.intracen.org

⁴⁷www.worldcoal.org

Тариф болон тарифын бус саад

Манай улсаас өнөөдөр БНХАУ-д гарч байгаа болон ирээдүйд гарах боломжтой барааны импортын тарифыг судалж үзвэл, БНХАУ-ын нүүрсний импортын гаалийн тариф 2014 оны 10 сарын 15-ны байдлаар 0-8 хувьтай байна. Монгол Улсаас экспортолж буй бүх төрлийн нүүрсэнд ногдуулж буй тариф “0” хувьтай байгаа боловч 2015 оны 1 дүгээр сарын 1-ээс тарифыг нэмэгдүүлж чулуун нүүрсэнд 3 хувь, коксжих нүүрсэнд 3-6 хувь байна. Харин бусад нүүрсний /эрчим хүчний/ тарифыг 6 хувь болгож нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. Тэгэхээр БНХАУ-тай ЧХХ байгуулсан тохиолдолд эдгээр бүтээгдэхүүн Монгол Улсын сонирхлын бүлгийн бараа байна. (Гаалийн тарифын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1.1-ээс үзнэ үү). Нүүрс болон бусад эрдэс бүтээгдэхүүнд БНХАУ 17 хувийн НӨАТ ногдуулдаг.

БНХАУ-ын байгуулсан ЧХХ-ээс АСЕАН, Чили, Шинэ-Зеланд, Сингапур, Перу, Коста-Рика, Исланд, Австрали Улстай байгуулсан хэлэлцээрт нүүрсний гаалийн тарифыг тэглэсэн. Иймд Монгол Улс БНХАУ-тай ЧХХ байгуулсан тохиолдолд нүүрсний гаалийн тарифыг тэглүүлэх боломжтой нь харагдаж байна.

Нөгөөтэйгүүр, БНХАУ 2014 оны нэгдүгээр сарын 1-нээс “Арилжаанд зориулагдсан нүүрсний чанарын хяналтын талаар мөрдөх түр журам”-ыг мөрдөж эхэлсэн. Уг журмын шаардлагад нийцээгүй нүүрсний импорт, борлуулалт, холын зайн тээврийг хоригложээ. Тухайлбал, 600 км-ээс дээш зайд тээвэрлэх нүүрсэнд тодорхой хязгаарлалтуудыг тогтоосон.⁴⁸ Бусад төрлийн нүүрсэнд үнслэг 30 хувиас, хүхрийн агууламж 2 хувиас бага, илчлэг нь 4300 ккал/кг-аас дээш байх ёстой. Энэ хязгаарлалт Монголын нүүрсний экспортод хэрхэн нөлөөлөх нь БНХАУ-ын нүүрсний дотоод хэрэглээний өсөлт, бууралтаас шалтгаална.

Нүүрс-химийн бүтээгдэхүүн

БНХАУ-ын 21-р зууны эрчим хүчний бодлого нүүрсийг шингэрүүлэх, хий болгон хувиргахад чиглэж байна.⁴⁹ БНХАУ нь нутгийн баруун хэсгээр эрчим хүчний томоохон 14 төвөөс бүрдсэн кластерийг байгуулж, эдгээр үйлдвэрийг нүүрс боловсруулан синтетик газ, хий, химийн бүтээгдэхүүн, бордоо зэргийг үйлдвэрлэх зорилготой юм байна. Энэ нь эдийн засгийн ач холбогдолтойгоос гадна геополитикийн бодлоготой холбоотой.

Нүүрснээс гаралтай органик нэгдлүүдээс их хэмжээгээр үйлдвэрлэгддэг хэсгийг олейфинууд (этилен, пропилен, бутadiен), ароматикүүд (бензол, толуол, ксилен), метанол гэж ерөнхийд нь ангилдаг. Дэлхийн зах зээлд яг хичнээн төрлийн химийн бүтээгдэхүүн байгаа нь тодорхойгүй боловч 700 орчим шинэ бүтээгдэхүүнийг нийлүүлдэг бөгөөд зөвхөн Европын Холбооны зах зээл дээр 140 мянга гаруй бүтээгдэхүүн, урвалж зарагддаг гэсэн мэдээ байдаг. 1970 оны үед 171 тэрбум ам.долларын химийн бүтээгдэхүүн арилжаалагдаж байсан бол 2010 оны байдлаар энэ үзүүлэлт 4,12 их наяд ам.доллар болж өссөн байна. Энэ нь химийн бүтээгдэхүүний хэрэгцээ маш их байгааг харуулж байна.

Хятадын химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2015 он хүртэл жил тутам 10 хувиар өснө гэж Америкийн химийн зөвлөл тооцсон байна. Түүнчлэн, дэлхийн аж үйлдвэрлэлд полимер композит материал, нийлэг каучук, поликарбонат болон полиуретан, понипенилен сульфид зэрэг шинэ материалууд шаардагдана.

⁴⁸Нүүрсэнд агуулагдах мөнгөн ус 0.6 мкг/г, хүнцэл 80 мкг/г, фтор 200 мкг/г, фосфор 0.15 хувиас, хлор 0.3 хувиас бага, хүрэн нүүрсний үнслэг 20 хувиас бага, хүхрийн агууламж 1 хувиас бага, илчлэг нь 3946 ккал/кг-аас дээш

⁴⁹www.fortune.com

Дээрхээс үзэхэд, Монгол Улс ойрын ирээдүйд өмнөд зах зээлийн хэрэгцээ, хэрэглээг харгалзан нүүрс-химийн салбарыг хөгжүүлж, экспортлох боломжтой юм.⁵⁰ Нүүрс хийжүүлэх үйлдвэр байгуулах чиглэлээр Засгийн газраас тодорхой ажлууд хийгдсэн. Тухайлбал, нүүрснээс шингэн түлш гарган авах технологийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материалыг гаалийн албан татвараас 2018 оныг дуустал чөлөөлсөн (УИХ-ын 2013 оны тогтоол), мөн төслийн урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулаад байна.⁵¹ Нүүрс хийжүүлэх үйлдвэр ашиглалтад орсноор 50 жилийн туршид жилд 15 тэрбум шоометр буюу 5 тэрбум ам.долларын үнэ бүхий нийлэг хийг БНХАУ-д экспортлох ба дотоодын хэрэгцээнд 1 тэрбум шоометр байгалийн хий нийлүүлэх боломжтой болно.⁵²

Түүнчлэн Монгол Улсад коксжих нүүрсийг ашиглан металлургийн кокс үйлдвэрлэж, БНХАУ-д нийлүүлэх боломж байгаа тул үйлдвэр байгуулах ТЭЗҮ-г боловсруулсан. Үйлдвэрийн хүчин чадлыг жилд 2.2 сая тонн металлургийн кокс, дайвар бүтээгдэхүүн (хий, давирхай, түүхий бензол, аммоны сульфат, хүхрийн хүчил) гаргана гэж тооцоолжээ.⁵³

Нүүрсний үйлдвэрлэлээс дагалдан гарах Органик химийн нэгдлийн бүлгийн (БТКУС 28) импортын гаалийн тариф 1-14 хувьтай байна.⁵⁴ Энэ бүлгийн барааны 80 орчим хувьд хамаарах барааны гаалийн тариф 5-14 хувьтай байгаа бөгөөд цаашид нэмэгдэхгүй. Харин үлдсэн 5-аас доош тарифтай бараа бүтээгдэхүүний тариф 2-14 хувь хүртэл өсөх боломжтой (Гаалийн тарифын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1.2-оос үзнэ үү). Эдгээр барааны гаалийн тарифыг АСЕАН, Чили, Шинэ-Зеланд, Сингапур, Коста-Рика болон Исландтай хийсэн хэлэлцээрт “тэглэсэн”. Монгол Улс БНХАУ-тай ЧХХ байгуулсан тохиолдолд нүүрсний үйлдвэрлэлээс гарган экспортлох боломж бүхий органик химийн нэгдлүүдийг тодорхой болгож, эдгээр барааны гаалийн тарифыг чөлөөлөх хүсэлт тавих нь зүйтэй.

Монголд нэмүү өртөг шингэсэн нүүрсний бүтээгдэхүүнүүдийг ирээдүйд дотооддоо үйлдвэрлэсний дараа БНХАУ-тай химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн, бараагаар ЧХХ байгуулах нь өнөөгийн нөхцөлд нийцнэ гэж үзэж байгаа хүмүүс байгаа хэдий ч БНХАУ-д нийлүүлэх зах зээлийг нээж өгсөн нөхцөлд бусад орноос (тухайлбал Япон улс) хөрөнгө оруулалт татаж өмнөд хөршид гаргах асуудал мөн нээлттэй бөгөөд хэрэгжих боломжтой.

⁵⁰Жилд 400 мянган тн бензин, 17 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий үйлдвэрлэх “Адуун чулууны хүрэн нүүрснээс шингэн түлш гарган авах” төсөл, “Багануур Энержи Корпорейшн” ХХК-ийн жилд 450 мянган тонн дизель, 100 мян. тонн хийн түлш үйлдвэрлэх “Нүүрс шингэрүүлэх” төсөл, 500 мян. тонн дизель үйлдвэрлэх “Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордыг түшиглэн байгуулах эрчим хүч, нүүрс-химийн цогцолбор” төсөл судалгааны ажлыг хийж гүйцэтгээд байна.

⁵¹Монгол Улсын Ерөнхий Сайдын БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Синопек корпорацийн хооронд “Монгол Улсад нүүрснээс нийлэг хий үйлдвэрлэх, экспортлох төсөл хэрэгжүүлэх тухай” санамж бичгийг 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Бээжин хотод байгуулсан. Тус санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголын тал буюу Уул уурхайн яамны дэргэдэх Нүүрснээс нийлэг хий үйлдвэрлэх төслийн нэгж болон Синопек корпорац хамтран Нүүрс хийжүүлэх төслийн урьдчилсан-Техник Эдийн Засгийн Үндэслэл /ТЭЗҮ/-г боловсруулаад байна. ТЭЗҮ-ийн тайланд дурьдсанаар тус төслийн хүрээнд жилд тус бүр 8 тэрбум шоометр нийлэг хий үйлдвэрлэх 2 үйлдвэр, нүүрс хийжүүлэх үйлдвэрүүдээс Улаанбаатар хот болон БНХАУ-ын хил хүртэл нийт 1050 км урт хий дамжуулах хоолой, 400 км урт ус дамжуулах хоолой болон усан сан шинээр барих, Улаанбаатар хотын ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдэхээр байна.

⁵²Ашигт малтмалын газар.

⁵³ТЭЗҮ-г “Сигнум индустриал” ХХКомпани БНХАУ-ын “МСС” компаниар хийлгэсэн бөгөөд төслөө цааш нь хөгжүүлэн ажиллаж байна.

⁵⁴Сорбитол (Д глюцитол 290544) хамгийн өндөр буюу 14 хувийн татвартай.

3.3 Төмөр болон ган

Үйлдвэрлэл, нөөц

Монгол Улсад төмрийн хүдрийн ордын 14 гол бүс нутаг байдаг бөгөөд хүдрийн нийт нөөц нь 11 тэрбум тонн юм. Үүнээс нөөц нь тогтоогдсон 33 орд байгаа ба баталгаат нөөц нь 660,8 сая тонн, таамаг нөөц нь нэг тэрбум тонн гэж тооцоологдсон байна. Монголын төмөр үйлдвэрлэгч нарын суурилагдсан хүчин чадал 122,6 мянган тонн/жил, ган туйвангийн жилийн хэрэглээ 260 орчим мянган тонн, дотоодын үйлдвэрлэгчид 2011 онд 71 мянган тонн ган туйван үйлдвэрлэж, 190 орчим мянган тонн ган туйван импортолсон. Дарханы төмөрлөгийн үйлдвэр 2011 онд 52,4 мянган тонн ган туйван үйлдвэрлэж хүчин чадлынхаа 50 гаруй хувийг ашигласан нь түүхий эдийн үнэ, хомсдолоос болсон гэж үздэг.⁵⁵ Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор төмөрлөгийн үйлдвэрийг 30 жилийн хугацаатайгаар концессийн гэрээгээр эзэмшүүлэх шийдвэр гарсан.

2012 онд Хөгжил, шинэтгэлийн хорооны захиалгаар хийлгэсэн “Монгол Улсад хар төмөрлөгийн цогцолбор барих техник эдийн засгийн урьдчилсан судалгаа”-нд Монгол Улсын ган, төмөр бүтээгдэхүүний эрэлт 2012 онд 612.6 мянган тонн байсан бол 2020 онд 1,3 сая тонн болж 2 дахин өсөх тооцоог судлаачид гаргажээ. Түүнчлэн манай улсаас БНХАУ-д жилд 1,7 сая тонн ган бүтээгдэхүүн (уртааш цувимал бүтээгдэхүүн 700 мянган тонн, хавтгай цувимал бүтээгдэхүүн 500 мянган тонн, цулдмай ширэм 500 мянган тонн) экспортлох боломжтой гэжээ.

Өсөн нэмэгдэж буй дотоодын хэрэгцээ болон экспортод чиглэсэн хар төмөрлөгийн үйлдвэрлэл бий болгоход Засгийн газар анхааран ажиллаж байна. Тухайлбал, Дархан-Сэлэнгийн бүс нутагт хар төмөрлөгийн цогцолбор байгуулах ТЭЗҮ-г Дэлхийн банктэй хамтран хийлгэж байна. Олон улсын ISO/EN стандартад нийцсэн шууд ангижруулсан төмөр, цутгамал ширэм, шингэн ширэм, төмөр бэлдэц, блюм, туйван, хөнгөн хэлбэрийн цувимал, хүнд хэлбэрийн цувимал (Н-хэлбэрийн цувимал, U-хэлбэрийн цувимал), төмөр замын рейс төмөр зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт тавин ажиллаж байна.

Экспорт, хэрэгцээ

Монгол Улсын төмрийн хүдэр, баяжмалын экспорт 2004 онд 15 мянган тонн байсан бол 2010 оноос эрс өсч эхэлсэн. 2012 онд 6,4 сая тонн, 2013 онд 6,7 сая тонн, 2014 оны эхний 10 сард 5,0 сая тонныг тус тус экспортод гаргасан. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ-д экспортолсон.⁵⁶

Хүснэгт 2. Төмрийн хүдэр баяжмалын экспорт, 2004-2014.10, мян.тонн

Он	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014.1
Нийт	15.11	177.79	312.47	240.35	1013.1	1598.12	3563.67	5802.02	6415.94	6724.47	4997.58
БНХАУ-д	15.08	177.79	259.16	240.35	1013.09	1598.12	3563.35	5802.02	6415.94	6724.47	4997.58

⁵⁵ҮХААЯ, Хүнд үйлдвэрийн бодлогын газар.

⁵⁶Төмрийн хүдэр болон хар төмөрлөгийн бүтээгдэхүүний голлох хэрэглэгч нь БНХАУ, Япон, Өмнөд Солонгос, АНУ, Европын Холбооны улсууд багтдаг.

БНХАУ 1998 онд төмрийн хүдрийн эрэлтийнхээ 28 хувийг импортоор хангаж байсан бол 2013 онд 69 орчим хувь болсон. 2015 онд БНХАУ-ын дотоодын хэрэгцээнд 670-750 сая тонн боловсруулаагүй ган шаардлагатай гэж “China Iron and Steel association” байгууллага таамаглал гаргажээ. БНХАУ-ын гангийн гол үйлдвэрүүд зүүн бүс дэх далайн эргийн дагуу төвлөрч байдаг.

Манай улстай хамгийн ойрхон оршдог Өвөр Монголд үйл ажиллагаа явуулдаг Baotou Steel Union үйлдвэрийн жилийн хүчин чадал 10 сая тонн. Хүйтнээр болон халуунаар цувсан тууз, хүнд хавтан, ширээсгүй ган хоолой, рейс төмөр, хэлбэржүүлсэн хөндлөн огтлолтой төмөр бүтээцийн ган, ган туйван, төмөр утас үйлдвэрлэх шугамуудтай, хүчин чадлаа нэмэгдүүлэхэд бэрхшээлтэй байдал нь Монгол Улс эхний ээлжинд анхдагч ширэм үйлдвэрлэж, БНХАУ-ын дээрхи бүс нутагт нийлүүлэх боломж байна.

Гаалийн тариф

БНХАУ хүдэр, баяжмалыг импортын гаалийн татваргүйгээр нэвтрүүлдэг (Хавсралт 1.3-аас үзнэ үү). Зөвхөн үнс, шаарагт 4 хувийн татвар ногдуулдаг. Харин гангийн үйлдвэрт дөрвөн зэрэглэлийн баяжуулсан хүдэр хэрэглэдэг бөгөөд импортын хүдэртээ нэгдүгээр зэрэглэлийн шаардлага тавьдаг. Энэ нь төмрийн агуулга 64 хувиас доошгүй байх ёстой ба нойтон баяжуулалт хийснээр нэгдүгээр зэрэгт хамаардаг ажээ.⁵⁷ БНХАУ-ын дотоодод олборлож буй төмрийн хүдэр дэх төмрийн агууламж буурч байгаа нь төмрийн хүдэр олборлох зардлыг өсгөж, өрсөлдөх чадварыг бууруулсаар байгаа юм. Иймд Монгол Улс бүтээгдэхүүний зэрэглэлээ ахиулж чадсан тохиолдолд урт хугацааны давуу тал бий болж, БНХАУ-ын өндөр өртөг бүхий дотоодын үйлдвэрлэлтэй өрсөлдөх боломж бүрдэнэ.

БНХАУ-ын төмөр, гангийн бүтээгдэхүүнд (БТКУС-ийн 72-р бүлэг) ногдуулж байгаа гаалийн тариф 0-10 хувьтай байна. Эдгээр бүтээгдэхүүний 55 хувь нь 0-5 хувь, бусад нь 6-10 хувийн гаалийн тарифтай. Монгол Улсын экспортлох боломж бүхий ширэм, төмрийн хүдрийг шууд ангижруулах замаар гаргаж авсан хар төмөрлөгийн бүтээгдэхүүн, хорголжийн хувьд гаалийн тариф 1-2 хувьтай байдаг (Хавсралт 1.4-өөс үзнэ үү).

Зэвэрдэггүй гангаар хийсэн бүтээгдэхүүнүүдийн (БТКУС-ийн 7219-7123) хувьд БНХАУ-ын импортын гаалийн татвар 10 хувьтай байгаа бөгөөд ЧХХ-ийн хүрээнд гаалийн тарифыг “тэглэсэн” тохиолдолд Япон улсын талаас ижил төрлийн бүтээгдэхүүнийг Монгол Улсад үйлдвэрлэх сонирхол бий болох юм.

Монгол Улсаас экспортлох боломж бүхий төмөр болон гангийн бүтээгдэхүүний БНХАУ-ын гаалийн тарифыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. БНХАУ-ын гаалийн тариф (БТКУС-ийн 4 орноор)

Код	Барааны нэр	Тариф (2014.10.15), хувиар
7201	Анхдагч хэлбэрт ширэм	1
7202	Төмрийн хайлш. (зөвхөн ферро ванадий-9 хувь)	1-2
7203	Төмрийн хүдрийг шууд ангижруулах замаар гаргаж авсан төмрөн бүтээгдэхүүн	2
7204	Хар төмөрлөгийн хаягдал	0
7205	Ширэм ба гангийн үрэл ба нунтаг.	2
7206	Цутгамал буюу анхдагч бусад хэлбэртэй чанаржуулсан ган	2

⁵⁷www.mongolianminingjournal.com/

7207	Чанаржуулаагүй гангаар хийсэн хагас боловсруулсан бүтээгдэхүүн.	2
7208	Чанаржуулаагүй ган цувимал бүтээгдэхүүн.	3-6
7209	Чанаржуулсан ган цувимал бүтээгдэхүүн.	3-6
7210	600 мм-ээс доошгүй өргөнтэй, гальваник болон бусад төрлийн бүрхүүл суулгасан ган цувимал.	4-10
7211	600 мм-ээс доош өргөнтэй, гальваник болон бусад төрлийн бүрхүүл суулгаагүй ган цувимал.	6
7212	600 мм-ээс бага өргөнтэй, гальваник болон бусад төрлийн бүрхүүл суулгасан ган цувимал.	4-8
7213	Халуунаар цувиж ороосон чанаржуулаагүй ган цулдан ба туйван.	3-5
7214	Халуунаар цувиж, давтаж, мушгисан, чанаржуулаагүй гангаар хийсэн бусад цулдан ба туйван.	3-7
7215	Чанаржуулаагүй гангийн бусад цулдан ба туйван.	3-7
7216	Чанаржуулаагүй гангаар хийсэн булан төмөр, хэлбэрт ган, зүсмэл.	3-6
7217	Чанаржуулаагүй гангаар хийсэн утас.	8
7218	Цутгамал болон зэвэрдэггүй гангаар хийсэн хагас боловсруулсан бүтээгдэхүүн.	2
7219	600 мм-ээс багагүй өргөнтэй зэвэрдэггүй ган цувимал.	4-10
7220	600 мм-ээс доош өргөнтэй зэвэрдэггүй хавтгай ган цувимал.	10
7222	Зэвэрдэггүй гангаар хийсэн цулдан, янз бүрийн хэлбэрээр огтолсон зэвэрдэггүй ган.	10
7223	Зэвэрдэггүй ган утас.	10
7224	Цутгамал, чанаржуулсан бусад ган, тэдгээрээр хийсэн хагас боловсруулалтын бүтээгдэхүүн.	2
7225	600 мм-ээс багагүй өргөнтэй чанаржуулсан бусад гангаар хийсэн цувимал хуудсан бүтээгдэхүүн.	3-7
7226	600 мм хүртэл өргөнтэй чанаржуулсан бусад гангаар хийсэн цувимал хуудсан бүтээгдэхүүн.	3
7227	Халуунаар цувисан, хуйлсан, чанаржуулсан гангаар хийсэн цулдан ба туйван.	3-6
7228	Чанаржуулсан гангаар хийсэн, хөндий туйван ба цулдан	3-6
7229	Чанаржуулсан бусад гангаар хийсэн утас.	5-7

Эх сурвалж: Дэлхийн худалдааны байгууллага

Харин төмөр, гангаар үйлдвэрлэсэн эдлэлийн (БТКУС-ийн 73-р бүлэг) хувьд импортын гаалийн тариф нь өндөр буюу 3-23 хувьтай байна. Цаашид тарифын дээд хязгаарт хүргэнэ гэж үзвэл 30 хувьд хүрэх боломжтой.

Монгол Улсын үйлдвэрлэх боломжтой зэвэрдэггүй гангаар хийсэн эдлэлийн (БТКУС-ийн 7307, 732393, 732410 гэх мэт) хувьд БНХАУ-ын импортын гаалийн татвар 8.4-12 хувьтай байгаа бөгөөд ЧХХ-ийн хүрээнд гаалийн тарифыг тэглэсэн тохиолдолд өмнөх шатны үйлдвэрлэлийг дэмжих сайн талтай (Гаалийн тарифын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1.5-аас үзнэ үү).

БНХАУ нь АСЕАН, Шинэ-Зеланд, Сингапур, Коста-Рика, Исланд орнуудтай хийсэн хэлэлцээрт эдгээр барааны (БТКУС-ийн 72, 73 бүлгийн) гаалийн тарифыг тэглэсэн. Иймд, Монгол Улс БНХАУ-тай ЧХХ байгуулсан тохиолдолд эдгээр оронд олгосонтой ижил нөхцөл олгох хүсэлт тавих хэрэгтэй.

3.4 Хонины мах

Үйлдвэрлэл, нөөц, боломж

Сүүлийн 5 жилд малын тоо ихээхэн өсч, нийт 45.1 сая толгой мал (2013 оны байдлаар) тоолсон бөгөөд үүнээс хонь 20.1 сая, ямаа 19.2 сая, үхэр 2.9 сая, адуу 2.6 сая болсон нь мах үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж байна. Манай улс 2013 онд нийт малын 25 хувь буюу 10.2 сая толгой мал хүнсэнд хэрэглэж, 240 мянган тонн мах бэлтгэсэн.


Хүснэгт 4. Махны үйлдвэрлэл-боловсруулалтын хэмжээ

Үзүүлэлт	Х. нэгж	2008	2009	2010	2011	2012	2013	Өсөлт 2013/2012
Хөдөө аж ахуйгаас бэлтгэсэн мах	мян.тн	221.3	264.4	204.4	208.0	220.4	238.2	107.4%
Үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн	мян.тн	12.0	21.4	14.7	15.6	16.4	22.1	134.7%

Эх сурвалж: Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам

Үүнээс хонины махны үйлдвэрлэл 2013 онд 92.4 мянган тонн байсныг өмнөх онтой харьцуулбал 37 хувиар нэмэгдсэн боловч 2009 оны түвшинд байгааг доорх зургаас харж болно.

Зураг 3. ХАА-аас бэлтгэсэн мах, 2009-2013 (мян.тонн)



Улсын хэмжээнд жилд 85.0 мянган тонн тураг мах үйлдвэрлэх хүчин чадалтай 42 мал нядлах, эхлэн боловсруулах үйлдвэр бүртгэлтэйгээс 18 нь сүүлийн 3 жилд тогтмол үйл ажиллагаа эрхэлж, бусад нь суурилагдсан хүчин чадлынхаа багахан хувийг ашиглан улирлын ажиллагаатай байна. Дээрх 42 үйлдвэр нь 80 мянган тонн мах хадгалах хүчин чадал бүхий хөргөлттэй агуулахтай. Мөн хиам, нөөшилсөн бүтээгдэхүүн боловсруулах том, жижиг 130 орчим үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Нийт 5.3 сая толгой мал буюу 146.5 мянган тонн мах экспортлох боломжтой гэж ҮХААЯ үзэж байна.

Хонины махны хувьд боломжит нөөцийн урьдчилсан тооцоо болон малын махны

экспортын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн хүсэлт дээр үндэслэн ҮХААЯ-ны хийсэн судалгаагаар экспортлох боломжит нөөц нь 2015 онд хонины махны 40 хувь буюу 17.1 мянган тонн байхаар тооцсон байна. Тооцоог хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Хонь, ямааны махны экспортын нөөцийн тооцоо (2015)

№	Хүнсний нэр төрөл	ЖД хүн амын жилийн нийт хэрэгцээ, мян.тн	Дотоодын нөөц бололцоо, мян.тн		Экспортын нөөц		
			Хүнсэнд хэрэглэх малын тоонд шилжүүлбэл, мян.толгой	Хүнсэнд хэрэглэхээр тооцсон малын тоо	Мал, сүргийн эргэлтээр тооцоолсон малын тоо (мян.толгой)	Нядалгааны жингээр	2015 онд мян.тн
1.	Хонины мах	86,396.2	4,993	5,325.4	2,400.0	43.2	17,3
2.	Ямааны мах	57,536.5	4,448	4,687.3	2,100.0	29.4	11,7

Манай улсын махны хэрэглээний 30.3 хувийг хонины мах эзэлдэг бөгөөд 2013 онд 403 тонн хонь, ямааны мах экспортолсоноос үзэхэд хонины махны дийлэнхийг дотоодын хэрэгцээнд хэрэглэсэн. Нөгөөтэйгүүр, Хүнсний тухай хуулиар махыг стратегийн хүнс гэж тодорхойлсон бөгөөд 2014 онд 4.3 мянган тонн хонины мах экспортлох хязгаарлалт тогтоож, аж ахуйн нэгжүүдэд 2.8 мянган тоннын зөвшөөрөл олгожээ.

Монгол мах, махан бүтээгдэхүүн нь ерөнхийдөө чанар сайтай, органик гэж бид үздэг боловч боловсруулах үйлдвэрүүд бусад орны стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангаж чадахгүй байна. Мал нядлах, мах боловсруулах үйлдвэрүүдийн хувьд хөрөнгө санхүүгийн чадамж муу байгаагаас техник тоног төхөөрөмжийн дорвитой шинэчлэл хийгдэхгүй, үйлдвэрүүдэд олон улсын ISO 22000, HACCP зэрэг олон улсын стандарт нэвтрээгүй байна. Иймд, цаашид мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд импортлогч орны эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Экспорт

Сүүлийн жилүүдэд малын тоо толгой, үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн үзүүлэлттэй байхад мах болон малын гаралтай хүнсний дайвар бүтээгдэхүүний экспорт эрс буурсан байна: 2010 онд-29 мянган тонн, 2011 онд-11 мянган тонн, 2012 онд-4 мянган тонн, 2013 онд-3,8 мянган тонн, 2014 оны эхний 10 сарын байдлаар 2 мянган тонн болжээ. 2013 оны экспортыг 2010 онтой харьцуулбал 7.6 дахин буурсан үзүүлэлт байна (Хүснэгт 6-д үзүүлэв).

Хүснэгт 6. Махны экспорт, 2009-2014 /тонн/

Код	Барааны нэр	Экспорт	2009	2010	2011	2012	2013	2014.10 сар
0201	Үхрийн шинэ буюу хөргөсөн мах	Нийт	-	-	-	-	-	-
		БНХАУ	-	-	-	-	-	-
0202	Үхрийн хөлдүү мах	Нийт	8,818.4	3,806.2	5,795.8	965.0		440.0
		БНХАУ	50.0	-	-	-	-	-
0204	Хонь, ямааны шинэ, хөргөсөн буюу хөлдүү мах	Нийт	585.1	12,082.1	505.0	675.1	403.4	-
		БНХАУ	584.9	318.4	-	-	-	-

0205	Адуу, илжиг, луус ба хөдий луусын шинэ, хөргөсөн ба хөлдүү мах	Нийт	8,635.3	10,874.9	3,865.1	1,462.1	2,597.8	1,262.1
		БНХАУ	499.2	669.5	294.8	225.3	2,137.8	62.1
0206	Үхэр, гахай, хонь, ямаа, адуу, илжиг, луус ба хөдий луусын шинэ, хөргөсөн буюу хөлдүү хүнсний дайвар бүтээгдэхүүн	Нийт	568.4	2,048.6	414.5	821.2	790.4	192.1
		БНХАУ	557.8	1,942.8	408.8	797.2	786.8	188.5
0210	Давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан буюу утсан мах ба дайвар бүтээгдэхүүн; мах, дайвар бүтээгдэхүүний хүнсний гурил	Нийт	0.8	-	120.0	1.81	-	63.7
		БНХАУ	-	-	120.0	-	-	62.5
Нийт дүн			18,608.2	28,812.0	10,700.6	3,925.3	3,791.6	1,958.1

Хонины махны хувьд 2009 онд БНХАУ-д экспортолсон хэмжээ 585 тонн байсан бол сүүлийн 4 жилд экспорт огт хийгдээгүй байна. Энэ нь гол төлөв малын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага хангаж чадахгүй, түүнчлэн дотоодын зах зээлийн үнэ өндөр байгаатай холбоотой гэж үзэж байна.

Тариф болон тарифын бус зохицуулалт, хэрэгцээ

Хятад Улсад хонины мах экспортлоход тулгарч байгаа бас нэг саад бол импортын өндөр татвар ногдуулдаг явдал юм. БНХАУ-д хонины мах экспортлоход Хятадын гааль дээр 40 орчим хувийн татвар хураан авдаг. Үүнд: 12-23 хувийн гаалийн тариф, 13 хувийн НӨАТ орж байна. Энэ нь махны үнийг өсгөж өрсөлдөх чадварыг бууруулж байна (Гаалийн тарифын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1.6-аас үзнэ үү).

Монголын экспортын хувьд БНХАУ бол агуу том зах зээл гэдэг нь ойлгомжтой. Ялангуяа, Хятадын хүн ам, зах зээлийн хэмжээ, хүн амын орлого, хотжилт зэргээс шалтгаалан зах зээлийн хэмжээ, хүн амын хэрэглээ цаашид өсөх хандлагатай гэсэн судалгаа бий.⁵⁸ Дэлхийн хөдөө аж ахуйн салбарын 2050 он хүртэлх өсөлтөд Хятад Улс дангаараа 43 гаруй хувийг эзэлнэ гэсэн тооцоо гарчээ.⁵⁹

БНХАУ өнөөдөр хонины махны хувьд дэлхийн хамгийн том зах зээл. Хятадын хүн амын махны хэрэглээг авч үзвэл гахайн мах нийт махны хэрэглээний 65 хувь, тахианы мах-20 хувь, үхэр, хонины мах нийлээд 14 орчим хувь байна. Хонины мах нь хятадын хойд болон баруун хойд нутгийн хүн амын гол хэрэглээ юм. Хятадын хонь, ямааны махны хэрэглээ сүүлийн 10-аад жилийн хугацаанд 2 дахин нэмэгдэж, жилийн хэрэгцээ нь 2 сая тоннд хүрсэн бөгөөд ойрын 10 жилд 1 сая тонноор нэмэгдэнэ гэж НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага тооцоолжээ.⁶⁰ Үүний зэрэгцээ, хонины махны үнэ сүүлийн 10 жилийн хугацаанд 2 дахин өссөн бөгөөд гахай, тахианы махны үнээс 1.5-2 дахин өндөр юм.

⁵⁸Хятад Улс 187 сая хоньтой (дэлхийн хонины 15.9 хувь). НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага. 2014 оны 2 дугаар сарын мэдээлэл.

⁵⁹www.dfat.gov.au

⁶⁰"Opportunities for NZ Meat in China". www.thebeefsite.com

Монгол Улсаас БНХАУ-д хонины мах экспортлох нь нэг талаас, хэрэгцээ нь өсөж, нөгөө талаас, дотоодын нийлүүлэлт буурч байгаа нөхцөлд ашигтай байж болно. Дотоодын нийлүүлэлт буурах шалтгаан нь үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлага, тариалангийн газар, усны хангамжийн байдалтай холбоотойгоор хонь, үхрийн мах үйлдвэрлэгчид Засгийн газраас олгож байсан дэмжлэгийг эрс багасгасан явдал юм. Иймд, хонь, үхрийн махны импорт нь сүүлийн жилүүдэд өссөн ба цаашид ч нэмэгдэх хандлагатай. 2013 оны байдлаар Хятад Улсын хонины махны нийт импорт 954 сая ам.доллар буюу 258,7 мянган тонн хүрч, 2012 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн байна. Хонины махны импортын 96 хувийг Австрали, Шинэ Зеланд Улсаас нийлүүлдэг.

Түүнчлэн, хүнсний дайвар мах (offal) сүүлийн үед эрэлт хэрэгцээтэй бараа болсон талаар зарим судалгаанд дурдсан байдаг.⁶¹ Хятад Улс 2009 онд Шинэ Зеландаас 4000 орчим тонн дайвар мах (үхэр, хонины) импортолсон бол манай улс 2010 онд 2000 орчим тонн дайвар бүтээгдэхүүн Хятад Улсад гаргасан. Тоо баримтаас харахад, манай улс энэ бүтээгдэхүүнээр Хятадын зах зээлд бусад улстай өрсөлдөн борлуулах зах зээл бий болгох боломжтой гэж дүгнэж байна. Манай улсаас 2012, 2013 онд БНХАУ-д экспортолсон хүнсний дайвар мах 800 орчим тонн болж, 2009 онтой харьцуулбал 2.5 дахин буурсан. Хятадын энэ бүтээгдэхүүнд ногдуулж байгаа гаалийн тариф 12-20 хувьтай байна.

МХЕГ-аас мэдээлснээр БНХАУ-д салаа туурайт малын гаралтай дайвар мах экспортлоогүй, харин адууны дотор эрхтэнд БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газраас олгосон зөвшөөрлөөр экспортолсон байна. Иймд, БНХАУ-д хүнсний дайвар мах экспортлоход эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хангасан байх ёстой.

Тарифын бус зохицуулалтын хувьд, БНХАУ-ын Экспорт, импортын барааны хяналтын тухай хууль, Амьтан, ургамлын гаралтай барааны экспорт, импортын хорио цээрийн тухай хуулийн дагуу махны импортын асуудлыг зохицуулж байна. Хуулийг БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар хэрэгжүүлж, мах импортлоход тавих нөхцлийг тодорхойлдог. Импортын маханд дээрх хуулиас гадна үндэсний хүнсний аюулгүй байдлын стандарт, шаардлагыг хангах ёстой бөгөөд улсын хилээр оруулах тусгай зөвшөөрлийг дээрх хяналтын байгууллагаас авдаг. Манай улс БНХАУ-тай Мал, амьтны хорио цээр болон мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг 1994 онд байгуулсан боловч хонины махны экспорттой холбоотой хоёр талын хэлэлцээр байгуулаагүй байна. Хавсралт 2-т хоёр орны хооронд энэ чиглэлээр байгуулсан хэлэлцээрийн дэлгэрэнгүйг үзнэ үү.

Манай мах боловсруулах үйлдвэрүүд БНХАУ-ын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хангах боломжийг эрэлхийлж байна. Тухайлбал, 2014 онд Монгол Улсаас БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн экспортлох аж ахуйн нэгж болон нядалгааны үйлдвэрүүдэд БНХАУ-ын холбогдох байгууллага үнэлгээ хийсэн. Үнэлгээний дагуу “Хатансүйх импекс”, “Хүн-Од”, “Мах маркет” ХХК БНХАУ-д бүртгүүлэх зөвшөөрөл авсан. Мөн нядалгааны газрын хувьд аж ахуйн нэгжүүдийг үнэлсэн. Мах маркет ХХК-ыг бүртгэхийг зөвшөөрч, Эрдэнэт хүнс, Грийн грасланд, Эрдмийт, Жиаб, Монгол эко мах, Дархан мийт фүүд ХХК зэрэг 6 компанийг засвар хийсний дараа бүртгэхийг зөвшөөрсөн бол Мах импекс, Хангай хүнс ХХК-ийг шаардлага хангахгүй хэмээн үнэлж, зөвшөөрөгдсөн нядалгааны газар нь бүртгэгдсэн аж ахуйн нэгжүүдэд түүхий эд нийлүүлж болох бөгөөд үхэр, хонины мах, махан бүтээгдэхүүн БНХАУ-д экспортлохыг хориглоно хэмээн үнэлжээ.

⁶¹Мөн тэнд.

Бусад улстай байгуулсан ЧХХ

БНХАУ Шинэ Зеланд, Австрали зэрэг хонины махны томоохон үйлдвэрлэгч улстай ЧХХ байгуулсан. Шинэ Зеланд улстай байгуулсан хэлэлцээр 2008 онд хэрэгжиж эхэлсэн бөгөөд Австрали улстай 2014 оны 11 дүгээр сард үзэглэсэн. Хэлэлцээрийн дагуу, Шинэ Зеланд Улсаас авах хонины маханд ногдуулж байгаа гаалийн тарифыг 2016 оноос тэглэхээр тохирсон. Австрали улсаас импортлох хонины махны тарифыг 2023 оноос тэглэх тохиролцоо хийсэн. Иймээс, манай улс хонины мах, махан бүтээгдэхүүн БНХАУ-д экспортлох бол Шинэ Зеланд, Австрали болон Хятадын дотоодын махтай өрсөлдөх шаардлага гарна. Хятадын зах зээлд манай хонины махны өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд тарифыг тэглэх буюу ЧХХ байгуулах замаар шийдвэрлэх боломжтой. Үүний тулд юуны өмнө хятадын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагад махны боловсруулалтыг нийцүүлэх, малыг эрүүлжүүлэх нь нэн тэргүүний зорилго байх ёстой гэж үзэж байна.

3.5 Бусад

Энэхүү судалгаанд тодорхой нэр төрлийн барааг БНХАУ-ын зах зээлд гаргах, ЧХХ байгуулах боломжийг судлах даалгавар өгсөн. Гэсэн хэдий ч өнөөгийн байдлаар БНХАУ-д экспортод гарч байгаа болон гарах боломжтой түүхий газрын тос, зэс болон түүгээр хийсэн барааг нэмж товч судалсан болно. Учир нь, ЧХХ байгуулсан тохиолдолд эдгээр барааны тарифыг бууруулах хэлэлцээ хийх зайлшгүй шаардлага гарна.

Түүхий газрын тос

Түүхий газрын тосны олборлолт, экспорт жилээс жилд тогтмол өсөлттэй байна. 2004 онд 180 мянган баррелийг экспортолж байсан бол 2012 онд 3568, 2013 онд 5244, 2014 оны эхний 10 сард 5710 мянган баррелийг экспортолсон нь бүгд БНХАУ-д гарчээ.

БНХАУ-ын газрын тосны импортод Монгол Улсын экспорт өчүүхэн байгаа бөгөөд өнөөгийн байдлаар Хятад Улс түүхий газрын тосны импортыг чөлөөтэй буюу тэг тарифаар оруулж байна. Иймд, ЧХХ байгуулсан ч энэ бараагаар хэлэлцээ хийгдэхгүй.

Зэс болон түүгээр хийсэн зүйлс

Монгол Улс зэс-порфирын төрлийн ордоор баялаг орны тоонд багтдаг. Зэсийн 30 орд, 1170-аад илрэл тогтоогдсон ба 7979 сая тонн хүдэр, 54.8 сая тонн зэсийн нөөц бүртгэгдсэн. Манай дотоодын үйлдвэрлэл өнөөгийн байдлаар жилд 1.6 сая тонн байна (Эрдэнэт, Оюутолгой). Цагаан суваргын орд ашиглалтад орсноор үйлдвэрлэл 1.9 сая тоннд хүрнэ. “Эрдэнэт”, “Оюутолгой”-н баяжуулсан зэсийг 100 хувь экспортод буюу БНХАУ-д голлон гаргаж байна.

Өнөөгийн байдлаар манай улс катодын зэс, зэсийн баяжмал гаргаж байгаа бөгөөд зэсийн боловсруулалтыг нэмэгдүүлэн бэлэн бүтээгдэхүүн гаргах асуудлыг бодлогын түвшинд гаргаж, зэсийн баяжмал хайлах үйлдвэр байгуулах талаар Улсын Их Хурлын тогтоолд⁶² заасан байдаг. Үйлдвэр ашиглалтанд орсноор 120 мянган тонн катодын зэс, түүний дайвар бүтээгдэхүүн 480 мянган тонн хүхрийн хүчил үйлдвэрлэж, БНХАУ-ын зах зээлд гаргах боломжтой.

⁶²Монгол Улсад зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах тухай УИХ-ын 2010 оны 21 дүгээр тогтоол.

Зэсийн хүдэр, баяжмалыг 2004-2012 онуудад “Эрдэнэт” УБҮ дангаар экспортод гаргадаг байсан бөгөөд 600 мянган тоннд хүрч байсан. 2013 онд Оюутолгойн орд нэмэгдсэнтэй холбоотойгоор зэсийн хүдэр, баяжмалын экспорт нэмэгдэж, 2013 онд 650 мянган тонн, 2014 оны эхний 10 сарын байдлаар 1095 мянган тоннд хүрчээ. Зэсийн хүдэр, баяжмалын экспортын 99.7 хувь нь БНХАУ-д ногдож байна.

2013 онд БНХАУ 10.1 сая тонн зэсийн хүдэр, баяжмал импортоор авсан (Чили-28 хувь, Перу-19 хувь, Австрали-9 хувь, Монгол-5.6 хувь).

2013 онд БНХАУ 3.3 сая тонн катодын зэс импортолсон ба үүний 34.4 хувийг Чили улсаас, 6 хувийг тус тус Энэтхэг, Австрали, Япон улсаас авчээ.

Ирээдүйд манай улсад зэс хайлуулах үйлдвэр байгуулна гэж тооцвол дайвар бүтээгдэхүүн болох хүхрийн хүчил, фторын хүчил, криолит, фосфорын бордоог ч урьд хөршид гаргах боломжтой.

Дэлхийн зэсийн олборлолт 2016 онд 27.7 сая тонн-д хүрнэ гэж тооцоолж байна. БНХАУ нь 2012 онд 1.5 орчим сая тонн зэс үйлдвэрлэж, дэлхийд Чили улсын дараа хоёрт⁶³, Монгол Улс 19 дүгээрт орсон.⁶⁴

БНХАУ-д бүтээн байгуулалт ихээр хийгдэж, дэд бүтцийн салбар хурдацтай хөгжиж, зэсийн хэрэглээ 2015 он гэхэд 8,8 сая тонн хүрэх тооцоо байна. Түүнчлэн эрчим хүч, автомашин болон гэр ахуйн барааны үйлдвэрлэлт нэмэгдэх нь тодорхой байгаа тул Хятад улсын хэрэглээг улам өсгөх ажээ.⁶⁵

Банкны салбар дахь байгууллагын зохистой засаглалыг бэхжүүлэх, ил тод, нээлттэй, шударга ёсны зарчмуудыг хэвшүүлэхэд банкны хяналт шалгалтыг сайжруулах, банкуудын сайн засаглалын хэрэгжилтэд олон нийтийн анхаарлыг хандуулах, том өмчлөгчийн өмчлөх хэмжээнд хязгаарлалт хийх шаардлагатай байна. Түүнчлэн зээлийн эрсдэл өндөр байгаа нь зээлийн хүү буурахгүй байхад нөлөөлж байна. Зээлийн эрсдлийг бууруулахад зээлийн мэдээллийн санг бүрдүүлэн зээл олгох үйл ажиллагааны зардал, хугацааг хэмнэх, аж ахуйн нэгжүүдийн өмчлөлийг ил тод болгож, нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ зохистой хязгаараас давах явдлыг зогсоох нь чухал ач холбогдолтой байна.

ГУРАВ. ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТААС**3.1 Оросын Холбооны Улс⁶⁹**

ОХУ-ын Төв банкны тухай хуулийн /О Центральном Банке Российской Федерации (Банке России)/ 64-65 дугаар зүйлд зээлийн байгууллагаас зээлдэгчид олгох зээлийн хэмжээг хуульчлан зохицуулсан байна.

ОХУ-ын Төв банкны тухай хуулийн 64 дүгээр зүйлд 2013.07.02-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулан 2015.01.01-ний өдрөөс мөрдөж эхлэнэ.

Уг хуулиар 64-р заалтыг дараах байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Хүснэгт 1. ОХУ-ын Төвбанкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт

Одоо мөрдөж буй хуулиар	2015.01.01-нээс мөрдөх хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлт
<p>64-р зүйл: Нэг зээлдэгч эсхүл хоорондоо холбоо бүхий /хуулийн этгээдийн хувьд үндсэн, хараат, охин компани/ бүлэг зээлдэгч нарт тавигдах эрсдлийн дээд хэмжээ нь банк, санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгө /капитал/-ийн хэмжээнээс хувиар тооцох бөгөөд энэ нь 25 хувиас хэтэрч болохгүй.</p> <p>Эрсдлийн дээд хэмжээг тодорхойлохдоо нэг зээлдэгч болон хоорондоо холбоо бүхий зээлдэгчийн нийт олгосон зээлийн хэмжээ, түүнчлэн баталгаа, батлан даалтын нийт нийлбэр дүнгээс тооцохыг харгалзан үзнэ.</p>	<p>64-р зүйл: Нэг зээлдэгч эсхүл хоорондоо холбоотой этгээд нь зээлийн байгууллагын хувьд тэдгээрийн өөрийн хөрөнгийн 25 хувиас хэтрэхгүй, банкны нэгдлийн хувьд банкны нэгдлийн өөрийн хөрөнгийн 25 хувиас хэтэрч болохгүй.</p> <p>64 /1/ зүйл: Нэг зээлдэгч эсхүл хоорондоо холбоо бүхий /хуулийн этгээдийн хувьд үндсэн, хараат, охин компани/ бүлэг зээлдэгч нарт тавигдах эрсдлийн дээд хэмжээ нь банк, санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгө /капитал/-ийн хэмжээний 20 хувиас хэтэрч болохгүй.</p>

Нэг зээлдэгч эсхүл холбоотой зээлдэгч нарын эрсдлийн дээд хэмжээг тогтоохдоо тэдгээрийн зээлийн байгууллага /банкны нэгдлийн/ өмнө хүлээсэн үүрэг болон гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүрэг /тус гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүрэг нь зээлийн байгууллагад тус заагдсан этгээд /хоорондоо холбоотой зээлдэгчдийн бүлэг/ шаардлага үүсэх/ зэргийг тооцох шаардлагатай юм.

Холбогдох зээлдэгчийн бүлгийн хувьд энэхүү Төв банкны тухай хуулийн зорилгоор дараах байдлаар тодорхойлогдоно.

Зээлдэгчийн хэн нэгэн нь нөгөө зээлдэгчийг хянадаг буюу мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх эрх бүхий бол, эсхүл зээлдэгч нар нь зээлдэгч бус гуравдагч этгээдийн мэдэгдэхүйц нөлөөнд ор, эсхүл хяналтад байгаа нөхцөлд холбоотой зээлдэгч гэж үзнэ.

Хяналтандаа байлгах буюу мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг этгээд гэдэгт ОХУ-ын нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн тайлангийн Олон Улсын стандартад нийцүүлэн тодорхойлсон этгээд байна.

Мөн түүнчлэн энэ хуулийн зорилгод нийцүүлэн зээлийн байгууллагын холбоотой байгууллага гэдэгт дараах хүмүүсийг тооцно.

- Зээлдэгч нар нь хоорондоо холбоотой, нэг этгээдийн эдийн засгийн байдал муудсан нь нөгөө этгээдээс зээлийн байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй шалтгаан болох. Тухайлбал,

⁶⁹www.fms.gov.ru

хуулийн этгээд хувь хүн нь зээлийн байгууллагаас баталсан зээлийн гэрээ, хадгаламжийн гэрээний үндсэн дээр зээлийн байгууллагаас авсан мөнгөн хөрөнгийг шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан өөр этгээдэд шууд шилжүүлсэн этгээд;

- Зээлийн байгууллагын өмнө зээл, хадгаламж, зээлийн гэрээний дагуу үүрэг хүлээгээгүй гуравдагч этгээд биелүүлсэн этгээдийг тус тус хамааруулж үзнэ.
- ОХУ-ын Төв банкны тухай хуульд 2013.07.02-ны өдрийн хуулиар 64 /1/ зүйлийг нэмэлтээр оруулсан.

64 /1/ зүйл: Нэг зээлдэгч эсхүл хоорондоо холбоо бүхий /хуулийн этгээдийн хувьд үндсэн, хараат, охин компани/ бүлэг зээлдэгч нарт тавигдах эрсдлийн дээд хэмжээ нь банк, санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгө /капитал/-ийн хэмжээний 20 хувиас хэтэрч болохгүй.

Зээлийн байгууллагатай холбоотой этгээд гэдгийг энэхүү хуулийн зорилгод нийцүүлэн дараах байдлаар тодорхойлно.

1. Зээлийн байгууллагыг хянадаг хуулийн этгээд эсхүл түүнд томоохон нөлөө үзүүлдэг хуулийн этгээд
2. Зээлийн байгууллагыг хянадаг хувь хүн /түүний төрөл садан, эхнэр нөхөр, эцэг эх, төрсөн болон үрчилсэн хүүхэд, ах, дүү, ач зээ/
3. Төлөөлөн удирдах зөвлөл /Хяналтын зөвлөл/ захирлуудын зөвлөл, гүйцэтгэх удирдлага, түүний орлогч, зээлийн байгууллагын ерөнхий нягтлан, хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүн бусад удирдах албан тушаалтан нь зээлийн байгууллагын хувьд заавал биелүүлэх норм, нормативыг хангуулах эсхүл банкны дампуурлын урьдчилан мэдэгдэх, арга хэмжээг авахад нөлөөлөх шийдвэр гаргах, оролцох албан тушаалтан хамаарна.

Зээлийн байгууллагын этгээдийн эрсдлийн дээд хэмжээг тодорхойлохдоо дараах зүйлийг харгалзан үзнэ.

- Зээлийн байгууллагын өмнө үүрэг хүлээсэн;
- Гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүрэг, тэдгээрийн үр дүнд зээлийн байгууллагын өмнө шаардах эрх үүссэн;
- Зээлийн байгууллагатай холбоотой этгээдийн эрсдлийн дээд хэмжээг тогтоохдоо бүлэг этгээдийн ойлголтыг ОХУ-ын өрсөлдөөнийг хамгаалах 2006 оны хуульд тодорхойлсоноор ойлгоно.

ОХУ-ын Төв банкны тухай хуулийн 95-р зүйл: Нэг том зээлдэгчийн эрсдлийн дээд хэмжээ нь зээлийн байгууллагын өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтэрч болохгүй Нийт хэмжээ нь 800 хувиас хэтэрч болохгүй бөгөөд Төв банк нь том зээлдэгчийн бүртгэлийг хөтөлнө.

3.2 Ирланд улс

1989 оны Төв Банкны тухай хуулийн 117 дугаар зүйлд “Банк нь Сайдтай зөвшилцсөний үндсэн дээр банкны хяналтан дор үйл ажиллагаа явуулж буй этгээд, эсхүл бүхий л ангиллын лиценз эзэмшигч нарт хамаарах асуудлаарх үйл ажиллагааны дүрмийг батлах бөгөөд холбогдох банкны хяналтан дор үйл ажиллагаа явуулж буй этгээд, эсхүл бүхий л ангиллын лиценз эзэмшигч нар тус дүрмийг даган мөрдөнө” гэж заасны дагуу Ирланд улсын Төв Банкаас Холбогдох этгээдэд олгох зээлийн үйл ажиллагааны дүрмийг /Code of Practice on Lending to Related Parties/ батлан 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс даган мөрдөж байна.

Тус дүрмийн 6.9-р заалтад: Зээлийн байгууллага нь холбогдох этгээдэд зээл олгохдоо дараах хувь хэмжээнээс хэтрүүлэн зээл олгохыг хориглоно.

Хүснэгт 2: Ирланд улсын холбогдох этгээдэд олгох зээлийн хувь хэмжээ

№	Төрөл	Хувь хэмжээ
1	Тухайн зээлийн байгууллагын удирдлага, удирдах албан тушаалтан болон тэдгээрийн холбогдох этгээд, мөн удирдлага, эсхүл удирдах албан тушаалтны нөлөө бүхий хувьцаа эзэмшиж буй байгууллага	Өөрийн хөрөнгийн 0.5 хувь
2	1-д заасан нийт хэмжээ	Өөрийн хөрөнгийн 5 хувь
3	Зээлийн байгууллагаа бус нэг нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, тухайн хувьцаа эзэмшигчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшиж буй бусад байгууллага	Өөрийн хөрөнгийн 5 хувь
4	3-т заасан нийт хэмжээ	Өөрийн хөрөнгийн 15 хувь
5	Тухайн зээлийн байгууллага нь зээлийн байгууллагаа бус зээлдэгч, эсхүл бүлэг зээлдэгчдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч	Өөрийн хөрөнгийн 5 хувь
6	5-д заасан нийт хэмжээ	Өөрийн хөрөнгийн 5 хувь

Эх сурвалж: *Bringing down the banking system: Lessons from Iceland, 2014, Chapter 11. Tunneling money through related party lending* <http://books.google.mn>

Хүснэгт 3: Гадаад зарим орны холбогдох этгээдийг тодорхойлсон байдал, холбогдох этгээдэд олгох зээлд тавих хязгаарлалтын хэмжээ /Дэлхийн Банк, 2011/

№	Улс орны нэр	Холбогдох этгээдийн тодорхойлолтод дараах этгээдүүд хамаарах эсэх				Холбогдох этгээдэд олгох зээлийн хэмжээнд хязгаарлалт тавигдах эсэх	Холбогдох этгээдэд олгох зээлийн хэмжээнд хязгаарлалтын хэмжээ /хувь/
		1 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч /Дагуу эрхтэй хувьцаа эзэмшигчид/	2 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд	3 1 болон 2-н гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн	4 3-н нэгдмэл сонирхолтой этгээд		
1	Ангол	-	-	-	-	+	100.00
2	Аргентин	+	+	+	+	+	20.00
3	Армен	+	+	+	+	+	5.00
4	Австрали	+	+	+	+	+	25.00
5	Австри	+	-	+	-	+	25.00
6	Бахрейн	+	+	+	+	+	40.00
7	Бангладеш	+	+	+	+	+	10.00
8	Беларусь	+	+	+	+	+	15.00
9	Бельги	+	+	+	+	+	25.00
10	Белиз	+	+	+	+	+	2.00*
11	Бенин	+	+	+	+	+	10.00

12	Бутан	+	+	+	+	+	40.00
13	Босни Герцеговин	---	+	+	+	+	40.00
14	Ботсвана	+	+	+	+	+	25.00
15	Болгар	+	+	+	+	+	1.00
16	Буркина Фасо	+	+	+	+	+	10.00
17	Бурунди	+	+	+	+	+	20.00
18	Кайманы Арлууд	+	+	+	+	+	25.00
19	Чили	+	+	+	+	+	10.00
20	БНХАУ	+	+	+	+	+	50.00
21	Колумб	+	+	+	+	+	30.00
22	Кукийн Арлууд	+	+	+	+	+	25.00
23	Коста Рика	+	+	+	+	+	20.00
24	Кот Дивуар	+	+	+	+	+	10.00
25	Хорват	+	+	+	+	+	10.00
26	Кипр	+	+	+	+	+	20.00
27	Доминикан	+	+	+	+	+	50.00
28	Египет	+	+	+	+	+	50.00
29	Эль Сальвадор	+	+	+	+	+	5.00
30	Эстон	+	+	+	+	+	5.00
31	Эфиопи	+	+	+	+	+	35.00
32	Фижи	+	+	-	+	+	25.00
33	Финлянд	+	+	+	+	+	25.00
34	Франц	+	+	+	+	+	25.00
35	Гамби	+	+	+	+	+	25.00
36	Гана	+	+	+	+	+	10.00
37	Гибралтар	+	+	+	+	+	20.00
38	Грек	+	+	+	+	+	25.00
39	Гватемал	+	+	+	+	+	15.00
40	Гвиней Бисау	+	+	+	+	+	10.00
41	Гвиана	+	+	+	+	+	2.00
42	Гондурас	+	+	+	+	+	30.00
43	Гонг Конг	+	+	+	+	+	10.00
44	Унгар	+	+	+	+	+	0.00
45	Исланд	+	+	+	+	+	1.00
46	Энэтхэг	-	+	-	+	-	0.00
47	Индонез	+	+	+	+	+	10.00
48	Ирак	+	+	+	+	+	10.00

49	Ирланд	+	+	+	+	+	5.00
50	Мэн Арал	+	+	+	+	+	25.00
51	Израиль	+	+	+	+	+	10.00
52	Ямаик	+	+	+	+	+	20.00
53	Иордан	+	+	+	+	+	50.00
54	Кени	+	+	+	+	+	100.00
55	БНСУ	+	+	+	-	---	8.00
56	Косово	+	+	+	+	+	20.00
57	Кувейт	+	+	+	+	+	50.00
58	Латви	+	+	+	+	+	15.00
59	Ливан	+	+	+	+	+	5.00
60	Лесото	+	+	+	+	+	10.00
61	Лихтенштейн	+	+	+	+	-	25.00
62	Литв	+	+	+	+	+	25.00
63	Люксембург	+	+	+	+	+	25.00
64	Макао	+	+	+	+	+	20.00
65	Мадагаскар	+	+	+	+	+	35.00
66	Малави	+	+	+	+	+	25.00
67	Малайз	+	+	+	+	+	100.00
68	Мали	+	+	+	+	+	10.00
69	Мальт	+	+	+	+	+	25.00
70	Мавритани	+	+	+	+	+	150.00
71	Мексик	+	+	+	+	+	50.00
72	Молдов	+	+	+	+	+	10.00
73	Монтенегро	+	+	+	+	+	200.00
74	Мозамбик	-	-	-	-	+	20.00
75	Мьянмар	+	+	+	+	+	30.00
76	Намиби	+	+	+	+	+	30.00
77	Непал	+	+	+	+	+	15.00
78	Шинэ Зеланд	+	+	+	+	+	15.00
79	Нигер	+	+	+	+	+	10.00
80	Нигери	-	+	+	+	+	20.00
81	Норвеги	+	+	-	+	+	25.00
82	Оман	+	+	+	+	+	15.00
83	Пакистан	+	+	+	+	+	30.00
84	Палестинын газар нутаг	+	+	+	+	+	20.00
85	Панам	+	+	+	-	+	25.00
86	Парагвай	+	+	+	+	+	20.00
87	Перу	+	+	+	+	+	30.00
88	Польш	+	+	-	+	+	10.00

89	Португали	+	+	+	+	+	10.00
90	Пуэрто Рико	+	+	+	+	+	15.00
91	Катар	+	+	+	+	+	100.00
92	Румын	+	+	+	+	+	25.00
93	ОХУ	+	+	+	+	+	25.00 (2015 - 20%)
94	Самоа	+	+	+	+	+	20.00
95	Сенегал	+	+	+	+	+	10.00
96	Серби	+	+	+	+	+	5.00
97	Сейшел	+	+	-	+	+	25.00
98	Сьерра Леон	+	+	+	+	+	0.67
99	Словак	+	+	+	+	+	40.00
100	Словени	+	+	+	+	+	25.00
101	Өмнөд Африк	+	+	+	+	+	25.00
102	Испани	+	+	+	+	+	20.00
103	Шри Ланка	+	+	+	+	+	30.00
104	Суринам	+	+	+	+	+	25.00
105	Свазиленд	+	+	+	+	+	25.00
106	Сири	+	+	+	+	+	0.00
107	Тайван	+	+	+	+	+	10.00
108	Тажикстан	+	+	+	+	+	10.00
109	Танзани	+	+	+	+	+	0.00
110	Тайланд	+	+	+	+	+	5.00
111	Того	+	+	+	+	+	10.00
112	Тонга	+	+	+	+	+	100.00
113	Тринидад ба Тобаго	+	+	+	+	+	25.00
114	Тунис	+	+	+	+	+	10.00
115	Турк	+	+	+	+	+	20.00
116	Уганда	+	+	+	+	+	20.00
117	Украин	+	+	+	+	+	5.00
118	Их Британи	+	+	+	+	+	25.00
119	АНУ	+	+	+	+	+	10.00
120	Уругвай	+	+	+	+	+	0.00
121	Вануату	+	+	+	+	+	25.00
122	Виргинийн Арлууд	+	+	+	+	+	25.00
123	Йемен	+	+	+	+	+	50.00
124	Зимбабве	+	+	+	+	+	25.00

Эх сурвалж: <http://elibrary.worldbank.org/doi/pdf/10.1596/1813-9450-5570>

Дээрх орнуудын ихэнх нь банкны холбогдох этгээдийг нарийвчлан тогтоож, холбогдох этгээдэд олгох зээлийн хэмжээнд тодорхой хэмжээний хязгаарлалт тогтоосон байна. 124 орны хязгаарлалтын дундаж хэмжээ 25 хувьтай тэнцүү байгаа бол 18 улс холбогдох этгээдэд олгох зээлийн хэмжээ банкны хөрөнгийн 5 буюу түүнээс доош хувьтай тэнцүү тогтоосон байна.

Олон улсын байгууллагууд, гадны судалгааны байгууллагуудын холбогдох этгээдэд олгох зээлийн хэмжээтэй холбоотой гаргасан судалгаа, зөвлөмжөөс тоймлон үзвэл агуулгын хувьд хоёр хувааж үзэж болохоор байна⁷⁰.

Ихэнх судлаачдын үзэж байгаагаар холбогдох этгээдэд олгох зээлийн хэмжээ тогтоосон хэмжээнээс хэтрэх, хууль дүрэм журмыг зохих хэрэгжилтийг хангахгүй байх явдал нь санхүүгийн хямралын нэг шалтгаан, өдөөгч хүчин зүйл болдог гэж үзсэн байна. Үүнд 1997 оны Азийн санхүүгийн хямрал, мөн түүнчлэн Индонез, Тайланд, Исланд, Латин Америкийн орнууд дахь банкны салбарын хямралыг дурдаж болох юм.

Нөгөөтэйгүүр банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хэмжээг өөрчлөх нь банкны үйл ажиллагаа, тогтвортой байдалд төдийлөн хүчтэй нөлөө үзүүлж чадахгүй, гагцхүү тухайн орны хуулийн хэрэгжилтээс шалтгаалан тус өөрчлөлт нь эерэг, эсхүл сөрөг үр дагавартай гэж зарим судалгаа дүгнэсэн байна. Энэ нь ялангуяа хөгжиж буй, хууль эрх зүйн орчин сул, хуулийн хэрэгжилт тааруу орнуудын хувьд сөрөг үр дагавар дагуулах нь элбэг гэж үзжээ.

- 2010 онд Европын компанийн засаглалын хүрээлэнгийн судлаачдын хийсэн судалгаанд төрийн өмчит банкуудын холбогдох этгээдэд олгох зээлийн талаар авч судалсан байна. Тус судалгаанд төрийн өмчит банкууд нь эргээд холбогдох этгээд болох засгийн газарт зээл олгох асуудлыг түлхүү судалсан ба энэхүү үзэгдэл нь сонгуулийн үеэр улс төрийн нөлөөн дор ихээхэн явагдаж байгааг олж тогтоосон. Судлаачдын үзэж байгаагаар хууль дүрэм, банкны засаглал, ил тод байдал ихээхэн хөгжсөн барууны орнуудад тус үзэгдэл ажиглагдаж байгаа нь засаглалын хэм хэмжээ бүрэн хөгжөөгүй, хөгжиж буй орнуудын хувьд илүү байх магадлалтай гэж үзсэн байна.⁷¹
- 2009 онд хийсэн судалгаанд Австрийн төрийн өмчит банкууд, тэдгээрийн холбогдох этгээдэд олгох зээл болон улс төрийн нөлөөллийн тухай судалж үзсэн байна. Судалгаанд 1995 онд Австрийг ЕХ-д элсэхээс өмнө банкны холбогдох этгээдүүд нь өөрсдийн банкнаас хөнгөлөлттэй нөхцөлөөр, бага зээлийн хүүтэй зээл авч байсан нь тогтоогдсон байна. ЕХ-д элсэж чанга стандартыг дагаж мөрдөх болсноор уг үзэгдэх үлэмж хэмжээгээр буурсныг онцолсон. Харин улс төрийн нөлөөлөл дор үйл ажиллагаа явуулдаг банкуудын хувьд банкныг тонох /санаатайгаар дампууруулах - looting/ үзэгдэл түлхүү анзаарагддаг, улс төрийн нөлөө ихтэй боловч төлөөлөн удирдах зөвлөлийн хэмжээ томтой банкуудад бага байсныг тэмдэглэсэн байна. Иймд улс төрийн нөлөөлөл их банкуудад ТУЗ-ын том бүтэц илүү үр дүнтэй гэж үзсэн байна.⁷²
- 2004 онд АСЕАН-н зөвлөгөөнд зориулан гаргасан Холбогдох этгээдэд олгох зээл болон банкны эрүүл тогтолцоог Индонезийн жишээн дээр судалсан бөгөөд холбогдох этгээдэд олгох зээлийг 1997 оны Азийн санхүүгийн хямралын гол хөшүүрэг болсон гэж үзжээ.⁷³

⁷⁰Bank Regulation and Supervision Around the World a Crisis Update. www.asbaweb.org/

⁷¹Судалгааны дэлгэрэнгүй тайланг дараах хаягаар орж үзнэ үү: <https://enim.wiwi.hu-berlin.de/>

⁷²Дэлгэрэнгүй мэдээллийн доорх хаягаас харна үү: <http://home.business.utah.edu/>

⁷³Холбогдох мэдээллийг дараах хаягаас үзнэ үү. www.pem.org.my/

- Латин Америкийн санхүүгийн хямрал нь банкнаас холбогдох этгээдэд олгох зээл нь төвлөрлийн эрсдлийг нэмэгдүүлэх, банкны тогтвортой байдалд сөрөг нөлөөтэйг харуулсан. Доминикан улсад үүссэн хямралыг холбогдох этгээдэд олгох зээлтэй нягт холбоотойг дурдсан байна. Банкны хяналт шалгалтын Базел II стандартад харьцангуй бага/зөөлөн зохицуулагдсан, уг стандарт нь холбогдох этгээдэд банкны хөрөнгийн тодорхой хэмжээний хязгаарлан олгохыг зөвшөөрдөг.⁷⁴
- Холбогдох этгээдэд олгох зээлтэй холбоотойгоор Исланд Улсыг дурдаж болох юм. Тус улсад 2008 онд 3 томоохон банкны дампуурлаас үүдсэн банкны системийн хямрал, түүний шалтгаан болон холбогдох этгээдэд олгох зээлийн хоорондын уялдаа хамаарлыг мөн адил холбогдох этгээдэд олгох зээлтэй шууд хамааралтай гэж тайлбарласан байна.⁷⁵

Манай улсын хувьд ОУВС, Дэлхийн банк зэрэг Олон улсын байгууллагаас гаргасан судалгаанаас үзэхэд:

- Дэлхийн банкнаас гарсан 2013 оны Монгол Улсын эдийн засгийн улирлын тоймд: Зохистой байдлын журам, шаардлагууд Базел 2, 3-ын стандартад нийцсэн боловч мөрдүүлэлт хоцорсоор байна. Тухайлбал, хэд хэдэн банк холбогдох этгээд, том зээлдэгчид олгох зээлийн дээд хязгаарыг мөрдөж ажиллахгүй байна.
- Бүс нутгийн бусад улсуудтай харьцуулахад Монгол Улсад өөрийн хөрөнгийн нөөц доогуур, чанаргүй зээлийн харьцаа өндөр байна. Алдагдлын сан байгуулах шаардлагыг бүрэн биелүүлэхгүй байгаа учраас албан ёсоор зарлаж байгаа тоонууд нь байж болох алдагдлыг гүйцэд харуулж чадахгүй байгааг (зохицуулагч байгууллагын хүлээцтэй байдал) ОУВС-аас 2011 оны дундуур хийсэн Санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээнд онцолсон байна. Хугацаа хэтрэлттэй байгаа зарим томоохон зээлдэгчид дээр алдагдлын санг зохих ёсоор байгуулахгүй, томоохон зээлдэгчдэд дамжуулан олгосон зээлээр бүртгэлтэй банк хоорондын зээлийн эрсдлийн жинг зохистой тооцохгүй байгаагаас ийм байдал үүсч байна.⁷⁶
- Хамгийн том гурван банк өөрийн хөрөнгөө олон янзын эх үүсвэрээс нэмэгдүүлж чадсан. Харин Монголбанк нөгөө гурван банкны хувьд (системийн ач холбогдолтой нэг банк ороод) зохицуулалтын журам зааврыг биелүүлэхгүй байгаад нь хүлээцтэй хандаж байна. 2011 оны эхнээс хяналтын ажлын төлөвлөгөө гаргаж, нэг жилийн дотор зохистой байдлын үзүүлэлтүүдийг хангаж ажиллах үүргийг банкуудад өгсөн. Банкуудын зээл, хадгаламжийн харьцаа (засгийн газрын хадгаламж ороогүй) 2010 онд 77 хувьтай байсан бол 2011 оны 12 дугаар сард 100 хувийг бага зэрэг давж, хөрвөх чадварын эрсдэл нэмэгдэж байгааг харуулж байна.
- Иймд Монголбанк санхүүгийн эрсдлийг сайтар хянаж, зохистой байдлын үзүүлэлтүүдийг арилжааны банкуудад бүрэн мөрдүүлэх нь чухал байна. Нэн ялангуяа, өөрийн хөрөнгийн нөөцийг зохистой хэмжээнд байлгаж, одоо байгаа болон цаашид үүсч болзошгүй чанаргүй зээлийн алдагдлыг хаах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.⁷⁷
- Хадгаламжийн банкны саяхны дампуурал Монгол банк нь 2013 оны 7 дугаар сард Хадгаламжийн банк төлбөрийн чадваргүй болох үед өөрийн оролцоог гаргасан. Хувийн өмчит Хадгаламжийн банк нь нийт банкны хөрөнгийн 8 хувийг эзэлдэг байсан (тухайн улсад томоороо тавд харин таван системийн чанартай банкны хамгийн жижиг нь). Банк нь сул корпорац, холбоотой компаниудад олгосон зээл нь төлөгдөх чадваргүй болсны үр дүнгээс дампуурсан харагдаж байна. Холбогдох этгээдэд олгосон зээл нь хөрөнгөөс 2 дахинаас илүү хэмжээгээр давж гарсан (нийт холбогдох этгээдэд олгох хөрөнгийн хязгаарлалт нь 20 хувь, банкны холбогдох этгээдэд олгох зээлийн хэмжээ нь 5 хувь). Хадгаламж банк нь сүүлийн хоёр

⁷⁴<http://books.google.mn/books>

⁷⁵Bringing down the banking system: Lessons from Iceland, 2014, Chapter 11. Tunneling money through related party lending, Холбогдох мэдээллийг дараах хаягаар орж үзнэ үү: <http://books.google.mn/books>

⁷⁶www.oecd.org/corporate/ca/

⁷⁷Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүд, ОУВС-ийн Санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээ, 2011.

жилийн хугацаанд МБ-ны хяналт, шалгалтын тусгай хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байсан боловч дотоод/асуудлыг багасгаж чадаагүй бөгөөд түүний хөрөнгийн хүрэлцээтэй байдлыг сэргээж чадаагүй юм.⁷⁸

- 2011 онд Дэлхийн Банкны судалгааны албаны холбогдох этгээдэд олгох зээлийн хязгаарлалтын талаар хийсэн судалгаанд судлаачид нь холбогдох этгээдэд олгох зээлийн хязгаарлалт болон банкны салбарын хөгжлийн хооронд ямарваа нэгэн эерэг болон сөрөг харилцан хамаарлыг олж тогтоогоогүй байна. Харин дээрх хоёрын харьцаан дээр ил тод байдал /авлига/, хуульд захирагдах ёсыг чанд баримталж буй орнуудад дээрх хамаарал эерэг байсан бол хууль, дүрэм журам хэрэгжилт сул, авилгын хэмжээ ихтэй орнуудад тус үзүүлэлт нь сөрөг хамааралтай байсан байна. Ийнхүү тус орнуудад холбогдох этгээдүүд нь банкныг хохироох, дампууруулах боломж, бололцоо өндөртэй байсан байна.
- Судалгаанд мөн банкныг санхүүгийн бус байгууллага өмчлөх нь банк өөрөө санхүүгийн бус байгууллагыг өмчлөхөөс илүү эрсдэлтэй гэж үзсэн байна. Санхүүгийн хямралын үед буурай хөгжилтэй орнуудад санхүүгийн бус байгууллага нь банкаа /тонох, дампууруулах/ үзэгдэл нэмэгддэгийг тогтоожээ. Иймд банкууд нь холбогдох этгээдэд зээл олгох явдлыг буруу, зөв гэж тогтоогоогүй гагцхүү өөрийн орны нөхцөл байдалд хэрхэн зөв нийцүүлэхийн ач холбогдлыг цохон тэмдэглэжээ.⁷⁹

Монгол Улс хоёр шатлалтай банкны тогтолцоонд шилжсэнээс хойш нийт 31 банкинд банкны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгосноос өнөөдрийн байдлаар 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Банкуудын дампуурал болон татан буулгахад макро эдийн засгийн тогтворгүй байдлаас гадна бүтцийн сул байдал нөлөөлсөн гэж үзсэн байна. Банкны хямрал, дампуурлын шалтгааныг эдийн засагчид, мэргэжлийн байгууллагын хүмүүс макро эдийн засгийн тогтворгүй байдал, бүтцийн сул байдал гэсэн 2 үндсэн хэсэгт хуваан авч үзсэн байна. Бүтцийн сул байдлын илрэлийг банкны удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, банкны тухай бодит мэдээлэл дутмаг, банкны гишүүд болон удирдах ажилтнуудтай холбоотой зээлүүд их хэмжээгээр байсан, Монголбанкнаас авч хэрэгжүүлж байсан арга хэмжээ үр дүн муутай байсан зэргийг дурджээ.

Хүснэгт 4. Дампуурсан болон төлбөрийн чадваргүй болсон Монголын арилжааны банкууд, тэдгээрийн дампуурах болсон шалтгаан

№	Банкны нэр	Байгуулагдсан он	Үйл ажиллагаа зогсоосон	Шалтгаан
1	ХОТШ	11/19/90	2000-01	<ul style="list-style-type: none"> • Чанаргүй зээл • Ажилтан албан хаагчдын хариуцлагагүй үйл ажиллагаа
2	Монгол хоршоо	09/30/90	09/15/94	<ul style="list-style-type: none"> • Шинжилгээ хангалтгүй зээл • Захиргааны зардал өндөр • Дотоод хяналт сул • Ашиг, алдагдал шинжилгээ хийгээгүй • Зээлийн чанар муудсан
3	Ард	1990	1996	<ul style="list-style-type: none"> • Судалгаа хангалтгүй зээл • ААХ-ын хариуцлагагүй үйл ажиллагаа • Пассив нь активаасаа давсан
4	Монгол даатгал	10/09/90	12/13/96	<ul style="list-style-type: none"> • Хугацаа хэтэрсэн чанаргүй зээл их • Банкны удирдлага муу ажилласан (хувь нийлүүлэгчдийнхээ оруулсан хөрөнгийг үрэгдүүлсэн)

⁷⁸Дэлгэрэнгүй тайланг дараах хаягаар орж үзнэ үү: www-wds.worldbank.org/ 35 дахь тал.

⁷⁹Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаар орж үзнэ үү: <http://elibrary.worldbank.org/>

5	Их зам	12/02/90	01/01/96	<ul style="list-style-type: none"> • Дүрмийн сангийн хэмжээ 400 сая төгрөг хүрээгүй • Банкны эх үүсвэр бүрдүүлэх төлөвлөгөө хангалтгүй • МБ-ны бүрэн эрхт төлөөлөгч хангалтгүй ажилласан • Өөрийн хөрөнгө дутагдсан
6	Сэлэнгэ банк	11/07/92	10/01/94	<ul style="list-style-type: none"> • Өөрийн хөрөнгө хүрэлцээгүй • Валютын ханшны алдагдал • 2 улсын хоорондын төлбөр тооцоог үндэсний валютаар хийхэд хязгаарлагдмал эрхтэй байсан
7	Төв ази	06/01/92	06/29/96	<ul style="list-style-type: none"> • Өөрийн хөрөнгийн дутагдал • Дүрмийн сан нь 80 сая төгрөг байсан • Чанаргүй зээл • Гол буруутан нь хувь нийлүүлэгчид, банкны удирдлага
8	Баянбогд	1992	1999х	
9	Монгол бизнес	1995	1999-09	<ul style="list-style-type: none"> • Хувь нийлүүлэгчид нь гол буруутан • Банкны удирдлага
10	Эдийн тэнгэр	1993-06	1999-09	<ul style="list-style-type: none"> • Чанаргүй зээл • Гол буруутан нь хувь нийлүүлэгчид, банкны удирдлага
11	Экспорт импортын банк	1993-6	1999-12	<ul style="list-style-type: none"> • Чанаргүй зээл • Хувь нийлүүлэгчид нь их хэмжээний зээл аваад эргүүлж төлөөгүй
12	ММ Инвест	1996-07	05/01/99	<ul style="list-style-type: none"> • Зээлдэгчид олгох зээлийн дээд 1 хэмжээг хэтрүүлсэн • Төв банкны шалгуур үзүүлэлтүүдийг биелүүлээгүй • Банкны удирдлага муу ажилласан
13	Сэргээн босголтын банк	1996	2000-01	<ul style="list-style-type: none"> • Хугацаа хэтэрсэн чанаргүй зээл (9 тэр бус төгрөгийн зээлийн 8,3 тэр бус буюу 93% нь чанаргүй зээл байсан) • МБ-с тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаагүй • Харилцагчдын төлбөр тооцоо саатсан • Банкны удирдлага муу ажилласан
14	ХАА-н	1990	хх	Хуучин тогтолцооноос шилжин ирсэн зээл болон Засгийн газрын шийдвэрээр газар тариаланд зориулан олгосон зээлийн хүүгийн хамт төлөгдөөгүйгээс шалтгаалж 4,1 тэрбум төгрөгийн зээл төлөгдөөгүй

15	АНОД банк	1999	2008	<ul style="list-style-type: none"> • Хугацаа хэтэрсэн чанаргүй зээл • 1 зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ хэтрүүлсэн • Банкны удирдлага муу ажилласан
16	Зоос банк	05/18/99	Төрийн банк болсон	<ul style="list-style-type: none"> • Хугацаа хэтэрсэн чанаргүй зээл • Банкны удирдлага муу ажилласан • Зээлийн нөхцөл тохироогүй
17	Шуудан банк	04/01/93	04/01/10	<ul style="list-style-type: none"> • Малчны чанаргүй зээл • Зээлийн судалгаа шинжилгээ муу хийсэн
18	Хадгаламж банк		2013	Холбогдох этгээдэд олгох зээлийн хэмжээ зөвшөөрөгдсөн хэмжээнээс хоёр дахин хэтэрсэн

Эх сурвалж: www.mongolbank.mn

ДӨРӨВ. МОНГОЛБАНКНААС 2014 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДРИЙН А-1/994 ТООТ АЛБАН БИЧГЭЭР ИРҮҮЛСЭН САНАЛ ДҮГНЭЛТ

“Банкны тухай хуулийн 17.3 т заасан “Банкнаас холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтэрч болохгүй гэсэн зохицуулалтыг өөрийн хөрөнгийн 10 хувь болгон өөрчлөхөд гарах эерэг сөрөг нөлөө, үр дагаварын талаар” мэргэжлийн байгууллагаас дараах дүгнэлтийг ирүүлсэн.

Монголбанкнаас “банкнаас холбогдох этгээдэд олгох зээл, түүнтэй адилтган тооцох активын хязгаарлалтыг нэмэгдүүлж өөрийн хөрөнгийн 10 хувьд хүргэх саналыг банкны зохистой засаглалын түвшин, системд үзүүлж болзошгүй эрсдэл, эдийн засгийн өнөөгийн байдлыг харгалзан Монгол банкнаас дэмжих боломжгүй байна.” Энэхүү хязгаарлалтыг нэмэгдүүлэхэд нийгэм, эдийн засагт дараах эерэг болон сөрөг нөлөө, үр дагаварыг үзүүлэхээр байна.

Давуу тал:

Санхүүгийн салбарын хөгжилтэй уялдан банк нь санхүүгийн нэгдэлд оролцогч хэлбэрээр зохион байгуулагдаж, санхүүгийн бусад салбарт үйл ажиллагаа явуулах охин болон хараат компани байгуулан ажиллах замаар салбарын хөгжилд тодорхой түлхэц өгч байна. шинэ үйл ажиллагаа эхлүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт, зээлийг дээрх хязгаарлалтаас шалтгаалан тухайн банк бүрэн шийдвэрлэх боломжгүй үед гуравдагч этгээдээс нэмэлт эх үүсвэр татах шаардлага гарах юм.

Энэ тохиолдолд зээлдэгч, зээлдүүлэгч хоорондын мэдээллийн ялгаа их тул нэмэлт зээлийн хүү, шимтгэл өндөр байх, цаг алдах зэрэг сөрөг нөлөөтэй байж болзошгүй. Иймд дээрх хязгаарлалтыг нэмэгдүүлэх нь нэгдэл оролцогчдыг өргөжүүлэх ялангуяа өөрийн хөрөнгө багатай жижиг банкууд үйл ажиллагаагаа төрөлжүүлэх, санхүүгийн бусад салбарт өрсөлдөөн бий болгосон үр өгөөжтэй ажиллагааг дэмжих давуу талыг үүсгэх бололцоотой.

Сул тал:

Банкны салбарт зохистой засаглалын үндсэн зарчмууд бүрэн нэвтрээгүй өнөөгийн нөхцөлд холбогдох этгээдэд олгох зээлийн хязгаарлалтыг нэмэгдүүлэх нь системийн хэмжээнд эрсдэлтэй активыг өсгөх эрсдэлтэй. Тухайлбал: өнгөрсөн хугацаанд нэг эсвэл

бүлэг холбогдох этгээдэд олгосон зээл чанаргүй болсны улмаас төлбөрийн чадварын хүндрэлд орж, өөрийн хөрөнгөгүй болж татан буугдсан банкуудын жишээ тодорхой байна.

Холбогдох этгээд, ялангуяа гүйцэтгэх удирдлага болон эздэд олгох зээлийн шаардлага буурах, явцын хяналтын чанар сулрах, эргэн төлөлтийн доголдлыг нуун дарагдуулах, эрсдлийн санг тухай бүр байгуулахгүй байх зэрэг банкны салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа гарах өндөр эрсдэлтэй байдаг.

Өөрөөр хэлбэл холбогдох этгээд, том зээлдэгчид олгох зээлийн хязгаарлалтыг өсгөж, зээлийн төвлөрлийг нэмэгдүүлэх боломжийг банкуудад олгох нь системд учирч болзошгүй эрсдлийг нэмэгдүүлж, хямралын үед санхүүгийн зуучлалыг хэвийн үзүүлэх боломжийг бууруулдаг сөрөг талтай. Жишээ нь 2014 оны 07 сарын 31 ны байдлаарх банкны өөрийн хөрөнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний зээл авсан зөвхөн 3 холбогдох этгээдийн зээлийг чанаргүй болгож үзэхэд өнөөдөр үйл ажиллагаа явуулж буй 13 банкны 8 нь Монголбанкнаас тогтоосон I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангахгүй хэмжээнд хүрэхээр байна. (5 нь системийн нөлөө бүхий банк⁸⁰).

Харин дээрх хязгаарлалт 5 хувь хэвээр байх үед тус шокийг системд үзүүлэхэд бүх банкууд зохистой харьцааг хангахаар байна. Үүнээс дүгнэхэд холбогдох этгээдэд олгох зээлийн хязгаарлалтыг нэмэгдүүлэх нь банкны салбарын эрсдэл даах чадварыг сулруулж, эдийн засгийн хямралын үед төлбөрийн чадварын болон үйл ажиллагааны хүндрэлд орох эрсдлийг огцом нэмэгдүүлж байна.

Олон улсын туршлага:

Банкны систем дахь холбогдох этгээдийн ашиг сонирхлын зөрчлийг бууруулах, эрх мэдлээ урвуулан ашиглах боломжийг хязгаарлах үүднээс Базелийн хяналт шалгалтын хорооноос 2006 болон 2012 онд гаргасан үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчимд (Core Principles for Effective Banking Supervision) өөрийн орны санхүүгийн салбарын онцлог, хөгжлийн байдалтай нь уялдуулан нэг болон нийт холбогдох этгээдэд олгох зээлийн хязгаарлалтыг тогтоож, мөрдүүлэхийг эрх бүхий байгууллагуудад зөвлөсөн байдаг.

Олон улсын туршлагаас харахад манай улсын санхүүгийн салбарын хөгжилтэй ойролцоо орнуудад (Словени, Орос, Чех, Аргентин гэх мэт) нэг холбогдох этгээдэд банкны өөрийн хөрөнгийн 5-10 хувь, нийт холбогдох этгээдэд 15-25 хувь байх хязгаарлалтыг түгээмэл ашиглаж байна. харин санхүүгийн салбар зохистой сайн засаглал өндөр хөгжсөн орнууд нэг холбогдох этгээдийн хязгаарлалтаас зайлсхийж нийт хязгаарлалтыг ашиглах нь түгээмэл болсон байна. (Шинэ Зеланд, Сингапур гэх мэт) Харин зарим Африкийн оронд энэхүү хязгаарлалтыг 60 хувьд хүргэсэн тохиолдол ч байна (Нигер).

Дүгнэлт:

Хэдийгээр холбогдох этгээдэд олгох зээлийн хязгаарлалтыг нэмэгдүүлэх нь банкуудын бусад санхүүгийн болон түүнд хамааралтай бусад салбарт хөрөнгө оруулах боломжийг өсгөх сайн талтай боловч тэдгээрийн зээлийн төвлөрлийг нэмэгдүүлж, улмаар хэвийн үйл ажиллагаа нь холбогдох этгээдэд олгосон зээлийн чанараас хэт мэдрэмтгий болох өндөр эрсдлийг агуулж байна. Тиймээс банкны зохистой засаглалын түвшин, эдийн засгийн өнөөгийн байдлыг харгалзан холбогдох этгээдэд олгох зээлийн хязгаарлалтыг нэмэгдүүлэх оновчгүй байна.

⁸⁰Системийн нөлөө бүхий 6 банк байдаг. Эдгээр нь үйл ажиллагааны үзүүлэлтээр банкны салбарын 90-ээс дээш хувийг эзэлдэг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын Банкны тухай хууль /2010.01.28/
- “Үндсэн хуулийн цэцийн “Банкны тухай хуулийн зарим заалт Үндсэн Хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 2010.06.30-ны № 03 шийдвэр
- www.legalinfo.mn
- www.mongolbank.mn
- www.reuters.com
- Bank Regulation and Supervision Around the World a Crisis Update www.asbaweb.org
- <https://enim.wiwi.hu-berlin.de>
- <http://home.business.utah.edu/finmh/RelatedLendNovember.pdf>
- www.pem.org.my
- <http://books.google.mn>
- Bringing down the banking system: Lessons from Iceland, 2014, Chapter 11. Tunneling money through related party lending <http://books.google.mn>
- www.oecd.org/corporate/ca/corporategovernanceprinciples/44372710.pdf
- Дэлхийн Банкны мэргэжилтнүүд, ОУВС-ийн Санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээ, 2011
- www-wds.worldbank.org
- <http://elibrary.worldbank.org/doi/pdf/10.1596/1813-9450-5570>

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАНГИЛАА АСУУДЛУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа

Нэг. Макро эдийн засгийн үндсэн /зангилаа/ асуудлууд, төрийн зохицуулалт:

Онолын хувьд макро эдийн засгийн зангилаа асуудлуудыг дараах асуудлуудын хүрээнд авч үзсэн бөгөөд төрөөс эдгээр асуудлуудыг зохицуулж, зохистой байдлыг хангахад түлхүү анхаардаг байна. Үүнд:

- Ажил эрхлэлтийг дэмжих;
- Инфляцийг зохистой түвшинд хязгаарлан барих;
- Эдийн засгийн мөчлөгийг тогтворжуулах;
- Улсын төсвийн алдагдлыг бууруулах;
- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах

Эдгээр эдийн засгийн зорилтуудыг хангахын тулд төрийн зүгээс сангийн болон мөнгөний бодлогын арга хэрэгслээр дамжуулан төрийн зохицуулалт хийж тодорхой арга хэмжээ авдаг.

Макро эдийн засгийн үндсэн зорилгууд болох урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох, инфляцийг тогтворжуулах болон ажилгүйдлийг бууруулах зэрэг эдийн засгийн хөгжлийн тулгуур асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төрийн үйл ажиллагааг **сангийн бодлого** гэж ойлгож болно. Тодорхойлолтоос харахад татварын болон төсвийн зарлагын өөрчлөлт гэсэн параметрууд нь сангийн бодлогын үндсэн арга хэрэгслүүд болдог. Иймд сангийн бодлогыг явуулахдаа эдгээр арга хэрэгслүүдийг хослуулах, угсруулах зэргээр төр эдийн засгийн төлөв байдалдаа нөлөөлөх боломжтой. Гэхдээ сангийн ямар бодлого явуулах нь эдийн засгийн тухайн үеийн төлөв байдлаас шалтгаална.

Сангийн бодлоготой ижил зорилготой боловч мөнгөний нийлүүлэлт, хүү зээлийн нөхцлийн өөрчлөлтөөр дамжин хэрэгждэг бодлогыг төрийн мөнгө-зээлийн бодлого гэж нэрлэдэг.

Мөнгөний нийлүүлэлт-зээл гэсэн параметрууд нь мөнгө зээлийн бодлогын үндсэн арга хэрэгслүүд болдог байна. Үндсэн параметруудийг хэрхэн өөрчлөх нь эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарна. *Тухайлбал*, эдийн засгийн уналтын үед мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэн, зээлийн хүүг бууруулдаг байхад, хэт халалтын үед эсрэгээр гүйлгээн дэх мөнгөний тоо хэмжээг багасгаж, харин зээлийн хүүг өсгөдөг. Эдгээр арга хэмжээний үр дүнд эдийн засаг ерөнхий хандлагынхаа дагуу өсөх боломжтой болдгийн зэрэгцээгээр үнийн ерөнхий түвшин тогтворждог байна.

Манай улсын макро эдийн засгийн үндсэн /зангилаа/ асуудлуудын өнөөгийн төлөв байдлын талаарх тоон мэдээллийг Үндсэний Статистикийн Хорооны www.nso.mn, www.1212.mn сайтаас авч ашигласан болно.


Хоёр. Макро эдийн засгийн өнөөгийн төлөв байдал

2014 оны эхний хагас жилийн байдлаар манай улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд, төлбөрийн тэнцэл, төсвийн алдагдал, инфляци, валютын ханш зэрэг нь өмнөх онуудад байгаагүйгээр өндөр үзүүлэлттэй гарсан.

Энэ нь 2012 оноос эхлэн эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн, эдийн засгийн мөчлөн дагасан төсвийн бодлого, ирээдүйд олох экспортын бүтээгдэхүүн /уул уурхайн орлого/-ийг барьцаалж авсан богино хугацаатай зээлээр санхүүжсэн нийгмийн хавтгайрсан халамж буюу бэлэн мөнгө тараалт, гадаад секторын эрсдэлд өртөмтгий байдал, эдийн засгийн хувьд эрдэс баялгийн салбараас хэт хараат байдал зэргээс шалтгаалсан байна.


Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн өнөөгийн нөхцөл байдлыг зургаар авч үзвэл:

Зураг 1. ДНБ-ний өсөлт, бууралт (%) (улирлын нөлөөллийг арилгасан)




Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2011 онд 17.5 хувь хүрч байсан бол энэ өсөлт жил, улирал, сар дараалан буурсаар 2012 онд 12.3 хувь, 2013 онд 11.7 хувь, энэ онд 9 орчим хувь байхаар байна. Монгол Улсын инфляцын түвшин сүүлийн 3 жил дараалан 2-оос дээш оронтой тоогоор илэрхийлэгдэж энэ үзүүлэлтээрээ дэлхийд эхний арванхоёрдугаарт бичигдэж байна. Иргэдийн өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн 2 жилийн хугацаанд 10.6 хувиас 177 хувь хүртэл өсч, инфляцийн өсөлт иргэдийн амьжиргаанд хүчтэй дарамт үзүүлж нийгэмд сөрөг үзэгдэл үзүүлж байна.

Зураг 2. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, өссөн дүнгээр (сая.төг)




Зураг 3. Инфляцийн түвшин, оны эхнээс (%)



Ам.долларын ханшийн өсөлт үргэжилсээр байна. Ам долларын ханш 2012 оны 7 дугаар сард 1349 төгрөгтэй тэнцэж байсан бол өнөөдрийн байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1844 төгрөг болж 38 хувиар уналаа. Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн ханш ийнхүү огцом суларч байгаа нь иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хүнд дарамт учруулж байна.


Монгол Улсын гадаад валютын албан нөөц өнгөрсөн зургадугаар сарын байдлаар 1.31 тэрбум ам.доллар болж буурсныг Төвбанк мэдээлсэн. Энэ нь өмнөх сарынхаас 17.9, өнгөрсөн оны мөн үеэс 57.6 хувиар доошилж, 2012 оны 7 дугаар сард байсан 2.8 тэрбум ам долларын нөөц 2.2 дахин багассан үзүүлэлт юм.

Зураг 4. Гадаад худалдааны нийт тэнцэл, өссөн дүнгээр (сая. ам.доллар)



Банк санхүүгийн салбарт ч өндөр эрсдэл бий болсныг Үндэсний статистикийн хорооноос гаргасан тайлангаас харж болно. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ 7 дугаар сарын эцэст 599.7 тэрбум төгрөг, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 550.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 32.4 хувиар, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 3.4 дахин өссөн үзүүлэлтэй гарч, нийт банкны систем дэх эрсдэл эрс нэмэгдсэн байна.

Зураг 5. Ажилгүйдлийн түвшин, улирлаар (%)



Энэ оны 7 дугаар сарын байдлаар Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн 54.3 хувь нь буюу 54.8 мянган аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа зогсоосон нь 2012 оны мөн үетэй харьцуулахад 84.5 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь манай улсын бизнесийн орчин муудсаны илэрхийлэл юм.

Гурав. Эдийн засгийн салбарын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал**1. “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн хувьд:**

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хувьд Төсвийн орлогын төлөвлөлтөнд уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийн нөлөөллийг бууруулах үүднээс тэнцвэржүүлсэн үнээр тооцдог болсон хэдий ч биет хэмжээгээний өөрчлөлт томоохон эрсдэл учруулж байна. Иймээс төсвийн орлогын төлөвлөлтөнд эрсдлийг индексжүүлж тооцох, зардлын төлөвлөгөөг орлогын төлөвлөгөөнөөс шууд хамааруулан тооцдог болох шаардлагатай байна.
- Төсвийн Тогтвортой байдлын хуулийн 6.1.3-т “Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ- өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” гэж заасан. Гэвч хуулийн заалт нь төсвийн зарлагын өсөлтийн хязгаарлахад бодит үр дүн үзүүлж чадахгүй байна. Төсвийн орлогын өсөлтийг дагасан төсвийн зарлагын хэт өсөлтийг хязгаарлах, түүхий эдийн экспортоос хамааралтай төсвийн орлогын хэлбэлзлийг бууруулах, улмаар үндэсний санхүүгийн хуримтлал бүрдүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд “Төсвийн тусгай шаардлага”-ыг тодорхойлж өгсөн. Үүний дагуу тухайн жилийн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялагийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялагийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх ёстой.
- Мөн хуулийн 6.1.1-т “уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн дүрмийн санд хувь оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ирээдүйн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгааг хамааруулахгүйгээр тооцсон улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Үүнд “улсын өр” гэж Засгийн газрын дотоод, гадаад зээл, санхүүгийн түрээс, Засгийн газраас гаргасан баталгаа, өрийн бичиг, төрийн болон орон нутгийн өмчит болон тэдгээр өмч давамгайлсан хуулийн этгээдийн ирээдүйд эргэн төлөх үүрэг хүлээсэн санхүүгийн бүх төрлийн төлбөрийн үүргийн мөнгөн дүн, түүнд ногдох хугацаа хэтэрсэн хүү, алданги, торгуулийн нийлбэрийг ойлгоно гэж заажээ. Засгийн газар сүүлийн жилүүдэд хөнгөлттэй нөхцөлтэй зээлийн багцыг удирдан ашиглаж ирсэн төдийгүй эдийн засгийн хурдацтай өсөлтийн улмаас Монгол Улсын зээлжих эрх нэмэгдэж өнөөгийн байдлаар манай улсын нийт гадаад өрийн хэмжээ 2013 оны 3-р улирлын байдлаар 18,199,703 мянган ам.доллар хүрч өмнөх улирлаас 4 хувь, өмнөх оны мөн үеэс 39 хувиар өссөн дүнтэй байна. Үүнээс компани хоорондын зээллэг 56.1 хувь, засгийн газрын өр 23.3 хувь, Төв банк 4.9 хувь, арилжааны банкууд 6 хувь, бусад сектор 9.1 хувь эзэлж байна.⁸¹

2. Татварын хууль тогтоомжийн хувьд:

- Татварын хууль эрх зүйн орчинд өөрчлөлт орох, татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой хууль, тогтоомж батлагдан гарах нь төсвийн орлого буурах, төсвийн зарлагад нөлөөлөх үр дагавар бүхий хууль, эрх зүйн орчны аливаа өөрчлөлт, мөн төсвийн зарлагын норм, нормативыг өөрчлөх, орон тоо нэмэгдүүлэх шийдвэрүүд нь 2014 онд төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгосон. Мөн хууль эрх зүйн орчин тодорхой бус, өөрчлөлт орох хүлээлт бий болох нь хөрөнгө оруулагчдын шийдвэрт нөлөөлж, улмаар гадаадын хөрөнгө оруулалт буурах,

⁸¹Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

үүнийг дагаад бүтээн байгуулалт, импорт багасч эдийн засагт сөргөөр нөлөөлснөөс үүдэх улс төр, хууль эрх зүйн орчны эрсдэл үүсч болзошгүй байна. /Эдийн засгийн өршөөлийн тухай хууль, Татварын өршөөл үзүүлэх тухай гэх мэт/

3. Төсөв, мөнгөний бодлогын тухайд:

- Төсөв, мөнгөний бодлого хоорондын уялдааны хувьд хангалтгүй. Макро эдийн засгийн түвшинд төрийн гол зохицуулалт болохын хувьд эдгээр хоёр бодлого хоорондын уялдаа чухал байдаг хэдий ч өнөөгийн байдлаар эдгээр бодлогууд нь нэлээн тэлэлттэй байна. Эдийн засгийн халалт үүсгэж, улмаар тогтворгүй байдал бий болсон нь макро эдийн засгийн бодлогуудын хоорондын уялдаагүй байгааг харуулж байна. Төсөв, мөнгөний бодлогын хэт тэлэлт нь эдийн засаг дах нийт эрэлтийг өсгөж, улмаар инфляцийг онилоод байгаа мөнгөний бодлогын нөлөөг сулруулах, инфляцийн түвшинг өсгөхөд нөлөөлнө. Монгол Улсын хувьд мөнгөний болоод сангийн бодлогын хамгийн муу, буруу хослолыг хэрэгжүүлж байна. Сангийн бодлогын бодит секторын өсөлтөнд чиглэсэн биш, хэрэглээнд чиглэсэн хэт тэлэлт нь үнийн түвшинд нөлөөлж улмаар мөнгөний хатуу бодлого явуулах арга хэмжээ авч энэ нь бодит секторын өсөлтөд сөргөөр нөлөөлдөг.⁸²

Дөрөв. Эдийн засгийн салбарын хууль, эрх зүйн орчинд гарсан зарим өөрчлөлт

- **Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль** 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. Энэ хуульд банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан.

Банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээд /Хадгаламжийн даатгалын корпораци/-ийг үүсгэн байгуулж, банкнаас харилцах болон хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг Хадгаламжийн даатгалын корпорацид даатгуулах, даатгалын тохиолдолд бий болоход хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр төлөхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулснаараа ач холбогдолтой юм.

Энэ хууль батлагдсанаар санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, даатгалын тохиолдол бий болоход Хадгаламжийн корпораци хадгалмж эзэмшигчийн тухайн банкин дахь төрөг ба валютын нийт 20 сая хүртэл төгрөгийн хадгаламжийг нөхөн төлөхдөө тухайн банкны хадгаламж эзэмшигч бүрийг хамруулах, Банкны тухай хуулийн дагуу банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк хадгаламжийн даатгалд хамрагдах зэргийг зохицуулахаар тусгажээ.

- **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн** шинэчилсэн найруулга 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан. Уг хууль /2006/-ийг мөрдсөн хугацаанд Монгол Улсад банк, санхүүгийн тогтолцоо хөгжиж, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хирээр түүний тогтвортой байдлыг хангах, хууль бус хөрөнгийг илрүүлэх, таслан зогсоох, битүүмжлэх, хураах талаарх эрх зүйн орчны илүү боловсронгуй болгох зүй ёсны шаардлага гарсан. Өмнө нь НҮБ-ын холбогдох конвенц, Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын

⁸²"Төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах асуудал буюу инфляцийн эсрэг хамтын ажиллагаа" СЯ-ны ТБГ, Монголбанкны МБСГ, ОУВС-ийн зөвлөх Жап-тай хамтарсан судалгааны тайлан.

байгууллагын зөвлөмжид манай эрх зүйн орчин нийцэхгүй байснаас олон улсын хяналт, шаардлагад өртөх үндсэн нөхцөл болж байв. Иймд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг энэ шаардлагад нийцүүлэн шинэчилснээр банк, санхүүгийн үйл ажиллагаанд учирч болох эрсдлийг хаах эрх зүйн үндэс бүрдсэн байна.

- **Хөрөнгө оруулалтын тухай хууль** нь 2013 оны 10 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан. Энэ хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгааг тогтоох, хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын орчныг тогтворжуулах, хөрөнгө оруулалтын талаар төрийн байгууллагын эрх хэмжээ, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох зохицуулалт оржээ.
- **Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг** 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан. Энэ хууль нь үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг цогцоор нь хамгаалсан, уг зах зээлийн тогтвортой байдлыг хангасан эрх зүйн орчныг бүрдүүлэх явдал байсан. Мөн түүнчлэн энэхүү хууль батлагдсанаар үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлд оролцох сонирхол нэмэгдэж, уг зах зээлийн эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмэр өссөн явдал юм.
- **Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг** 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдөр тус тус баталсан. Энэхүү хууль батлагдсанаар үнэт цаасны бүртгэл, хөрөнгө оруулагчдын эрх ашиг, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эрх зүйн статус зэрэг харилцааг илүү нарийвчлан зохицуулснаараа ач холбогдолтой юм. Хөрөнгө оруулалтын сангийн тухай харилцааг хуульчлан зохицуулж өгснөөр санхүүгийн зах зээлийн зөв, тэнцвэртэй бүрээц бүрэлдэн тогтох боломж нээгдэж өгсөн төдийгүй цаашид хөрөнгө оруулалтын сангууд үүсэх нь жижиг дунд үйлдвэр, компаниуд зөвхөн банкны зээл бус, харин хөрөнгө оруулалт хэлбэрээр санхүүжилт болгох замаар томорч, үйл ажиллагаагаа тэлэх боломжтой болно.

ХАВСРАЛТ.

ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЛАВЛАГАА

№	Хууль	Зохицуулалт /холбогдох хуулийн заалтын хэсэгчлэн авав/
Үнэт цаасны зах зээл		
1	Аудитын тухай 1997.05.01	4 дүгээр зүйл. Аудитын үйл ажиллагаа 1. Аудитын үйл ажиллагаанд: 7/ үнэт цаас гаргахтай холбогдсон эдийн засгийн тооцоо, судалгааны үндэслэлийг хянаж дүгнэлт гаргах; 7 дугаар зүйл. Санхүүгийн тайлангаа баталгаажуулах байгууллага 1. Дараахь аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа аудитын байгууллагаар заавал баталгаажуулна: 1/ хөрөнгийн биржид бүртгэлтэй бүх төрлийн хувьцаат компани; 2/ хөрөнгийн биржид бүртгүүлэх зөвшөөрөл хүсч буй компани; 6/хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоо; 7/ банк, санхүү, даатгалын байгууллага; 8/ брокер, дилерийн үйл ажиллагаа явуулдаг үнэт цаасны компани болон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхэлдэг компани;

2	Валютын зохицуулалтын тухай 1994.05.12	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь валютын зохицуулалтын талаарх төрийн зохих байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд валютын гүйлгээ хийх, валютын гүйлгээнд хяналт тавих, Монгол Улсын үндэсний валютыг үнэгүйдлээс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
3	Иргэний хууль 2002.01.10	47 бүлэг Үнэт цаасны эргэлтээс үүсэх үүрэг 467-475 зүйл
4	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай 2011.02.10	7.1.Хөгжлийн банк дараахь үйл ажиллагааг эрхэлнэ: 7.1.1.зээл олгох, авах; 7.1.2.зээлдэгчийн харилцах данстай холбоотой гадаад, дотоод төлбөр тооцоо хийх; 7.1.3.өөрийн нэрийн өмнөөс зээлийн баталгаа, батлан даалт гаргах; 7.1.4.үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах; 7.1.5.гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах; 7.1.6.зээл худалдах, санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах; 7.1.7.хөрөнгө, өр төлбөрийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа. 14 дүгээр зүйл.Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах 14.1.Энэ хуулийн 24.1-д заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгийн болон мөнгөний зах зээл дээр арилжаалагдах үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах шийдвэрийг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон эдийн засгийн хөгжлийн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг тус тус үндэслэн Хувь нийлүүлэгчдийн хурал гаргана.
5	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай 2005.11.17	3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 3.1. Энэ хуульд заасан санхүүгийн үйлчилгээнд дараахь үйл ажиллагаа хамаарна: 3.1.1. банк бус санхүүгийн байгууллагын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа; 3.1.2. үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үйл ажиллагаа; 3.1.3. даатгагчийн Даатгалын тухай хуульд заасан үйл ажиллагаа; 3.1.4. даатгалын төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчийн Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан үйл ажиллагаа; 3.1.5. хоршооны Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасан хадгаламж, зээлийн үйл ажиллагаа; 3.1.6.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа; 3.1.7. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаа; 3.1.8.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан даатгалын үйл ажиллагаа; 3.1.9. хуульд заасан санхүүгийн бусад үйл ажиллагаа.

6	<p>Үнэт цаасны зах зээлийн тухай</p> <p>2013.05.24</p>	<p>5 дугаар зүйл. Үнэт цаас</p> <p>5.1.Энэ хуулийн зохицуулалтад хамрагдах үнэт цаасанд дараах санхүүгийн хэрэгсэл хамаарна:</p> <p>5.1.1.хувьцаат компанийн хувьцаа /цаашид “хувьцаа” гэх/;</p> <p>5.1.2.компанийн өрийн хэрэгсэл;</p> <p>5.1.3.Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл;</p> <p>5.1.4.хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх;</p> <p>5.1.5.хадгаламжийн бичиг;</p> <p>5.1.6.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;</p> <p>5.1.7.үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчид санал болгож байгаа тодорхой тооны хувьцаа болон өрийн хэрэгслийг тодорхой хугацааны дотор тохиролцсон үнээр захиалах эрх /варрант/;</p> <p>5.1.8.энэ хуульд заасан үүсмэл санхүүгийн хэрэгсэл;</p> <p>5.1.9.энэ хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гэж тогтоосон бусад санхүүгийн хэрэгсэл.</p> <p>5.2.Хуульд өөрөөр заагаагүй бол дор дурдсан санхүүгийн хэрэгсэл энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй:</p> <p>5.2.1.хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа;</p> <p>5.2.2.зохицуулалттай зах зээлд арилжихыг зөвшөөрөөгүй үүсмэл санхүүгийн хэрэгсэл;</p> <p>5.2.3.шилжүүлгийн болон энгийн вексель;</p> <p>5.2.4.банкаас гаргасан хадгаламжийн сертификат;</p> <p>5.2.5.Банкны тухай хуулийн 15.2-т заасны дагуу банкаас мөнгөний зах зээлд арилжихаар гаргаж байгаа нэг жил хүртэлх хугацаатай бусад санхүүгийн хэрэгсэл.</p> <p>5.3.Энэ хуулийн 5.2.4-т заасан санхүүгийн хэрэгсэл нь хадгаламжийн бичигт хамаарахгүй.</p>
7	<p>Хөрөнгө оруулалтын сангийн тухай</p> <p>2013.10.03</p>	<p>3 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн үйлчлэх хүрээ</p> <p>3.1.Энэ хуулиар хөрөнгө оруулалтын санд тусгай зөвшөөрөл олгох, сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах, сангийн хөрөнгөөр үйл ажиллагаа эрхлэх болон сангийн хөрөнгийг хадгалах, бүртгэх, хөрөнгө оруулагчийг мэдээллээр хангах, хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлэх үнэт цаасны зах зээлийн зохицуулалт бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.</p> <p>3.2.Тусгай хуулиар зохицуулагдсан сан, түүний хөрөнгөөр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцаа энэ хуульд хамаарахгүй.</p> <p>3.3.Банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогч, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.12, 24.1.13-т зааснаас бусад зохицуулалттай хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхтэй холбогдсон харилцаа энэ хуульд хамаарахгүй.</p> <p>3.4.Банк нийтээс төвлөрүүлсэн хадгаламжийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхтэй холбогдсон харилцааг Банкны тухай хуулиар зохицуулна.</p>
8	<p>Хөрөнгө оруулалтын тухай</p> <p>2013.10.03</p>	<p>5 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын хэлбэр</p> <p>5.1.Хөрөнгө оруулалтыг Монгол Улсад дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.1.хөрөнгө оруулагч дангаараа болон бусад хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах;</p> <p>5.1.2.хөрөнгө оруулагч хувьцаа, өрийн бичиг, бусад төрлийн үнэт цаасыг худалдан авах;</p> <p>5.1.3.компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх;</p> <p>5.1.4.концесс, бүтээгдэхүүн хуваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах;</p> <p>5.1.5.санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх;</p> <p>5.1.6.хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэр.</p>

9	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль 2010.04.23	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Банкны салбар		
10	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай 1995.10.31	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдээс банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд мөнгөн хөрөнгө хадгалуулах, хоорондын төлбөр тооцоогоо банк, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэх, банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл авах, түүнийг эргүүлэн төлөх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
11	Банкин дахь мөнгөн хадгаламжинд даатгалын тухай 2013.01.10	1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
12	Банкны тухай хууль 2010.01.28	6 дугаар зүйл. Банкны эрхлэх үйл ажиллагаа 6.1.Банк Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа эрхэлнэ: 6.1.1.мөнгөн хадгаламж; 6.1.2.зээл; 6.1.3.төлбөр тооцооны үйлчилгээ; 6.1.4.өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах; 6.1.5.гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах; 6.1.6.үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах; 6.1.7.үнэт зүйл хадгалах; 6.1.8.гадаад төлбөр тооцоо хийх; 6.1.9.үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах; 6.1.10.санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа; 6.1.11.зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах; 6.1.12.хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ. 6.2.Банк, түүний хараат болон охин компани Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа эрхэлнэ: 6.2.1.санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх; 6.2.2.итгэлцлийн үйлчилгээ; 6.2.3.даатгалын зуучлагч; 6.2.4.андеррайтерын үйлчилгээ; 6.2.5.кастодиан; 6.2.6.факторингийн үйлчилгээ; 6.2.7.харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ. 15 дугаар зүйл. Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах 15.1.Энэ хуулийн 17.4-т заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдах үнэт цаас гаргах, барьцаалах, худалдах, худалдан авахтай холбогдсон банкны үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна. 15.2.Банк мөнгөний зах зээл дээр арилжаалагдах нэг жил хүртэлх хугацаатай үнэт цаасыг Монголбанкны зөвшөөрлөөр гаргах буюу худалдаж, худалдан авч, барьцаалж болох бөгөөд энэ нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд хамаарахгүй.

13	Векселийн тухай 1995.11.02	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь иргэн,хуулийн этгээд болон тэдгээрийн хооронд хийх төлбөр тооцоонд векселийг хэрэглэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
14	Иргэний тухай хууль 2002.01.10	44 бүлэг Зээл тооцооны үүрэг 445-466 зүйл Банк төлбөр тооцоо
15	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай 2011.02.10	7.1.Хөгжлийн банк дараахь үйл ажиллагааг эрхэлнэ: 7.1.1.зээл олгох, авах; 7.1.2.зээлдэгчийн харилцах данстай холбоотой гадаад, дотоод төлбөр тооцоо хийх; 7.1.3.өөрийн нэрийн өмнөөс зээлийн баталгаа, батлан даалт гаргах; 7.1.4.үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах; 7.1.5.гадаад валют худалдах, худалдан авах, хадгалуулах; 7.1.6.зээл худалдах, санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах; 7.1.7.хөрөнгө, өр төлбөрийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.
16	Төв банк /Монгол банк/-ны тухай 1996.09.03	5 дугаар зүйл. Монголбанкны үйл ажиллагааны чиглэл Монголбанк энэ хуульд заасан өөрийн зорилтыг биелүүлэхийн тулд дараахь чиглэлээр үйл ажиллагаа эрхэлнэ: 1/ мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах; 2/мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх; 3/ Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх; 4/ банкны үйл ажиллагаанд хяналт тавих; 5/ банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах; 6/ гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, удирдах.
17	Шилэн дансны тухай 2014.07.01	6 дугаар зүйл. Шилэн дансны мэдээлэл 6.9.Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно. Мэдээллийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.
18	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай 2010.10.11	4-р бүлэг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, мөнгөний бодлого, төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх журам 25-р Үндсэн чиглэл, мөнгөний бодлого, төсөв хэлэлцэх

Бичил санхүүгийн зах зээл		
19	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай 2002.12.12	<p>7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа</p> <p>7.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж дараахь үйл ажиллагааг ойлгоно:</p> <p>7.1.1. зээл;</p> <p>7.1.2. факторингийн үйлчилгээ;</p> <p>7.1.3. санхүүгийн түрээс;</p> <p>7.1.4. төлбөрийн баталгаа гаргах;</p> <p>7.1.5. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах;</p> <p>7.1.6. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;</p> <p>7.1.7. гадаад валютын арилжаа;</p> <p>7.1.8. итгэлцлийн үйлчилгээ;</p> <p>7.1.9. богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;</p> <p>7.1.10. хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх.</p> <p>7.1.11. үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа.</p>
20	Хадгаламж зээлийн хоршооны тухай 2011.10.27	<p>16 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн хоршооны хадгаламжийн үйл ажиллагаа</p> <p>16.1. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хадгаламж, зээлийн хоршоо нь бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр зөвхөн гишүүдийнхээ мөнгөн хөрөнгийг хадгалж болно.</p> <p>16.2. Хадгаламжийн үйл ажиллагааны бодлогыг хадгаламж, зээлийн хоршооны бүх гишүүдийн хурлаас батална.</p> <p>16.3. Хадгаламж хэлбэрээр татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө нь тухайн хадгаламж, зээлийн хоршооны өөрийн хөрөнгөд хамаарахгүй бөгөөд уг хөрөнгийг зөвхөн зээлийн болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээний эх үүсвэр болгон ашиглахаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.</p> <p>16.4. Гишүүний хадгаламжийг барьцаалж, түүнд зээл олгож болно.</p> <p>16.5. Хадгаламжийг хамтран эзэмшиж болох бөгөөд хамтран эзэмшигч нь хадгаламж, зээлийн хоршооны гишүүн байх эсэх асуудлыг тухайн хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр зохицуулна.</p> <p>16.6. Нэг гишүүнээс авч болох хадгаламжийн хэмжээнд Хороо хязгаарлалт тогтоож болно.</p> <p>16.7. Хадгаламж, зээлийн хоршоо гишүүдийнхээ хадгаламжийн баталгааг хангах үүрэгтэй.</p>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- “Эдийн засгийн ухаан Макро экономикс” Н.Грегори Мэнкью УБ, 2009 он;
- “Макро эдийн засгийн төрийн зохицуулалт, санхүү-мөнгөний бодлого” Д.Лувсанцэрэн УБ, 2008 он;
- “Төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах асуудал буюу инфляцийн эсрэг хамтын ажиллагаа” Сангийн яамны Төсвийн бодлогын газар нь Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар болон ОУВС-ийн зөвлөх Жап-тай хамтарсан судалгааны тайлан, www.iltod.gov.mn;
- “Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ” Д.Ган-Очир, УБ, 2012 он;
- “Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын хандлага ” Ч.Хашчулуун УБ, 2012 он;
- “Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг дээшлүүлэх нь” судалгааны тайлан, Т.Нарантуяа, Д.Баярмаа, М.Сарантуяа , ШУТИС, КтМС УБ, 2012 он;
- www.legalinfo.mn
- www.nso.mn
- www.1212.mn
- www.frc.mn

МОНГОЛ УЛСАД БОЛОН ГАДААДЫН УЛС ОРНУУДАД ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН АСУУДЛЫГ ЭРХ ЗҮЙН ТАЛААС НЬ ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ, ЗАРИМ ЖИШИГ

Г.Чулуун, Б.Ариунжаргал, Р.Нургүл

АГУУЛГА

Удиртгал

А) Монгол Улсын газрын харилцааны хууль тогтоомж дахь газар өмчлөлийн холбогдолтой “тодруулбал зохих” зарим асуудал

- 1) “Газрыг өмчлөх” –ийн учир шалтгааны зарим үндэс
- 2) [Монголын нийгмийн] Газрын харилцааны түүхэн уламжлал
- 3) Монгол Улсад газар өмчлөх, эзэмших, ашиглах харилцааг эрхзүйн талаас нь зохицуулсан өнөөгийн байдал
- 4) Үндсэн хуульд «... Газрыг ... Монгол Улсын иргэнд газар өмчлүүлж болно» гэсний тайлбарт холбогдох нэмэлт өгүүлэмж
- 5) Газар төрийн өмч үү, улсын өмч үү .. бүр ард түмний өмч үү?!
- 6) Конституцид өөрчлөлт оруулахад “баримтлах зарчим” –ын зарим асуудал

В) Гадаадын зарим орны газар өмчлөлийн эрх зүйн зохицуулалтын зарим онцлог

- Сингапур Улс
- Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- Бүгд Найрамдах Казахстан Улс
- Румын Улс
- Оросын Холбооны Улс

Ашигласан материал

УДИРТГАЛ

Гадаадын улс орнуудад болон монголд газар өмчлөлийн байдал ямар байгаа тодруулахыг, улмаар удирдамж чиглүүлгийн чанартай нэр бүхий 9 багц сэдвийг зарим тодотголтойгоор зааж ирүүлсэн захиалагчийн хүсэлтийн дагуу доорх мэдээллийг бэлтгэв. Захиалагч тал “газар өмчлөл, газар хувьчлалын асуудал” –ыг тухайлан сонирхож буй тул, мэдээлэлдээ бид “газрыг өмчийн талаас нь” түлхүү харж, харин түүний “эзэмших ба ашиглах” –тай холбогдох харилцааны онцлогийг аль болохоор тойрохыг эрмэлзсэн болно.

Гэвч, гадаадын зарим оронд (жишээ нь, ОХУ–д) “собственник земли” буюу “газар өмчлөгч” ухагдахуунд газар түрээслэгч ашиглагчийг ч хамаатуулдаг. (Тоймын “гадаадын туршлага” –ын талаарх хэсэгт энэ талаар дэлгэрүүлж дурдана) Орос хэлний тайлбар тольд өгүүлснээр “ямар нэг зүйлийг өөртөө өмчлөгчийг өмч эзэмшигч буюу “собственник” гэсэн байв. Монголын газрын харилцааны түүхэн уламжлалаас ч харсан “газрын түрээс” ухагдахуунд газрыг эзэмших ба газрыг ашиглах ойлголтууд багтдаг байсан харагдсан. Нэр томьёоны асуудал хууль тогтоомжийн агуулгад шийдвэрлэх нөлөөтэй байдаг. Тиймээс, газар эзэмших ба газар ашиглахтай холбоотой харилцааг хөндөхгүй орхиж бас болохгүй байв.

Газрын харилцаа, газрын шинэтгэлийн асуудлыг, олон улсын төвшиндээ ч тэр, монголын хувьд ч тэр, эдүгээ эрх зүйн хүрээний урт удаан хугацаанд нилээн сайн судлагдсан, “нуруу нь авагдсан” сэдвийн нэг үздэг. Олон судалгаа бий. Тэдгээрээс жишээлж дурдахад,

- 2007 оны зун Монгол Улсын Засгийн газрын тухайн үеийн тохируулагч агентлаг-Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, Ази, Номхон далайн газар зүйн нийгэмлэгийн дэд бүтцийн байнгын хороо (PC GIAP), Швед Улсын Швейдсурвей (Swedesurvey) байгууллагууд хамтран НҮБХХ, АХБ, Нээлттэй нийгэм хүрээлэн, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг (GTZ), Олон улсын хэмжин

зураглаачдын холбоо (FIG) –ны дэмжлэгтэйгээр Сайн газрын харилцаа ба түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үр нөлөө” сэдэвт олон улсын Бага хурал монголд зохион байгуулагдаж байв.

- Монголын нээлттэй нийгэм хүрээлэн (Соросын сан) –гаас Иргэнд газар өмчлүүлэх тухай Монгол Улсын хуулийн агуулга үзэл санаанд дүн шинжилгээ хийгдэж, хөндлөнгийн [шинжээчийн] дэлгэрэнгүй дүгнэлт гарсан байдаг.
- Монгол Улсын Их сургууль, Удирдлагын академийн эрдэмтэн судлаачдын бүтээл [Г.Жаргал (Ph.D), Д.Солонго (Ph.D), М.Уянга, “Газар: Баялагаас өмч үүсгэх арга (Газрын эрх зүй)”, УБ, 2014] –д Монгол Улсын газрын эрх зүйн түүхэн харьцуулалт, Газрын харилцааны шинэтгэлийн асуудал, Австрали, Герман болон бусад улсын газрын эрх зүйн зохицуулалтыг дэлгэрэнгүй авч үзсэн.

Газар бол, нэг талаас, байгалийн объект тул, түүнд байгаль хамгааллын үүднээс хандах, газар нь үйлдвэрлэлийн хэрэгсэл тул түүнтэй хэрхэн харьцах ёстойг “заах чиглүүлэх”, мөн газар нь үл хөдлөх хөрөнгө тул өмчлөгчийн эрхийг хамгаалах асуудуудыг цогцоор харах .. гэсэн олон замын уулзавр дээр газрын харилцааны асуудлыг зохицуулдаг гэж хэлж болно.

Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн орчныг сайн бүрдүүлж чадвал газрын харилцаагаар дамжиж улсын төсвийн орлого, хөрөнгө оруулалт нэмэгдэж, үйлдвэржих хотжих үйл явц түргэсч, иргэдийн ахуй амьдралд эерэг бодит нөлөөгөө үзүүлдэг. Хэрэв энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалт нийгмийн амьдралын шаардлагаас хоцорч, удааширч, улмаар хүлээлт үүсгэвэл газрын хууль бус элдэв бизнес өрнөж, далд эдийн засгийн сөрөг үзэгдэл, авилга хахууль дэлгэрэх хөрс бий болдог.

Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтын хүрээнд газар өмчлөл, газар хувьчлалын асуудлыг монголд болон гадаадын улс орнуудад хэрхэн шийдэж ирснийг авч үзэхдээ, захиалагчийн нэрлэсэн сэдвүүдийг дотор нь төсөөтэйгээр бүлэглэн, тэдгээрт, дараалын дагуу хариулах байдлаар тоймлов. Тойм мэдээлэл,

- А. Монгол Улсын газрын харилцаан хууль тогтоомж дах дахь газар өмчлөлийн холбогдолтой “тодруулбал зохих” зарим асуудал (судл. реф. Г.Чулуун)
- В. Гадаадын зарим орны газар өмчлөлийн эрх зүйн зохицуулалтын зарим онцлог (судл. реф. Р.Нургүл, Б.Ариунжаргал) гэсэн 2 хэсгээс бүрдэх ба хэсгүүд дотроо [хоорондоо агуулгын хувьд тэр бүр хамааралгүй, нийт 8 дэд] гарчигт хуваагдана.

Газар өмчлөлийн асуудлын ард оршиж болох философ сэтгэлгээний үндсийг болон улстөрийн философийн нэр бүхий (ард түмэн, төр, улс, улстөр) ухагдахуунуудыг энгийн ойлгомжтой тайлбарлахыг хүсэхдээ захиалагч “судлаачдын бүтээлч санаалчлагад итгэж найдаж” байгаагаа илэрхийлсэн байв. Үүнийг бид “газрын харилцаан дах өмчлөлийн асуудлыг авч үзэхдээ өнөөгийн Үндсэн хуулийн үзэл санаанд хэт захирагдаж явцууралгүй, чөлөөтэй ажиллах” агуулгаар ойлгож хүлээж авсан болно. Тиймээс манай тоймын зарим хэсэг харьцангуй нийтлэг биш өгүүлэмжтэй болсон байх магадлалтайг анхаарна уу.

А) МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ “ТОДРУУЛБАЛ ЗОХИХ” ЗАРИМ АСУУДАЛ

1) “Газрыг өмчлөх” –ийн учир шалтгааны зарим үндэс

Аливаа баялагийн анхдагч эх булаг бологч газар нь байгалийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүн төрөлхтний хөгжил, дэвшилд чухал үүрэг гүйцэтгэсээр иржээ. Бүх баялаг

газраас эхтэй, түүнээс төлжин амилж байдаг. Газрын асуудлыг шинжлэх ухааны үүднээс танин мэдэх нь нийгэм, эдийн засаг, оюун санааны амьдрал, эрх зүйн хувьд ч олон талын чухал ач холбогдолтой юм.

Хөрөнгө гэж юу вэ?

Хөрөнгө гэж эзэндээ орлого ашиг авчирдаг эд зүйлсийг хэлнэ.

Хөдлөх хөрөнгө орлого бий болгодог. Үл хөдлөх хөрөнгө орлого авчирдаг гэж үзэх бичих нь бий. Газар нь үл хөдлөх хөрөнгийн сонгодог нэг хэлбэр юм. Хүний гараар бүтээгдсэн зүйлс (хөрөнгө) өртгөө нөхөөд ашиг өгдөг байх учиртай. Харин, газарт ийм шаардлага “тавигддаггүй”, тэрийг хүн бүтээгээгүй, элэгдэж эвдэрсэн ч устаж үгүй болдоггүй онцлогтой.

Газар эзэндээ ашиг орлого авчирна. Түүний “энэ чанар” –ыг харьцуулан жиших, хэмжих хэрэгцээ үүсдэг. Ингэж “газрыг үнэлэх” шаардлага бий болдог. Газрыг өмчилнө, эзэмшинэ, ашиглана, түрээслэнэ гэдэг нь түүний энэ шинжтэй чанартай холбоотой.

Монгол Улсын Үндсэн хуулийн газрын харилцаанд хамаарах өгүүлэмжийг зөвхөн түүний 6 дугаар зүйлийн агуулгаар явцуу харах нь өрөөсгөл юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 зүйлд, жишээ нь, “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах, хувийн аж ахуй эрхлэх, байнга оршин суух газраа сонгох зэрэг иргэний үндсэн эрхүүдийг нэрлэн зааж баталгаажуулсан.

Хүний эрхийн үндэсний комиссоос иргэний “үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх” –ийг, танин мэдэхүйн агуулгаар хялбаршуулан тайлбарлажээ. Тэнд дурдсанаар,

- Монгол Улсын Үндсэн хуульд заасан “эд хөрөнгийг шударгаар олж авах” гэдэг нь түүнийг эзэмших, өмчлөхийн өмнөх зайлшгүй шат, шаардлага юм. Тодруулбал, иргэн бие махбодоороо хийсэн, мэдлэг оюунаараа бүтээсэн хөдөлмөр, гараараа хийж буй ажил .. эд бүгдийн үр шим нь эд хөрөнгийг шударгаар олж авах урьдач нөхцөл болно;

Эд хөрөнгө гэж юу вэ?

Эд хөрөнгөд эд юмс болон эдийн бус баялаг багтана. Эд юмс гэсэн ойлголтыг монголын хууль тогтоомжид нарийвчлан тодорхойлсон нь үгүй ч энэ нь биет байдалтай аливаа объектыг хэлдэг гэж ойлгоно, өөрөөр хэлбэл гарт баригдах зүйлсийг хэлнэ. Салхи, агаар, урсгал ус зэрэг нь мэдрэгддэг хэдий ч барьж авах боломжгүй зүйл учраас эд хөрөнгө болох боломжгүй талдаа байдаг. Харин эдийн бус баялаг гэдэг нь физик утгаараа “биегүй” байж болох ба үүнд оюун санааны шинжтэй зүйлс хамаарна. Оюуны өмч, зохиогчийн эрх, патент гэх мэт.

- Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний өмчлөх эрх [саяын дурдсан бүх төрлийн] эд хөрөнгөд хамаатай гэж ойлгоно. Хуульд өөрөөр зохицуулсан тохиолдол байдаг. Үүнийг Үндсэн хуулиас өөрөөс нь жишээлье. Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 3 –т, “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно” гэж заасан. Энэ заалт ёсоор, Монгол Улсад бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээний газрыг [иргэнд] өмчлүүлэхгүй.

Үл хөдлөх эд хөрөнгө гэж юу вэ?

Эд хөрөнгийн талаарх ерөнхий ойлголтыг “үл хөдлөх эд хөрөнгө” гэх мэтээр, тухайлсан ухагдахуунуудаар нарийсган авч үздэг. Эд хөрөнгө нь үл хөдлөх ба хөдлөх гэсэн хэлбэртэй. Хөдлөх, үл хөдлөх гэж эд

юмсыг ялгаж байгаа нь түүнийг анх олж авах, бусдад шилжүүлэх үйл явц нь ялгаатай байдагтай холбоотой.

Үнэлгээний олон улсын стандартанд «газар болон түүний салшгүй хэсэг болох мод, эрдэс баялаг, түүн дээр хүмүүсийн бий болгосон барилга ба сайжруулалт, шугам сүлжээ, хоолой, цахилгаан утас, цахилгаан шат зэрэг барилгад хөдөлгөөнгүй бэхлэгдсэн байгууламж зэрэг газрын дээрх болон доорх зүйлсийг үл хөдлөх хөрөнгөд хамруулна» гэж заасан. Нийтлэг практикт үйлдвэрийн тоног төхөөрөмжийг өмчлөгч нь үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд оруулаад данс тооцоондоо тусгасан бол тэдгээр нь үл хөдлөх хөрөнгийн татварын объект болно, эсрэг тохиолдолд үгүй.

Монгол Улсын Иргэний хуульд зааснаар газар, түүнээс салгасан тохиолдолд зориулалтын дагуу ашиглах боломжгүй болох эд юмсыг үл хөдлөх эд хөрөнгө гэж үзнэ. Үл хөдлөх эд хөрөнгийг тодорхойлох урьдач нөхцөл бол тухайн эд хөрөнгө газартай бат бэх холбогдсон байх явдал юм. (Энд “батбэх” гэдэг нь салшгүй гэсэн туйлын утга агуулаагүйг тэмдэглэе) Үл хөдлөх эд хөрөнгийг газраас салгамагц тэрээр ашиглагдах боломжоо алддаг.

Барилга байгууламж, хашаа саравчийг газраасаа салбал ашиглагдах боломжгүй болох тул тэдгээрийг үл хөдлөх эд хөрөнгө гэж үзнэ. Нүүдлийн мал аж ахуйг олон зуун жил эрхэлж уламжилж ирсэн монгол орны хувьд малчдын өвөлжөө хаваржааны зориулалттай хашаа, саравч нь үл хөдлөх эд хөрөнгөд хамаарна.

Үл хөдлөх хөрөнгө нь хүний амьдралын гол хэрэгцээ болсон хэвийн аж төрөх боломжийг нөхцөлдүүлдэгээрээ бусад эд баялагтай харьцуулбал хамгийн ашиг тустай өмч юм. Эдгээр зориулалт нь үл хөдлөх аливаа хөрөнгийг өмчлөлийн зүйл, бизнес, хөрөнгө оруулалтын эх сурвалж болгож байдаг. Үл хөдлөх эд хөрөнгийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлснээр, харин, хөдлөх хөрөнгийн хувьд түүнийг бусдад шилжүүлснээр өмчлөх эрх нь баталгаажна.

“Газар олох” зарим боломжийн талаар

Хэний нэгний өмчлөл, эзэмшилд байгаа нь тодорхойгүй ямар нэг эд зүйлийг олж аваад түүнийгээ өөрийн өмчийн адил тордон хамгаалж, эзэмшиж, ашиглаж байсан бол 5 жил өнгөрсний дараа уг эд зүйлсээ өөрийн хууль ёсны өмч болгох боломж байдаг.

Түүнчлэн эзэнгүй үл хөдлөх эд хөрөнгө, жишээ нь, барилга байшинг олж авсан бол түүнийгээ улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш 15 жилийн хугацаанд өмчлөгчийн адил эзэмшсэн бол уг хөрөнгийг өөрийн хууль ёсны өмч болгох боломжтой. Гэхдээ тохиолдлуудын аль алинд нь нэг шаардлага зайлшгүй тавигдана. Тэр нь, тухайн эд хөрөнгийг шударга арга замаар олж авсан байх явдал юм. Хэрэв тэрхүү эд хөрөнгийг бусдын өмчлөл, эзэмшилд байгааг мэдсээр байж мэдээгүй дүр эсгэх, эсвэл эзэнгүй эд хөрөнгийг нийтийн ашиг сонирхолд харшаар ашигласан үйлдэл гарсан бол өмчлөх эрх үүсэхгүй. [1]

ОХУ –ын холбогдох хууль тогтоомжид “газар олж төвхнөх”(самовольное занятие земель) тухай өгүүлэмж бий. Тэдгээрт, олж буусан газраа 15 жилийн турш өмчлөгчийн адилаар эзэмшсэн бол тэр газрыг нь “түүний өмч мөн” гэж үзэх ба зөвшөөрөх

санаа туссан байдаг ч, тухайн асуудалд холбогдох хуулийн заалтууд нь хоорондоо нийцэмжгүй байх зөрөх явдал бас гардаг.

“Газар олж буух боломжийг нээх”, “газрыг олж авсан хугацааны факторыг тооцох”, “олж авсан газраа өмчлөх эрхтэйг хүлээн зөвшөөрөх, уг эрхийг нь хангах” [признание права собственности в силу приобретательной давности (пятнадцатилетнее добросовестное, открытое и непрерывное владение чужим недвижимым имуществом как своим собственным)], “олсон газраа урьчилан бүртгүүлэх боломжийг нээлттэй байлгах” гэх мэт утгачилсан хэллэгүүдийг тухайлан тодотгож лавшруулан ухварлах замаар “бүх газар төрийн өмч байх ёсгүй” –г дамаар нотлох боломжтой гэж үзнэ.

* * *

Дээрх тайлбарт, хүний гараар бүтсэн, газраасаа салбал үл хөдлөх хөрөнгө байх чанараа гээдэг, газартай бэхлэгдсэн өмчийн талаар голлон өгүүлжээ. Харин, хүний хөдөлмөрөөр бүтсэн үл хөдлөх объектийн доорх газар, эсхүл дээрээ объектгүй сул газар [өөрөө] үл хөдлөх хөрөнгө байх боломж чанарыг “тайлбарлахгүй” –гээр тойрсон байдал анзаарагдаж байна.

Үл хөдлөх хөрөнгийн эрх нь албан ёсоор баталгаажуулах газар дээр “түүнтэй бэхлэгдсэн объект барьж байгуулж”, улмаар уг объектийг үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэхэд “объектийн доорх газар” автоматаар үл хөдлөх хөрөнгө болж хувирдаг, эсвэл бүртгэгддэг эсэх талаар барьцтай мэдээлэл олдохгүй талдаа байв.

Газар бол үл хөдлөх хөрөнгө мөн гэдэг нь манай улсын хууль тогтоомжид дам байдлаар хангалттай тусгасан. **Жишээ нь,**

а) Монгол Улсын Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд “газар барьцаалах онцлог” –ийн талаар дэлгэрэнгүй туссан:

- 53.1. Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газар болон газар эзэмших эрх барьцааны зүйл байж .. болно.
- 54.1. [...] Газрын хувьд зээлдэгчийн өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэснээр барьцааны эрх үүснэ.

б) Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд ч газраас авах үл хөдлөх хөрөнгийн татварын заалтууд бий.

“Газрыг зээлийн барьцаанд авч байгаа байдал”-ыг ХААН банкны жишээн дээр товч тодруулахад,

- ХААН банк бизнесийн зориулалттай зээлийг үйлчлүүлэнчдийхээ үл хөдлөх хөрөнгө, мөн газрыг нь барьцаалан олгосоор ирсэн. Тус банкинд, өмчлөл бүхий газар болон газар ашиглалтын лицензыг барьцаалах боломжтой. Харин, газар ашиглах болон эзэмших эрх нь худалдан борлуулах боломжгүй учраас эдийн засагийн эргэлтэнд дангаараа орох боломж байдаггүй ба [уг газар баригдсан байгаамжийнх нь хамтаар] хосолсон барьцааг хэрэглэнэ. Энэ тохиолдолд, хэрэв тухайн газрын ашиглах, эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа богино байвал банкнаас урт хугацаат зээл олгох боломжгүй.
- Газар өмчлөх эрх зохих шийдвэрээр баталгаажихи Улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авсан Улсын бүртгэлийн дугаартай газрыг барьцаалдаг.

- Газар ашиглалтын лицензийг барьцаалдаг. Уул уурхайн чиглэлээр бизнес эрхлэгчдийн хувьд ашигт малтмал ашиглалтын лицензийг барьцаалан зээл олгож байгаа бөгөөд Газрын кадастрын албанд бүртгүүлсэнээр зээлийн барьцаа баталгаажиг байна.
- Улсын бүртгэлийн дугаартай өмчлөх эрхийн гэрчилгээтэй тохиолдолд газрыг дангаар нь барьцаалж байгаа ба барьцааны гэрээг Улсын бүртгэлийн албанд бүртгүүлэн баталгаажуулдаг. Газар ашиглах эсвэл эзэмших гэрчилгээтэй тохиолдолд тухайн газрын дээр баригдсан үл хөдлөх хөрөнгийг газрын хамт барьцаална.

2) [Монголын нийгмийн] Газрын харилцааны түүхэн уламжлал

Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг шийдэхэд монгол түмний газар бэлчээр ашиглаж ирсэн түүх уламжлалыг, түүний эрх зүйн эртний үндсийг сонирхох хэрэгцээ гардаг.

Малын бэлчээрийг өмчлөх – эзэмших – ашиглах – хамгаалах тал дээр монголын түүхийн сурвалжид нэгдөр багцалсан шинжтэй тухайлсан өгүүлэмж ховор юм. Түүхэн урт хугацаанд малын бэлчээр нутаг [гэдэг] хамгаалбал зохих түр зуурын чухаг объект байсан нь үнэн ч, талын нүүдэлчдийн хувьд, энэ нь хэзээ ч тэргүүн зэргийн ач холбогдолтой нүд салгалгүй манавал зохих үл хөдлөх өмч хөрөнгө байж болж чадаагүй байдаг. Ган гачиг, хор хохирол дагуулах дайн байлдаан нүүрлэсэн үед хаяад нүүж болдог, хожим сүүлд эргээд эзэмшиж болдог байсан учраас тэр байх. Харин, сурвалж бичигт бэлчээр нутгийн талаар тэмдэглэсэн дам өгүүлэмж их.

Олон зууны туршид малчин монголчууд газрыг [зөвхөн] бэлчээр нутгийг агуулгаар харж хандаж иржээ. Малын бэлчээрийг эзэмшиж ашиглаж ирсэн монгол түмний арга ухаан түүхэн урт хугацаанд ямар байсан, яаж өөрчлөгдөж хөгжиж ирсэн тухай сэдэвчилсэн мэдээлэл УИХ –ын Тамгын газрын Судалгааны санд бий. Түүхэн сурвалжийн эш бүхий Газрын мэдээний бяцхан тойм гаргая. Үүнд:

- Нийтийн тооллоос өмнө Түмэн шанюйн хүү “улсын үндэс газар мөн” хэмээсэн домогтой. “Миний нутгийн газар шорооноос бурхан гуйсан ч бүү өг” хэмээсэн Моадун “шаньюйн үг” Ардын уран зохиолч Тангадын Галсангийн мөртүүд бөгөөд эх нутгийн газар шорооны үнэ цэнийг уран бүтээлчийн зүгээс уран сайхны аргаар тодруулсан ийн тодруулсан хэрэг юм.
- Х зуунд хүчирхэгжсэн хятан нар “улсын сүргийг эрхлэх [адууны] яам” –тай байж. Тэд мал аж ахуйн [нэг ёсны] удирдах газартай байсан эндээс харагдах бөгөөд тэр үед газар бэлчээрийн эрх зүйн бүдүүлэг боловч зохицуулалттай, газрыг язгуурын эдэлбэр газар, тариа ногооны, бэлчээрийн, ан гөрөөний, хүүр оршуулгын гэж ангилж байжээ.
- Монголын нууц товчоонд бэлчээр нүүдэлтэй холбоотой өгүүлэмж элбэг. Нутаг сонгож нүүнэ гэдэг бол малчин монголчуудын хувьд, угтаа бэлчээр сэлгэх шилжилт хөдөлгөөн юм. Сонгосон газрыг нь өөр этгээд давхар сонгочихсон байвал аюул болно. Тиймээс аливаа нүүдэл их дэгтэй харуул хамгаалалтын дор явагддаг байж. Бэлчээр дагасан нүүдэл суудал хэзээнээсээ малчин монгол ахуйн [өдөр тутмын] үндэс суурь байсан нь МНТ –ны агуулгаас тод харагддаг.

- Чингис хаан мянган бүртээ газар хуваарилан, түүнийг эзэмших, зохицуулах эрхийг мянгатын ноён [засаг захиргааны нэгжийн удирдлага] -д мэдүүлсэн. МНТ-ны §219-д, Сорхон шар, Хорч зэрэг үнэнч зүтгэж үйл бүтээсэн эрх бүхий ноёдод газар нутаг, өрх иргэнийг зарлигаар эзэмшүүлжээ.
- Чингис хааны “Их засаг” –т малын бэлчээрийг онцгойлон үзэж, түүнийг эвдлэн сүйтгэх явдлаас хамгаалахыг чухалчилсан байна. Өвс ургамал ногоорсон хойно газар нүхэлсэн, бэлчээр сүйтгэсэн хүнийг шийтгэх, малын бэлчээрийг мянган (засаг захиргааны нэгж) бүрд хувааж “өгч” тэдний эзэмшилд байлгах, гал түймэр алдаж бэлчээр шатаасан хүнийг алах, малын хэвтэр, хашаан дотор шээхийг цээрлэх тухай тэнд заасан байдаг.
- Их Юань улсын “Хар татаарын хэргийн товчоон” сударт дээрхтэй төстэй өгүүлэмж бий.

Монголын эзэнт гүрний үед хязгаарын доторхи бүх газар нутгийг эзэн хааны мэдлийн (улсын өмч) гэж үзэж байсан бололтой. Газар шороо, уул ус, нутаг бэлчээр, өвс ургамалаа хайрлан дээдлэж, зөв зохистой ашиглахыг их хаанд “дээрээс” хүлээлгэсэн тэнгэрийн захиас гэж үзнэ. Ийм учраас хуулийн заалтууд нь шашин суртахууны, зан заншлын хэв шинжийг ихээр агуулдаг. Мөн “газар нутаг”, “ус бэлчээр” гэсэн ойлголт нь түүн дээр оршин ахуй айл хунар, ургамал ногоо, нуур ус, ан амьтантайгаа үргэлж “нэг цул, цуг явж ирсэн” нь нүүдэлч амьдралын онцлогтой холбоотой.

- Халхын үйсэн дээр бичсэн цааз эрхэмжийн бичиг (1600) -т мод хатгасан газар мэдэж байж бууваас гурван ест буй, эс мэдэж бууваас нэгэн морь ав; гэсэн нь тухайн үедээ газар бэлчээр эзэмших ашиглах харилцааны өвөрмөц нэг зохицуулалт байв.

Энд анхаарууштай зүйл ажиглагдсан. Эрх дархтай хөрөнгө чинээтэй нь эхэлж очоод “хожим (нүүж) буух газартаа мод хатгаж тэмдэг тавьдаг” байж. Зэлүүд газарт хаана хэн “гадас шаасныг” тэр бүр мэдэх бололцоогүй. Гэтэл, шав тавьсныг мэдэлгүйгээр ирээд буусан ч гэсэн уг айл шийтгэлээс мултарч чадахааргүй тийм хуультай байж. Эрхэм дээдэстэн эхэлж буудаг суудаг, эрх мэдэлгүй нь “шав тавьсан эсэхийг асууж мэдсэн байхыг албадсан шинжтэй”, хүнийг нийгмийн байдалаар нь эрэмбэлсэн нэгийг нөгөөгөөс нь хараат байлгахад чиглэсэн тийм зохицуулалт юм.

- Манжийн үед (1691–1911) монголыг Улиастайн жанжны газраас захирч, ингэхдээ монгол түмэн “Манж чин улсын бүгд хууль, Халх журам, Гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг (Монгол цаазын бичиг)” –ийг дагаж байв.

Манжийн хаанаас “шинэ дагасан халх нарыг тэдний хууль ёсоор болтугай” хэмээн зарлиг буулгаж байсан нь тэдний “захиран засах арга ухаан” уян хатан байсныг харуулна. Манжууд монголчуудын бэлчээрийг хамгаалах, ялангуяа түймрийн эсрэг тэмцэхдээ хэрэглэж байсан уламжлалт хууль ёсыг говийн умард (Шар мөрнөөс хойшхи нутаг) –д 300 шахам жилд төдийлэн хөндөөгүй юм.

- Гурван хушууны их цааз буюу “Халх журам” (1709) -д газар эзэмшил, бэлчээр хамгаалах, газар нутгийг онголон дархлах тухай хэм хэмжээг тогтоожээ. Бусдын өвсийг мэдэж байж малд идүүлэн сүйтгэх тарианд мал оруулж сүйтгэл тарихыг хориглох, түймэр шатваас зартай заргүй ирж унтраах тухай заажээ. 1700 -аад оны эхээр манжийн цэрэг монголд ихээр байршиж, цэргийн хэрэглээний зориулалтаар ялангуяа сэлэнгэ тийшээ тариа ногоо тарих ажил [нэг хэсэг] эрчимжсэн байдаг.
 - Энд, [эрт дээр үед] өвсийг хэн нэгний өмч гэж үзсэн нь ил байна. Харьцуулах үүднээс хожмын жишээ татвал, Монгол Улсын хязгаарын доторх ой мод газрыг захирах дүрэм (1925) –ийн нэгдүгээр зүйлд, харъяат хязгаарын доторх ой мод цөм “улсын хөрөнгө” болно гэж заасан. Тэр үед “төрийн өмч” гэсэн ойлгоц хэлц байгаагүй, харин “улс нийтийн хөрөнгө” гэж ярьдаг байлаа. Сонирхолтой нь, энэхүү Газрыг захирах дүрэмд өвсийг байтугай “газрыг улсын хөрөнгө” гэж заагаагүй байна.
 - Монгол Улсын Үндсэн хууль (1992) –ийн 6.1. –т “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэснээс үзвэл өвс ургамал өнөөдөр манайд төрийн өмч гэхээсээ илүү төрийн хамгаалалтанд байдаг “нийтийн өмч” гэж харагдахаар байгаа. Гэвч, төрийн өөрийн өмч, төрийн нийтийн өмч гэсэн ухагдахуун хууль тогтоомжид бий.

Энд хамгаалах гэж юуг хэлэх, мөн хэнээс хамгаалах гэх зэргээр асуудлыг нарийсган ярих боломжтой. Хамгаалж байгаа нэрээр өмчлөөд байж болох эсэхийн тухай асуулт ч гарч ирж байна. Хамгаалах процесс иргэдийн зохист хэрэглээг боогдуулахгүй байх учиртай болов уу.
 - Газрын тухай хуулиар “иргэдэд өмчлүүлснээс бусад бүх газар төрийн өмч” юм. Мөн тэнд “газар” гэж газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхаргыг гэснээс үзвэл монголын төр өнөөдөр өвсийг хүртэл өмчилжээ. Үндсэн хуульд үүнийг арай өөр агуулгаар дурдсан байдаг. Ой бол ой байдаг, харин ургамал бол товчдоо өвс юм.
- “Монгол цаазын бичиг” (1795) -ээр газар ба бэлчээрийн асуудлыг зохицуулахдаа тогтоосон засаг захиргааны нэгжийн хуваарийг зөрчих, мөн өөрийн харьяалагдах засаг захиргааны нэгжийн хилээс дур мэдэн гадагш гарч нутаглахыг шууд хориглож байв.

Цааз бичгийн агуулгаас тухайн үед газар, бэлчээр түүнийг эзэмших хамгаалахтай холбогдсон зөрчил маргаан түгээмэл байсныг харагддаг. Газар бэлчээр эзэмших журам зөрчсөн этгээдэд хүлээлгэж байсан хариуцлага хэлбэрийн хувьд [нилээн] хүнд шийтгэлд орохоор байна. 50 адуугаар торгох, харцыг боол болгон хувиргах ял нь бусад төрлийн гэмт хэрэгт ногдуулснаас эрэмбэ дээгүүр хүнд шийтгэл юм.
- [XIX зуун, XX зууны эх] хүртэлх үеийн манжийн төрийн бодлого монголчуудыг уламжлалт аж төрөх байдлаар нь байлгаж, хэрэгтэй цагт ашиглах, түшиг тулгуур болгох, холбоотон байлгах зорилго бүхий байжээ. Хожим Чин гүрний засгийн бодлого нь аажмаар хятадын бодлого болон

хувирч Халхын хүрээний газарт монголын нийгмийн байдал хүндэрсэн байдаг. Хятадууд монголчуудын малын бэлчээрийн зарим хэсгийг хурааж, [бас] худалдан авч, дотор газраас газаргүй олон ядуу иргэнийг авчирч ар газар суулган тэдний амьдралыг өөд татахыг эрмэлзэв. Хятад шинэ засгийн хахир бодлого монгол газар ийн хэрэгжсэнээр монгол түмэн зовлон гамшиг амсаж, өрөнд баригдаж, улмаар тусгаар тогтнолынхоо төлөө босч тэмцсээр төр улсаа дахин сэргээж (1911) байсан түүхтэй.

Энэ мэдээнд газрыг хураасан, худалдан авсан тухай гарч байна. Энэ нь Халхын хүрээний газарт тэр үед газар [хэдийгээр нийтлэг биш ч гэсэн] эдийн засгийн эргэлтэнд жинхэнэ утгаараа орж, тодорхой тохиолдолд өмч болж, өмчлөгдөж байсныг илтгэнэ. Богд хаант Монгол Улсын үед газрыг худалддаггүй түрээсэлдэг байсан. Газрыг албан ёсоор зохих гэрээний дагуу түрээслэж хэрэглэсэн иргэн, гадаадын харъяатууд цөөнгүй байжээ. Дашрамд тэмдэглэхэд, хятад хүнийг монгол хүнээс ялгамжлахын тулд “иргэн” гэдэг байв. “Иргэн” гэдэг нь Дундад иргэн улсын харъяат гэсэн утга бүхий болов уу.

Түүх уламжлал түшиж яривал, нүүдэлч монголчуудын хувьд “газар” ба “бэлчээр” нь олон зууны туршид ойлголтынхоо хувьд бараг ялгамжгүй нэг зүйл байсан гэж хэлж болохуйц байдаг ч Монгол Улсад газар өмчилж ирсэн түүх, түүхэн уламжлал огт байхгүй, байгаагүй гэж яг таг хэлэхэл бас эрт, тодруулах зүйлс байдаг.

- Богд хаант Монгол Улсын үед (1911) одоогийнхоор бол, хөдөө аж ахуйн газрын улсын нэгдсэн тооллого явагдаж, газар тариаланд тохиромжтой 512400 га. газар байгааг тогтоон, Түшээт ханы Хараа, Засагт ханы Буянт (Ховдын) зэргэмжийн газарт «сангийн тариа» –ны улсын [сангийн] аж ахуй байгуулж, аймгуудын ноёдод тариаланг хөгжүүлэх зарлиг хүргүүлсэн байдаг ч, орон нутагт уг зарлигийг төдийлэн хайхралгүй харин ч бүр тариалангийн талбайг улам багасган, үүнийгээ малын бэлчээрийг хамгаалах нэрээр зөвтгөн тайлбарлаж байв. Улмаар Богдын засгийн газар 1919 онд “аяндаа нурсан” хэрэгжээгүй энэ шийдвэрээ арга буюу цуцалжээ.

Барон жанжинд газар олгосон нь

Шашныг мандуулагч, амьтныг жаргуулагч, умар зүгийн аврал итгэл, хамгийг айлдагч, оройн дээд чандмань, очир дара ийн хувилгаан, нарангэрэлт түмэннаст, номын богд лам, шашин төрийг хослон баригч Жибзундамба хутагт хааны зарлиг (1921.02.21) –т “Орос жанжин генерал Барон болбоос бидний Монголын өөрөө эзэрхэх засгийн газрыг дахин байгуулах хэрэгт тэргүүлэн чармайн зүтгэсэн гавъяа бүхий хүмүүн мөн. Түүний бие анх цэрэг авч ирснээс нааш хүйтэн жихүүнд халиралгүй, олон ардыг өчүүхэн төдий гаслаасан үгүй, эцэстэлээ зоригийг хатуужин явсаар халхын Хүрээний газрыг байлдан авч гавьяаг бүтээсэн ба шан хорыг тэгшлэн цэргийн цаазыг явуулсныг үзвээс үнэхээрийн тодорхой чанга хэмээвээс болмой. Тиймийн тул би бээр их сайшаан үзэж генерал Баронд үе улиран ханы

зэргэ, дархан хошой чин вангийн хэргэм, ногоон жууз, улбар шар хүрэм, шар жолоо, гурван нүдэт тогосын отго, Улсыг мандуулагч их баатар жанжин цол шагнав. Хойч өдөр үе улиран тасрал үгүй залгамжлуулагтун. Иймийн тул шар торгоны өргөмжлөлд эрдэнэ дарж олгов. Олноо өргөгдсөний Арван нэгдүгээр он” гэсэн нь бий.

Дахин сэргэсэн орчин цагийн шинэ Монгол Улсыг туурга тусгаар үлдэхэд хүндтэй гавъяа байгуулсан, Богд хаант Монгол Улсын зарлигаар тохоогдсон Батлан хамгаалахын сайд, европын язгууртан, германы барон, оросын генерал, Азийн морин дивизийн ерөнхий командлагч, хүн төрөлхтний түүхийн нэгэн их хөлөг баатар Унгерн фон Штернбергт монголын хойд хил тушаа Зэлтэрийн гацаа орчимд 40 десятин үр тарианы талбай, 50 верст эдлэнгийн зориулалттай суурьшлын газрыг олгосон [нэмж шагнасан] мэдээ байдаг.

Газар, бэлчээрийг эзэмших, ашиглах талаар нутаг ус, өвөлжөө бууцаа миний, чиний хэмээн булаалдах зарга маргаан үе дамжин маш ихээр гарч байсан бөгөөд түүнийг харьяат хушуу ноёд ихэвчлэн түүгээрээ шийдэн зохицуулдаг байжээ.

Дашрамд тэмдэглэхэд, ус бэлчээр арвин, ургац гарцыг тэгш дүүрэн байлгах гэж монголчууд “тэнгэр тайх эртний ёс” –ыг уулан дээр “тэнгэртээн илүү ойртож байгаад” үйлддэг байж. Уул овоог биш уулын тэнгэрийг тахина. Сурвалжид, “уулын тэнгэрийг тайх” гэдгээрээ тэмдэглэгдсэн нь бий. Харин, уул усыг онголон дархлах нь тахилга сүлднээс өөр, жинхэнэ бэлчээр ус нөөцлөх - аривтгах чиглэлийн “бодит ажил” байсан гэж үзмээр юм уу.

- Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичгийн XII дэвтэр (1918) -т, “гадаадын хүнд газар түрээслэх” заалт бий. Тэнд, “гадаадын хүн газар түрээслэх болбол гадаад яамнаас уг газар харштай харшгүйг нутгийн захиргаанаас байцааж, үнэхээр харшгүй тогтоогдвол ёсоор болгоно, энэ хэрэгт зориудаар гадаадын хүнийг элсээж болохгүй, зөрчвөөс харц хүнийг 100 ташуур занч, байцаахыг алдсан засгуудын хагас жилийн пүнлүүг хас” гэсэн байдаг.
- 1921 он. Энэ үеийн ардын засгийн бодлогын нэг хэсэг нь газрын харилцааны эрхзүйн зохицуулалтыг өөрчлөхөд чиглэж байв. Үүнд холбогдох гол баримт бичиг нь 1921.5.21 -ний өдрийн Түр засгийн газрын XIX хурлын тогтоол юм. Энэ тогтоолд,

Монгол Улсын бүх газар шороог үүнээс хойш гадаад дотоодын хүн нар миний хэмээн түрэмгийлэн эзлэхийг үүрд зогсоовой; хэмээсэн.

Энэ нь, газрыг улсын өмч, ард нийтийн хүртээл болохыг анх удаа хуульчилсан улс төр, нийгэм, эдийн засаг, хууль зүйн ач холбогдолтой, тухайлсан заалтынхаа хувьд, эдүгээчилбэл, үндсэн хуулийн шинжтэй чухал баримт бичиг байсан юм.

- Анхдугаар конституц (1924) -д “БНМАУ -ын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус, тэдгээрийн баялгууд нь ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно”, “Газар эдлэх нийтийн дүрмийг батлах, аймаг, хушуудын нутгийн хил хязгаарыг байгуулах, дэлхийн баялгийг ашиглах дүрэм заавар тогтоох” -ыг Улсын дээд эрхийг хадгалах газрууд эрхлэн шийтгэвэл зохимой” хэмээжээ.
- Үндсэн хуулийн [дээрх] заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас олон шийдвэр гарсны нэг нь “Газар бэлчээрийг эдлэх тухай” 227 дугаар тогтоол (1926) юм. Тогтоолд “ард олны дотор бие биесийг нутаг бэлчээр, өвөлжөө бууц зэргээр гачигдуулан хохироож, маргаан будлиан үүсгэн, илүү нутаг эзэрхэх явдал гарч байгааг зогсоох, гагцхүү олон онд нутаглаж, хүн мал идээшсэн, хөрөнгө малын олон цөөний байдалд тохируулан аль бололцоод бууц бэлчээрийг нутгийн эрх баригчдаас зүй зохисоор заан олгуулж байх” -ыг заажээ.

Ардын засгийн жилүүдэд ч тэр өнөө цагт ч тэр монгол газарт монгол малчид өвөлжөө бууц нутаг бэлчээрээ булаалдаж нэг нь нөгөөгөөс илүүг эзэмшихээр тэмцэлдсээр ирсэн нь дам харагдаж байна.

Бэлчээрээр нь бүдүүлгээр оролдвол монголчууд хэзээнээсээ босдог тэмцдэг байсан төлөв ажиглагддаг. Дээхнэ үедээ ч тийм байж, одоо ч тийм байх боломжтой. Жишээ нь, Өвөрмонголд, өнөө цагийн монгол малчид бэлчээрээ тойруулж хашч эзэмшдэг. 2010.5.10 –нд Шилийн гол аймгийн Баруун үзэмчин хошууны малчин эзэмшсэн бэлчээртээ автомашин оруулахгүй гэж эсэргүүцтэл тэндэхийн нүүрсний уурхайн жолооч дайрч амь насыг нь хөнөөжээ. Хохирогч хэсэг нөхдийн хамт бэлчээрээ хамгаалан нүүрсний тээврийн замыг хаасан байдаг.

Хэрэг явдал нутгийн монгол иргэдийн дургүйцлийг хүргэснээр өвөрмонголын олон газар эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөв. Оюутан голцуу олон мянган хүн оролцсон жагсаалыг цагдаагийн хүчээр дарж, 90 гаруй жагсагчийг баривчлан, 40 гаран хүнийг барьж хорьсон талаар Dailynews мэдээлж байсан.

БНХАУ –ын Засгийн газар олон нийтийн эсэргүүцлийг анхаарч хүн дайрсан хятад жолоочид цаазын ял, түүний сэлгээ жолоочид бүх насаар нь хорих ял оноож, хохирогчийн ар гэрт нөхөн олговороор 560000 юань (86000 ам. долл.) өгсөн ба ус бэлчээрээ хамгаалан тэмцсэн монголчуудын шаардлагад “дураараан загнаж байгаа нүүрсний компаниудад хатуу арга хэмжээ арга хэмжээ авна” гэсэн тайтгаруулсан хариу мэдэгджээ.

- БНМАУ –ын Засгийн тогтоолоор “Монголчууд тус улсын хязгаарын дотор нутаг бэлчээрийг эдлэх түр дүрэм” (1928) -ийг баталж, олон ардууд эрх биш өөр өөрийн нутгийн хязгаар дотор нутаглавал зохих, шалтгаангүйгээр бусад хушууны нутагт нүүдэллэн орохыг хязгаарлах, хэрэв хил тодорхойгүй бол түүнийг шинэчлэн тогтоох, ган зуд тохиолдох үед өөр өөрсдийн захиргааны байгууллагаар уламжлан урдаас зөвшөөрүүлж байх” -ыг тогтоожээ.

- 1935.8.25 –нд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлөөс “Бэлчээр усыг эдлэх дүрэм” –ийг баталж, тэнд, тус улсын харьяат нар, улсын ба хоршоо аж үйлдвэр, олон нийтийн байгууллагууд бэлчээр усыг үнэ төлбөргүй, хугацаагүй эдлэх бөгөөд гадаадын харьяат нарт түрээсээр эдлүүлэхээр болсон. Газрын харилцааг зохицуулахад тэр үеийн “Газар шороог хэрхэн эдлэх тухай дүрэм”, “Хадлан хадах, тариалан ногоо тарих тухай хууль” чухал үүрэг гүйцэтгэжээ.
- Газар эдэлбэрийн тухай хууль (1942)-иар нэгдэл ба хоршоо, үйлдвэр зэрэг улсын байгууллагад газар шороог бэлчээр өвс, хадлан тариаланд ямар ч үнэ төлбөргүй, хугацаагүй ашиглуулахаар болсон.
- БНМАУ-ын [1960 оны] Үндсэн хуульд газрын асуудлаар өмнөхөөсөө ялгаатай “хөдөө аж ахуйн газрын газрыг [эзэмшигчид нь] үнэ төлбөргүй, байнга эдлүүлнэ” гэсэн заалт нэмж оруулсан.
- [1971 онд] “БНМАУ-ын газар эдэлбэрийн хууль” гарч, түүгээр газрын харилцааг тусгайлан зохицуулсан, газрын санд улсын нөөцийн газар гэсэн шинэ ангилал бий болсон. Энэ хуульд газар эзэмшигчид, тэдний эрх, үүрэг, газар олгох, авах журам, газрын бүртгэл, тоо бүртгэл, хяналт, газар зохион байгуулалт, газрын маргааныг шийдвэрлэх талаар тодорхой заасан байв.

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд хөдөө аж ахуйн үлгэрчилсэн дүрэм (1974) батлагдсан. Гүн социализмын үед бэлчээрийн бэрхшээл харьцангуй бага, улсын хэмжээнд нийт малын тоо толгой 25 саяаас хэтрээгүй, газар бэлчээрийн байдал өнөөгийнхөөс сайн нөхцөлтэй байсны дээр улс төрийн тогтолцооныхоо онцлогоо дагаад “газрыг өмчлөх өмчлүүлэх тухай ойлголт” нийгэмд зохих ёсоор бүрдээгүй, энэ байдал тогтвортой үргэлжилсээр 1990-ээд онтой золгожээ.

Хүснэгт⁸³

Он	1911-1923 он	1924-1940 он	1941-1960 он	1961-1991 он	1992 оноос
Үндсэн хуулийн онцлог	Хуулийн утгал үе	Феодал ангийг устгах	Хувийн өмчийг устгах	Социализмыг байгуулах	Иргэний нийгэмд шилжих
Хууль, дүрмийн нэр	Тариалангийн газар түрээслэх дүрэм	Газар бэлчээрийг эдлэх, Уурхайн дүрэм	БНМАУ-ын Газар эдэлбэрийн хууль	БНМАУ-ын Газар эдэлбэрийн хууль	Газрын тухай хууль
Товч нэр, баталсан огноо	Дүрэм, 1913 он	Дүрэм, 1923.08.30;	Хууль-1, 1942.02.06	Хууль-2, 1971.11.30	Хууль-3, 1994.11.11; Хууль-4, 2002.06.07
Газрын тухай хуулийн онцлог	Тариалангийн газар	Тариалан, бэлчээр, уурхай эрхлэх	Газар ашиглагч субъектийн ангилал	Газрын нэгдмэл сан, объектын ангилал	Газрын нэгдмэл сан, объектын ангилал
Газрын эдийн засаг	дурдаагүй	дурдаагүй	Газар ашиглагчийн төрлөөс хамаарсан рент	Газрыг үнэгүй, хугацаагүй ашиглах	Газар өмчлөх; эзэмших, ашиглах

⁸³Эх сурвалж: Г.Жаргал (Ph.D), Д.Солонго (Ph.D), М.Уянга нарын “Газар: Баялагаас өмч үүсгэх арга (Газрын эрх зүй)”, УБ, 2014, хуудас 3.

Газрыг өмчлөх сэтгэхүйн хандлага	Ардын хөрөнгө	Нийтийн хөрөнгө	Улсын хөрөнгө	Ард түмний хөрөнгө	<ul style="list-style-type: none"> ▪ Төрийн өмч ▪ Хувийн өмч
-------------------------------------	------------------	--------------------	------------------	-----------------------	--

Газрын харилцааны хууль тогтоомжийн хөгжлийн эволюц (сүүлийн ~100 жилд)

Эртний монголчууд төр ёсоо дээдэлж, засаг хуулийг биелүүлж, “малдаа захирагдаж, малаа дагаж [эцсийн дүндээ] ямагт ялж дийлж явсан бахархалт түүхтэй. Нүүдэлчин малчин монголчуудын аж төрөх арга ухааны анхдагч арга сэдэл сүргийн бэлчээр, суух буух нутаг эзэмшлийн хүрээгээр тодорхойлогддог байсан нь дээрх хроно-тоймоос ерөнхийдөө ил байна.

Тал нутгийн эсгий туургатны улс гэрээ засч ирсэн “эзэнт бодлого” –ын нэг гол чиглэл нь газраа, малаа, хүнээ яг таг хуваагаад авчихдаг, тэрийгээ угсаа залгамжлан [хадгалах], захирах, цааз дэг тогтоох явдалд оршиж байжээ. Засаг ноёдууд газар нутгаа “өөрсдийн мэдэлд” хуваагаад авчихдаг болохоор харъяа нутаг бэлчээртээ, мэдээж хэрэг, эзэн сэтгэлээр хандана.

Эрт үед улсын хил хүрээ нааш цааш “хөдөлдөг”, газрын эн их, хүн зон цөөн, нүүдэлчдийн аж байдал байгалиас шууд хараат байсан учраас эзэн мэдсэн гэх газраа өвөг дээдэс маань өнөөгийн сонгодог утгаар нь “өмчилж бардаггүй” тэгж чаддаггүй байв. Тиймээс, монголын эртний түүхэн болон хууль цаазын сурвалж бичгүүдэд, газрын холбогдолтой заалтууд нь ерөнхийдөө “заншлын хэм хэмжээ” –г нэг их хол давж гараагүй гэж үздэг.

Газар бэлчээрийн асуудлыг заншлын эрхзүйн хүрээнд зохицуулж, хүний ёс жудагт их төлөв даатган, харьцангуй чөлөөтэй, олон зууны туршид ерөнхийдөө “сул зоргоор” явж явуулж ирсэн уламжлалт сэтгэлгээний хуучин арга өнөөгийн нийгэм – эдийн засгийн харилцаанд улам бүр таарахгүй болсоор байгаа ч урьдын инерцээрээ тэссээр оршсоор байна. Үүнд нөлөөлдөг хөндлөнгийн хүчин зүйл олон байна.

Судлаач мэргэжилтнүүдийн, монголд, газрыг албан ёсоор өмчилж эхэлсэн энэ цаг үеийг хүртэл газар нутаг ус бэлчээр монголд өмчлөлийн зүйл болж байгаагүй, харин, бэлчээрийг эзэмших, хамгаалах эрхийн харилцаа сүрхий мөрдөгдөж ирсэн гэж үздэгийн зарим талаар эргэлзээтэй дүгнэлт гэж үзнэ. Монголын түүхэнд газрыг улсын хаан (Чингэс хаан, Богд хаан) мэддэг хуваарилдаг бэлэглэдэг байсан мэдээ цөөнгүй.

Эртний монголчуудын хувьд бэлчээрийг эзэмших ашиглах өмчлөх нь олон талаар хэзээнээсээ нэг утгатай зүйл байсан, нүүдэлчдийн газар бэлчээрийн харилцааны түүхэн уламжлал ерөнхийдөө ийм юм. Одоогоос зуу (100) -хан жилийн өмнө бид “газар эзэмших” гэж ярьдаггүй “газар эдлэх” гэдэг, “газрыг эзэмших – ашиглах” гэдэггүй “газар түрээслэх” гэдэг байжээ.

3) Монгол Улсад газар өмчлөх, эзэмших, ашиглах харилцааг эрхзүйн талаас нь зохицуулсан өнөөгийн байдал

Газрын харилцааны, түүн доторх газар хувьчлал, газар өмчлөлийн асуудал олон хуулиар зохицуулагддаг. 1990 –ээд оноос үеэс газрын харилцааны шинэтгэлийн олон асуудал эрх зүйн хүрээндээ шийдэгдэж холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдсан. 1992 оны Үндсэн хуульд газрын харилцааны баримтлах үндсэн зарчим туссаны дагуу Газрын тухай (1994), Газрын төлбөрийн тухай (1997), Геодези, зураг зүйн тухай (1997), Кадастрын зураглал ба кадастрын тухай (1999), Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай (2000), Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай (2002), Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн тухай (2003) хуулиуд батлагдан хэрэгжиж байна.

Эрүү, иргэн, засаг захиргааны холбогдолтой хуулиудаар ч газрын харилцааны асуудал дамаар мөн зохицуулагдаж явдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд газрын асуудалтай шууд ба дам холбогдох заалтууд олон. Тэдгээрээс дурдвал,

- Монгол Улсад газар, газрын болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна;
- Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар ... төрийн өмч мөн;
- Мал сүрэг үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно;

Газрыг ашиглах тухай заалт Монгол Улсын Үндсэн хуульд байхгүй. Тэнд, газрыг хамгаална, өмчлүүлнэ, эзэмшүүлнэ гэсэн. Иргэн хүн газрын эзэмшиж байгаа бол ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах эрх нь нээлттэй байх ёстой гэсэн асуудал хөндөгдөх болов. Газрыг эзэмшиж ашиглаж байгаа тохиолдолд түүнийг эдийн засгийн эргэлтэд [жинхэнэ утгаар] оруулах боломж хомс гэж үздэг.

Бэлчээрийг өмчлүүлж болохгүй; гэсэн Үндсэн хуулийн заалт социализмын үеийн нэгдлийн дарга нар зонхилсон хурлаас гарсан шийдвэр юм. Тухайн цаг үеийн засаг захиргааны нэгжийн удирдагч нар бол “мал–малчин–бэлчээр хадлан” –гийн асуудал дээр “салбарын гаршууд мэргэжилтнүүд” байсныг тэмдэглэхгүй байхын аргагүй. Тэд (тэр баг) туршлагаараа, зөнгөөрөө “бэлчээрийг өмчлүүлж болохгүй” гэдгийг “мэдсэн” бололтой байдаг. Уг нь, бэлчээр бол газар мөн, газрыг бол өмчилж болдог, тиймээс бэлчээрийг ч өмчилж болох учиртайсан. Гэтэл тэгээгүй, тэгүүлээгүй. Яагаад тэд энд итгэл төгс “үгүй” гэж хэлж чадав. Ихээхэн бодууштай, “тэднийг сонсох” газар бол энэ юм. Конституцийн агуулгын энэ хэсэгт логикийн зөрчил байна уу, бэлчээрийг газар гэж үзэх үү, газар биш гэж үзэх үү гэдэгт хариу эрэх шаардлага үүсч байна.

Тухайн үеийн шийдвэр гаргагч нар тэрхэн үедээ нэг зүйлийн урьчилан сайн төсөөлөөгүй шиг байдаг. Улс орны хөгжил дэвшил урт хугацааны үйл явц. Үйлдвэржилт, уурхайжилт өндөр эрчимтэйгээр өсөн нэмэгдэх тусам хөдөө аж ахуйн, ялангуяа мал аж ахуйн салбараас олж байгаа орлого [улсын хэмжээндээ] үйлдвэрлэл эрхэлснээс олдож байгаа ашгаас хавьгүй доогуур болж ирнэ, буурна. Ийм байхад хүмүүсийн (залуусын) мал дагах сонирхол үргэж багасах чигт тэмүүлэх бөгөөд тэгсээр ч ирсэн зүй тогтолтой. Ийм “уналттай” үзүүлэлтийг шаардлагатай гэж үзвэл улсаас бодлогоор дэмждэг. Улам бүр хагас нүүдэлчин, хагас суурин суугч болж өөрчлөгдсөөр байгаа [өнөөгийн] малч түмний малаа дагах сонирхлыг элдэв аргаар хөхиүлэн дэмжих, тэдний гарт “бэлчээрийг нь хүртэл зоригтой өгөх” санал санаачлага эндээс эхэлж үүсдэг, гардаг. АИХ –ын депутатууд асуудлыг тухайн тохиолдолдоо зөв, ерөнхий тохиолдолдоо зөв бус өнцгөөс харсан байх бололцоотой.

Монгол Улсын Газрын тухай хуульд, газрыг эзэмших, өмчлөх, ашиглах гэсэн харилцааны гурван хэлбэр туссан. Өмчлөх нь мэдээж Үндсэн хуулинд заасны дагуу Монгол Улсын газрыг Монголын төр, мөн, Монгол Улсын иргэн өмчилнө. Өмчлөх эрхтэй өөр субъект үгүй. Газрыг эзэмшиж болно. Хэнд ямар зориулалтаар эзэмшүүлэх нь тодорхой, гадаадын иргэнд газар эзэмшүүлэхгүй, харин газрыг ашиглуулна. Газрыг гадаадын иргэнд ашиглуулах нь аль ч улсад байдаг зүйл. [А. Бакей]

Газрын тухай хууль дурдсанаар,

- “газар өмчлөх” гэдэг нь тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг; (Энэ нь газрын эзэн өөрөө газраа хэрхэн ашиглах вэ гэдэг нь түүний үзэмжийн асуудал гэсэн утгатай)
- “газар эзэмших” гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг; (Гэрээний хугацаа дууссаны дараа эзэмших эрх нь хүчин төгөлдөр бус болно. Энэ нь түрээслэх хэлбэртэй ойролцоо арга юм)
- “газар ашиглах” гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг хэлнэ. (Үүнийг ч мөн түрээслэх хэлбэр талаас нь харж болно)

Амьдрал баян, бүхнийг хуульчлан зохицуулах гэж оролдох тэмүүлэх тоолонгоор түүнтэй холбоотой шинэ шинэ нөхцөл “дахин” үүсч дараа дараагийн эрх зүйн зохицуулалтыг “нэхэх” хүлээх хэрэг гардаг.

Буяны ажил хариуцсан компаниудын оршуулгын цогц үйлчилгээний нэрлэсэн багцын үнэд “газрын өөрийх үнэ” шингэсэн байдаг. Газар зохион байгуулах зөвшөөрөл авсан, “буяны төрлийн” үйлчилгээ үзүүлэх эрхтэй компаниуд, одогсодыг нутаглуулах алга дарам газрыг талийгаачийн ар гэрийнхэнд нь өндөр үнээр, хэрэг дээрээ “зарчихдаг” –аас болж иргэд үнийн дарамтад арга буюу өртдөг, гэвч ёс заншлаа бодож хэнд ч гомдоллодоггүй тухай мэдээ их.

Энэ нь газрыг зохион байгуулах, эзэмших, ашиглах, өмчлөхийн хоорондын ялгаа заримдаа ихээхэн бүдэг, зохих ёсоор тодорч өгдөггүйн жишээ юм. Газар ашиглах эрхийг хэн нэгэнд худалдах, ашиглаж байгаа газраа хэсэгчлэн “худалдахын” хооронд мэдэгдэхүйц том ялгаа энд илрээд гараад ирж байна. Газар “ашиглах эрхийг худалдаж болохгүй” гэсэн хязгаарлалт энэ тохиолдолд газрыг “худалдахад” саад болоогүй мэт. Тиймээс, газрын харилцааны эрх зүйн зохицуулалтын нэр томъёоны асуудалд онцгой анхаарах шаардлагатай гэж үзнэ.

Газрыг өмчилж болох төдийгүй, тэгэх зайлшгүй гэдэг нь эдүгээ нэгэнт тодорхой болж, хууль дүрэм нь гарч улам бүр боловсронгуй болсоор байна. Газрын харилцааны түүхэн тойм зэргээс үзвэл, газрыг монголд түрээслэж байсан туршлагатай. Богд хаант Монгол Улсын үеийн “Өвс хадах, мал адгуулах газрыг гадаадын харъяат нарт түрээслэх дүрэм (1913), [гадаад дотоодын харъяат нарт] Тариалангийн газар түрээслэх дүрэм (1913) нь, өнөөгийн хэлээр бол, тус тусдаа бие даасан “Монгол Улсын нэр бүхий хуулиуд” юм. “Газар түрээслэх” уламжлалт энэхүү “хуулийн хэллэг” –ийн илэрхийлэмж дотор, өнөөгийн маргаан дагуулдаг “газар ашиглах”, “газар эзэмших” ойлголтууд цөм багтжээ.

Газрын эзэн өмчилсөн газраа худалдаад олсон мөнгийг банкинд хадгалуулан, улмаар түүний “хүү”гээс ашиг олно гэж сэтгэв. Хадгаламжийн хүүгээс олох “түүний ирээдүйн орлого” нь уг газрын ренттэй жишихүйц байг. Энэ тохиолдолд газрын эзэн өмчилсөн газраа бусдад зарах борлуулах боломжтой бөгөөд түүний “газраасаа салах” сонирхлыг ойлгож болно. Газрын үнэ бол капиталчлагдсан рент мөн. [К. Маркс] Газрын түрээсийн (монополь, абсолют, дифференциал .. гэх мэт) олон хэлбэр төрөл бий.

Эх орныхоо уудам дэлгэр нутгийн зах хязгаарын дотор, алс хэтдээ өмчлөх боломж бүхий “улсын тусгай хэрэгцээнийхээс бусад” –т, амьдрах зориулалтаар, “стандарт хэмжээтэй газар олж” буусан айл өрх (иргэн) –д уг газрыг нь төрөөс өгөх өмчлүүлэхийн төлөө байх учиртай. Төрийн зүгээс улсын бүх газрыг “өөрийн хэмээн сэтгэх” (өмчлөх), эсхүл бүх

газрыг жишээ нь бэлчээр байлгах гэж үзэх арга хандлагатай байж болохгүй. Монгол Улсын Үндсэн хууль ёсоор, улсын хязгаарын доторх газар нь ард түмний (нийтийн) мэдэлд байдаг (өмч) юм.

4) Үндсэн хуульд «... Газрыг ... Монгол Улсын иргэнд газар өмчлүүлж болно» гэсний тайлбарт холбогдох нэмэлт өгүүлэмж

“Газрын харилцааны холбогдолтой хуулиудад Монгол Улсын иргэний газар өмчлөх эрхийг зохих ёсоор хамгаалаагүй нь Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг зөрчиж байна” гэсэн утгатай маргааныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1995 онд хянан хэлэлцсэн, улмаар дүгнэлт гаргасан байдаг. Үндсэн хуулийн цэцийн 1995.3.09 –ний өдрийн 03 тоот дүгнэлтийг сөхөж харъя. Энд, Үндсэн хуулийн цэцийн [эцсийн] дүгнэлтийг гэхээсээ илүү, мэтгэлцэгч талуудын гаргасан аргууд сонируул татахуйц байсныг тэмдэглэж байна.

- Монгол Улсын иргэн [хүсвэл] газар өмчлөх эрхтэй. Газрыг “зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлнэ” гэсэн нөхцөлт хязгаарлалтыг хангахын тулд [наад зах нь] газрын аливаа хөдөлгөөнийг төрөөс бүртгэн хянах хэрэгцээ шаардлага үүсдэг. Энэ нь газар төрийн хамгаалалтанд байна гэсэн заалттай уялдаж байдаг. Мөн, Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт байгаа «Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар ... төрийн өмч мөн» гэсэн заалтаар “давхар өмчлөл” гэсэн хууль зүйн талаасаа утгагүй зүйл тусгаагүй. Улсын Их Хурал бол хууль тогтоох дээд байгууллага болохынхоо хувьд газар өмчлөх эрхийг устгасан хууль гаргах эрхтэй боловч үүнийгээ эрх зүйн соёлтой хийх үүрэгтэй. Үүний тулд Үндсэн хуулинд иргэний өмчийн эрхэнд халдана гэсэн утга бүхий өөрчлөлт оруулахаас эхлэх ёстой. [нэг талаас Д. Ламжав]
- Үндсэн хуульд «Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно» гэснийг хууль зүйн талаас нь зөв ойлгох явдал чухал. Иргэн Д.Ламжав дээрх заалтыг тайлбарлахдаа иргэнд газар өмчлүүлэхийг [Үндсэн хуульд] хоёрдмол санаагүй шийдвэрлэсэн гэснийг зөвшөөрөх боломжгүй. Үндсэн хуульд «... газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлнэ» гээгүй. Харин «... өмчлүүлж болно» гэсэн. Энэ хоёр үг утга агуулгаараа ялгаатай. Өмчлүүлж болно гэдэг нь энд агуулгаараа өмчлүүлж болохыг ч, мөн өмчлүүлэхгүй ч байж болохыг хэлж байна. [нөгөө талаас С. Нямзагд, Ц. Шаравдорж]

Иргэний хуулийн хэлэлцүүлгийн үед 1994.11.21 -ний хуралдаан дээр, газрыг “Үндсэн хуулинд төр иргэн хоёрт хоёуланд нь өмчлүүлнэ гэсэн. Газрыг “дан ганц төр өмчилнэ” гэсэн санааг Иргэний хуульд оруулбал “Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн хэрэг болно, улмаар тэр заалт [хожим, ҮХЦ дээр] унана; гэсэн [Ж. Бямбадорж] байдаг.

5) Газар төрийн өмч үү, улсын өмч үү .. бүр ард түмний өмч үү?!

Захиалагчийн зүгээс, газрыг өмчлөх эзэмших ашиглах асуудлыг судлаачийн бодомжийн үүднээс лавшруулж авч үзэх, газар нь төрийн өмч ба улсын өмчийн алин болох, газрыг улс өмчилж, төр ба иргэн хоёр эрх тэгш эзэмшигч байхуйцаар эрх зүйн талаас нь зохицуулах боломж бий эсэхэд анхаарахыг мөн хүссэн. Тавигдсан асуулт ярвигтайг тэмдэглэхийн сацуу түүнд тойруугаар, “эсрэг талаас нь, өөр зүйл ярих замаар” харах хариулахыг эрмэлзэв.

а) Бэлгэдэл булаацалдах боломж

Монголын төр хуульчлагдсан хуульчлагдаагүй олон бэлгэдэлтэй. Монголын төр сүлдтэй, тамгатай, далбаатай, дуулалтай, хүндэтгэлийн өргөөтэй, хан хууртай, соёмботой, тугтай, бас баахан өмчтэй. Төрийн туг дотроо 9 задарна, батлан хамгаалахынхан байсхийгээд баахан хар цагаан сүлд цэнгүүлнэ. Анхдугаар Үндсэн хуульд, төрийн далбааг “туг далбаа” гэсэн хоршоо үгээр нэрийдэж байж. Өнөөдөр, туг нь тусдаа, далбаа нь бас тусдаа болж “хөгжин” салжээ. Энэ бүхэн ард олны төрөө дээдлэх уламжлалт сэтгэлгээ урьдын адил хүчтэй хэвээр байгааг, түүнийг нь шүүрч төр өөртөө “хэт ашигласаар” яваагийн илрэл юм.

Монголчуудын бэлгэдэл дээдлэх зан үйл тухайн үеийн бурангуй заншилтайгаа нэгдэн хавсарч хүчээ авсаар, сүүлдээ “хүнээр туг тахиx” хэмжээнд хүртлээ гажуудсан гунигт түүхтэй. Ихэнхи уламжлалыг санаатайгаар болон санамсаргүйгээр гэж явах нь өлзийтэй бөгөөд ингэх нь нийгмийн хөгжлийг нөхцөлдүүлэхэд дэм болдог. Уламжлалаа гээхгүй улам бүр шинэ шатанд гаргаж “хөгжүүлсээр” байвал, сүүлдээ, дээд газраас дэглэн найруулдаг “жүжгийн” тоо хэт олширох боломжтой. Өмч, газар, банк, архив, хэл .. гээд, бүх юм өмнөө “төрийн” гэсэн тодотголтой болсоор байна. Уг нь, саяхан болтол бид улсын банк, улсын хөрөнгө, нийгмийн өмч гэж ярьдаг байлаа.

Д. Нацагдорж “амьд явбал улсын наадам үзнэ” гэсэн. Эдүгээ нийтээрээ төрийн наадам (үндэсний баяр) гэх хандлагатай болов. “Нандигнан хайрлах нийгмийн өмчийг алхам тутамдаа нүдлэн хамгаалж хир буртаг өчүүхэн ч хүргэлгүй цэвэр ариун байлгах ёстой” гэж уншиж цээжилж бичиж дуулж явсан түрүү үеийнхэнд халх аялгуут монгол хэл ярианы өөрчлөлтийг харьцуулан жишиг боломж дурсамж элбэг бий. Үсэг бичиг өөрчлөгдөөгүй ч энэ хооронд хэл яриа “хөгжсөн” байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ л эргэлзэх, эргэж харах зүйл байна.

Товчдоо, бүхнийг төрийн нэртэй яаж ийгээд холбоод авах гэсэн үзэл хандлага эдүгээ нийгэмд нэоэнхүйдээ хавтгайрчээ. Зохимжгүй чиглэл рүү зоргоор тэмүүлэх энэ мэт явдлыг төрийн зүгээс журамлаж зохицуулдаггүй юм аа гэхэд “ташуур өгч” хөгжөөмөөргүй байна. Ингээд байдгийн нэг учир нь шалтгаан нь “албаны [модон] хэл, албан бичгийн гэх хэл, хуулийн хэлний зарим онцлогт оршиж байна.

Төрийн хэл гэх нь эргэлзээтэй хэллэг юм. Төр бас тусдаа хэлтэй “байх” хэрэг үү?! Бид төрийг “хүнчилж” ойлгоод байна. [Энэ тухай хойно тусгай дэд гарчигт тусад нь өгүүлнэ]. Харин, улсын албан ёсны хэл гэвэл өөр хэрэг. Европын холбооны албан ёсны хэл гэж байна, европын холбооны төрийн хэл гэж үгүй. Нэр томьёо, нэр тодотголын талаасаа байдал нэг иймэрхүү. Бүх “юмыг” төрийн нэртэй холбоод авах сонирхол засагдахааргүй гүнзгийрч “нийгмийн үзэгдлийн” хэмжээний гажуудал болжээ.

Газар төрийн өмч үү, улс нийтийн өмч үү?! гэсэн захиалагчийн лавласан асуултад эрх зүйн болон улс төрийн гүн сэтгэлгээний “том” хариулт эрэхээсээ өмнө, ухагдахууныг нэршлийн талаас нь бяцхан шинжье. Ингэхдээ, энэ зорилгод нийцэх “төстэй бэлэн өгүүлэмж” –ийг сонгов. УИХ –ын Тамгын газрын Судалгааны санд байгаа “төрийн далбаа ба улсын далбааны ялгаа” –ны талаарх лавлагаа “төрийн өмч”, “нийтийн өмч” ухагдахууны тодотголын тайлбарт хамаарч бүрнээ болохоор байна.

1945 оноос өмнө монголчууд бид төрийн далбаагаа “улсын далбаа” гэж нэрлэдэг байв. 1940 оны Үндсэн хуулийн 106 дугаар зүйлд “улсын далбаа” гэсэн нь бий. 1945 оны 7 дугаар сарын 10 -ны өдөр [Х. Чойбалсан нарын] хуралдсан Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 43 дугаар хурлаар “БНМАУ -ын төрийн далбааны маяг, найрууллын тухай” тусгайлан хэлэлцээд улсын далбааг төрийн далбаа болгожээ. (Болгох ч гэж дээ, зүгээр л тэгж нэрлээд бичээд явчихсан гэвэл үнэнд илүү дөхөм. Тэрнээс биш “улсынхаа далбааг цаашдаа төрийн далбаа гэе” гэсэн тухайлсан тусдаа шийдвэр хаанаас ч гараагүй)

Хэт гүрнээс улстөр-эдийн засгийн хараат явж ирсэн бидний улс, орчуулгын хэлний нөлөөнд арга буюу орж, түүнээс улбаалсан олон зовлонг одоо ч эдэлсээр байна. “Государственная граница” –ыг “улсын хил” гэж орчуулдаг атлаа “государственный флаг” -ыг болохоор “төрийн далбаа” гэж хэлж бичиж, хуульчилж баталгаажуулах ямар хэрэг байв? Бид чинь улсынхаа далбааг төрийн далбаа гэж “андуураад” байгаа юм биш байгаа! гэдэг дээр бодох ёстой. “Государственная библиотека” гэвэл нийтийн номын сан, улсын номын сан, “государственные праздники” гэвэл “улс-нийтийн баяр” болоод явчихдаг. Эрдэмтэн Я. Цэвэлийн “Монгол хэлний тайлбар толь”-д “төрийн далбаа” –ны ард, хашилтанд, улсын далбаа гэсэн байна.

Тэгэхээр, хэргийн хамаг учир орчуулгын хэлэнд оршиж байна. “Государство, государственный” гэх үг монголоороо “улс”, “нийтийн..”, “ард нийтийн..”, “нийгмийн..”, “төр”, “төр-улс”, “засаг-төр” гэхчилэнгийн олон салаа утгатай. Ямар үгтэй хоршихоосоо хамаарч, заримдаа “улс”-аар, заримдаа “төр”-өөр нь явах хэрэг гарна. Эдүгээ ихэнхи тохиолдолд “государство [бол] төр” гэсэн хөшүүн хадмал ганц хувилбарлуу хэлбийжээ.

Төрийн далбааг Үндэсний далбаа гэсэн ч болно. “Төрийн далбаа”, “улсын далбаа” -н дээр нэмэгдээд “Үндэсний далбаа” гэсэн 3 дахь хэллэг үүсээд гараад ирэхээр зэрэг ердийн ухамсрын түвшинд хүмүүс хавтгайдаа будилаад эхэлдэг. Энэ бүхнээс сэргийлсэн ч байж магадгүй, польшид жишээ нь, улсынхаа далбааг төр нь авч хэрэглэх тохиолдолд, дээр нь [хэн хэрэглэж байгаагаа илтгэх] тусгай таних тэмдэг тавьдаг.

Улсынхаа наадмаар, улсынхаа далбааг хацар дээрээ зуруулчихаад (ийм үйлчилгээ дэлгэрсэн) баяр бахархалаар гэрэлтэн гийж, инээж баясан итгэл төгс алхаж яваа хүүхэд залуусаа харахад хичнээн гоё байх вэ! Улсынхаа наадмаар улсынхаа далбаагаар гоёх эрхийг нь хууль зарлигаар “булааж” авч болохгүй. Төрийн далбаа бол төрийн [л] далбаа болохоороо төрд тодорхой хэмжээгээр өмчлөгдөнө.

Төрийн далбааг үйлдэх, мандуулах, байрлуулах, дүрслэх, дурсгах, хэрэглэхтэй холбогдсон харилцааг Төрийн бэлгэ тэмдгийн хуулиар зохицуулсан. Төрийн бэлгэ тэмдгийн тухай Монгол Улсын хуульд Төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэх эрх чөлөөг хангасан заалт бий нь бий. Гэхдээ л, тухайн хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдсон тэр хэсэгт, “хяналтыг .. цагдаагийн байгууллага хэрэгжүүлнэ” гэсэн заалттай. Хариуцлага шийтгэл нь ч тодорхой. Энэ нь төр өөрийнхөө өвөрмөц өмчийг хамгаалж байгаа хэрэг.

Улсын далбааг төр шүүрч өмчилснөөс үүдсэн бяцхан мөртөө ноцтой хэрэг явдлын талаар утгачилан өгүүлье. ОХУ –ын Нижегород мужийн прокурор төрөлх хотыхоо төвөөс “улсынхаа далбааг буруу цагт өлгөсөн” зөрчил олныг илрүүлж, улмаар, хотын мэр –ийг хуулийн заалтаар айлган “дарамталжээ”. Цаад зөрчил нь “баярын өдрөөр мандуулах ёстой далбааг баярын бус өдөр төв гудамжинд зүүсэн” –ээс цаашгүй ялихгүй зүйл байв.

Сонин болгоноор шуугисан их маргаанаас үзвэл, хотын дарга Вадим Булавинов “халуун эх оронч, зоригтой эр” тул прокурорт бууж өгөлгүй тэсч, бүр шийтгүүлэлгүй зүгээр өнгөрчээ. Өмнө нь ийм асуудлаар Калининград, Казань хотын удирдлагууд, Белгород мужийн хэсэг бизнесмэн .. олон хүн торгуулж, хуулийн өмнө арга буюу “гараа өргөж” байлаа. Харин, хотын мэр яагаад зүгээр өнгөрөв, түүнд [хэн] туслав?! Урьд нь ийм төсөөтэй хэргээр 5 сарын цалингийн хэмжээний торгууль хүлээсэн сувиллын газрын нэр хүндтэй захирлыг хотын оршин суугчид хотлоороо нэгдэн өмөөрч, айл болгон тагтан дээрээ улсынхаа далбааг зэрэг зэрэг мандуулав. Болдоггүй хуультайг нь мэдсээр байж тэгэхээс тэгж хууль зөрчсөн” инээдэмтэй төдийгүй эмгэнэлтэй энэ сургамж прокурорын хатуу байр суурийг жаахан ч гэсэн зөөлрүүлсэн байх гэж нэгэн сурвалжлагч “Флаги долой!” (Далбаа сөнөтүгэй!) өгүүлэлдээ бичсэн байв. Гарсан зөрчил маргааны уг чанар нь, “төр иргэн 2 улсынхаа далбааг булаацалдсан” –д оршиж байна.

b) Газар булаацалдах боломж

Үүн лүгээ адил, манай тохиолдолд, төр иргэн хоёр “төрийн нийтийн өмчийн” талбарт өөр өөрийн эрх ашгийг хамгаалан элдвээр маргах боломжтой гэж үзнэ. Тиймээс, “газрыг улс өмчилж, төр ба иргэн эзэмшиж байх” –уйц эрх зүйн зохицуулалт боломжтой юу гэсэн захиалагчийн асуултад “тийм” гэж хариулах үндэс бүхий байна.

“Улсын бүх газрыг өмчлөх” төрийн “сонирхол” газрын шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд саад болж байгаа ба монголын төр энэ эрхээсээ татгалзах боломжтой төдийгүй шаардлагатай талаар “Сайн” газрын харилцаа, эдийн засгийн хөгжилд түүний гүйцэтгэх үүрэг” сэдэвт Олон улсын Бага хурал (2007) дээр яригдсан болно.

Газрын тухай хуулийн 5.1. –д “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад [бүх] газар төрийн өмч мөн” гэсэн. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас үзвэл “нийтийн хэрэгцээний газар” хүртэл төрийн өмч “болж” таардаг. Монголд “хэн нэгний өмч биш газар” үлдэх боломжгүй болчихож байна.

Үндсэн хууль ёсоор, монгол газар ард түмний мэдэлд байх ёстой, ард түмний мэдэлд байгаа газрыг төр хамгаалах үүрэгтэй. Газрын тухай хуульд байгаа “газар өмчлөх” ухагдахууныг харвал, “газрыг хэн мэдэлдээ байлгана, тэр түүний өмчилдөг” гэсэн санаа ил. Үндсэн хуульд заасанаар бол “газар ард түмний мэдэлд байдаг. Энэ нь “монголын бүх газрыг өмчлөгч нь төр биш, харин, газрыг өөрийн мэдэлдээ байлгадаг (үндсэн хуульд ингэж заасан) “монголын ард түмэн” мөн гэж хэлсэн мэт.

“Ард түмэн” ба “төр” гэсэн ухагдахуунуудыг тайлбарлах хэрэгцээ шаардлага эндээс ийн арга буюу урган гарч ирж байна. Захиалагчийн зүгээс ч эдгээр нэр томьёог тус тус тайлбарлахыг хүссэн байв.

с) Ард түмэн гэж хэн бэ?

Дэлхийн бараг бүх улсын конституц “... ард түмэн бид ...” гэж эхэлдэг нь түүнийг “бодитой оршигч субъект мөн” гэдгийг зэрэг зэрэг нотолж байгаа хэрэг юм. Үндсэн хууль бүхэн ийн хэлж байхад маргах хүн ховор биз. Гэтэл, тоталитар дэглэмт хуарангийн (соц.) нийгмийн нэрт лидер ард түмнийг хоосон цаастай адилтган үгүйсгэсэн гэлцэх.

Олон улсын харилцаанд оролцогч субъектын хоорондын харилцааг зохицуулах хууль зүйн зарчим хэм хэмжээний системийг олон улсын эрх зүй, олон улсын эрх зүйн харилцаанд оролцож эрх эдлэж үүрэг хүлээж буй этгээдийг олон [нийтийн] эрх зүйн субъект гэнэ. Бүрэн эрхт улс, ард түмэн, тусгаар тогтнож хараахан чадаагүй байгаа түүний төлөө тэмцэж байгаа [өөрийгөө зарласан] улс үндэстэн олон улсын нийтийн эрх зүйн субъектэд тооцогддог.

Үндсэн хуулийн бус замаар бий болсон Засгийн газрыг тухайн ард түмэн хүлээн зөвшөөрсөн бол түүнийг олон улсад хүлээн зөвшөөрөх тухай асуудал яригддаг зэргээс үзвэл аливаа ард түмэн нь яах аргагүй эрх зүйн субъект мөн нь тодорч байна. Засгийн эрх ард түнээс үүсэлтэй, засаг төрийн дээр ард түмэн байдаг учраас ингэдэг.

Энд зарим тохиолдолд “үндсэн хуулийг үл тоох” үзэл санаа цухалзаж, конституциас дээгүүр эрэмбийн зүйл яригдаж байгааг уншигч анзаарсан байх. Ер нь эрх зүйн аливаа асуудлыг үндсэн хуульд нийцүүлж ярих судлах гэж эрмэлзэх нь өөрөө буруу хандлага гэж үзнэ. Байх ёстой юмыг байх ёстой тэр өнцгөөс нь харах ярих учиртай. Газар ард түмний мэдэлд байна гэж Монгол Улсын Үндсэн хууль заасан. Иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч гэж Үндсэн хууль “хэлснийг” мөн тэмдэглэх нь зөв болов уу.

“Ард түмэн” –ийг ард түмэн байлгах чигт чухал чухал шийдвэрүүдийг дэлхийн улс орнууд гаргасаар ирсэн жишээ жишиг олон бий. Зарим улсад “ард түмэн хууль санаачлах эрхтэй” байдаг. Энэ тохиолдолд, мөн ард нийтийн санал асуулгын практиктаас чухам хичнээн хүнийг ард түмэн гэж үзэх вэ гэсэн асуултын хариу дам байдлаар тодрох боломжтой. Энэ хэмжээс хүн амын тоотой уялддаг учраас орон гүрэн болгонд харилцан ялгаатай.

d) Төр гэж юу вэ?!

Төрийн онол, төрийн тусгай онолын ном сурах бичиг хангалттай их бөгөөд энэ талын мэдлэгийг их дээд сургуульд тусгай предмет болгон судалдаг. Улс орныг удирдан зохион байгуулах, газар нутгаа бусдаас хамгаалах, нийгмийн дэг журмыг сахиулах, нийгмийн баялгийг бий болгох, бий болгосныгоо хуваарилах, нийгмийн ерөнхий зорилтыг хэрэгжүүлэх, улс орны тэнцвэрт байдлыг хадаглах зэрэг олон асуудлыг “засаглахгүйгээр хэрэгжүүлэх” боломжгүй. Энэ зорилгоор Засгийн газрыг байгуулна. Засгийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг тогтолцоо нь төр юм. Төрийг “төр” гэж нэрлэх, өөрөөр нэрлэхээс үл хамааран засаглах тогтолцоо оршин байдаг. Монголын ард түмэн бараг XX зууныг дуустал “нам-засаг” гэсэн нэр бүхий төртэй явж иржээ гэх мэт. Харин засаглах арга хэлбэрийн тухай асуудал тусдаа зүйл.


Төр бол засаглах тогтолцоо, засаглах үйл явц юм. Үүний хэрэгжүүлэх процессийг ерөнхийд нь “улстөр” гэж хялбаршуулан нэрлэнэ. Улстөр (police, политика) бол ард түмэн, иргэд, сонирхлын бүлгүүдийн шийдвэр гаргах үйл явц мөн гэсэн үзэл санаа түгээмэл. Эндээс, төр өөрөө “өмчийн эзэн байх” чадамжийн хэр хэмжээ ямар нэг байдлаар тодорч харагдах болов уу. Төр газрыг өмчилж чадах ч ашиглах эзэмших тал дээр “газрын эзэн иргэн”-ээс илүү бүтээлч байж чадах эсэх нь тун эргэлзээтэй.

Канадын нэрт эрдэмтэн Дэвид Истон (David Easton, 1917 - 2014) “Улстөр гэдэг нь засгийн эрх мэдлийг ашиглан нийгэм дэх үнэт зүйлсийг хуваарилан байршуулах үйл явц мөн” гэсэн бол “Хүнд угаас эрх мэдэл рүү тэмүүлэх төрөлхийн чанар оршин байдаг. Эд баялаг, нэр хүнд, эрх чөлөөтэй болж авах, улмаар аж амьдралаа сайжруулах арга хэрэгсэл түүнд хэрэгтэй. Тэр нь эрх мэдэл юм. Эрх мэдэлтэй байж улс төр хийнэ. Тиймээс улстөр бол «хэн, юуг, хэзээ, хэрхэн олж авч буйг илтгэх тэмцэл мөн» гэж улстөрийн шинжлэх ухааныг үндэслэгчийн нэг, америкийн политологч Г. Лассуэл (Harold Lasswell, 1902—1978) хэлжээ.

Аливаа засаглалын харилцаа, үйл ажиллагааны зөвхөн төрийн эрх мэдэлтэй холбогдох тэр хэсгийг улстөр гэж ойлгож болно.

6) Конституцид өөрчлөлт оруулахад “баримтлах зарчим” –ын зарим асуудал

Үндсэн хуулийн 6.1. –д “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэсэн. Аливаа хуулийг, бүр конституцийг ч амьдралд нийцүүлэн өөрчилдөг, үүнийг нийгмийн хөгжил өөрөө шаарддаг юм. Гэтэл, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хууль (2010) –ийн 5.2.2. –т “дурдсан заалтыг өөрчилж үл болно” гэжээ. Үүний үндэслэлийг тодруулна уу гэсэн асуултад дор байдлаар хариулья.



Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах журмын тухай хууль (2010) –ийн 5 дугаар зүйл “**Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны үндсэн зарчим**” гарчгийн дор “Үндсэн хуулийг дээдлэн сахих, түүний тогтвортой байдлыг хамгаалах, ард түмний бүрэн эрхт байдла, оролцоог хангах, бодитой байх, ил тод байх” зарчмыг дурдсан. Мөн тэнд эдгээр “зарчмыг хангах арга зам” –ыг ч заасан гэж оролджээ. Тухайлбал,

5.2. Улсын Их Хурал, хууль санаачлагч нь дээрх зарчмыг дор дурдсан үндсэн арга замаар хангана. Үүнд:

- 5.2.1. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд харшлахгүй байх;
- 5.2.2. Үндсэн хуулийн Нэг, Хоёр, Гурав, Дөрөвдүгээр зүйл, Тавдугаар зүйлийн 1-4 дэх хэсэг, Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аравдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван дөрөв, Арван тав, Арван ес, Хорьдугаар зүйл, Хорин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин нэг, Дөчин долдугаар зүйл, Дөчин есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Жаран найм, Жаран есдүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно; гэх мэт.

Баримтлах зарчмын тухайд нэмж хэлэхэд “... өөрчлөлт оруулах журмын тухай хууль” өөрөө конституцийн аливаа өөрчлөлтийг “дэмжсэн” агуулгатай байх учиртай. Зорилго нь өөрөө нэг юмыг өөчлөхөд оршиж байна. Гэтэл, конституцийн олон заалтыг “өөрчлүүлэхгүй” гээд байгаа нь зорилгоо “мартсан”, үндсэн хуулийн агуулгын өөрчлөлтийг дэмжих зарчимдаа харш үзэл санаа юм.

Үндсэн хуулийн 68, 69 дүгээр зүйлд “~~Үндсэн хуульд өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.~~ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно”, “Үндсэн хуулийн өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална” гэсэн “цоож” –оор үндсэн хууль “өөрөө өөрийгөө хамгаалсан” байдаг ч “заасан хаалгыг зохих ёсоор нээж орж ирээд намайг өөрчил, ямар ч өөрчлөлтийг хүлээж авахад бэлэн” гэдгээ дамаар илэрхийлжээ. Эндээс харвал Үндсэн хууль “тодорхой болзол” –тойгоор Үндсэн хуулийн өөрчлөлтийг өөрөө дэмжиж байдаг” нь, үгйдээ л тас хориглоогүй нь ил байна.

Гэтэл, Үндсэн хуулийн үзэл санаанд нийцсэн эсэх нь эргэлзээтэй, чухамдаа “энийг ч тэрийг ч өөрчилж болохгүй” гэсэн олон заалтыг дурдан, ингэснээрээ “нэмэлт шинэ цоож” –уудыг Журмын тухай хуульд “суулгасан” –ыг ойлгох тайлбарлахад бэрх байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 68, 69 дүгээр зүйлд заасан “конституцийн хамгаалалтын механизмын бат бөхийн зэрэг” –ийг үнэлж цэнэлгүйгээр, үндсэн биш “бусад” хуулиар конституцийг давхар цоожлох гэсэн эрмэлзэл өөрөө эргэлзээтэй алхам гэж үзнэ. Энд “давхар цоожилсон” гээгүй, “давхар цоожлохыг эрмэлзсэн” гэснийг анхаарна уу. Бусад хуульд суусан цоожоор конституцийн тогтвортой байдлыг хангана гэж сэтгэж болохгүй. Бусад хууль өөртөө “цоож” үгүй учраас тэдгээрийг өөрчлөх хэцүү биш. Тиймээс ... Журмын тухай хуулийг аюул авралын туйлширсан өнцгөөс харах шаардлагагүй гэж үзнэ.

Дашрамд тэмдэглэхэд “Үндсэн хуульд өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно” гэсэн заалтад яг юун тухай ярьж байгаа нь мэдэгддэггүй, үүнийг хүмүүс өөрийнхөөрөө ойлгож тайлбарласаар олон жил болов. Адаглаад энийг хүртэл Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулан тодруулах гэхээр ... Журмын тухай хууль хууль “саатуулагч хүчин зүйл болж үйлчлэхүйц болжээ. (“Монгол Улсад газар .. байгалийн баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэсэн заалтыг өөрчлөх, эс өөрчлөхөд холбогдох зарим аргументыг өмнөх дэд гарчгуудад авч үзсэн болно)

Конституцийн тодорхой заалтуудыг хэзээ ч хэн ч үл өөрчлөхөөр консервлох санаа өөрөө яав ч саруул ухаан байж чадахгүй бөгөөд Үндсэн хуулийн “өөрийх нь дотоод” асуудлыг үндсэнбус хуулиар зохицуулах нь “түр зуурын шинжтэй, найдваргүй төдийгүй [эцсийн дүндээ] бүтэшгүй” оролдлого юм. Конституцийн нэр бүхий заалтыг өөрчилж болохгүй гэж үйлдээрээ ч болов хэлнэ гэдэг хэрэг дээрээ Үндсэн хуульд гар хүрч болохгүй гэсэнтэй агаар нэг утгатай.

* * *

В) ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ ОНЦЛОГ

Гадаадын зарим оронд “газрыг улс өмчлөх болсны учир шалтгаан, түүний давуу ба сул тал, үр дүн үр дагавар

Ихэнх улс оронд газрыг хувьд өмчлөхийг зөвшөөрдөг байхад зарим улс орны хувьд зөвхөн төрийн өмчид байдаг байна. Газар нь төрийн өмчид байдаг улсуудаас Сингапур болон Хятадын газар өмчилж ирсэн түүх, газрыг улс өмчлөх болсны давуу тал, үр дүн, газар ашиглах хэлбэрийн талаар авч үзье.

• СИНГАПУР УЛС

Сингапур улс 1965 онд тусгаар тогтнолоо олж авсны дараа хөгжлийн хөтөлбөрүүдийг, ялангуяа хот дахин хөгжүүлэх болон үйлдвэржилтийн төслүүдийг хэрэгжүүлэхэд багахан газар нутагтай тус улсын хувьд газраар хангах нь тусламдсан асуудал байлаа⁸⁴.

Улмаар 1996 онд Газар худалдан авах тухай хууль гарснаар нийгмийн хөгжлийн төлөө улс нь газрын эздээс газрыг худалдан авч, өмчлөх эрхтэй болсон. Газар худалдан авах тухай хууль нь 1966 онд парламентаар батлагдсан бөгөөд дараа жилийн 7 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн. Энэ хуулинд газрыг улсын өмчид шилжүүлснээр газрын эзэнд төлөх нөхөн төлбөрийн хэмжээг мөн зохицуулсан байна.

Хожим, газрыг дамлан худалдахыг зогсоох болон газар худалдан авах үнийн хязгаарыг тогтоох зорилгоор 1973 онд хуулинд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Шинэчлэгдсэн хуулиар өмнө арай бага байсан нөхөн төлбөрийн хэмжээг зах зээлийн үнээр тогтоохоор болсон байна.

Газар худалдан авах тухай хууль гарснаар газрыг улс өмчлөх процесс илүү хурдацтай явагдах болсон. Үүний үр дүнд 1959-1984 онуудад Сингапурын Засгийн газар нийт газрын гуравны нэг буюу 43713 акр (17690 га, эсвэл 177 км²) газрыг өмчлөх болсон байна. Засгийн газар 1949 онд нийт газрын дөнгөж 31 хувийг өмчилдөг байсан бол 1985 онд ихэнхийг буюу 76.2 хувийг өмчлөх болов. Ийнхүү газрыг улс өмчлөх болсноор Сингапур дараах давуу байдлыг бий болгож, сайн үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- Орон сууцны болон аж үйлдвэрийн зориулалттай байшин барилгын үнийг тогтвортой байлгаж чадсан.
- Дэд бүтцийн төлөвлөлт, хотын хөгжлийг илүү сайн үр ашигтай хийх болсон.
- Газрыг зөв зохистой, үр ашигтай ашиглах маш сайн бодлого хэрэгжүүлдэг.
- Улс орныг хөгжүүлэх төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж, хурдацтай хөгжих боломж бүрдсэн.

⁸⁴<http://eresources.nlb.gov/history/events/>

Газрыг ашиглах эрх, газар ашиглалтыг зохицуулсан байдал

Сингапур нь олон жил английн колони байсан тул үл хөдлөх хөрөнгөтөй холбоотой хууль эрх зүйн актууд английн хуулиудад суурилсан. Бүх газар улсын өмч бөгөөд эзэмших, түрээслэх гэсэн 2 хэлбэрийн эрх байдаг⁸⁵.

Эзэмших эрх нь Засгийн газраас зөвшөөрөл олгосны дагуу газрыг хэсэгхэн хугацаанд хувьд эзэмшиж байгаа хэлбэр юм. Харин түрээслэх эрх нь газар эзэмших гол хэлбэр бөгөөд Засгийн газраас 99 хүртэл жилийн хугацаатай олгодог. Энэхүү хугацааг 1992 оны Улсын газрын тухай хуулинд тодорхойлсон байна⁸⁶. Сингапурт газар ашиглалтыг төлөвлөж зохицуулах үүрэг бүхий 3 төрийн агентлаг ажилладаг. Үүнд:

- Орон сууц болон хөгжлийн зөвлөл (Housing and Development Board);
- Дэд бүтцийг дахин хөгжүүлэх газар (Urban Redevelopment Authority);
- Журоны⁸⁷ корпораци (Jurong Town Corporation) орно.

Орон сууц болон хөгжлийн зөвлөл, Дэд бүтцийг дахин хөгжүүлэх газар нь бизнес арилжааны болон орон сууцны зориулалтаар өөрөөр хэлбэл, орон сууц, оффис, худалдаа үйлчилгээний байшин барилга барих газар түрээслүүлдэг. Оффис болон худалдаа үйлчилгээний зориулалтаар газар түрээслэхэд 3-5 жил байх ба хугацаа дуусахад шинээр эрх олгох замаар зохицуулдаг. Орон сууцны хувьд 1-3 жил байна. Харин Журоны корпораци нь аж үйлдвэрийн барилга байгууламж барих зориулалтаар газар түрээслэх асуудлыг хариуцдаг.

Газрыг улсын өмчид авсан явдал нь багахан хэмжээний газар нутагтай Сингапур шиг хот-улсын хувьд сайн үр дүнд хүргэсэн бөгөөд газрыг төрийн нэгдсэн бодлогоор зөв зохистой төлөвлөн зарцууж, улс орны хөгжилд чухал хувь нэмэр оруулсан юм.

• БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД УЛС

Хятад улсад газар өмчлөлийн байдал нийгмийн хөгжлийг дагаад янз бүрээр хөгжиж ирсэн.

Хаант засгийн үе⁸⁸

Газрыг тариалан тариалах болон газар доорх баялгийг ашиглах гэсэн 2 хэлбэрээр ашиглаж байлаа. Газар эзэмшигч нь улсад татвар төлдөг байсан бөгөөд эргээд тариаланчдад газраа түрээслэж түрээсийн төлбөр авдаг байв. Гэхдээ энэ үед газар хувийн өмч байв уу, үгүй юу гэдэг нь одоог хүртэл маргаантай байдаг байна.

Коммунист нийгэм⁸⁹

Энэ үед газар бүхэлдээ улсын өмч, эсвэл хамтралын өмч байсан бөгөөд газрын эздийг хувьсгалын эсэргүү, дайсан хэмээн үзэж байлаа. Коммунистууд газар эзэмшигчдээс газрыг нь хураан авч тариачдад хуваарилан өгөв. Гэвч удалгүй хятадын коммунист нам хамтралуудыг байгуулж эхэлсэн бөгөөд тариачид газар болон тариалангийнхаа ажлыг орхиод хамтралд элсэн орох болсноор газар хамтралын өмчид шилжсэн.

⁸⁵Land rights usage: Types of land tenure. www.realtor.org/intlprof.nsf/all/singapore

⁸⁶State Lands Act. <http://statutes.agc.gov.sg/aol/>;

⁸⁷Журон (Jurong) нь Сингапурын аж үйлдвэрийн бүс юм.

⁸⁸http://en.wikipedia.org/wiki/Chinese_property_law#Imperial_China

⁸⁹Мөн тэнд.

Дэн Сяопины үе⁹⁰

1982 онд хятадын Үндсэн хууль батлагдсан бөгөөд үүнд өмч болон өмчийн эрхийн талаарх суурь зарчмуудыг тусгасан. Үндсэн хуулинд “социалист нийтийн өмч”-ийн талаарх зохицуулалтуудыг тодорхойлсон бөгөөд улсын өмч болон хамтралын өмч гэсэн 2 хэлбэртэй байв.

Үндсэн хуулинд 2004 онд 4 дэх удаа нэмэлт өөрчлөлт оруулж, өмч, ялангуяа хувийн өмчтөй холбоотой зарим зохицуулалтыг хийсэн байна. Үүнд, Үндсэн хуулийн 13 дугаар зүйлд “Иргэдийн хууль ёсны хувийн өмч халдашгүй дархан байна. Улс нь иргэдийн хувийн өмчийн болон өв залгамжлах эрхийг хуулийн дагуу хамгаална. Шаардлагатай тохиолдолд нийгмийн хэрэгцээний улмаас хувийн өмчийн өмчлөх эрхийг хүчингүй болгох, мөн улсын өмчид шилжүүлж болох ба энэ тохиолдолд нөхөн төлбөр олгогдоно” хэмээн тодорхойлсон⁹¹.

Энэ нь хятадад өмч хөрөнгөтэй холбоотой хууль эрх зүйн орчин илүү боловсронгуй болсныг харуулж байна. Ялангуяа, 14 жил маргаантай байсны эцэст 2007 онд Өмчийн тухай хуулийг батлан гаргасан нь дэвшилтэд алхам байлаа.

Газар ашиглах эрх, газар ашиглалтыг зохицуулсан байдал

Хятадад өмчийн дараах 3 хэлбэрийн эрх байдаг⁹².

- өмчлөх эрх (ownership right);
- ашиглах эрх (usufructuary right);
- барьцаалах эрх(security right).

Өмчлөх эрх (ownership)

Үүнийг Өмчийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд тусгасан⁹³. Энэ нь өмчлөгчид газар болон үл хөдлөх хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, газрын давуу талыг ашиглаж ашиг олох эрхийг олгоно. Гэхдээ энэхүү эрхийг хуулийн дагуу хэрэгжүүлэх бөгөөд олон нийтийн эрх ашгийг зөрчиж болохгүй. Нийгмийн ёс суртахуун болон хэм хэмжээнд нийцүүлэх ёстой.

Хятадад газар нь улсын өмчид байдаг боловч хөдөө аж ахуйн зориулалттай газрыг ерөнхийдөө хөдөө аж ахуй эрхлэгчид, харин дэд бүтцийн зориулалттай газрыг зөвхөн улс өмчилдөг байна.

Ашиглах эрх (usufructuary)

Энэ нь бусдын өмчийг эзэмших, ашиглах, түүний давуу талыг ашиглаж ашиг олох боломж олгох юм. Өмчийн эзэн нь өмчийг ашиглагчид энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд хөдлөнгөөс оролцож болохгүй.

Ашиглах эрхийн хэд хэдэн төрөл байдаг. Үүнд:

- Газрыг гэрээгээр ашиглах. Энэ нь газрыг хөдөө аж ахуйн зорилгоор эзэмших, ашиглах, ашиг олох боломж олгоно. Энэхүү эрхийг бусдад шилжүүлэх боломжтой, харин хөдөө аж ахуйн бус зориулалтаар дүр мэдэн ашиглаж болохгүй.

⁹⁰Мөн тэнд.

⁹¹Constitution of the People's Republic of China. www.npc.gov.cn/englishnpc/Constitution/

⁹²http://en.wikipedia.org/wiki/Chinese_property_law#Imperial_China

⁹³Property Law of the People's Republic of China www.lawinfochina.com/

- Барилга байгууламж барих зориулалтаар ашиглах. Зөвхөн улсын өмчит газрыг энэ зориулалтаар ашиглах бөгөөд газрыг эзэмших, ашиглах, ашиг олох боломжтой юм. Энэхүү эрх нь эрх шилжүүлэх замаар олгогдож байгаа ч бусдад шилжүүлэх нь хязгаарлагдмал байна. Хэрэв газрыг өмчлөх эрх өөрчлөгдвөл түүн дээрх үл хөдлөх хөрөнгө буюу барилга байгууламжийг өмчлөх эрх мөн адил өөрчлөгдөх онцлогтой. Газрыг ашиглах эрх дуусгавар болонгуут газар болон түүн дээрх үл хөдлөх хөрөнгийн эрх автоматаар төрд шилждэг. Харин ашиглах хугацаа дуусахаас өмнө буцаан авах шаардлага гарвал нөхөн төлбөр олгогдоно.
- Орон сууц барих зориулалтаар ашиглах. Энэхүү эрхийг хамтран эзэмшиж, ашиглах замаар хэрэгжүүлнэ.
- Хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах. Энэ нь өөрийн өмчийн үр ашгийг хүртэхийн тулд бусдын өмчийг ашиглах эрх юм. Энэхүү эрхийг эдлэхэд гэрээний нөхцөлийг дагаж мөрддөг.

Барьцаалах эрх

Энэ нь моргейж, зээл болон барьцаа гэсэн хэлбэртэй байна.

Хятадад газрыг ашиглаж хэрэглэх хугацаа нь орон сууц, байшин барих зориулалтаар 70 жил; аж үйлдвэрийн зориулалтаар 50 жил; боловсрол, шинжлэх ухаан технологи, соёл урлаг, эрүүл мэнд, спортын зориулалтаар 50 жил; худалдаа арилжаа, аялал жуулчлал, амралт зугаалгын зориулалтаар 40 жил; бусад зориулалтаар 50 жил байна.

Үндсэн хуулинд 2004 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу улс иргэнээс газрыг нь авах тохиолдолд нөхөн төлбөр олгохоор тусгасан. Хуулиар дэвшилттэй алхам хийсэн хэдий ч хятадын Засгийн газар олон нийтийн эрх ашгийн төлөө гэх нэрийдлээр ямар ч хувийн өмчийг хураан авах эрхээ хадгалсан хэвээр байна. Ялангуяа, фермерүүдээс газрыг нь эргүүлэн авахад нөхөн төлбөрийн хэлбэр, хэмжээ зэргээс шалтгаалж Засгийн газар болон фермерүүдийн хооронд томоохон асуудал үүсдэг байна. Энэхүү асуудлыг шийдэхийн тулд 2011 онд хятадын Засгийн газар илүү сайн нөхөн төлбөрийн системийг нэвтрүүлэх журам гаргасан. Гэвч барууны шүүмжлэгчид илүү сайн, ил тод байдлыг хүлээж байгаа ч хятад шиг хэт их хүнд сурталтай оронд энэ нь ихээхэн бэрхшээлтэй байгаа юм.

Монгол Улсад газрыг өмчлөх, эзэмших, ашиглах гэсэн 3 хэлбэр байдаг бол Сингапурт эзэмших, түрээслэх гэсэн 2 хэлбэр байна. Харин хятадад өмчлөх, ашиглах, барьцаалах гэсэн хэлбэрүүд байдаг.

СОЦИАЛИЗМААС ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГТ ШИЛЖСЭН ОРНУУДЫН ГАЗАР ӨМЧЛӨЛ, ШИНЭТГЭЛИЙН ТАЛААРХ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

• БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

Казахстан нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан тул газрын харилцааны асуудал ЗХУ-ын хууль эрх зүйн хүрээнд зохицуулагддаг, хараат байдалтай байлаа. Энэхүү дэглэм задарч, Казахстан улс тусгаар тогтнолоо тунхагласны дараа газрын харилцаа бие даан хөгжиж эхэлсэн бөгөөд шинэ Үндсэн хууль болон зах зээлийн эдийн засгийн, өөрөөр хэлбэл, цоо шинэ нөхцөлд зохицон хөгжих болжээ. Ийнхүү газрын харилцаанд шинэтгэл хийх болсноор газар зөвхөн төрийн өмчид байхаа больж, эдэлбэр газрыг хувьд өмчлүүлэх, газрын зах зээл хөгжиж газар худалдах, худалдан авах зэрэг боломжийг бүрдүүлснээр газрын бодлого болон харилцааг хөгжүүлэх хууль эрх зүйн орчин улам боловсронгуй болсон.

Казахстаны газрын харилцаатай холбоотой хууль эрх зүйн актууд нь Үндсэн хуулийн зохицуулалтыг баримталдаг бөгөөд Үндсэн хуулинд газар болон түүний бүх нөөц баялаг төрийн өмчид байдаг боловч хуулийн хүрээнд хувийн өмчид байж болохыг зөвшөөрсөн байна⁹⁴.

Казахстаны тусгаар тогтнолын дараах газрын харилцааны хөгжлийг хэд хэдэн үе шатад хувааж үздэг⁹⁵. Үүнд:

- 1-р үе буюу 1991-1993 он. 1990 онд Казахстан улсын Дээд Зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу тухайн үеийн хууль эрх зүйн актуудад газрыг зөвхөн түрээслэх боломжтой бөгөөд худалдах, худалдан авах зэрэг бусад харилцааг хориглосон байна.
- 2-р үе буюу 1994-1995 он. 1994 онд Ерөнхийлөгч шийдвэр гаргаснаар газрын харилцаанд дэвшилтэд алхам хийгдсэн бөгөөд зах зээлийн хэлэлцээрийн журмаар газар ашиглах эрх нээлттэй болсон юм.
- 3-р үе буюу 1996-2000 он. 1995 онд Ерөнхийлөгчийн шийдвэрээр газрын хуулинд анх удаа газрыг хувьд өмчлөх тухай зохицуулалт оруулжээ. Хүн ам оршин суудаг бүсүүдэд эдэлбэр газрыг хувьд өмчлүүлэхээр болсон байна.
- 4-р үе. Парламентын 2 танхимаар 2 жилийн турш хэлэлцэгдсэний эцэст 2001 оны 1-р сарын 24-нд Газрын тухай хууль батлагдан гарснаар хууль эрх зүйн орчин илүү сайжирсан байна.
- 5-р үе. 2003 оны 6-р сарын 20-нд одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Газрын тухай хуулийг шинээр батлан гаргасан ба энд газрын харилцаанд чухал шаардлагатай зохицуулалтуудыг тусгасан нь дэвшилтэт алхам байлаа.

Шинэ хууль гарснаар өмнө нь зөвхөн төрийн өмч байсан хөдөө аж ахуйн зориулалттай газар болон ой, усны нөөц газрын зарим хэсгийг хувьд өмчлөх боломж бүрдсэн байна. Газрын харилцаанд хийгдсэн энэхүү шинэтгэл нь газрыг өмчлөх, ашиглах хууль эрх зүйн орчныг улам боловсронгуй болгож, илүү таатай боломжуудыг бий болгосон.

Газрын шинэтгэлийн үр дүнд бий болсон хамгийн дэвшилтэт алхам нь газрыг зөвхөн төр өмчилдөг хатуу дэглэм бүхий төрийн ноёрхлыг халж, газрын зарим хэсгийг хувьд өмчлүүлэх болсон явдал юм. Үүний үр дүнд газрыг төлбөртөйгөөр ашиглах, ялангуяа бүх хэлбэрийн аж ахуйн зориулалтаар ашиглах боломж бүрдсэн нь олон төрлийн аж ахуйн хэлбэр хөгжих сайхан боломжийг олгосон. Мөн газар болон үл хөдлөх хөрөнгийн зах зээл үүсч хөгжих таатай нөхцөл бүрдсэн юм.

Газар нь нэг талаар байгалийн бүтээгдэхүүн, нөгөө талаар өмчийн нэг хэлбэр болдгоороо өвөрмөц онцлогтой. Иймд газрыг ашиглахаас гадна түүнийг байгалийн баялаг болохынх нь хувьд хамгаалах асуудлыг хууль, журамд зайлшгүй тусгах шаардлагатай. Өнөө үед газрыг зөв зохистой ашиглах, газар болон түүний нөөц баялгийг хамгаалах нь эдийн засаг, нийгэм, байгаль-экологи гээд аль ч салбарын бодлогод чухал байр суурь эзэлдэг бөгөөд илүү их анхаарал хандуулах чухал асуудал болоод байна.

⁹⁴Конституция Республики Казахстан. Статья 6.3. <http://adilet.zan.kz/rus/>

⁹⁵<http://cyberleninka.ru/article/n/razvitie-zemelnyh-otnosheniy-v-respublike-kazahstan>

• РУМЫН УЛС

Газрыг өмчилж ирсэн түүх

Румын улсад удаан хугацааны турш тариачдын ихэнх нь язгууртан, газрын эздийн өмчлөлд байсан бөгөөд тэдний хяналтан доор газрыг ашиглан амьдарч байжээ. 19 дүгээр зуунд болсон газрын шинэтгэл нь хамжлагат ёсийг халж тариачдыг өөрсдийн газрын өмчлөгчид болгон шинэчлэх удаан хугацааны үйл явц байсан. Тухайн шинэтгэл нь зөвхөн хэсэгчилсэн байдлаар амжилтад хүрсэн бөгөөд харин эцсийн дүндээ тариачдыг ихээхэн өрөнд унагаж, өөрсдийн эзнээс хамааралтай болгосон байна.

Дэлхийн нэгдүгээр дайны дараа газрыг дээд ангийхнаас авч тариачдад дахин хуваарилан өгөх нь эдийн засгийг шинэчлэн дунд хэмжээний, гэр бүлийн фермүүдийг бий болгох зорилготойгоор коммунистууд газрын шинэчлэлийг хийсэн байна. Тариачдад нэг бол өөрсдийн газраа улсад тушаах эсвэл шинээр байгуулагдаж байсан хамтрал, сангийн аж ахуйд гишүүнээр орохыг тулгаж байсан нь удаан хугацаанд үргэлжилсэн, хүч хэрэглэсэн үйл ажиллагаа болсон байна.

Румын улсын уур амьсгал болон газар зүйн байрлал нь хөдөө аж ахуйн салбар хөгжихөд маш тохиромжтой бөгөөд үр тарианы үйлдвэрлэл нь Европын тариаланд томоохон байр суурийг эзэлж байсан байна. Социалист нийгмийн үед хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт ихээхэн хийгдсэн ч тухайн салбарыг аж үйлдвэржилтийн нөхцөлийг хангах, гадаадын өрийг төлөхөд ашиглаж байжээ. 1945 оноос хөдөө аж ахуй давамгайлсан эдийн засгаас хүн амын ихэнх нь хот суурин газарт амьдарч томоохон үйлдвэрт ажиллах болсон байна.

1980 оноос Чаушескугийн дэглэмийг түлхэн унагасан үеэс, 1990-1991 онд улс төрийн уур амьсгал ихээхэн тогтворгүй болж иргэд нь өмнө өмчилж байсан газартаа төр засгийн зөвшөөрлийг хүлээлгүйгээр өөрсдийн тариалангийн аж ахуйг эрхлэх болсноор газрыг дахин хуваарилах талаарх хууль гаргах шаардлагатай болсон байна.

Газрын шинэтгэлийн гол асуудал

Румын улсын Үндсэн хуулиар өмчийн эрхийн талаархи заалт нь зарим талаар тодотгогдож, шинэ өмчлөх эрхийг бий болгосон байна. Тухайн хуулинд 2013 оны 12 дугаар сарын 31 хүртэл “гадаадын иргэн хөдөө аж ахуйн газар худалдан авах эрхгүй” гэж заасан байна.⁹⁶

Румын улс 1949-1962 онуудад жил болгон газрыг улсын мэдэлд авсан нь үйлдвэрлэл хөдөө аж ахуйн хоршоо (SEC)-ны үндэс болсон байна. 1990 онд батлагдсан хөдөө аж ахуйн шинэчлэлийн хөтөлбөр нь газрыг хуваарилах, ашиглах давхарга бий болгох зорилготой байсан.

1991 онд батлагдсан “Газрын сангийн тухай хууль” нь газрыг дахин хуваарилах үндэс болсон. Энэ хуулийн хүрээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газар нутгийн 47 хувь буюу 4,3 нь (SEC)-д хамрагдсан байна. Газрын сангийн тухай хуульд газар эзэмших эрх бүхий хүнд: сүүлийн 5 жилд гэрээтэй ажиллаж байгаа иргэд болон уг газрын эзэмшиж байсан хүмүүсийн өв залгамжлагчид газар авах эрх үүссэн байна.⁹⁷

⁹⁶Dela roumanie 1991. www.cdep.ro

⁹⁷Газрын сангийн тухай хууль 1991. www.consultant.ru

Газрын шинэтгэлийн асуудлыг дараах байдлаар авч үзсэн байна. Үүнд:

- газар хуваарилалт
- газрын ашиглалтыг зохицуулах явцад үүссэн хөрөнгийн горимын талаар

Газар өмчлөлийн талаар 4 төрлийн нэхэмжлэл байна. Үүнд:

- өмнө эзэмшиж байсан газар дээр нь хамтрал, сангийн аж ахуй байгуулагдсан иргэд байна. Тэдгээр иргэд нь анх сангийн аж ахуйд нэгдэн орохдоо нийгэмчилсэн 1 хүртэлх гектар газрыг эргүүлэн шаардах эрхтэй байна.
- хамтрал, сангийн аж ахуйд ямар нэгэн хэмжээгээр газар нийлүүлээгүй боловч тухайн ферм, сангийн аж ахуйд 3 аас дээш жил ажилласан иргэд байна. Эдгээр иргэд нь хамгийн багаар 0.5 гектараас 10 гектар хүртэлх газрыг нэхэмжилж болно.
- өмнө нь хөдөө аж ахуйн газрыг эзэмшиж байсан, гэхдээ тухайн сангийн аж ахуй, фермийн хувьцаанаас оногдсон боловч ямар нэгэн шалтгааны улмаас газар аваагүй иргэд багтдаг. Эдгээр иргэд өөрсдийн газрыг 1945 оны шинэтгэлийн үед хууль бусаар хураалгасан эсвэл өөрийн газраа хүчээр нийгэмчилсэн байна.
- фермерийн аж ахуй эрхлэхээр шинээр газар нэхэмжлэх хүмүүс. Үүнд: шинээр фермерийн аж ахуй эрхлэхийг хүсэж байгаа залуу гэр бүлүүдэд өгөх боломжтой.

Газар өмчлөлийн онцлог

Социалист үйлдвэрлэлд хүмүүс өөрсдийн эзэмшлийн газарт ирж үйл ажиллагаа явуулах болсон ч ургацын даатгалын тогтолцоо байхгүйгээс газар эзэмших нь хүндрэл учирсан байна. Тус улсад газрын зах зээл харилцан адилгүй хөгжиж байгаагаас шалтгаалан иргэд газраа худалдахаас өмнө үнэ өсөхийг хүлээсэн байна. Зарим иргэд өөрсдийн газрыг гэр бүлийн түүхийн нэгэн хэсэг хэмээн үздэг бөгөөд газраа зарахыг хүсдэггүй зэрэг олон шалтгаанууд байдаг. Румынд гадаадын иргэд газар худалдан авах хоригын хугацаа дууссаны дараа энэ салбарт бизнес эрхлэснээр таатай орчин бүрдэж хөгжинө гэж эдийн засагчид үзсэн байна.

- Гэр бүлийн хэрэгцээнд 0,5 га газар олгогддог. Олгогдсон газраа 3 жилийн дотор ашиглаагүй тохиолдолд төр газрыг буцаан хурааж авдаг.
- 100 га хүртэлх газрыг эзэмшүүлэхээр өгч байсан.
- Хүлэмжийн тариалан эрхэлж байгаа газрыг бүрэн хувьчлаагүй байдаг. 1996 онд 2-3 жилийн дотор хувьчилж дуусгах зорилттой байсан ч төлөвлөсөн хугацаандаа бүрэн дуусаагүй.
- Хөдөө аж ахуйн газрыг (SEC) татан буулгахдаа тухайн төрийн мэдлийн газрыг (цэцэрлэг, зам гм) нийт хөдөө аж ахуйн газар нутгийн 28 хувь байсан.
- Тухайн хувьчилж байгаа газрын 30 хүртэл хувийн газрыг тухайн газарт ажиллаж байгаа хүмүүст өгсөн. Үлдсэн 70 хувийг дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсөн бөгөөд тухайн үед ажиллаж байсан хүмүүст үнийн саналаа хэлж худалдан авах эрхийг мөн өгсөн⁹⁸.

Румын улсын газрын шинэтгэлийн үр дүн

Энэхүү шинэтгэл нь газар ашиглах болон өмчлөх хууль зүйн шинэ бүтцийг бий болгох, түүгээр төр болон иргэний газрын харилцааг шинэчлэн тогтоож, хүмүүс өөрийн газраа эзэмших, захиран зарцуулах(хуваах, үйл ажиллагаа явуулах, үл хөдлөх хөрөнгө байгуулах, бусдад түрээслэх, өвлүүлэх г.м), ашиглах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэхийг зорьсон. Төр иргэнд газраа өмчлүүлээд, тухайн хөрөнгө эзэмшигчтэй харилцах эрх зүйн орчинг бүрдүүлэхэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, төрийн өөрийн үйл ажиллагааны

⁹⁸www.vasilievaa.narod.ru

хүрээг бий болгох, олон нийтийн эрх ашгийг хамгаалах үүрэг оролцоог тодорхой болж чадсан байна.

1991 оны шинэчлэлийн бодлогын эцсийн үр дүнд төр нь газрыг хувьчлахдаа өөрөө хөрөнгө болгон батлан дааж, газрын өмчлөлийн системээр дамжуулан газар эзэмшигчдэд өмчлөх эрхийг өгөх болсон.

Газрыг ингэж харилцан эрх үүсгэн өмчлүүлснээр санхүүгийн гүйлгээ, хөрөнгийн барьцаа болгон ашиглах боломжийг нээсэн байна. Энэхүү газар өмчлөлийн шинэтгэлийн явцыг Румын улсын газрын шинэчлэлийн туршлагыг ОХУ хөдөө аж ахуйн газрын шинэчлэл хийхдээ анхааран үзэж, шинэтгэл, газар өмчлөлийн эрх зүйн орчин бүрдүүлэх, хувьчлалыг хэрэгжүүлэхэд ашигласан байна. Иймээс Румын улсын газар өмчлөлийн үйл явц нь манай Монголын газар өмчлөлийн бодлогод хамаарах нь дамжиггүй юм. Харин энэхүү шинэтгэлийн 1991 оноос хойших 6 жилийн туршид хөдөө аж ахуйн салбарт маш их хямрал, уналтыг дагуулсан бөгөөд, төдий л бүрэн дүүрэн үр дүнд хүрээгүй гэдгийг анхаарна уу.

Үүний цаад нөхцөл нь ХАА -н зах зээлийн уналт явагдаж, эдийн засгийн алдагдал хүлээсэн байна. Яагаад алдагдал хүлээсэн хүчин зүйлсээс дурьдвал, газрыг ашигтай хэрэглэж чадаагүй, их хэмжээний тариалаагүй, орхигдсон газрууд бий болж, үүний хэрээр үндэсний бүтээгдэхүүний нийлүүлт буурч байсан байна. Хөдөө аж ахуйн шинэтгэлийг хийхийн тулд дэд бүтцийг бий болгох, төрөөс бодитой дэмжлэг зайлшгүй үзүүлэх хэрэгтэй. Газар өмчлөлд суурилсан хөдөө аж ахуй нь хууль эрх зүйн зохион байгуулалтын хэлбэр, удирдлагын болон үйл ажилагааны шинэлэг байдал, хангалттай зах зээлийг бий болгох нь чухал байсан.

• ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ОХУ -д газар өмчлөлийн хэлбэр нь улсын, орон нутгийн, хувийн болон нийтийн өмчийн гэсэн хэлбэрүүд байна. Дараах байгууллагын мэдэлд байна. Үүнд: Засгийн газрын эзэмшдэг, ОХУ-ын эрх бүхий байгууллагын мэдлийн, орон нутгийн засаг захиргааны мэдлийн эзэмшдэг, хувийн өмчийн газар байна.

1990 оны “Газрын шинэтгэлийн тухай” хуульд дараах байдлаар ангилсан байна. Үүнд:

- иргэдийн эзэмшлийн - туслах ба тариачны аж ахуй, жимс жимсгэний, мал аж ахуй, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар олгосон газар;
- өвлөн эзэмших, түрээслэх, газар ашиглалт
- Газар нэгдэл, сангийн аж ахуй болон хамтын цэцэрлэгжүүлэлт хамтын эзэмших төрийн бусад хөдөө аж ахуйн аж ахуйн нэгж, иргэдийн үндсэн дээр бий болгосон тэр дундаа хөдөө аж ахуйн хоршооллын бусад аж ахуйн нэгж, хувьцаат компани болон тариачдын санхүүг зохицуулах түүнээс гарах үед багийн гишүүн бүр газар хэлбэрээр өөрийн хувийг авах эрхтэй байсан.

2014 оны зургадугаар сард Төрийн Дум иргэн, газраа 5 -аас дээш жилээр эзэмшсэн гэр бүлд үнэ төлбөргүй газар өмчлүүлэх тухай хуулийг баталсан байна.⁹⁹

ОХУ -ын газрын шинэчлэл

1990 онд ОХУ-д эхэлсэн Газрын шинэтгэлээр газрын холимог (төрийн болон хувийн) харилцааг зохицуулах эдийн засгийн тогтолцоо бий болгох, тогтвортой ашиглах, газар нутгийг нь хамгаалах явдлыг хөхиүлэн дэмжих, бусад байгалийн нөөцийг ашиглах эрх

⁹⁹www.zakonrf.info

зүйн нөхцөлийг хангах, ялангуяа хөдөө аж ахуйн, төрийн газрын монополь эрхээс эзэмших татгалзсан хэдий ч газар хувьчлалын явц удаашралтай байжээ.

1990 оны дөрөвдүгээр сард ОАСДН-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн зарлигаар орон нутагт хөдөө аж ахуйн газрыг, түрээсээр ашиглах тухай газар ашиглалтын хэв журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

1990 оны сүүлээр, ОАСДН-ын Дээд Зөвлөл “Газрын шинэчлэл”-ийн хуульд “фермер байгуулах” хуулийг хэлэлцэн баталсан байна. «Тосгоны нийгмийн хөгжил», “Тариачин (фермер) эдийн засгийн тухай” акцад хамтын аж ахуй (аж ахуйн ажилтан) -ын гишүүн нь гишүүнээс татгалзвал газраа давуу эрхээр эзэмших, түрээслэх эрх олгосон байна..

ОХУ-д хувийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ашиглах газрыг дараах байдлаар өмчлөх эрх өгчээ. Энэ нь фермерүүд, цэцэрлэгч, хувийн аж ахуй, хувь хүний орон сууцны барилгыг 5-10 жилээр ашиглах хамтын хоршооллын хэлбэрийг зөвшөөрсөн байна.

- 1991 онд Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Нэгдэл, сангийн аж ахуй өөрчлөн байгуулах тухай» «ОАСДН-ын газрын шинэчлэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай» нэгдэл, улсын сангийн аж ахуй нь хувийн, хамтынхэлбэрт шилжих талаар шийдвэр нэгдэл -dolevoу болон тариачны (фермерүүд) зарах, өмчлөхөөр шийдвэрлэж газрын өөрийн өртгийг тогтоосон байна.
- 1992 “хувийн хэвшлийн болон туслах болон зуслан аж ахуй, цэцэрлэгт, хувь хүний орон сууцны барилгын газрыг худалдах тухай хуулиар баталсан байна. 1992 оны сүүлч, 1993 оны газар, зах зээлийн эргэлтийн хувьд газрын эдийн засгийн үнэлгээний арга барилыг тодорхойлох тоон болон чанарын шинж чанарыг харгалзан барьж, газар эзэмших төрөл бүрийн бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох зэрэг 50 гаран томоохон журмыг баталсан байна.
- 1993 оны тавдугаар сард RF Засгийн газрын тогтоолоор “ОХУ-ын газар нутгийн иргэдэд худалдах журам” баталсан юм.

Төрийн өмчийн монополь байдлыг халж, дунд жижиг хэмжээний газар эзэмшигчийн газрын харилцааг зохицуулах, газар ашиглах эдийн засгийн тогтолцоог нэвтрүүлэх, газар зохион байгуулалтыг төлөвлөх зэрэг газар эзэмшилтэй холбоотой арга хэмжээг авч байсан байна. Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтын нэг чухал алхам бол анхны хөрөнгө нутагт болсон «газрыг өмчлөх эрхийн харилцааг зохицуулах тухай нэмэлтийг ОХУ-ын арванхоёрдугаар сарын 12, (1993 оны 12сарын 2-нд баталсан) шинэ Үндсэн хуульд тусган баталсан байна.

- 1994 оны 3-ны өдрийн сарын ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор “газрын зах зээлийн жишиг үнийг тодорхойлох журам” -нд газрын нэгж талбайд ноогдох газрын татварын хувь тэнцүү газрын стандарт үнэ, тогтоосон юм.
- 1995 оны үл хөдлөх хөрөнгө (Үл хөдлөх эд хөрөнгийн) -д газрын хэвлийн болон усны тухай ОХУ-ын Иргэний хуулийн төслийг хэлэлцсэн байна.
- 1997 онд газрын харилцааны хөгжилд чухал ач холбогдолтой « Үл хөдлөх эд хөрөнгө, түүний эзэмшлийн эрх, улсын бүртгэлийн тухай» байгууллагын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо үүсэх, цуцлах журам баталсан. (1998 оны хоёрдугаар сард хүчин төгөлдөр болсон).
- 1998-2001 онд. “Улсын газрын кадастрын тухай”, “Газрын менежмент-нд”, “газар” болон ОХУ-ын Газрын хуулийн төрийн эзэмшлийн хязгаарын талаар тус улсад газрын харилцааны үүсэх асуудлыг боловсронгуй болгох: чухал ач холбогдолтой хэд хэдэн хууль тогтоомж баталсан байна.

Газрын шинэтгэлийн үр дүн

1991-2001 онд 275 орчим (тариачин) фермерийн аж ахуй өргөтгөсөн газар, орон нутгийн суурин газрыг дахин хуваарилах, аж ахуйн нэгжийн газрыг хувьчлах үйл явцыг эхэлжээ. Улсын хэмжээнд газрын кадастрын тогтолцоог бүрдүүлэх, газрыг зах зээлийн эргэлтэд оруулах, хувийн орон сууц, үл хөдлөх хөрөнгө барих, байгуулах нөхцөлийг бүрдүүлжээ. Гэхдээ газрын шинэтгэлийн үйл явцад газар ашиглалтын үр ашгийн асуудал, улс орны аюулгүй байдлын асуудал тулгамдсан байна. Жишээ нь, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг багасаж, тариалангийн газар, тариалангийн талбай болон бут шугуй, намгархаг, элэгдэлд орсон 13 сая гаруй га талбайн ашиглалт, газрын нөхөн сэргээлт, үр өгөөжийг сайжруулах шаардлагатай тулгарч байсан байна.

ОХУ-ын газрын шинэтгэлийн өнөөгийн байдал

2001 онд “Газрын хууль”-ийг шинэчлэн “Төрийн өмчийн газрын хязгаарын тухай” төрийн болон орон нутгийн өмчийн газар эзэмших зураглалыг баталсан бол (LCRF) 2014 оны 6 сарын 23 нд ОХУ-ын ерөнхийлөгч “ОХУ-ын Газрын тухай болон зарим хууль эрх зүйн актуудад нэмэлт өөрчлөлт” оруулсан байна. Энэ нэмэлт өөрчлөлт нь ОХУ-ын сүүлийн 14 жилийн хугацаанд гарсан газрын шинэтгэлийн талаарх томоохон өөрчлөлт болсон байна.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Г.Жаргал (Ph.D), Д.Солонго (Ph.D), М.Уянга, “Газар: Баялагаас өмч үүсгэх арга (Газрын эрх зүй)”, УБ, 2014;
- НҮБХХ -ийн “Бэлчээрийн тогтвортой менежмент” төсөл (2003 - 2004) -ийн хүрээнд бэлтгэгдсэн “Бэлчээрийн менежментийн бодлогын гарын авлага”, УБ., 2004;
- Т.Алтангэрэл, “ХҮI - ХҮII зууны Монгол цаазын бичгүүд”, УБ., 1999;
- О.Амархүү, “Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн түүхэн хөгжил, тогтвортой хөгжилд тэдгээрийн эзлэх байр суурийн асуудал”, УБ., 1999;
- Б.Баярсайхан, “Монгол цаазын бичиг”, УБ., 2001;
- Д.Лүндээжанцан, Ж. Болдбаатар, “Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал”, УБ., 1997;
- И.Дашням, “Монгол оронд дундад үеийн эрх зүйн тогтолцоог халж шинэ үеийн эрх зүйн анхны тогтолцоо бүрэлдэн тогтсон нь (1921 - 1940)”, УБ., 2002;
- С.Жалан-Аажав, “Халх журам бол Монголын хууль цаазны эртний дурсгалт бичиг мөн”, УБ., 1958;
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, цахим хаяг: www.mn-nhrc.org/;
- <http://eresources.nlb.gov.sg/>;
- Land rights usage: Types of land tenure. www.realtor.org/intlprof.nsf/all/singapore;
- <http://statutes.agc.gov.sg/>;
- http://en.wikipedia.org/wiki/Chinese_property_law#Imperial_China;
- **Constitution of the People's Republic of China.** www.npc.gov.cn/englishnpc/Constitution/;
- Property Law of the People's Republic of China. www.lawinfochina.com/;
- Конституция Республики Казахстан. <http://adilet.zan.kz/rus/>;
- <http://cyberleninka.ru/article/n/razvitie-zemelnyh-otnosheniy-v-respublike-kazahstan>;
- <http://adilet.zan.kz/rus/docs/K030000442>;

**ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН БОЛОН
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ХОРИГЛОХ,
ХЯЗГААРЛАХ НӨХЦӨЛҮҮД**

Г.Билгээ, Ч.Онончимэг, Д.Халиун

ОРШИЛ

Судалгааны зорилго

Захиалагчийн ирүүлсэн хүсэлтийн дагуу АНУ, ОХУ, БНХАУ, Канад, Австрали улсын ашигт малтмалын хууль тогтоомжийг судалсны үндсэн дээр дараах байдлаар тодруулан авч үзэхийг зорьсон болно.

- Дээр дурдсан орнуудын хувьд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход хориглох нөхцөлүүд;
- Мөн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход хязгаарлах нөхцөлүүд;

Судалгааны ерөнхий дүгнэлт:

Газрын тос болон эрдэс баялгийн арвин их нөөц илэрсэн улс орнуудад байгалиас заяасан энэхүү ашигт малтмал нь тухайн улс үндэстний хувьд урт хугацааны туршид стратегийн өндөр ач холбогдолтой байдаг билээ.

Судалгаанаас үзэхэд газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолт явагдах үйл ажиллагаатай уялдаж тухайн орон нутгийн хийгээд бүс нутгийн нийт хэмжээнд байгаль орчин, нийгмийн бусад асуудлаар оршин суугчид, нийгэм-олон нийтэд үзүүлж болзошгүй сөрөг дагавар ба нөлөөллүүдийн урьдчилан тооцсон байдаг. Энэ асуудал ялангуяа засаг захиргаа-нутаг дэвсгэрийн бүтэц тогтолцоо нь холбооны улсын байдлаар зохион байгуулагдсан /Тухайлбал, АНУ, Канад, Австрали, ОХУ, Нигери гэх мэтчилэн/ улсуудад нэн чухалаар тавигддаг бөгөөд учир нь эдгээр улсуудад байгалийн ашигт малтмалын, түүний дотор газрын тос, байгалийн хийн нөөцийн хайгуул, олборлолтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон асуудлыг үндсэн нь тухайн муж улс, эсхүл орон нутгийн засаг захиргааны хүрээнд шийдвэрлэн зохицуулж байх зарчим үйлчилдэг байна.

АНУ

АНУ-ын газрын хэвлийн ашигт малтмал, баялгийн хайгуул, олборлолт, ашиглалттай холбоотой асуудлыг 1872 онд батлагдсан Ерөнхий уул уурхайн тухай хуулиар зохицуулдаг (General Mining Act of 1872 / бүтэн нэр нь: АНУ-ын уул уурхайн баялгийн хөгжлийг дэмжих тухай хууль, An Act to promote the Development of the Mining Resources of the United States).

АНУ-ын уул уурхай, газрын хэвлийн нөөц, баялгийн хайгуул, ашиглалт, хамгаалалттай холбоотой асуудал нь газрын хэвлийн өмчлөлийн олон шатлал бүхий тогтолцооноос үүдэн дэлхийн хамгийн ярвигтай тогтолцоонд зүй ёсоор тооцогддог. Газрын хэвлийн баялгийн ашиглах асуудлыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт нь тухайн газар нутгийн өмчлөгч субъект болон газрын доорх баялгийн өмчлөгчөөс ихээхэн хамаарна. АНУ-ийн хувьд газрын хэвлийн баялаг нь холбооны, мужийн болон хувийн өмч байж болно. Холбооны хэмжээнд газрын хэвлийн баялагтай холбоотой асуудлыг 1872 оны хууль, 1920 онд батлагдсан Уул уурхайн түрээсний тухай хууль (Mineral Leasing Act of 1920), 1947 оны Ашигт малтмалын тухай (Mineral Materials Act of 1947) хуулиар, муж улсын өмчлөлийн ашигт малтмалыг тухайн муж улсын уурхайн тухай хуулиар тус тус зохицуулна.

АНУ нь зөвхөн өөрийн иргэд болон өөрийн нутаг дэвсгэр дээр байгуулагдсан хуулийн этгээд газрын хэвлийг ашиглах эрх олгодог. Гадаадын иргэд нь зөвхөн гэрээний үндсэн дээр газрын хэвлийг ашиглах эрх эдэлнэ. Практик дээр газрын хэвлийг ашиглах тухай концесс болон бусад төрлийн гэрээ нь ихэвчлэн хувийн өмчлөлд байгаа газрыг ашиглуулахад хэрэглэгдэж байна. АНУ-д газрыг патент болон түрээс гэсэн хоёр үндсэн хэлбэрээр ашигладаг.

Хүдрийн болон зарим төрлийн хүдрийн бус ашигт малтмалын хайгуул болон олборлолтын патентыг орон нутгийн /муж/ Дотоод хэргийн яамны харьяа Газрын удирдлага хариуцсан товчооноос олгодог. Патент нь газар эзэмших зөвшөөрөл бөгөөд үүнд газрын доорх баялгийн хайгуул болон ашиглалтын эрх орох юм. Газрын тос, байгалийн хий, нүүрс, калийн болон бусад төрлийн давс, хүхэр зэргийн олборлолтын эрхийг түрээсийн гэрээний үндсэн дээр олгоно. Түрээсийн гэрээг тендерийн үндсэн дээр явуулах боловч хуульд заасан нөхцөлийн дагуу тендер явуулахгүйгээр түрээсийн гэрээ байгуулах боломжийг олгосон байна. Патентын тогтолцоо нь хүдрийн болон тодорхой төрлийн хүдрийн бус ашигт малтмал бүхий газрыг ашиглуулахад хэрэглэгдэнэ.

Холбооны газар нутаг, цэргийн объект, нутгийн уугуул оршин суугчдын газар нутаг буюу резерваци зэрэгт патент бус тусгай зөвшөөрөл болон гэрээний үндсэн дээр уул уурхайн ажиллагаа явуулахыг зөвшөөрнө.

АНУ-ын Ашигт малтмалын газар болон уул уурхай тухай хуулийн 3А бүлгийн Түрээс болон хайгуулын зөвшөөрлийн тухай хэсэгт Дотоод яамны төрийн нарийн бичгийн дарга нь хайгуулын зөвшөөрөл эзэмшигч, зөвшөөрлийн нөхцөлийн дагуу бус үйл ажиллагаа явуулсан тохиолдолд зөвшөөрлийг цуцлах эрх эдэлнэ гэж заасан байна.

АНУ-ын газрын нутаг дэвсгэр дээр уул уурхайн ажиллагаа явуулахад тавигдах нийтлэг шаардлагын нэг нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн байх явдал юм. Үүнээс гадна уул уурхайтай холбоотой асуудлыг холбооны хэмжээний байгаль орчны 30 гаруй хуулиар зохицуулж байгаагаас гадна төрийн байгууллагуудын эрх, үүрэг давхацсан, уурхайн байрлал, байгаль орчны тогтоц зэргээс шалтгаалан ялгаатай зөвшөөрөл, баримт бичиг бүрдүүлдгээрээ онцлог юм. Ингэхдээ холбоо, муж улсын хэмжээнд тавигдах нийтлэг шаардлага нь цэвэр ус, агаарын чанар, агаар бохирдуулагч бодисуудыг бууруулах зэрэг асуудлаар холбогдох газруудаас зөвшөөрөл авахаар заасан байна.

ОХУ

ОХУ-д газрын хэвлийг ашиглах зөвшөөрлийг авахтай холбоотой харилцааг Газрын хэвлийн тухай Холбооны хууль болон Газрын хэвлийг ашиглах зөвшөөрлийг олгох журмын тухай Холбооны Дээд зөвлөлийн тогтоол зэрэг эрх зүйн баримт бичгээр зохицуулдаг байна.

Газрын хэвлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд хэвлийг ашиглах хэд хэдэн төрлийг тогтоосон ба үүнд ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалт хамаарна. Ингэхдээ газрын хэвлийг судлах, хайгуул хийх, олборлох буюу нэгэн зэрэг ашиглахыг зөвшөөрч болохыг заасан байна. Холбооны хуулиас гадна Газрын хэвлийг ашиглах зөвшөөрлийг олгох журмын тухай Холбооны Дээд зөвлөлийн тогтоол нь ашигт малтмалын хайгуул хийх, олборлох болон бусад зорилгоор газрын хэвлийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахыг тогтоолын 1 дүгээр зүйлд заасан байна.

Тус улсад олборлох ашигт малтмалын төрөл, газрын хэвлийд гүйцэтгэх ажлын төрөл зэргээс хамаарч зөвшөөрөл олгох журам янз бүр байна. Газрын хэвлийн тухай хуулийн Газрын хэвлийг ашиглахыг хязгаарлах тухай хуулийн 8 дугаар зүйлд зааснаар үндэсний

аюулгүй байдал болон хүрээлэн буй орчныг хамгаалах үүднээс газрын хэвлийн зарим хэсгийг ашиглахыг хязгаарлах, эсхүл ашиглахыг хориглож болно. Мөн суурьшмал газар, байгалийн зурвас газар, аж үйлдвэрийн объект, тээврийн хэрэгслэлийн зурвас газар зэрэгт хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, тухайн объект болон хүрээлэн буй орчинд хохирол учруулахаар бол газрын хэвлийн зарим хэсгийг ашиглахыг хязгаарлах, эсхүл ашиглахыг хориглож болно. Онцгой хамгаалалтад байгаа газар нутгийн газрын хэвлийг ашиглах харилцааг тухайн газар нутгийн харилцааг зохицуулсан эрх зүйн баримтаар зохицуулна.

Холбооны Дээд зөвлөлийн Газрын хэвлийг ашиглах зөвшөөрлийг олгох журмын тухай тогтоолын 7.1-д лиценз олгох хугацааг тогтоосон байна. Үүнд: газрын хэвлийд геологийн судалгаа хийх зөвшөөрлийг 5 хүртэлх жил, ашигт малтмал олборлох зөвшөөрлийг 20 хүртэлх жил, газрын хэвлийд геологийн судалгаа хийх болон ашигт малтмал олборлох зөвшөөрлийг 25 хүртэлх жилийн хугацаатай олгоно.

ОХУ-ын Төрийн зөвлөлөөс явуулж буй монополийн эсрэг бодлогын дагуу, түүнчлэн эдийн засгийн шинэ салбарыг дэмжих үүднээс нэг аж ахуй нэгжид олгох нийт зөвшөөрлийн тоог хязгаарлах ба энэ нь тухайн аж ахуй нэгжийн зөвшөөрөл авах хүсэлтийг буцаах үндэслэл болох талаар тогтоолын 11.7-д заасан байна.

БНХАУ

БНХАУ-ын Ашигт малтмалын тухай хууль 1986 онд хүчин төгөлдөр болсон, 1996 онд нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд гол онцлог нь тус хуулийг төрийн албан хаагч зөрчсөн тохиолдолд захиргааны хариуцлагаас гадна эрүүгийн хариуцлага ногдуулахаар тогтоосон явдал юм. Ашигт малтмалтай холбоотой асуудлыг Газар болон ашигт малтмалын яам (Ministry of Land and Natural Resources) эрхэлнэ.

Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу БНХАУ-ын газрын хэвлий дахь ашигт малтмал нь төрийн өмч мөн бөгөөд улсын нутаг дэвсгэр дээрх ашигт малтмалын хайгуул болон ашиглалт явуулахад холбогдох яамнаас тусгай зөвшөөрөл авахаар заасан байна. Үүнээс гадна ашигт малтмалтай холбоотой асуудлыг 1994 онд Төрийн зөвлөлийн 152 дугаар тогтоолоор баталсан Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх тухай журам (Rules for Implementation of the Mineral Resources Law) болон бусад тогтоолуудаар зохицуулж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 5 дахь зүйлээр, Төр нь хайгуул болон олборлолт явуулах эрхийг худалдан авах зарчимд тулгуурласан системийг нэвтрүүлнэ; гэвч тухайн нөхцөл байдалд тохируулан татварыг бууруулах, эсвэл авахгүй байхаар шийдвэрлэж болохоор зохицуулжээ. Уурхай бүр холбогдох төрийн зохицуулалтын дагуу нөөцийн татвар болон нөөцийн нөхөн төлбөрийг төлөх үүрэг хүлээнэ.

Хуулийн 20-р зүйлд, Төрийн зөвлөлийн холбогдох эрх бүхий газар зөвшөөрөөгүй бол доорх газруудад ашигт малтмал олборлохгүй:

- Боомт, нисэх буудал болон батлан хамгаалах объектын дотор;
- Чухал үйлдвэрлэлийн бүсээс тодорхой зай хүртэлх, том хэмжээний ус нөөцлөх төсөл, байгууламж, хотын инженерийн байгууламжийн дотор;
- Төмөр зам, чухал хурдны авто замаас тодорхой зайд;
- Гол мөрөн, чухал суваг шуудуунаас тодорхой зайд;
- Төрийн хамгаалалттай дархан цаазат нутаг, гол байгалийн үзэсгэлэнт газар, түүхэн шүтээн газар, үл хөдлөх түүхийн үнэ цэнэтэй газар;
- Төрөөс өмнө нь зөвшөөрөгдсөн уурхайн газар.

32-р зүйлд, уул уурхайн салбарт ажиллаж байгаа хүн бүр байгаль орчныг хамгаалах болон байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг сахиж мөрдөх үүрэгтэй гэж заасан. Хүн бүр газрыг арвич хямгач ашиглана. Уулын ажлын үр дүнд тариалангийн талбай, бэлчээр, эсвэл ой мод гэмтсэн бол холбогдох байгууллага нь мод тарих, өвс суулгах, эсвэл бусад аргаар тухайн газрыг сэргээх үүрэгтэй. Ашигт малтмалын олборлолтоос үүдэн бусдын үйлдвэрлэл болон амьдралд хохирол учруулсан хүн бүр нөхөн олговор олгох хариуцлага хүлээх буюу сэргээн засварлах үүрэг хүлээнэ.

33-р зүйлд, төмөр зам, үйлдвэр, нөөц хадгалах байгууламж, нефтийн хоолой, өндөр хүчдэлийн шугам, эсвэл том хэмжээний барилга байгууламж барихаас өмнө барилга угсралтын байгууллага нь геологи, эрдэс баялаг хариуцсан эрх бүхий газраас эрдэс баялгийн тархалт, олборлолтын талаар мэдээлэл авсан байх шаардлагатай гэж тусгажээ. Эрх бүхий газраас зөвшөөрөл аваагүй бол ийм барилга байгууламж нь чухал орд газрыг хамарч болохгүй.

Ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар бүлэгт тус хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгасан ба нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан гол онцлог нь 47, 48 дугаар зүйлд төрийн албан хаагчтай холбоотой үүссэн асуудлаар захиргааны хариуцлагаас гадна эрүүгийн хуулиар хариуцлага ногдуулахаар заасан байна.

Орон нутгуудын хувьд ашигт малтмалын асуудлаар бүс нутгийн эдийн засгийн хөгжил дэвшилд нэмэр оруулахуйц, өөрсдийн хүчээр боловсруулах боломжтой ашигт малтмалд тэргүүний ач холбогдол өгөхөөс гадна үндэсний цөөнхийн эрх ашгийг харгалзан үзэхээр заасан байна.

Ашигт малтмалын геологийн хайгуулын ажлыг Төрөөс тогтоосон нэгдсэн төлөвлөгөөний дагуу явуулах бөгөөд металл, цацраг идэвхт түүхий эдийг 40 үндсэн блокийн хэмжээ бүхий талбайд 3 жилийн хугацаатай тусгай зөвшөөрлийн дагуу явуулах бөгөөд байгалийн хий болон газрын тосны тухайд 2500 үндсэн блокийн хэмжээ бүхий талбайд дээд тал нь 7 жилийн хугацаатай тусгай зөвшөөрлийн дагуу тус тус явуулна. Дээрх тусгай зөвшөөрлийг авахдаа өргөдөл, байгууллагын гэрчилгээ, төслийг санхүүжүүлэх эх үүсвэрийн талаарх мэдээлэл, геологийн хайгуулын ажлын төлөвлөгөө зэргийг бүрдүүлэх тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад бүрдүүлж өгдөг. Өргөдлийг 40 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Зарим тохиолдолд тендер зохион явуулж болдог. Ингэхдээ газрын хэвлийн талбай/блокийн дээд хэмжээг дараах байдлаар тогтоосон байна.

- Ус -10 блок,
- Металл, металл бус болон цацраг идэвхт түүхий эд – 40 блок,
- Халуун рашаан, нүүрс болон нүүрс хүчлийн хий – 200 блок,
- Газрын тос болон байгалийн хий – 2500 блок байхаар тус тус хязгаарласан байна.

Тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлага:

Газар болон ашигт малтмалын яам нь хоёр төрлийн тусгай зөвшөөрөл олгодог. Нэг нь хайгуулын, нөгөө нь ашиглалтын тусгай зөвшөөрөл юм. Ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад дараах шаардлагыг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Хуулийн этгээд байх,
- Геологийн хайгуул явуулах эрхтэй байх, эсхүл хайгуул явуулах төлөвлөгөөндөө геологийн хайгуул явуулах эрх бүхий байгууллагаар явуулах итгэмжлэл олгосон байх,
- Хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа явуулахдаа дэд гүйцэтгэгч байгууллагыг ажиллуулахгүй байх гэсэн шаардлагууд тус тус тусгагдсан байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг:

Ашигт малтмалын тухай хуульд дээрх хоёр тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийг нарийвчлан тогтоосон бөгөөд зөвшөөрөл авснаар тусгай зөвшөөрөлд заасан нөхцөлийн дагуу зөвшөөрөлд заасан талбайд хайгуул/ олборлолт явуулах, шугам хоолой, ус, цахилгаан татах, газар ашиглах зэрэг эрхтэй болох юм.

Өргөдлийг хүлээн авч, тусгай зөвшөөрлийг олгохоор шийдвэрлэсэн тохиолдолд өргөдөл гаргагч нь 30 хоногийн дотор хайгуул явуулах эрхийн мөнгөн төлбөр төлнө. Хайгуулын үйл ажиллагааг төрөөс санхүүжүүлсэн тохиолдолд, дээрх төлбөрөөс гадна хайгуулын ажил явуулсны нөхөн төлбөрийг нэмж төлнө. Төлбөл зохих нөхөн төлбөрийг тогтоосон хугацаанд /30 хоног/ төлөөгүй тохиолдолд алданги тооцно. Нөхөн төлбөрийг төлөөгүй нөхцөлд тусгай зөвшөөрлийг хүчин болгоно. Ийм тохиолдолд тус тусгай зөвшөөрөл эзэмшигч 6 сарын хугацаанд холбогдох төрийн албадаас дахин хайгуул болон олборлолтын тусгай зөвшөөрөл авах эрхгүй байна. Газрын тос, байгалийн хий, нүүрс болон цацраг идэвх ашигт малтмалын тухайд ордын нөөцийн их, бага хэмжээнээс хамаараад тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа ялгаатай байх бөгөөд бага нөөцтэй – 10 жил, бусад нь – 30 жилийн хугацаатай байна.

КАНАД

Канад улсын хувьд Холбооны болон муж улсын Засгийн газрын өмчлөлд байгаа газрын хэвлийн баялгийг төрийн өмч байхаар хуульчилжээ. Холбооны улсын уурхайн хууль нь зөвхөн холбооны улсын шүүх эрх мэдэлд хамаарагдах газар болон далай тэнгисийн доорх газрын хэвлийн ашигт малтмалыг ашиглах харилцааг зохицуулдаг байна.

Муж улсууд өөр өөрсдийн газар нутгийн газрын хэвлийг ашиглах уурхайн хуультай ба хайгуул хийх эрхийг хязгаарлагдмал талбайд олон хувь хүн, хуулийн этгээдийг дундын өмчлөлийн хөрөнгийн биржийг ашиглан санхүүгийн хэрэгслээр (хувьцаа, бонд) дамжуулан оролцуулахаар хуульчилсан байна. Ашигт малтмалын орд нээн илрүүлэгчдэд тухайн ордын хэсэгхэнийг ашиглах эрх олгох ба үлдсэн хэсгийг олон нийтийн өмчлөлд биржээр дамжуулан хувьцаа гаргаж худалдах замаар эзэмшүүлдэг байна.

Хайгуулын болон орд ашиглах эрхийг зөвхөн Канадын иргэд хяналтын багц хувьцааг эзэмшдэг уул уурхайн компани болон Канадын хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргасан гадаадын хөрөнгө оруулалттай компанид олгодог. Цөөн тохиолдлоос бусад үед ашигт малтмалыг хайх, олборлох эрхийг орон нутгийн Засгийн газар компаниудад олгоно. Өөрөөр хэлбэл, энэ нь тухайн муж, эсвэл нутаг дэвсгэрт бага хэмжээний хураамж төлж авсан ашигт малтмалын зөвшөөрөл эзэмшигчид уул уурхай эрхлэх эрх олгогдоно гэсэн үг юм. Энэхүү эрхийг гол төлөв нэг жилийн хугацаагаар олгох ба энэ хугацаанд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн газартаа бага ч гэсэн ямар нэгэн ажил хийсэн байх ёстой.

Ашигт малтмалын эрэл хайгуулын ажиллагаа байгаль орчинд их хохирол үзүүлэх, газар нутгийг сүйтгэх магадлалтай тул зарим муж хайгуул хийгдэхийн өмнө тодорхой шаардлагууд тавьдаг байна. Тухайлбал, Ньюфаундленд гэхэд аюулгүй байдлын урьдчилгаа төлбөр авдаг бол Юконд 2 ба 3 дугаар шатны хайгуулын зөвшөөрөл авдаг.

Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхэд газар, ус, байгаль орчин, аюулгүй байдал, ажиллах хүч зэрэгтэй холбоотой маш олон төрлийн зөвшөөрлийг орон нутгийн болон холбооны засаг захиргаанаас авах шаардлагатай, энэ нь муж бүрт харилцан адилгүй байна. Жишээ нь Онтарио мужид гэхэд л 23 төрлийн зөвшөөрөл шаарддаг. Дээрх зөвшөөрлүүдийг олгохын өмнө холбооны, мужийн болон нутаг дэвсгэрийн бүх хууль журам хүрээлэн

буй орчны үнэлгээг шаарддаг. Энэ үнэлгээг тусгай хуулийн (*Environmental Assessment Acts*) дагуу хийнэ. Хувийн эзэмшлийн газрын хэвлийг эзэмших эрхтэй иргэдийн газрын хэвлийн баялгийг хайгуул хийх, ашиглах эрхийг АНУ-ын адил газар өмчлөлийн хуулиар зохицуулдаг байна.

АВСТРАЛИ

Австралийн муж улсууд нь тус тусдаа “Mineral law” буюу ашигт малтмалын хуультай, эдгээр нь хоорондоо зохицуулалтын нарийн ялгаатай боловч ашигт малтмалын хуулийн үйлчлэх ерөнхий хүрээ нь ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа, түүнтэй шууд хамаатай байгаль орчныг нөхөн сэргээх, хаягдал зайлуулах, тээвэрлэх харилцааг зохицуулахаар хязгаарлагддаг тул агуулгын хувьд үндсэндээ хайгуулын болон олборлолтын гэсэн 2 төрлийн тусгай зөвшөөрөл олгогдож байна. (Зарим муж улсад, тухайлбал, Баруун Австрали мужид эрэх, хайх, хадгалах, олборлох гэсэн 4 төрлийн тусгай зөвшөөрөл олгодог бол Квинсленд мужид техникийн бус аргаар ашигт малтмал олборлох зөвшөөрлийг тусад нь олгохоор хуульчилсан байдаг).

Австралийн муж улсуудын ашигт малтмал, газрын тосны хуульд байдаг нийтлэг зохицуулалтуудын нэг нь, хэрэв тусгай зөвшөөрөл олгогч “боломжгүй” л гэж үзсэн бол тусгай зөвшөөрөл эзэмших хүсэлт гаргагч нь хуульд заасан болзол шаардлагуудыг хэдий хангаж байсан ч тусгай зөвшөөрөл олгогдохгүй байх явдал юм.

Австралийн Ашигт малтмалын болон Газрын тосны хууль (*Petroleum Law*) дах хайгуул олборлолтын тусгай зөвшөөрлийн эрх зүйн зохицуулалтад хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсоноос хойш нэг жилийн дотор түүнийг шилжүүлэх, барьцаалахыг хориглодог нийтлэг зохицуулалт бий. Энэ хугацаанд лиценз эзэмшигч өөрийн хөрөнгөөр хайгуулаа хийх ёстой. Тэгж чадахгүй бол лицензийг нь буцаан хурааж авдаг. Учир нь хайгуулын лиценз анх олгохдоо санхүүгийн чадавхыг гол болгон шалгаруулах бөгөөд эхний жилд хайгуулын ажилд зарцуулах хөрөнгийн доод хэмжээ, заавал хийж гүйцэтгэх ажлыг яг тохирдог тул үүнийг биелүүлээгүй нь тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болдог байна.

Австрали улсын хувьд Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой бөгөөд газар зүйн байршил, ашигт малтмалын онцлогоос хамаараад Муж бүр тусдаа ашигт малтмалын хуулийг дагаж мөрддөг. Үүнд:

- Өмнөд шинэ Уэльс муж – 1992 онд батлагдсан “Уул уурхайн тухай хууль”-тай. Уг хуулиар алт, мөнгөний уурхайн үйл ажиллагааг зохицуулсан.
- Квинсленд муж – 1989 онд батлагдсан “Ашигт малтмалын нөөцийн тухай хууль”-тай. Энэ хуулиар бүх төрлийн ашигт малтмалын харилцааг зохицуулсан.
- Өмнөд Австрали муж – 1971 онд батлагдсан “Уул уурхайн тухай хууль”-тай. Энэ хуулиар бүх төрлийн ашигт малтмалын харилцааг зохицуулсан.
- Тасмани муж – 1995 онд батлагдсан “Ашигт малтмалын нөөцийн тухай хууль”-тай. Уг хуулиар алт, мөнгө, газрын тос, цацраг идэвх эрдэсийн харилцааг зохицуулсан.
- Виктория муж - 1990 онд батлагдсан “Ашигт малтмалын нөөцийн тухай хууль”-тай. Хуулиар ихэнх ашигт малтмалын харилцааг зохицуулсан.
- Өрнөд Австрали муж – 1978 онд батлагдсан “Уул уурхайн тухай хууль”-тай. Уг хуулиар бүх үнэт металл болон бусад ашигт малтмалын харилцааг зохицуулсан байна.

Австрали улсын уул уурхайн салбарын хууль эрх зүй нь хүдрийн төрлийн ашигт малтмалыг олборлох, газрын тос, хийн ашигт малтмалыг олборлох гэсэн 2 үндсэн чиглэлд хуваагддаг. (Зарим муж улсад, тухайлбал Баруун Австрали мужид эрэх, хайх, хадгалах, олборлох гэсэн 4 төрлийн тусгай зөвшөөрөл олгодог бол Квинсленд мужид техникийн бус аргаар ашигт малтмал олборлох зөвшөөрлийг тусад нь олгохоор хуульчилсан байдаг)

Австралийн ашигт малтмалын эрх зүйн зохицуулалт нь ашигт малтмалыг ялган авах, олборлох үйл ажиллагаа нь олборлолтын тусгай зөвшөөрлөөр буюу ашигт малтмалын хуулиар зохицуулагдаж, харин бүтээгдэхүүн үйлдвэрлэх асуудал нь ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, юунд ашиглахаас шалтгаалан ашигт малтмалын хуулиар бус тухайн салбар эрх зүйгээр нь зохицуулагддаг.

Тусгай зөвшөөрлийн төрөл:

- Хайгуулын тусгай зөвшөөрөл;
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл;
- Түр хадгалалтын гэрээ;
- Олон төрлийн зориулалт бүхий лиценз.

Австралийн муж улсууд нь тус тусдаа “Mineral law” буюу ашигт малтмалын хуультай, дор бүрнээ зохицуулалтын нарийн ялгаатай боловч ашигт малтмалын хуулийн үйлчлэх ерөнхий хүрээ нь ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа, түүнтэй шууд хамаатай байгаль орчныг нөхөн сэргээх, хаягдал зайлуулах, тээвэрлэх харилцааг зохицуулахаар хязгаарлагддаг тул агуулгын хувьд үндсэндээ хайгуулын болон олборлолтын гэсэн 2 төрлийн тусгай зөвшөөрөл олгогдож байна. (Зарим муж улсад, тухайлбал Баруун Австрали мужид эрэх, хайх, хадгалах, олборлох гэсэн 4 төрлийн тусгай зөвшөөрөл олгодог бол Квинсленд мужид техникийн бус аргаар ашигт малтмал олборлох зөвшөөрлийг тусад нь олгохоор хуульчилсан байдаг)

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага, хязгаарлалт:

Хайгуулын тусгай зөвшөөрөл /лиценз/-г ямар ч хүнд олгоно. /Уул уурхайн тухай хуулийн 5 дугаар бүлэг./ Лицензээр олгогдох газар нь 1000 квадрат км-с ихгүй байх ба үнэт чулууны хайгуулын газрын хувьд уг хэмжээ 20 квадрат км-с ихгүй гэж заажээ.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргагч нь уурхайн үйл ажиллагаа, уг ордыг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, бусад бичиг баримт зэргийг бэлтгэхийн зэрэгцээ өргөдлийн төлбөрийг төлнө.

Тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзах, цуцлах эрх зүйн зохицуулалт

Австралийн эрх зүйн цаад үр дагавар нь ашигт малтмалын хайгуул, олборлолтыг хэзээ, хаана, хэнээр хийлгэхийг өмчлөгчийн хувьд төр шийдэх онцгой бүрэн эрхтэй хэдий ч нэгэнт шийдээд олгосон тусгай зөвшөөрөл хуулиар тогтоосон хугацаанд, үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа эзэмшигчдээ бүрэн хадгалагдах, хэрэв зайлшгүй шаардлагын улмаас цуцлагдахад хүрвэл хууль ёсны эзэмшигч төрөөс нөхөх олговор авах эрхээр хангагдахыг баталгаажуулсан байна. Харин зайлшгүй шаардлага гэдэг нь олон нийтийн тусын тулд, итгэлцлийн (in good faith) үүднээс урган гарсан байх нь гол зарчим. Байгаль орчинг хамгаалах, олон нийтийг болзошгүй аюулаас сэргийлэх, хүний амьдрах орчин, эрүүл мэндийг хамгаалах гэх мэт олон үндэслэл үүнд багтана. Эдгээр зорилгоор төрөөс тусгай зөвшөөрлийг цуцлах нь эрх зүйн ерөнхий зарчим, шударга ёсны үнэлэмжид харшлахгүй хэмээн үзэж болно.

Квинсленд Үүний зэрэгцээ дээрх зорилгоор тусгай зөвшөөрлийг цуцалсан нь төр болон бусад сонирхогч этгээдэд санхүүгийн ашиг орлого авчраагүй байх нь дараагийн нэг чухал зарчим Тусгай зөвшөөрөл эзэмшигч хэдийгээр үнэ цэнэтэй эрхээ алдаж байгаа ч түүний оронд хэн ч, түүний дотор төр, санхүүгийн аливаа ашиг олоогүй байх нь энэ зарчмын гол агуулга аж.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Rules for implementation of the mineral resources law of the People's Republic Of China. www.mlr.gov.cn/mlrenglish/laws/
- Mineral resources law of the People's Republic Of China, 1986. www.mlr.gov.cn/mlrenglish/laws/
- A Guide to Investment in China's Mineral Industry, 2012. www.chinaminingtj.org/esp/document/
- Mining overview. www.un.org/esa/dsd/
- www.blm.gov/wo/st/en.html
- Закон Российской Федерации от 21 февраля 1992 г. N 2395-I "HYPERLINK "http://ivo.garant.ru/document?id=10004313&sub=0"О недрахHYPERLINK "http://ivo.garant.ru/document?id=10004313&sub=0""
- Положением о порядке лицензирования пользования недрами, утвержденным постановлением Верховного Совета РФ от 15 июля.
- www.elaws.gov.on.ca/html/statutes/english/elaws_statutes_90m14_e.htm
- www.gov.pe.ca/law/statutes/pdf/m-07.pdf
- www.gov.yk.ca/legislation/acts/qumi.pdf

**МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ УУЛ УУРХАЙН
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ТАТВАРЫН ТОГТОЛЦОО***Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа***ОРШИЛ**

Захиалгын дагуу Монгол Улсын уул уурхайн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын тогтолцоо, хувь хэмжээ, татварын ачаалал болон гадаадын зарим орны уул уурхайн салбарын татварын хувь хэмжээ, 2014-2015 онд гарсан өөрчлөлт, шинэчлэлийн талаарх харьцуулсан судалгааг дараах байдлаар хийж гүйцэтгэлээ.

- Монгол Улсын уул уурхайн салбарын татварын тогтолцоо, эрх зүйн зохицуулалт;
- Монгол Улсын уул уурхайн салбарын татварын ачаалал болон уул уурхайн салбараас улсын төсөвт оруулж буй орлого;
- Гадаадын зарим орны уул уурхайн салбарын татварын тогтолцоо, хувь хэмжээ.

Судалгааны ерөнхий тойм:

Судалгааны 1-р хэсэгт: Судалгааны энэхүү хэсэгт хууль тогтоомжийн www.legalinfo.mn мэдээллийн сангаас манай улсын уул уурхайн салбарт үйлчилж буй хууль тогтоомжийг авч судлав. Одоогийн байдлаар хууль тогтоомжийн хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 21 татвар, төлбөрөөс уул уурхайн салбарт 15 төрлийн татвар, төлбөр, хураамж мөрдөгдөж байгааг Хүснэгт 1-т дэлгэрэнгүй байдлаар гаргав.

Судалгааны 2-р хэсэгт: Монгол Улсын уул уурхайн салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 60-70 хувь, ДНБ-ний 20-30 хувь, экспортын бүтээгдэхүүний 90-ээд хувийг бүрдүүлж байна. Судалгааны энэхүү хэсэгт уул уурхайн салбарын өнөөгийн байдал, 2013 онд төсвийн орлого бүрдүүлэлтэд уул уурхайгаас оруулсан татварын орлого, уул уурхайн салбарын 2007-2013 оны татварын ачааллын түвшин, 2012-2013 оны байдлаарх гол нэр төрлийн ашигт малтмал тус бүрээр татварын ачааллын түвшинг харуулсан болно.

Судалгааны 3-р хэсэгт: Уул уурхайн салбар хөгжсөн улс орнуудад хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээ, чиг хандлагаас харахад эдийн засгийн хямралын үед уул уурхайн салбарын татварын хувь хэмжээг өсгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиг хандлага ажиглагддаг. Энэ нь тус салбарын ашиг өндөр байдагтай холбоотой юм. Ийм ч учраас уул уурхайн салбарын татварын хувь хэмжээнд олон орон 2015 оноос эхлэн хууль тогтоомжиндоо нэмэлт, өөрчлөлт оруулсныг судалгааны энэхүү хэсэгт дэлгэрэнгүй байдлаар харууллаа. Мөн түүнчлэн Авсртали, Канадын мужууд болон нийт БНХАУ, Индонез, Чили зэрэг есөн орны уул уурхайн татварын хувь хэмжээг Монгол Улсын татварын хувь хэмжээтэй харьцуулан дэлгэрэнгүй байдлаар судаллаа.

**НЭГ. УУЛ УУРХАЙН ТАТВАРЫН ТОГТОЛЦОО, МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН
САЛБАРТ ҮЙЛЧИЛЖ БУЙ ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Уул уурхайн татварын үндсэн зорилго нь төр газрын хэвлийд байгаа баялгаа бусдад худалдаж төлбөр ногдуулж байгаа нь уул уурхайн компаниудын хувьд ашигт малтмалыг худалдан авч байгаагаас гадна олборлох эрх авч байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл уул уурхайн үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхлэж буй компанийн хувьд тухайн баялгийн эзэн болон орлогын албан татварыг ногдуулагч нь зөвхөн төр байна.

Байгалийн баялагаа худалдаалахдаа дэлхийн нийтээр дараах гурван төрлийн татварыг ашиглаж байна¹⁰⁰:

- Олборлож борлуулсан тоо хэмжээнд суурилсан нөөцийн төлбөр (жин, эзлэхүүний нэгж тутамд);
- Ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнд суурилсан нөөцийн төлбөр (ad valorem-тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээ буюу борлуулалтад тодорхой хувиар);
- Resource rent буюу ашиг хуваах (олборлогч компанийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийн тодорхой хэмжээнээс давсан хэсгийг нь Засгийн газар хуваан хүртэх).

Эдгээр татвар тус бүрээр товч үзвэл:

Олборлож борлуулсан тоо хэмжээнд суурилсан нөөцийн төлбөр (жишээ нь: олборлож борлуулсан хүдрийн тонн тутамд тодорхой хэмжээгээр ногдуулах төлбөр) нь төрийн өмч болох байгалийн баялгийг бусдад төлбөртэйгээр ашиглуулахад төлбөр ногдуулах хамгийн энгийн арга боловч тухайн баялгийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлт бууралтын нөлөөллийг тусгаж чаддаггүй онцлогтой. Бодит байдал дээр бараа бүтээгдэхүүн борлуулж байгаа эзэн нь тухайн барааныхаа зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан үнэ ханшаа уян хатан өөрчилдөг.

Бас нэг сул тал нь уул уурхайн салбарт эргээд сөргөөр нөлөөлж болно. Энэ арга нь олборлогч компанийн олборлолтын зардлыг тооцдоггүй. Нөөцийн төлбөр нь бүтээгдэхүүний өртгийн зөвхөн нэг хэсэг тул хүдрийг газрын хэвлийгээс олборлохтой холбоотой бүх шууд болон шууд бус зардлыг нэмж байж нийт олборлолтын зардлыг тодорхойлно. Газрын өнгөн хэсэг дэх нөөц жил бүр багасаж олборлолт газрын гүн рүү явагдах бөгөөд олборлолтын зардал улам нэмэгдсээр байдаг.

Газрын гүнд байгаа ашигт малтмалын үнэлгээ нь газрын өнгөн хэсэгт байгаа олборлоход хялбар ашигт малтмалын үнэлгээтэй харьцуулахад хэд дахин хямд байдаг. Энэ хэлбэрийн нөөцийн төлбөр нь олборлолтын нөхцөл, үнэлгээний дээрх зөрүүг тусгаж чаддаггүй бөгөөд зарим уурхайн хувьд ажиллах боломжгүйд ч хүргэж болно.

Ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнд суурилсан нөөцийн төлбөр¹⁰¹ (ad valorem-борлуулалтын үнэлгээнд тодорхой хувиар татвар ногдуулдаг) нь Монгол Улсад мөрдөж байгаа хувилбартай ижил бөгөөд зах зээлийн үнийн өөрчлөлтийг тодорхой хэмжээгээр тусгаж чаддаг. Ашигт малтмалын зах зээлийн үнэ өссөнөөс борлуулалтын орлого өсөх бөгөөд улмаар нөөцийн төлбөрийн хэмжээ дагаж өснө. Гэвч өмнө дурдсан биет хэмжээнд ногдуулдаг аргатай нэгэн адилаар газрын хэвлий дэх баялгийн үнэлгээг (олборлолтын өртгийг) тухай бүр тусгаж чаддаггүй. Тухайлбал, борлуулалтын үнэлгээг дэлхийн зах зээлийн үнэлгээгээр тооцооло гэхэд газрын доор байрлаж байгаа байгалийн баялгийг олборлож, тээвэрлэж борлуулах зардал харилцан адилгүй байдаг. Харин борлуулалтад ногдуулах нөөцийн төлбөр нь газрын гадаргад ойр олборлоход хялбар ашигт малтмал, газрын гүнд байрлалтай олборлолтын хүнд нөхцөлтэй ордын хувьд ижил хэмжээгээр татвар ногдуулдаг.

Мөн дэд бүтцэд ойр орд, дахин шинээр хөрөнгө оруулалт хийж дэд бүтэц бий болгосны үндсэн дээр олборлолт, борлуулалт хийх ордуудад ижил хэмжээгээр татвар ногдуулдаг. Ийнхүү борлуулалтын орлогод ногдуулдаг нөөцийн төлбөр нь биет хэмжээнд ногдуулдаг төлбөртэй нэгэн адилаар борлуулалтын орлого, түүнд ногдох татвар нь тогтмол байж хөрөнгө оруулалтын эцсийн өгөөжийг үл харгалзан тооцогддог тул олборлогч компаниудын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг гэж тооцогддог.

¹⁰⁰"Монгол Улсын татварын тогтолцоо ба уул уурхайн салбар" Дэлхийн өсөлт Олон Улсын байгууллагын судалгаа, 2008-XII сар

¹⁰¹<http://mining.news.mn/content/108410.shtml>

Resource rent буюу ашиг хуваах хувилбар нь олборлолтын зардал, дэлхийн зах зээлийн үнийг үндэслэн тухайн ашигт малтмалын үнэлгээг тодорхойлдог арга юм. Энэ татварын тооцоолол нь тухайн уул уурхайн компанийн оруулсан хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын өгөөжийг Засгийн газрын бонд авсантай адил аливаа эрсдэлгүй, баталгаатай байхаар тогтоосон тооцооллоор эхэлнэ. Нэгэнт Засгийн газрын бондод бус уул уурхайн бизнест хөрөнгө оруулсны хувьд өмнө тооцсон хөрөнгө оруулалтын өгөөжийг тодорхой нэмэлт хувиар нэмэгдүүлж өгнө. Энэхүү хөрөнгө оруулалтын өгөөжүүдийн нийлбэр нь тухайн уул уурхайн компанийн хөрөнгө оруулалтыг ашигласны төлбөр болон тэдний хүлээж байгаа эрсдлийн үнэлгээ юм. Энэ дүн нь тухайн ашигт малтмалын үнэлгээний түвшинг тодорхойлно. Энэ түвшин хүртэлх ашгийг хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдлийн үнэлгээ гэж үзнэ. Харин давсан ашгийг ашигт малтмалын өөрийн үнэлгээнд хамааруулна. Хэрэв тухайн улс нь resource rent буюу ашиг хуваах хувилбарыг сонгосон бол ашигт малтмалын үнэлгээнд ногдох хэсгийг тухайн олборлогчтой хуваана. Төр нь ашигт малтмалын үнэлгээнд ногдох ашгийн тодорхой хувийг нь авна гэсэн үг.

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 21 татвар, төлбөрөөс уул уурхайн салбарт дараах 15 төрлийн татвар, төлбөр, хураамж мөрдөгдөж байна.

№	Татварын төрөл	Эрх зүйн зохицуулалт	Хувь хэмжээ	Тайлбар
1	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Ашигт малтмалын тухай хуулийн 47.3 ¹⁰² -т, 47.5-т	<p>47.3.1.дотоодод борлуулж байгаа нүүрсний нөөц ашигласны төлбөр тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5%;</p> <p>47.3.2.энэ хуулийн 47.3.1, 47.3.3-т заасан Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтнаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн доод хэмжээ нь тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5,0 хувьтай тэнцүү.</p> <p>47.3.3.Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд энэ хуулийн 47.3.2-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2,5 хувь, энэ хуулийн 47.5-д заасан нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү.</p> <p>47.5 т заасан нэмж ногдуулах төлбөрийн хэмжээ</p>	

¹⁰²Ашигт малтмалын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2006 оны №30 -т нийтлэгдсэн.

2	ААН-ийн орлогын албан татвар	ААНОАТТХ-ийн 17.2.1, 17.2.2, 17.2.5, 17.2.6, 17.2.7, 17.2.8, 17.2.9.а-г, 17.2.10	<p>17.2.1 Ногдол ашгийн орлогод 10%;</p> <p>17.2.2 Эрхийн шимтгэлийн орлогод 10%;</p> <p>17.2.5 Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод 2%;</p> <p>17.2.6 Хүүгийн орлогод 10%;</p> <p>17.2.7 Эрх борлуулсны орлогод 30%;</p> <p>17.2.8 Гадаадын аж ахуйн нэгжийн төлөөний газар өөрт ногдох ашгаасаа гадаадад шилжүүлбэл шилжүүлсэн ашгийн 20%;</p> <p>17.2.9 Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод 20%;</p> <p>17.2.10 Монгол Улсын арилжааны банкны гадаад, дотоодын хөрөнгийн биржид гаргасан бондыг худалдан авсан Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн бондын хүүгийн орлогод 10%.</p>	17.2.10 дахь заалтыг 2014 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд үүнийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
3	Гаалийн албан татвар	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн		
4	НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль ¹⁰³ -ийн 11.1, 12.1.1, 12.1.2, 12.1.3, 12.1.7	<p>11.1.Импортлолсон болон үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний албан татвар тооцох үнэлгээний 10%;</p> <p>12.1.1.худалдах зориулалтаар Монгол Улсын нутаг дэвсгэрээс экспортод гаргасан бөгөөд гаалийн байгууллагад мэдүүлсэн бараа-0%;</p> <p>12.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаад улсад, гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт, түүнчлэн гадаад улсаас Монгол Улсын нутгаар дамжуулан бусад улсад гаргасан зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ 0%;</p> <p>12.1.3.Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна үзүүлсэн /албан татвараас чөлөөлсөн үйлчилгээг оролцуулан/ үйлчилгээ 0%;</p> <p>12.1.7.экспортод гаргасан уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн 0%.</p>	Засгийн газрын 2010 оны №286 тоот тогтоолоор Уул уурхайн эцсийн бүтээгдэхүүний жагсаалтыг баталсан. Энэ тогтоолд Засгийн газрын 2013 оны 296 тоот тогтоолоор өөрчлөлт орсон.

¹⁰³Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2006 оны №40-т нийтлэгдсэн.

5	Автобензин, дизелийн түлшний албан татвар	Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хуулийн 6-р зүйл	6-р зүйл. Тонн тутамд дараахь хэмжээгээр ногдуулна: 1. Автобензин 90 хүртэл октантай-20350 төг/тн 90-ээс дээш октантай-25700 төг/тн /шинжилгээний аргаар тодорхойлсон/ 2. Дизелийн өвөл, зуны түлш-2140 төг/тн	
6	Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	AMTX-ийн 32.2	Хайгуулын талбайн гектар тутамд эхний жилд 0,1 америк доллар, 2 дахь жилд 0,2 америк доллар, 3 дахь жилд 0,3 америк доллар, 4-6 дахь жилд тус бүр 1,0 америк доллар, 7-9 дэх жилд тус бүр 1,5 америк доллар, 10-12 дахь жилд 5 америк доллар байна.	Нэмэлт орсон.
7	Ашиглалтын тухай зөвшөөрлийн төлбөр	AMTX-ийн 32.3	Уурхайн талбайн гектар тутамд 15 америк доллар байх бөгөөд харин шохойн чулуу, нүүрс, дотоодын үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмалын хувьд гектар тутамд 5 америк доллар байна.	
8	Агаарын бохирдлын төлбөр	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 7.1 ¹⁰⁴	7.1 Олборлосон түүхий нүүрсний төлбөрийн хувь, хэмжээг нүүрсний килограмм тутамд 1-2 төгрөгийн хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.	
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль ¹⁰⁵	6.1.2.уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан 10.1-т уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр тооцох бөгөөд Төлбөрийн хязгаар /экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар/ байна. Уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд: а/ашигт малтмал олборлох, баяжуулах гадаргын усанд 10-40% газар доорх усанд 20-60%, б/зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах гадаргын усанд 10-50%, газар доорх усанд 20-70%, в/усыг шавхан зайлуулах гадаргын усанд 10-15%, газар доорх усанд 15-50%, г/эрэл, хайгуулын өрөмдлөг хийх гадаргын усанд 10-30%, газар доорх усанд 20-50%.	

¹⁰⁴ Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2010 оны №29-т нийтлэгдсэн.

¹⁰⁵ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны №22-т нийтлэгдсэн.

10	Газрын тосны нөөц ашигласны төлбөр	Газрын тосны тухай хуулийн 31 зүйл	31 дүгээр зүйл. Нөөц ашигласны төлбөр, түүнийг хуваарилах 31.1.Газрын тос, байгалийн хийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь олборлосон түүхий тос, байгалийн хийн 5-15 %; 31.2.Уламжлалт бус газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нь 5-10%; 31.3.Нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг тухайн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг улсын төсөвт тус тус төвлөрүүлнэ. 31.4.Засгийн газарт ногдох түүхий тосны жил бүрийн борлуулалтын орлогын гурван хувийг Газрын тосны салбарыг хөгжүүлэх санд төвлөрүүлнэ.	
11	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр	“Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” ¹⁰⁶ хуулийн 4.1.11, “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуулийн 35.6-т	35.6. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь доор дурдсан төлбөр төлнө: 35.6.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр хайгуулын талбайн гектар тутамд эхний жилд 100 төгрөг, хоёр дахь жилд 200 төгрөг, гурав дахь жилд 300 төгрөг, дөрвөөс тав дахь жилд тус бүр 1000 төгрөг; 35.6.2.түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн 0-20 гектар тутамд 5000 төгрөг, 30 гектар хүртэл 8000 төгрөг, 50 гектар хүртэл 10000 төгрөг, 100 гектар хүртэл 15000 төгрөг, 200 гектараас дээш 20000 төгрөг.	Энэ хэсгийг 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн.
12	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	“Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” ¹⁰⁷ хуулийн 33.1	33 дугаар зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 33.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө. 33.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү байна.	

¹⁰⁶Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2014 оны №7-д нийтлэгдсэн.¹⁰⁷Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2014 оны №7-д нийтлэгдсэн.

13	Ус ашигласны төлбөр	Усны тухай хуулийн ¹⁰⁸ 31-т	31 дүгээр зүйл. Ус ашигласны төлбөр 31.1.Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө. 31.2.Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлөх бөгөөд шатлан өсгөх хэлбэрээр төлбөр тооцох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална. 31.3.Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөлийг хуулиар тогтооно.	
14	Ус бохирдуулсны төлбөр	Ус бохирдуулсны төлбөрийн тухай ¹⁰⁹ хуулийн 7-р зүйл	7 дугаар зүйл. Төлбөрийн хэмжээ, түүнийг төвлөрүүлэн зарцуулах 7.1.Төлбөрийн хэмжээг дараах хязгаарт багтаан тогтооно: Бохирдуулах бодис Хэмжих нэгж Төлбөрийн хязгаар /төгрөгөөр/ доод дээд Жинлэгдэх бодис килограмм 100 500 Органик бодис килограмм 100 500 Эрдэс бодис килограмм 50 200 Хүнд металл килограмм 1000 5000 Аюултай бохирдуулах бодис грамм 1000 5000 7.2.Төлбөрийн хэмжээг усны сав газар тус бүрээр усны экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн энэ хуулийн 7.1-д заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно. 7.3.Төлбөрийн орлогыг Байгаль хамгаалах санд төвлөрүүлэн, усыг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна.	
15	Газрын хэвлийг олгох тэмдэгтийн хураамж	"Улсын тэмдэгтийн хураамжийн тухай" хуулийн 39.1.8-т	39.1.Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгох, газрын хэвлийг олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана. 39.1.8.ашигт малтмал олборлоход зориулан газрын хэвлийг олгоход 1 000 000 төгрөг;	

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТАТВАРЫН ОРЛОГО БА ТАТВАРЫН АЧААЛАЛ


Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар нь Монгол Улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 60-70 хувь, ДНБ-ний 20-30 хувь, экспортын бүтээгдэхүүний 90-ээд хувийг бүрдүүлж байгаа тэргүүлэгч томоохон салбар бөгөөд энэ нь манай улсын эдийн засгийн үзүүлэлтүүдэд уул уурхайн салбар шууд нөлөө үзүүлсээр байгааг харуулж байна.

¹⁰⁸www.legalinfo.mn/law/details/8683?lawid=8683

¹⁰⁹Ус бохирдуулсны төлбөр тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны №22 нийтлэгдсэн.

Уул уурхайн үйлдвэрлэл нь эдийн засгийн эрсдэл өндөртэй, нөхөн сэргээлт байгаль орчны тогтвортой байдлыг хангахад их хэмжээний хөрөнгө зарцуулдгаараа бусад салбаруудаас онцлог юм. Иймд хөрөнгө оруулалт татахын тулд татварын орчин тогтвортой байх нь урт хугацаанд салбарыг хөгжүүлэх чухал үзүүлэлт болдог байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын эзлэх хувь




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эрдэс баялгийн үйлдвэрлэлд татварын хувь хэмжээ бага бол шавхагдах эрдэс баялгийн ашиглалтаас улсын төсвийн орлогын хэмжээ багасах ба харин хөрөнгө оруулагчдад татварын дарамт их байвал хөрөнгө оруулалт багасах хандлагатай болдог байна. Иймд төр засгийн болон хөрөнгө оруулагч компаниудын ашиг сонирхлыг уялдуулсан татварын бодлого нэн чухал юм.

Уул уурхайн салбар нь асар их хөрөнгө оруулалтыг шаардаж байдаг ба тухайн оруулсан хөрөнгөтэйгөө дүйцэхүйц хэмжээний эрсдэлийг дагуулж байдаг. Иймд хөрөнгө оруулагчдын хувьд татварын орчин тогтвортой байх нь чухал асуудлуудын нэг болдог.

Ашигт малтмалын газраас уул уурхайн салбарын 2007-2013 оны татварын ачааллын түвшинг тооцоолон гаргасныг зурагт үзүүлбэл:

Уул уурхайн салбарын татварын ачаалал /хувиар/



Эх сурвалж: Ашигт малтмалын газар /2014 оны статистик мэдээлэл хараахан гараагүй байгаа болно./


Үүнд: 2007 онд 37 хувь, 2008 онд 25 хувь, 2009 онд 23 хувь болж буурсан бол 2010 онд 34 хувь болж өсөж, 2011 онд 29 хувь, 2012 онд 21 хувь болж буурсан бол 2013 онд эргээд өсөж 32 хувьд хүрсэн байна. Энэ нь 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хуулиар өөрчлөлт орж алтны босго үнийг 1 унци алтны үнэ 850 ам доллар болгож өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2009 онд татварын ачаалал буурсан ба ихэнх алт олборлогч аж ахуйн нэгжүүд Монгол банкинд тушаах алтны хэмжээ багассантай холбоотой байна. 2011 онд үнийн өсөлтийн албан татвар хүчингүй болж Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 5-д заасан нэмж ногдуулах

өсөн нэмэгдэх ашигт малтмалын төлбөрийн хувь хэмжээг тогтоосноор татварын ачаалал өссөн байна.

2011 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар хүчингүй болсон нь 2011-2012 оны татварын ачаалал бууруулсантай шууд хамааралтай байна¹¹⁰.

2012 болон 2013 оны байдлаар уул уурхайн салбарын гол нэр төрлийн ашигт малтмал тусбүрээр татварын ачааллын түвшинг тооцсоныг харуулав.

Татварын ачааллын түвшин



Эх сурвалж: Ашигт малтмалын газар

Зургаас харахад 2012 онд зэсийн баяжмалд ногдох татварын ачаалал хамгийн их буюу 34 хувьтай байсан бол 2013 онд 42 хувь, жоншны татварын ачаалал хамгийн бага буюу 4 хувьтай байсан бол 2013 онд огцом нэмэгдэж 20 хувьд хүрсэн байна. Үүнийг ашигт малтмалын өсөн нэмэгдэх нөөцийн төлбөрийн хэмжээ зэсийн баяжмалд харьцангуй өндрөөр тогтоосноор тайлбарласан байна.

Алт болон нүүрсний татварын ачаалал 2013 онд өмнөх оноос 1-3 хувиар буурч, татварын ачаалал 18-20 хувьтай байна.

Ашигт малтмалын газраас хийсэн судалгаагаар татварын хамгийн өндөр ачаалал нь зэсэн дээр байгаа нь Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцох хувь нь өндөр, мөн алтны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс авах татварын хэмжээ өндөр зэргээс шалтгаалан татварын ачаалал өндөр гарахад нөлөөлж байна хэмээн дүгнэсэн байна. Мөн судалгаанд өсөн нэмэгдэх нөөцийн төлбөрийн сөрөг үр дагавар нь алт, зэсийн бүтээгдэхүүнд ногдуулах татварын хэмжээ эрс нэмэгдсэн нь зах зээлийн үнийн өсөлттэй шууд холбоотой гэж үзсэн байна. Үүнээс үүдэн алтны олборлолтын хэмжээ эрс буурч зэсийн орд газруудыг ашиглах, эхлүүлэх боломж үндсэндээ хаагдсан байна¹¹¹.

Бусад ашигт малтмал болох жонш, уулын гянтболдын баяжмал, төмөр, барилгын материалын татварын ачааллын дундаж түвшин 2012 онтой харьцуулахад 5-16 хувиар тус тус нэмэгдсэн байна.

¹¹⁰Ашигт малтмалын газар, Монгол Улсын уул уурхайн салбарын татварын ачаалал ба өөрчлөлт, шинэчлэлтийн судалгаа, 2013 он.

¹¹¹Ашигт малтмалын газар, Монгол Улсын уул уурхайн салбарын татварын ачаалал ба өөрчлөлт, шинэчлэлтийн судалгаа, 2013 он.

Уул уурхайн салбарын орлого сүүлийн 5 жилд төсвийн орлогын 20 орчим хувийг бүрдүүлж ирсэн бөгөөд 2010 онд хамгийн өндөр буюу 28 хувьд хүрч байсан бол сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч, 2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр хамгийн бага түвшинд буюу 14 хувь байхаар байна.



Уул уурхайн салбараас улсын төсөвт оруулсан нийт орлогын хэмжээ (сая.төг)

Татвар, төлбөрүүд	2008	2009	2010	2011	2012	2013
АМНА төлбөр	98 141.3	121 358.4	235 358.8	532 564.85	684 544.1	461 089.4
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	119 099.4	132 466.8	213 427.4	299 652.34	277 875.6	184 924.3
НӨАТ	31 490.9	24 321.5	43 636.1	212 980.1	136 778.7	107 182.0
Тусгай зөвшөөрлийн төлбөр	4 177.8	3 323.9	56 789.6	3 950.97	7 165.4	7 143.2
Газар ашигласны төлбөр	10 089.2	19 952.7	11 465.9	12 957.9	12 086.0	14 098.8
Ус ашигласны төлбөр	2 400.7	2 493.6	3 776.3	3 552.5	11 191.4	37 959.34
ТХӨЯМ-ын татвар	189.9	1 020.7	548.2	1 921.2	965.5	2284.6
Гадаад ажилчдын ажлын байрны төлбөр	3 377.6	3 078.2	4 865.2	13 907.7	8 020.1	7 297.3

Үл хөдлөх хөрөнгийн татвар	32 682.5	2 647.7	2 913.6	3 780.0	4 321.9	13 172.3
Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын нөхөн төлбөр	5 035.1	11 835.0	4 635.9	2 276.4	2 465.9	1 975.9
Бусад татвар /гааль агаарын бохирдол, төрийн өмчийн дивидент, ХАОАТ г.м/	419 613.4	217 638.2	466 204.8	-	-	63 403.7
Нийт татварын хэмжээ	726 297.9	540 136.9	1 043 622.0	1 087 543.9	1 145 414.5	1 301 431.2

Сүүлийн 5 жилд (2008-2013) уул уурхайн салбарын татварын орлогын дундаж өсөлт нь 13 хувь байсан бол уул уурхайн бус салбарын татварын өсөлт 31 хувь байсан.

Харин 2014 оны хувьд уул уурхайн салбар өсөлтөө хадгалж 14 хувиар өсөх төсөөлөлтэй байгаа бол уул уурхайн бус салбарын хувьд 7 хувиар буурах төсөөллийг Сангийн яамнаас гаргасан байна.¹¹² Төсөвт оруулсан орлого нэмэгдсэн гол нөлөө нь нүүрсний бүтээгдэхүүний хэмжээ, ус ашигласны төлбөр, жижиг үнээс хамаарч өсөн нэмэгдэх татвар авдаг болсон зэрэг нь нөлөөлсөн байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹¹²Ашигт малтмалын газар, Монгол Улсын уул уурхайн салбарын татварын ачаалал ба өөрчлөлт, шинэчлэлтийн судалгаа, 2013 он.

Уул уурхайн салбараас 2013 онд улсын нэгдсэн төсөвт оруулсан нийт орлогын хэмжээ (сая.төг)(Татварын ерөнхий газрын мэдээгээр)

№	Татварын төлбөрүүд	Алт	Зэс,молибдени	Бар/мат	Төмөр	Жонш	Нуурс	Гянтболд	Бусад	Нийт
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	15,865,126.5	69,418,588.2	1,487,609.4	15,709,257.0	2,654,105.4	50,517,140.8	3,296.1	23,248,306.5	178,903,409.9
2	Бараа, үйлчилгээний НӨАТ	846,144.7	1,791,008.4	4,211,418.4	1,451,784.1	98,932.9	8,826,244.7	24,432.5	52,163,891.0	69,413,856.7
3	Нөөц ашигласны төлбөр	18,208,680.9	102,255,349.4	185,227.2	29,995,055.2	2,926,940.5	137,612,331.3	7,657.6	22,332,573.2	313,523,815.3
4	Үнийн өсөлтийн албан татвар	77,680.2							2,614.5	80,294.7
5	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	6,369,642.3	14,599,500.2	1,777,066.8	1,874,539.9	568,169.9	8,209,739.5	14,760.2	20,885,226.2	54,298,635.0
6	Суутлагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	171,390.6	86,488.1	68,716.5	1,347,928.2	22,686.6	325,295.8	2,254.3	921,571.3	2,946,331.4
Уг журамд байгаль орчны эсрэг хэв журмын зөрчилд ногдуулах мөнгөн торгуулийн болон сануулах арга хэмжээ, прокурорт шилжүүлэн өгөх, давж заалдсаны дараах процесс зэргийг тодорхойлсноос гадна санамсаргүй (хайнга) үйлдэл, хураах болон өмчлөлөөс салгахад баримтлах үндсэн зарчмыг тусгажээ. Мөн нэг удаагийн (дан) болон олон удаагийн (давтан) гэмт үйлдэл, тодорхой хүмүүсийн бүлэг (эвсэл холбоод)-ийн талаар тусгайлан зааварлажээ.

Байгаль орчны эсрэг хэв журмын зөрчлүүдийг доорх салбаруудад ангилан хувааж үзжээ. Үүнд:

- Хог хаягдал зайлуулах,
- Хөрс хамгаалалт ба хур хаягдал¹⁶⁰,
- Эмисийн хамгаалалт¹⁶¹ (Агаарын бохирдол),
- Усны ай савын хамгаалалт¹⁶²,
- Байгаль хамгаалалт болон газар нутгийн тордолт¹⁶³,
- Гений инженерчлэл¹⁶⁴.

Журамд мөнгөн торгуулийн хэмжээг 20-50,000 еврогийн хооронд байхаар тогтоожээ.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Natural Environment conservation act. <http://elaw.klri.re.kr/>
- ФЗ “О защите окружающей среды”. <http://base.garant.ru/>
- Кодекс об административных правонарушениях (КоАП РФ). <http://base.garant.ru/>
- Уголовный кодекс (УК РФ). <http://base.garant.ru/>
- БНХАУ-ын байгаль орчныг хамгаалах тухай хууль. www.china.org.cn/english/
- БНХАУ-ын ашигт малтмалын тухай хууль. www.lehmanlaw.com/
- Методические указания по оценке и возмещению вреда, нанесенного окружающей природной среде в результате экологических правонарушений. base.consultant.ru
- Постановление Правительства РФ от 26.11.2007 г. N 273 «Об утверждении такс для исчисления размера взысканий за ущерб, причиненный лесному фонду и не входящим в лесной фонд лесам нарушением лесного законодательства РФ». base.consultant.ru
- Jennifer Norberry., australian pollution laws ¾ offences, penalties and regulatory agencies. www.aic.gov.au/
- Protection of the Environment Operation Act 1997. www.epa.nsw.gov.au/
- Холбооны байгаль хамгаалах тухай хууль - Bundesumweltschutzgesetz. www.schleswig-holstein.de/
- “Байгаль орчин хамгаалах” сэдэвт мөнгөн торгуулийн каталог - BuYgeldkatalog „Umweltschutz“. www.stmuv.bayern.de/

¹⁶⁰Altlasten

¹⁶¹Immissionsschutz

¹⁶²Gewässerschutz

¹⁶³Naturschutz und Landschaftspflege

¹⁶⁴Gentechnik

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН АСУУДЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА*Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа***АГУУЛГА****Нэг. Тойм мэдээлэл****Хоёр. Хавсралт мэдээлэл**

- 2.1 Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААН, байгууллагын тоо
- 2.2 Төрөөс ЖДҮ-г дэмжих зээл авсан аж ахуйн нэгж, иргэдийн тоо
- 2.3 Жижиг дунд бизнес эрхлэгчдийн татвар төлөлтийн хувь хэмжээ
- 2.4 Гаалийн татвараас чөлөөлөгдсөн тоног төхөөрөмж авсан аж ахуйн нэгж, иргэдийн тоо
- 2.5 Татан буугдсан аж ахуйн нэгжийн тоо, үйл ажиллагааны чиглэлээр

Нэг. ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

- Аж ахуйн нэгжийн ажиллагсадын тоо болон тухайн жилийн борлуулалтын орлого нь харилцан адилгүй байх бөгөөд 2011-2013 оны байдлаар аж ахуйн нэгжийн ажиллагсадын тоо, борлуулалтын орлогыг он тус бүрээр гаргалаа. Мөн энэхүү судалгаанд төрийн үйлчилгээ болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний хувьд борлуулалтын орлого байхгүй учир үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн тоонд оруулаагүй болно.
- Түүнчлэн ЖДҮ эрхлэгчдийг бүртгэлжүүлэх асуудлыг 2011 оноос эхлэн эрчимтэй хэрэгжүүлж эхэлсэн хэдий ч ЖДҮ эрхлэгч хуулийн этгээдийг Улсын бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгэж, харин иргэнийг Татварын Ерөнхий газарт бүртгэж байгаатай холбоотойгоор ЖДҮ эрхлэгчдийн хувьд нэгдсэн бүртгэлийн систем болон тоон мэдээлэл хараахан бүрдээгүй байгаа бөгөөд ихээхэн удаашралтай байгаа талаар ЖДҮХГ-ийн мэргэжилтэнтэй холбогдож мэдээлэл авсан. Дээрх газруудад бүртгэлд хамрагдаагүй, ЖДҮ дэмжих сангаас хөнгөлөлттэй зээл аваагүй олон ЖДҮ эрхлэгч иргэн болоод хуулийн этгээдүүд байна.
- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчидэд олгосон хөнгөлөлттэй зээлийн хэмжээг орон нутгийн зээл болон бүсийн зээлийн ангиллаар гаргасны зэрэгцээ, ЖДҮ-ийг хөгжүүлэх санд ирүүлсэн төслийн хүрээнд шинээр бий болсон ажлын байрны тоог улсын хэмжээнд 2009-2014 оны байдлаар гаргасан болно.
- Төрөөс ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, төрийн бодлогыг хэрэгжүүлсний дүнд ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хэмжээ болон шинээр бий болсон ажлын байр улсын хэмжээнд жил тутам нэмэгдэж байна. Тухайлбал, 2011 онд 175 013 /сая.төг/ хөнгөлөлттэй зээлийг олгож, 9604 шинээр ажлын байр бий болсон бол 2014 онд 357 298 /сая.төг/ хөнгөлөлттэй зээл олгож, 28 586 ажлын байрыг шинээр бий болгосон байна.

Хоёр. ХАВСРАЛТ МЭДЭЭЛЭЛ

2.1 Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААН, байгууллагын тоо

№	Үзүүлэлт	2011		2012		2013	
		Бүртгэлтэй	Үйл ажиллагаа явуулж байгаа	Бүртгэлтэй	Үйл ажиллагаа явуулж байгаа	Бүртгэлтэй	Үйл ажиллагаа явуулж байгаа
1	Ажиллагсдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо	6 186	4 338	7 847	4 705	8 596	4 425
2	Ажиллагсдын тоо нь 149-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо	15 993	7 962	27 234	10 612	29 720	11 486
3	Ажиллагсдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиглэн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо	10 098	7 541	12 400	8 524	13 404	8 890
4	Ажиллагсдын тоо нь 49-өөс дээшгүй бөгөөд 1.0 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоо	23 590	16 765	30 399	17 731	35 351	19 997
БҮГД		55 867	36 606	77 880	41 572	87 071	44 798

* Төрийн байгууллага болон төрийн бус байгууллагыг хамруулаагүй болно.
Эх сурвалж: ҮСХ

ХҮСНЭГТ 2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР ЭРХЛЭГЧЭЭР БҮРТГҮҮЛСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭД

№	Он	Тоо
1	2011	20
2	2012	189
3	2013	897
Нийт		1106

Эх сурвалж: Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар

Жич: 2010 оноос өмнө жижиг дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгүүлсэн хуулийн этгээд байхгүй байна.

2.2 Төрөөс ЖДҮ-г дэмжих зээл авсан аж ахуй нэгж, иргэдийн тоо

ХҮСНЭГТ 3. 2009 онд ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас ЖДҮ эрхлэгчдэд олгосон хөнгөлөлттэй зээлийн мэдээ

/бүс нутгийн болон орон нутгийн зээлийн ангиллаар/

№	Аймаг	Орон нутгийн зээл				Бүсийн зээл				2009 онд нийт			Ажлын байр	
		төсвийн тоо		Шинэ /м.н.т./	Хад	төсвийн тоо		Шинэ /м.н.т./	Хад	төсвийн тоо	Зээлийн хэмжээ /м.н.т./	Шинэ	Хад	
		төсвийн тоо	Зээлийн хэмжээ /м.н.т./			төсвийн тоо	Зээлийн хэмжээ /м.н.т./							
1	Архангай	70	845,000	173	1	300,000	21	22	71	1,145,000	194	22		
2	Баян-Өлгий	83	763,000	361	1	400,000	31	39	84	1,163,000	392	39		
3	Баянхонгор	53	778,050	182					53	778,050	182	0		
4	Булган	57	807,993	562					57	807,993	562	0		
5	Говь-Алтай	82	801,690	241					82	801,690	241	0		
6	Говьсүмбэр	64	737,650	78					64	737,650	78	0		
7	Дархан-Уул	37	763,250	134	3	1,420,000	90	103	40	2,183,250	224	103		
8	Дорнод	71	604,180	113	2	120,000	24	24	73	724,180	137	24		
9	Дорноговь	61	783,850	82					61	783,850	82	0		
10	Дундговь	46	735,758	113					46	735,758	113	0		
11	Завхан	81	780,000	114					81	780,000	114	0		
12	Орхон	46	780,000	107	2	1,000,000	68	88	48	1,780,000	175	88		
13	Өмнөговь	48	645,971	99					48	645,971	99	0		
14	Өвөрхангай	77	808,462	330	1	400,000	60	78	78	1,208,462	390	78		
15	Увс	79	828,400	117					79	828,400	117	0		
16	Сүхбаатар	54	780,000	236					54	780,000	236	0		
17	Сэлэнгэ	55	727,600	158	4	2,780,000	99	89	59	3,507,600	257	89		
18	Төв	128	906,620	192	1	100,000	7	5	129	1,006,620	199	5		
19	Ховд	80	782,000	225					80	782,000	225	0		
20	Хөвсгөл	70	745,600	391					70	745,600	391	0		
21	Хэнтий	51	716,100	155					51	716,100	155	0		
22	Улаанбаатар	211	9,668,180	1092	19	6,320,000	501	268	230	15,988,180	1593	268		
	БҮГД	1604	25,789,354	5,255	34	12,840,000	901	716	1,638	38,629,354	6,156	716		

Эх сурвалж: Хөдөлмөрийн яам, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

ХҮСНЭГТ 4. 2010 ОНД ЖДҮ-ИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЖДҮ ЭРХЛЭГЧДЭД ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ
/бүс нутгийн болон орон нутгийн зээлийн ангиллаар/

№	Аймаг	2010 он									
		Орон нутгийн зээл		Бүсийн зээл		Хад		Шинэ		2010 онд нийт	
		төслийн тоо	/₮·нвм/ €€жмєх нийлээс	төслийн тоо	/₮·нвм/ €€жмєх нийлээс	Хад	Шинэ	төслийн тоо	/₮·нвм/ €€жмєх нийлээс	Шинэ	Хад
1	Архангай	86	805,700	2	450,000	168	207	88	1,255,700	288	267
2	Баян-Өлгий	152	815,600			239	162	152	815,600	162	239
3	Баянхонгор	76	919,980			333	196	76	919,980	196	333
4	Булган	44	649,000	2	645,000	87	106	46	1,294,000	140	136
5	Говь-Алтай	61	645,600			108	177	61	645,600	177	108
6	Говьсүмбэр	39	652,100			62	142	39	652,100	142	62
7	Дархан-Уул	92	913,700	2	600,000	229	155	94	1,513,700	165	312
8	Дорнод	73	724,200	1	70,000	131	222	74	794,200	232	142
9	Дорноговь	61	765,046			137	199	61	765,046	199	137
10	Дундговь	38	527,200			49	76	38	527,200	76	49
11	Завхан	76	621,600	2	400,000	127	121	78	1,021,600	149	171
12	Орхон	25	695,000	7	852,000	113	89	32	1,547,000	188	213
13	Өмнөговь	38	690,510			60	60	39	890,510	60	60
14	Өвөрхангай	75	689,500	2	490,000	149	95	77	1,179,500	125	249
15	Увс	65	812,950	2	580,000	153	151	67	1,392,950	172	198
16	Сүхбаатар	46	610,800			31	85	46	610,800	85	31
17	Сэлэнгэ	61	698,500	4	1,200,000	246	286	65	1,898,500	356	338
18	Төв	49	641,300	8	1,910,000	139	245	57	2,551,300	406	440
19	Ховд	114	916,000	1	400,000	316	159	115	1,316,000	187	329
20	Хөвсгөл	81	881,500			199	311	81	881,500	311	199
21	Хэнтий	20	650,000	2	200,000	125	106	22	850,000	137	155
22	Улаанбаатар	151	6,950,010	49	9,940,000	1126	524	199	16,690,010	1667	2212
	БҮГД	1523	22,275,796	84	17,737,000	4327	3874	1607	40,012,796	5620	6380

Эх сурвалж: Хөдөлмөрийн яам, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

ХҮСНЭГТ 5. 2011 ОНД ЖДҮ-ИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЖДҮ ЭРХЛЭГЧДЭД ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

/бүс нутгийн болон орон нутгийн зээлийн ангиллаар/

№	Аймаг	2011 он											
		Орон нутгийн зээл		Шнэ	Хад	Бүсийн зээл		Шнэ	Хад	2011 онд нийт		Ажлын байр	
		төслийн тоо	сээлийн хэмжээ /т.нвм./			төслийн тоо	сээлийн хэмжээ /т.нвм./			төслийн тоо	сээлийн хэмжээ /т.нвм./	Шнэ	Хад
1	Архангай	50	1,467,900	153	80	2	1,210,000	80	12	52	2,677,900	233	92
2	Баян-Өлгий	92	1,718,548	613	515	2	180,000	38	13	94	1,898,548	651	528
3	Баянхонгор	52	1,630,783	175	146	1	500,000	12	0	53	2,130,783	187	146
4	Булган	46	1,271,016	150	82	2	600,000	65	4	48	1,871,016	215	86
5	Говь-Алтай	52	1,178,250	129	155					52	1,178,250	129	155
6	Говьсүмбэр	24	682,500	68	34					24	682,500	68	34
7	Дархан-Уул	89	2,891,092	215	271	8	9,200,000	766	100	97	12,091,092	981	371
8	Дорнод	85	1,758,586	224	160	2	630,000	60	0	87	2,388,586	284	160
9	Дорноговь	20	842,000	63	90					20	842,000	63	90
10	Дундговь	33	1,267,150	91	147	1	80,000	18	16	34	1,347,150	109	163
11	Завхан	90	1,999,500	225	206					90	1,999,500	225	206
12	Орхон	46	1,920,422	46	74	3	435,000	82	40	49	2,355,422	128	114
13	Өмнөговь	27	872,500	31	60					27	872,500	31	60
14	Өвөрхангай	61	2,079,600	331	307	1	100,000	16	5	62	2,179,600	347	312
15	Увс	95	2,880,000	174	173	2	7,130,000	28	23	97	10,010,000	202	196
16	Сүхбаатар	31	1,049,500	116	87	1	800,000	20	18	32	1,849,500	136	105
17	Сэлэнгэ	20	387,800	80	54	7	1,408,500	208	54	27	1,796,300	288	108
18	Төв	25	663,500	131	86	2	1,600,000	42	12	27	2,263,500	173	98
19	Ховд	45	1,421,000	141	144	1	400,000	7	0	46	1,821,000	148	144
20	Хөвсгөл	73	1,714,400	285	225	1	500,000	50	18	74	2,214,400	335	243
21	Хэнтий	27	702,700	56	36	1	100,000	5	0	28	802,700	61	36
22	Улаанбаатар	443	26,957,050	1373	1857	143	92,784,100	3237	2171	586	119,741,150	4610	4028
	БҮГД	1526	57,355,797	4870	4989	180	117,657,600	4734	2486	1706	175,013,397	9604	7475

Эх сурвалж: Хөдөлмөрийн яам, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

ХҮСНЭГТ 6. 2012 ОНД ЖДҮ-ИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЖДҮ ЭРХЛЭГЧДЭД ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ
/бүс нутгийн болон орон нутгийн зээлийн ангиллаар/

2012 он													
№	Аймаг	Орон нутгийн зээл		Шнэ	Хад	Бүсийн зээл		Шнэ	Хад	2012 онд нийт		Ажлын байр	
		төслийн тоо	төс.т./н.нвм/сн			төслийн тоо	төс.т./н.нвм/сн			төслийн тоо	төс.т./н.нвм/сн	Шнэ	Хад
		1	Архангай	2	85,000	8	3					2	85,000
2	Баян-Өлгий	1	15,000	2						1	15,000	2	0
3	Баянхонгор									0	0	0	0
4	Булган	1	10,000		1					1	10,000	0	1
5	Говь-Алтай	3	230,000	30	22					3	230,000	30	22
6	Говьсүмбэр	1	50,000	6						1	50,000	6	0
7	Дархан-Уул	1	50,000	5	7	1	2,070,000	0	35	2	2,120,000	5	42
8	Дорнод					2	2,200,000	38	0	2	2,200,000	38	0
9	Дорноговь	2	28,000	6	5					2	28,000	6	5
10	Дундговь									0	0	0	0
11	Завхан									0	0	0	0
12	Орхон	2	51,600	6	8					2	51,600	6	8
13	Өмнөговь	1	8,000	1		1	100,000	4	4	2	108,000	5	4
14	Өвөрхангай									0	0	0	0
15	Увс									0	0	0	0
16	Сүхбаатар									0	0	0	0
17	Сэлэнгэ					2	103,000	4	3	2	103,000	4	3
18	Төв					2	250,000	28	35	2	250,000	28	35
19	Ховд	1	50,000	18						1	50,000	18	0
20	Хөвсгөл	3	30,000	9	5					3	30,000	9	5
21	Хэнтий	3	60,000	3	7					3	60,000	3	7
22	Улаанбаатар	47	3,410,100	155	264	28	16,779,000	479	454	77	20,189,100	634	718
	БҮГД	68	4,077,700	249	322	36	21,502,000	553	531	104	25,579,700	802	853

Эх сурвалж: Хөдөлмөрийн яам, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

ХҮСНЭГТ 7. 2013 ОНД ЖДҮ-ИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЖДҮ ЭРХЛЭГЧДЭД ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ
/бүс нутгийн болон орон нутгийн зээлийн ангиллаар/

№	Аймаг	2013 он											
		Орон нутгийн зээл		Шинэ	Хад	Бусийн зээл		Шинэ	Хад	2013 онд нийт		Ажлын байр	
		төсвийн	т/х, н/х/м/х нийлээс			төсвийн	т/х, н/х/м/х нийлээс			төсвийн	т/х, н/х/м/х нийлээс	төсвийн	т/х, н/х/м/х нийлээс
1	Архангай	13	410,000	44	11	1	150,000	10	1	14	560,000	54	12
2	Баян-Өлгий	20	475,000	126	83					20	475,000	126	83
3	Баянхонгор	20	502,000	134	38	1	400,000	6	25	21	902,000	140	63
4	Булган	16	503,500	77	31	1	150,000	15	7	17	653,500	92	38
5	Говь-Алтай	9	500,000	32	15					9	500,000	32	15
6	Говьсүмбэр	4	200,000	20	18					4	200,000	20	18
7	Дархан-Уул	18	457,700	144	44	4	1,530,000	140	69	22	1,987,700	284	113
8	Дорнод	12	450,500	68	32	6	1,520,000	93	37	18	1,970,500	161	69
9	Дорноговь	13	498,000	79	23					13	498,000	79	23
10	Дундговь	16	500,000	122	80					16	500,000	122	80
11	Завхан	30	349,000	96	27	4	2,620,000	68	59	34	2,969,000	164	86
12	Орхон	12	549,000	87	89	2	220,000	30	21	14	769,000	117	110
13	Өмнөговь	12	460,000	54	35					12	460,000	54	35
14	Өвөрхангай	10	491,000	39	33	2	380,000	45	39	12	871,000	84	72
15	Увс	16	495,000	104	69					16	495,000	104	69
16	Сүхбаатар	18	500,000	61	58					18	500,000	61	58
17	Сэлэнгэ	18	500,000	70	30	5	3,096,000	160	24	23	3,596,000	230	54
18	Төв	19	578,000	88	136	5	3,961,000	177	19	24	4,539,000	265	155
19	Ховд	17	500,000	85	59	1	150,000	10	10	18	650,000	95	69
20	Хөвсгөл	21	515,000	154	58	1	200,000	8	10	22	715,000	162	68
21	Хэнтий	21	485,000	150	77					21	485,000	150	77
22	Улаанбаатар	117	3,782,100	623	526	97	44,823,100	2533	1272	214	48,605,200	3156	1798
	БҮГД	452	13,700,800	2457	1572	130	59,200,100	3295	1593	582	72,900,900	5752	3165

Эх сурвалж: Хөдөлмөрийн яам, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

ХҮСНЭГТ 8. 2014 ОНД ЖДҮ-ИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЖДҮ ЭРХЛЭГЧДЭД ОЛГОСОН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

/бүс нутгийн болон орон нутгийн зээлийн ангиллаар/

№	Аймаг	2014 он										2009-2014 онд нийт			Ажлын байр	
		Бүсийн зээл		Шуэ	Хад	2014 онд нийт		Шуэ	Хад	төсвийн тоо	ХЭМЖЭХ НҮЙЛСЭЭ /мн.т/	төсвийн тоо	ЗЭЭЛИЙН НҮЙЛСЭЭ /т.н.мн/	Шуэ	Хад	
		төсвийн тоо	ЗЭЭЛИЙН НҮЙЛСЭЭ /мн.т/			төсвийн тоо	ЗЭЭЛИЙН НҮЙЛСЭЭ /мн.т/									
1	Архангай	0	0	0	0	0	0	0	0	0	0	227	5,723,600	777	396	
2	Баян-Өлгий															
3	Баянхонгор	0	0	0	0	0	0	0	0	0	0	351	4,367,148	1,333	889	
4	Булган	0	0	0	0	0	0	0	0	0	0	203	4,730,813	705	542	
5	Говь-Алтай															
6	Говьсүмбэр															
7	Дархан-Уул	1	200,000	26	15	1	200,000	26	15	256	20,095,742	1,685	8,201,466	857	399	
8	Дорнод	1	124,000	5	4	1	124,000	5	4	255	2,916,896	429	2,916,896	429	255	
9	Дорноговь															
10	Дундговь															
11	Завхан	2	140,000	16	21	2	140,000	16	21	285	6,910,100	668	3,110,108	420	292	
12	Орхон	1	200,000	16	14	1	200,000	16	14	146	6,703,022	630	2,976,981	249	159	
13	Өмнөговь															
14	Өвөрхангай	0	0	0	0	0	0	0	0	229	5,438,562	946	11,301,400	1,192	615	
15	Увс	1	140,000	6	15	1	140,000	6	15	260	12,866,350	601	3,740,300	518	194	
16	Сүхбаатар															
17	Сэлэнгэ	3	400,000	57	23	3	400,000	57	23	179	10,610,420	1,071	11,301,400	1,071	733	
18	Төв	0	0	0	0	0	0	0	0	239	4,619,000	673	4,586,500	1,208	515	
19	Ховд	0	0	0	0	0	0	0	0	250	2,913,800	506	225,171,640	12,186	9,337	
20	Хөвсгөл	0	0	0	0	0	0	0	0	125	2,913,800	506	225,171,640	12,186	9,337	
21	Хэнтий															
22	Улаанбаатар	30	3,958,000	526	313	30	3,958,000	526	313	1,336	357,298,147	28,586	357,298,147	28,586	18,994	
БҮГД		39	5,162,000	652	405	39	5,162,000	652	405	5,676	357,298,147	28,586	357,298,147	28,586	18,994	

Эх сурвалж: Хөдөлмөрийн яам, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан

2.3 Жижиг дунд бизнес эрхлэгчдийн татвар төлөлтийн хувь хэмжээ

ХҮСНЭГТ 9. ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО ТАТВАР ТӨЛӨЛТИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

Борлуулалтын орлого	2011 он			2012 он			2013 он		
	ТТТоо	Борлуулалтын орлого	Төлсөн татвар	ТТТоо	Борлуулалтын орлого	Төлсөн татвар	ТТТоо	Борлуулалтын орлого	Төлсөн татвар
0-1 сая	31065	1,691,782.6	12,470,884.4	34061	1,702,525.8	10,395,434.4	33459	1,712,828.1	37,802,829.3
1-2 сая	2118	3,199,898.9	465,988.2	1984	2,991,798.4	787,213.1	1943	2,915,977.2	2,676,344.3
2-3 сая	1645	4,113,401.4	1,326,202.1	1649	4,155,564.8	538,579.4	1583	3,962,779.0	966,058.6
3-5 сая	2759	11,072,449.0	792,364.7	2663	10,625,228.4	1,214,246.6	2484	10,017,788.0	1,449,569.9
5-10 сая	7610	61,088,388.1	2,401,884.9	7987	64,516,940.8	2,960,613.9	8128	65,807,468.9	4,236,159.3
10-15 сая	2090	25,773,735.6	1,486,674.9	2213	27,270,311.5	1,733,253.9	2239	27,814,231.6	2,338,593.2
15-20 сая	1319	22,942,970.1	1,264,530.7	1563	27,157,125.1	1,399,889.5	1712	29,824,650.1	2,167,071.2
20-50 сая	4572	150,147,395.5	8,553,958.0	5202	170,773,282.3	8,829,674.5	5785	189,716,689.6	9,753,856.3
50-100 сая	3095	220,218,097.7	9,070,445.5	3548	255,430,936.8	13,637,755.6	4002	287,791,757.4	11,716,255.8
100-150 сая	1514	185,525,081.6	6,782,429.5	1779	217,979,441.3	10,144,554.9	2096	257,305,676.5	11,069,425.3
150-200 сая	948	163,470,637.7	5,552,359.0	1133	196,095,381.5	9,382,185.8	1340	232,376,860.8	9,082,908.0
200-250 сая	643	143,858,924.1	4,803,385.2	803	179,770,735.5	7,786,398.8	894	199,447,296.4	8,618,512.9
250-1 тэрбум	2854	1,429,255,608.2	53,160,444.2	3554	1,787,326,909.2	69,737,174.6	4031	2,026,694,433.9	68,336,150.2
1-1.5 тэрбум	519	636,865,353.6	22,347,912.2	604	737,722,097.7	30,940,749.0	685	844,202,749.0	29,845,060.7

Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

2.4 Гаалийн татвараас чөлөөлөгдсөн тоног төхөөрөмж авсан аж ахуйн нэгж, иргэдийн тоо

ХҮСНЭГТ 10. 401, 402, 403, 421, 461, 462, 463 ЗЭРЭГ ГОРИМУУДААР ГААЛИЙН ТАТВАР, НӨАТ-ААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ БАРААНД БҮРДҮҮЛЭЛТ ХИЙСЭН ААН, ИРГЭДИЙН ТОО

Он	Иргэдийн тоо	Аж ахуйн нэгжийн тоо
2010	160	1029
2011	260	1152
2012	261	1276
2013	257	1313
2014-эхний хагас жил	97	559

Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газар

2.5 Татан буугдсан аж ахуйн нэгжийн тоо, үйл ажиллагааны чиглэлээр

ХҮСНЭГТ 11. ТАТАН БУУГДСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД

№	Үйл ажиллагааны чиглэл	Татан буугдсан тоо				
		2009	2010	2011	2012	2013
1	Гадаад худалдаа	344	269	100	75	253
2	Хүнс, барааны дэлгүүр	108	39	13	15	37
3	Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ	32	16	2	9	20
4	Барилга угсралт, барилгын завсар, засал чимэглэл, барилгын материалын үйлдвэрлэл, худалдаа	44	33	14	8	21
5	Аялал жуулчлал	18	21	9	8	11
6	Цайны газар, зоогийн газрын үйлчилгээ	21	20	5	6	14
7	Хэвлэх үйлдвэр, хэвлэлийн эх бэлтгэл	3	4	2	2	4
8	Мал аж ахуй	11	9	2	1	4
9	Ойн аж ахуй, мод бэлтгэл	4	1	0	0	3
10	Компьютер, программ хангамжийн үйлчилгээ	14	7	0	1	3
11	Газар тариалан эрхлэх, үр тариа, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах	40	12	2	15	17
12	Үйл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлал, түрээс	7	2	1	0	8
13	Оёдлын үйлдвэрлэл, худалдаа	3	1	5	1	7
14	Бизнесийн зөвлөгөө, зуучлал	5	3	1	7	7
15	Мод, модон эдлэлийн үйлдвэрлэл	4	2	2	0	3
16	Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5	2	0	2	1
17	Үсчин, гоо сайхны үйлчилгээ	4	4	1	0	2
18	Хадгаламж зээлийн үйл ажиллагаа	14	14	3	2	1
19	Шатахууны жижиглэн худалдаа	8	2	0	2	2
20	Автомашин угаалга, засвар үйлчилгээ	10	8	3	2	5
21	Мал эмнэлгийн үйлчилгээ	5	8	2	3	1
22	Талх нарийн боов, үйлдвэрлэл	2	5	1	0	1
23	Хууль эрх зүйн зөвлөгөө өгөх	1	1	3	2	0
24	Ашигт малтмалын хайгуул хийх	6	1	2	0	2
25	Бусад	106	75	29	43	87
	НИЙТ	819	559	202	204	514

Эх сурвалж: Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар

2

БҮЛЭГ

НИЙГМИЙН БОДЛОГО

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЗАРИМ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ, ХӨНГӨЛӨЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Р.Хатанбаатар, А.Пагма, Д.Жигваагүнсэл, Р.Нургүл

1. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

1.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх эрх зүйн зохицуулалт

- ОХУ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай”¹⁶⁵ хуулийн 20-24 дүгээр зүйлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн баталгааг хангах дараах арга хэмжээг хуульчилсан. Үүнд:
- 100-аас дээш ажилтантай байгууллагад ажилтны дундаж тоонд хувь тэнцүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулах квот тогтоох (2 хувиас доошгүй, 4 хувиас дээшгүй),
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэргэжлээрээ хөдөлмөрлөх боломжтой ажлын байрны нөөцийг бий болгох,
- Аж ахуйн нэгж, байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн онцлогт тохируулан зохион байгуулсан, нэмэлт тоног төхөөрөмж суурилуулсан тусгай ажлын байр бий болгох явдлыг дэмжих,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн нөхөн сэргээх хөтөлбөрийнх нь дагуу тэдний хөдөлмөрлөх нөхцөлийг бий болгох,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд аж ахуйн үйл ажиллагаа явуулах, эрхлэх нөхцөлийг бий болгох,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг шинэ мэргэжил эзэмших сургалтыг зохион байгуулах,
- Ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байртай холбоотой мэдээллийг зохих журмын дагуу өгөх зэрэг болно.

ОХУ-ын “Хөдөлмөрийн тухай”¹⁶⁶ хуулийн дагуу хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэд дараах хөнгөлөлтийг эдэлдэг. Үүнд:

- 1-2 дугаар группын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цаг долоо хоногт 35 цагаас илүүгүй байна.
- Ийм иргэнд жил бүр ээлжийн амралтыг календарийн 30 хоногоос доошгүй, харин цалингүй амралтыг 60 хүртэл хоног олгоно.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг өөрийнх нь бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр амралтын өдөр, шөнийн цагаар ажиллуулахыг хориглоно.

1.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурах, бүх шатны боловсрол эзэмших талаарх эрх зүйн зохицуулалт

ОХУ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсрол эзэмших явдлыг бүхий л талаар дэмжин, үүний тулд шаардлагтай нөхцөлийг баталгаатай хангана”¹⁶⁷ гэж заажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүх шатны боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхийг баталгаажуулсан бөгөөд энэ нь эдгээр иргэд бусад хүмүүсийн нэгэн адил хүний эрх, эрх

¹⁶⁵ФЗ “О социальной защите инвалидов в российской федерации”. www.docs.cntd.ru

¹⁶⁶ФЗ “Трудовой кодекс”. <http://base.garant.ru>

¹⁶⁷ФЗ “О социальной защите инвалидов в российской федерации.” www.docs.cntd.ru

чөлөөг эдлэх, тэдгээрийн бие хүний болон хувийн онцлог, боломжийг хөгжүүлэх, нийгмийн хөгжилд татан оролцуулахад чиглэгддэг байна.

Боловсролын удирдах болон боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд, тэдгээрийн эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эзэмшихтэй холбоотой мэдээллээр хангах үүрэгтэй.

Мөн дээрх байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эзэмших үйл явцад сэтгэл зүй-сурган хүмүүжүүлэх дэмжлэг үзүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэрийн нөхцөлд нь сургахад дэмжлэг үзүүлнэ. Хүүхдээ гэрээр боловсрол олгоход гаргах зардлын хэмжээг ОХУ-ын субъектүүдийн эрх зүйн актын дагуу тодорхойлон эцэг, эхэд нь олгодог байна.

Түүнчлэн ОХУ-ын “Боловсролын тухай”¹⁶⁸ хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэргэжлийн боловсролыг нэг бус удаа үнэ төлбөргүй эзэмших эрхтэй ба 1-2 дугаар группын хөгжлийн бэрхшээлтэй иргэд техникийн дээд сургууль, техникийн дунд боловсролын сургуульд элсэлтийн уралдаант шалгалтгүйгээр элсэн орох эрх эдэлдэг. Үүнээс гадна тэдэнд оюутны цалинг 50 хувь нэмэгдүүлэн олгодог ажээ.

1.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өндөр насны тэтгэврийн талаарх эрх зүйн зохицуулалт

Энэхүү асуудлыг ОХУ-ын “Төрийн тэтгэврийн хангамжийн тухай”¹⁶⁹ Холбооны хуулиар зохицуулсан байна. Тус хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн тахир дутуугийн тэтгэвэр, өндөр насны тэтгэвэр хоёрын аль нэгийг сонгох эрхтэй, өөрөөр хэлбэл, хөдөлмөр эрхэлж өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн энэ хоёр тэтгэврийн аль өндөр хэмжээтэй тэтгэврийг сонгон авах эрхтэй юм.

Дээрх хоёр тэтгэврийг нэгэн зэрэг авах эрхтэй хүмүүсийн жагсаалтыг хуулиар тодорхой заасан. Дараах хөгжлийн бэрхшээлтэй иргэд нэгэн зэрэг тахир дутуугийн ба өндөр насны тэтгэвэр авах эрхтэй. Үүнд:

- Байлдааны ажиллагааны улмаас тахир дутуу болсон,
- Эх орны Агуу их дайнд оролцогч,
- “Ленинградд бүслэгдэгч” тэмдэгээр шагнагдсан иргэн зэрэг болно.

2. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Тус улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашиг, нийгмийн хамгаалал, хөнгөлөлт, тусламжийн талаарх асуудлыг дараах гол хууль эрх зүйн актуудаар зохицуулдаг. Үүнд:

- “Нийгэм, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах тухай” хууль - Schwerbehindertengesetz (SchwbG),
- “Нийгмийн тусламж, ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль - Sozialgesetzbuch II (SGBII),
- “Өндөр насны суурь хангамжийн тухай” хууль - Sozialgesetzbuch XII (SGBXII),
- “Дайнд хохирогчдод тусламж үзүүлэх тухай” хууль - Bundesversorgungsgesetz (BVG) зэрэг болно.

¹⁶⁸ФЗ “Об образовании”. www.consultant.ru

¹⁶⁹ФЗ “о государственном пенсионном обеспечении”. www.consultant.ru

ХБНГУ-д хөгжлийн бэрхшээлийг тухайн хүний бие организм үүргээ биелүүлэх чадвараа алдсан хувиар нь тодорхойлон хөгжлийн бэрхшээлийн түвшинг 20-100 хувь гэж ангилан (GradderBehinderung - GdB) тогтоодог байна. Ингэхдээ 50 хувиас доошгүй хөгжлийн бэрхшээлийг хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээл (Schwerbehinderter) гэж тооцон тусгай үнэмлэх олгодог.

2.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх эрх зүйн зохицуулалт

“Нийгэм, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах тухай” хуулиар хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалсан байна.

Энэхүү хуулийн §§ 5-12 SchwbG (Beschäftigungspflicht)¹⁷⁰ зүйлийн дагуу 16-аас доошгүй тооны ажилтантай нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагууд нийт ажлын байрны 6 хувьтай тэнцэх ажлын байранд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах үүрэгтэй болно. Хэрэв ажил олгогч хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хийх боломжтой ажлыг нь хийх боломж олгоогүй бол тэрээр тусгай сан болох Integrationsamt жилд 1200 евро төлөх ёстой.

Ажил олгогч нь 6 сараас дээш хугацаагаар ажилласан хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлаас халахдаа (§§ 15-22 SchwbG) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нутгийн холбоо (Hauptförsorgestelle des Landes wohlfahrtsverbandes) эсвэл Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажил олгогчдын зөвлөлдөх албаны зөвшөөрлийг заавал авсан байна.

Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь ийм иргэдэд зориулсан тусгай газруудад (Werkstatt für Behinderte) ажил хөдөлмөр эрхлэх эрхтэйгээс гадна тусгай нөхөн сэргээх төвүүдэд (Berufshilfswerke) энгийн өөрт тохирсон мэргэжил эзэмших эрхтэй.

Түүнчлэн 50 хувиас доош түвшиний хөгжлийн бэрхшээлтэй иргэн зохих газруудад хандан хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй нэгэн адил эрх эдлэн дээрх хуулийн заалтын дагуу хөдөлмөрлөх эрхээ хамгаалуулах боломжтой ажээ.

Мөн хувийн бизнесээ эрхэлж эхлэх (selbständiger Unternehmer) сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөрийн бирж ба интеграцийн товчоогоор дамжуулан санхүүгийн дэмжлэг хүртэх эрхтэй.

2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурах, бүх шатны боловсрол эзэмших талаарх эрх зүйн зохицуулалт

ХБНГУ-ын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусад хүмүүсийн нэгэн адил боловсрол эзэмших эрхтэй болохыг хуульчилж, төрөөс бүх иргэдэд заавал эзэмших үнэ төлбөргүй бүрэн дунд боловсролыг баталгаатай олгохыг заасан.

Тус улсад боловсролын тухай холбооны гол хуулийн үндсэн дээр муж улс бүрт өөрийн боловсролын хууль үйлчилдэг байна.

Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдүүдийн нэгэн адил ердийн сургуульд суралцдаг ба ийм онцгой хэрэгцээтэй хүүхдүүд ердийн сургуульд суралцах боломжтой байдаг. Ердийн сургуулиуд эдгээр хүүхдүүдийн хэрэгцээнд тохируулан сурганы арга, арга зүйн үндсэн дээр зохих нөхцөлийг бүрдүүлсэн байна.

¹⁷⁰Schwerbehindertengesetz (SchwbG). <http://behinderung.org/gesetze/schwbg.htm>

Ийм маягийн инклюзив сургалттай ердийн сургууль нь нийгмийн харилцаанд эерэг уур амьсгалыг бий болгох, бүх нийтийг боловсролд тэгш хамруулах, ялгаварлан гадуурхах үзэлтэй хийх тэмцэлд ихээхэн үр нөлөө үзүүлдэг ажээ.

Ямар нэг шалтгааны улмаас ердийн ерөнхий боловсролын сургуульд суралцах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тусгай сургалттай сургуульд суралцдаг.

ХБНГУ-ын боловсролын хууль тогтоомжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээд, болон мэргэжлийн боловсрол эзэмших эрхээр бусад хүмүүсийн нэгэн адил хангагдсан ба ихэнх их, дээд сургуулиуд үнэ төлбөргүй байдаг. Үүний зэрэгцээ цөөн тооны оюутан элсүүлдэг зарим факультетад хөгжлийн бэрхшээлтэй элсэгчид зарим хөнгөлөлт эдэлдэг.

Хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын сурах үйл явцын үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор тусгай тусламж авах эрхээр хангасан байдаг ба үүнд зарцуулагдах зардлыг холбооны муж улсын нийгмийн албад хариуцдаг. Харин хөгжлийн бэрхшээлтэй оюутны эцэг, эх нь дундаж цалингийн хэмжээнээс дээгүүр орлоготой бол тусгай тусламжийн зардлын тал хувийг өөрсдөө хариуцдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд түүний суралцахад нь тусламж үзүүлэх хувийн туслагч тодорхой хугацаагаар үйлчилж, тусламж үзүүлэхийг тусгай тусламж гэх бөгөөд энэ нь дадлагын ажил бичих, ном, сурах бичиг олох, дадлага хийх, хараагүй оюутанд хичээлийн материалыг уншиж сонсгох, сонсголгүйд нь хичээлийг нь тэмдэглэж өгөх, өөрөө явах, хөдлөх боломжгүйд нь сургуульдаа явж, хөдөлөхөд нь туслах гэх мэтээр тусладаг ажээ. Ийм маягийн туслагчаар тэр сургуулийнх нь оюутнууд ба тус сургуулийн дэргэдэх ийм тусламж үзүүлэх зорилго бүхий албаны ажилтнууд ажилладаг.

Үүнээс гадна хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд сургалтандаа нэмэлт техникийн тусламж авдаг, тухайлбал, тусгай программ бүхий зөөврийн компьютер, хараагүй оюутнууд номын санд тусгай тоноглолгдсон суудал, компьютертай байдаг.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад улирлын шалгалтын хугацааг сунгах, шалгалт өгөх хэлбэрийг сонгох, шалгалтыг тусгайлан өгөх зэрэг хөнгөлөлт үзүүлдэг.

2.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өндөр насны тэтгэврийн талаарх эрх зүйн зохицуулалт

ХБНГУ-д 2005 онд “Өндөр насны суурь хангамжийн тухай” хууль - Sozialgesetzbuch XII (SGBXII)-ийг шинэчлэн баталсан ба энэхүү хуулийн дагуу ажил хөдөлмөр эрхэлж байсан хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгохдоо өндөр насны суурь тэтгэвэр дээр 17 хувийн нэмэгдэл авах эрхээр хангагдсан байна¹⁷¹.

3. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

1980-аад оны эхээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг “тахир дутуу ба хөдөлмөрийн чадваргүй /хэрэггүй/” гэх утгатай “can fei,” хэмээх ялгаварлан үзсэн нэр томъёогоор нэрийддэг байжээ. 1980-аад оны сүүлч үеэс эхлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухайд нийгмийн ерөнхий хандлага аажим боловч суурь үндсээрээ өөрчлөгдсөн. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өмгөөлөл идэвхжисэн ба Засгийн газрын зүгээс энэ талаарх санал санаачилгуудыг сайн дэмжиж байсантай холбоотой. Өнөөдөр албан ёсны бичиг баримтууд ба нийтээр «хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс» эсвэл “хөдөлмөрийн чадвараа алдсан хүмүүс” гэх утгатай “can ji ren” хэмээх нэр томъёог хэрэглэж байна.¹⁷²

¹⁷¹§30 Abs.1 SGBXII. www.gesetze-im-internet.de

¹⁷²The Protection of Rights of People with Disabilities in China, By Eric Zhang. www.disabilityworld.org/

Хятадад эдгээр иргэдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа 1980-аад оноос эрчимжсэн ба тэдгээрийн эрхийг хамгаалах Төрийн Консултай хамтран ажиллах хороо (The State Council Coordination Committee on Disability (SCCCD)), Хятадын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Холбоо (China Disabled Persons' Federation (CDPF))-г тус тус байгуулсан байна. Эдгээр байгууллага нь өөрийн орон нутаг дахь холбоодын хамтаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, тэдэнд хамаарах бодлого гаргах түвшний үйл ажиллагаанд оролцох зэрэгт гол чухал үүргийг гүйцэтгэдэг байна.

3.1 Хууль эрх зүйн орчин¹⁷³

Хятад улс Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Конвенц 159 /ILO Convention 159/ зэрэг олон улсын хүний эрхийн хамгааллын 20 орчим гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон байдаг.

Харин дотоодын хууль эрх зүйн хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, тэдний сурч боловсрох, ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх, эрхийг хамгаалах харилцааг зохицуулсан олон хууль, журамтай. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах тухай ерөнхий зарчмуудыг Үндсэн хуульд тодорхой заасан байдаг. Тухайлбал: Үндсэн хуулийн 45-р зүйлд¹⁷⁴: “бүх иргэд... өтөлсөн, өвдсөн эсвэл хөдөлмөрийн чадваргүй (тахир дутуу) болсон үедээ төр, нийгмээс материаллаг тусламж авах эрхтэй. Иргэддээ энэ эрхийг нь эдлүүлэх үүднээс төрөөс нийгмийн даатгал, нийгмийн халамж, эмнэлэг ба эрүүл мэндийн үйлчилгээг хөгжүүлнэ...” гэжээ.

Энэ ч үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах дараах хууль, журмуудыг баталсан байна. Үүнд:¹⁷⁵

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах хууль /Law on the Protection of Persons with Disabilities/
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил эрхлэлтийн тухай журам /Regulations on the Employment of Persons with Disabilities/
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын тухай журам /Regulations on the Education of Persons with Disabilities/
- Арван нэгдүгээр таван жилийн хөгжлийн төлөвлөгөөний үеийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр /The Outline of the Work for Persons with Disabilities during the 11th Five-year Development Program Period/ зэрэг болно.

Мөн Сонгуулийн хууль, Иргэний хууль, Иргэний үйл ажиллагааны хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн үйл ажиллагааны хууль, Боловсролын хууль, Дээд боловсролын хууль, Хөдөлмөрийн хууль, Гэр бүлийн хууль, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах хууль, Ахмад настнуудын эрхийг хамгаалах хууль, Өв залгамжлалын хууль, Хүүхэд үрчлэлийн тухай хууль, Даатгалын хууль гэх мэтчилэн 30 гаруй хууль тогтоомжид Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний эрхийг хамгаалахтай холбоотой тодорхой заалтууд байдаг байна.¹⁷⁶

Ийнхүү хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбогдох хууль тогтоомж хангалттай их байгаа боловч тэдгээрийн хууль ёсны хамгааллыг сайжруулахад засаг захиргааны үүрэг оролцоо ихээхэн чухал гэж үздэг.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах тухай хууль” нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухайд чухал ач холбогдолтой гол хууль юм. Энэ хууль нь 1990 онд батлагдаж, 1991 оноос хүчин төгөлдөр болсон бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй

¹⁷³Мөн тэнд.

¹⁷⁴Constitutions of People's Republic of China, Article 45. www.constitution.org/cons/china.txt

¹⁷⁵Laws and documents. www.cdpc.org.cn/english/lawsdoc/lawsdoc.htm

¹⁷⁶The Protection of Rights of People with Disabilities in China, By Eric Zhang. www.disabilityworld.org/

хүмүүсийн сувилал, боловсрол, ажил эрхлэлт, нийгэм-соёлын амьдрал, халамж, үйлчилгээ, хууль зүйн үүрэг хариуцлага зэрэг асуудлыг хамарсан 9 бүлэг, 54 зүйлтэй.

Уг хуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай нийгмийн ухамсрыг дээшлүүлэх зорилгоор Хятад болон үндэсний цөөнхийн 7 хэл ба Брайл үсгээр 10 сая гаруй хувь хэвлэж, Засгийн газрын албад болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон нийтийн байгууллагуудын сүлжээгээр дамжуулан улс орон даяар түгээсэн байна.

Энэ хуулийн ихээхэн хэсэг нь сувилал, боловсрол, ажил эрхлэлт ба нийгмийн сайн сайхан гэх зэрэг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгайлсан хэрэгцээг зохистой хангахад чиглэсэн байна.

Дээрх хуулийн 3-р зүйлд¹⁷⁷: “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь улс төр, эдийн засаг, соёл ба нийгмийн салбарууд, гэр бүлийн амьдрал ба бусад бүх талаар бусад иргэдийн адил тэгш эрхийг эдлэх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн иргэний эрхийг, нэр төрийг хуулиар хамгаална. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох ба эрхийг нь зөрчихийг хориглоно.” хэмээн ялгаварлан гадуурхахын эсрэг зарчмыг үндэслэсэн байна.

Мөн 7-р бүлгийн 48-р зүйлд: 5-р сар бүрийн гурав дахь 7 хоногийн бүтэн сайн өдрийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд туслах үндэстний өдөр” болгон тунхагласнаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүндэтгэх соёл ба ёс зүйг сурталчилсан байдаг байна.

3.2 Боловсрол¹⁷⁸

Хятад улс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох асуудлыг ихээхэн анхаарч ирсэн. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах тухай хуулийн 18-р зүйлд: «Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол эзэмших эрхийг төрөөс баталгаажуулна... Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад албан ёсны боловсролыг олгоно... албан ёсны боловсрол эзэмшиж буй сурагчдад төрөөс сургалтын төлбөр ногдуулахгүй.”¹⁷⁹ гэхчлэн заажээ.

Үүнээс гадна «Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын тухай журам», Боловсролын хууль, Тусгай мэргэжлийн боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль гэх зэрэг холбогдох хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролыг дэмжихэд чиглэсэн тусгай заалтууд бий. Жишээлэхэд, Боловсролын тухай хуульд¹⁸⁰: “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын үйл ажиллагааг төр дэмжин хөгжүүлнэ», «Төр, нийгэм, сургууль ба бусад боловсролын байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие ба сэтгэл зүйн шинж чанар, хэрэгцээнд тохируулан боловсрол олгож, тусалж, таатай нөхцөлийг нь бүрэлдүүлж өгөх ёстой” гэжээ.

Дээрхээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай сургуулийг төрийн холбогдох хууль, дүрмийн дагуу боловсролын захиргааны албадын хяналт шалгалт, зөвшөөрлийн дагуу байгуулах ба барилгыг тэдний тусгай эрэлт хэрэгцээнд нийцүүлэн барихыг шаардахаас гадна ердийн сургуулиуд ч, тэдний үнэнхүү бодит нөхцөл байдлыг харгалзан үзэж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг суралцах таатай орчин нөхцөлөөр нь хангаж өгөх ёстой гэж үздэг байна.

¹⁷⁷Law on the Protection of Persons with Disabilities. www.cdprf.org.cn/english/lawsdoc/

¹⁷⁸The Protection of Rights of People with Disabilities in China, By Eric Zhang. www.disabilityworld.org/

¹⁷⁹Law on the Protection of Persons with Disabilities. www.cdprf.org.cn/english/lawsdoc/

¹⁸⁰Education Law of the People's Republic of China. www.moe.edu.cn/publicfiles/

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын тухай журамд Сургуулийн өмнөх боловсрол, Албан ёсны боловсрол, Мэргэжлийн сургалт боловсрол, ба насанд хүрэгчдийн боловсрол, Багш нар болон Материаллаг нөхцөлийн баталгаа зэргийг илүү нарийн тусгасан байна. Журам¹⁸¹ нь 9 бүлэг, 52 зүйлтэй.

Журам ёсоор¹⁸² бүх түвшний Ардын засгийн газрууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын зардлыг төлөх санг бүрдүүлэх үүрэгтэй ба, тэдгээр сангууд нь баталгаатай байж, боловсролын үйл ажиллагааны зардал өсөхийн хэрээр эрэлт хэрэгцээнийх нь дагуу, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсролын хөгжилд хэрэглэгдэх тусгай тэтгэлгийн сангуудыг байгуулж болно. Мөн бүх шатны орон нутгийн Ардын засгийн газруудаас албан ёсны боловсролд зориулан бүрдүүлсэн сангууд ба сургалтын төлбөрийн илүү төлөлтөөс үүссэн хуримтлалын тодорхой хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын албан ёсны боловсролд зарцуулах ёстой байдаг байна.

Энэ мэт хууль эрх зүйн боловсронгуй зохицуулалтын үр дүнд Төрөөс тэдгээр иргэдийн сурч боловсрох орчныг бүрдүүлэх, үнэ төлбөргүй суралцах боломжийг хангахын сацуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролыг дэмжих олон төсөл хөтөлбөр сангууд бий болох орчин нөхцлийг бүрдүүлсэн байна.

Тухайлбал, Тусгайлан зохион байгуулагддаг хонжворт сугалаанаас санхүүждэг Боловсролын сан нь ядуу өрхийн сургуулийн өмнөх шатны боловсролын насны хөгжлийн бэрхшээлтэй 10 000 гаруй хүүхдүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Энэ сан өөр олон сувгаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх шатны боловсрол олгоход дэмжлэг үзүүлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай сургуулиуд байхын зэрэгцээ маш олон ердийн буюу үндсэн сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг элсүүлэн авдаг. Учир нь зарим хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ердийн сургуульд суралцахыг сонгох нь элбэг байдаг байна.

Дээд боловсролын тухай хууль ёсоор¹⁸³ бол аль ч сургууль ямарваа оюутныг хөдөлмөрийн бэрхшээлтэйгээр нь үндэслэн элсүүлэн авахаас татгалзах ёсгүй. Гэсэн хэдий ч, хөгжлийн бэрхшээлтэй зарим оюутнууд зарим их сургуулийн биеийн тамирын шалгалтын шаардлага зэргээс үүдэн багагүй саад бэрхшээлтэй тулгарсан хэвээр байгаа юм. 2013 оны байдлаар¹⁸⁴ 7538 хөгжлийн бэрхшээлтэй оюутан үндсэн дээд боловсролын сургуулиудад, харин 1388 хөгжлийн бэрхшээлтэй оюутан тусгай дээд боловсролын сургуулиудад элсэн орсон байна.

3.3 Ажил эрхлэлт

Хятадад ажил хөдөлмөр эрхлэх эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах хуулиар баталгаажуулдаг. Энэ хуульд¹⁸⁵: *“Ажил эрхлэлт, сүй тавих, нийгмийн байдлыг тогтоох, дэмжих, техникийн эсвэл мэргэжлийн цолыг тодорхойлох, хөдөлмөрийн хөлсийг тогтоох, тэтгэмж ба нийгмийн даатгал эсвэл аливаа бусад талаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан үзэх ёсгүй”* гэжээ.

Энэ ч үүднээс Засгийн газраас бүх улсын болон хувийн салбарын ажил олгогч нарт ажлын байрны 1,5%-аас багагүй орон тоог хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гаргах ёстой

¹⁸¹Regulations on the education of persons with disabilities, Beijing, China, 1997. www.cdpf.org.cn/english/lawsdoc

¹⁸²Мөн тэнд.

¹⁸³Higher Education Law of the People's Republic of China. www.moe.edu.cn/publicfiles/

¹⁸⁴Statistical Communique on the Development of the Work for Persons with Disabilities in 2013. www.cdpf.org.cn/english/

¹⁸⁵Law on the Protection of Persons with Disabilities. www.cdpf.org.cn/english/lawsdoc/

гэсэн квотын системийг шаардах болжээ. Үүнийг орон нутгийн, мужийн захиргааны тусгай захирамж, журмын дагуу үндэслэсэн байдаг. Ингэснээр энэ квотын шаардлагыг биелүүлээгүй газрууд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажил эрхлэлтийн хамгааллын сан-д төлбөр төлөх ёстой ба, үүгээрээ тэдгээр иргэдийн тусгай мэргэжлийн сургалт зэрэгт хандив тусламж үзүүлж байгаа хэрэг болдог байна. Энэ талын хяналт мониторингийн ажлыг татварын албад ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагууд хийдэг.

Засгийн газар нь татварын хөнгөлөлт урамшуулал, санхүү, техник ба бусад тусламж зэргээрээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олгосон байгууллагуудыг дэмжих ба, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хувиараа хөдөлмөр эрхлэхэд нь дэмжин урамшуулдаг¹⁸⁶ байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хамгааллын хууль ба бусад холбогдох бодлогуудын шаардлагаар 2001 оны 6-р сард Барилгын Яамнаас Хотын зам ба барилга байгууламжийн хэрэглээний тухай загварын дүрмийг (JGJ 50-2001) 1988 оны бичиг баримтад үндэслэн шинэчлэн баталжээ. Эдгээр дүрмийг бүх хотын зам, барьж байгуулсан орчин, нийтийн хэрэглээтэй холбогдох хэрэгслүүд, байр, албан өрөө, бизнес, үйлчилгээ, соёл, боловсрол, спортын арга хэмжээ, ажлын газрууд, шинээр баригдах болон засварлагдаж буй бүх барилгуудад баримтлах бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн таатай орчинг бүрдүүлж буй хэрэг юм. Энэ нь албан ёсны шаардлага болсон учир бүрэн хэрэгждэг.

Хөдөлмөрийн тухай хуулинд (1) Тэтгэвэрт гарах; (2) Өвдөх эсвэл гэмтэж бэртэх; (3) Ажлын байран дээрээ тахир дутуу болох эсвэл ажил мэргэжлийн өвчнөөр өвдөх; (4) Ажилгүй болох; (5) Хүүхэд төрүүлэх тохиолдлуудын алинд боловч нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдан холбогдох тэтгэмжийг авах эрхтэй.¹⁸⁷

3.4 Өндөр насны тэтгэвэр

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өндөр насны тэтгэврийн асуудлыг Өндөр нас, Хөгжлийн бэрхшээлтэй ба тэжээгчээ алдсаны тэтгэмжийн тухай журмаар зохицуулахаас гадна Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Халамжийн тухай хуулиар зохицуулдаг.

Өндөр нас, Хөгжлийн бэрхшээлтэй ба Тэжээгчээ алдсаны тэтгэмжийн тухай журамд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрт тэтгэврийн насанд хүрээгүй буюу өндөр насны тэтгэврийн шаардлагыг хангаагүй тохиолдолд Хөдөлмөрийн чадварын үнэлгээний хорооны анагаахын мэргэжилтнүүдийн тогтоосон түвшинг үндэслэн 10 түвшингээр тэтгэвэр олгодог байна. Энэ нь бүрэн хөдөлмөрийн чадваргүй хүмүүст олгодог тэтгэвэр бөгөөд тогтмол удаан хугацаанд олгох тэтгэвэр юм.

Харин хөгжлийн бэрхшээлтэй хүн тэтгэврийн насанд хүрсэн болон өндөр настны тэтгэврийн шаардлагыг хангасан тохиолдолд өндөр настны эрт тэтгэврийг тогтоолгож болох бөгөөд өндөр настны тэтгэвэр нь хөдөлмөрийн бэрхшээлтэйн тэтгэврээс бага байгаа тохиолдолд тэнцвэржүүлэх үүднээс зөрүүг Нийгмийн даатгалын сангаас олгодог.¹⁸⁸ Өндөр настны эрт тэтгэврийн нөхцөл нь хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан 50 нас хүрсэн эрэгтэй, 45 нас хүрсэн эмэгтэй дор хаяж 10 жил ажилласан байх, эсвэл хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд наанадаж 8-10 жил тасралтгүй ажилласан 55 нас хүрсэн эрэгтэй, 45 нас хүрсэн эмэгтэй байхыг тус тус шаарддаг.

¹⁸⁶Regulations on the Employment of Persons with Disabilities. www.cdprf.org.cn/english/lawsdoc/

¹⁸⁷Law of Labor in China. www.jus.uio.no/lm/china.labor.law.1994/doc.html

¹⁸⁸Old age, disability, survivors Regulatory Framework. www.socialsecurity.gov/policy/

2013 оны байдлаар¹⁸⁹ Хот суурин газрын 1.62 сая хөгжлийн бэрхшээлтэй иргэн өндөр насны тэтгэвэр авч байгаа бол орон нутгийн 6,281 сая хөгжлийн бэрхшээлтэй иргэн өндөр насны тэтгэвэр авч байна.

3.5 Мэдээлэл, үйлчилгээ

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах хуулиар¹⁹⁰ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл ба харилцаа холбоог хэрэглэх боломжийг баталгаажуулсан байдаг.

Улс үндэстний хэмжээний стандарт дохионы хэлийг хэдийнээ боловсруулсан бөгөөд Хятадын Брайл Хэвлэлийн газар ба бусад хэвлэн нийтлүүлэгчид Брайл үсэгтэй болон сонсдог ном, сэтгүүл хэвлүүлэх ажлыг хийж байна. Үүнд үндсэн хууль ба бусад хуулиудыг ийм хэлбэрээр хэвлүүлэх ажил ч орж байна.

Эдийн засгийн өндөр хөгжилтэй бүс нутгуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд тэдэнд зориулсан хэд хэдэн сониныг хэвлэн гаргаж түгээсэн. Тухайлбал, Бээжинд «Chinese Times» сониныг, Хятадын Хөгжлийн бэрхшээлтэй Хүмүүс гэдэг сар тутмын сэтгүүл зэрэг болно.

Хууль ёсоор¹⁹¹ хараагүй иргэдэд зориулсан унших материалыг улсын шуудангаар үнэ төлбөргүй хүргэх ёстой байдаг байна.

4. АВСТРАЛИ УЛС

4.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг хууль¹⁹²

Хэсэг 2 – Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглох

Бүлэг 1 – Хөдөлмөрийн ялгаварлан гадуурхалт

15. Хөдөлмөр эрхлэлтээр ялгаварлан гадуурхах

(1) Ажил олгогч, эсхүл ажил олгогчийн нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж буй этгээдийн зүгээс хүнийг хөгжлийн бэрхшээлтэй нь хувьд доор дурдсан хэлбэрээр ялгаварлан гадуурхах нь хууль бус:

- (a) ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхойлох зорилгоор тавигдах зохицуулалтаар;
- (b) ажлын байрыг хэнд өгөхийг тодорхойлохдоо;
- (c) ажлын байр санал болгох нөхцөлөөр.

(2) Ажил олгогч, эсхүл ажил олгогчийн нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж буй этгээдийн зүгээс ажилтныг хөгжлийн бэрхшээлтэй хувьд нь доор дурдсан хэлбэрээр ялгаварлан гадуурхах нь хууль бус:

- (a) ажил олгогчийн зүгээс ажилтны хөдөлмөр эрхлэх нөхцөл, хугацаагаар;
- (b) хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тоноглол хийхгүй байх, тоноглолыг хязгаарлах, ажилтны албан тушаал ахих, өөр ажилд шилжих, сургалтанд хамрагдах болон ажлын байртай нь холбоотой бусад ололт, дэвшилд хүрэх нөхцлийг нь хаах, хязгаарлах;
- (c) ажилтныг халах;
- (d) ажилтанд бусад хэлбэрээр хохирол учруулах.

¹⁸⁹Statistical Communique on the Development of the Work for Persons with Disabilities in 2013.

www.cdpf.org.cn/english/statistics/

¹⁹⁰Law on the Protection of Persons with Disabilities, Article 37,38. www.cdpf.org.cn/english/lawsdoc/

¹⁹¹Мөн тэнд.

¹⁹²Disability Discrimination Act 1992. www.comlaw.gov.au

Мөн энэ бүлгийн 16, 17, 18 дугаар заалтуудад худалдааны агент (*commission agents*), гэрээт ажилтан, хоршооллогчдын хувьд дээр дурдсан 15 дугаар заалттай адилаар хүнийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь ялгаварлан гадуурхах нь хууль бус гэж тодорхойлжээ.

Энэ бүлгийн 19 дүгээр зүйлээр тодорхой мэргэжилийн дадлага олгох, мэргэшүүлэх, зөвшөөрөл олгох болон эгүүлэн хураах эрх, үүрэг бүхий тусгай байгууллагуудын зүгээс; 20 дугаар зүйлд аливаа бүртгэгдсэн байгууллага, түүний удирдлагын хорооны зүгээс хүнийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь ялгаварлан гадуурхах нь хууль бус болохыг тус тус тодорхойлсон байна.

21. Хөдөлмөр эрхлэлтийн агентлагууд

(1) Хөдөлмөр эрхлэлтийн агентлагууд хүнийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь дараах хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглоно:

- (a) өөрийн үзүүлдэг аливаа үйлчилгээг үзүүлэхээс татгалзах;
- (b) өөрийн үзүүлдэг аливаа үйлчилгээг үзүүлэхдээ тавигдах нөхцөл, хугацаагаар;
- (c) өөрийн үзүүлдэг аливаа үйлчилгээг үзүүлэх арга хэлбэрээр.

Бүлэг 2 – Бусад хэлбэрийн ялгаварлан гадуурхалт

22 Боловсрол

(1) Боловсролын байгууллага хүнийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь дараах хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглоно:

- (a) хөгжлийн бэрхшээлтэй хүний суралцах хүсэлтийг хүлээн авахгүй байх, татгалзах;
- (b) суралцуулахаар авах нөхцлөөр ялгавар тогтоох.

(2) Боловсролын байгууллага суралцагчийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь дараах хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглоно:

- (a) хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зориулсан тоноглол хийхгүй байх, тоноглолыг хязгаарлах, боловсролын байгууллагын зүгээс олгох аливаа хөнгөлөлтийг хязгаарлах;
- (b) суралцагчийг хасах;
- (c) суралцагчид бусад хэлбэрийн хүндрэл учруулах.

(2A) Боловсролын байгууллага хүнийг хөгжлийн бэрхшээлтэйн хувьд нь дараах хэлбэрээр ялгаварлан гадуурхах нь хууль бус:

- (a) сургалтын хөтөлбөр болон дадлагын курсын агуулгыг боловсруулахдаа суралцагчын оролцох боломжийг хаасан, эсхүл хүндрэл учруулсан;
- (b) дээрх заалтанд тусгагдсан агуулга бүхий сургалтын хөтөлбөр болон дадлагын курсыг батлах.

4.2 Өндөр насны тэтгэвэр

1908 онд Өндөр насны болон тахир дутуугийн тэтгэврийн хууль (*Invalid and Old-Aged Pensions Act 1908*) батлагдаж, 1910 оноос хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэтгэвэр олгож эхэлжээ. Энэ тэтгэврийг цалин хөлстэй хөдөлмөр эрхлэн бие даан амьдрах бололцоогүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан бий болгосон. Дээрх хуулиар 16 нас хүрсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гэр бүл, төрөл төрөгсдийн зүгээс дэмжлэг авахгүй гэж үзэж, тэтгэвэр тогтоодог.

Одоо 1991 онд батлагдсан Нийгмийн хамгааллын хуулиар (*Social Security Act 1991*¹⁹³) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамж, тэтгэвэр, бусад хөнгөлөлтүүдийг зохицуулдаг. Энэ хуулийн 2 дугаар хэсгийн (*Chapter 2-Pensions, benefits and allowances*) Бүлэг 2.3.-т

¹⁹³Social Security Act 1991. www.comlaw.gov.au

(*Part 2.3-Disability support pension*) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийн талаар заасан байдаг.

Энэ хуулиар:

- 16 наснаас тэтгэврийн нас хүртэл
- Хараагүй болон бие, оюун, сэтгэцийн хувьд хөгжлийн бэрхшээлтэйд тооцогдох
- Хөдөлмөрлөх чадваргүй, эсхүл хөгжлийн бэрхшээлээсээ шалтгаалан ойрын 2 жилд долоо хоногт 15 ба түүнээс дээш цагаар ажиллаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжихын тулд дахин бэлтгэгдэх шаардлагатай хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр авна.

Австралид өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас нь:

- 1949 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө төрсөн эмэгтэй 64,5 насандаа, 1949 оны 1 дүгээр сарын 1-нээс 1952 оны 6 дугаар сарын 30-ны хооронд төрсөн эмэгтэй 65 насандаа, 1952 оны 7 дугаар сарын 1-нээс өмнө төрсөн эрэгтэй 65 насандаа тус тус тэтгэвэрт гарах эрхтэй болно. Харин 2017 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн тэтгэвэр тогтоох насыг 65-аас 65 нас 6 сар болгон нэмэгдүүлнэ. Ингээд цаашид тэтгэвэр тогтоох насыг 2 жил тутамд 6 сараар нэмэгдүүлж, 2023 оны 7 сарын 1 гэхэд 67 нас хүргэнэ.
- 1991 оны Нийгмийн хамгааллын хуулийн 55 дугаар зүйлд зааснаар өндөр насны ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийн хэмжээг хараагүй хүний хувьд энэ хуулийн 1065 дугаар зүйлээр, бусад хүний хувьд 1064 дүгээр зүйлээр тогтооно.

5. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Солонгост хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсрол, төрөөс үзүүлэх тусламж дэмжлэг, хөнгөлөлт болон бусад асуудлыг ерөнхийд нь *Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тухай хуулиар* (*Act on Welfare of persons with disabilities*)¹⁹⁴ зохицуулдаг.

Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд халамж үйлчилгээ үзүүлэх, тэдний нийгмийн оролцоог урамшуулан дэмжих замаар нийгэмд бусдын адил амьдрах нөхцөл бололцоогоор хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ая тухтай амьдрах нөхцөл болон түүний эрхийг хангах талаар төр, орон нутгийн засаг захиргааны үүрэг хариуцлагыг тодорхой болгох, зөвхөн мөнгө өгөх биш, эмнэлэгийн үйчилгээ, нөхөн сэргээх эмчилгээ, боловсрол, ажил эрхлэх, амьдралын нөхцөлөө дээшлүүлэх зэрэг тэдний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж бие даан амьдрах бололцоо болон амьжиргааны тогтвортой байдлыг дэмжихэд оршино.

Хуулинд тодорхойлсноор, биеийн болон оюуны чадамжаа урт хугацаагаар алдсаны улмаас нийгмийн болон өдөр тутмын амьдралд хэвийн амьдрах чадвараа алдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэнэ.

Биеийн чадамжаа алдах гэж биеийн гаднах болон дотоод эрхтэний хэвийн үйл ажиллагаанд бэрхшээл үүсч хэвийн ажиллагаа алдагдахыг хэлнэ.

Оюуны чадамжаа алдах гэж сэтгэхүйн хөгжлийн бэрхшээл, эсвэл сэтгэцийн өвчинтөй тохиолдлыг хэлнэ.

¹⁹⁴Act on Welfare of persons with disabilities. http://elaw.klri.re.kr/eng_mobile/

5.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурах, бүх шатны боловсрол эзэмшихэд төрөөс үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсролын асуудлыг *Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусгай боловсролын тухай хууль (Act on Special education for disabled person)*¹⁹⁵ болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулдаг.

Хуулийн зорилт төр, орон нутгийн засаг захиргаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжлийн бэрхшээлийн төрөл, зэрэгт нь тохирсон тусгай боловсролоор хангах, сурч боловсрох орчин бүрдүүлэх зэргээр тэдний нийгмийн оролцоог хангах, авьяас чадвар, чадавхийг хөгжүүлэн дэмжихэд оршино.

Төр, орон нутгийн засаг захиргаа дараах үүрэгтэй. Үүнд:

- Төр, орон нутгийн засаг захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний нас, боломж бололцоо, хөгжлийн бэрхшээлийн төрөл, зэрэгт нь тохирсон үр ашигтай боловсрол олгох ба түүний агуулга, арга хэлбэрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоонд тохируулан сайжруулахад шаардлагатай арга хэмжээг авна.
- Төр, орон нутгийн засаг захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсролын талаарх судалгаа шинжилгээний ажлыг урамшуулан дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхцөл байдал, онцлогт тохирсон мэргэжил олгох сургалтын системийг боловсруулна.

Боловсролын байгууллагын үүрэг:

- Аль ч шатны сургуулийн удирдлага хөгжлийн бэрхшээлтэй иргэний суралцах хүсэл, хэрэгцээг хүндэтгэн үзэх ба зүй зохисгүй хандаж болохгүй. Тухайлбал, сургуульд суралцах хүсэлт гаргах, эсвэл элсэлтийн шалгалтыг амжилттай өгч элсэх хүсэлт гаргахад хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгаанаар татгалзаж болохгүй.
- Бүх боловсролын байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сургуульд элсэн орох болон суралцахад хөгжлийн бэрхшээлийн төрөл, зэрэгт нь тохирсон тав тухтай, тусгай нөхцөлөөр хангах ба бусад шаардлагатай арга хэмжээг авна.

Хуулинд тодорхойлсноор тусгай боловсрол гэдэг нь тусгай боловсрол авах эрх бүхий хүмүүст зориулсан ба тэдний онцлогт тохирсон боловсролоор хангах *“тусгай боловсролд хамаарах үйлчилгээ” (special education-related services)* юм.

“Тусгай боловсролд хамаарах үйлчилгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сурч боловсроход чухал шаардлагатай, хүний оролцоотой дэмжлэг туслалцаа болон материаллаг тусламжийг хэлнэ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүний гэр бүлд боловсролтой холбоотой болон бусад зөвлөгөө өгөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эмчилгээнд (физик) дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд боловсрол эзэмшихэд нь туслах тусгай бэлтгэгдсэн хүнээр хангах;
- Бүх шатны сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сурч боловсроход тохиромжтой сургалтын орчин, тусгай хэрэгсэл, зориулалтын техник, төхөөрөмжөөр хангах;
- Бүх шатны сургууль хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг автобус унаагаар хангах, сургуулийн төлбөр зардлыг хариуцах, суралцахад тав тухтай орчин бүрдүүлэх гэх мэт суралцахад шаардлагатай нөхцөлөөр хангах;
- Сургуулийн дэргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан дотуур байртай байх;
- Интернет болон бусад хэлбэрээр мэдээлэл авах боломжоор хангах зэрэг үйлчилгээнүүд багтана.

¹⁹⁵Act on special education for the disabled persons. http://elaw.klri.re.kr/eng_mobile/

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн:

- Ердийн сургуульд ердийн боловсрол эзэмших;
- Ердийн сургуульд тусгай боловсрол эзэмших;
- Тусгай сургуульд, эсвэл тусгай боловсролын төвд боловсрол эзэмших боломжтой.

Түүнээс гадна боловсрол олгох дараах 3 хэлбэр байдаг. Үүнд:

- 1) *Integrated education*: Хөгжлийн бэрхшээлийн төрөл, зэргээс үл хамааран нас чацуу хүмүүсийг нэгтгэн ердийн сургуулийн зарчмаар боловсрол олгоно. Сургуулийн удирдлага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сурч боловсрох нөхцөлөөр хангах цогц төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Үүнд тусгай сургалтын хөтөлбөр зохиох, хүний туслалцаагаар хангах, тусгай хэрэгсэл, зориулалтын техник төхөөрөмжөөр хангах, тусгай багш бэлтгэх зэрэг асуудлыг хамруулна. Түүнчлэн, тусгай анги нээж хуулинд заасан стандартын дагуу тоноглож тохижуулна.
- 2) *Individualized education*: Тухайн хүний нөхцөл байдал, онцлогт нь тохирсон зорилго, хөтөлбөр, арга барил, тусгай боловсролд хамаарах үйлчилгээ бүхий тусгай хөтөлбөрийг боловсролын бүх шатанд боловсруулж хэрэгжүүлнэ. Бүх шатны сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд боловсрол олгохын тулд тусгай баг зохион байгуулах ба үүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний асран хамгаалагч, багш, тусгай боловсролын багш, ирээдүйн ажил мэргэжил буюу ажил хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх багш, “тусгай боловсролд хамаарах үйлчилгээ”-ний хүрээнд бэлтгэгдсэн хүн хамрагдана. Тусгай баг нь семестер тутамд шинэ хичээлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлдэг. Суралцагч өөр сургууль руу шилжих, эсвэл анги дэвших, дээд шатны сургуульд ороход хичээлийн хөтөлбөрийг дамжуулж өгнө.
- 3) *Itinerant education*: “Тусгай боловсролд хамаарах үйлчилгээ”-ний хүрээнд бэлтгэгдсэн хүн, эсвэл тусгай боловсролын багш бүх шатны сургуульд, эрүүл мэндийн байгууллагад, гэрт нь очиж боловсролын үйлчилгээ үзүүлнэ. Энэ тохиолдолд тусгай боловсролын төвүүд болон сургуулиудад тусгай багш, эсвэл “тусгай боловсролд хамаарах үйлчилгээ”-ний хүрээнд бэлтгэгдсэн хүнийг ажиллуулна. Хэрэв хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан тодорхой хугацаанд сургуульд явах боломжгүй бол энэхүү хэлбэрээр боловсрол эзэмших боломжтой. Мөн хөгжлийн бэрхшээлийн улмаас хөдлөх боломжгүй, эмнэлэг, асрамжийн газар болон гэртээ байдаг бол тусгай боловсролын багш, эсвэл тусгай бэлтгэгдсэн хүн очиж боловсролын үйлчилгээ үзүүлэх юм.

5.2 Ажил хөдөлмөр эрхлэх бэлтгэл сургалт (Education for future career and vocation).

Холбогдох агентлагууд хамтран ажиллах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг боловсрол эзэмшсэний дараа нийгэмд ажил хөдөлмөр эрхлэхэд бэлтгэлтэй болгох, биеэ даан амьдрахад сургах юм.

Ахлах-дунд сургууль болон дээд шатны сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ирээдүйд ажил хөдөлмөр эрхлэх бэлтгэл сургалтыг зохион байгуулдаг. Сургуулийн зүгээс стандартын дагуу сургалтын орчин бүрдүүлж, бусад шаардлагатай зүйлсээр хангах үүрэгтэй. Энэ сургалтын хүрээнд мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн боловсрол олгох болон ажлаар хангана. Түүнээс гадна, өдөр тутмын амьдрал болон нийгэмд дасан зохицож бие даан амьдрах чадварыг эзэмшүүлэх юм.

Тусгай боловсролын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажил хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх зорилготой мэргэших тэнхим байгуулж, 1 ба түүнээс дээш жилийн сургалт явуулна. Тусгай сургалтын төвүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг энэхүү сургалтаар хангахын тулд холбогдох агентлагуудтай хамтарч ажилладаг.

Тусгай боловсролын сургууль болон бусад бүх шатны сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсролд зориулж тусгай ангиудыг нээж ажиллуулна. Үүнд:

- Цэцэрлэгийн анги. Хэрэв тусгай боловсрол эзэмших суралцагчийн тоо 1-4 байвал 1 анги, 4-өөс их бол 2 болон түүнээс олон ангитай байна.
- Бага анги болон бага дунд анги. Суралцагчийн тоо 1-6 бол 1 анги, 6-аас их бол 2 болон түүнээс их анги байгуулна.
- Ахлах дунд анги. Суралцагчийн тоо 1-7 бол 1 анги, 7-оос их бол 2 болон түүнээс олон ангитай байна.

Цэцэрлэг, бага сургууль, бага дунд сургууль, ахлах дунд сургуулийн боловсрол нь заавал эзэмших боловсролд тооцогддог бөгөөд үүнийг 3-17 настай хөгжлийн бэрхшээлтэй иргэд ч эзэмших боломжтой.

Аль ч шатны сургууль, түүний удирдлага хөгжлийн бэрхшээлтэй иргэний суралцах хүсэлтийг хүлээн авахаас, элсэлтийн шалгалтад оруулахаас, шалтгалтаа амжилттай өгсөн иргэнийг суралцуулахаас татгалзах зэргээр ялгаварлан гадуурхаж, түүний суралцах боломжийг хааж болохгүй.

5.3 Хөдөлмөр эрхлэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэх асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн чадварыг сэргээх тухай (*Employment promotion and vocational rehabilitation*)¹⁹⁶ хуулиар зохицуулдаг.

Төр, орон нутгийн засаг захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, энэ талаар олон нийтэд сурталчлан таниулах болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг байнга дэмжиж ажилладаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор бизнес эрхлэгчид болон олон нийтэд илүү сайн ойлголт өгөх талаар түлхүү анхаардаг байна. Ялангуяа, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүнийг илүү анхаарч үздэг.

Төр, орон нутгийн захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор бизнес эрхлэгчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тэдний хөдөлмөр эрхлэлтэд санаа тавьж буй байгууллага, хүний үйл ажиллагааг урамшуулан дэмждэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд зарцуулагдах зардлын зарим хэсгийг төрөөс санхүүжүүлдэг.

Төр, орон нутгийн засаг захиргааны үүрэг:

- Төр, орон нутгийн засаг захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд зуучилж хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Төр, орон нутгийн засаг захиргаа нь мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн чадварыг хөгжүүлэх, ажил мэргэжилд дасан зохицох сургалт зохион байгуулах, ажилд сургаж авах зэргээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авьяас чадвар, чадавхид тохирсон ажилтай болгоход шаардлагатай арга хэмжээг авна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тохиромжтой мэргэжлийн төрөл болон бусад хөдөлмөр эрхлэлттэй холбоотой судалгаа шинжилгээний ажлыг урамшуулан дэмжинэ.

¹⁹⁶Employment promotion and vocational rehabilitation of disabled persons. http://elaw.klri.re.kr/eng_mobile/

Бизнес эрхлэгчдийн үүрэг:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах бөгөөд тэдний авьяас чадвар, чадавхид тохирсон ажлаар хангах болон ажил эрхлэх талаар зохих бодлогыг хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажил хөдөлмөр эрхлэхэд ялгаварлан гадуурхаж болохгүй.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх боломжоор хангах, ажлын байрандаа тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, өргөжүүлэхэд анхаарч ажиллах үүрэгтэй. Үүнд хөдөлмөрийн яамнаас бизнес эрхлэгчид дэмжлэг туслалцаа үзүүлдэг.
- Хөдөлмөрийн яам нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн талаарх үндсэн төлөвлөгөөг боловсруулах бөгөөд үүнд дараах асуудлыг тусгана:
- хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн чадварыг сэргээх;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн талаар;
- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагааг оруулна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд төр, орон нутгийн засаг захиргаа болон холбогдох яамдууд дараах дэмжлэг туслалцаа, хөнгөлөлтүүдийг үзүүлдэг.

Мэргэжлийн чиг баримжаа олгох (Vocational Guidance)

Хөдөлмөрийн яам болон Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамнаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог, хэрэгцээ, чадавхид тохирсон ажлаар хангахын тулд мэргэжлийн талаар зөвлөгөө өгөх, мөн тэдний мэргэжлийн чадварыг тодорхойлох, ажлын байранд дасан зохицох чадварыг (workplace skill) үнэлэх, хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллээр хангах зэргээр мэргэжлийн чиг баримжаа олгодог. Шаардлагатай тохиолдолд энэхүү үйлчилгээг үзүүлдэг мэргэжлийн байгууллагад хандах бөгөөд холбогдох зардлыг яамнаас гаргана. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрхлэхэд тохиромжтой ажлын байр болон ажлын төрлийг хөгжүүлэхэд анхаарч ажилладаг.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа эрхлэх гэж буй, эрхлэж буй байгууллага болон хүнд зээл, мөнгөн тусламж олгох замаар дэмжлэг үзүүлнэ.

Мэргэжлийн сургалтаар хангах (Vocational Adjustment Training)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлаар Хөдөлмөрийн яам нь Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамтай хамтран ажилладаг ба хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэл эрмэлзэл, авьяас чадвар, чадавхид тохирсон мэргэжлийн сургалтаар хангах хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа явуулж буй этгээдэд түүний энэхүү үйл ажиллагаанд зориулж зээл, мөнгөн тэтгэмж олгох зэргээр урамшуулан дэмждэг байна. Түүнчлэн, хөтөлбөр болон сургалтанд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мөн зээл, сургалтын тэтгэмж олгох замаар дэмжлэг туслалцаа үзүүлдэг.

Ажлын байранд дасан зохицох чадварыг хөгжүүлэх (Workplace Skill Development Training)

Хөдөлмөрийн яам хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэл эрмэлзэл, авьяас чадвар, чадавхид тохирсон ажлын байранд дасан зохицох чадварыг хөгжүүлэх хөтөлбөр гаргана.

Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж буй байгууллага, хүнд мөн үүнд хамрагдан суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зээл, мөнгөн тэтгэмж, сургалтын тэтгэмж олгох зэргээр дэмжлэг үзүүлнэ.

Ажил үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх (Supportive Employment)

Хөдөлмөрийн яам болон Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамнаас хөгжлийн бэрхшээл нь илүү хүнд бөгөөд үүний улмаас ажил үүргээ биелүүлэхэд бэрхшээл үүсч буй хүмүүст зориулан тусгай хөтөлбөр хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, ажил үүргээ хүндрэлгүй, амар хялбар гүйцэтгэхэд шаардлагатай тусламжаар хангах юм.

Protective employment

Төр, орон нутгийн захиргаа нь ердийн ажлын орчинд ажиллах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тусгай ажлын орчноор хангах хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Ажилд зуучлах үйлчилгээ (Job Placement Services, etc.)

Хөдөлмөрийн яам нь ажил эрхлэлтийн талаарх мэдээлэл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэл эрмэлзэл, авьяас чадвар, чадавхийг харгалзан тохиромжтой ажлаар хангах бодлого баримталдаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг өөрөө бие даан ажил хөдөлмөр эрхлэхэд тусалж дэмжих бөгөөд шаардлагатай арга хэмжээнүүдийг авдаг. Шаардлагатай үед энэ төрлийн арга хэмжээг зохион байгуулдаг мэргэжлийн байгууллагуудад хандах ба зардлыг яам хариуцна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд зуучлах үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хүнд зээл болон мөнгөн тусламж олгох зэргээр урамшуулан дэмждэг.

Хөдөлмөрийн яам ажилд зуучлах үйлчилгээг өргөжүүлэх, илүү хүртээмжтэй болгох үүднээс компьютерийн сүлжээ ажиллуулж байна. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэргэжлийн чадварыг сэргээх чиглэлээр ажилладаг байгууллагууд болон ажилд зуучлах байгууллагууд нь хоорондоо ажлын байрны талаарх, бусад төрлийн мэдээлэл солилцох боломжтой болжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хувиараа хөдөлмөр эрхлэхэд дэмжиж туслах (Support for Self-Employed Disabled Persons)

Хөдөлмөрийн яам нь бизнес эрхлэхээр төлөвлөж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжиж зээл олгох, бизнес явуулах байрыг хөнгөлөлттэй нөхцөлөөр түрээслэх зэргээр дэмжлэг үзүүлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд олгох дэмжлэг тусламж (support for disabled workers)

Хөдөлмөрийн яам хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд тогтвортой ажиллахад нь шаардлагатай тохиолдолд зээл олгодог.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын удирдамжаар хангах (Adjustment guidance after employment)

Хөдөлмөрийн яам болон Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамнаас хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үүднээс хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын орчинд хэрхэн ажиллах удирдамжаар хангана.

Бизнес эрхлэгчид зориулсан удирдамж (Employment Guidance for Business Proprietors)

Хөдөлмөрийн яам хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилуулдаг болон ажиллуулахаар төлөвлөж буй бизнес эрхлэгчийг шаардлагатай удирдамжаар хангана. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажил эрхлэлт, түүнд үзүүлэх тусламж дэмжлэг, түүний ажиллах орчин, тоног төхөөрөмж болон бусад асуудлын оруулна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг түүний онцлогт тохирсон ажиллах орчноор хангах (Support for Standard Workplaces for Disabled Persons)

Хөдөлмөрийн яам нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний стандартад тохирсон ажлын орчин бүрдүүлсэн болон уг орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан бизнес эрхлэгчид зээл болон мөнгөн тусламж олгох зэргээр дэмжлэг үзүүлнэ. Ялангуяа, энэхүү орчныг хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүнд зориулсан бол зээл, мөнгөн тусламж үзүүлэхэд илүү давуу эрх олгоно.

Солонгосын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих агентлаг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой Солонгосын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих агентлаг (*Korea employment agency for the disabled*) ажилладаг. Агентлаг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээлэл цуглуулж судалгаа, дүн шинжилгээ хийх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил болон ажлын орчинд дасан зохицох бэлтгэл сургалт явуулах, ажилд зуучлах гэх мэт олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг.

Бусад хүний нэгэн адил хөгжлийн бэрхшээлтэй иргэн ч өөрийн гэсэн тогтмол орлогогүйгээр, өөрөөр хэлбэл, ажиллаж хөдөлмөрлөхгүйгээр сайхан амьдрах боломжгүй юм. Иймд Хөдөлмөрийн яамнаас тэднийг тогтмол ажилтай байлгахад илүү анхаарлаа хандуулдаг. Энэ хүрээнд яамнаас зарим чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, 300-аас дээш ажилтантай компаний ажилчдын 2% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байх талаар шийдвэр гаргажээ¹⁹⁷. Компани үүнийг биелүүлэхгүй бол торгууль төлөх юм. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлаар хангасан компанид татварын хөнгөлөлт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний цалин мөнгөнд тусламж үзүүлнэ.

Сүүл хотын засаг захиргаанаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор жил бүр шинээр бий болж буй төрийн албаны орон тооны 10%-д нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулахаар болсон байна¹⁹⁸. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтмол ажилтай болгож, тэдний тогтвортой амьжиргааг хангахад чухал хувь нэмэр оруулах юм.

5.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, тэтгэмж¹⁹⁹

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Үндэсний тэтгэвэрийн сангаас тахир дутуугийн тэтгэвэр авдаг бөгөөд тэтгэврийн хэмжээ хөгжлийн бэрхшээлийн зэргээс хамаардаг. Хөгжлийн бэрхшээлийн зэргийг 4 ангилдаг. Хөгжлийн бэрхшээлийн 1, 2, 3 дугаар зэрэг бүхий иргэн энэхүү тэтгэврийг авах эрхтэй. Харин 4 дүгээр зэрэг бүхий иргэнд нэг удаа бөөнд нь мөнгөн тэтгэмж олгоно.

¹⁹⁷<http://mojseul.ru/obshhestvo/lyudi-s-ogranichennymi-vozmozhnostyami.html>

¹⁹⁸Мөн тэнд.

¹⁹⁹Social Security programs throughout the world: Asia and the Pacific, 2012. www.ssa.gov/

Хөгжлийн бэрхшээлийн зэрэг нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- 1 дүгээр зэрэг буюу хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бөгөөд байнгын асаргаа сувилгаанд байх шаардлагатай.
- 2 дугаар зэрэг буюу хөдөлмөрийн чадвараа их хэмжээгээр алдсан.
- 3 дугаар зэрэг буюу хөдөлмөрийн чадвараа бага хэмжээгээр алдсан.
- 4 дүгээр зэрэг буюу хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан.

Үндэсний тэтгэврийн корпораци нь хөгжлийн бэрхшээлийн зэргийг тодорхойлж, тэтгэврийн хэмжээг тогтоодог.

Ийнхүү хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр өгөхөөс гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэр бүл, түүнд хамааралтай зарим хүмүүст нэмэгдэл нөхөн олговор олгоно. Үүнд дараах хүмүүс хамрагдана:

- хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэр бүлийн хүн;
- 18-аас доош насны, эсвэл 1, 2 дугаар зэргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэний 60 ба түүнээс дээш насны, эсвэл 1, 2 дугаар зэргийн хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэр бүлийн хүний 60 ба түүнээс дээш насны, эсвэл 1, 2 дугаар зэргийн хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх орно.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Constitutions of People's Republic of China, 1982. www.constitution.org/cons/china.txt
- Law on the Protection of Persons with Disabilities 1990. www.cdpf.org.cn/english/
- Education Law of the People's Republic of China, 1995. www.moe.edu.cn/
- Higher Education Law of the People's Republic of China. www.moe.edu.cn/
- law of Labor in China, 1994. www.jus.uio.no/lm/china.labor.law.1994/doc.html
- Regulations on the Employment of Persons with Disabilities. www.cdpf.org.cn/english/
- Regulations on the education of persons with disabilities, Beijing, China, 1997. www.cdpf.org.cn/english/
- Old age, disability, survivors Regulatory Framework 2011. www.socialsecurity.gov/
- The Protection of Rights of People with Disabilities in China, By Eric Zhang. www.disabilityworld.org/
- Statistical Communique on the Development of the Work for Persons with Disabilities in 2013. www.cdpf.org.cn/english/statistics/
- China Disabled Persons' Federation. www.cdpf.org.cn/english/
- Act on Welfare of persons with disabilities. http://elaw.klri.re.kr/eng_mobile/
- Act on special education for the disabled persons. http://elaw.klri.re.kr/eng_mobile/
- Employment promotion and vocational rehabilitation of disabled persons. http://elaw.klri.re.kr/eng_mobile/
- Social Security programs throughout the world: Asia and the Pacific, 2012. www.ssa.gov/
- ФЗ "О социальной защите инвалидов в российской федерации." www.docs.cntd.ru
- ФЗ "Трудовой кодекс". <http://base.garant.ru>
- ФЗ "О социальной защите инвалидов в российской федерации." www.docs.cntd.ru
- ФЗ "Об образовании". www.consultant.ru
- ФЗ "о государственном пенсионном обеспечении". www.consultant.ru
- Schwerbehindertengesetz (SchwbG). <http://behinderung.org/gesetze/schwbG.htm>
- SGBXII. www.gesetze-im-internet.de
- Disability Discrimination Act 1992. www.comlaw.gov.au
- Social Security Act 1991. www.comlaw.gov.au

ГАНЦ БИЕ ЭЦЭГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХАНДЛАГА

Р.Хатанбаатар, А.Пагма, Д.Жигваагүнсэл,
Р.Нургул, Б.Ариунжаргал

Гадаадын зарим орны туршлагаас үзэхэд бүрэн бус гэр бүл, түүн дотроо ганц бие эцэгтэй гэр бүлийг төрийн зүгээс анхаарч ихээхэн дэмжлэг, тусламж үзүүлдэг болох нь харагдаж байна. Ялангуяа Европын улсуудад бүрэн бус гэр бүлийг бий болсон шалтгаанаас нь үл хамааран нэгдсэн нийгмийн бодлого хэрэгжүүлдэг ажээ.

Өнөөгийн байдлаар хүүхэдтэй гэр бүл, түүний дотор бүрэн бус гэр бүлд төрийн зүгээс халамж, хөнгөлөлт үзүүлдэг дараах 4 үндсэн хэлбэр бий. Үүнд:

1. Хүүхэд төрсөн, түүнийг өсгөн хүмүүжүүлэхтэй холбоотой мөнгөн төлбөр (тэтгэмж, тэтгэвэр);
2. Хөдөлмөр, татвар, орон сууц, зээл, эрүүл мэндийн болон бусад хөнгөлөлт үзүүлэх;
3. Гэр бүл ба хүүхдэд хүүхдийн хүнс, тэжээл, эм, хувцас, жирэмсэн эмэгтэйчүүдэд хоол, хүнс үнэгүй олгох;
4. Гэр бүлд тодорхой хууль, эрх зүй, сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх тусламж, зөвөлгөө өгөх, нийгмийн үйлчилгээ үзүүлэх зэрэг болно.

Монгол Улс болон гадаадын зарим улсын ганц бие эцгүүдэд үзүүлдэг нийгмийн халамж, үйлчилгээний талаар доор авч үзье.

1. БҮГД НАЙРАМДАХ ФИЛИППИН УЛС

1.2 Хууль эрх зүйн орчин

Филиппин улсын хувьд өрх толгойлсон ганц бие эцгийн асуудлыг *Ганц бие эцэг, эхийн халамжийн тухай (Solo Parent's Welfare act)* хуулиар зохицуулдаг. Уг хууль 2000 онд батлагдсан ба түүнийг хэрэгжүүлэх журам болон зохицуулалтуудыг 2002 онд гаргасан байна.

Хуулийн зорилт нь өрх толгойлсон ганц бие эцэг/эх болон түүний хүүхдийг дэмжих, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах явдал юм. Түүнчлэн, Нийгэм хамгаалал, хөгжлийн газраас (Department of Social Welfare and Development) боловсруулсан “Өрх толгойлсон ганц бие эцэг/эх, түүний хүүхдэд зориулсан халамжийн цогц үйлчилгээ-хөтөлбөр”-ийг холбогдох төрийн агентлагууд, төрийн бус байгууллагууд хэрхэн хүргэх талаар зохицуулна.

Өрх толгойлсон ганц бие эцэг/эхэд дараах хүмүүсийг хамруулах ба дээр дурдсан халамжийн үйлчилгээг авах эрхтэй. Үүнд:

- Хүчингийн хэргийн улмаас жирэмсэлж, хүүхдээ төрүүлсэн эх;
- Эцэг, эсвэл эх нас барсан;
- Эцэг, эсвэл эх 1 ба түүнээс дээш жилийн хугацаатай ял шийтгэл хүлээн хоригдож байгаа;
- Эцэг, эсвэл эх физиологийн болон оюуны чадамжаа алдсан;
- Хууль ёсны салалт, эсвэл де факто салалтын улмаас хүүхэд асрах үүрэг хүлээсэн эцэг/эх;
- Гэрлэлтийг шүүхийн, эсвэл сүмийн шийдвэрээр хүчингүй болгосон ба түүний улмаас дангаараа хүүхдээ асрах үүрэг хүлээсэн эцэг/эх;
- Хүүхдээ бусдаар, эсвэл асрамжийн байгууллагаар бус өөрөө өсгөн хүмүүжүүлж буй гэрлээгүй эцэг/эх;

- Ганцаараа хүүхэд өсгөн хүмүүжүүлж буй дурын хүн. (Нийгэм хамгаалал, хөгжлийн газраас албан ёсоор үрчлэх эрх авсан, эсвэл шүүхийн шийдвэрээр албан ёсны асран хамгаалагчаар томилогдсон байх);
- Эцэг/эх нь 1 ба түүнээс дээш жилээр гэр бүлээ орхиж явсан. Тухайлбал, эцэг/эх алга болох, урт хугацаагаар хол яваад сураггүй байгаа, тусдаа амьдардаг гэх мэт.

1.2 Нийгмийн халамж, хандлага

Өрх толгойлсон ганц бие эцэг/эхийн ID карт

Орон нутгийн Нийгэм хамгаалал, хөгжлийн газраас өрх толгойлсон ганц бие эцэг/эхэд ID карт (үнэмлэх) олгох ба ингэснээр холбогдох байгууллагуудаас халамжийн үйлчилгээ авах боломжтой болох юм. ID карт авахын тулд нийгмийн ажилтанд шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлж өгөх бөгөөд нийгмийн ажилтан өрх толгойлсон эцэг/эхтэй сайтар ярилцаж, түүний нөхцөл байдлын талаарх тооцоолол болон үнэлгээг хийнэ.

ID картыг материал өгснөөс хойш 30 хоногийн дараа олгоно. Түүний хүчинтэй хугацаа 1 жил бөгөөд хугацаа дуусахаар сунгана. Хэрэв өрх толгойлсон эцэг/эхийн нөхцөл байдал өөрчлөгдсөн бол сунгалт хийхэд тухайн өөрчлөлтүүдийг нэмж хийнэ.

Өрх толгойлсон ганц бие эцэг/эхэд зориулсан халамжийн цогц үйлчилгээ-хөтөлбөр

Үүнд өрхийн амьжиргааг дэмжих, хувиараа хөдөлмөр эрхлэх ур чадварыг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэхэд үзүүлэх хөнгөлөлтүүд, нийгмийн болон сэтгэл зүйн, боловсролын, эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх, орон байраар хангах зэрэг үйлчилгээнүүд багтана.

Халамжийн үйлчилгээнд өрх толгойлсон эцэг/эхээс гадна түүний гэрлээгүй, ажил эрхэлдэггүй 18-аас доош насны хүүхэд, 18-аас дээш настай боловч хөгжлийн бэрхшээлтэй бие даан амьдрах чадваргүй хүүхдийг хамруулна.

Хэрэв өрхийн орлого нь *Үндэсний эдийн засаг хөгжлийн газраас* тогтоосон хязгаараас доош буюу ядуурлын түвшинд байгаа бол халамжийн үйлчилгээ-хөтөлбөрт бүхэлдээ хамрагдана. Харин боломжийн орлоготой бол зөвхөн уян хатан ажлын цаг, эцэг/эхийн чөлөө болон Нийгэм хамгаалал, хөгжлийн газраас тодорхойлсон бусад үйлчилгээнд хамрагдана.

Халамжийн үйлчилгээ-хөтөлбөрийг дараах байгууллагууд хариуцдаг. Үүнд:

- Эрүүл мэндийн үйлчилгээг Эрүүл мэндийн газар (Department of Health);
- Боловсролын үйлчилгээг Дээд Боловсролын Комисс болон Техникийн боловсрол, ур чадварын хөгжлийн газар (Commission on Higher education, Technical Education and Skill Development Authority);
- Орон байрны үйлчилгээг Үндэсний Орон сууцны газар (National Housing Authority);
- Эцэг/эхийн чөлөөг Ажил олгогч, Хөдөлмөр, ажил эрхлэлтийн газар, Төрийн албаны зөвлөл (Employer, Department of Labor and Employment, Civil Service Commission) тус тус хариуцана.

Хөдөлмөр эрхлэхэд үзүүлэх хөнгөлөлтүүд

Уян хатан ажлын цаг:

Ажил олгогч нь өрх толгойлсон эцэг/эхийн ажлын цагийг уян хатан зохицуулах үүрэгтэй. Хөдөлмөр, ажил эрхлэлтийн газраас дараах уян хатан ажлын цагийг тодорхойлсон байна.

Үүнд:

- Compressed workweek - Ажлын хоногийг шахах. Энэ нь 7 хоногт 6 өдрийн нийт 48 ажлын цагийг 5 өдөрт буюу өдрийн 9.6 цагаар ажиллаж 1 өдрийн амралт гаргах юм. Энэ тохиолдолд илүү цагийн мөнгө бодогдохгүй, харин хоол унааны болон бусад нэмэгдэл ажлын 6 өдрөөр тооцогдоно.
- Gliding time schedule – Ажлын цагийг нөхөн ажиллах. Өглөө ажил эхэлсэний дараа тодорхой цагт ирж болох ба орой нөхөж ажиллана. Тухайлбал, ажилдаа өглөө 7-9 цагийн хооронд ирэх бөгөөд ирсэн цагаасаа ажлын 8 цагийг гүйцээн ажиллах юм.
- Зөвшөөрөгдсөн бусад ажлын цагийн хуваарь байж болно.

Өрх толгойлсон эцэг/эх хүсэлт гаргасан тохиолдолд ажил олгогч энэхүү хөнгөлөлтийг олгоно. Энэ нь байгууллагын ажлын бүтээмжид нөлөөлөхгүй байх ёстой. Хэрэв зайлшгүй үндэслэл шалтгаантай бол ажил олгогч энэ үүргээс татгалзах боломжтой. Энэ тохиолдолд Хөдөлмөр, ажил эрхлэлтийн газарт хүсэлт гаргана.

Ажил эрхлэхэд ялгаварлан гадуурхахгүй байх нөхцөлөөр хангах:

Ажил олгогч нь өрх толгойлсон эцэг/эхийг түүний амьдралын нөхцөл байдал, хөнгөлөлттэй нөхцөл эдэлсний төлөө болон бусад шалтгаанаар ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглосон байна.

Эцэг/эхийн чөлөө:

Энэ нь хүүхдийнхээ өмнө эцэг, эхийн үүрэг, хариуцлагыг биелүүлэх боломж бүрдүүлэх зорилготой юм. Үүнийг *Ганц бие эцэг, эхийн халамжийн тухай* хуулиас гадна Төрийн албаны комиссын 2004 оны 8 дугаар Санамж бичигт бас тусгажээ.

Эцэг/эхийн чөлөөг өрх толгойлсон эцэг/эхийн ID олгогдсоны дараа эдлэх боломжтой бөгөөд заавал нэг удаад биш, жилийн турш хуваан авч болно. Энэ нь ажлын 7 хоногийн хугацаатай, цалинтай олгогдоно.

Энэхүү чөлөөг өрх толгойлсон ганц бие эцэг/эхийн өөртөй нь хамт амьдардаг 18-аас бага насны, мөн хөгжлийн бэрхшээлтэй 18 ба түүнээс дээш настай хүүхэд бүрийн хувьд олгоно.

Эцэг/эхийн чөлөөнд дараах нөхцөл, шаардлагууд тавигдана. Үүнд:

1. Өрх толгойлсон эцэг/эх 1 жил ажилласан байх (тасралтгүй, тасарсан байж болно).
2. Эцэг/эхийн чөлөө нь жил бүр олгогдох бөгөөд чөлөөний оронд мөнгө авч болохгүй. Энэхүү чөлөөг тухайн жилдээ багтаан авах бөгөөд авч чадаагүй бол тухайн жилийн хувьд хүчингүй болно.
3. Чөлөөг нэг удаад, эсвэл хуваан авах эсэхийг эцэг/эх ажиллаж буй байгууллагын удирдлагатай зөвшилцөж шийднэ. Яаралтай, онцгой тохиолдлоос бусад үед чөлөө авахаас ядаж 7 хоногийн өмнө хүсэлт гаргана.
4. Эцэг/эхийн чөлөөг дараах онцгой тохиолдлуудад авч болно. Үүнд:
 - Хүүхдийн төрсөн өдөр, төгсөлтийн баяр зэрэг онцгой үйл явдал тэмдэглэх;
 - Сургуулиас зохион байгуулж буй арга хэмжээ, багш-эцэг эхийн зөвлөлийн уулзалтад оролцох;
 - Хүүхэд өвдөх, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах;
 - Хүүхдийн оролцох арга хэмжээнд эцэг/эх нь заавал байлцах бусад арга хэмжээнүүд.
5. Тухайн байгууллагын удирдлага эцэг/эхийн чөлөөг олгох эсэхийг, эсвэл чөлөө авах эрх дуусгавар болох, хүчингүй болох үндэслэл байгаа эсэхийг тодруулахын тулд шалгалт хийх эрхтэй.

Бусад халамжийн үйлчилгээнүүд

Боловсролын үйлчилгээ: Дээд Боловсролын Комисс болон Техникийн боловсрол, ур чадварын хөгжлийн газраас өрх толгойлсон ганц бие эцэг/эх, түүний хүүхдэд суурь болон дээд боловсрол, албан бус боловсрол олгох, техник ур чадварыг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Эрүүл мэндийн үйлчилгээ: Эрүүл мэндийн газар нь эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд, тэдгээрийн орон нутаг дахь салбар, нэгжээр дамжуулан өрх толгойлсон ганц бие эцэг/эх түүний хүүхдэд эрүүл мэндийн цогц үйлчилгээг үзүүлнэ.

Орон байраар хангах: Үндэсний орон сууцны газар нь Засгийн газраас хэрэгжүүлж буй, үнийн хувьд хямд бөгөөд уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон байраар хангах хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулдаг.

Өрх толгойлсон ганц бие эцэг, эхийн халамжийг зогсоох

Өрх толгойлсон ганц бие эцэг/эх хүнтэй сууж гэр бүл болох, гэрээс яваад сураггүй байсан эцэг/эх буцаад ирэх болон бусад тохиолдлоор хуулинд заасан нөхцөл байдал өөрчлөгдвөл халамжийн үйлчилгээг дуусгавар болгоно.

2. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС**2.1 Хууль эрх зүйн орчин**

Солонгосын *Ганц бие эцэг/эхтэй гэр бүлийг дэмжих тухай хууль (Single-parent Family Support act)* нь 1989 онд батлагджээ. Хуулиар ганц бие эцэг/эхтэй гэр бүлийн тогтвортой амьжиргааг дэмжих, эрүүл, соёлтой амьдралын нөхцөл бүрдүүлэх зохицуулалтуудыг хийсэн байна.

Энэ хууль нь анх *Ганц бие эх болон хүүхдийн халамжийн тухай хууль* нэртэй, зөвхөн өрх толгойлсон ганц бие эхийг дэмжих зорилготой байсан бөгөөд яваандаа хүүхдийн асуудлыг хамруулж ганц бие эх, түүний хүүхдийг дэмжихэд чиглэгдэж байв. 2005 оноос хуулийн хамрах хүрээ улам өргөжиж ганц бие эцгийн асуудлыг мөн адил авч үзэх болжээ. 2007 оноос хүүхэд өсгөн хүмүүжүүлж буй ганц бие эцэг/эхийн асуудлыг гэр бүлийн хэмжээнд тодорхойлж, өөрчлөн найруулснаар одоогийн *Ганц бие эцэг/эхтэй гэр бүлийг дэмжих тухай* хууль гарсан байна. Хууль гарснаас хойш хөгжлийнхөө явцад хэд хэдэн удаа нэр нь өөрчлөгдсөн бөгөөд 20 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Ганц бие эцэг/эх гэж хүүхдээ өөрөө өсгөн хүмүүжүүлж буй дараах хүмүүсийг хэлнэ. Үүнд:

- Эхнэр/нөхөр нас барсан, салсан, тусдаа амьдардаг;
- Эхнэр/нөхөр урт хугацаанд биеийн болон оюуны чадамжаа алдаж хөдөлмөрийн чадваргүй болсон;
- Эхнэр/нөхөр ял шийтгэл хүлээн хоригдож байгаа, эрүүл мэндийн улмаас эмнэлэг, эсвэл асрамжийн байгууллагад байгаа, цэргийн алба хааж буй;
- Гэрлээгүй хүн (де факто харилцаа хамаарахгүй);
- 24 ба түүнээс доош настай буюу өсвөр насны ганц бие эцэг/эхийг багтаана.

Хуулинд тодорхойлсноор ганц бие эцэг/эхтэй гэр бүл гэж “эцэг болон хүүхэд”, эсвэл “эх болон хүүхэд”-тэй гэр бүлийг хэлнэ. Хүүхдийн хувьд 18-аас доош насны хүүхдийг хамруулж ойлгоно. Мөн 22-оос доош настай, сургуульд суралцдаг, эсвэл цэргийн алба хаасны дараа суралцаж буй хүүхдийг хамруулна.

2.2 Нийгмийн халамж, хандлага

Жендерийн тэнцвэрт байдал ба гэр бүлийн яамнаас шийдвэр гарснаар ганц бие эцэг/эхтэй гэр бүл халамжийн үйлчилгээ авах эрх үүснэ. Энэ үйлчилгээнд ганц бие эцэг/эх, түүний хүүхэд хамрагдах бөгөөд мөнгөн болон мөнгөн бус халамжийн үйлчилгээнүүдийг үзүүлнэ.

Тэтгэмж тэтгэлэг олгох:

- Амьжиргааны тэтгэмж;
- Хүүхдийн сургалтын тэтгэлэг;
- Хүүхэд асрах тэтгэмж;
- Ерөнхийлөгчийн шийдвэрээр зөвшөөрөгдсөн бусад төрлийн тэтгэмжийг авна.

Түүнчлэн дараах тохиолдолд **халамжийн сангаас зээл** авах боломжтой:

- Бизнес эрхлэхэд;
- Хүүхдийн сургалтын төлбөр;
- Эмчилгээний төлбөр;
- Орон байрны төлбөр;
- Ерөнхийлөгчийн шийдвэрээр зөвшөөрөгдсөн бусад зээл болно.

Мөнгөн тусламжаас гадна **ганц бие эцэг/эхтэй гэр бүлийг дэмжихэд дараах үйлчилгээнүүдийг** хэрэгжүүлдэг (*family support service*). Үүнд:

- Хүүхэд харах болон боловсрол олгоход туслах;
- Хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, архаг хүнд өвчтэй хүмүүст тусламж үзүүлэх;
- Хоол хийх, цэвэрлэгээ, угаалга зэрэг гэр орны ажилд туслах;
- Гэр бүлийн холбоог бэхжүүлэх талаар боловсрол олгох, зөвлөгөө өгөх;
- Хууль эрх зүйн зөвлөгөө өгөх;
- Ерөнхийлөгчийн шийдвэрээр зөвшөөрөгдсөн бусад үйлчилгээг үзүүлнэ.

Өсвөр насны ганц бие эцэг/эхэд зориулсан боловсролын дэмжлэг. Үүнд:

- Сургууль завсардуулахгүй байх, сургалтын төлбөр, боловсролын зэрэг олгох шалгалт өгөхөд дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- lifelong education²⁰⁰ хөтөлбөрөөр боловсрол эзэмшиж байгаа тохиолдолд сургалтын төлбөрийг төлөх;
- Бага дунд боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан дэмжлэгийг хэрэгжүүлэх буюу амьдралын гачигдалтай байдлаас сургууль завсардахад хүрсэн болон завсардсан суралцагчийг уян хатан хичээлийн цаг, сургалтын хөтөлбөрөөр хангах;
- бусад дэмжлэгээр хангана.

Өсвөр насны ганц бие эцэг/эхийн боловсролын асуудлаар Жендерийн тэнцвэрт байдал, гэр бүлийн яам нь Боловсролын яамтай хамтарч ажилладаг.

Түүнчлэн, өсвөр насны ганц бие эцэг/эхийн амьдрах чадавхийг дэмжих зорилгоор орон байр зэрэг үл хөдлөх хөрөнгөтэй болоход нь мөнгөн тусламж үзүүлнэ.

Ганц бие эцэг/эхийн гэр бүлд чухал шаардлагатай халамжийн нэг төрөл амьдрах орон байраар хангах дэмжлэг юм. “Ээж ба хүүхэд”, “Аав ба хүүхэд”, “Гэрлээгүй ээж ба хүүхэд” гэр бүлийг орон байраар хангах, амьдрах нөхцөлөө сайжруулахад тусламж дэмжлэг үзүүлнэ.

²⁰⁰Амьдралын гачигдлаас шалтгаалж сургуульд суралцан боловсрол эзэмших боломжгүй хүмүүст зориулсан боловсрол олгох хөтөлбөр.

Мөн ганц бие эцэг/эхтэй гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүд ажилладаг.

Ганц бие эцэг/эхтэй гэр бүлийг дэмжихэд төр, орон нутгийн засаг захиргаа болон олон нийтийн зүгээс дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Ганц бие эцэг/эхтэй гэр бүлийн эрх ашгийг хамгаалах;
- Халамжийн үйлчилгээ үзүүлэх;
- Өөрийн хүчээр амьдрах чадварыг дэмжих;
- Боловсрол эзэмших болон бусад нийгмийн харилцаанд ямар нэг байдлаар хохирох, ялгаварлан гадуурхагдахаас урьдчилан сэргийлэх. Нийгмийн холбоо, нэгдлийн гишүүн бүр ганц бие эцэг/эхтэй гэр бүлийн байдлыг ойлгож, дэмжих үүрэгтэй;
- Иргэн бүр ганц бие эцэг/эхтэй гэр бүлд дэмжлэг үзүүлнэ.

Ганц бие эцэг/эхтэй гэр бүл дараах эрх, үүргийг эдэлнэ:

- Бусдын адил сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх эрхтэй. Зүй бусаар жирэмлэсэн, хүүхэд төрүүлсэн, ганц бие эцэг/эх болсны төлөө ялгаварлан гадуурхаж болохгүй.
- Ганц бие эцэг/эх, түүний хүүхэд давуу тал болон хөдөлмөрийн чадвараа ашиглаж өөрийн хүчээр амьдарлын нөхцөл байдлаа сайжруулахын төлөө санаачилгатай амьдарна.

Ганц бие эцэг/эхтэй гэр бүлийн халамжид зарцуулагддаг зардлын талаар авч үзье. Ганц бие эцэг/эхтэй гэр бүлд 1992 онд 40 орчим тэрбум вон зарцуулж байсан бол энэ тоо 2011 онд 780 тэрбум вон хүрчээ. Нийгмийн халамжийн зардлын ДНБ-д эзлэх хувь 1992 онд 3 хувь байснаа 2011 онд 10 хувь хүрч хурдтай өссөн. Харин ганц бие эцэг/эхтэй гэр бүлд зориулсан зардлын Нийгмийн халамжийн зардалд эзлэх хувь 1992 онд 0.04 хувиас 2001 онд 0.06 хувь хүрч, удааширалттай өссөн байна.

Хүснэгт 1. Нийгмийн халамжийн болон Ганц бие эцэг/эхтэй гэр бүлийн халамжийн зардал²⁰¹ (1992-2011, тэрбум воноор)

Он	ДНБ (А)	Нийгмийн халамжийн зардал (В)	Нийгмийн халамжийн зардал ДНБ-д эзлэх хувь (В/А)	Ганц бие эцэг/эхтэй гэр бүлийн халамж (С)	Ганц бие эцэг/эхтэй гэр бүлийн халамж Нийгмийн халамжийн зардалд эзлэх хувь (С/В)
1992	263.993	8.632	3.27	4	0.04
1993	298.762	10.104	3.38	5	0.05
1994	349.973	12.030	3.44	7	0.05
1995	409.654	14.984	3.66	7	0.05
1996	460.953	17.701	3.84	9	0.05
1997	506.314	21.769	4.30	11	0.05
1998	501.027	31.120	6.21	13	0.04
1999	549.005	37.700	6.87	13	0.04
2000	603.236	34.309	5.69	16	0.05
2001	651.415	38.866	5.97	19	0.05
2002	720.539	41.337	5.74	18	0.04
2003	767.114	46.500	6.06	18	0.04
2004	826.893	55.737	6.74	17	0.03
2005	865.241	61.873	7.15	21	0.03

²⁰¹Ministry of Gender Equality and Family Republic of Korea., Modularization of Korea's Development Experience: Korea's support policies for single parent families., 2014. www.kdevelopedia.org/

2006	908.744	73.760	8.12	33	0.05
2007	975.013	81.482	8.36	35	0.04
2008	1.026.452	93.429	9.10	45	0.05
2009	1.065.037	112.060	10.52	55	0.05
2010	1.173.275	118.775	10.12	74	0.06
2011	1.235.161	127.845	10.35	78	0.06

Хүснэгтээс харахад 1992 оноос хойш хориод жилийн дотор нийгмийн халамжийн зардал ДНБ-тэй харьцуулахад хурдацтай өссөн мөртлөө ганц бие эцэг/эхийн гэр бүлд зориулсан халамжийн зардал дөнгөж 0.04-0.06 хувиар буюу бага зэрэг л өссөн байна.

Анхны хууль буюу *Ганц бие эх түүний хүүхдийн халамжийн тухай* хууль хэрэгжсэнээс хойш ганц бие эцгийн гэр бүлийн асуудал бүхэлдээ орхигдсон бөгөөд сүүлийн 10 жилийн байдлаар ийм гэр бүлийн тоо нэмэгдэн, асуудал улам хүндрэх болжээ. Ганц бие өрх толгойлсон эхийнхтэй харьцуулахад тэдний асуудал илүү хүнд нөхцөлд байв. Иймээс хуулийг *Ганц бие эцэг, эх болон хүүхдийн халамжийн тухай* хууль болгон өөрчилсөн бөгөөд хуулийн хамрах хүрээг өргөжүүлэн, ганц бие эцгийн асуудлыг ч авч үздэг болсон.

Ер нь тооцоо судалгааны 95 хувь ганц бие эхийн тухай байдаг бол дөнгөж 5 хувь нь ганц бие эцгийн асуудлыг хөнджээ. Хэдийгээр хуулиндаа ганц бие эцгийн асуудлыг мөн адил тусгасан боловч ганц бие эхийн асуудал хамгийн түрүүнд хамгийн ихээр яригддаг, түүнд илүү ач холбогдол өгдөг. Харин бодит байдалд, хүүхдээ өөрөө өсгөн хүмүүжүүлж буй ганц бие эцгийн асуудал илүү эмзэг бөгөөд илүү их анхаарал халамж шаарддаг байна. Ганц бие эцгийн асуудал дөнгөж 5 хувь эзэлж байгаа нь тэдний ихэнх нь дахин гэр бүл зохиодогтой холбоотой. Харин ээж нарын хувьд эсрэгээрээ бөгөөд тэд ихэнх тохиолдолд дахин гэрлэхээс илүүтэй өөрөө гэр бүлээ авч явахын төлөө тууштай зүтгэдэг байна.

Жендэрийн тэнцвэрт байдал ба гэр бүлийн яамнаас 3 жил тутамд ганц бие эцэг/эхтэй гэр бүлийн асуудал болон түүнд зориулж буй халамж үйлчилгээний талаар судалгаа хийж, бодлого боловсруулахад ашигладаг байна.

3. НИДЕРЛАНДЫН ВАНТ УЛС²⁰²

Нидерландад өрх толгойлсон эцэг гэх ойлголт байдаггүй харин ганц бие эцэг, эх гэсэн ойлголт түгээмэл байна. Нидерландын бүх хүүхэдтэй өрхүүдийн 16 хувь нь ганц бие эцэг эсвэл эхчүүд байдаг байна. Энэ нь бусад оронтой харьцуулахад харьцангуй бага хувьтай үзүүлэлт юм. Нидерландын гэрлэлтийн хувь их өндөр, харин гэр бүл салалтын хувь нь дундаж байдаг. Ганц бие эцэг, эхийн тоог харьцуулан үзэхэд ганц бие эцэг нь эхээс харьцангуй цөөн байх боловч сүүлийн жилүүдэд нэлээд нэмэгдэж байгаа ажээ. Энэ нь нийгмийн байдал, гэрлэлт цуцлах үйл явц өөрчлөгдсөн зэрэг олон шалтгаантай юм байна.

3.1 Хууль эрх зүйн орчин

Тус улсад ганц бие эцэг, эхчүүдэд үзүүлдэг нийгмийн халамж, үйлчилгээний харилцааг дараах хууль, хөтөлбөрүүдээр нарийн зохицуулсан байдаг. Тухайлбал;

- Хөдөлмөр ба нийгмийн халамжийн хууль (Work and Social Assistance Act),
- Хөдөлмөрийн хууль (Labour Law),
- Нидерландын Иргэний Хууль (The Civil Code of the Netherlands),

²⁰²www.government.nl/documents-and-publications/

- Хүүхдийн Тэтгэмжийн тухай Ерөнхий Хууль (General Child Benefit Act-AKW),
- Нас барагсдын ар гэрийнхний тухай Ерөнхий хууль (General Surviving Relatives Act - ANW),
- Бэлэвсэрсний ба Өнчирсний Тэтгэмжийн тухай Ерөнхий Хууль (General Widow's and Orphan's Benefit Act),
- Эрүүл мэндийн онцгой зардлын тухай хууль (AWBZ),
- Ажилгүйдлийн даатгалын хууль (WW),
- Нэмэлт тэтгэмжийн тухай хууль (TW),
- Ажил ба Нийгмийн Тусламжийн Хууль (WWB),
- Ахмад болон Хөдөлмөрийн чадвараа (35 хувь) алдсан ажилгүй хүмүүсийн схемийн хууль (IOAW),
- Ахмад болон Хөдөлмөрийн чадвараа (35 хувь) алдсан, урьд нь хувиараа хөдөлмөр эрхэлж байсан хүмүүсийн орлогын схемийн тухай хууль (IOAZ) зэрэг ганц бие эцэг эсвэл эхийн авах тэтгэмж зэргийг тусгайлан заасан хуулиудтай байдаг байна.

Нидерланд улс нь ганц бие эцэг, эхчүүдийн нийгмийн халамжийг хэрхэн яаж олгохыг хуулиар нарийн зохицуулсан байдаг бөгөөд ганц бие эцэг, эхчүүдийг адил хэмжээнд авч үздэг ажээ.

3.2 Нийгмийн халамж, үйлчилгээ

Ганц бие эцэг ба эхчүүдэд ажилдаа эргэн орох урамшуулал хэлбэрийн мөнгө өгдөгөөс өөр тусгайлсан тэтгэмж байдаггүй. Ганц бие эцэг эсвэл эх хэрвээ 5-аас доош насны хүүхэдтэй бол заавал ажил хөдөлмөр эрхлэх албагүй. Хотын захиргаанаас тэднийг Нийгмийн Тусламжийн хөтөлбөрт (моргэйжийн зээлийн хүү төлөхөд туслах төлбөрийг оролцуулж бас болдог) хамруулан саяхныг болтол амьдралын баталгаажих түвшний бараг 90 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгож байв. Үүний ихэнхийг төв Засгийн газар санхүүжүүлнэ. Энэ тэтгэмжийг бага орлоготой өрхүүдэд тэтгэмж болгон хоёр жилийн хугацаатайгаар олгож болох ба хотын захиргаа шийдвэрлэнэ.

Нидерланд улсад бараг бүх нийтээрээ үндэсний даатгалын тогтолцоо ба нийгмийн хамгааллын тэтгэмжид хамрагддаг. Тодорхой хэлбэл, энэ улсад ажил хөдөлмөр эрхэлж буй хэн боловч цаанаа даатгагдсан орлогын албан татвар төлнө. Мөн цалинтай ажил эрхэлж буй хэн боловч ажилтан, албан хаагчийн даатгалын схемд хамрагдах үүрэгтэй. Тэгвэл албан даатгалд хамрагдаж чадаагүй хэн боловч тодорхой эрсдэлийг бууруулах нөхцөл бүхий сайн дурын даатгалд хамрагдах боломжтой. Үндэсний даатгалын схемээс гадна Нидерланд нь Нийгмийн хамгааллын тэтгэмжтэй ба энэ нь нийгмийн амьжиргааны доод түвшин хүртэлх маш бага орлого бүхий өрхүүдэд нэмэлт тэтгэмж өгөх зорилготой. Энэ схемд нь ганц бие эцэг эсвэл эх гэдгийг гэртээ 18 наснаас доош насны хүүхэдтэйгээ, түүний төлөө хүүхдийн тэтгэмж авч амьдардаг хүнийг хэлнэ гэжээ.

3.3 Хүүхдийн Тэтгэмжийн тухай Ерөнхий Хууль (General Child Benefit Act-AKW)

Хүүхдийн Тэтгэмжийн тухай Ерөнхий Хууль (AKW) -аар эцэг эхчүүдэд 18 хүртэлх насны хүүхдүүдээ асарч, өсгөхөд нь дэмжлэг болгон тэтгэмж олгоно. Үүнд 18 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эхчүүд хамрагдана. Хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээ нь хүүхдийн наснаас хамаарна. 1995 оны 1-р сарын 1-нээс өмнө төрсөн хүүхдүүдийн тухайд бас ам бүлийг тоог харгалзана.

Хүснэгт 2. Хүүхдийн тэтгэмжийн хэмжээ

1995 оны 1-р сарын 1-нээс өмнө төрсөн хүүхдүүд	
Нэг ам бүлд амьдарч буй 12-17 насны хүүхдүүдэд:	Улирал тутамд
1 хүүхэд	278,55 евро
2 хүүхэд	313,25 евро
3 хүүхэд	324,81 евро
4 хүүхэд	350,23 евро
5 хүүхэд	365,47 евро
6 хүүхэд	375,64 евро
7 хүүхэд	382,90 евро
8 хүүхэд	396,22 евро
9 хүүхэд	406,57 евро
10 хүүхэд	414,85 евро
1995 оны 1-р сарын 1-нд буюу түүнээс хойш төрсөн хүүхдүүд	
Хүүхдүүдэд	Улирал тутамд
0-5 насны хүүхдүүд	194,99 евро
6-11 насны	236,77 евро
12-17 насны	278,55 евро

Хүүхдийн тэтгэмж авах өргөдөл гаргах тухайд

Эцэг эхчүүдэд хүүхэдтэй болсон даруйд нь гэрт нь өргөдлийн маягтыг хүргүүлдэг. Учир нь шинээр төрсөн хүүхдийг бүртгүүлсэн даруйд нь түүний тухай болон эцэг, эхийн тухай мэдээллийг Хотын захиргаанаас нь Нийгмийн Даатгалын Банкинд (SVB) дамжуулдаг байна. Харин Нидерландад амьдардаггүй ба дөнгөж гэр бүлийн хамтаар Нидерландад шилжин ирээд буй хүмүүс Нийгмийн Даатгалын Банкинд өөрсдөө хандаж өргөдөл авах ёстой.

3.4 Нас барагсдын ар гэрийнхний тухай ерөнхий хууль (General Surviving Relatives Act - ANW)

Хэрвээ хань ижил, хамтран амьдрагч эсвэл эцэг, эх нас барвал энэ нь үлдэж буй хань ижилд эсвэл хүүхдүүдэд нь санхүүгийн хүндрэлтэй байдаг. Энэхүү хуулиар ард үлдсэн гэр бүл нь тэжээгчээ алдсаны тэтгэмжийг авах эрх, нөхцөл үүснэ. Өнчин хүүхдүүд бас энэ тэтгэмжийг авах эрхтэй.

Нас барагчийн ар гэрийнхэн дараах шаардлагуудыг хангаж байвал ANW тэтгэмжийг авна:

- Нас барагчийн ар гэрийн хүн 65-аас доош настай байх
- Нас барагчийн ар гэрийн хүн 1950 оноос өмнө төрсөн байх,
- 18-аас доош насны нэг буюу түүнээс олон хүүхэд асардаг бол,
- 45 ба түүнээс дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан зэрэг болно.

Энэ тэтгэмжийг авах эрх тухайн үлдсэн ар гэрийн хүн дахин гэр бүл зохиосноор, бүртгэл бүхий хамтран амьдрагчтай болсноор, эсвэл нэг гэрт хэн нэгэнтэй хамт амьдрах болсноор дуусгавар болдог байна. Мөн 1996 оны 7-р сарын 1-нээс өмнө ANW буюу «Бэлэвсэрсний ба Өнчирсний Тэтгэмжийн тухай Ерөнхий Хууль» (General Widow's and Orphan's Benefit Act)-ийн дагуу тэжээгчээ алдсаны тэтгэмж авах эрх үүссэн хүмүүс шилжилтийн схемд

хамрагдана. Бүх мэдээлэл нь SVB буюу Нийгмийн Даатгалын Банкинд нь байдаг учир автоматаар шилждэг байна.

Тэжээгчээ алдсаны тэтгэмжийн хэмжээ нь тухайн хүний орлогоос хамаарна.

Хүснэгт 3. Тэтгэмжийн хэмжээ

<i>2013 оны 1-р сарын 1-ний байдлаар сарын тэтгэмжийн нийт хэмжээ</i>	<i>ANW</i>	Амралтын тэтгэмж
Нас барагчийн ар гэрийн тэтгэмж	1,119,52 евро	82,56 евро
Хагас өнчний тэтгэмж	249,53 евро	23,58 евро
10 хүртэлх насны бүтэн өнчин	358,25 евро	26,42 евро
10-16 насны бүтэн өнчин	537,37 евро	39,63 евро
16-21 насны бүтэн өнчин	716,49 евро	52,84 евро
Нэмэлт тэтгэмж	16,23 евро	--

Хүүхдийн тэтгэлэг

Хүүхдийн тэтгэлэг бол тодорхой түвшинийг хүртэлх өрхүүдийн зардалд зориулж Засгийн газраас олгодог тэтгэмж юм.

18 нас хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эхчүүд энэ тэтгэмжинд хамрагдах боломжтой. Гэхдээ энэ нь тэдний орлогоос хамаарна. 18 нас хүрээгүй хүүхдийн тоог харгалзан үзнэ. Хичнээн олон хүүхэд байна тэр хэрээр хүүхдийн тэтгэмжийг өндөр тооцож олгоно.

Хүүхдийн тэтгэлгийн хэмжээ тухайн хүний орлого ба хөрөнгө чинээнээс шалтгаалах бөгөөд иргэний хөрөнгө чинээ 2013 оны 1-р сарын 1-ний байдлаар дор дурдсанаас илүү өндөр байвал тэрбээр 2013 оны хүүхдийн тэтгэлэгт хамрагдахгүй.

28,897 евро хүртэлх орлого бүхий өрхүүд хамгийн их хэмжээний хүүхдийн тэтгэлэг хүртэнэ. Харин орлого нь 28,897 еврогоос давсан өрхүүдийн авах хүүхдийн тэтгэлгийг бага багаар бууруулсан байна. Тухайлбал,

Хүснэгт 4.

<i>Өрх</i>	<i>Жилд авах хамгийн их төсөв</i>
1 хүүхэдтэй	1,017.00 евро
2 хүүхэдтэй	1,553.00 евро
3 хүүхэдтэй	1,736.00 евро
4 хүүхэдтэй	1,842.00 евро
5 хүүхэдтэй	1,948.00 евро

Удаах хүүхэд бүрт жил бүр 106 евро нэмж олгоно. 12-17 насны хүүхдүүдэд сургуулийн зардалд нь зориулсан нэмэгдэл тэтгэмж бас бий. Шаардлагатай бүх нөхцөлийг хангасан эцэг, эхчүүдийн тухайд энэ тэтгэлэгт хандаж өргөдөл гаргах шаардлагагүй. Татварын газраас SVB-наас бүх орлого ба хүүхдийн тэтгэмж гэх тэргүүтэн бусад мэдээллийг авч шалган үзнэ.

Тахир дутуу хүүхэд асаргааны тэтгэмж (TOG)

Тахир дутуу хүүхэд асаргааны схем нь бие махбодын болон сэтгэцийн эмгэгтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдэд санхүүгийн нэмэлт тэтгэлэг олгодог юм. Үүнд ихээхэн асаргаа сувилгаа шаардлагатай ноцтой гэмтэл согог бүхий хүүхэдтэй эцэг, эхчүүд хамрагдана. Эрүүл мэндийн онцгой зардлын тухай хуулиар (AWBZ) долоо хоногт наанадаж 10 цаг гэж заасны дагуу энэ тэтгэмжийг авах эрх үүснэ.

Тэтгэмжийн хэмжээ нь улирал тутамд 215.80 евро байна. Энэ тэтгэмжийн тухайд ямарваа татвар төлөхгүй. Бас хүүхдийн тэтгэмжинд нөлөөлөхгүй. Иргэд энэ тэтгэмжийг авах өргөдөл хүсэлтээ AWBZ заалтыг үндэслэн SVB буюу Нийгмийн даатгалын банкинд гаргана.

Хувиараа хөдөлмөр эрхэлдэг ганц бие эцэг, эхчүүдэд зориулсан тэтгэмжийн схем (ZEZ схем)

Хувиараа хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүд/эрэгтэйчүүд наанадаж 16 долоо хоногийн хүүхэд асаргааны тэтгэмж авах эрхтэй. Авах тэтгэмжийн хэмжээ нь хэрвээ тэрээр өмнөх жил нь хувиараа наанадаж 1225 цаг ажилласан бол түүнийг хөдөлмөрийн доод хөлсний хэмжээнд ажилласан байна гэж үзэн тэр хэмжээний тэтгэмж өгнө. Хэрвээ түүнээс бага цагаар ажилласан бол түүний авах тэтгэмжийн хэмжээ олсон ашгаас нь хамаарна. Гэхдээ ямар боловч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй.

3.5 “Ажил ба нийгмийн тусламжийн хууль” (WWB)

WWB нь Нидерландад хууль ёсоор оршин суугаа бөгөөд амьжиргааны үндсэн хэрэгцээний өртгөө олоход хангалтгүй байгаа хэн бүхэнд хамгийн бага түвшний орлоготой дүйцэх тэтгэмжийг өгдөг. Нийгмийн тусламжийн тэтгэмж нь дахин ажилд орох хүртэл нь хугацаанд нь олгогдож байгаа хэрэг юм. Энэ хугацаанд тухайн хүн ажилд орох үүрэгтэй. Хэрвээ чадахгүй бол Нийгмийн үйлчилгээнийхэн түүнд ажил олж өгөх эсвэл сургалтанд хамруулах ажлыг гүйцэтгэнэ.

Тэтгэмжийн хэмжээ нь нас, хүүхэдтэй хүүхэдгүй, гэрлэсэн ба ганц бие эсвэл ганц бие эцэг эсвэл эх, AOW -д хамрагдах эрх үүссэн, үүсээгүй гэх зэргээс шалтгаалан харилцан адилгүй өөр өөр. Жишээлэхэд, AOW-д хамрагдах эрх бүхий гэрлэсэн хүмүүс сард 1,397.30 евро авдаг байхад ганц бие эцэг эсвэл эхчүүд 1,277.52 евро, харин ганц бие хүмүүс 1,015.16 евро авна. AOW эрх үүсэх насны ганц бие эцэг эсвэл эхчүүд сард 925.37 евро авч байхад 18-21 насны ганц бие эцэг эсвэл эхчүүд 492,78 евро, харин их, дээд сургуульд сурч буй эцэг, эхчүүд сард 455.63 евро авч байхад ганц бие эцэг эсвэл эхчүүд 292.94 евроны тэтгэмж авах гэх мэтчилэн.

Энэ мэтээр «Ахмад болон Хөдөлмөрийн чадвараа (35 хувь) алдсан ажилгүй хүмүүсийн схемийн хууль» (IOAW), “Ахмад болон Хөдөлмөрийн чадвараа (35 хувь) алдсан, урьд нь хувиараа хөдөлмөр эрхэлж байсан хүмүүсийн орлогын схемийн тухай хууль» (IOAZ) зэрэгт ганц бие эцэг эсвэл эхийн авах тэтгэмж зэргийг тусгайлан заасан байдаг.

Нидерландын “Хөдөлмөр ба халамжийн хууль” (Work and Care Act)-ийн 3:1-д²⁰³ эхчүүдэд хүүхдээ төрүүлсний дараа 16 долоо хоногийн 100 хувийн цалинтай хүүхэд асаргааны чөлөө олгодог бол аавуудад 100 хувийн цалинтай 2-хон өдрийн чөлөө олгодог. Гэвч эцэг эхийн хэн хэн нь ажлаасаа 26 долоо хоног хүртэлх хугацаагаар цалингүй чөлөө авч болдог байна.

²⁰³Maternity allowance, paternity and parental leave. www.easyexpat.com/en/

Хүүхэд асрах чөлөөг богиносгосон цагаар авбал илүү удаан хугацаагаар авч болно. Ажилчин, албан хаагчдын ажлын цаг ба гэр бүлийн үүрэг хариуцлагаа зохицуулах үндсэн тогтолцоо нь Ажлын Цагийг Зохицуулах Хууль (the Working Time Adjustment Act)-аар ажлын цагаа багасгах арга байдаг байна. Үүнд хэрвээ тухайн нэг компанийн ашиг сонирхолтой нөхцөлд зөрчилдөхгүй нөхцөлд ажилтан, албан хаагч хүсэлт гарган өөрийн ажлын цагийг нэмэх ба багасгах эрхтэй аж.²⁰⁴

Хүүхдийн тэтгэмжийг тооцоолон тогтоох нь

Гэр бүл салсан тохиолдолд хүүхдийн эцэг нь гэрлэлтээ батлуулсан үгүйгээс үл хамааран хүүхдээ тэтгэн дэмжих хууль ёсны үүрэгтэй байна. Эцэг эхчүүд сайн дураараа хүүхдээ хэрхэн тэтгэн дэмжих тухайд төлөвлөн тохиролцож болно. Хэрвээ ийнхүү харилцан тохиролцож чадахгүй бол хүүхдийн тэтгэмжийн хэмжээг Дүүргийн Шүүхээс шийдвэрлэн тогтооно. Ингэхдээ тухайн шүүх TREMA гэж нэрлэгдэх хүснэгт дэх амьжиргааг үнэлэн тогтоох томъёонуудыг ашиглан шийдвэрлэнэ. Хүүхэдтэйгээ хамт амьдардаг болон амьдардаггүй эцэг эхчүүдийн хэн хэнийх нь төлбөрийн чадварыг үнэлэн тогтооход хэд хэдэн хүчин зүйлсийг харгалзан үзнэ:

- нийгмийн тусламжийн үнэлэмж ханшинд үндэслэн бүх орлогоос нь амьжиргааны зардлуудыг нь тооцон хасаж, орлогын үлдсэн хэсэгт үнэлгээ тооцоо хийнэ.
- гэрээсээ явж буй эцэг эсвэл эхэд шинэ гэртэй болох ба хүүхдүүдтэйгээ уулзах өртөг мөнгө үлдэж байх ёстой.
- хэрвээ гэрээсээ явж буй нэг нь хоёр дахь гэр бүлийн амьдралаа эхлүүлбэл хүүхдийн тэтгэмж тооцож авах орлогын хэсгийг 50 хувь бууруулан бодно. Учир нь энд хүмүүс шинэ гэр бүлийн харилцаа тогтоох эрх чөлөөтэй хэмээх зарчмыг баримтална.
- гэрээсээ явсан эцэг эсвэл эхийн хамтран амьдрагч нь бас хамт амьдарч байна уу, тусдаа байна уу гэдгээс үл хамааран өөрсдийн хүүхдүүдийн амьжиргааны зардлыг төлөлцөж байх ёстой ба бас өөрийн хамтран амьдрагчийнхаа хүүхдүүдийн амьжиргааны төлбөрт, хэрвээ тэдний харилцаа эцэг ба эхийн үүрэгт нөлөөлж байвал, зохих хэмжээгээр оролцох хэрэгтэй болох магадтай.
- хүүхдүүдтэйгээ үлдсэн эцэг эсвэл эх шинэ харилцаанд орвол, хойд эцэг эсвэл эх ба гэрээсээ явсан эцэг эсвэл эхийн амьжиргааны зардалд оролцох хувь хэмжээг гэрээсээ явсан эцэг эсвэл эх ба хүүхдүүдийн хоорондох харилцаа холбоог үнэлэх үүднээс тогтоон шийднэ. Үүнд тухайн хүүхдүүд хэний овгоор овоглож байгаа, тогтмол харилцдаг эсэх зэргийг тооцож үзнэ.

Ийнхүү тооцож үздэг олон хүчин зүйлс байхын учирт тодорхой жишээг үзүүлэх бэрхшээлтэй. Гэхдээ сард 78 евро төлөх нь хүүхдийн тэтгэмжийн нийтлэг хэмжээ юм.

Тогтоосон хүүхдийн тэтгэмж ба сайн дураар өгч буй тэтгэмж зэрэг нь хэтэрхий бага байх тохиолдолд ганц бие эцэг, эхчүүд LBIO хэмээх Хүүхдийн Асаргааны Зардлыг Сэргээн Тогтоох Үндэсний Товчоонд хандан төлбөрийг мөн л TREMA хүснэгтэд үндэслэн тооцуулж болно. Гэвч Дүүргийн Шүүхийн шийдвэр өөрчлөгдөхгүй.

Нидерландын хүүхдийн тэтгэмжийн систем нь 1997 оны 1-р сараас эхлэн хэрэгжсэн, тэтгэмж төлдөг эцэг эсвэл эхийн тоо цөөн, бас энэ тогтолцоогоо үр дүн сайтай гэж үздэг ба одоогоор үүнтэй холбоотой маргаан хэлэлцүүлэг тун бага байдаг.

Ийнхүү энэ улсад хэдийгээр тухайлан Ганц бие эцэг эсвэл эхчүүдэд тусгайлан зориулсан дэмжлэг тэтгэмжийн зохицуулалт байдаггүй боловч ерөнхий нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн хамгаалал, хүүхдийн асаргаа, боловсролын дэмжлэг зэрэг нь сайн тул энэ нь төдийлөн тусгайлах асуудал болдоггүй байна.

²⁰⁴[https://docs.google.com/viewer?a=v&q=cache:DY-The Netherlands](https://docs.google.com/viewer?a=v&q=cache:DY-The+Netherlands)

4. НОРВЕГ УЛС

Тус улс нь янз бүрийн байгууллагаас гаргасан амьдралын чанарын чансаанд тэргүүлэх байр эзэлдэг ба нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцоондоо ДНБ-ний 13 хувийг зарцуулдаг байна²⁰⁵.

4.1 Хууль эрх зүйн орчин

Хүүхэдтэй гэр бүл, хүүхэд, хүүхэдтэй ганц бие эцэг, эхчүүдэд зориулсан нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг дараах хууль эрх зүйн актуудаар зохицуулсан байна. Үүнд:

- Хүүхдийн тухай хууль. The Children Act (Act No. 7 of 8 April 1981 relating to Children and Parents)
- Мөнгөн тэтгэмжийн тухай хууль. Act No. 41 of 26 June 1998 concerning Cash Benefit for Parents with Small Children (Cash Benefit Act).
- Хүүхэд хамгаалах тухай хууль. (The Child Welfare Act)
- Хүүхэд хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх Журам. Regulations related to The Child Welfare Act.
- Даатгалын тухай хууль. Lov om folketrygd болон бусад хууль тогтоомжууд болно.

4.2 Нийгмийн халамж, үйлчилгээ

Норвег улсад хүүхэдтэй гэр бүлд зориулсан үндсэн 2 янзын тэтгэмж байдаг бөгөөд ганц бие эцэг энэ хоёр тэтгэмжийг авах эрхээр хангагдсан болно.

Хүүхдээ ганцаараа өсгөн хүмүүжүүлж байгаа эцэг хүн гэдэг ойлголтод дараах хүмүүс хамаардаг байна. Үүнд:

- Төрсөн хүүхдээ эхгүйгээр ганцаараа өсгөж байгаа эцэг
- Үрчилж авсан хүүхдээ ганцаараа өсгөж байгаа эцэг
- Хүүхдийг эхгүйгээр өсгөж байгаа асран хамгаалагчид
- Хүүхдээ эхгүйгээр ганцаар өсгөж байгаа хойд эцэг
- Албан ёсоор үрчилж аваагүй боловч хамт амьдарч ганцаараа хүүхдийг өсгөж байгаа эцэг зэрэг болно.

Дээр дурдсан 2 тэтгэмжийн эхний тэтгэмж нь хүүхдийн буюу гэр бүлийн тэтгэмж (barnetrygd) ба түүний зорилго нь хүүхдийг өсгөж хүмүүжүүлэх зардлыг нөхөхөд гэр бүлд дэмжлэг болох явдал юм. Уг тэтгэмжийг Норвегид амьдардаг бүх хүүхдэд 18 нас хүртэл нь олгодог ба сарын тэтгэмжийн хэмжээ нь 970 норвег крон болно²⁰⁶. Харин ганц бие эцэг, эхчүүд хэдэн хүүхэдтэйгээс үл хамааран нэг хүүхдийн тэтгэмжийг илүү авдаг. Үүнийг өргөтгөсөн тэтгэмж гэж нэрлэдэг байна.

Үүнээс гадна хөдөлмөрийн чадвараа түр алдсан эцэг, эхчүүд өргөдөл гарган нэгээс гурав хүртлэх насны хүүхэд бүрийн тоогоор нэг удаа 660 кроны тэтгэмж авах эрхтэй. Үүнд ганц бие эцгүүд ч мөн хамрагдана.

Норвегийн засгийн газар хамгийн нялх балчир хүүхдүүдэд гол онцгой анхаарал хандуулж байдаг. Хоёр дахь үндсэн тэтгэмж болох хүүхэд асрах тэтгэмжийг (kontantstøtte) 13-23 сартай хүүхдээ асарч буй эцэг, эхчүүдэд олгодог ба хүүхэд 13-18 сартай бол сард 5000 крон, 19-23 сартай бол 3304 кроны тэтгэмж олгодог байна²⁰⁷. Хэрэв хүүхэд цэцэрлэгт хамрагдахгүй бол эцэг, эхчүүд өргөдөл гарган дахин 11 сараар тэтгэмжийг сунгуулж болох бөгөөд ингэхдээ 50 хувиар бууруулж олгодог.

²⁰⁵Пресловутая социальная система Норвегии. <http://norse.ru/>

²⁰⁶Family benefits. www.regjeringen.no

²⁰⁷Мөн тэнд.

Норвег улсад бүрэн бус гэр бүл нь дээрх тэтгэмжүүдэд хамрагдахаас гадна үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээ хүртэж, орон сууцны төлбөрт зориулсан тэтгэмж авдаг ажээ.

5. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Хөдөлмөр эрхлэгч эрэгтэй, эмэгтэй хүмүүст ижил боломж олгох талаарх Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Конвенцийн заалтын дагуу ОХУ-д ганц бие эцгүүдэд төрөөс тусламж, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд ихээхэн анхаарах болсныг судлаачид тэмдэглэжээ²⁰⁸.

ОХУ-д хууль эрх зүйн хувьд эрх зүйн байдал тодорхойлогдоогүй боловч өрх толгойлсон эцэг буюу “одинокый отец” гэж ганцаараа нэг буюу хэд хэдэн хүүхдээ өсгөн, асран хамгаалж буй эцэг хүнийг ойлгодог. Хүүхдүүдийн эх нь нас барсан, эх байх эрхээ хасуулсан, сураггүй алга болсон, удаан хугацааны эмчилгээтэй, хорих ангид хоригдож байгаа эсхүл шүүхийн шийдвэрийн дагуу салсны дараа хүүхдүүд эцгийнхээ асрамжинд үлдсэн зэрэг шалтгаантай байж болно.

Хэдийгээр ганц бие эцгийн эрх зүйн байдал тодорхойлогдоогүй боловч тэд өрх толгойлсон эхчүүдийн нэгэн адил хуулийн дагуу тэтгэмж, тусламж, нийгмийн баталгаануудыг хүртдэг байна. Тухайлбал, “ОХУ-ын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн тухай” хуульд ажил хайх явцад хамгаалалт онцгой шаардлагатай иргэдийн тоонд ганц бие, олон хүүхэдтэй эцэг, эхчүүд, түүний дотор ганц бие эцэг орно гэж заажээ²⁰⁹.

Ер нь тус улсад гэр бүлийн нийгмийн хамгааллыг чухалчилж, энэ чиглэлийн эрх зүйн бааз, суурийг боловсронгуй болгоход ихээхэн анхаардаг байна. Тухайлбал, “Хүүхэдтэй иргэдэд үзүүлэх төрийн тэтгэмжийн тухай”²¹⁰, “Хүүхэдтэй гэр бүлийг дэмжих төрийн дэмжлэгийн талаар авах нэмэлт арга хэмжээний тухай”²¹¹ зэрэг Холбооны хуулиуд болон бусад холбооны хуулиуд, ОХУ-ын Засгийн газрын тогтоолууд, ОХУ-ын субъектүүдийн бусад хууль, эрх зүйн актуудаар зохицуулагдаж байна.

Ганц бие эцэгт үзүүлэх баталгаа, хөнгөлөлтийн талаар юуны өмнө ОХУ-ын “Хөдөлмөрийн хууль”²¹²-д дараах зүйлүүдийг хуульчилсан. Үүнд:

1. 5 хүртэл насны хүүхэдтэй ганц бие эцгийг илүү цагаар ажиллуулах, томилолтоор ажиллуулахдаа, түүний зөвшөөрлийг бичгээр авсан байна.
2. Ганц бие эцгийг шөнийн цагаар болон оройн ээлжинд ажиллуулахыг хориглосон ба ажлын бүрэн бус цагаар ажиллуулахыг зөвшөөрсөн, ингэхдээ хөдөлмөрийн дэвтэрт нь тэмдэглэл хийхгүй.
3. Тус хуульд заасан тодорхой нөхцөлүүдээс бусад тохиолдолд 14 хүртэл насны хүүхэдтэй эсхүл тахир дутуу хүүхэдтэй ганц бие эцэгтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачлагаар цуцлахыг хориглоно.

Мөн “ОХУ-ын Тэтгэврийн заавал даатгалын тухай”²¹³ хуулийн дагуу ганц бие эцэг, эхнэр нь нас барсан тохиолдолд хүүхдийн тэжээгчээ алдсаны тэтгэврийг авах эрхтэй. Түүнчлэн “Хүүхэдтэй иргэдэд үзүүлэх төрийн тэтгэмжийн тухай” хуулийн дагуу ганц бие эцэг хүүхдийн тэтгэмж авах эрхтэй. Үүний хамт эхнэр нь гэр бүлээ орхисон бол алимент буюу хүүхдийн тэтгэмж авна.

²⁰⁸Гаврюшенко Л. В. Как получить статус отца одиночки. www.9111.ru/questions/

²⁰⁹Федеральный Закон РФ от 19.04.1991 № 1032-1 (ред. от 02.07.2013) «О занятости населения в Российской Федерации [Электронный ресурс]. URL: www.consultant.ru/document/cons_doc_LAW_148901/

²¹⁰ФЗ “О государственных пособиях гражданам, имеющих детей”. www.Consultant.ru

²¹¹Федеральный закон от 29 декабря 2006 года N 256-ФЗ “О дополнительных мерах государственной поддержки семей, имеющих детей”. www.zakonprost.ru

²¹²“Трудовой кодекс” <http://dogovor-urist.ru/>

²¹³ФЗ “Об обязательном пенсионном страховании в РФ”. www.assessor.ru

ОХУ-д 2007 оноос эхлэн Эхийн мөнгө буюу гэр бүлийн мөнгийг²¹⁴ 2 дахь болон дараагийн хүүхдээ төрүүлсэн буюу үрчилж авсан эхчүүдэд олгодог ба энэ нь гэр бүлийг дэмжих зорилготой төрийн дэмжлэгийн хэлбэр юм. Эхийн мөнгөний сертификатыг авах эрхийг 2 дахь хүүхэд нь 2007 оны 1 сарын 1-нээс хойш төрсөн гэр бүл эдлэх ба энэхүү дэмжлэг нь 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл хэрэгжих юм. 2014 оны эхийн мөнгөний хэмжээ 429 408 руб. байна²¹⁵.

Эхийн мөнгийг бэлэн мөнгөөр олгодоггүй, харин сертификат олгож, зөвхөн дараах зориулалтаар зарцуулахыг зөвшөөрдөг. Үүнд:

- Гэр бүлийн орон сууцны нөхцөлийг сайжруулах,
- Хүүхдийн боловсрол,
- Эхийн тэтгэврийн хуримтлалын хэсгийг нэмэгдүүлэх,
- Хүүхдийн сургууль, цэцэрлэгийн төлбөр зэрэг болно.

Тус сертификатыг авахын тулд эхчүүд зохих баримт бичгийг бүрдүүлэн ОХУ-ын Тэтгэврийн санд хандах журамтай.

ОХУ-ын Засгийн газрын 2006 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Эхийн (гэр бүлийн) мөнгөний төрийн сертификат олгох журмын тухай” тогтоолд²¹⁶ зааснаар хүүхдийн төрсөн эцэг болон хүүхэд үрчилж авсан эцэг нь хүүхдийн эх нас барсан ба эх байх эрхээ хасуулсан тохиолдолд эхийн (гэр бүлийн) мөнгийг авах эрхтэй болно. Иймээс ганц бие эцэг нь эх хүний нэгэн адил гэр бүлийн мөнгийг авч зохих журмын дагуу зарцуулах боломжтой юм.

Үүний зэрэгцээ сүүлийн үед ОХУ-д ганц бие аавуудад тусламж үзүүлэх зорилготой төвүүд байгуулагдан тэдэнд эрх зүйн, сэтгэл зүйн, эмнэлгийн олон талт тусламж үзүүлж байгаа билээ.

6. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС²¹⁷

Ганц бие эцэг, эх гэдгийг эцэг эсвэл эх өөрийн хүүхдүүдийн хамтаар дангаараа, аль эсвэл том гэр бүлийн дотор хань ижилгүйгээр амьдарч буйг хэлнэ гэж АНУ-ийн Йова Улсын Их Сургуулийн эдийн засагч, судлаач Daniel R. Meyer болон Steven Garasky нар тодорхойлжээ.²¹⁸

ХХ зууны сүүлчийн хагасаас эхлэн «Ганц Асран Хамгаалагч бүхий гэр бүл»-ийн тоо асар хурдацтай өсөж эхэлсэн. Энэхүү өөрчлөлтийг эрдэмтэд гэр бүлийн задрал бөгөөд хүүхэд, гэр бүл, нийгэмд сөрөг үр дагавартай үзэгдэл (Porepoe 1996) гэж үзэж байхад зарим нь ганц асран хамгаалагч бүхий гэр бүл бол бүх цаг үеийн бүх нийгэмд байсан, байсаар ч байгаа гэр бүлийн бас нэгэн хэлбэр хэмээн үзэж байна (Coontz 1997). Ийнхүү гэр бүлийн хэлбэр, төрөл зүйлийг хэчнээн өөр янз бүрээр тайлбарлахаас үл хамааран ганц асран хамгаалагч бүхий гэр бүлийн тоо улам бүр өсөж, гэр бүлийн амьдралын нийгэм, эдийн засаг ба улс төрийн агуулгад голлох нөлөөтэй үзэгдэл болсоор иржээ.

²¹⁴Материнский капитал, семейный капитал

²¹⁵2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Монгол банкны төгрөгийн рубльтэй харьцах ханшаар тооцоход 19 452 182 төгрөг болж байна.

²¹⁶Постановлению Правительства РФ от 30 декабря 2006 г. “О порядке выдачи государственного сертификата на материнский (семейный) капитал”. garant.ru

²¹⁷Worst off – single-parent families in the united states. 2012. www.legalmomentum.org/

²¹⁸Daniel R. Meyer and Steven Garasky. Technical Analysis Paper no. 42, 1991. Available from the Office of Human Services Policy, Office of the Assistant Secretary for Planning and Evaluation, U.S. Department of Health and Human Services, 202-245-1880. Forthcoming as Daniel R. Meyer and Steven Garasky RP Discussion Paper no. 982-92, 1992. www.legalmomentum.org/

6.1 Нийгмийн чиг хандлага, өнөөгийн байдал

Түүхэн үүднээс бол ганц асран хамгаалагчтай гэр бүл эцэг, эхийн аль нэг нь нас барснаас үүдэн бий болдог байв. Гэтэл өнөө цагийн АНУ-гийн ганц бие асран хамгаалагч бүхий гэр бүлүүдийн хамгийн нийтлэг ерөнхий хүчин зүйлс бол нийгэм ба соёлын хөгжлийн чиг хандлагын өөрчлөлтүүд, гэр бүл салалт ба насанд хүрээгүй хүүхдийн жирэмслэлтийн хувь өссөн, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн боломж өссөн, эрэгтэйчүүдийн (ялангуяа, Африк гаралтай америк эрэгтэйчүүдийн) ажил эрхлэх боломж буурсан, эмэгтэйчүүд өөрсдийн өрх гэрийг авч явахуйц хэмжээний нийгмийн тэтгэмж халамж сайжирсан зэргээс шалтгаалж байна гэж гэр бүл судлаачид үзэж байна²¹⁹.

Дэлхий даяар өрх толгойлсон буюу ганц асран хамгаалагчтай гэр бүлийн тоо бүх гэр бүлийн дөрөвний нэгээс гуравны нэг орчмыг эзэлж байна. Ялангуяа, өндөр хөгжилтэй орнуудад гэр бүл салалт их болсонтой холбоотойгоор ганц асран хамгаалагч бүхий гэр бүлийн тоо эрс өссөн үзүүлэлттэй байдаг. Эдгээр улс орнууд дотор АНУ хамгийн өндөр хувьтай байна. 2011 оны байдлаар АНУ 34 хувь, түүний араас Канад 22 хувь, Австрали 20 хувь, Дани 19 хувь улсууд орж байна. Гэтэл хөгжингүй улс орнуудын хувьд хэдийгээр гэр бүл салалт төдий л их биш боловч, гэр бүлээ хаях, нас барах, хоригдох зэргээс шалтгаалан ганц асран хамгаалагч бүхий гэр бүлүүд, голчлон өрх толгойлсон эхчүүд олноороо бий болж байгаа ажээ.

Хүснэгт 5. Ганц бие асран хамгаалагчдын гэрлэлтийн байдал

	Гэрлэж байгаагүй	Тусдаа амьдардаг	Салсан	Бэлэвсэрсэн
Австри	32	5	50	12
Бельги	17	22	51	10
Канад	32	29	31	4
Финланд	32	11	52	5
Франц	38	6	48	8
Герман	29	18	49	5
Нидерланд	16	4	73	8
Норвеги	44	18	35	4
Швед	45	9	44	2
Их Британи	38	23	34	5
АНУ	44	18	33	4

Тухайлбал сүүлийн үеийн судалгаагаар²²⁰ /2011 он/ ганц асран хамгаалагчтай гэр бүлийн 84 хувь нь эмэгтэйчүүд, 16 хувь нь эрэгтэйчүүд байдаг гэсэн судалгаа байна. Эдгээр өрх толгойлсон эмэгтэйчүүдийн ихэнх нь гэр бүлээ цуцлуулсан эсвэл тусдаа амьдардаг (58 хувь), хэзээ ч гэрлэж байгаагүй эхчүүд (24 хувь), харин бэлэвсэн эхчүүд (7 хувь)-ийг эзэлдэг бол, ганц бие эцгүүдийн тухайд гэрлэлтээ цуцлуулсан эсвэл тусдаа амьдардаг эцгүүд (8.4 хувь), огт гэрлэж байгаагүй эцгүүд (1.5 хувь) ба бэлэвсэн эцгүүд (0.9 хувь)-ийг эзэлж байна. Эдгээр ганц асран хамгаалагч бүхий өрхүүдийг арьс өнгөний байдлаар ангилж үзэхэд 22 хувь нь цагаан арьстнууд, 57 хувь нь хар арьстнууд, харин 33 хувь нь латин америк гаралтай байжээ.

²¹⁹Мөн тэнд.

²²⁰Worst off – single-parent families in the united states.2012. www.legalmomentum.org/

6.2 Ганц бие аав нарын тухай

АНУ дахь хүүхдийн тэтгэмж нь их ойлгомжтой байдаг байв. Тухайлбал, Эхчүүд хүүхдүүдээ асаргаандаа авах ба голчлон өндөр орлоготой байдаг аавууд нь хүүхдийн тэтгэмж төлөхийг шүүхээс даалгадаг байлаа. Гэтэл одоо цагт эрчүүд хүүхдүүдээ асаргаандаа авцгаах болсноор нөхцөл байдал улам бүр илүү нарийн төвөгтэй болжээ.

АНУ-ийн Йовагийн их сургуулийн эдийн засагч, судлаач Daniel R. Meyer болон Steven Garasky нар хүүхдээ асран хүмүүжүүлж буй ганц бие аав нар дээр судалгаа хийсний дүнд бодит байдал дээр нөхцөл байдал, тэдний тухай боддог ердийн ойлголт ба нийтлэг үзэл баримтлалаас их өөр болохыг тогтоосон байна.²²¹

Дээрх хоёр судлаач бүх нийтэд түгээмэл болсон хүүхдээ асарч буй эцгүүдийн талаар:

1. хүүхдээ асран хамгаалж буй эцгүүд ихэвчлэн өндөр орлоготой байдаг;
2. хүүхдүүдээ өөр дээрээ авч асран хамгаалж буй эцгүүд тийм олон биш;
3. хүүхдээ асран хамгаалж буй ихэнх эцгүүд дахин гэрлэдэг;
4. хүүхдээ асран хамгаалж буй ихэнх эцгүүд бэлэвсэрсэн хүмүүс байдаг;
5. тийм эцгүүд голчлон том болсон хөвгүүдээ л өөрийн асаргаанд авдаг зэрэг ойлголтуудыг шинжлэн судалж дараах дүгнэлтийг хийсэн. *Тухайлбал,*
 - Ганц бие эцэг бүхий гэр бүлүүдийн нэлээд хувь нь ядуу зүдүү амьдралтай байдаг. Бүх ганц бие эцэг бүхий гэр бүлийн 18 хувь ядуу амьдралтай ба тэдний бараг тэн хагасынх нь орлого амьжиргааны доод түвшнээс 50 хувь доогуур байдаг. Гэсэн хэдий ч ерөнхий дунджаар нь үзвээс, ганц бие эцэг бүхий гэр бүлүүдийн орлого ганц бие эх бүхий гэр бүлээс чамгүй өндөр байдаг тал ажиглагддаг.
 - Тодорхой цаг үед үнэхээр «ганц бие асран хамгаалагчтай гэр бүлүүд дотор ганц бие эх бүхий гэр бүлүүдийн эзлэх хувь их өндөр байсан тул судлаачид тэр бүгдийг шууд өрх толгойлсон эх гээд явахад асуудалгүй байсан. Гэтэл энэ нь одоо нэгэнт өөр болжээ.
 - Дахин гэрлэсэн эцгүүдийн ихэнх нь гэрлэхээсээ өмнө эсвэл дараахан хүүхдүүдээ өөрсөд дээрээ авцгаасан байдаг байна. Энэ нь тэд хүүхдүүдээ өсгөх илүү бат найдвартай орон гэр бүхий болтлоо хүлээж байгаад дараа нь авцгаадаг байж болох юм гэж үзэж болохоор байна.
 - Тодорхой цаг үед хүүхдүүдээ өөр дээрээ авсан олон эцгүүд үнэхээр бэлэвсэрсэн ба урьд нь нэгэнтээ гэрлэж байсан хүмүүс байдаг байжээ. Бэлэвсэн эцгүүдийн тоо 1990 онд 150 000 болж буурсан атал огт гэрлэж байгаагүй эцгүүдийн тоо эрс өссөн байдаг. Энэ хугацаанд гэрлэлтээ цуцлуулсан эцэгтэйгээ амьдарч буй хүүхдүүдийн тоо 168 000-аас 1 сая болтлоо өссөн байна. Өдгөө ганц бие эцэг бүхий өрхүүдийн 7,5 хувь орчим нь бэлэвсэн эцгүүд, 24,5 хувь нь гэрлэж байгаагүй эцгүүд байна.
 - Ганц бие эцэгтэйгээ амьдарч буй хүүхдүүдийн нас ганц бие эх бүхий гэр бүлээс ялимгүй ахимаг байдаг нь үнэн боловч, тэдний 17,5 хувьд нь 0-3 насны хүүхэдтэй байна. Энэчлэн, ганц бие эцэг бүхий өрхүүдийн хүүхдүүд ихэвчлэн хөвгүүд байдаг боловч тийм өрхийн нийт хүүхдийн 44 хувь нь охид байна зэрэг болно.

²²¹Daniel R. Meyer and Steven Garasky. Technical Analysis Paper no. 42, 1991. Available from the Office of Human Services Policy, Office of the Assistant Secretary for Planning and Evaluation, U.S. Department of Health and Human Services, 202-245-1880. Forthcoming as Daniel R. Meyer and Steven Garasky RP Discussion Paper no. 982-92, 1992.

6.3 Хууль эрх зүйн орчин

АНУ-д ганц бие асран хамгаалагчтай гэр бүл түүний дотор ганц бие аав нарт үзүүлдэг тусламж дэмжлэг, нийгмийн үйлчилгээний асуудлыг муж улс бүр өөрсдийн Нийгмийн халамжийн хуулиар зохицуулдаг. Харин Холбооны Засгийн Газраас Нийгмийн хамгааллын Өндөр настны, тэжээгчээ алдсаны, гэнэтийн ослын даатгалын (the Old-Age, Survivors, and Disability Insurance (OASDI)) хөтөлбөр, Хэрэгцээтэй Гэр бүлүүдэд үзүүлэх Түр зуурын Тусламж (Temporary Aid to Needy Families (TANF)) хөтөлбөр зэрэг олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Ганц бие асран хамгаалагч бүхий гэр бүлүүдэд нэмэлт тэтгэлэг олгодог Хэрэгцээтэй Гэр бүлүүдэд үзүүлэх Түр зуурын Тусламж /TANF /хөтөлбөр нь анх 1935 онд гэр бүлийн эрэгтэй тэжээгчээ алдсан эхчүүд болон хүүхдүүдийг дэмжих зорилгоор Нийгмийн Хамгааллын хуулийн нэгэн хэсэг болж байгуулагдсан зорилтот бүлгийн хөтөлбөр юм. Түүхэн үүднээсээ анх энэ мэт нийгмийн тэтгэлгийн бодлого нь бэлэвсэрсэн болон салсан эсвэл гэрлээгүй эмэгтэйчүүдийн хооронд ялгаатай хандах үндсэн дээр хэрэгждэг байжээ. Хөтөлбөрт амьдралдаа зөвхөн нэг удаа 5 жилийн хугацаатай хамрагдах боломжтой бөгөөд тухайн муж улсын энэ хөтөлбөрт хамрагдагсдын тэн хагас нь ажилтай болох эсвэл ажилтай холбоотой үйл ажиллагаанд хамрагдах шаардлагуудыг тавьдаг.

Мөн хүүхэд асрах чөлөөг Холбооны Гэр бүл ба Эрүүл мэндийн чөлөөний тухай хууль (FMLA-federal Family and Medical Leave Act)-аар, бусад гэр бүл, нийгмийн халамж, үйлчилгээ, ажил эрхлэлт зэрэг олон асуудлыг Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөр ба хүүхэд асаргааны тухай хууль, Гэр бүлийн тухай хуулиудаар зохицуулдаг.

6.4 АНУ-ын Ганц бие аав нарын ажил эрхлэлт ба нийгмийн халамж

АНУ-ын ганц бие эцэг, эхчүүдийн ажил эрхлэлтийн хувь дунджаас дээгүүр байдаг. Гэтэл тэдний маш бага цалинтай ажил эрхэлдэг хувь хэмжээ их өндөр байдаг байна. Энэ нь улсын зүгээс хүүхэд асаргаа, цалинтай чөлөө, тэтгэмж гэх зэргээр бодлоготой дэмждэг хөтөлбөр, хууль эрх зүй ихээхэн хангалтгүй, заавал ажил эрхлэхийг шаарддагтай холбоотой байдаг байна. Гэхдээ ганц бие эцгүүдийн ажил эрхлэлтийн хувь хэмжээ ганц бие эхчүүдээс өндөр байдаг. 2010 оны байдлаар үзэхэд, АНУ-д сарын дундаж ажил эрхлэлтийн хувь хэмжээ ганц бие эцгүүдийн хувьд 76 хувь, харин ганц бие эхчүүдийн хувьд 67 хувь байжээ.

Олонх улс оронд эцэг, эхчүүд хүүхэд асаргааны цалинтай чөлөө авах хууль зүйн эрхтэй байдаг байхад АНУ-д ийм эрх байдаггүй. Учир нь АНУ-д энэ тохиолдолд Холбооны Гэр бүл ба Эрүүл мэндийн чөлөөний тухай хууль (FMLA-federal Family and Medical Leave Act)-аар “зөвхөн хүүхэд асаргааны цалингүй чөлөө авч болдог. Хуулинд наанадаж 50 ажилтантай газарт, багадаа л 1 жил ажилласан, мөн 1250 цаг ажилласан ажилтанд хүүхэд асаргааны цалингүй чөлөө олгоно” гэж журамлажээ. Тиймээс, бага цалинтай бөгөөд бага орлоготой ажилчид үүнд хамрагдах бараг боломжгүй. Энэчлэн ихэнх оронд шинэ эцэг эхчүүдэд цалинтай ба цалингүй чөлөөг олгож, ажлын байрыг нь хадгалах хууль эрх зүйн зохицуулалт байдаг байхад АНУ-д ийм практик байдаггүй. Зөвхөн зарим цөөн тооны ажил олгогчид сайн дурын үндсэн дээр л хүүхэд асаргааны цалинтай чөлөө олгодог байна. 2011 оны байдлаар нийт АНУ-ын ажил эрхлэгчдийн зөвхөн 11 хувь нь л цалинтай чөлөө авчээ. Тэгэхээр ажлын байрыг нь хадгалан чөлөө олгох хугацаа хамгийн бага нь АНУ-д 12 долоо хоног бол хамгийн их нь Франц ба Герман орнуудад 162 долоо хоног байна.

Мөн олонх оронд жил тутмын цалинтай чөлөө ба амралт авах, өвчтэй байх зэрэг эрхүүд байдаг атал АНУ-д байдаггүй.²²²

²²²Worst off – single-parent families in the united states. 2012.хуудас 12. www.legalmomentum.org/

Хүснэгт 6. Цалинтай чөлөө

	<i>Жил тутмын чөлөө (7 хоногээр)</i>	<i>Баярын амралт (өдрөөр)</i>	<i>5 өдөр ажилтан өвчтэй байх</i>	<i>5 өдөр хүүхэд өвдсөний чөлөө</i>
Австрали	4	7	5	5
Австри	4,4	13	5	5
Бельги	4	10	5	0
Канад	2	8	0	0
Дани	4	9	5	1
Финланд	5	9	5	0
Франц	6	1	1	0
Герман	4	10	5	5
Ирланд	4	9	0,7	3
Итали	4	13	1	0
Нидерланд	4	0	3,5	3,8
Норвеги	5	2	5	5
Испани	4,4	12	1,2	2
Швед	5	0	3,2	4
Швейцар	4	0	5	3
Их Британи	4	0	0,4	0
АНУ	0	0	0	0

Ихэнх улс орнууд бүх нийтийн эрүүл мэндийн даатгалтай байхад АНУ-д мөн л ийм тогтолцоо үгүй аж. 2010 оны байдлаар, АНУ-д ганц бие асран хамгаалагчтай өрхийн хүүхдүүдийн 11 хувь, эцэг эхтэйгээ хамт амьдардаг өрхийн хүүхдүүдийн 8 хувь эрүүл мэндийн даатгалгүй байжээ.

Үүгээр үл барам, ихэнх улс орнуудад «хүүхдийн тэтгэмж», «гэр бүлийн тэтгэмж» гэхчлэн нэрлэгдэх хөтөлбөрийн дагуу эцэг эхчүүд хүүхдийн мөнгө авдаг байхад АНУ-д ийм хөтөлбөр огт байдаггүй. Зарим улс орнуудад хүүхдийн тэтгэмжийг нэгдсэн нийтлэг хэмжээгээр олгодог байхад, зарим оронд эцэг, эхийн орлогын хэмжээг тооцож олгодог байна.²²³

Хүснэгт 7. Хүүхдийн тэтгэмжийн хөтөлбөрүүд

	<i>Нийтэд тогтоосон дүнгээр эсвэл орлогыг нь судалж тогтоодог</i>	<i>6 настай хүүхдэд сар бүр олгодог тэтгэмж</i>
Австрали	Өрхийн орлогыг харгалзана	449 ам доллар
Австри	тогтсон дүнгээр	149 ам доллар
Бельги	тогтсон дүнгээр	108 ам доллар
Канад	Өрхийн орлогыг харгалзана	120 ам доллар ба 307 ам доллар
Дани	тогтсон дүнгээр	185 ам доллар
Финланд	тогтсон дүнгээр	132 ам доллар
Франц	тогтсон дүнгээр	80 ам доллар
Герман	тогтсон дүнгээр	217 ам доллар
Ирланд	тогтсон дүнгээр	219 ам доллар

²²³Worst off – single-parent families in the united states. 2012. хуудас 16. www.legalmomentum.org/

Итали	Өрхийн орлогыг харгалзана	Өгөгдөл байхгүй байна
Нидерланд	тогтсон дүнгээр	311 ам доллар
Норвеги	тогтсон дүнгээр	156 ам доллар
Испани	Өрхийн орлогыг харгалзана	32 ам доллар
Швед	тогтсон дүнгээр	153 ам доллар
Швейцар	Хослуулна	216 ам доллар
Их Британи	тогтсон дүнгээр	108 ам доллар
АНУ	Аль аль нь үгүй	Аль аль нь үгүй

Хэдийгээр АНУ-д хүүхдийн тэтгэмжийн хөтөлбөр байдаггүй боловч хоёр ч холбооны орлогын татварын кредитээр олон тооны бага орлоготой өрхүүдэд багагүй хэмжээний мөнгийг олгодог байна. Тэдгээр нь EITC (Earned Income Tax Credit)-"Олсон Орлогын Татварын Кредит" ба ACTC (Additional Child Tax Credit) -"Нэмэлт Хүүхдийн Татварын Кредит" хоёр болно. Эдгээр нь буцаан олгодог кредитүүд юм. Эцэг, эхийн татвар төлөлт шаардагдах хэмжээнээс хэтэрвэл түүнийг буцаан олгодог байна.

Олонх оронд ганц бие асран хамгаалагчдад амьжиргааны мөнгө тэтгэмж урьдчилан олгодог байхад АНУ-д ийм практик байдаггүй байх юм.

Хүснэгт 8. Хүүхдийн тэтгэмж авдаг ганц бие асран хамгаалагчдын хувь

А. Энэ талаар хөгжингүй орнууд	
Швед	100
Дани	94
Финланд	77
Герман	77
Швейцар	67
Норвеги	56
Австри	54
Бельги	39
Франц	30
Испани	27
Дундаж	62
Б. Энэ талаар төдий л сайн хөгжөөгүй орнууд	
Канад	38
Австрали	37
Нидерланд	37
АНУ	30
Итали	22
Их Британи	22
Ирланд	15
Дундаж	29

Гэр бүлээ цуцлуулан хүүхдээ асаргаандаа авагсдын 71 хувь нь хүүхдийн зохих хэмжээний тэтгэмж авсан байдаг бол 41 хувь нь бүрэн хэмжээний тэтгэмж авчээ. Хүүхдийн тэтгэмжийн байвал зохих дундаж дүн хэмжээ нь 1 долоо хоногт 115 ам доллар байдгаас бодитой хүртдэг дундаж хэмжээ нь 1 долоо хоногт 70 ам доллар байна.²²⁴

Энэчлэн АНУ хэдийгээр ажилгүйдлийн даатгалын тогтолцоотой боловч ажилгүй ганц бие асран хамгаалагчид маш бага хувийн ажилгүйдлийн даатгал авдаг байна. Учир нь ажилгүйдлийн даатгал олгох хугацаа ба тэтгэмжийн хэмжээ нь ажилласан жил гэх зэрэг олон үзүүлэлт шаардлагуудаас шалтгаална.

АНУ нь ганц бие асран хамгаалагчдад үзүүлдэг нийгмийн тэтгэмж тусламжийн тухайд нэн хомс орны нэг юм.

Хүснэгт 9. Ганц бие асран хамгаалагчдад үзүүлдэг нийгмийн тусламжийн хэмжээ²²⁵ /орлогын голч дүнгийн хувиар/

Улсын нэр	Тусламжийн хувь хэмжээ
Австрали	45%
Австри	42%
Бельги	45%
Канад	39%
Дани	61%
Финланд	47%
Франц	37%
Герман	54%
Ирланд	55%
Нидерланд	54%
Норвеги	40%
Швед	43%
Швейцар	41%
Их Британи	62%
АНУ (Калифорн)	29%
АНУ (IA)	23%
АНУ (MS)	18%

АНУ-ын хувьд «Ганц бие аав»-ын тоо хэмжээ нэмэгдсэн нь нийгмийн хөгжил, гэр бүл салалт, гэр бүл төлөвшилт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Нөгөөтэйгүүр, АНУ-д гэр бүлийн уламжлалт тогтолцоо байхгүй, гэр бүл нийгмийн харилцаа бүрэн төлөвшөөгүй гэж хэлж болохоор байна.

Мөн ганц бие аав нарын нийгмийн халамж, тусламж, дэмжлэгийг тусгайлан журамласан хууль эрх зүй байхгүй бөгөөд ганц бие эхчүүдтэй адил халамж үйлчилгээ эдлэх боловч тэр нь бусад улс орнуудтай харьцуулахад нэлээд хязгаарлагдмал байдаг байна.

²²⁴Мөн тэнд.

²²⁵Мөн тэнд.

АНУ нь бусад улс орнуудтай харьцуулахад ганц бие асран хамгаалагчтай гэр бүлд үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээ бага, түүнийг зохицуулдаг хууль эрх зүйн орчин хангалтгүй ажээ.

7. МОНГОЛ УЛС

Монгол Улсын хүн ам 2013 оны байдлаар 2 сая 930 мянга болж, өмнөх оныхоос 2.2 хувиар өссөн бөгөөд үүнээс 1 сая 367 мянга нь эрчүүд байгаа нь нийт хүн амын 49.9 хувийг эзэлж байгаа тоон мэдээлэл бий.²²⁶

Манай улсад өрх толгойлсон эцэг /эх/-ийн эрх зүйн байдлыг Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуульд /шинэчилсэн найруулга/ 3.1.8-т “өрх толгойлсон эх /эцэг/” гэж нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хэлнэ гэж тодорхойлсон байна.²²⁷

7.1 Хууль эрх зүйн орчин

Монгол Улсад ганц бие эцэг, эхчүүдэд үзүүлдэг нийгмийн халамж, үйлчилгээний харилцааг дараах хууль, журам, хөтөлбөрүүдээр зохицуулсан байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Хүний хөгжил сангийн тухай хууль
- Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих үндэсний стратеги

7.2 Нийгмийн халамж, үйлчилгээ

Ганц бие эцэгт үзүүлэх халамж үйлчилгээний талаар дараах хуулиудад заасан байна.

Хөдөлмөрийн тухай хуульд:

- 3 хүртэлх насны ганц бие эцгийг ажлаас халахыг хориглох,
- 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцгийг шөнийн буюу илүү цагаар, албан томилолтоор ажиллуулахыг хориглох,
- 6 сар болон 1 хүртэлх настай ихэр хүүхдэд 2 цаг, 6 сар-1 нас хүртэлх хүүхдэд 1 цаг, зайлшгүй асаргаа шаардлагатай хүүхдэд 1 цагийн чөлөө нэмж олгох,
- Нярай хүүхэд үрчлэн авсан эцэгт хүүхдийг нь 60 хоногтой болтол чөлөө олгоно,
- 3 хүртэлх насны хүүхэдтэй эцэг өөрөө хүсвэл чөлөө авч болно,
- Хүүхэд асрах чөлөө дууссан, эсхүл дуусаагүй боловч эх эцэг өөрөө хүсвэл ажил олгогч нь түүнийг ажил, албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах үүрэгтэй бөгөөд хэрэв орон тоо нь хасагдсан, ажилтны тоог цөөрүүлсэн бол түүнд өөр ажил олж өгнө.

Нийгмийн халамжийн тухай хуульд:

Өрх толгойлсон ганц бие эцэгт үзүүлэх нийгмийн халамжийн талаар дараах зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэврийг 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэгт өгнө.

²²⁶Статистикийн эмхэтгэл. УСХ. Уб., 2013 он.

²²⁷Нийгмийн халамжийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/.

Энэхүү тэтгэврийн хэмжээ нь сард 115000 төгрөг байна²²⁸.

- Нийгмийн халамжийн тэтгэмжийг гурав ба түүнээс дээш тооны 14 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-д олгоно. Энэхүү тэтгэмжийн хэмжээ нь жилд 120000 төгрөг байна²²⁹.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль:

Шимтгэл төлсөн хугацаанд тэтгэмжтэй чөлөө авч хүүхдээ асарсан хугацаа орно.

Хүний хөгжил сангийн тухай хуульд:

Монгол Улсын иргэн дараах хэлбэрээр сангаас хишиг, хувь хүртэнэ. Үүнд:

- эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний төлбөр;
- хүүхдийн мөнгө.

Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журамд:

- Хүүхэд болон хүүхдийг төлөөлөн хүүхдийн мөнгө авах эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд/ нь үйлчлүүлэх арилжааны банкныг өөрөө сонгох эрхтэй.
- Хүүхдийн эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд/ эсхүл 16 насанд хүрсэн бол хүүхэд өөрөө хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргаж болно.

Нийгмийн халамжийн сангаас 2014 оны эхний хагас жилд 191.0 мянган хүнд 69.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж авагчдын тоо 12.7 мянган хүн буюу 7.1 хувиар, олгосон тэтгэврийн хэмжээ 3.7 тэрбум төгрөг буюу 5.6 хувиар өсчээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2014 оны эхний хагас жилд 60.1 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 3.5 мянган хүн буюу 5.6 хувиар буурч, олгосон тэтгэврийн хэмжээ 2.1 тэрбум төгрөг буюу 5.4 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 316.0 мянган хүн хамрагдсаны 69.5 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 4.7 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд байна.

“Хүний хөгжил” сангаас 2014 оны эхний хагас жилд 18 хүртэлх насны 976.3 мянган хүүхдэд 118.2 тэрбум төгрөгийг хүүхдийн мөнгөнд олгосон байна.²³⁰

7.3 Өрх толгойлсон ганц бие эцгүүдийн талаарх өнөөгийн хандлага

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийг 1995 онд шинээр баталсан бөгөөд энэхүү хуульд анх удаа өрх толгойлсон эх /эцэг/ гэсэн томъёоллыг оруулсан байна. Харин 2012 онд батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад анх удаа өрх толгойлсон эх /эцэг/-ийн эрх зүйн байдлыг хуульчилсан ба тус хууль болон бусад хууль, эрх зүйн баримт бичгийн заалтын дагуу өрх толгойлсон ганц бие эцгүүд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг авч байна.

Дээр авч үзсэн гадаадын зарим улсын ганц бие эцэгт үзүүлж байгаа халамж, хөнгөлөлтийн эрх зүйн зохицуулалт, нийгмийн үйлчилгээ, хандлагыг манай улсын ийм төрлийн халамж үйлчилгээний эрх зүйн зохицуулалттай харьцуулан үзэхэд Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулиар тодорхой хязгаарлалт, нөхцөлүүдийг заасан нь учир дутагдалтай

²²⁸Нийгмийн халамжийн тэтгэвэр, асарааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. №16. www.legalinfo.mn

²²⁹Нийгмийн халамжийн тэтгэмж. www.halamj.gov.mn

²³⁰Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал. 2014 оны 6 сарын байдлаар, YCX.

байна. Тухайлбал, олон хүүхэдтэй боловч 50 нас хүрээгүй, нэг, хоёр хүүхэдтэй боловч мөн 50 нас хүрээгүй ганц бие эцгүүд нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхгүй, нэг, хоёр хүүхэдтэй өрх толгойлсон ганц бие эцэг нийгмийн халамжийн тэтгэмжийг хүртэх эрхийг хуулиар хязгаарласан байна.

Сүүлийн үед манай улсын иргэд, түүний дотор эмэгтэйчүүд олноор суралцах, ажиллах зорилгоор гадаад улсыг зорих болсноор аавууд ганцаараа хүүхдээ харж үлдэх явдал ихээхэн нэмэгдэж байгаа талаар ТББ-ын зүгээс тэмдэглэсэн байна.²³¹ Бусад орнуудын туршлагаас үзэхэд эцэг эхийн аль нэг нь тодорхой хугацаагаар (1 жилээс дээш гэх мэт) хамт амьдраагүй тохиолдолд хүүхдээ харж үлдсэн эх эсвэл эцэг нь тэтгэмж, хөнгөлөлт эдлэх зохицуулалттай байна.

2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн ордонд Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор «Нийгмийн хөгжил-Эрэгтэйчүүдийн оролцоо» үндэсний чуулганыг ХАХНХЯ, Жендерийн үндэсний хороо, Эрүүл мэндийн яам, Монголын эрэгтэйчүүдийн холбоо, болон бусад дэмжигч байгууллагууд хамтран зохион байгуулсан байна. Чуулганд нийслэл, дүүрэг, хөдөө орон нутаг, төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын төлөөлөл бүхий 800 орчим төлөөлөгчид оролцож, нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоог идэвхижүүлэх, эрчүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрийн аюулгүй байдал, нийгмийн хамгаалал, гэр бүл дэх эрэгтэйчүүдийн оролцоо, хандлага, зан үйл гэсэн сэдвүүдийн хүрээнд ярилцан, санал бодлоо нэгтгэсэн байна.

Монголын эрэгтэйчүүдийн холбооноос 2004 онд 8000 хүнээс *“Аавуудын өдөр”-тэй байх нь зөв үү* гэсэн санал асуулга явуулж 5000 хүн дэмжиж 2005 оны наймдугаар сарын 8-ны өдөр тэмдэглэх болсон бөгөөд энэ өдрийг тэмдэглэдэг 18 дахь орон болсон. «Аавуудын өдөр»-ийн гол зорилго нь аав хvvхэд хоёр бие биенийгээ хvндэтгэх, хайрлахад оршиж байгаа бөгөөд нөгөө талаараа аавуудад ухаарал хайрлах өдөр. Аав нарын өдрийг дэлхийн 100 гаруй оронд өөр өөрийн онцлогтой тэмдэглэдэг. Тухайлбал, Нидерландад өглөө нь аавтайгаа хоол идчихээд орой нь өвөөгийнхөө цугларч тэмдэглэдэг байна. Монголчууд аавуудын өдрийг “Аавын баяр” албан ёсны хүндэтгэлийн өдөр болгож, ургийн бичгээ хөтөлж, хамаатан садан, үр хүүхдээ танилцуулдаг баяр болгох саналыг гаргаж байгаа ажээ.

Монголын эрэгтэйчүүдийн холбооноос 2006 онд Баянзүрх дүүргийн зарим хорооны өрх толгойлсон аавуудыг цуглуулахад 200 орчим хүн ирсэн байна. Улаанбаатар хотын хэмжээнд 7000 гаран өрх толгойлсон эцэг бий гэсэн мэдээ байна. Гэхдээ энэ нь нарийвчилсан тоо биш юм. Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт хамгийн олон ганц бие аавууд байдаг ажээ.²³²

Харин арван жилийн өмнө Монголын эмэгтэйчүүдийн холбоо Монголын хэмжээнд 10 000 орчим аав ганцаараа хүүхдүүдээ өсгөж байгаа бөгөөд Баян-Өлгий аймаг энэ үзүүлэлтээр хамгийн их гэсэн мэдээлэл хийж байсан байна.

Өрх толгойлсон ганц бие эцэгтэй өрхийн албан ёсны тоог гаргадаггүй учир дараах хүснэгтэд Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны хийсэн өрх толгойлсон, гэр бүлгүй хүний тоог хүйсээр болон ам бүлийн тоогоор, өрх толгойлсон болон гэр бүлгүй эрэгтэй хүний тоог гаргасныг харна уу.²³³

²³¹ www.niitlelch.mn

²³² Мөн тэнд.

²³³ Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн мэдээлэл.

Хүснэгт 10. Өрх толгойлсон, гэр бүлгүй хүний тоо, аймаг, нийслэл, байршил, ам бүлийн тоо, хүйсээр

Аймаг нийслэлийн нэр	Бүгд		Байршлаар				Ам бүлийн тоогоор					
			хот		хөдөө		3 хүртэл		3-5		6 ба түүнээс дээш	
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Архангай	1080	2787	90	334	990	2453	724	1733	290	952	66	102
Баян-Өлгий	710	1971	174	727	536	1250	347	1359	271	468	92	144
Баянхонгор	1800	3795	559	1355	1241	2440	1318	2085	391	1350	91	360
Булган	904	1866	198	427	706	1439	656	1257	212	524	36	85
Говь-Алтай	644	2033	164	600	480	1433	477	1228	139	647	28	158
Дорноговь	1151	2543	476	1295	675	1248	869	1338	239	999	43	206
Дорнод	2498	3629	542	2050	1956	1579	1500	2379	784	1032	214	218
Дундговь	881	1986	270	830	611	1156	659	1204	194	695	28	87
Завхан	1123	3179	184	745	939	2434	803	2197	279	835	41	147
Өвөрхангай	1179	2930	315	571	864	2359	661	1771	404	807	114	352
Өмнөговь	1501	2566	404	1047	1097	1519	1142	1794	277	671	82	62
Сүхбаатар	1549	2216	431	761	1118	1455	1095	1483	407	671	47	62
Сэлэнгэ	781	2807	332	1441	449	1366	526	1737	194	893	61	177
Төв	1235	2632	155	134	1080	2498	853	1702	315	775	67	155
Увс	1129	2712	346	1051	783	1661	832	1829	244	757	53	126
Ховд	882	2367	220	1094	662	1273	484	1229	277	810	121	328
Хөвсгөл	2481	5683	1034	2110	1447	3573	1505	3659	749	1666	227	358
Хэнтий	822	2781	176	1158	646	1623	598	1734	126	752	98	295
Дархан-Уул	1044	3913	810	3213	234	700	658	2246	231	1237	155	430
Улаанбаатар	5875	23826	5875	23826			3249	11636	1814	9304	812	2886
Орхон	601	2749	490	2429	111	320	377	1491	184	1099	40	159
Говьсүмбэр	254	586	104	356	150	230	215	369	38	203	1	14
Улсын дүн	30124	81557	13349	47548	16775	34009	19548	47460	8059	27142	2517	6955

Хүснэгт 11. Өрх толгойлсон, гэр бүлгүй эрэгтэй хүний тоо, аймаг, нийслэл, байршил, ам бүлийн тоогоор

Аймаг нийслэлийн нэр	Бүгд	Байршлаар		Ам бүлийн тоогоор		
		хот	хөдөө	3 хүртэл	3-5	6 ба түүнээс дээш
Архангай	1080	90	990	724	290	66
Баян-Өлгий	710	174	536	347	271	92
Баянхонгор	1800	559	1241	1318	391	91
Булган	904	198	706	656	212	36
Говь-Алтай	644	164	480	477	139	28
Дорноговь	1151	476	675	869	239	43
Дорнод	2498	542	1956	1500	784	214
Дундговь	881	270	611	659	194	28
Завхан	1123	184	939	803	279	41

Өвөрхангай	1179	315	864	661	404	114
Өмнөговь	1501	404	1097	1142	277	82
Сүхбаатар	1549	431	1118	1095	407	47
Сэлэнгэ	781	332	449	526	194	61
Төв	1235	155	1080	853	315	67
Увс	1129	346	783	832	244	53
Ховд	882	220	662	484	277	121
Хөвсгөл	2481	1034	1447	1505	749	227
Хэнтий	822	176	646	598	126	98
Дархан-Уул	1044	810	234	658	231	155
Улаанбаатар	5875	5875		3249	1814	812
Орхон	601	490	111	377	184	40
Говьсүмбэр	254	104	150	215	38	1
Улсын дүн	30124	13349	16775	19548	8059	2517

“Монголын эрэгтэйчүүдийн холбоо” нь 11 аймаг, 7 суманд салбартай. Нийслэлийн цагдаагийн газрын харъяа албадан саатуулах, баривчлах төв дээр эрэгтэйчүүдэд зориулан зөвлөгөө өгдөг байна. Гэр бүлийн зөрчлөөр энд орж ирсэн хүмүүст сэтгэл зүйн зөвлөгөө өгч, яаж уур бухимдлаа хянах вэ, өөрийгөө яаж хөгжүүлэх вэ гэсэн чиглэлүүдээр сургалт явуулж, сэтгэл зүйн зөвлөгөөг ганцаарчлан өгдөг байна. Үүнийг эс тооцвол өнөөдөр эрэгтэйчүүдэд зориулсан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх байгууллага, сэтгэл зүйч хомс байгааг анхааран ганц бие эцэг болон залуу гэр бүлд тулгамдсан асуудлаар зөвлөгөө өгөх төвүүдийг бий болгож үйл ажилагааг нь олонд таниулах хэрэгтэй байна.

7.4 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн байдал

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 74 тоот тушаалаар жил бүрийн 03 дугаар сарын 18-ны өдрийг «Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих өдөр» болгон зарласан. Энэ хүрээнд “Эрчүүдээ хайрлая” уриан доор анх удаа нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 20 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд давхардсан тоогоор 3000 орчим иргэдэд үнэ төлбөргүй үзлэг хийж, зөвлөгөө өгсөн байна.

Дундаж наслалт

Монгол Улсын нийт хүн амын 48.6 хувийг эрэгтэйчүүд эзэлдэг. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт 64.9, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 74.3 жил байна. Дундаж наслалтын зөрүү нь 9.4 жил байна. Дундаж наслалтын зөрүү нь аль ч улс оронд байдаг хэдий ч манай улсад дэлхийн дундаж үзүүлэлтээс 2.5 дахин их байна. Энэ нь эрэгтэйчүүдийн эрүүл мэнд тулгамдсан асуудал болж байгааг харуулж байна.

Эрэгтэйчүүдийн нас баралт

Эрэгтэйчүүдийн нас баралт 2012 оны байдлаар бүх насны бүлэгт эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр төдийгүй 10000 хүн ам тутамд 75,8 эрэгтэй, 44,3 эмэгтэй нас баржээ.

Хүснэгт 12. Нас баралт, тэргүүлэх 3 шалтгаан/10000 хүн амд/

Д/д	Нас баралтын үзүүлэлт	Эр	Эм
1.	Нийт нас баралт	75.8	44.3
2.	Зүрх судасны тогтолцооны өвчин	25.02	17.04
3.	Осол гэмтэл гадны шалтгаант	18.85	4.07
4.	Хавдар	14.74	10.67

Ганц бие аавууд ихэвчлэн салалтаас бий болдог. Нийслэлийн шүүхийн архивт Иргэний шүүхээр хэдэн онд, хэдэн гэр бүл цуцлуулсан гэдэг тоо байхаас хичнээн аав хэдэн хүүхдээ өөр дээрээ авч үлдсэн гэсэн албан тоо байхгүй байна.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны хийсэн хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээс батлуулсан, батлуулаагүй гэр бүлтэй, цуцалсан, бэлбэсэн гэр бүлийн тоог харвал:²³⁴

Хүснэгт 13. Арван тав, түүнээс дээш насны хүн амын гэр бүлийн байдал, насны бүлэг хувиар (2000, 2010)²³⁵

Насны бүлэг 15+	Бүгд	Гэр бүлийн байдал								
	Тоо	Хувь	Огт гэр бүл болоогүй	Батлуулсан, Батлуулаагүй гэр бүлтэй	Цуцалсан, Тусгаарласан	Бэлбэсэн				
2000 он										
Эрэгтэй	749890	100	36.6	274460	58.5	438686	2.1	15748	2.8	20997
Эмэгтэй	774482	100	29.7	230021	57.1	442229	3.3	25558	9.9	76674
2010 он										
Эрэгтэй	937271	100	34.4	322421	60.7	568923	2.7	25907	2.2	20620
Эмэгтэй	968698	100	28.2	273173	59.6	577344	3.5	33904	8.7	84277

Сүүлийн үед манай иргэд амьдралаа дээшлүүлэх зорилгоор нөхөн үржихүйн насныхан гадаадад ажиллаж, амьдрах болсон нь гэр бүл салалт үүсэх шалтгаан болж, эцэг эхийнхээ нэгэнтэй эсвэл хоёулант нь амьдардаггүй хүүхдүүдийн тоо их болсон. Үүнийг дараах хүснэгтээс харж болно.²³⁶

Хүснэгт 14. Хүүхдийн амьдарч буй орчин

Үзүүлэлт	Тайлбар	Улсын дүн	Хот	Бүс					
				Хөдөө	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар
Төрсөн эцэг эхийнхээ хэн нэгэнтэй эсвэл хоёулант нь хамт амьдардаггүй хүүхэд	Төрсөн эцэг эхийнхээ хэн нэгэнтэй эсвэл хоёулант нь хамт амьдардаггүй 0-17 насны хүүхдийн хувь	6.4	6.9	5.6	4.1	7.5	8.5	7.7	5.7
Өнчин, хагас өнчин хүүхэд	0-17 насны хагас эсвэл бүтэн өнчин хүүхдийн хувь	6.7	7.0	6.3	6.0	6.2	6.8	7.6	7.1
Эцэг, эх нь гадаадад амьдардаг хүүхэд	Төрсөн эцэг, эхийнх нь хэн нэг нь эсвэл хоёулаа гадаадад амьдардаг 0-17 насны хүүхдийн хувь	1.5	2.4	0.2	0.3	0.5	1.1	0.6	3.1

²³⁴Хүн амын гэр бүлийн байдал. Судалгаа. Статистикийн эмхэтгэл, 2010.

²³⁵Статистикийн эмхэтгэл. УСХ, 2010.

²³⁶Монгол Улс Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа. УСХ, НҮБ-ын Хүн Амын Сан, НҮБ-ын Хүүхдийн Сан. УБ., 2013.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэлээр:

- Хөдөлмөрийн тухай хууль. Төрийн мэдээлэл №25. Уб., 1992
- Нийгмийн халамжийн тухай хууль. /шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл №8. Уб., 2012
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль. Уб., 1994
- Нийгмийн даатгалын тухай хууль. Уб., 1994
- Хүний хөгжил сангийн тухай хууль. ТМ-2009 №45
- Гэр бүлийн тухай хууль. Уб., 1999
- Иргэний хууль. Төрийн мэдээлэл №7. Уб., 2002
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль. Уб., 1996
- Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль. Уб., 2011
- Хувь хүний нууцийн тухай хууль. Уб., 1995
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. Төрийн мэдээлэл №23. Уб., 2004
- Харьяатын тухай хууль. Уб., 1995
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих үндэсний стратеги. ЭМЯ-ны сайдын 2013 оны 84 тоот тушаал.
- Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам ЗГ-2012 оны 70 дугаар тогтоол
- Монголын гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. Суурь судалгаа. Уб., 2010
- Монгол Улс Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа. ҮСХ, НҮБ-ын Хүн Амын Сан, НҮБ-ын Хүүхдийн Сан. Уб., 2013
- Монголын эрэгтэйчүүдийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд. Чуулганы илтгэлийн эмхэтгэл. Уб., 2008
- Нийгмийн хөгжил-Эрэгтэйчүүдийн оролцоо. Үндэсний чуулганы илтгэл. ХАХНХЯ, ЖҮХ. Уб., 2013
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн байдал. Судалгаа. ЭМЯ. Уб., 2013
- Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн мэдээлэл. Уб., 2014
- Статистикийн эмхэтгэл. ҮСХ. Уб., 2010

Англи хэлээр:

- FMLA-federal Family and Medical Leave Act. www.legalmomentum.org
- Work and Social Assistance Act. www.government.nl/documents-and-publications/
- Labour Law. www.government.nl/
- The Civil Code act of the Netherlands. www.government.nl/
- General Child Benefit Act. www.government.nl/
- General Surviving Relatives Act. www.government.nl/
- General Widow's and Orphan's Benefit Act. www.government.nl/
- Exceptional Medical Expenses Act (AWBZ). www.government.nl/
- Unemployment Insurance Act (WW). www.government.nl/
- Supplementary Benefits Act (TW). www.government.nl/
- Work and Social Assistance Act (WWB). www.government.nl/
- Act on Income Provisions for Older or Partially Disabled Unemployed Persons (IOAW). www.government.nl/
- Act on Income Provisions for Older or Partially Disabled Formerly Self employed Persons (IOAZ). www.government.nl/
- The Old-Age, Survivors, and Disability Insurance (OASDI). www.legalmomentum.org
- Temporary Aid to Needy Families (TANF). www.legalmomentum.org
- Timothy Casey, Laurie Maldonado; New-York, December 2012, Worst off-single-parent families in the united states. www.legalmomentum.org
- Myths about custodial fathers. www.irlp.wisc.edu/publications/
- Maternity allowance, paternity and parental leave. www.easyexpat.com/en/guides/netherlands/
- Child support. www.childpolicyintl.org/childsupporttables/1.105Netherlands.html
- Ministry of Social Affairs and Employment; January 2013, State of Affairs of social security. www.government.nl/documents-and-publications/
- The Children Act (Act No. 7 of 8 April 1981 relating to Children and Parents) www.regjeringen.no/en/doc/laws/
- Regulations related to The Child Welfare Act. www.regjeringen.no/en/
- Act No. 41 of 26 June 1998 concerning Cash Benefit for Parents with Small Children (Cash Benefit Act). www.regjeringen.no/en/doc/laws/

- Act of 17 July 1992 No. 100 Relating to Child Welfare Services (The Child Welfare Act). www.regjeringen.no/en/
- Family benefits. www.regjeringen.no
- Single parent welfare act. http://english.mogef.go.kr/sub04/sub04_11.jsp
- Ministry of Gender Equality and Family Republic of Korea., Modularization of Korea's Development Experience: Korea's support policies for single parent families. 2014. <https://www.kdevelopmentia.org/>
- Republic act No8972, The Solo Parent's welfare. <http://census.gov.ph>
- Guidelines on the grant of parental live to Solo parents. <http://excell.csc.gov.ph/PSU/CSCMCs.html>
- Implementing rules and regulations of republic act No8972. www.lawphil.net/

Орос хэлээр:

- Федеральный Закон РФ от 19.04.1991 № 1032-1 (ред. от 02.07.2013) «О занятости населения в Российской Федерации [Электронный ресурс]. URL: www.consultant.ru/
- ФЗ "О государственных пособиях гражданам, имеющих детей". www.consultant.ru/
- ФЗ "О дополнительных мерах государственной поддержки семей, имеющих детей". www.zakonprost.ru
- Трудовой кодекс. <http://dogovor-urist.ru/>
- ФЗ «Об обязательном пенсионном страховании в РФ». www.assessor.ru
- Гаврюшенко Л. В. Как получить статус отца одиночки. www.9111.ru/questions/

**СОЁЛЫН БИЕТ ӨВД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ ТООЦОХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ,
ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ЗАРИМ
ОРНУУДЫН ТУРШЛАГА***Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаа***УДИРТГАЛ****Судалгааны зорилго**

Судалгаанд Австрали, Герман, ОХУ, БНСУ, БНХАУ зэрэг орнуудад соёлын өвд учруулсан хохирлыг хэрхэн тооцож, нөхөн төлбөрийг хэрхэн олгох ба хуулийн ямар хариуцлага хүлээлгэдэг тухай эрх зүйн зохицуулалтыг судлахыг зорив.

Судалгааны дүгнэлт

Захиалгын дагуу судлах шаардлагатай дээрх орнуудын холбогдох хууль эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд ихэнх улс орнуудад Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Эрүүгийн тухай хуулиараа Соёлын өвд учруулсан хохирлыг хэрхэн тооцох ба нөхөн төлбөр болон хариуцлага хүлээлгэх асуудлыг зохицуулж байна.

Судлагдсан орнуудын хувьд соёлын өвд учирсан хохирлыг тооцохдоо соёлын өвийн эдийн засгийн үнэ цэнийг тодорхойлох аргачлалын дагуу эхлээд эвдрэл гэмтлийн үнэлгээг тогтоон, дараа нь түүнийг нөхөн сэргээх болон дахин барьж байгуулахад шаардлагатай өртөг зардал, эдийн засгийн үр ашиг зэргийг тооцож гаргах нийтлэг зарчмыг баримталж байна.

Харин соёлын өвд учирсан хор хохирлыг тооцооны үндсэн дээр нөхөн төлбөр болон хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Соёлын өвд учруулсан хохирол нь гэмт хэргийн шинж чанартай болон хүнд, онц ноцтой, давтан үйлдэгдсэн зэрэг тохиолдолд хорих болон цаазаар авах хүртэл ял шийтгэл ногдуулж байна. Тухайлбал БНХАУ-ын хууль эрх зүйн зохицуулалтаас харахад соёлын өвд санаатайгаар ноцтой хохирол учруулсан, соёлын өндөр үнэ цэнэтэй өвийг үрэгдүүлсэн, дахин давтан үйлдсэн тохиолдолд Эрүүгийн хуулиар насаар нь хорих болон цаазаар авах ял оногдуулахаар заасан байна.

**СОЁЛЫН БИЕТ ӨВД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ ТООЦОХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ,
ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ЗАРИМ ОРНУУДЫН
ТУРШЛАГА**

Дэлхийн банкнаас 2011 онд соёлын өвийн эвдрэл гэмтэл ба хохирлыг хэрхэн үнэлдэг тухай судалгаа²³⁷ хийсэн байна. Судалгаанд дурдсанаар соёлын өвийн хохирол гэдэг нь эвдрэл гэмтлийг сэргээн засварлах болон барихад шаардагдах хөрөнгийг урьдчилсан тооцоогоор үнэлэн тооцох ба, эдийн засгийн үйл ажиллагаа, нийтийн болон хувийн орлогод учруулсан алдагдлыг хэлдэг байна.

Эвдрэл гэмтэл ба хохирлын үнэлгээгээр тооцож болдог соёлын өвд дараах зүйлс багтдаг. Үүнд:

1. Соёлын байгууламжууд, соёлын дурсгалт газрууд, эд өлгийн зүйлс,
2. Соёлын холбогдолтой газрууд ба,
3. Байгалийн өв зэрэг болно.

²³⁷Damage and Loss Assessment: The Cultural Heritage Sector, Guido Licciardi, TTL, Urban Specialist, The World Bank, 2011. <http://siteresources.worldbank.org/>

Олон улсын түвшинд соёлын өвд учирдаг эвдрэл гэмтэл ба хохирлыг үндсэндээ дайн самуун ба байгалийн гамшигтай холбон үздэг байна.

Гамшгийн дараа аливаа улс орны соёлын өвийн салбар нь Соёлын дурсгалт байгууламж, газар ба барилга байшинд учирсан эвдрэл гэмтэл болон Сэргээн засварлах, дахин барих үеийн эдийн засгийн урсгалд гарах хохирлыг тооцох ажлыг хийдэг. Гэвч олон зууны туршид хадгалагдан ирсэн түүхэн дурсгалт барилга ба нөхөж болшгүй эд өлгийг устган үгүй болгосон тохиолдолд түүнийг дан ганц мөнгөн хэмжигдэхүүнээр үнэлэх нь ихээхэн бэрхшээлтэй.

Эвдрэл гэмтэл ба хохирлыг үнэлэн тооцохдоо дараах ерөнхий зарчмуудыг баримталдаг байна. Үүнд:

- Эвдрэл гэмтэл ба хохирлыг улсын болон хувийн, олон нийтийн байгууллагын зэрэг ямар хэлбэртэй байсан ч эзэмшигч эзэн шинжлэн тооцож гаргах ёстой.
- Соёлын өвийн эвдрэл гэмтлийг тооцон үнэлэхэд уламжлалт болон түүхэн эсхүл эртний барилга байгууламжийн арга ухааны мэдлэг, дадлага бүхий архитекторууд, барилгын инженерүүд, өв хадгалалт хамгааллын мэргэжилтнүүд, хот төлөвлөлтийн мэргэжилтнүүд зэргээс бүрдсэн баг ажиллах ёстой. Харин хохирлыг тооцоход эдийн засагчид шаардлагатай.

Эвдрэл гэмтлийн үнэлгээ: Эвдрэл гэмтлийг үнэлэн тооцохдоо энэ салбарын онцлог, мөн чанарыг олон талаас нь сайтар бодолцож, барилга тус бүрээр, эд өлөг тус бүрээр тооцон гаргах ёстой. Шууд засах, нөхөн тавих, эсвэл орлуулах өртгийг бас тус бүрчлэн тооцоолон бодно. Тавилга ба тоног чимэглэл сэлтийн өртгийг барилга байшингийн хэсэгтэй адил шалгуураар үнэлэн тооцох ба, соёлын өвийн барилга эсвэл эд өлөг тус бүрээр өргөдөл гаргана хэмээх зарчмыг зүй ёсоор баримталдаг. Ингээд эвдрэл гэмтлийг засах, сэргээх, орлуулах зэргийн өртгийн хамтаар биет материаллаг хэлбэрээр, мөнгөний нэгжид хувирган бодно.

Хохирлын үнэлгээ: Соёлын өвийг сэргээн дахин барих хугацаа нь хохирлын хүрээнд чухал тодорхойлогч болдог. Тухайн нэг барилга байгууламжийг сэргээн барих, гэмтэл эвдрэлийг нь бүрэн засах, улмаар соёлын өвийн газар ба өвийн дэд бүтцийн дахин нээхийг хүртэлх бүх хугацаанд хохирол тооцогдох ёстой. Учир нь энэ хугацаанд өвийн эзэн хохирсоор байгаа гэсэн үг. Хохиролд ихэвчлэн дараах зүйлс тооцогдоно. Үүнд: түр зуурын авран хамгаалах арга хэмжээ ба, цаашид гэмтээхгүй байх тухайд авсан урьдчилан сэргийлэх ажиллагааны өртөг, мөн тэрчлэн зарим хэсгээ хааснаар алдсан олох байсан орлого (*үзвэрийн тийзийн худалдаа ба өргөл хандиваас олох байсан*) зэрэг орно.

Макро-эдийн засгийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо: соёлын өвийн барилга доторх гадаадаас импортолсон эд зүйлсийг нөхөн тавих өртгийн үнэ цэнэ. */Орон нутагтаа үйлдвэрлэдэггүй эд материал, машин механизм, тоног төхөөрөмж зэргийг гадаадаас дахин импортлох./* төв засгийн газраас түр зуурын хадгалалт хамгаалалт ба эвдэгдсэн хэсгийг зохистойгоор зөөж цэвэрлэх зэрэгт оруулсан хувь хэсгийг нь тооцон санхүүгийн жилийн төсвийн шинжилгээнд оруулна. Алдсан орлогын хохирлыг үнэлэн тооцсон үнэ ба цаг хугацааны хэмжигдэхүүнээр нь бодож тухайн үеийн үнээр тооцох ба, соёлын өвийн барилга эсхүл эд өлөг засварлагдах ба баригдах хугацаанд тухайн хувийн эсвэл улсын салбарт нөхөн олгогдох дүнг эдийн засагч хүн амын орлогын үр нөлөөний тооцоог хийхдээ ашиглана.

- Тухайн нэг өвийн газарт түр хугацаанд зочид ирэхгүй болсны улмаас гарах гадаад валютын алдагдал хохирлыг тооцож төлбөрийн дүн шинжилгээний тайлан баланс гаргахдаа оруулна.
- Тухайн салбарын хэсгийн барилга байгууламж аль эсвэл эд өлөг гэмтсэн эсвэл устгагдсаны даатгалын үр дүнд, гадаадын компаниудад даатгуулсан тухайн

даатгагдсан хувь хэмжээг гадаад валютын орлого нэмэгдэж байна хэмээх үндэслэлээр тооцож үзэх ёстой юм. Энэ нь тухайлан түүх болон соёлын өндөр үнэ цэнэ бүхий ажил, эд өлөг ба цуглуулгын тухайд маш чухал байдаг юм. Тиймээс ийм эд өлгийн үнэ цэнийг тогтоохдоо мэргэжилтэн хүн заавал тухайн орон нутгийн даатгалын компаниудтай зөвлөлдөх шаардлагатай байдаг.

- Хувийн болон улсын секторын соёлын өв бүрэн сүйтгэгдсэний учирт нөхөн авсан орлогын хохирлын тооцоог макро эдийн засагч хүн заавал авч хүн амын орлогын үр нөлөөний тооцоонд оруулах ёстой.
- Ажил эрхлэлтэд үзүүлэх үр нөлөө: Энэ нь тухайн нэг хохирсон байгууллагын эсвэл олон нийтийн хүмүүс харьцангуй удаан хугацаанд ажил эрхлэхгүй болж буйгаас үүдэн гардаг үр нөлөө болно. Түр болон нэг мөсөн алдсан ажлын байрны тоог тооцоолж, тухайн салбарын мэргэжилтэн ажил эрхлэлтийн мэргэжилтэнтэй нягт хамтран ажиллах ёстой юм.
- Тухайн нэг өвийн газарт нэвтрэх татвар тасалбараас бүрдүүлдэг засгийн газрын эсхүл олон нийтийн орлого түр зуур зогсоход гарах алдагдал хохирлын тооцоог бусад холбогдох орлогын тооцооны хамтаар санхүүгийн жилийн төсвийн шинжилгээнд оруулна.
- Гадаадын жуулчдын итгэлийг дахин олохын тухайд хийсэн мэдээлэл, сурталчилгааны ажлын үнэ цэнэ ба зарцуулсан цаг хугацааны тооцоо,
- Энэхүү мэдээлэл, сурталчилгааны ажлын санхүүжилтэд засгийн газраас оруулсан хувь хэмжээний тооцоог санхүүгийн жилийн шинжилгээнд оруулж бодох зэрэг байна.

Соёлын өвийн эвдрэл гэмтэл ба хохирлыг тооцох аргачлалын хувьд дэлхийн улс орнууд дээрх ерөнхий зарчмыг баримталдаг байна.

Харин соёлын өвд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх болон хүлээлгэх хариуцлагыг тус тусын Эрүүгийн хууль болон Соёлын өвийг хамгаалах холбогдох хууль журмаар зохицуулж байна.

1. Бүгд Найрамдах Солонгос Улс

Судалгааны сэдвийн хүрээнд тус улсын соёлын өвд учруулсан хохирлыг хэрхэн тооцож, нөхөн төлүүлдэг, хариуцлагыг хэрхэн ногдуулдаг талаарх эрх зүйн зохицуулалтыг Соёлын өвийг хамгаалах хууль /Cultural heritage protection act, 1962/²³⁸, соёлын өвийн захиргааны албан ёсны вэб сайтад тавигдсан мэдээлэл зэргээс судалгааны мэдээлэл бэлтгэлээ.

Аливаа улс орны соёлын өвд учруулсан хохирлыг хэрхэн нөхөн тооцож, нөхөн төлүүлэх, хариуцлагыг хэрхэн ногдуулах эрх зүйн зохицуулалт нь соёлын өвийн хамгаалал, ангилал, зэрэглэл, зах зээлийн бодит үнэн цэнийг тооцох зэрэг бүхий л харилцааг нэгтгэсэн иргэн, хуулийн этгээдийн хамтын ажиллагаа юм.

Тус улсад Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу Соёлын өвийн захиргаа /Cultural Heritage Administration Of Korea/ соёлын өвийг хамгаалахад чиглэсэн бүхий л асуудлыг эрхэлсэн Засгийн газрын агентлаг юм. Соёлын өвийн захиргаа нь соёлын өвийг хамгаалах мастер төлөвлөгөөг 5 жилийн хугацаатай гаргаж улс болон орон нутгийн хэмжээнд мастер төлөвлөгөөний үнэлгээ, өвийн сэргээн засвар, өвийг хамгаалах талаар хяналт тавих, соёлын өвийн мэдээллийн сантай холбоотой асуудлууд, өвийг хадгалж, хамгаалах, ашиглахтай холбогдсон менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллага юм.

²³⁸Cultural Heritage Protection Act. <http://faolex.fao.org/docs/pdf/kor108384.pdf>

Соёлын өвийн захиргаа нь соёлын өвийг хамгаалах мастер төлөвлөгөөг удирдан зохион байгуулах салбар хороодын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. Хорооны гишүүдийг соёлын өвийн захиргааны тэргүүн томилж чөлөөлнө.

Соёлын өвийн захиргаа нь хорооны гишүүдийг сонгон шалгаруулахдаа соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу их, дээд сургуулийн, антропологи, социологи, архитектур, хот төлөвлөлт, аялал жуулчлалын салбарын багш, профессор зэрэг эрдэмтэн судлаачдаас томилогддог байна. Салбар хороод нь дэд хороодоос бүрдэх бөгөөд соёлын өвийн ангилал, зэрэглэлээс хамаарч соёлын өвийн зах зээлийн үнэлгээ тогтоох гэх мэт нарийн мэргэжлийн шинжээч, судлаачдын баг үйл ажиллагаа явуулдаг байна. Хорооны Соёлын өвийн захиргааны тэргүүн нь соёлын өвийг хамгаалахтай холбоотой мөрдөн байцаалт явуулах бөгөөд Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон журмаар зохицуулдаг байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар соёлын өвд учруулсан хохирлыг хэрхэн нөхөн тооцож, нөхөн төлүүлэх, хариуцлагын талаарх зохицуулалтыг авч үзье. Хуулийн 39, 90.1 дүгээр зүйлээр Гадаад улсад БНСУ-ын түүх, соёлын өвийг олон улсын үзэсгэлэнд оролцох зорилгоор гадаадын улс оронд 2 жилийн дотор эх оронд нь буцаан ирүүлэх нөхцөлтэйгөөр Соёлын өвийн захиргааны зөвшөөрөл авч экспортолдог бөгөөд заасан хугацаанд эх оронд нь буцаагаагүй гэм буруутай этгээдэд 5-аас доошгүй жил хорих ял оногдуулж холбогдох соёлын өвийг буцаан авна.

Хуулийн 60, 90.2 дүгээр зүйлээр энгийн соёлын хөдлөх өвийг гадаадын музейд /Засгийн газрын зөвшөөрлөөр худалдан борлуулснаас бусад тохиолдолд/ худалдан борлуулснаас хойш 10 жилийн дотор илрүүлсэн бол гэм буруутай этгээдийг 3-аас доошгүй жил хорих ял оногдуулж холбогдох соёлын өвийг буцаан авна.

Хуулийн 91 дүгээр зүйлээр Хуурамч бичиг баримт бүрдүүлэх буюу хууль бус бусад аргаар соёлын өвд хохирол учруулсан гэм буруутай этгээдэд 5-аас доошгүй жил хорих ял онооно.

Хуулийн 92 дүгээр зүйлээр Хохирол учруулж, нуун дарагдуулсан гэмт хэрэг Соёлын өмч хөрөнгөнд (чухал биет бус соёлын өвөөс бусад) хохирол учруулж тонож, нуун далдалсан гэм буруутай этгээдэд 3-аас доошгүй жил хорих ялаар шийтгэх буюу 20-150 сая воноор торгоно.

Хуулийн 95, 96 дугаар зүйлээр соёлын өвийн хамгаалалтын бүсийн журам зөрчсөнөөс Түүх, соёлын өвийн дурсгалт газрууд үер усанд автаж хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд хохирлын хэмжээнээс хамаарч 2-10 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

Хуулийн 97 дугаар зүйлээр дээрх 90, 92 гэмт хэрэг үйлдэхийг завдсан гэм буруутай этгээдийг 96 дугаар зүйлд заасан шийтгэл ногдуулна. Соёлын өвийн хамгаалалтын бүсийн журам зөрчсөнөөс Түүх, соёлын өвийн дурсгалт газрууд үер усанд автаж хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд хохирлын хэмжээнээс хамаарч 2-10 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

Хуулийн 98 дугаар зүйлээр дээрх 95, 96 зүйлд заасан гэмт хэргийг санамсаргүй үйлдсэн бол 10 сая вонноос доошгүй торгох ялаар шийтгэнэ.

Хуулийн 99 дүгээр зүйлээр Иргэн, хуулийн этгээд соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчиж зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж соёлын эд хөрөнгөнд хохирол учруулсан бол гэм буруутай этгээдэд 5-аас доошгүй жил хорих ялаар шийтгэх эсхүл 20-50 сая вонноос ихгүй торгууль ногдуулна.

Хуулийн 100 дугаар зүйлээр Онцгой байдлын үеийн соёлын өвийг хамгаалах /зэвсэгт мөргөлдөөн, олон нийтийн үймээн / төлөвлөгөөний журам зөрчиж шаардлагатай арга хэмжээг аваагүйн улмаас соёлын өмч хөрөнгөнд хохирол учирсан бол гэм буруутай захиргааны албан хаагчид 3-аас доошгүй жил хорих ялаар шийтгэх буюу 30 сая won-ноор торгоно.

Хуулийн 101 дүгээр зүйлээр Иргэн, хуулийн этгээд барилгын ажлын явцад зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлж соёлын өвийг гэмтээсэн, соёлын өвч хөрөнгөнд цаашид эвдэрч сүйдэх аюулд өртсөн бол гэм буруутай этгээдийг 2-оос дээш жил хорих эсхүл 20 сая won-ноор торгоно.

ХХ дугаар зууны үед БНСУ-ын соёлын үнэт зүйлсүүд их хэмжээгээр устсан бөгөөд сүүлийн хэдэн арван жилийн турш олон улсын урлагийн зах зээлийн өсөлтийг дагаж эртний эдлэлүүдийн талаар хууль бус малтлага ихээр гарах болж урлагийн олон төрлийн эртний керамик, баримал, үнэт эдлэлийн хууль бус худалдааны өсөлт нэмэгджээ. Соёлын үл хөдлөх хөрөнгийн хулгайтай холбоотойгоор тус улсад жилдээ 1100 орчим хэрэг бүртгэгддэг байна.

2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Соёлын үнэт зүйлсийг хамгаалах, устгагдахаас соёлын олон төрөл зүйлийг хамгаалах Холбооны болон муж улсын хууль, Европын Холбооны хууль, тогтоомж, Олон улсын эрх зүйгээр хамгаалах эрх зүйн зохицуулалттай.

Соёлын үнэт зүйлсийг хамгаалах тус улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ, конвенцийн хүрээнд соёлын олон төрөл зүйлийн хууль бус худалдаа, хулгай, харилцан эрхийг баталгаажуулах, хууль бус импорт, тусгай хамгаалалттай соёлын үнэт зүйлсийг экспортлохоос урьдчилан сэргийлэх, зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах харилцааг зохицуулахаас гадна зарим худалдааны эрх зүйн хэм хэмжээ үйлчлэх тохиолдол байдаг байна.²³⁹

Европын Холбооны хууль тогтоомжоор соёлын үнэт зүйлсийг гуравдагч улс оронд экспортлохоос хамгаалах, хамгаалагдсан соёлын үнэт зүйлсийг хууль бусаар Холбооны өөр нэг гишүүн улсад экспортолсон бол эргэн шаардах эрхтэй байна. Холбооны Улсын хуулиар соёлын олон төрөл зүйлийг хамгаалах ерөнхий зохицуулалттай бөгөөд 16 мужид бүр тус тусын хуулиар соёлын олон төрөл зүйлийг хамгаалах дүрэм, журмууд үйлчилдэг.

Холбооны Засгийн газрын соёлын хэвлэл мэдээлэл, комиссар соёлын эд хөрөнгө, үндэсний ач холбогдол бүхий архивын материал экспортлох тусгай зөвшөөрөл олгох үүрэгтэй бөгөөд гадаадын улс орнууд, соёлын үл хөдлөх хөрөнгийг гадаадын улс оронд зохион байгуулсан үзэсгэлэн оролцуулж хууль ёсны буцах батлан даалт гаргасны төлөө хариуцлага хүлээнэ.

Соёлын өвд учруулсан хохирлыг хэрхэн тооцож, нөхөн төлүүлдэг, хариуцлагыг хэрхэн ногдуулдаг талаар тус улсын соёлын өвийн харилцааг зохицуулсан дараах хуулиудын зохицуулалтыг авч үзье.

Германы соёлын өмчийг алдахаас урьдчилан сэргийлэх тухай хууль, /Act to Prevent the Exodus of German Cultural Property, 1975/²⁴⁰ -ийн 3 дугаар бүлгийн 16 зүйлд Аливаа этгээд нь тусгай зөвшөөрөлгүйгээр хууль бус аргаар бүртгэгдсэн соёлын өвийн эд зүйлсийг экспортолсон, экспортлохоор завдсан бол 3 жил хүртэлх хугацаагаар хорих буюу тухайн соёлын өвийн зэрэглэлээс хамаарч торгох ялаар шийтгэнэ.

²³⁹Cultural property protection under international law. www.kulturgutschutz-deutschland.de/EN/

²⁴⁰Act to Prevent the Exodus of German Cultural Property. www.eui.eu/Projects/InternationalArtHeritageLaw/

Соёлын өмчийн конвенцийг хэрэгжүүлэх тухай хууль /Act Implementing the Cultural Property Convention, 1970/²⁴¹ -ийн 5 дугаар бүлгийн 20 зүйлд Аливаа этгээд санаатай хулгай, дээрэм буюу хууль бусаар, эсвэл конвенцийн дагуу хамгаалагдсан соёлын эд хөрөнгийг санаатайгаар халдаж устгасан, гэмтээсэн бол гэм хэрэгт гэж үзэх бөгөөд 3 жил хүртэлх хугацаагаар хорих эсүл 5000 еврогоор торгох шийтгэл ногдуулна.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль /1998, (Strafgesetzbuch, StGB)/²⁴²ийн 259, 260 дүгээр зүйлээр хулгайлагдсан өмчийг хүлээн авах, худалдан авсан, гуравдагч этгээдэд дамжуулсан, тухайн эд зүйлсийг бүлэглэн хулгайлсан бол 5-10 жил хүртэл хугацаагаар хорих буюу торгох ял ногдуулна.

Мөн хуулийн 27 дугаар бүлгийн 303 дүгээр зүйлд Өмч хөрөнгийг гэмтээсэн, гэмтээхээр завдсан, зориулалтыг нь өөрчилсөн этгээдэд 2- оос дээш жил хорих эсхүл торгох ял ногдуулна.

304 дүгээр зүйлээр олон нийтийн өмчид түүх, соёлын дурсгалт зүйлс, дурсгалт цуглуулгын зүйлс, урлаг, шинжлэх ухаан, гар урлал хадгалж буй байгууламж, нийтийн эзэмшлийн аливаа объектод аливаа хэлбэрээр хохирол учруулсан, хохирол учруулахаар завдсан этгээдэд 3-аас дээш жил хорих эсхүл торгох хорих ял ногдуулна.

305-304 дүгээр зүйлээр хамгаалагдсан аливаа өмчийн хэлбэрийг хууль бусаар бүхэлд буюу хэсэгчлэн устгасан, завдсан этгээдэд 5-аас дээш жил хорих ял ногдуулна.

Мөн хуулийн 27 дугаар бүлгийн 306 дүгээр зүйлээр нийтийн өмчийн объектыг бүхэлд нь хэсэгчлэн галдан шатаасан, гэмт хэргийн улмаас хүний амь нас хохироосон этгээдэд 5-10 жилийн хорих ял ногдуулна. Гэм хэргийг болгоомжгүй үйлдсэн этгээдэд 3 жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл торгох ял ногдуулна.

Соёлын өмчийг хамгаалахад чиглэсэн эрх зүйн баримт бичгүүдэд бүх ард түмний соёлын өвийг нь маш чухал ач холбогдолтой хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг хууль бусаар хураах, соёлын үнэт зүйлсийн эсрэг чиглэсэн аливаа үйлдэл хийхийг хориглоно. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай Конвенцын дагуу бүх ард түмний соёлын өвийг нь маш чухал ач холбогдолтой гэдгийг хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгөнд (архитектур, урлаг, эсвэл түүх, шашин мөргөлийн газар, ном гэх мэт дурсгалт өгдөг, шинжлэх ухааны цуглуулгууд) довтолж ямар нэгэн байдлаар гэмтээж, устгахыг хориглоно.

3. Австрали Улс²⁴³

Австралийн соёлын өвийг²⁴⁴ хамгаалах асуудлыг улс, муж улс, нутаг дэвсгэр, орон нутгийн засаг захиргаа хэрэгжүүлэх ба Байгаль орчны департамент болон Ерөнхий Прокурорын департаментын дэргэдэх Соёл, урлагийн алба хариуцна.

Австралийн соёлын өвийг бүртгэлийн хэлбэрээр нь:

- Дэлхийн өв;
- Уугуул иргэдийн өв;
- Хамтын Нөхөрлөлийн өв гэж ангилна.

²⁴¹Act Implementing the Cultural Property Convention. www.kulturgutschutz-deutschland.de/

²⁴²Strafgesetzbuch, StGB. www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html

²⁴³www.pc.gov.au/_data/assets/pdf_file/0008/92375/06-chapter4.pdf

²⁴⁴www.worldcp.org/australia.php?aid=1

Хууль, эрх зүйн орчин

Австралийн Байгалийн болон соёлын өвийн тухай голлох хууль тогтоомж нь 1999 оны Байгаль орчны хамгаалал болон биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай хууль /Environment Protection and Biodiversity Conservation Act 1999/ юм. Үүнээс гадна Австралийн байгаль, түүх, соёлын өвтэй холбоотой зарим хуулиуд нь:

- Соёлын хөдлөх дурсгалыг хамгаалах тухай хууль 1986;
- Түүхэн ач холбогдол бүхий сүйрсэн усан онгоцны тухай хууль 1976;
- Уугуул иргэдийн болон Торрес хоолойн арлынхны уугуул иргэдийн соёлын өвийг хамгаалах тухай хууль 1984;
- Австралийн соёлын өвийн зөвлөлийн тухай хууль 2003 зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг баталсан байна.

Австралийн соёлын өвийг хадгалж, хамгаалах асуудлыг улс, муж улс, нутаг дэвсгэр болон орон нутаг гэсэн гурван хүрээнд авч үзнэ. Соёлын өвийг тодорхойлох шалгуур нь дээрх шатлал тус бүрд агуулгын хувьд ойролцоо байх ба өвийн үнэлгээний шалгуур /*Cultural heritage assessment criteria*/ нь хоорондоо ялгаа багатай байдаг байна.²⁴⁵

1) Соёлын өвд учруулсан хохирлыг хэрхэн тооцох

Австралийн муж улс болон нутаг дэвсгэрийн соёлын өвийн тухай хуулиудад соёлын өвийн үнэлгээний ерөнхий шалгуурыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Тухайн газар нь тухайн газар нутгийн байгаль, соёлын түүхэн чухал ач холбогдлыг илэрхийлсэн байдал;
- Тухайн газар нь байгаль, соёлын түүхэнд өвөрмөц, ховор эсхүл сүйрлийн ирмэгт байгаа байдал;
- Тухайн газар нь байгаль, соёлын үүсэл, хөгжил, түүхийг ойлгоход тус дэм болохуйц мэдээлэл агуулсан байдал;
- Соёлын өвийн чухал, ач холбогдолтой байх байдал;
- Тухайн газар нь хэсэг бүлэг хүмүүс эсхүл нийгмийн хувьд соёл эсхүл шашны хувьд чухал ач холбогдолтой байдал зэрэг шалгуурууд ордог байна.

Соёлын хөдлөх дурсгалын хувьд, 1986 оны Соёлын хөдлөх дурсгалыг хамгаалах тухай хуулийн 25 дугаар хэсэг, 1997 оны Санхүүгийн удирдлага болон хариуцан тайлагнах тухай хуулийн 21 дүгээр хэсэгт заасныг тус тус үндэслэн Ерөнхий Прокурорын Департаментын дэргэдэх Соёл, урлагийн албаны харьяа Үндэсний соёлын өвийн сан /The National Cultural Heritage Account/-г байгуулсан байна. Тус байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилго нь соёлын байгууллагуудад үндэсний чухал ач холбогдол бүхий дурсгалт эд зүйлсийг эх оронд нь хадгалж, хамгаалах олон нийтэд хүртээмжтэй болгоход зориулагдсан тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Сан нь хүсэлт гаргасан улсын, орон нутгийн болон төрийн бус статустай музей, уран зургийн галерей, номын сан, архив, түүхийн ач холбогдол бүхий барилга байгууламж зэрэг соёлын төрөлжсөн байгууллагуудад жил бүр нийт 500 мянган долларын санхүүжилтийг үзүүлдэг байна. Сангаас олгох дэмжлэг нь дурсгалт эд зүйлийн зах зээлийн бодит үнийн зөвхөн тодорхой хэсгийг санхүүжүүлнэ.

2) Соёлын өвийн үнэлгээ буюу зах зээлийн үнэ цэнийг тогтоох аргачлал

Австрали, Шинэ Зеланд улс нь 1990-ээд оны дунд үеэс эхлэн төрөөс соёлын өвийн талаар хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг илүү оновчтой болгох, төрийн байгууллагуудын хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор соёлын биет өв хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаж байхаар тогтоосон байна.

²⁴⁵Protection of Movable Cultural Heritage Act No. 11 of 1986 as amended. www.comlaw.gov.au/

Засаг захиргааны нэгжүүд буюу муж, улсын нутаг дэвсгэр нь өөрийн эзэмшилд байгаа хөрөнгө, соёлын биет өв хөрөнгийг санхүүгийн тайланд тусгахтай холбоотойгоор арга зүйн зөвлөмж боловсруулах бөгөөд Квинсленд муж улсын Худалдаа, сангийн яамнаас боловсруулсан Квинслендийн улсын салбарын биет хөрөнгийн үнэлгээний тухай баримтлах бодлогыг судалж үзэхэд Квинсленд муж улсын хувьд соёлын өвийн үнэлгээ буюу соёлын өвийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох асуудлаар Улсын салбарын биет хөрөнгийн талаар баримтлах бодлогын баримт бичиг /Non-current Asset Policies for Queensland Public Sector/-т хөрөнгийн үнэ цэнийг тогтоохдоо Австралийн нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл /Australian Accounting Standards Board цаашид AASB гэх/-өөс тогтоосон хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолох /AASB 13 Fair Value Measurement/ стандартаар тогтоодог байна.

Хөрөнгийн үнэлгээг тооцохдоо, хэрэглэх үнэлгээний аргачлалаас үл хамааран, бодит үнэ цэнийг тооцоход ашиглах тоо мэдээ, мэдээллийг AASB 13-т заасан бодит үнэ цэнийн 3 зэрэглэлд хуваана. 1 дүгээр зэрэгт багтсан хөрөнгийн үнэлгээг шууд тогтоох боломжтой, 2 дугаар зэрэгт багтсан хөрөнгийн холбогдох тоо мэдээ, мэдээлэл нь хөрөнгийн үнэлгээг шууд тогтооход хүрэлцэхгүй, нэмэлт мэдээлэл, дүн шинжилгээ шаардагдахыг, 3 дугаар зэрэгт бэлэн байгаа тоо мэдээ, мэдээлэл нь хөрөнгийн үнэлгээг тогтооход ач холбогдолгүй, соёлын өв хөрөнгийн тухайд авч үзвэл зах зээлийн үнэ ханшийн талаарх мэдээлэл нь хомс эсхүл мэргэжлийн экспертийн үнэлгээ, дүн шинжилгээ шаардахыг тус тус илэрхийлнэ.

Урлагийн бүтээл, үнэт эдлэл, цуглуулга зэргийн үнэ цэнийг тогтоохдоо холбогдох ижил төрлийн эд зүйлсийн зах зээлийн мэдээлэл байгаа тохиолдолд зах зээлийн хандлагын аргыг ашиглах нь тохиромжтой байдаг байна.

3) Соёлын өвийн хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлага хүлээлгэх²⁴⁶

Соёлын өвд учруулсан хохирлыг барагдуулах болон түүнд хүлээлгэх хариуцлагыг Хөдлөх соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Эрүүгийн хуулиар зохицуулж байна.

Хөдлөх соёлын өвийг хамгаалах тухай хуульд зааснаар хэрвээ хуулийн энэ хэсгийг баримтлан тодорхой эд өлөг ба зөрчлийг илрүүлэх зорилгоор олгогдсон зөвшөөрлийн бичгийн дагуу нэгжлэг хийх үеэр хэдийгээр зөвшөөрлийн бичигт тодорхойлон заагаагүй боловч мөрдөн байцаагч өөрөө энэ хуулийг зөрчсөн өөр нэгэн эд зүйл эсхүл үйлдэл байна гэж үзэх хангалттай учир үндэслэл байна хэмээн үзэхүйц зүйлийг илрүүлсэн мөрдөн байцаагч тухайн зүйлийг цаашид экспортлох, импортлох, нуун дарагдуулах, хохирол учруулах эсхүл устгагдах, зөрчил үүсэх, дахин давтан үйлдэгдэх эсхүл өөр бусад зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс хураан авах эрхтэй байдаг байна.

Мөн хуульд Мөрдөн байцаагч хэрвээ экспорт хийхээр завдаж байна, эсхүл экспорт хийж байна хэмээн хангалттай үндэслэлээр сэжиглэж буй бол тийнхүү сэжиглэгдэж буй хэнээс ч Австралийн хамгаалалт бүхий эд зүйлийг экспортлох албан ёсны зөвшөөрөл эсхүл гэрчилгээг, тэрхүү гэрчилгээнд дурдсан зүйлсийг баталгааг шаардаж болно.

Энэхүү шаардлагыг биелүүлж чадаагүй хүнийг гэм буруутайд үзэж \$1,000 илүүгүй мөнгөөр торгоно. Хэрвээ тухайн хүнд хүндэтгэн үзэх шалтгаан буй бол (2) хэсгийн шийтгэлийг ногдуулахгүй.

Соёлын өвд учруулсан хохирол нь хүнд болон гэмт хэргийн шинжтэй бол 1995 оны Эрүүгийн хуулиар шийтгэнэ.

²⁴⁶Мөн тэнд.

Хуулийн энэ хэсгийн дагуу ямарваа орон байр, барилга байгууламж, усан онгоц, нисэх онгоц эсхүл авто хэрэгсэл зэрэг ямар нэг эд хөрөнгөтэй холбоотойгоор албан ёсоор ногдсон эрх үүргээ хэрэгжүүлэх явцад тухайн хөрөнгийн эзэн эсхүл хариуцаж буй этгээд мөрдөн байцаагчид зохих ёсоор туслах үүрэгтэй ба, хүссэн бүхнийг даган биелүүлэх ёстой.

Үүнийг зөрчвөөс ногдуулах шийтгэл нь: \$2,000 торгууль эсхүл 12 сар баривчлан хорих, эсхүл хоёуланг нь эдлүүлнэ.

Соёлын өвтэй холбогдох зөрчил нь эрүүгийн хариуцлага ногдуулах хэрэг байхаас гадна, хэрвээ шүүхээс зохистой гэж үзэхийн сацуу яллагдагч ба прокурор нь зөвшөөрөх аваас шүүхийн шийдвэрийг сонсгож, гэмт хэрэгт холбогдох хуулийн хариуцлагыг тодорхойлно.

(а) хэрвээ тухайн этгээд нь хувь хүн бөгөөс - шийтгэлийн 50 нэгжээр торгох эсхүл 2 жилээс хэтрэхгүй хугацаагаар хорих, эсхүл хоёуланг нь ногдуулах,

(б) хэрвээ тухайн этгээд нь аж ахуйн нэгж бөгөөс - шийтгэлийн 200 нэгжээс хэтрэхгүй хэмжээгээр торгууль ногдуулах арга хэмжээ авдаг байна.

4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс²⁴⁷

Соёлын өвд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлага хүлээлгэх харилцааг 2002 онд шинэчлэн найруулсан «Соёлын өвийг хамгаалах хууль» ба 1997 оны Эрүүгийн хуулиар зохицуулдаг.

Хуульд зааснаар бүх шатны орон нутгийн ардын засгийн газрууд нь тус тусын засаг захиргааны нутаг дэвсгэр дэх соёлын дурсгалуудыг хамгаалалтдаа авна. Харьцангуй их хэмжээний соёлын дурсгал бүхий шууд Төв Засгийн газрын харьяаны муж, өөртөө засах бүс нутаг, томоохон хотууд ба өөртөө засах дүүрэг, сумууд нь тус тусын захиргааны нутаг дэвсгэрийн дотор соёлын дурсгалыг хамгаалах ба хянах бүтцийг байгуулж болдог. Бүх засгийн газрын албад, улсын байгууллагууд ба хувь хүмүүс улс орныхоо соёлын дурсгалыг хамгаалах үүрэгтэй. Улсын хил хязгаар доторх газрын доорх болон усан доорх бүх соёлын дурсгалууд нь төрийн мэдэлд байна.

Аливаа хамт олон эсвэл хувь хүний эзэмшилд үеэс үед дамжин ирсэн дурсгалт барилга, эртний архитекторын байгууламж ба соёлын дурсгалыг төрийн хуулиар хамгаална. Соёлын дурсгалын эзэмшигчид нь соёлын дурсгалыг хамгаалах ба хянах тухай холбогдох төрийн хууль журмыг даган мөрдөнө. Соёлын дурсгалыг хамгаалах ба хянах ажлын зардлыг төв болон орон нутгийн захиргааны төсөвт жагсаалтаар оруулдаг.

“Хувийн цуглуулгад буй соёлын дурсгалыг соёлын захиргааны департаментаас нэр заасан нэгжүүд худалдан авч болно. Өөр бусад ямар ч нэгж эсхүл хувь хүн соёлын дурсгалыг худалдаалах бизнест оролцож болохгүй” гэжээ. Мөн 25-р зүйлд нь: “Хувийн цуглуулгад буй соёлын дурсгалыг ашиг олох зорилгоор дахин худалдаж борлуулахыг хатуу хориглох ба, энэчлэн гадаадын иргэдэд тийм дурсгалуудыг хувиараа худалдаалахыг хориглоно” гэж заасан байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30-р зүйлд дараах үйлдлүүдийн аль нэгийг үйлдсэн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:

²⁴⁷Law of the People's Republic of China on the Protection of Cultural Relics.
http://english.mep.gov.cn/Policies_Regulations

(1) газар дороо, усан дороос, улсын мэдлийн тэнгисийн уснаас эсвэл бусад газраас нуусан соёлын дурсгалыг олоод төрд мэдээлээгүй ба хүлээлгэн өгөөгүй этгээдэд Улсын Аюулгүйн Албанаас сануулга өгөх эсвэл торгууль ногдуулах ба түүний хууль бусаар эзэмшсэн соёлын дурсгалыг нөхөн гаргуулна;

(2) соёлын захиргааны департаментын зөвшөөрөлгүйгээр соёлын дурсгалын худалдан авсан эсхүл зарсан этгээдэд Аж үйлдвэр ба худалдааны албанаас сануулга өгөх эсхүл торгууль ногдуулах ба түүний хууль бусаар олсон орлого ба соёлын дурсгалыг хураан авч болно; эсхүл

(3) хувийн цуглуулга дахь соёлын дурсгалыг гадаадын иргэнд зөвшөөрөлгүйгээр худалдсан этгээдэд Аж үйлдвэр ба худалдааны албанаас сануулга өгөх эсхүл торгууль ногдуулах ба холбогдох соёлын дурсгал ба хууль бусаар олсон орлого зэргийг нь хураан авч болно.

Мөн хуулийн 31-р зүйлд дараах үйлдлүүдийн аль нэгийг үйлдсэн хүнийг хуулийн дагуу эрүүгийн хариуцлагад татаж мөрдөн байцаана гэжээ. Үүнд:

(1) төрийн мэдлийн соёлын дурсгалыг хууль бусаар авсан эсхүл хулгайлсан;

(2) соёлын үнэт дурсгалыг хууль бусаар хил гаргасан эсвэл соёлын дурсгалыг үрэгдүүлсэн ноцтой хэрэгт;

(3) төрийн хамгаалалтад байдаг соёлын үнэт дурсгал эсхүл соёл болон түүхийн сонирхолтой газруудыг санаатай эвдэж гэмтээсэн;

(4) төрийн албан үүргээ цалгардуулсны уршгаар соёлын үнэт дурсгалыг ноцтой гэмтээсэн эсхүл ноцтой хохирол учруулсан бол;

(5) Эртний соёл эсхүл эртний булш бунхныг зөвшөөрөлгүйгээр ухаж малтлага хийсэн этгээдийг

Хувийн цуглуулгад байсан соёлын үнэт дурсгалыг гадаадын иргэнд зөвшөөрөлгүйгээр худалдан борлуулсан этгээдийг соёлын үнэт дурсгалыг хууль бусаар хил давуулсан хэргээр татаж шийтгэнэ.

Соёлын дурсгалын салбарт ажилладаг хүн өөрийн хариуцан хамгаалах ёстой байсан соёлын дурсгалыг хулгайлсан этгээдийг мэдсээр байж нуусан тохиолдолд хуулийн дагуу хатуу шийтгэл ногдуулна.

Дээрх тохиолдолд хуулийн дагуу торгох, 1-6 сар баривчлан саатуулах, эд хөрөнгийг нь хураах, 2-оос дээш жилээр хорих, зарим хэрэгт бүр цаазаар авах ял ногдуулдаг байна.

Хятадад соёлын өв нь төрийн хамгаалалтад байдаг бөгөөд хууль зөрчсөн тохиолдолд ногдуулах шийтгэл нь маш хатуу байдаг. 1980 аад оны сүүлч 1990-ээд оны эхээр Хятадын соёлын өвийг хууль бусаар хил давуулан наймаалах нь ихэссэн тул үүнтэй холбогдох Эрүүгийн хуулийн заалтыг ийнхүү чангатгасан байна. Гэхдээ Эрүүгийн хуулийн заалтууд нь Соёлын өвийг хамгаалах тухай хуульд орсон заалтуудтай зарим талаар давхацсан байдаг.

5. Оросын Холбооны Улс²⁴⁸

Оросын Холбооны Улсын соёлын өвийн газруудыг (түүх ба соёлын дурсгалуудыг) өвлөн хадгалах, ашиглах, түгээн дэлгэрүүлэх ба Засгийн газрын хамгаалалтай холбогдох бүх харилцааг Оросын Холбооны Үндсэн Хууль, Оросын Холбооны Иргэний Хуулийн холбогдох хэсгүүд, Оросын Холбооны №73-ФЗ дугаар Холбооны хууль ба, түүнтэй нийцүүлсэн Оросын Холбооны Ард түмний соёлын өвийн газруудын хамгааллын хуулиудаар зохицуулдаг.

²⁴⁸Cultural heritage. www.culturalpolicies.net/web/russia.php?aid=533

Соёлын өвийн газруудын (түүхэн ба соёлын дурсгалуудын) хадгалалт, ашиглалт ба засгийн газрын хамгаалалтын дүрэм журмын зөрчилд ногдуулах хариуцлагын тухай асуудлуудыг захиргааны ба эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр зохицуулдаг байна.

Оросын Холбооны Үндсэн хууль нь Оросын Холбооны болон Оросын Холбооны харьяат нарын хууль тогтоох байгууллагуудын чадамжийг соёлын үнэт зүйлстэй холбогдох хууль журмын тухай асуудал дээр хязгаарлаж өгсөн байдаг.

Оросын Холбооны Үндсэн Хуульд «Хүн бүр соёлын үнэт зүйлсийг ашиглах эрхтэй ба хүн бүр түүхэн болон соёлын өвийг хадгалах, түүхэн болон соёлын дурсгалуудыг хамгаалах, байгаль экологийг хадгалах, байгалийн баялагт анхаарал болгоомжтой хандах, (Оросын Холбооны Үндсэн Хууль, 58-р Хэсэг) үүрэг хариуцлагатай байхыг хуульчилсан бол, мөн хуулийн 14-р хэсэгт Соёлын хүрээн дэх өмчлөлийн эрхийн тухайд зааж өгсөн. Өмчийн эрх нь дурсгалт газар, цуглуулга, барилга байгууламж, байгууллага, институт, аж ахуйн нэгж ба түүхэн ба соёлын ач холбогдол бүхий бусад эд өлгийн зүйлстэй хамаатай ба, энэ эрхийг иргэн бүр эдэлнэ²⁴⁹ гэж заасан байна.

2002 оны 6-р сарын 25-ны өдрийн №73-ФЗ дугаар бүхий “Оросын Холбооны ард түмний Соёлын өвийн газруудын (Түүхэн ба соёлын дурсгалууд) тухай” хэмээх ОХУ-ын холбооны түвшний хууль нь соёлын өвийн хадгалалт, ашиглалт, түгээн дэлгэрүүлэлт ба засгийн газрын хамгаалалтын хүрээний харилцааг зохицуулж, хүн бүрийн соёлын үнэт зүйлсийг ашиглах үндсэн хуулиар олгогдсон эрхийг эдлүүлэх ба, хүн бүрт мөн үндсэн хуулиар ногдуулсан түүхэн болон соёлын өвийг хадгалах, хамгаалах үүрэг хариуцлагыг хүлээлгэх, энэчлэн ОХУ-ын бүрэлдэхүүн дэх бусад угсаатны нэгдмэл байдлыг хадгалах ба хөгжүүлэх, өөрсдийн түүх болон соёлын орчныг хамгаалах, сэргээх, хадгалах, улмаар соёл үүссэн ба хөгжсөн тухай мэдээллийн эх сурвалжийг хамгаалах ба хадгалах эрхийг нь эдлүүлэх зэргийг хэрэгжүүлэх зорилготой юм.

Энэ хууль нь түүхэн газруудыг хамгаалахтай холбоотой Засгийн газрын оролцооны зорилтуудыг тодорхойлж өгсөн байна. Үүнд тэдгээр нь: түүхэн өвийн газруудыг нээх, бүртгэх, тайлагнах, судлах ба тэдгээрийг сүйтгэгдэх ба эвдэрч гэмтэхээс урьдчилан сэргийлэх, соёлын өвийн газруудын хадгалалт ба ашиглалтад хяналт тавих зэрэг болно.

Соёлын өвийг бүртгэх ба тайлагнах асуудал нь энэ хуулийн нэгэн чухал хэсэг бөгөөд энэ нь засгийн газарт түүхэн болон соёлын мэргэжилтний үнэлгээг хийлгэх, тухайн соёлын өвийг хадгалахад хэрэгтэй арга хэмжээнүүдийн агуулгыг тодорхойлох заалтуудыг үндэслэж өгсөн байдаг. Энэ хуульд бас хөшөө дурсгалуудыг дахин бүтээх тухай асуудлууд тусгагдсан байдаг байна. Мөн энэ хуулиар соёлын өвийн газруудтай холбоотой өмчлөх эрхийн тухай хуулийн зохицуулалтын нарийн механизмыг үндэслэж өгсөн байдаг юм. Тус хуульд бас хуулийн заалтуудыг ханган биелүүлж чадаагүй ба соёлын өвийн газарт гэмтэл эвдрэл учруулсан тохиолдолд ногдуулах хариуцлагын төрөл зүйлүүдийг тодорхойлсон байдаг.

Оросын Холбооны бүрэлдэхүүн хэсгүүдийн хууль зүй нь соёлын өвийн газруудыг хадгалах, түгээн дэлгэрүүлэх ба засгийн газрын хамгаалалтын хэрэг зорилгод маш чухал байдаг. Холбооны түвшний энэхүү хуультай зэрэгцэн батлагдсан ОХУ-ын харьяаны улсуудын (бүс нутгуудын) хууль зүй нь ОХУ-ын Үндсэн хуультай зөрчилдөх ёсгүй гэдэг зарчимд тулгуурлана.

²⁴⁹Мөн тэнд.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Damage and Loss Assessment: The Cultural Heritage Sector, Guido Licciardi, TTL, Urban Specialist, The World Bank, 2011. <http://siteresources.worldbank.org/>
- Cultural Heritage Protection Act. <http://faolex.fao.org/>
- Strafgesetzbuch, StGB. www.gesetze-im-internet.de/englisch_stgb/
- Act to Prevent the Exodus of German Cultural Property. www.eui.eu/
- Act Implementing the Cultural Property Convention. www.kulturgutschutz-deutschland.de/
- Cultural property protection under international law. www.kulturgutschutz-deutschland.de/EN/
- www.pc.gov.au/
- Law of the People's Republic of China on the Protection of Cultural Relics. http://english.mep.gov.cn/Policies_Regulations/
- Cultural heritage. www.culturalpolicies.net/

**ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙГ “ГАЛЫН ОСЛЫН ЗААВАЛ ДААТГАЛ”-Д ХАМРУУЛАХ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ ЖИШИГ, ГАДААДЫН ТУРШЛАГА**

*И.Жаргалзаяабямба, Г.Чулуун,
Ө.Мөнхтунгалаг, Г.Алтан-Оч (Ph.D)*

Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийн хүрээнд Даатгалын тухай хуульд “иргэн, аж ахуйн нэгжийг гал түймрийн эрсдэлээс хамгаалах зорилгоор [албан журмын] даатгалд хамруулах” зохицуулалт нэмэх асуудал хөндөгдсөнтэй холбогдуулж, УИХ –ын Хууль зүйн байнгын хорооноос,

- а) Галын даатгалын талаарх гадаадын улс орны эрх зүйн зохицуулалт, харьцуулалт;
- б) Төсвийн байгууллагуудыг галын албан журмын даатгалд хамруулах (Байнгын хорооны албан бичигт дурдсанаар авав) асуудал; сэдвээр судалгааны захиалга ирүүлсэн.

“Судалгаа гаргуулах тухай” УИХ –ын Байнгын хорооны 2014 оны 10/8452 тоот албан бичигт хавсаргасан материалтай танилцлаа. Засгийн газрын өргөн мэдүүлсэн нэр бүхий хуулийн төслүүд, холбогдох танилцуулга, мэдээлэлд процедурын шинжтэй зарим зөрчилт байдал ажиглагдсан. Засгийн газрын 2014 оны 1/57 тоот албан бичгээр УИХ –д ирүүлсэн танилцуулга дотор Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдож “Даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орохгүй” гэдгийг зориуд дурджээ.

* * *

**Үл хөдлөх хөрөнгийг галын албан журмын даатгалд хамруулах арга боломж,
гадаадын туршлага****а) Галын даатгалын талаарх ХБНГУ, Австри улсуудын эрх зүйн зохицуулалт**

Галын даатгал нь ерөнхийдөө галаас үүдэлтэй хохирлыг даатгалын нөхцөлийн дагуу нөхөн төлөхийн тулд оршдог. Ингэхдээ хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, цаашилбал галаас үүдэлтэй үйлдвэрлэл зогсолтын даатгалын үед, тасарсан орлогыг даатгадаг. Түүнээс гадна даатгалын хамгаалалт нь зайчлах болон нүүлгэн шилжүүлэх зэрэг нилээд олон төрлийн зардлын нөхөн олговрыг багтаасан байдаг.

Галын даатгал нь дэлхий дээрх хамгийн эртний даатгал бөгөөд Германы Хамбург хотын зөвлөлөөс 1676 онд анх “Хамбургийн галын касс” нэртэйгээр байгуулж байжээ. Үүний үндэс суурийг шар айргийн үйлдвэрүүдийн 1591 онд байгуулсан “Хамбургийн галын гэрээ” тавьсан гэж үздэг.

Өмнө нь галын даатгал нь албан журмын даатгал байсан. Одоо Германд албан журмын бус болсон. Гэвч Кассел хотод одоо болтол галын касс ажилладаг бөгөөд 90-ээд оны сүүлчээр орон нутгийн хадгаламжийн банкинд даатгал хэлбэрээр нэгтгэсэн байдаг. Энэ хооронд галын даатгал нь даатгалын салбарын голлох байр сууриа амь болон автомашины даатгалд алдаад байна. Ялангуяа, монополь даатгалын тогтолцоо төгсгөл болсноор, мөн холбооны зарим улсуудад оршин байгаа албан журмын даатгалын улмаас галын даатгалын ач холбогдол буурсан.

Шинэ мянганы эхэн хүртэл зандалчилал (терроризм)-аас үүдэлтэй хохирлыг галын даатгалд хамруулдаг байсан боловч 2011 оны 9 дүгээр сарын 11 -ний өдрийн үйл явдлаас хойш бүх даатгалын байгууллага энэхүү эрсдэлийг даатгалын гэрээнээсээ түр зуур хасаад байсан юм. Энэ хооронд зандалчилалын хохирлыг тусгайлан түүнд зориулсан,

төрийн оролцоо бүхий “Экстремус-Даатгал” олон нийтийн нийгэмлэг (хувьцаат компани)-т даатгуулж болно. Гэхдээ энэ нь зөвхөн аж ахуйн нэгжүүдэд хамаарах ба хувь хүн хангалттай нөхцөлөөр даатгуулах боломж хараахан бүрдээгүй.

ХБНГУ, Австри улсуудад даатгалын шимтгэлийн тодорхой хувийг галаас хамгаалах татварын байдлаар суутган авдаг. Энэхүү татварын орлогыг зөвхөн гал түймэртэй тэмцэх байгууллагыг санхүүжүүлэхэд зарцуулдаг байна.

Герман улсад галаас хамгаалах татвар нь муж (улс)-ын татварт хамаардаг бөгөөд уг татварыг галаас хамгаалах татварын тухай хуулийг үндэслэн доорх даатгалууд хийгдсэн нөхцөлд шимтгэлд нь ногдуулдаг. Үүнд:

1. Галын даатгал (галын улмаас үйлдвэрлэл зогсолтын даатгалыг оруулан)
2. Байшин барилгын болон эд хогшлын даатгал

ХБНГУ, Австри улсуудад даатгалын шимтгэлийн тодорхой хувийг галаас хамгаалах татварын байдлаар суутган авдаг. Энэхүү татварын орлогыг зөвхөн гал түймэртэй тэмцэх байгууллагыг санхүүжүүлэхэд зарцуулдаг байна.

Албан журмын татварыг зөвхөн даатгуулсан эд зүйлс нь даатгалын хураамж төлөх үед галаас хамгаалах татварын тухай хуулийн үйлчлэх хүрээнд оршин байх тохиолдолд л төлөх үүрэгтэй. Даатгуулсан эд зүйлс нь улсын дотоодод (нутаг дэвсгэр дээр) байх ёстой. Татвар төлөгч нь даатгагч байдаг. Тэрээр татварын хэмжээг өөрөө тооцоолж, татварын албанд мэдүүлэх үүрэгтэй.

Галаас хамгаалах татварын орлогыг галаас хамгаалах тухай хуулинд тодорхойлон заасан түлхүүрийн дагуу холбооны бүх улсад хуваарилдаг. Зарцуулалт нь тодорхой зорилготой бөгөөд гал түймрийн аюулаас хамгаалах үйлсэд ашигладаг. 2010.07.01-ний өдрөөс хойш доорх татварын хувь хэмжээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

- Галын ба Галын улмаас үйлдвэрлэл зогсолтын даатгал: нийт татварын хувь хэмжээ 22%
 - Үүнээс даатгалын татвар $60\% = 13.2\%$
 - Үүнээс галаас хамгаалах татвар $40\% = 8.8\%$
- Орон сууцны барилгын даатгал: нийт татварын хувь хэмжээ 19%
 - Үүнээс даатгалын татвар $86\% = 16.34\%$
 - Үүнээс галаас хамгаалах татвар $14\% = 2.66\%$
- Эд хогшлын даатгал: нийт татварын хувь хэмжээ 19%
 - Үүнээс даатгалын татвар $85\% = 16.15\%$
 - Үүнээс галаас хамгаалах татвар $15\% = 2.85\%$

1994.07.01 -ний өдрөөс хойш галаас хамгаалах тухай хуулинд энэхүү өөрчлөлт орсон 2010 он хүртэл галаас хамгаалах татварын хувь хэмжээ нь даатгалын шимтгэлийн 8 хувьтай тэнцүү байсан. Энэхүү хувь хэмжээ нь галын даатгалын хувьд даатгалын шимтгэл бүхлээрээ, харин орон сууцны барилгын болон эд хогшлын даатгалын хувьд даатгалын шимтгэлийн 25 хувь ба 20 хувьтай (ингэснээр бодит татварын хэмжээ нь хураамжийн нийт дүнгийн 2хувь ба 1.6 хувьтай) тус тус тэнцүү байв.

Австри улсад галаас хамгаалах татвар нь галын даатгалын хураамжийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг байдаг. Түүнийг зөвхөн гал түймрийн аюулаас хамгаалах үйлсийн зорилгоор зарцуулдаг. Уг татвар нь хэдийгээр холбооны татвар боловч мужууд (улсууд)-ад шууд дамжуулан өгдөг.

Холбооны улсууд нь уг татвараар, нэг талаар галаас хамгаалах сургууль буюу улсын мэргэжлийн холбоод (төрийн бус байгууллагууд) зэрэг улсын байгууллагуудыг, нөгөөтэйгүүр, орон нутгийн гал түймрээс хамгаалах албанд зайлшгүй байх багаж,

тоног төхөөрөмжийн журмын шаардлагыг хангах зорилгоор олгодог татаасын ихэнхийг бүрдүүлэхэд зарцуулдаг. Мөн татварын орлогын зарим хэсгийг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх албанд зарцуулдаг

Гэвч сүүлийн үед даатгалын салбар дахь өрсөлдөөнт тэмцэл ширүүссэний улмаас татварын хураамж, түүнтэй холбоотойгоор галаас хамгаалах татварын орлогын хэмжээ эрс унаад байна. Ингэснээр галаас хамгаалах албанд олгодог татаас буурах, төлбөр барагдуулах хугацаа уртсах зэргээр бэрхшээл тулгараад байгаа билээ.

Германд, даатгалын байгууллагуудын үйл ажиллагаанд төрийн зүгээс хүчтэй хяналт тавьдаг. Даатгалын улсын хяналтын тухай бие даасан хуультай. [Холбооны Улсын] даатгалын хяналтын төв байгууллагын үндсэн үүрэг нь даатгагчийн буруугаас болж даатгуулагчийн эрх ашиг хохирохоос сэргийлэх явдал юм. Германд жишээ нь, томоохон үйлдвэрийн газрын үл хөдлөх хөрөнгийг даатгахад, талуудын хооронд байгуулах даатгалын гэрээ Улсын хяналтын байгууллагаар хянагдаж байж сая хүчин төгөлдөр болно.

б) Азербайджан улсад ...

- Үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгалтай улс орнууд цөөнгүй. Тэдгээрийн нэг нь Азербайджан улс юм. Үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгалтай холбоотой асуудлыг тэнд Үл хөдлөх хөрөнгийн заавал даатгалын тухай хуулиар зохицуулдаг.
- Үл хөдлөх хөрөнгийн заавал даатгалын үр нөлөөгөөр Азербайджаны даатгалын сан үлэмж арвижсан. Зөвхөн энэ он (2014) -ы эхний 8 сарын хуримтлалын дүн \$361 сая долларт хүрсэн нь 2013 мөн үеийнхээс 6.6 хувиар их байв. Азербайджаны Заавал Даатгалын Хорооноос гаргасан Үл хөдлөх хөрөнгийн заавал даатгалын хуулийн хэрэгжилтийн талаарх 2014 оны 8 сарын дүн мэдээнд, үл хөдлөх хөрөнгийн даатгалын шинээр байгуулсан гэрээний 80 хувь нь иргэдийн байр сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө, 0,3 хувь нь захиргааны зориулалттай байшин барилга, үлдсэн хувийг бусад төрлийн үл хөдлөх хөрөнгө эзэлдэгийг дурджээ.
- Азербайджанд, үл хөдлөх хөрөнгийн даатгалын хураамж бүх төрлийн эрдслийн хүрээнд дунджаар үнийн дүнгийн 0.1 хувь (үнийн дүнгийн мянганы нэг) орчимд хэлбэлздэг. Үл хөдлөх хөрөнгийн даатгалын хуулиндаа, тэнд, галын түймрийн аюул эрсдлийг учирч болох бусад эрдлээс салгаж тусад нь ангид авч үздэггүй, байж болох эрсдлүүдийн нэг үндсэн хэлбэр гэж үздэгч, Азербайджан нь хэрэг дээрээ галын заавал даатгалтай улс юм.
- Азербайджан улсын галын аюулгүй байдлын тухай хуулийн III бүлгийн 23 дугаар зүйлд "... Азербайджан улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл эрхэлж байгаа хуулийн этгээд бүхэн (гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хамаарна) өмчлөж, ашиглаж, эзэмшиж байгаа үл хөдлөх хөрөнгөө галын заавал даатгалд хамруулна" гэж заасан байна. Энд, галын заавал даатгалын асуудлыг Галын аюулгүй байдлын тухай хуулиар шийдсэн ба шийдэж болдог нь харагдаж байна.
- Азербайджан улсын Үл хөдлөх хөрөнгийн заавал даатгалын хуульд "хувь хүн хуулийн этгээдийн орон сууц, байр байшин, хүн амьдардаггүй байгууламж, төрийн өмчийн өмчийн байшин байгууламж заавал даатгалд хамрагдсан байна" гэж заажээ. Харин, заавал даатгалд хамрагдах ёстой төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг гүйцэтгэх засаглалын бүтцийн эрх бүхий байгууллагаас тогтооно. Азербайджаны хуульд үл хөдлөх хөрөнгийн заавал даатгалын үйлчлэх "заавал даатгалын тохиолдлууд" –ыг нэрлэн заасны нэгдүгээрт, "гал түймэр + аянга цахилгаан" –ыг дурдсан ба жагсаалтад нийт 9 багц тохиолдлыг оруулсан байна.

Бүс нутгийн ангилал, нэр	Заавал даатгалт хамрагдах үл хөдлөх хөрөнгийн доод үнэ (AZN)	Заавал даатгалын хураамж (AZN)	Тодруулга
▪ Баку хот	25.000	50	Азербайджан нь 9 сая хүнтэй, 86600 км² нутагтай. 1 хүнд ногдох ДНБ –ий хэмжээ (2011) нь 10300 ам. долл. Азербайджаны 1 манат ойролцоогоор 1 евро –ийн ханштай. (2014.11.04)
▪ Гянджа, Сумгаит, Нахчыван хотууд	20.000	40	
▪ Бусад суурин газар	15.000	30	

- Үл хөдлөх хөрөнгийн худалдах ба худалдан авах гэрээ байгуулах нэг нөхцөл нь “заавал даатгалын полистой байх” –ыг шаардана. Үүнийг, үл хөдлөх хөрөнгийн заавал даатгалын системийн хяналтын аргуудын нэг гэж үздэг. Үл хөдлөх хөрөнгийн даатгалын хэрэгжилтийн хангах үүднээс, Азербайджанд, гамшиг ослоос үл хөдлөх хөрөнгийн даатгалд хамрагдалгүй байж байгаад эрсдэлд орсон хүмүүст “улсаас туслахгүй” байх асуудал ордог. Энэ нь “эзэн хүн өөрийхөө өмчийг хамгаалахын төлөө санаа зовохгүй байхад төр засаг ч таны өмчийн төлөө санаа тавихгүй байх үндэс бүхий” гэсэн шахалтын агуулгатай байр суурь юм. Дурдсан арга хандлагуудаас харвал Азербайджаны үл хөдлөх хөрөнгийн албан журмын даатгалын механизм уян хатан, хүлээж азнасан, хатуу албадлагын механизм яаран ашигладаггүй нь харагдаж байна.
- Азербайджаны [үл хөдлөх хөрөнгийн] Заавал Даатгалын Хороо нь Иргэний хуульд заасан хуулийн этгээд үүдийн нэгдэл хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг, үндсэн үүрэг нь үл хөдлөх хөрөнгийн хохиролд өртсөн даатгалтай иргэн байгууллага гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах үүрэгтэй юм. Заавал даатгалын хороог 2011.12.16 –наас дагаж мөрдсөн Заавал даатгалын төрөл зүйлийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд байгуулсан. Азербайджанд Заавал даатгалын хорооны гишүүн нэр бүхий 27 компани бий. Азербайджаны даатгалын системийн улсын хяналтын чиг үүргийн Сангийн яамны бүтцийн байгууллага хэрэгжүүлдэг.

с) Украин улсад ...

Даатгалын, түүн дотроо заавал даатгалын харилцааны эрх зүйн зохицуулалт нь дан гагц даатгалын тухай хуулийн хүрээгээр хязгаарлагддаггүй. Даатгалын болон өмчийн харилцааны асуудал олон хуулийн уулзвар дээр оршино. Үүнийг тодруулах жишээ болгож, Төрийн ба нийтийн аж ахуйн өмчийг түрээсээр эзэмшүүлэх тухай Украин Улсын хуулийн агуулгыг цухасхан авч үзье.

- Төрийн өмч, үл хөдлөх хөрөнгийг байгалийн гамшиг гал усны аюул эрсдэлээс хамгаалахын тулд тэдгээрийг заавал даатгалд хамруулах үзэл санаа Украинд харьцангуй саяханаас буюу 2008 оны сүүлээр яригдаж, удалгүй хэрэгжиж эхэлсэн байдаг.
- Төрийн ба нийтийн аж ахуйн өмчийг түрээсээр эзэмшүүлэх тухай Украин улсын хууль (2014.8.14 –ний өдрийн өөрчлөлтийг тусгасан) –ийн 10 дугаар зүйлд, төрийн өөрийн ба төрийн нийтийн өмчийг хувь хүн, хуулийн этгээдэд түрээслэх түрээсийн гэрээ байгуулахад дагах “гэрээний үндсэн 11 нөхцөл” –ийг нэрлэн зааж өгчээ. Тэрхүү жагсаалтад,
 - улсын өмчийг түрээслэж авсан тал уг өмчийг [заавал] даатгуулах;
 - улсын өмчийг түрээслэсэн үед тухайн өмчийг гал түймрийн аюулаас

хамгаалах чиглэлд түрээсийн гэрээний талуудын хүлээх үүрэг тодорхой туссан байх; гэж заажээ.

Мөн хуулийн 24 дүгээр зүйлд түрээслүүлсэн төрийн өмчийн “зуурдаар устгах” (случайная гибель) эрсдлийг түрээслүүлэгч тал, харин, түрээсийн өмчийг цагт нь буцааж хүлээлгэн өгөөгүй бол тэр хугацаанд учирсан “устгах эрсдэл” –ийг түрээслэгч тал хариуцана; гэжээ.

- Украин улсын Даатгалын хуульд “заавал даатгал” –ын төрлийг заасан байдаг. Иргэний хариуцлагын Даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлд дурдсан жагсаалтад, жишээ нь, аюулын зэрэг өндөртэй экологийн сүйрэл дагуулах боломж бүхий үйлдвэрлэл аж ахуй эрхлэгч субъектүүдийг “субъектийн иргэний хариуцлага” (гражданская ответственность субъекта) –ын даатгалд заавал хамруулна гэжээ. Энд, томоохон үйлдвэрийн газруудад гал түймэр гарах, осол аваар болоход дагалдах уршигийн тухай, тэдгээрийн нийгмийн өмнө хүлээх хариуцлагын асуудал хөндөгдөж байна.
- Нефть ба байгалийн хийн тухай Украин улсын хуульд, үйлдвэрлэлийн явцад гарч болох өмчийн эрсдлийн заавал даатгалын тухай заалт орсон. Мөн, Украины Бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай хуульд өмчийн эрсдлийн заавал даатгалыг хуульчилсан. Үйлдвэрлэлийн явцдаа хорт хаягдал гаргагч уурхай үйлдвэрийн газрууд “экспортлогчийн хариуцлагын заавал даатгал” –д хамрагддаг. Үл хөдлөх өмч хөрөнгийг нь гэхээсээ илүү уг өмчийг ашиглагч эзэмшигч хариуцагч субъектэд нь “нийгмийн хариуцлагын чанартай” тухайлсан нэр нэршилтэй заавал даатгалд хамрагдах үүрэг хүлээлгэхийг даатгалын нэг үр нөлөөтэй хэлбэрт тооцдог.
- Украины сансар судлалын объектууд, түүний газар дээрх дэд бүтцийн байгууламжууд “сансрын объектын заавал даатгал” –д хамрагдана. Энэ төрлийн заавал даатгалд хамрагдах улсын объектийн жагсаалтыг Украины үндэсний сансрын агентлагийн санал болгосоны дагуу засгийн газраас баталдаг. Ер нь, Украинд, заавал даатгалын хамрах хүрээ нилээн өргөн. Галт эвсэгтэй хүн, аялал жуулчлалын бизнес эрхлэгч, .. нохойтой айл хүртэл гуравдагч этгээдэд учруулж болзошгүй эрсдэлийнхээ төлөө “үүрэгжүүлсэн тухайн төрлийн заавал даатгал” –д хамрагддаг байна. Тэнд, өмчийг даатгах, өмчийн эзэн субъектийн хариуцлагыг нь даатгах арга хэлбэрүүдийн аль алиныг нь өргөн, олон тохиолдолд зэрэгцүүлэн хэрэглэнэ.
- Украинд, өндөр хүчдэлийн шугам, цахилгаан түгээх дэд бүтцийн байгууламжууд өмчийнхөө хувьд “заавал даатгал” -тай байдаг. Ипотекийн зүйлс ч үүнд мөн хамаарна. Концессийн гэрээгээр шилжүүлсэн хөрөнгийг (гал усны болон бусад эрсдлээс) заавал даатгах хуулийн зохицуулалттай.

d) ОХУ –д ...

- ОХУ –ын Даатгалын [үйлчилгээний] зохион байгуулалтын тухай болон Иргэний кодекс (§927) -ийн аль алинд нь даатгуулах хэлбэр “сайн дурын, заавал” гэсэн 2 төрөлтэй; гэж заасан. Сайн дурын даатгал талуудын гэрээгээр баталгаажин хэрэгждэг. Сайн дурын гэрээний нөхцөлүүд нь хууль дүрэмд харшлах ёсгүй. Сайн дурын даатгалыг нийтлэг биш нөхцөлөөр ч байгуулж бас болно. Сайн дурын даатгалын олон асуудал санхүүгийн эрх зүйн хэм хэмжээгээр дам зохицуулагддаг.

Хуулийн дагуу хийгдэх даатгалыг тэнд “албан журмын даатгал” гэнэ. Албан журмын даатгалыг оросууд яриан хэлэндээ хялбаршуулан “обязаловка” буюу “заавал даатгал” гэх нь элбэг. “Заавал даатгал” хэллэгийг манайд ч хэрэглэх тохиолдлууд гарсаар байна.

ОХУ –ын Даатгалын хяналтын хяналтын газар нь Сангийн яамандаа харъяатай. Даатгалын салбарт гардаг гэмт хэргийн ял шийтгэлийг ОХУ –ын Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлгийн багц заалтаар тодорхойлогдсон.

ОХУ –д заавал даатгал нь дотроо 2 үндсэн төрөлтэй. Үүнд:

- даатгуулагчид учирсан хохирлыг улсын төсвөөс барагдуулдаг “улсын заавал даатгал”,
 - даатгуулагчдын өөрсдийнх нь дундаасаа бүрдүүлсэн санг ашиглан тэдэнд учирсан хохирлыг барагдуулдаг байх заавал даатгал;
- Даатгалын үйлчилгээний зохион байгуулалтын тухай ОХУ –ын хууль (1992) –ийн 4 дүгээр хэсгийн 3 дахь зүйлд Заавал даатгалын тодорхой хэлбэр төрлийг нэрлэж заасан. ОХУ –ын улсын, улсын заавал даатгалын төрлүүд дэх “иргэн субъектийн өмчийн сонирхолыг хамгаалсан хэлбэрүүд” олон хуулийн агуулгын хүрээгээр тодорхойлогдоно. Жишээ нь,
- Хувь хүний банкны хадгаламжийн [заавал] даатгалын тухай хууль;
 - Байрны захиалгад хамрагдах замаар олон айлын орон сууц бариулж байгаа хувь нийлүүлэгч нарт учирч болох [үл хөдлөх хөрөнгийн] эрсдлийг хамгаалах даатгал; (Барилгын ажил гүйцэтгэгч компанийн хамрагдах энэхүү улсын заавал даатгал, тусдаа бүр бие даасан хуультай байдаг)²⁵⁰гэх мэт.
- ОХУ –д, иргэдийн үл хөдлөх хөрөнгийн даатгал өмчлөгчийн өөрийнх нь шийдэх сайн дурын асуудал байдаг. Орост энэ тал дээр одоо болтол заавал даатгалын механизм нэвтрээгүй, нэвтрүүлээгүй нь бодит ба хийсвэр (абстракт) олон шалтгаантай юм. Үүнийг жишээ нь,
- даатгалын байгууллагуудад итгэх иргэдийн итгэл сул;
 - “жолоочийн” хариуцлагын албан журмын даатгалын хэрэгжилтийн өнөөгийн байдал туршлага “заавал даатгал” –ын механизмын нэр хүндийг нийт хэрэглэгчийн дунд өсгөж төдийлэн чадаагүй;
 - нийгэм нь “даатгалын залилан” ихтэй;
 - даатгалын тохиолдол үүсэхэд зохих нөхвөрийг даатгалын компаниас тоо ёсоор төвөггүй гаргуулж “олж авах” магадлал өндөр биш байдагтай холбож тайлбарлах нь бий.
- ОХУ –д иргэдийн болон төрийн байгууллагын үл хөдлөх хөрөнгийн заавал даатгалын асуудалд хүлээцтэй болгоомжтой ханддаг. Үүнийг нотлох жишээнээс дурдвал,
- a. ОХУ –д төрийн нийтийн өмчийг улсын заавал даатгалд хамруулж болдог ч, Москва хотын засаг захиргаанаас нийтийн өмчийн орон сууцны бус зориулалттай үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламжийг улсын заавал даатгалд хамруулах явдлыг 2016 он дуустал түр зогсоох шийдвэр гаргасан байна. Хотын мэр ийм шийдвэрт гарын үсэг зурах болсон үндэслэлээ “төсвийн мөнгөний зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой” гэж тайлбарлажээ.
 - b. ОХУ –ын Онцгой байдлын яам гал түймрийн эсрэг үр дүнтэй тэмцэх бодлогын шинэчлэлийн хүрээнд галын хамтын заавал даатгалын механизм бий болгох эрх зүйн үндэсийг тавих чиглэлд ажиллаж байна. Тус яамнаас Галын хамтын заавал даатгалын тухай хуулийн төсөл боловсруулах (10 сая рублийн) тендерийг 2011.4.27 –ноос 1.5 жилийн хугацаатай зарлаж, асуудлын эрх зүйн зохицуулалтын шинэ арга

²⁵⁰Федеральный закон от 30.12.2004 N 214-ФЗ «Об участии в долевом строительстве многоквартирных домов и иных объектов недвижимости».

хандлагыг эрэлхийлж байв. Онцгой байдлын яамны энэ санаачлага, хуулийн төслийг засгийн газрын холбогдох бусад яам газар дэмжихгүй байгаа бөгөөд Эдийн засгийн хөгжлийн яам нь эсрэг саналтай явж ирсэн нь анхаарал татдаг.

- с. Оросын Холбооны Улсад, эрх зүйн холбогдох зохицуулалт нь хийгдэж гэмээнэ, галын заавал даатгалд хамрагдах боломжтой нийт 63 сая үл хөдлөх хөрөнгө (объект) байгаагийн 31 сая нь иргэдийн орон сууцны байшин байна. Эндээс, улсын заавал даатгалын санд жилд төвлөрөх үүсвэрийг тооцох боломжтой бөгөөд үүнийг Онцгой байдлын яамнаас гаргасан байна. Орост, улсын хэмжээнд гал түймрийн улмаас учирдаг нийт хохирлын жилийн дундаж хэмжээ 7 тэрбум ам. долл. –т хүрдэг.

е) Энэтхэг улсад ...

Галын даатгал нь Энэтхэгт ерөнхий даатгалын үндсэн төрөл хэлбэрийн нэг байдаг бөгөөд холбогдох хууль тогтоомждоо галын ослын даатгалд заавал хамрагдах иргэн байгууллага хуулийн этгээдийн хүрээг тодорхойлсон. Энд зөвхөн үл хөдлөх хөрөнгийн даатгалын төдийгүй, өмчийн эзэн, эзэмшигчийн хариуцлагын даатгалын асуудлыг давхар хөндөж зохицуулжээ.



Тэдгээрт,

- Байшин, барилга, агуулах эзэмшигчид;
- Дэлгүүрийн эзэд, компани;
- Боловсролын ба эрдэм шинжилгээний байгууллагууд;
- Зочид буудал, дотуур байрны, эмнэлэг, эсхүл үйлчилгээ эрхлэгчид;
- Томоохон үйлдвэрийн газрууд;
- Түрээслэгч, түрээслүүлэгч, банк, санхүүгийн байгууллагууд;
- Барьцаалагч ба барьцаагаар эзэлдүүлэгчид;
- Итгэмжлэгч этгээд, буяны байгууллагууд;
- Тээвэрлэгчид (C & F ангилал);

Энэтхэгийн Галын даатгалын зөвлөх хороо нь албан ёсны ёсны эрх бүхий байгууллага бөгөөд Галын даатгал, үнэлгээ, үнэ тарифын асуудлыг хариуцдаг, 2001 оны III сард байгуулагджээ.

f) Бусад улс оронд ...

Галын заавал даатгалын асуудлыг улс орнууд нэг хэв загвараар шийддэггүй. Гадаадын туршлага, олон улсын туршлага гэх ухагдахуун энд их төлөв тухайлсан нэг-хоёр, эсхүл нэг хэсэгхэн орны арга механизмыг ярьсан нийтлэг биш өгүүлэмжтэй байдгийг тэмдэглэх нь зөв болов уу. Олон улсын практикт улсын ба хувийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг байгалийн гамшигт эрсдэх явдлыг заавал даатгалын арга механизмаар шийдэх нь бий ч түгээмэл биш юм.

- Францад, жишээлбэл, “галын заавал даатгал” гэсэн ойлголт үгүй. Гэхдээ, тэндэхийн иргэн банкнаас зээл авч гэмээнэ, эхлээд 2 үйлдлийн заавал хийсэн байх шаардлагатай болдог. Нэгд, зээлдэгч этгээд “амьдралын даатгал” –тай, хоёрт, “үл хөдлөх хөрөнгийн даатгал” –тай байх ёстой. Үл хөдлөх хөрөнгөө даатгуулахын тулд тэр хүн галын байцаагчийг гэртээ буюу объект дээрээ урьж галын эрсдлийн үнэлгээ хийлгэж, тэр үнэлгээ дүгнэлт нь түүгээрээ даатгалын компанид очно, улмаар даатгагдана. “Заавал” гэсэн тодотголгүй хирнээ заавал хийгдэх болдог францын энэ механизм үл хөдлөх хөрөнгийн түрээсийн асуудалд ч хамаарна. Энэ даатгалын системийн мөн чанар нь «хариуцлагын даатгал + үл хөдлөх хөрөнгийн даатгал + уг үл хөдлөх хөрөнгийн дотор агуулагдсан эд зүйлс» –ийг бүхэлд нь багтаасан шинжтэй байна.
- АНУ –д үл хөдлөх хөрөнгийн аливаа даатгал [заавал биш] сайн дурынх байна. Америкийн даатгалын индустрийн хөгжлийг дэлхийд үлгэрлэх жишиг бүхий гэж үздэг. Тэнд, хэн ч юуг ч ямар ч нөхцлөөр даатгуулах боломжтой, улсын даатгал гэсэн ойлголт үгүй. Даатгалын хуримтлалын нийт сан нь 2000 тэрбум долл. –р хэмжигдэнэ, төлөх чадамж өндөртэй. Жишээлсэн тохиолдол болгож өгүүлэхэд, 2001.9.11 –ний өдрийн террорист халдлагад өртсөн “хоёр өндөрийн” хохирчдын нөхөн төлбөрийг барагдуулсан хөрөнгийн дүн 29 тэрбум долл. болж байв.
Америкийн үйлдвэрлэл үйлчилгээний том фирмүүдийн хөрөнгийн даатгалаас жилд дунджаар 8 тэрбум долл. –ын хуримтлал үүсгэдэг. Даатгалын зарим том компани нь дэлхийн 130 гаран оронд өөрийн салбартай байх жишээний. Америкийн даатгалын компаниудад монополийн эсрэг хууль тогтоомж үйлчилдэггүй.
- Английн заавал даатгалын нэр төрлийн жагсаалтад их төлөв “хариуцлагын заавал даатгал” –ууд зонхилох бөгөөд даатгалын компанийн “даатгалын брокерийн хариуцлагыг албан журмаар заавал даатгасан байх” зохицуулалттай. Английн даатгалын компаниудын зарим нь “шөнийн клуб, рестораны” гэх мэт өмчийн тодорхой чиглэлийг сонгож “дагнах мэргэших байдалтайгаар” үйл ажиллагаагаа явуулдаг.
- Австралид галын ослын даатгал, тээврийн хэрэгслийн даатгал, орон гэрийн даатгал цугтаа нэг багц болж явдаг. Австралид галын алба нь хуулийн дагуу жил бүр улсын төсөвт хувь нэмрээ оруулах үүрэгтэй. Австралийн галын ослын даатгал нь зөвхөн эд хөрөнгийг даатгалд хамруулахаар хязгаарлагдахгүй, сэргээн босголт хийх засварлах үйл ажиллагааны зардлыг нөхөх чиг зорилготой.

* * *

Даатгалын зах зээлийн хөгжил өөрийн үнэлгээ хэмжүүртэй. Даатгалын зах зээл сайн хөгжөөгүй улс нийгэмд даатгалын улсын хяналтын механизм зүгшрээгүй байх нь түгээмэл. Даатгалын улсын хяналтын механизм зохих ёсоор төлөвшиж бүрдээгүй үед төрийн өөрийн ба төрийн нийтийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн (элдэв эрсдлийн, галын гэх мэт) заавал даатгалыг хуульчлах нь болгоомжлол тооцоо, бодит үндэслэл шаардсан бодлогын ярвигтай асуудлын нэг юм.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Галаас хамгаалах татвар. <http://de.wikipedia.org/wiki/Feuerschutzsteuer>
- Галын даатгал. <http://de.wikipedia.org/wiki/Feuerversicherung>
- Даатгалын тухай хууль 1973 (СТН). www.insuranceinstituteofindia.com/. 2011.11.23-нд татаж авсан.
- www.iloveindia.com/real-estate/home-insurance/fire-insurance.html
- www.business.gov.in
- www.axa.com/en/group/axaworld/asia-pacific/australia/#act1
- http://en.wikipedia.org/wiki/Insurance_in_Australia
- www.uac.org.au
- <http://nslegislature.ca/legc/statutes/firesafe.htm>
- <http://assembly.nl.ca/Legislation/sr/statutes/f10.htm>
- www.tbs-sct.gc.ca/pol/doc-eng.aspx?id=17316§ion=text
- www.global.law
- www.vaud.ch
- www.insurancouncil.com.au

ТӨРИЙН АЛБАНААС ТЭТГЭВЭРТ ГАРАХ НАСЫГ ТОГТООДОГ ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ

Г.Алтан-Оч (Ph.D),
И.Жаргалзаяабямба, Б.Ариунжаргал

Энэхүү лавлагаа мэдээлэлд гадаад орнуудын Төрийн албаны талаарх судалгааны хүрээнд өндөр насны тэтгэврийг хэдэн насаар тогтоодог, хүн амын дундаж наслалтын талаарх дэлхийн статистик мэдээлэл болон Монгол Улсын хүн амын дундаж наслалтыг 2013 оны байдлаар өмнөх 10 жилтэй харьцуулсан судалгааг хамруулсан болно.

I. ТЭТГЭВРИЙН НАС

Дэлхийн улс орнуудад өндөр насны тэтгэврийн санг Засгийн газрын үр ашгаас хамааруулан тооцож санхүүжүүлдэг байна.

Өндөр насны тэтгэвэрт гарах насыг дэлхийн улс орон бүрт хэрхэн тогтоосныг судалгаа хийгдсэн оноор нь доорх хүснэгтээр үзүүлэв:²⁵¹

Дэлхийн орнуудын тэтгэврийн нас (2007-2014 он)

№	Улс	Эрэгтэй	Эмэгтэй	Судалгаа хийгдсэн он
1	Австрали	65-67	64.5-67	
2	Австри	65	60	2011
3	Азербайжан	62	59.5	2012
4	Албани	65	60	2012
5	АНУ	62-67	62-67	2013
6	Армени	63	63	2011
7	Беларус	60	55	2007
8	Бельги	65	65	2009
9	Болгар	63	60	2011
10	Босни-Герцеговина	65	65	2011
11	Вьетнам	60	55	2011
12	Герман	65	65	2008
13	Грек	67	60-67	2012
14	Гүрж	65	60	2011
15	Дани	65-67	65-67	2008
16	Израил	67	62	2011
17	Ирланд	65-66	65-66	2008
18	Исланд	67	67	2007
19	Испани	65	65	2011
20	Итали	66	64	2014
21	Казахстан	63	58	2011
22	Кипр	65	65	2011
23	Киргизстан	63	58	2011

²⁵¹ "Тэтгэврийн нас" - Retirement Age. http://en.wikipedia.org/wiki/Retirement_age

№	Улс	Эрэгтэй	Эмэгтэй	Судалгаа хийгдсэн он
24	Колумб	62	57	2014
25	Косово	65	65	2011
26	Латви	62	62	2011
27	Литва	62.5	60	2011
28	Лихтенштейн	64	64	2007
29	Люксембург	65	65	2011
30	Македон	64	62	2011
31	Мальта	61	60	2008
32	Молдав	65	60	2011
33	Монтенегро	65	60	2013
34	Непал	58	58	2007
35	Нидерланд	65-67	65-67	2009
36	Норвеги	67	67	2011
37	Нэгдсэн Вант Улс	65	60	2011
38	ОХУ	60	55	2011
39	Пакистан	60	60	2007
40	Польш	65-67	60-67	2013
41	Португал	66	66	2014
42	Румын	64	59	2013
43	Саудын Араб	62	62	2014
44	Серби	65	60	2011
45	Сингапур	65	65	2012
46	Словак	62	62	2012
47	Словени	63	61	2008
48	Тажикстан	63	58	2011
49	Турк	60	58	2014
50	Туркменистан	62	57	2011
51	Узбекстан	60	55	2011
52	Украйн	60	55-60	2011
53	Унгар	62	62	2011
54	Финлянд	62-68	62-68	2008
55	Франц	62	62	2011
56	Хорват	65	60	2011
57	Хятад	60	50-55	2011
58	Чех	63	59-63	2013
59	Чили	65	60	
60	Швед	61-67	61-67	2011
61	Швейцарь	65	64	2007
62	Шинэ Зеланд	65	65	2013

№	Улс	Эрэгтэй	Эмэгтэй	Судалгаа хийгдсэн он
63	Энэтхэг	60	60	2012
64	Эстони	63	62	2014
65	Япон	55–65	55–65	


Судалгаанд авагдсан орны тэтгэврийн насыг, хүйсээр нь ангилан түүвэрлэснийг доорх хүснэгтэд харуулав:

Улсын тоо

Тэтгэврийн нас	Эрэгтэй	Эмэгтэй
55 нас		5
57 нас		2
58 нас		5
59 нас		1
60 нас	7	14
61 нас	1	1
62 нас	7	4
63 нас	8	1
64 нас	3	1
65 нас	19	8
66 нас	3	2
67 нас	10	7
68 нас	1	

Үүнийг нэгтгэн диаграмаар үзүүлбэл:

Дэлхийн улс орнуудын тэтгэврийн насны давтамж



Эндээс үзэхэд, өндөр насны тэтгэврийн насыг дэлхийн хамгийн олон оронд (20 улс) 60-аар тогтоосон бол удаах байруудад 65 нас (18 улс), 67 насыг 10 улс орон тус тус сонгосон байдаг ажээ.

Зарим улсад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарах насыг тусгайлан зохицуулсан байна. Үүнд Ирланд, Герман, Кени зэрэг улсыг нэрлэж болно.

Ирланд улсын төрийн албан хаагчийн тэтгэврийн нас

Ирланд улсын Засгийн газраас 2014 оны 1-р сарын 1-ны өдөр улсын тэтгэврийн нөхцөлийн эрх зүйн орчинг шинэчлэн бүрдүүлж, 2005 оны 18 тоот “Төрийн албаны тухай”²⁵² хуулийн 8-р хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулжээ.²⁵³ Үүнд:

- 65 нас хүрсэн байх;
- 66 нас хүрээгүй байх;
- ажлаас чөлөөлөгдсөн байх;
- тэтгэврийн санд нийгмийн даатгалын шимтгэлийг хангалттай хуримтлуулсан байх ёстой ажээ.

Ирланд улсад тэтгэвэрт гарах насыг хөдөлмөрийн гэрээгээр заасан байдаг. Энэхүү хөдөлмөрийн гэрээгээр эрүүл мэндийн шалтгаанаар ажиллах чадвараа алдсан тохиолдолд 55-60 насыг “эрт тэтгэвэрт гарах нас” гэж үзээд тусгай заалт оруулсан байна. Ердийн тохиолдолд хууль ёсны тэтгэвэрт гарах насыг 65 гэж үздэг. Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүний тэтгэврийн насыг тэтгэврийн насны жишгээр хамгийн өндрөөр ч тогтоож болдог ажээ.

Мөн өндөр насны тэтгэврийг 1 насаар нэмэгдүүлж 66 нас болгон шилжүүлэх байдал дуусгавар болоод байна. Төрийн албан хаагч нь эрт тэтгэвэрт гарах (55 нас) бол өмнө нь нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх ёстой.

Ирландын эмэгтэйчүүд нь эрчүүдээсээ илүү удаан насалдаг байна. 2013 оны байдлаар, хүн амын хүйсийн харьцаа нь 65-69 насны ангилалд 100 эмэгтэй тутамд 100 эрэгтэй ноогдож байсан бол 85-аас дээш насанд 100 эмэгтэй тутамд ноогдох эрэгтэйчүүдийн тоо 48 болж буурчээ²⁵⁴.

Мөн 2013 онд ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн 54 хувь нь эрэгтэй, ажилгүй хүмүүсийн 2/3 буюу 69 хувь нь эрэгтэйчүүд байв. 2013 оны бүх эмэгтэйчүүдийн 98.2 хувь нь гэр бүлтэй болон гэр бүлгүй эмэгтэйчүүд, тэтгэвэрт гарагчдын 63.2 хувь нь эрэгтэйчүүд байсан гэж тодорхойлжээ.²⁵⁵

Герман улсын төрийн албан хаагчийн тэтгэврийн нас

Герман улсын нийтийн албаны²⁵⁶ ажилтнуудын зөвхөн гуравны нэг нь төрийн албан хаагч²⁵⁷ байдаг. Төрийн албан хаагчийн тэтгэврийг Холбооны улс, муж улс болон орон нутгийн түвшинд нэгдмэл байдлаар Төрийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар²⁵⁸ зохицуулдаг. Тус хуулийн холбогдох заалтууд нь мөн шүүгч нарт хамаардаг. Харин мэргэжлийн цэргийн албан хаагчийн тэтгэврийг энэхүү хуулийн зарчмыг баримтлан тусгайлан Цэргийн тэтгэврийн тухай хуулиар²⁵⁹ зохицуулна.²⁶⁰

²⁵²Төрийн албаны тухай хуулийн 8-р хэсэг. www.oireachtas.ie/documents/

²⁵³Төрийн албаны тухай хууль. 2005 он. Төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарах нас. www.oireachtas.ie/documents/

²⁵⁴Ирландын нийгмийн давхарга, амьдралын хэв шинж” - Social Cohesion and Life Styles. www.cso.ie/en/releasesand-publications/

²⁵⁵Ирландын 2013 оны статистикийн мэдээ” - Ireland: Principal economic status, 2013.

²⁵⁶Public service.

²⁵⁷Civil servant.

²⁵⁸Төрийн албан хаагчийн хангамжийн тухай хууль” - Beamtenversorgungsgesetz (BeamtVG).

²⁵⁹Цэргийн хангамжийн тухай хууль” - Soldatenversorgungsgesetz (SVG).

²⁶⁰Германы нийтийн албаны тэтгэвэр” - Public Sector Pensions in Germany, A.Freiberg (Sigma Paris), Seminar on “Social Rights and Pensions for Civil Servants in some EU Member States”, Vilnius, Lithuania, 9 November 2006. www.sigmaweb.org/publicationsdocuments/38701086.pdf

Төрийн албан хаагчийн тэтгэвэр нь хүний нөөцийн зардалд багтах бөгөөд тэтгэврийг төрийн байгууллага нь жилийн төсвөөсөө шууд төлдөг. Төрийн албан хаагч нь нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй (хууль ёсны ерөнхий нийгмийн хамгаалал, тэтгэврийн санд²⁶¹ хувь оруулахгүй) бөгөөд татвараас санхүүждэг тусгай тогтолцооны улмаас албан татвар төлөхгүй. Төрийн албан хаагч тохирох тэтгэвэр авах нь төрийн албаны уламжлалт зарчмуудын нэг мөн бөгөөд Үндсэн хуулиар хамгаалагдсан (баталгаажсан) байдаг.

Төрийн албан хаагч ажлаас халагдмагц тэтгэвэр тогтоолгох эрх нь бүрддэг. Энэ нь доорх тохиолдолд хэрэгжинэ. Үүнд:

- ерөнхий тэтгэврийн нас (65 насанд), эсвэл тусгай тэтгэврийн нас (цагдаа, хорих болон мэргэжлийн гал сөнөөх ангийн ажилтан бол 60 насанд) хүрсэн;
- 63-аас дээш насанд хүсэлт гаргасан (тахир дутуугийн групптэй бол 60-аас дээш);
- эсвэл хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан.

Төрийн албан хаагч нь хууль ёсны ерөнхий ослын даатгалын²⁶² хамгаалалт авдаггүй боловч төрийн албан хаагчийн тэтгэврийн тогтолцоо²⁶³ нь ослын тохиолдлыг харгалзсан байдаг. Хэрэв төрийн албан хаагч ажлын байранд осолдох буюу нас барвал түүний ажил олгогч (төрийн байгууллагын дарга) нь түүнд буюу түүний асран хамгаалуулагчид эмчилгээ, асран сувилах болон материалын зардлын нөхөн төлбөр, мөн орлого буурсны нөхөн олговор олгодог байна. Төрийн албан хаагч ажлын байранд осолдсоны улмаас ажлаас халагдвал түүнд тодорхой нөхцлүүд хангасан бол ослын нэмүү тэтгэвэр өгнө.

Тэтгэврийн хэмжээг улсын эдийн засгийн хөгжил болон төсвийн орлого, мөн төрийн албан хаагчийн цалинтай уялдуулан тохируулах бөгөөд Холбооны хуулиар тогтоодог.

Хууль ёсны тэтгэврийн даатгал²⁶⁴ болон нийтийн албаны нэмэлт тэтгэврийн тогтолцооны²⁶⁵ дагуух тэтгэврээс ялгаатай нь төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэврийг татварын хуулиар хөдөлмөрийн орлого гэж үзэх ба тэтгэвэрт (3000 еврогоос давсан хэсэгт) нь бүрэн албан татвар ногдуулдаг байна.

Тэтгэвэр авахын тулд төрийн албан хаагч хамгийн багадаа 5 жил төрийн алба хаасан, эсвэл ажлын байранд осолд орсоны улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан байх ёстой. Мөн ерөнхийдөө төрийн албан хаагч нь нийтийн албаны ажлаас халагдсан байх шаардлагатай.

Төрийн албан хаагч тэтгэвэрт гарахаасаа өмнө нийтийн албанаас халагдсан бол түүнийг хууль ёсны тэтгэврийн даатгалд ухраан хамруулж болдог (гэхдээ нийтийн албаны нэмэлт тэтгэврийн тогтолцоонд хамрахгүй).

Тэтгэвэр тогтоох алба хашсан жил, тэтгэвэр тогтоох цалинг үндэслэн тэтгэврийг тооцоолно.

Тэтгэвэр тогтоох алба хашсан жилд нийтийн алба, мэргэжлийн болон мэргэжлийн бус цэргийн алба хаасан жил, иргэний хуулийн дагуу нийтийн албанд ажилласан жил, болон сургалтанд хамрагдсан хугацааг оруулж тоолно.

²⁶¹General statutory social security and pension scheme.

²⁶²General statutory accident insurance

²⁶³Pension scheme for civil servants

²⁶⁴Statutory pensions insurance

²⁶⁵Supplementary pension scheme

Тэтгэвэр тогтоох цалинд төрийн албан хаагчийн гэр бүлийн олговор²⁶⁶ (I шат) болон хуулинд тусгайлан заасан зарим олговрыг хамруулан хамгийн багадаа 3 жилийн туршид авсан сүүлчийн суурь хөлсийг оруулдаг. Гэхдээ шуудангийн олговор, хүнд нөхцөлд ажилласны нэмэлт төлбөр, зардал болон илүү цагийн олговрыг хамруулахгүй.

2003 он хүртэл хамгийн өндөр тэтгэврийн хэмжээ нь тэтгэвэр тогтоох цалингийн 75 хувь байсан. 2010 онд 71.75 хувь болж буурсан.

Хэрэв хууль ёсны тэтгэврийн нас (65 нас, цагдаагийн ажилтан бол 60) хүрэхээс өмнө төрийн албан хаагч тэтгэвэрт гарах бол эрт гарч буй жил тутамд тэтгэврийг 3.6 хувиар бууруулж тооцно. Хорогдуулалтын хамгийн дээд хэмжээ 10.8 хувь байна. Тахир дутуугийн группэд байдаг төрийн албан хаагчийн хувьд хууль ёсны тэтгэврийн нас 63 байдаг.

Хэрэв илүү ашигтай бол төрийн албан хаагч нь хамгийн багаар тэтгэвэр тогтоолгож болно. Энэ нь тэтгэвэр тогтоолгох цалин (гэр бүлийн бүрэн олговрыг оруулан)-гийн 35 хувьтай тэнцэх ба 2004 оны байдлаар хамгийн багадаа 1290.97 (хуучин улсуудад), 1196.44 (шинэ улсуудад) евро тус тус байлаа.

Кени улсын төрийн албан хаагчийн тэтгэврийн нас

Зүүн Африкийн Кени улсад төрийн албан хаагчдын тэтгэврийн нас нь хамгийн багаар 55 нас гэж тогтсон байдаг байна. Олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн Хөдөлмөрийн байгууллага (ОУХБ) нь тэтгэвэрт гарах насыг тухайн орны онцлог шинж, тэтгэвэрт гарах насны дундажтай харьцуулан 60 нас гэж тогтоосон байдаг боловч Кени улсын Засгийн газар төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарах насыг тодорхойлох, удирдан чиглүүлэх, насыг хянан үзэх, байгалийн хүчин зүйлс, онцлог шинжүүдэд тохируулан бодлогын судалгаа хийсний үндсэн дээр тэтгэвэр тогтоох схем боловсруулсан байна.

2009.04.01-ний өдөр Кени улсын Засгийн газар төрийн албаны хаагчдын тэтгэвэрт гарах насыг 5 жилээр нэмэгдүүлэн 60 нас болгон өөрчилсөн нь барууны орнуудын хувьд энгийн үзэгдэл билээ. Өндөр хөгжилтэй орны хувьд их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудын ажилтны өндөр насны тэтгэврийг 70 нас гэж “тэтгэвэрт гарах нас”-д өөрчлөлт оруулж байгаа нь тухайн орны санхүүжилт, цалинтай холбоотой түгээмэл асуудал байдаг.

Дэлхийн орнуудын жишгээр төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарах насыг Кени улсад нэмэгдүүлэх боломжгүй талаар маргаан мэтгэлцээн үүссээр байна. Энэ нь тухайн орны хүн амын дундаж наслалт, хүн амын өсөлт, хөгшрөлтийн явц, ажиллах хүчний чадвар, байгалийн онцлог шинжээс үүдэлтэй гэж тайлбарлаж болно. Төрийн албаны тэтгэврийн тогтолцооны үндсэн мэдээлэл нь төрийн албаны тэтгэврийн системээр тодорхойлогдоно. Тэтгэвэрт гарах наснаас эхлэн нас барах хүртлээ өндөр насны тэтгэврийг олгоно.²⁶⁷

Кени улсын төрийн албаны хаагчийн тэтгэврийн хэмжээ нь 400 000 шиллинг (1\$=84 шиллинг) байна. Үүнд: бүх ажилчдыг хамруулах ба боловсролын салбарын нийт багш нар 53 хувь, яамдуудын төрийн албан хаагчид 30 хувь, цэрэг, цагдаа болон хүчний багууллагынхан 21 хувь, үлдсэн нь 17 хувийг бүрдүүлдэг байна. Кени улсын Статистикийн газрын мэдээлсэнээр, төрийн албан хаагчдын тоо 12 000 байна.

²⁶⁶Family allowance

²⁶⁷“Тэтгэврийн насны үзэл баримтлал” - The Concept of Retirement Age: A Commentary by Monica Were, Research & Development Department, RBA. www.rba.go.ke/publications/

Одоогоор тэтгэвэрт гарсан төрийн албан хаагчдын тэтгэврийг цаг хугацаанд нь олгох, амласны дагуу амьжиргааны тэтгэврийн стандартыг мөрдөж үүргээ биелүүлэх нь тулгамдсан асуудал болоод байна. 2002 оны байдлаар төрийн албаны тэтгэврийн тогтолцооны далд тэтгэврийн өр нь 176.5 тэрбум шиллинг болжээ. Үнэндээ тэтгэврийн насыг 60 гэж нэмсэн ч эрт тэтгэвэрт гарах нас нь дунжаар 50 нас болоод байна. Цагдаа, хорих байгууллага, хүчний байгууллага, хамгаалагч нар эрт тэтгэвэр тогтоолгож байна.

II. ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гаргасан дэлхийн хүн амын дундаж наслалтын (2012 он) жагсаалтыг доорх хүснэгтээр харуулав:²⁶⁸

№	Улс орон	Дундаж наслалт	Эрэгтэй	Эмэгтэй
1	Австрали	83	80.5	85.5
2	Австри	81.5	78.5	84.5
3	Азербайжан	71.5	69.5	74.5
4	Албани	74	72	76
5	Алжир	73.1	70.1	78.7
6	Ангол	52	51	53
7	Андорра	84.2	80.8	87.6
8	Антигуа-Барбуда	75.8	74.4	77.2
9	АНУ	79.8	77.4	82.2
10	Арабын Нэгдсэн Эмират	79.2	77.2	81.2
11	Аргентин	76	73	79
12	Ардчилсан Конго Улс	49.5	48	51
13	Армени	74.4	70.6	78.2
14	Афганистан	60	59	61
15	Багамын Арлуудын Нөхөрлөл	76.5	73.5	79.5
16	Бангладеш	70	69.5	70.5
17	Барбадос	78.5	76.2	80.8
18	Бахрейн	77	75	79
19	Беларусь	72.5	68.5	77.5
20	Белиз	77	74.4	79.4
21	Бельги	81	78.5	83.5
22	Бенин	59	58	60
23	Болгар	74.5	71	78
24	Болив	69	67	71
25	Босни-Герцеговина	76	74	78
26	Ботсван	66	64.5	67.5
27	Бразил	76.2	72.6	79.8
28	Бруней	79	77.5	80.5
29	Буркина Фасо	56.5	54	57
30	Бурунди	53	52	54
31	Бутан	70.8	69.2	72.4
32	Вануату	72	71	74
33	Венесуэл	75	71.5	78.5
34	Вьетнам	75	73	77
35	Габон	64	62	66
36	Гайана	70.5	67.5	73.5
37	Гайти	63	62	64
38	Гамби	59	57.5	60.5


²⁶⁸ Дэлхийн улс орнуудын дундаж наслалтын жагсаалт - List of countries by life expectancy. http://en.wikipedia.org/wiki/List_of_countries_by_life_expectancy

№	Улс орон	Дундаж наслалт	Эрэгтэй	Эмэгтэй
39	Гана	66	64	68
40	Гватемаль	71.5	68	75
41	Гвиней	55	54	56
42	Гвиней Биссау	50	48	52
43	Герман	81	78.5	83.5
44	Гондурас	74	72	76
45	Грек	81	78	84
46	Гренада	76.5	73	80
47	Гүрж	74.5	70.2	78.8
48	Дани	79.5	77	82
49	Доминик	77.5	75	80
50	Доминикан	73.2	72	74.4
51	Египет	73.2	71.2	75.2
52	Жибути	61	59	64
53	Жордан	74.6	72.4	76.8
54	Зааны Ясан Эрэг	56.5	55	58
55	Замби	55.5	54	56
56	Зимбабве	54	53	55
57	Йемен	64	63	66
58	Израиль	82.1	80.3	83.9
59	Индонез	72	68	76
60	Ирак	68.5	65	72
61	Иран	73.5	72	75
62	Ирланд	81.4	79.2	83.6
63	Исланд	83.3	81.4	85.2
64	Испани	82.5	79.5	85
65	Итали	83.1	80.4	85.8
66	Кабо-Верде	74.5	70.6	78.4
67	Казахстан	68	63	73
68	Камбож	66	64	68
69	Камерун	61.5	59	64
70	Канад	82.5	80.4	84.6
71	Катар	75.5	73	78
72	Кени	60	59	61
73	Кипр	81.2	79.1	84.3
74	Киргизстан	69	65	72
75	Кирибати	68	65	71
76	Колумб	74.6	72.4	76.8
77	Коморын арлууд	68	65	71
78	Конго	58	57	59
79	Коста-Рика	79.8	78.3	81.3
80	Куба	79.4	77.4	81.4
81	Кувейт	78.2	75.5	80.5
82	Лаос	68	66.5	69.5
83	Латви	74.5	69.5	78.5
84	Лесото	51	50	52
85	Либерри	59	58	60
86	Ливан	80.5	78.9	82.5
87	Ливи	74.5	71	78
88	Литва	75.9	70.8	81
89	Лихтенштейн	80.7	77.8	83.6

№	Улс орон	Дундаж наслалт	Эрэгтэй	Эмэгтэй
90	Люксембург	82	79.5	84.5
91	Мавритани	75.2	71	79.4
92	Мавритани	59.5	57	61
93	Мадгаскар	66	65	68
94	Македон	75	73	77
95	Малави	58	57.5	58.5
96	Малайз	75.7	72.2	79.2
97	Мали	51	50	53
98	Мальдив	77.2	76.2	78.2
99	Мальт	81	79.4	82.6
100	Марокко	76.5	73.4	79.9
101	Маршаллын Арлууд	73.5	69	75
102	Мексик	77.2	74.2	80.2
103	Микронези	70	68	72
104	Мозамбик	52.5	52	53
105	Молдав	71	67	75
106	Монгол	69	65	73
107	Монтенегро	74.5	71.5	77.5
108	Мьянмар	68	66	70
109	Намиб	67.2	66.2	68.2
110	Науру	73	70	76
111	Непал	69	68	70
112	Нигер	56	55	57
113	Нигери	53	52	54
114	Нидерланд	81.5	79.5	83.5
115	Никарагуа	74.5	71.5	77.5
116	Норвеги	81.9	80.2	83.6
117	Нэгдсэн Вант Улс	81	79.5	82.5
118	Оман	76	73	79
119	ОХУ	70.5	62	76.3
120	Өмнөд Африк	61	59	63
121	Өмнөд Солонгос	81	77.5	84.5
122	Пакистан	67	66	68
123	Палау	74	70	78
124	Панам	77.8	74.6	81
125	Папуа Шинэ Гвиней	67.5	65	69
126	Парагвай	74.7	71.6	77.8
127	Перу	74.7	71.6	77.8
128	Польш	77.5	73.5	81.5
129	Португаль	80	76.9	82.8
130	Руанда	60	59	61
131	Румын	74	70	78
132	Самоа	74	71	77
133	Сан-Марино	83.5	82	85
134	Сан-Томе ба Принсипи	72	68	76
135	Саудын Араб	74.3	72.4	76.2
136	Свазиланд	50	49	51
137	Сейшелийн Арлууд	74.7	71	78.4
138	Сенегал	64	62	66
139	Сент Китс ба Неви	75.5	71.5	79.5
140	Сент-Винсент ба Гренадин	76	73	79
141	Сент-Китс ба Невис	75.1	72.2	78

№	Улс орон	Дундаж наслалт	Эрэгтэй	Эмэгтэй
142	Серби	74	71	77
143	Сингапур	84	82	87
144	Сири	75	72	78
145	Словак	76.3	72.9	79.61
145	Словени	80	77	83
147	Соломоны Арлууд	73	71	75
148	Сомали	50	48	52
149	Судан	63	61	65
150	Суринам	74.5	72	77
151	Сьерра-Леон	38	37	39
152	Тажикстан	68	67	69
153	Тайвань	80.6	78	83.2
154	Тайланд	74.9	71.4	78.4
155	Танзани	59	58	61
156	Тимур-Лэстэ	64	63	65
157	Того	57	55.5	58.5
158	Тонга	74.5	73	76
159	Төв Африк	48.5	47	50
160	Тринидад-Тобаго	74.8	71.5	78.1
161	Тунис	74.6	72.6	78.9
162	Турк	74.4	72.4	76.4
163	Туркменистан	66.5	63	70
164	Уганда	56	54.5	57.5
165	Узбекстан	68.5	66	71
166	Украйн	68,25	62,37	74.5
167	Унгар	75	71	79
168	Уругвай	77.3	74.2	80.4
169	Фижи	73	70	76
170	Филиппин	73	70	76
171	Финлянд	81	78.0	84
172	Франц	82.3	79.4	85.2
173	Хойд Солонгос	69	66	72
174	Хонг Конг	83.8	82	85.6
175	Хорват	77.5	74.5	80.5
176	Хятад	76	74	77
177	Чад	51	50.5	53.5
178	Чех	78	75	81
179	Чили	81.2	80.1	82.3
180	Швед	83	81.4	84.6
181	Швейцарь	82.8	80.4	85.4
182	Шинэ Зеланд	81.7	79.4	84
183	Шри-Ланка	74.7	71.4	78
184	Эквадор	76	73	79
185	Экваторын Гвиней	54	53	55
186	Эль Сальвадор	74.6	70.8	78.4
187	Энэтхэг	65	64	67
188	Эритрей	61.5	59	64
189	Эстони	76.1	71	81.2
190	Эфиоп	60.5	59	62
191	Ямайка	74.8	71.5	78.2
192	Япон	84.6	85	87.3

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Эрүүл мэндийн статистикийн тайланд шинээр дурдсанаар, 1990 оноос хойш дэлхийн улс орнуудад хүн амын дундаж наслалт сүүлийн 6 жилд өсөж, 70 нас хүрсэн байна. Дэлхийн хэмжээнд эмэгтэйчүүдийн дундаж нас 73 байгаа бол харин эрэгтэйчүүдийнх 68 байна.²⁶⁹



2012 оны энэхүү байдлаар, Америк, Европ, Өрнөд номхон далайн бүсийн дундаж наслалт тус тус 76 нас гэж дэлхийн дундаж наслалтаас дээгүүр байна. Харин Дорнод газар дундын тэнгисийн бүс-68, Зүүн өмнөд ази-67, Африк-58 нас гэж дэлхийн дунджаас доогуур байна.

Улсаар нь авч үзвэл, Сьерра Леон улсын дундаж наслалт нь хамгийн бага буюу 46 нас байна. Япон улсын эмэгтэйчүүдийн хувьд хамгийн урт наслалттай буюу 87 нас байхад, Исланд улсын эрэгтэйчүүдийн наслалт нь хамгийн урт буюу 81.2 нас байна.

Дэлхийн хэмжээнд эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс даруй 4.6 жилээр илүү байна гэж уг тайланд дурджээ.

Европын хүн амын дундаж наслалт

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын Европ дахь салбарын төлөөлөгчид тус тивийн хүн амын эрүүл мэндийн нөхцөл байдлын талаарх судалгааг танилцууллаа. Европчуудын дундаж наслалт өндөр, эрүүл саруул амьдралын хэв маягтай байгаа боловч тивийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийг сайжруулах бодлого тэгш бус хэрэгжиж байгааг судлаачид хэлж байна.

Хэдийгээр европчуудын дундаж наслалт өндөр, эрүүл амьдралын орчин нөхцөл сайн байгаа боловч Засгийн газрууд эрүүл мэндийн салбар дахь төсвөө бууруулбал сөрөг үр дүн гарах эрсдэлтэй болохыг ДЭМБ-ын судлаачид анхаарууллаа.

Европын холбооны “Европын эрүүл мэндийн тайлан-2012” сэдэвт судалгаанд дурдсанаар, бүс нутгийн хэмжээнд хүн амын дундаж наслалт 82.2 буюу хамгийн өндөр үзүүлэлттэй байгаагаараа Испани улс тэргүүлж байгаа бол Казахстан улсын хүн амын дундаж наслалт 68.7 буюу хамгийн бага байгаа юм.

Евро бүсийн хэмжээнд хүн амын дундаж наслалт 1980 оноос хойш 5 жилээр нэмэгдэж, 2010 оны байдлаар европчуудын дундаж наслалт 76-д хүрчээ. Гэвч Европ тивийн хэмжээнд хүн амын эрүүл мэндэд чиглэсэн бодлого тэгш бус хэрэгжиж буйг судлаачид хэлж байна. ДЭМБ-аас гаргасан уг судалгаа Израиль, Төв ази болон Баруун европын баян чинээлэг орнуудаас гадна Зүүн европын ядуу буурай улс орнууд зэрэг 53 улсыг хамарчээ. Тус бүс нутгийн 9 улс дэлхийн хэмжээнд дундаж наслалтаараа тэргүүлж байгаа боловч Европ тив архидалт, тамхидалтын үзүүлэлтээрээ өндөрт орж байгаа болохыг судалгаа харуулж байна.

²⁶⁹ “Дундаж наслалт нэмэгдсэн ч бүсийн ялгаа хэвээр байна” - Life expectancy rises, but regional differences remain, Matt Petronzio, 20 May 2014. <http://mashable.com/2014/05/19/life-expectancy-global/>

Тайланд дурдсанаар, хүн амын дундаж наслалтын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж байгаа гол хүчин зүйлст зүрхний өвчлөл орж байгаагаас гадна ямар нөхцөлд амьдарч буй нь ихээхэн нөлөөтэй байгаа юм. Мөн тус бүс нутагт эмэгтэйчүүдийн дундаж наслалт 80 бол эрэгтэйчүүдийн дундаж наслалт 72.5 буюу ихээхэн зөрүүтэй байгааг тайланд онцолжээ.²⁷⁰

Дэлхийн хамгийн өндөр дундаж наслалттай 10 улс

Урт наслахад хамгийн чухал нь хөрөнгө мөнгө. Учир нь баян хүмүүс эрүүл хоол идэж, архи тамхи бага хэрэглэж, чанартай эмнэлгийн тусламж авдаг. Мөн баян орнуудад гэмт хэрэг, иргэний дайн бага байдаг. Дэлхийн дараах орнуудад дундаж наслалт өндөр байдаг бөгөөд АНУ-ын дундаж наслалт 77.85 байх ба энэхүү үзүүлэлтээрээ дэлхийд 48-р байранд ордог байна.²⁷¹

1.АНДОРРА: 83.51 Франц, Испаний дунд байдаг Андорра улс нь дэлхийн II дайны дараа жуулчдын зорих дуртай газар болох хүртлээ европын хамгийн ядуу улсын нэг байсан. Андоррагийн 71 мянган хүн өөрийн улсын байнга өсч дэвжиж буй эдийн засгийнхаа ачаар маш сайн хүнсний хангамж, нийгмийн эрүүл мэндийн тусламжийг хүртэж чаддаг байна.

2.МАКАО: 82.19 Андоррагийн адил, Өмнөд Хятадын тэнгис дэхь энэхүү арал нь асар хурдацтай өсч буй эдийн засгийнхаа үр шимийг хүртэж буй юм. Саяхан чөлөөтэй болсон мөрийтэй тоглоомын салбарын ачаар ихэнх мөнгөө жуулчдаас олдог бөгөөд ялангуяа эх газрын Хятадууд тэдэнд ихээхэн хувь нэмэр оруулдаг байна. Улсын орлогын 70 хувийг мөрийтэй тоглоомоос олон, түүнийгээ засгийн газар нь эргүүлээд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулахад маш их хэмжээгээр цацдаг.

3.САН МАРИНО: 81.71 Төв Итали дахь энэхүү тусгаар улс нь европын 3 дахь жижиг улс (Ватикан, Монакогийн дараа орох) бөгөөд дэлхийн хамгийн хөгшин Бүгд Найрамдах улс юм. Тэдний урт насладагийн учир нь тогтвортой хөгжил болон хүн амынх нь ихэнх хэсэг нас богиносгодог хүнд хүчир үйлдвэрлэлийн ажлаас илүү тасалгаанд суудаг ажилтай байдаг нь холбоотой юм.

4.СИНГАПУР: 81.71 Хөгжил цэцэглэлтийг нь тооцохгүйгээр хандвал, Сингапурын иргэдийн дундаж наслалт урт байдаг нэг хүчин зүйл нь 1980-аад оны эхээр тус улсын Засгийн газар ард иргэдээ өндөр насалж буй буюу иргэдийнх нь дундаж нас тогтмол өсөж буйг ажигласан явдал юм. Улмаар Засгийн газар нь эртнээс төлөвлөн ажил хэрэг болгосны хүчинд одоо Сингапур улсын ахимаг настандаа үзүүлэх эрүүл мэндийн тусламж маш өндөр түвшинд хүрсэн юм.

5.ХОНГКОНГ: 81.59 Хонг Конг дахь хүмүүс ерөнхийдөө эрүүл, тэнцвэртэй хоол хүнс буюу ихэвчлэн будаа, ногоо, дүпүнд суурилсан хоол хүнс хэрэглэдэг бөгөөд маш бага хэмжээний мах хэрэглэдэг. Энэ нь таргалалтын түвшин бага байх боломжийг олгож улмаар хүнсний хэрэглээтэй холбоотой хорт хавдар, зүрх судасны өвчлөл доогуур байна гэсэн үг юм.

6.ЯПОН: 81.25 Өндөр хөгжилтэй улсууд дунд Япон улс нь насанд хүрэгсдийн таргалалтаараа хамгийн бага улсуудын нэг буюу дөнгөж 3 хувь байдаг. Үүний гол шалтгаан нь Хонг конгчуудтай ижил эрүүл хоол хүнс буюу ихэвчлэн ногоо, загас, будаа болон гоймонтой хүнс хэрэглэдэгтэй холбоотой. Ихэнх япончууд цадталаа иддэггүй бөгөөд 80 хувь нь дүүрэхэд л үргэлжлүүлэн идэхээ зогсоодог байна. Япончууд барууны улсуудаас бас нэг зүйлээр ялгаатай нь тэд машинд тэднээс илүү бага хамааралтай байж боломж л олдвол алхдаг ба түүгээрээ ч хангалттай дасгал хөдөлгөөнийг хийж байдаг.

²⁷⁰"Европын хүн амын дундаж наслалт өндөр байна", Т.Сарангя, 2013.03.13 <http://world.time.mn/>

²⁷¹"Дэлхийн хамгийн өндөр дундаж наслалттай 10 улс", МонголМед-Монголын Анагаахын Сэтгүүлүүдийн Холбоо (МАСХ), 2008-2. www.mongolmed.mn/article/1121

7.ШВЕД: 80.51 1990-ээд оны сүүлд тохиосон эдийн засгийн хямрал Шведийн дэлхийд алдартай амгалан байдаг болон нийгмийн эрүүл мэндийн тогтолцоонд тодорхой хэмжээний хохирол учруулсан хэдий ч тэд дэлхийн шилдгүүдийн нэг байсаар байна. Мөн Швед улс тамхичдынхаа тоогоор хөгжингүй орнуудаас хамгийн бага буюу 17 хувь. Иймээс тамхитай холбоотой нас барагтын түвшин европын дунджаас даруй 2 дахин бага юм.

8.ШВЕЙЦАРЬ: 80.51 Тогтвортой эдийн засгийн хөгжил болон өндөр наслалтын гол хүчин зүйлүүд болох эрүүл хооллолт, өндөр түвшний эрүүл мэндийн тусламж зэргээс нь салгаж харвал, Швейцарийн бусад улстай маш найрсаг харилцдаг төвийг сахисан бодлого нь зэвсэгт мөргөлдөөнөөс болж иргэд нь амь насаа алдах боломжийг багасгаж өгдөг юм.

9.АВСТРАЛИ: 80.50 Хөгжил цэцэглэлттэй холбоотой бүх л хүчин зүйлүүд энд үйлчлэх хэдий ч нутгийн уугуул иргэдийн наслалт нь цагаан арьст Австраличуудаас 20 жилээр бага байдаг нь амьдралыг богиносгодог тамхи, таргалалт, ядуураг зэрэг хүчин зүйлсийн түвшин өндөр байгаатай холбоотой. Сонирхолтой нь, нэгэн судалгаанд дурдсанаар Австраличуудын дунд таргалалт тархалтын зэрэгт хүрч эхэлж буйтай холбоотой дундаж наслалт буурч эхэлж магадгүй гэнэ.

10.ГЕРНСИ: 80.42 Гернси арал нь Англи Сувагт оршдог бөгөөд Британий хаанчлалд хамаардаг боловч Нэгдсэн Вант улсын харъяа биш юм. Гернсийн маш бага татвар нь тэдэнд маш сайн хүнсний хангамж болон эмнэлгийн үйлчилгээгээр хангаж чадах татварын орогнол хүсэгчдийг татах боломж олгосон юм. Арлын орлогын тавиас илүү хувь нь санхүүгийн үйлчилгээний газрууд, өөрөөр хэлбэл ширээний ард суух ажлуудад ордог бөгөөд маш цөөхөн хүн хүнд үйлдвэрт ажилладаг.

III. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ

Монгол Улсын төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2013 онд улсын хэмжээнд 69.1 болж өмнөх оныхоос 0.4 пунктээр нэмэгдсэн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75.0, эрэгтэйчүүдийнх 65.4 жил байна.²⁷²

Хүн амын дундаж наслалт, хүйсээр, 2004-2013 он

Үзүүлэлт	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Төрөлтөөс тооцсон дундаж наслалт (жил)	64.6	65.2	65.9	66.5	67.2	68.0	68.1	68.3	68.7	69.1
Эрэгтэй	61.6	62.1	62.6	63.1	63.7	64.3	64.9	64.7	64.9	65.4
Эмэгтэй	67.8	68.6	69.4	70.2	71.0	71.8	72.3	73.8	74.3	75.0

Аймгуудын хувьд хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалтыг харвал Дундговь аймаг улсын дунджаас харьцангуй өндөр буюу 3.5 жилээр их, Хөвсгөл аймаг харьцангуй бага буюу 3.8 жилээр бага байна. Улсын дунджаас өндөр 14 аймаг байна.

Хүн амын дундаж наслалт (аймаг, нийслэлээр) 2013 он

№	Аймаг, нийслэл	Дундаж наслалт
1.	Дундговь	72.61
2.	Говьсүмбэр	72.26
3.	Баян-Өлгий	72.16
4.	Булган	71.70
5.	Төв	71.46

²⁷² "Хүн амын үзүүлэлтүүдийн өөрчлөлт, өнөөгийн байдал", YCX, 2013. www.nso.mn

6.	Сэлэнгэ	71.27
7.	Сүхбаатар	71.19
8.	Ховд	71.12
9.	Өмнөговь	70.85
10.	Улаанбаатар	70.65
11.	Хэнтий	70.35
12.	Орхон	70.25
13.	Архангай	69.95
14.	Дорноговь	69.59
15.	Өвөрхангай	68.75
16.	Завхан	68.62
17.	Баянхонгор	68.32
18.	Говь-Алтай	68.27
19.	Дархан-Уул	67.94
20.	Дорнод	67.84
21.	Увс	67.72
22.	Хөвсгөл	65.25

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) хүний дундаж наслалтыг тогтоох судалгаанд Монгол хүний дундаж наслалтыг 69.29 жил гэсэн байна.²⁷³

Монгол Улсын эрэгтэйчүүдийн дундаж наслалт 64.9, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 74.3 жил байна. Дундаж наслалтын зөрүү нь 9.4 жил байна. Манай улсын дундаж наслалтын зөрүү нь дэлхийн дундаж үзүүлэлтээс 2.5 дахин их байна.²⁷⁴

Төрийн албанаас тэтгэвэрт гарах нас

Төрийн албанаас тэтгэвэрт гарах насыг тогтоохдоо *“тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн”, “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн” эсэхийг төрийн жинхэнэ албан хаагчийн иргэний үнэмлэх дээр бичигдсэн он, сар, өдрөөр тодорхойлно.*

“Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн” гэдгийг Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд *“60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн”* гэж зааснаар авч үзнэ.²⁷⁵

Төрийн албаны тухай хуульд төрийн алба хаах насны дээд хязгаарыг 65 насаар тогтоосон байдаг.²⁷⁶

Төрийн албан хаагч тэтгэврийн насанд хүрсэн үед албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх талаар Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасан бөгөөд тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн төрийн жинхэнэ албан хаагчийг үргэлжлүүлэн ажиллуулах эсэхийг эрх бүхий этгээд шийдвэрлэнэ. Гэхдээ төрийн алба хаах насны дээд хязгаар хүрсэн бол цаашид үргэлжлүүлэн ажиллуулах эрхзүйн боломжгүй болдог байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийг тэтгэвэр тогтоолгох насанд хүрээгүй байхад нь сайн дураар хүсэлт гаргуулан тэтгэвэртээ гарахыг шаардахгүй. Хөдөлмөрийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуулиар “60 насанд хүрч, өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн”-ийг “тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн” гэж үзэх бөгөөд энэ насанд хүрээгүй байхад нь тэтгэвэртээ гарахыг шаардах эрх байгууллагын удирдлагад байхгүй.

²⁷³“Хүний дундаж наслалт”, ДЭМБ. <http://society.time.mn/>

²⁷⁴“Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн байдал”, ЭМЯ, 2012. www.moh.mn

²⁷⁵Хөдөлмөрийн тухай хууль.

²⁷⁶Төрийн албаны тухай хууль.

Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр²⁷⁷ тогтоолгон авах эрхтэй.²⁷⁸

Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 55 нас хүрсэн эмэгтэй, төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, 50 нас хүрсэн бол өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно²⁷⁹, гэж заасан. Энэ тохиолдолд, эмэгтэй өөрөө хүсэлт гаргасан байх ёстой.

Тэтгэврийн нас өндөр байх нь дараах эрсдлийг дагуулдаг байна.²⁸⁰ Үүнд:

Нэгдүгээрт: Төсөв санхүүгийн байдалд нөлөөлнө. Өөрөөр хэлбэл, тэтгэврийн нас бага байгаа тохиолдолд хүмүүс цөөн жил ажиллаад олон жил тэтгэвэр авах юм. Энэ нь эмэгтэйчүүдийн хувьд илүүтэй илэрдэг. Харин эрэгтэй даатгуулагчдын хувьд бол 60 настайдаа тэтгэвэрт гараад тэтгэвэр авах хугацаа нь 15 орчим жил байдаг байна. Одоогийн байдлаар эрэгтэйчүүдийн тэтгэврийн насыг нэмэгдүүлэх боломж багатай боловч бодит тоон судалгаагаар аваад үзэхэд эмэгтэйчүүдийн тэтгэврийн насыг 60 насанд аажмаар хүргэх боломж харагдаж байна. Тэтгэврийн насыг нэмэх асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх боломжгүй. Яагаад гэвэл, олон жилийн турш урьдчилан бэлтгүүлж байж шийдвэрлэгддэг. Хүмүүсийн насжилт уртассанаар тэтгэвэр авах хугацаа нэмэгдэж байна.

Хоёрдугаарт: Ахмад настнуудын тоо нэмэгдэж байгаа учраас тэтгэврийн зардал түүний хэрээр нэмэгдэж улсын төсөвт дарамт ирнэ. Европын улсууд болон Япон улс тэтгэврийн шинэчлэлийн эхний үе шатаа нилээд түрүүнд хийгээд эхэлсэн учраас тэтгэврийн зардал нь өндөр болчихсон. Харин Монгол Улсын хувьд харьцангуй хүн ам залуу учраас одоо л тэтгэврийн шинэчлэлийг ярьж эхэлж байгаа.

УИХ-аас 1994 онд баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй байхаар зохицуулсныг 1999 онд хуульд орсон өөрчлөлтөөр эрэгтэй, эмэгтэй адилхан 60 нас хүрсэн бол, харин 55 насанд хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл тэтгэвэр тогтоолгох эрхтэй байхаар өөрчилсөн. Цаашид монгол хүний дундаж наслалт уртсаж байгаа, мөн 20-иод жилийн дараа хүн ам насжиж, ахмад настны тоо эрс нэмэгдэх, шимтгэл төлөгчдийн тоо буурах хандлагатай байгаа учраас тэтгэвэрт гарах насыг эдийн засгийн нөхцөл байдал, ажлын байрны орон тоо зэргийг харгалзан үзэх шаардлагатай болно.

Цэргийн алба хаасны тэтгэврийг цэргийн жинхэнэ алба болон тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад алба хаасан албан хаагчид авах бөгөөд эдгээр байгууллагад алба хаасан нийт хугацааг тооцдог байна.²⁸¹

Цэргийн албан хаагч нь дор дурдсан үндэслэлээр нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Үүнд:

- 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй;
- 20-иос доошгүй жил алба хаасан эмэгтэй;
- байлдааны нисдэг тэрэгний нисгэгчээр 23-аас доошгүй жил цэргийн алба хаасан;

²⁷⁷Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, 4-р зүйлийн 1-р заалт. www.legalinfo.mn/

²⁷⁸Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль

²⁷⁹Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, 4-р зүйлийн 2-р заалт. www.legalinfo.mn/

²⁸⁰"Тэтгэврийн насыг нэмэх асуудлыг нэг дор богино хугацаанд шийдвэрлэх боломжгүй", Л.Мөнхзул. www.info.mn

²⁸¹Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль.

- байлдааны тийрэлтэт сөнөөгч онгоцны жинхэнэ нисгэгчээр 20-иос доошгүй жил цэргийн алба хаасан.

10-аас доошгүй жил цэргийн алба хаасан цэргийн албан хаагч дор дурдсан шалтгаанаар халагдсан бол цэргийн алба хаах насны хязгаарт хүрээд цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй. Үүнд:

- орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлтөөр;
- биеийн эрүүл мэндээр;
- цэргийн алба хаах нас хэтэрч.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тэдний цэргийн алба хаасан сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д, 5 хүртэл жил алба хаасан бол цэргийн алба хаасан нийт хугацаанд авсан цалин хөлсний нийлбэрийг алба хаасан сарын тоонд хувааж тодорхойлдог.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- “Тэтгэврийн нас” - Retirement Age. http://en.wikiedia.org/wiki/Retirement_age
- Төрийн албаны тухай хууль” 2005 он, Төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарах нас. www.oireachtas.ie/documents/bills/acts/2005/1805.pdf
- “Ирландын нийгмийн давхрага, амьдралын хэв шинж” - Social Cohesion and Life Styles. www.cso.ie/en/releasesandpublications/
- “Ирландын 2013 оны статистикийн мэдээ” - Ireland: Principal economic status, 2013
- “Германы нийтийн албаны тэтгэвэр” - Public Sector Pensions in Germany, A.Freiberg (Sigma Paris), Seminar on “Social Rights and Pensions for Civil Servants in some EU Member States”, Vilnius, Lithuania, 9 November 2006. www.sigmaweb.org/publicationsdocuments/38701086.pdf
- “Тэтгэврийн насны үзэл баримтлал” - The Concept of Retirement Age: A Commentary by Monica Were, Research & Development Department, RBA. www.rba.go.ke/publications/
- “Дэлхийн улс орнуудын дундаж наслалтын жарсаалт”-List of countries by life expectancy, Wikipedia http://en.wikipedia.org/wiki/List_of_countries_by_life_expectancy
- “Дундаж наслалт нэмэгдсэн ч бүсийн ялгаа хэвээр байна”-Life expestandy rises, but regional differencies remain, Matt Petronzio, 20 May 2014. <http://mashable.com/2014/05/19/life-expectancy-global/>
- “Европын хүн амын дундаж наслалт өндөр байна”, Т.Сарангя. 2013.03.13. <http://world.time.mn/>
- “Дэлхийн хамгийн өндөр дундаж наслалттай 10 улс”, МонголМед-Монголын Анагаахын Сэтгүүлүүдийн Холбоо (MACX), 2008-2. www.mongolmed.mn/article/1121
- “Хүн амын үзүүлэлтүүдийн өөрчлөлт, өнөөгийн байдал”, ҮСХ, 2013. www.nso.mn
- “Хүний дундаж наслалт”, ДЭМБ. <http://society.time.mn/>
- “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн байдал”, ЭМЯ, 2012. www.moh.mn
- Хөдөлмөрийн тухай хууль.
- Төрийн албаны тухай хууль.
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль.
- “Тэтгэврийн насыг нэмэх асуудлыг нэг дор богино хугацаанд шийдвэрлэх боломжгүй”, Л.Мөнхзул. www.info.mn
- Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль.

ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН АСУУДЛААРХ МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА*Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа***АГУУЛГА**

1. Тойм мэдээлэл
2. Хавсралт мэдээлэл
 - 2.1 Эрүүл мэндийн даатгалийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал
 - 2.2 Даатгуулсан иргэдийн тоог аймаг, дүүрэг тус бүрээр хүйс, насны ангиллаар
 - 2.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчийн тусламж үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө сүүлийн 10 жилээр
 - 2.4 Эрүүл мэндийн үйлчилгээнд төлбөр тусламж авсан хүний тоо сүүлийн 10 жилээр
 - 2.5 Төрөөс шимтгэлийг дааж буй иргэдийн тоо сүүлийн 10 жилээр

1. ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

Нийгмийн Даатгалын Ерөнхий газраас авсан статистик мэдээллээс харахад эрүүл мэндийн даатгалын сангаас гаргасан даатгуулагчийн тусламж үйлчилгээний зардал сүүлийн 10 жилд тогтмол өссөөр ирсэн бөгөөд 10 жилийн дунджаар жилд 22,8 хувиар өссөн байна. Тусламж үйлчилгээний нийт зардалд 2003 онд 18658,8 сая төгрөг зарцуулж байсан бол 2008 онд 50840,4 сая, 2010 онд 78128,4 сая төгрөг, 2012 онд 114396,4 сая, 2013 онд 120737,4 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. Эрүүл мэндийн даатгалын сангаас гаргасан зардлыг өмнөх онтой харьцуулж үзэхэд 2008 онд хамгийн их буюу 93,9 хувиар өссөн бол 2010 онд 37,2 хувиар, 2011 онд 11,7 хувиар, 2012 онд 31,2 хувиар, 2013 онд 5,5 хувиар тус тус өссөн байна.

2006-2013 оны эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн тоог авч үзэхэд жилээс жилд тасралтгүй өсч 2013 онд даатгуулсан иргэдийн тоо 2 864 500 хүрч өмнөх онтой харьцуулахад 10,2 хувиар өссөн байна. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн тоог аймаг, дүүрэг, хүйс, насны бүлгээр ангилсныг дэлгэрэнгүйгээр хүснэгтэд харуулсан.

Мөн эрүүл мэндийн даатгалын сангаас гардаг зардлуудын 74,1 хувийг улсын эмнэлгийн зардалд, 3,6 хувийг рашаан сувилалын зардалд, 8,0 хувийг эмийн үнийн хөнгөлөлтөд, 14,2 хувийг хувийн эмнэлгүүдэд олгосон зардалд, 0,1 хувийг бусад зардалд тус тус зарцуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ авсан даатгуулагчдын тоог авч үзвэл 2011 онд 3198,7 мянган хүн, 2012 онд 4126,5 мянган хүн, 2013 онд нийт 3843,2 мянган хүн эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ авсан байна. Тусламж үйлчилгээ авсан даатгуулагчдын тоо сүүлийн 5 жилийн дунджаар жилд 20,6 хувиар өссөн байна.

18 хүртэлх насны хүүхэд, өндөр насны тэтгэвэр авагч, хүүхдээ асарч буй эх/эцэг/, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, цэргийн албан хаагч, халамжийн тэтгэвэр авагч, 2012 оноос эхлэн өдрийн ангийн оюутан, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцан төлж байгаа бөгөөд төрөөс хариуцан төлж байгаа нийт даатгуулагчдын 62,8 хувийг хүүхэд, 14,7 хувийг өндөр насны тэтгэвэр авагчид, 9,0 хувийг өдрийн ангийн оюутнууд, 5,8 хувийг хүүхдээ асарч буй эцэг эхчүүд, 3,9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд заасны дагуу их, дээд сургууль, коллежийн өдрийн ангийн суралцагчдын эрүүл мэндийн

даатгалын шимтгэлийг 2012 оноос эхлэн төрөөс хариуцаж байгаагийн дагуу 2012 онд 133,1 мянга, 2013 онд 149,4 мянган оюутны даатгалыг төр хариуцан төлсөн байна.

2. ХАВСРАЛТ МЭДЭЭЛЭЛ²⁸²

2.1 ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг анх 1993 онд Улсын Их Хурлаар батлан 1994 оноос эхлэн мөрдөж байна. Энэ хугацаанд нэг удаа /2002 онд/ шинэчилсэн найруулгыг нь баталж, 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан болно. Эрүүл мэндийн даатгал нь нийгмийн даатгалын нэг төрөл бөгөөд эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Нийгмийн даатгалын ерөнхий газар эрхлэн гүйцэтгэж байна.

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар Монгол Улсын иргэн бүр түүнчлэн Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулж шимтгэл төлснөөр сан бүрдүүлэх, уг сангаас эрүүл мэндийн улмаас санхүүгийн эрсдэлд өртсөн даатгуулагчийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ; өдрийн эмчилгээ; амбулаторийн тусламж, үйлчилгээ; оношлогоо, шинжилгээ; нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ; уламжлалтын эмчилгээ; хөнгөвчлөх эмчилгээний болон өрх, сум, багийн эмчийн жороор олгох зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээний зардлыг жилд 1 800.0 мянган төгрөгт багтах хэмжээгээр тооцон эрүүл мэндийн даатгалын сан хариуцан төлж байна.

